



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



ПАРЛАМЕНТЫН  
СУДАЛГАА  
СУРГАЛТЫН  
ХҮРЭЭЛЭН

# ПАРЛАМЕНТ



СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

БОТЬ  
47

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

# “ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



- Эрх зүй, төрийн байгуулалтын судалгааны хэсэг

ННА-67  
ДАА-340  
П-183

ISBN 978-9919-9940-9-9

“Парламент” судалгааны эмхэтгэл (47 дугаар боть)-ийг  
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс  
эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Цогзолмаа  
Ц.Норовдондог (Ph.D.)

Эмхэтгэсэн: Р.Оргилмаа

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Төгсзаяа

УИХ-ын Тамгын газар ©  
“ПАРЛАМЕНТ” СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ - БОТЬ 47

## ГАРЧИГ

### I БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ

- |     |  |     |
|-----|--|-----|
| 1.1 | Цахим өргөдөл (e-petition)-ийн системээр иргэдийн саналыг хүлээн авах, парламентаар хэлэлцэх процедур: бусад орнуудын туршлага (СТ-23/213) | 6   |
|     | <i>Ц.Норовдондог (Ph.D.), Г.Билгээ, Ц.Ариунаа, Э.Билгүүн, О.Билгүүтэй, Р.Нургүл, П.Уранчимэг</i>   |     |
| 1.2 | Засаглалын тухай: Улс төрийн намын сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан байдал, холбогдох хууль ба институтууд (СТ-23/303)             | 46  |
|     | <i>Г.Билгээ, О.Нарантуяа</i>   |     |
| 1.3 | Засаглалын үзүүлэлтүүд ба Монгол Улсын нөхцөл байдал: Засаглал, түүнийг хэмжих нь (СТ-23/306)  | 110 |
|     | <i>Д.Халиун</i>  |     |
| 1.4 | Жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний тойм судалгаа: Монгол Улсын Их Хурал (СТ-23/304)  | 143 |
|     | <i>Ц.Норовдондог (Ph.D.), О.Нарантуяа, Б.Батцэцэг</i>  |     |
| 1.5 | Хүний эрхийн мэдрэмжтэй парламентын өөрийн үнэлгээний тойм судалгаа: Монгол Улсын Их Хурал (СТ-23/305)                                     | 232 |
|     | <i>Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, Э.Дашзэвэг</i>   |     |
| 1.6 | Парламентын ордны хөгжлийн чиг хандлага ба гадаадын зарим орны парламентын ордны талаарх тойм (СТ-23/413)                                  | 297 |
|     | <i>Г.Билгээ, П.Уранчимэг, Ц.Ариунаа</i>  |     |
| 1.7 | Тайванийн Хяналтын Юаны талаарх мэдээлэл, лавлагаа (СТ-23/417)   | 343 |
|     | <i>Г.Билгээ, П.Уранчимэг, О.Нарантуяа</i>  |     |
| 1.8 | Гадаадын зарим орны эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны талаарх мэдээлэл, лавлагаа (СТ-24/401)                          | 373 |
|     | <i>Г.Билгээ, П.Уранчимэг, Э.Билгүүн</i>  |     |





# БҮЛЭГ I

---

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ

**ЦАХИМ ӨРГӨДӨЛ (E-PETITION)-ИЙН СИСТЕМЭЭР ИРГЭДИЙН  
САНАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, ПАРЛАМЕНТААР ХЭЛЭЛЦЭХ ПРОЦЕДУР:  
БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Г.Билгээ,  
Ц.Ариунаа, Э.Билгүүн, О.Билгүүтэй,  
Р.Нургүл, П.Уранчимээ*

**АГУУЛГА**

Нэг. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТАД ЦАХИМ СИСТЕМЭЭР  
ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ПРОЦЕДУР (ЕВРОПЫН  
ОРНУУДЫН ТУРШЛАГА)

- 1.1.Иргэдийн өргөдөл (санал) өгөх эрх
- 1.2.Парламентад иргэдийн өргөдлийг хүлээн авах
  - 1.2.1.Парламентын өргөдөл хариуцсан хороо
  - 1.2.2.Өргөдлийг хянан шийдвэрлэх үндсэн үе шатууд
  - 1.2.3.Өргөдөл хүлээн авах хэлбэр
- 1.3.Өргөдөлд тавигдах шаардлага
  - 1.3.1.Саналын босго
  - 1.3.2.Өргөдлийн агуулгад тавигдах шаардлага
  - 1.3.3.Хүлээн авах боломжгүй өргөдөл
- 1.4.Өргөдлийг хянан шийдвэрлэх
  - 1.4.1.Өргөдлийг бусад байгууллагад шилжүүлэх
  - 1.4.2.Өргөдлийг хороонд шилжүүлэх
  - 1.4.3.Өргөдөл гаргагчийг хорооны хуралдаанд сонсох
  - 1.4.4.Бусад байгууллагыг сонсох
  - 1.4.5.Бусад байгууллагын шинжээч, албан тушаалтныг сонсох
  - 1.4.6.Мэтгэлцээн явуулах
  - 1.4.7.Баримт цуглуулах
- 1.5.Өргөдлийг авч үзсэний дараа авах арга хэмжээ
- 1.6.Өргөдлийг хаах
  - 1.6.1.Өргөдлийг хаах шалгуур
  - 1.6.2.Өргөдлийг хянан шийдвэрлэх хугацаа
  - 1.6.3.Олон нийтэд мэдээлэх

Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ИРГЭДИЙН ЦАХИМ ӨРГӨДЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ПАРЛАМЕНТААР ХЭЛЭЛЦЭХ ТУРШЛАГА

2.1.Бүгд Найрамдах Эстони Улс

2.2.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

2.3.Канад Улс

2.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

2.5.Шинэ Зеланд Улс

Гурав. ПАРЛАМЕНТЫН E-PETITION СИСТЕМИЙН ЗАРИМ АСУУДЛУУД

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

## **Нэг. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТАД ЦАХИМ СИСТЕМЭЭР ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ПРОЦЕДУР (ЕВРОПЫН ОРНУУДЫН ТУРШЛАГА)**

Дэлхийн улс орнуудын парламентуудад хууль тогтоох, хяналт тавих үндсэн үйл ажиллагаанаас гадна парламентын хэрэгжүүлдэг хамгийн чухал, шинэлэг үйл ажиллагаануудын нэг болох парламентын үйл ажиллагаанд, тэр дундаа хууль санаачлах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарах болсон. Европын улсуудын олон парламент сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд өргөдлийн системийг шинэчлэхээр эрчимтэй ажиллаж байна. Ингэхдээ парламентууд мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах замаар иргэдийг парламентын үйл ажиллагаанд татан оролцуулж байна.

Судалгааны энэ хэсэгт Лиссабоны Их сургуулийн улс төрийн шинжлэх ухааны доктор Тьяго Тибурсиогийн 2023 оны 09 дүгээр сард хийсэн “Парламентад өргөдөл гаргах эрхийн журам болон практик үйл ажиллагаа” сэдэвт судалгааг<sup>1</sup> тоймлон оруулав.


Энэхүү судалгааг Европын Парламентын Өргөдлийн хорооны хүсэлтээр, Европын Парламентын Иргэний эрх, Үндсэн хуулийн бодлогын газрын захиалгаар хийжээ. Судалгаанд 33 улс (Европын 32 улс болон Канад)-ын парламентын 44 танхим (дээд, доод танхим)-ын иргэдийн өргөдөл гаргах эрхийг хэрэгжүүлэх, парламентад өргөдөл хянан шийдвэрлэх журам, практик үйл ажиллагаа, зохион байгуулалтыг (парламентад хүлээн авах шаардлага, шалгуур, парламентаар авч хэлэлцэх, өргөдлийг хаах г.м.) судалсан байна.

### **1.1.Иргэдийн өргөдөл (санал) өгөх эрх**

Судалгаанд хамрагдсан Норвеги, Кипр, Финланд, Шведээс бусад орны парламентад иргэдийн өргөдөл гаргах эрх нь баталгаатай байдаг байна. Энэ нь эдгээр 4 улсад буюу XIX зууны эхэн үед Шведэд үүсэж, XX зуунд бусад улсад тархсан омбудсмэн институцтэй холбоотой ажээ.

<sup>1</sup> Rules, procedures and practices of the right to petition parliaments. Tiago Tábrcio (Ph.D. in Political Science from ISCTE - University Institute of Lisbon). Policy Department for Citizens' Rights and Constitutional Affairs Directorate-General for Internal Policies, European Parliament. September 2023. [https://www.europarl.europa.eu/thinktank/en/document/IPOL\\_STU\(2023\)753105](https://www.europarl.europa.eu/thinktank/en/document/IPOL_STU(2023)753105)

*Зураг 1. Иргэдийн өргөдөл гаргах эрхтэй парламентууд*



Омбудсмэн бол иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих, төрийн байгууллагын үйл ажиллагааны шударга, хууль ёсны байдлыг баталгаажуулан хангах үүрэгтэй институт юм. Омбудсмэн нь өөрөө шийдвэр гаргадаггүй, түүний саналыг заавал биелүүлэх үүрэг хүлээдэггүй ч эрх мэдэл, хүлээн зөвшөөрөгдөх байдлаараа хүчтэй нөлөө үзүүлдэг байна. Омбудсмэний иргэдийн эрхийг хамгаалагчийн үүрэг, өргөн хүрээний оролцоо, түүхэн туршлага нь зарим талаар иргэдийн парламентад өргөдөл гаргахтай дүйцэхүйц байдаг.


Судалгаанд хамрагдсан парламентууд нь иргэдийн өргөдлийг хүлээн авдаг бол Болгар, Францын парламентын хоёр танхимаас бусад парламентууд нь хуулийн этгээдийн өргөдлийг мөн хүлээн авдаг байна.

## **1.2. Парламентад иргэдийн өргөдлийг хүлээн авах**

### *1.2.1. Парламентын өргөдөл хариуцсан хороо*

Судалгаанд хамрагдсан парламентуудад ирүүлсэн иргэдийн өргөдөл хянан шийдвэрлэх асуудлыг хариуцах гурван субъект байна: 1) зөвхөн өргөдөл хариуцсан тусгай хороо; 2) өргөдөл хэлэлцэх эрх бүхий хороо; 3) тухайн асуудлыг хариуцсан байнгын хороо.

Зураг 2. Парламентын хариуцсан хороо




Судалгаанаас үзэхэд, парламентад зөвхөн өргөдөл хариуцсан тусгай хороо байх нь иргэдээс ирүүлсэн өргөдлүүдийг эрэмбэлж сонгох, авч хэлэлцэх зэрэг иргэдийн оролцооны энэхүү хэрэгсэлд чухал ач холбогдолтой. Мөн тэдгээрийг хянан шийдвэрлэх мэргэшсэн боловсон хүчнийг хангахад чиглэгддэг байна.

Судалгаанд хамрагдсан орнуудаас Австри, Бельги, Герман, Испани, Их Британи, Люксембург, Польш (Үндэсний Ассамблей), Туркийн парламентууд болон Европын Парламент нь өргөдөл хариуцсан тусгай хороотой байна. Харин Болгар, Польш (Сенат), Словени, Чехийн парламентууд нь тухайн асуудлыг хариуцсан байнгын хороо хариуцан ажилладаг байна.

1.2.2. Өргөдлийг хянан шийдвэрлэх үндсэн үе шатууд

Улс орнуудын парламентад өргөдлийг хянан шийдвэрлэх үе шатууд нь харилцан адилгүй байдаг ч ерөнхийд нь дараах үндсэн үе шатуудад хувааж болно:

Зураг 3. Өргөдлийг хянан шийдвэрлэх үндсэн үе шатууд




Дээрх үндсэн үе шатуудыг судалгаанд тоймлон авч үзнэ.

### 1.2.3. Өргөдөл хүлээн авах хэлбэр

Судалгаанд хамрагдсан бараг бүх парламентад цаасан өргөдөл хүлээн авсан хэвээр байна. Энэ нь орчин үеийн технологи ашиглах боломжгүй, эсхүл цаасан дээр өргөдөл гаргахыг илүүд үздэг иргэдтэй холбоо тогтоох боломжийг олгодог байна.

Парламентууд мөн цахим шуудангаар, эсхүл цахим хуудсаар дамжуулан иргэдээс өргөдөл хүлээн авч байна.

Зураг 4. Өргөдөл хүлээн авах хэлбэр



Эдгээрээс гадна ирүүлсэн өргөдлийг өөрөө биечлэн хүлээн авдаг туршлага зарим улс (Испани, Польш, Португал, Швейцар, Турк гэх мэт)-д байна. Тухайлбал, Португалд Парламентын дарга (эсхүл дэд дарга) чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд хангалттай өргөдөл (7500 хүний гарын үсэг) биечлэн хүлээн авдаг. Хорват, Латви парламентад биечлэн ирүүлсэн өргөдлийг хүлээн авдаг. Тухайлбал, Хорватын Парламентад танхимын даргатай шууд холбогдож утсаар ярих, эсхүл хорооны даргын өрөөнд уулзах боломжтой. Латвийн Парламентад Зочны болон мэдээллийн төвийн ажилтнууд нь иргэдийн амаар өгсөн хүсэлтийг бичгийн хэлбэрт оруулж өгдөг. Ингэхдээ тухайн иргэн нь тус төвд өөрийн биеэр ирж, гарын үсэг зурсан байхыг шаарддаг.

### 1.3. Өргөдөлд тавигдах шаардлага


Парламентууд нь иргэдийн өргөдлийг хүлээн авахад албан ёсны шаардлага тавих ба энэ нь парламентуудад ерөнхийдөө ижил байдаг. Тухайлбал, өргөдөлд өргөдөл гаргагчийн нэр, хаяг, гарын үсэг байна.



Зарим парламентад өргөдлийг хүлээн авахын тулд иргэдийн гарын үсгийн тооны доод хэмжээг тогтоосон байдаг. Гэхдээ ганцхан гарын үсэгтэй өргөдөл гаргахыг зөвшөөрдөг цөөхөн парламент хувь хүний оролцоог хангах, иргэн бүр дуу хоолойгоо хүргэх боломжийг олгодог.

Иргэдийн гарын үсэг хэдий чинээ олон байна, төдий чинээ өргөдөлд тусгасан тухайн асуудал нь олон нийтийн дэмжлэгийг илэрхийлсэн хэвээр байна. Нэлээдгүй парламентууд өргөдлийн бичвэр буюу түүний ойлгомжтой байдлыг харгалзан үзэх (Албани, Бельги, Хорват, Герман, Франц, Латви, Португал, Их Британи, Сан-Марино) ба өргөдөлд доромжилсон (Латви), зохисгүй, үл хүндэтгэсэн үг хэллэг (Итали) агуулаагүй байх зэрэг шаардлагуудыг холбогдох журмаар тогтоодог. Шаардлагатай тохиолдолд тухайн өргөдөл гаргагчаас тодруулга авч болно. (Чех, Хорват, Португал)

Зураг 5. Өргөдөл хүлээн авах шаардлага тавьсан парламентын тоо



### 1.3.1. Саналын босго

Парламентад өргөдөл хүлээн авах нэг шаардлага бол иргэдийн саналын тоо байдаг. Ихэнх парламентууд нэгээс олон дэмжигчтэй өргөдлийг хүлээн авдаг бөгөөд гарын үсгийн тоо нь өргөдөл гаргах үйл явцад нөлөөлдөггүй.

Өмнө дурдсанчлан өргөдөл гаргахын тулд хамгийн бага тооны дэмжигчийг шаарддаг хэд хэдэн улсын парламент байдаг. Энэ үзүүлэлт нь өндөр байх тусам тухайн санал улам хүчтэй болно гэсэн үг.

Хамгийн өндөр саналын босгыг Германы Парламент тавьсан байдаг. Тус улсын Парламентын Өргөдлийн хорооноос нийтийн сонсгол зохион

байгуулахын тулд хамгийн багадаа 50.000 хүний гарын үсэг шаарддаг. 2005-2010 оны хооронд нийт 9 өргөдөл л зургаан сарын дотор хүрэх ёстой энэ босгонд хүрч чаджээ.

Хамгийн бага босгыг үндэслэлтэй эсэхийг үнэлэхдээ тухайн улсын хүн амын тоо, өргөдлийн гарын үсэг (нэр, гарын үсэг, таних дугаар гэх мэт бусад дэлгэрэнгүй мэдээлэл гэх мэт) хүчинтэй байх журмыг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Зарим улсад гарын үсгийг цахимаар цуглуулдаг, тухайлбал, Латвид цахим гарын үсэг шаарддаг. Европын Парламент, Герман, Люксембургийн парламентуудад өөрийн платформ дээрээ гарын үсэг цуглуулахыг шаарддаг байна. Португалын хувьд цаасан болон цахим гарын үсгийг хүлээн зөвшөөрдөг.

*Хүснэгт 1. Парламентад өргөдөл хүлээн авах саналын босго*

<b>Улсын нэр</b>	<b>Хамгийн бага гарын үсгийн тоо</b>
Их Британи	5
Канад (цаасан өргөдөл)	30
Гүрж	300
Канад (цахим өргөдөл)	500
Австри	500
Португал, Эстони	1.000
Люксембург	4.500
Латви, Чех	10.000
Украин (цахим өргөдөл) Бельги	25.000
Герман	50.000

Зарим систем нь энэ гарын үсгийн сонголтыг зөвхөн цахим өргөдлөөр (Канад) хязгаарладаг бол зарим нь цаасан болон цахим өргөдлийг (Герман, Португал) хүлээн авдаг. Системүүдийн гол ялгаа нь цаг хугацаа юм. Европын Парламентад өргөдөлд нэмэлт гарын үсэг зурах эцсийн хугацаа байхгүй. Германд өргөдөл нийтлэгдсэнээс хойш 4 долоо хоногийн хугацаатай. Португал нь холбогдох хороо өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гарын үсгийг хүлээн авна.

Судалгаанд хамрагдсан улсуудаас 21 улсын парламентад өргөдлийг хүлээн авсны дараа гарын үсэг нэмж цуглуулах боломжтой байдаг бол Бельги, Болгар, Эстони, Литва, Румын, Словени, Испани, Швейцар зэрэг 8 улсад үүнийг хүлээн зөвшөөрдөггүй байна.

*1.3.2. Өргөдлийн агуулгад тавигдах шаардлага*

Өргөдлийн агуулгын хувьд, зарим парламент зөвхөн нийтийн эрх ашгийг хөндсөн өргөдлийг хүлээн авдаг (Чех) бол зарим нь хувийн ашиг сонирхлын хүсэлтийг хүлээн авдаг.

**Хүснэгт 2. Өргөдлийг хүлээн авахаас татгалзах бодит болон хууль эрх зүйн шалгуурууд (жишээ)**

	<b>Шалгуурууд</b>	<b>Улсын нэр</b>
1	Саяхан хянан үзсэн өөр саналтай үндсэндээ адилхан байх	Эстони, Латви, Португал
2	Үндсэн хуулийн суурь зарчимд илт нийцэхгүй байх	Эстони, Чех, Гүрж, Герман, Словак, Украин
3	Тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндсэн хуулийн журамд заналхийлсэн агуулгатай байх	Литва, Гүрж, Украин
4	Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагатай илт нийцэхгүй байх	Эстони, Словак
5	Холбогдох хуульд нийцэхгүй байх	Унгар, Словак
6	Хүндэтгэлгүй, ёс суртахуунгүй агуулгатай байх	Люксембург
7	Гүтгэлэг, эсхүл доромжилсон агуулгатай байх	Франц, Латви, Их Британи
8	Тодорхой хүмүүсийн (төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа албан тушаалтныг оролцуулан) хувийн хүрээлэл, нэр хүндэд хохирол учруулсан агуулгатай байх	Итали
9	Албадлагын, эсхүл сүрдүүлгийн шинжтэй байх	Герман
10	Нэг хүн, эсхүл хэсэг бүлэг хүмүүсийн эсрэг, ялангуяа тэдний улс төрийн үзэл бодол, гарал үүсэл, шашин шүтлэг, гишүүнчлэл, эсхүл гишүүнчлэлийн бус байдал, бэлгийн чиг хандлагынх нь эсрэг хүчирхийлэл, үзэн ядалтад уриалсан, гүтгэсэн, ялгаварлан гадуурхсан, түрэмгийлсэн, сөрөг хандлагад уриалсан, садар самуун сурталчилсан агуулгатай байх	Франц, Чех, Гүрж, Украин
11	Үндэстэн, шашин шүтлэг, үндэсний цөөнхийг доромжилсон агуулгатай байх	Франц, Чех, Унгар, Латви, Сан-Марино, Украин
12	Парламентыг доромжилсон агуулгатай байх	Унгар
13	Бусад хүмүүсийн эрх, эрх чөлөөг хязгаарлах аливаа шаардлага, саналыг агуулсан байх	Литва, Словак
14	Гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийг (барааны тэмдэг, зохиогчийн эрх гэх мэт) зөрчих	Франц
15	Гуравдагч этгээдийн хувийн нууцлал, зураг дүрсний эрхийг зөрчих	Франц
16	Хууль бус нэхэмжлэл гаргах	Португал, Чех
17	Нууц, эсхүл худалдааны нууц байж болох материалыг агуулсан байх	Их Британи
18	Тодорхой хүн, байгууллагыг гэмт хэрэгт буруутгах	Их Британи
19	Намын улс төрийн материал агуулсан байх	Их Британи
20	Шинэ хууль, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардах	Турк

Парламентууд эрх мэдлийн хуваарилалт, шүүхийн асуудалд хөндлөнгөөс оролцохгүй байх үүднээс шударга ёстой холбоотой өргөдлийг парламентаар авч үзэхгүйгээр хамгийн их хасагддаг. (Бельги, Герман, Канад, Европын Парламент, Португал, Словак, Турк, Их Британи) Зөвхөн нийтийн ашиг сонирхлын өргөдлийг авч үздэг системд тодорхой ашиг сонирхлын хүрээнд хязгаарлагдсан хүсэлтийг хасдаг байна.

### 1.3.3. Хүлээн авах боломжгүй өргөдөл

Парламентад хүлээн аваагүй өргөдлийг цааш хэрхэх талаар улс орнуудын парламентад харилцан адилгүй байна. Жишээлбэл, Бельги, Их Британид зөвхөн хүлээн авсан өргөдлийг цахим хуудсандаа нийтэлдэг. Гэтэл Португалд бүх өргөдлийг (доромжилсон агуулгатай) нийтэлдэг. Судалгаанаас үзэхэд, арван хоёр парламент хүлээн авах боломжгүй өргөдлийг тусад нь гаргаж өгдөг.

Парламентад хүлээн авах боломжгүй гэж үзсэн өргөдлийн тоо нь улс орнуудын хооронд зөрүүтэй байна. Судалгаанд авагдсан зарим улсад дийлэнх өргөдлийг хүлээн авсан байна. Харин шаардлага, шалгуур ихтэй улсуудад хүлээн аваагүй өргөдлийн тоо өндөр байна. Тухайлбал, 2021 онд Бельги, Украины парламентад өргөдлийн 50-аас дээш хувь байгаа бол, Европын Парламент болон Словакийн Парламентад 1/4-ийг хүлээн аваагүй байна.

Хүснэгт 3. Хүлээн авах боломжгүй гэж үзсэн өргөдлийн хувь

	2019		2020		2021	
	Ирсэн өргөдлийн тоо	Хүлээж аваагүй өргөдөл (хувиар)	Ирсэн өргөдлийн тоо	Хүлээж аваагүй өргөдөл (хувиар)	Ирсэн өргөдлийн тоо	Хүлээж аваагүй өргөдөл (хувиар)
Бельги	143	78	187	65	182	52
Европын Парламент	1357	30	1573	25	1392	26
Эстони	12	0	20	0	29	3
Итали	145	12	202	8	178	13
Португал	90	11	167	10	154	12
Словак	20	25	6	50	10	10
Турк	5747	7	6373	5	4464	26
Украин	1707	56	1151	69	783	70

### 1.4. Өргөдлийг хянан шийдвэрлэх

Парламентад өргөдлийг хүлээн авсны дараа хэрэгжүүлдэг нийтлэг үйл ажиллагааг дараах зурагт харуулав. Парламентууд хэд хэдэн үйл ажиллагааг нэгэн зэрэг хэрэгжүүлэх боломжтой байдаг.

**Зураг 6. Парламент дахь өргөдлийг хянан шийдвэрлэх хамгийн түгээмэл ажиллагаа**



Дээрх ажлуудыг өргөдлийн асуудал эрхэлсэн хороодод тусгайлан олгодог, эсхүл жирийн хороод өөрсдийн эрхлэх асуудлаарх өргөдлийг хянан хэлэлцдэг (Франц, Унгар, Португалын парламентын жишээн дээр) байна. Тухайлбал, Унгарын Парламентын практикт, хороодод дээрх хувилбаруудын заримыг хэрэгжүүлэх боломжтой боловч Парламентад өргөдөл гаргах практикт үүнийг төдийлөн ашигладаггүй.

#### 1.4.1. Өргөдлийг бусад байгууллагад шилжүүлэх

Өргөдлийг бусад байгууллагад шилжүүлэх гэдэгт засгийн газар, омбудсман, бүс нутгийн, эсхүл орон нутгийн засаг захиргаа орж байна. Тухайлбал, хороо нь холбогдох байгууллага (төр, орон нутгийн засаг захиргаа)-тай харилцаж, өргөдлийн дагуу тавьсан асуудлын талаар асуулт асуух, санал бодлыг нь авах, тэдгээртэй холбоотой мэдээлэл цуглуулах, эсхүл өргөдлийн агуулгыг тэдэнд мэдээлэх боломжтой.

Энэ тохиолдолд зарим улсын парламентад холбогдох байгууллагаас хариу өгөх хугацааг хуулиар тогтоосон байх бөгөөд зарим нь дагаж мөрдөөгүй бол хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг. Тухайлбал, судалгаанд хамрагдсан парламентын 17 нь асуусан асуултад заавал хариулах ёстой гэсэн хариулт өгсөн байна.

*Хүснэгт 4. Холбогдох байгууллагын хариу өгөх эцсийн хугацаа*

<b>Улсын нэр</b>	<b>Заавал хариу өгөх хугацаа (хоног)</b>
Гүрж	15
Их Британи	14-21
Португал	20
Болгар, Латви, Румын (Сенат), Словак, Турк, Чех, Эстони	30
Бельги, Канад	45
Хорват	30-60

Ийм хугацааг тогтоохоос гадна парламентуудад, тухайлбал, Бельгийн Парламент нь өргөдлийг сайдад илгээсэн бол тэрээр 6 долоо хоногийн дотор, эсхүл хорооноос тогтоосон бусад хугацаанд бичгээр хариу тайлбар өгөх үүрэгтэй. Португалын Парламентад энэ хугацаа 20 хүртэлх хоног байдаг бөгөөд энэхүү хамтын ажиллагааны үүргээ биелүүлэхгүй байх нь гэмт хэргийн шинжтэй боловч практик дээр энэ талаар шүүхийн байгууллагад мэдээлээгүй байна. Энэ хугацаа нь Европын Парламентад тухайн асуудлаас хамаарч 3 сар, Словенид 60 хоног байдаг.

*1.4.2. Өргөдлийг хороонд шилжүүлэх*

Судалгаанд хамрагдсан улсуудад өргөдлийг холбогдох хороонд шилжүүлэх нь хамгийн түгээмэл байдаг.

Тухайлбал, Германы Парламент, Европын Парламент нь өргөдлийн хороотой, эдгээр хороод нь хэлэлцэж буй асуудлаар мэргэжлийн хорооноос санал авдаг. Харин тусгайлсан өргөдлийн хороогүй парламентуудын хувьд асуудлынх нь дагуу анхнаасаа холбогдох хороонд өргөдлөө шилжүүлдэг.

Судалгаанд хамрагдсан улсуудын парламентад хороодын хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Бельгийн Төлөөлөгчдийн Танхимын хариуцах хороонд өргөдөл хүлээн авсан бол тус хороо нь өргөдлийн хариуг Өргөдлийн хороонд тогтмол, бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Өргөдлийн хорооны журмын 1.8-д заасны дагуу Өргөдлийн хороо нь өргөдөл хүлээн авсан хорооноос энэ талаар Өргөдлийн хороонд мэдэгдээгүй буюу хангалтгүй мэдээлсэн бол Өргөдлийн Хороо нь Танхимын дүрмийн 28.1-д заасны дагуу нэмэлт мэдээлэл өгч чадах хүмүүс, эсхүл байгууллагаас мэдээлэл, зөвлөгөө авч болно. Мөн тус улсад өргөдөл нь мэтгэлцээнд орох нөхцөл хангагдсан бол Өргөдлийн хороо тухайн өргөдлийг холбогдох асуудлыг хариуцсан хороонд шилжүүлдэг.

Эстонид Рийгикогу-ийн Удирдах зөвлөлөөс өргөдлийг хариуцан хэлэлцэх хамтарсан хороог томилж болно. Харин нэг хороо хариуцсан бол бусад хорооноос санал авах, эсхүл хэд хэдэн хорооны хамтарсан хурлаар хэлэлцүүлж болно.

Эдгээр хамтын ажиллагааны механизмын ихэнх нь албан ёсны журамгүйгээр явагддаг.

#### *1.4.3. Өргөдөл гаргагчийг хорооны хуралдаанд сонсох*

Өргөдөл гаргагч болон бусад холбогдох этгээдүүд байр сууриа илэрхийлэх, мэдүүлэг өгөх, хорооны хэлэлцүүлэгт оролцох боломжийг олгох үүднээс хороод нээлттэй хуралдаан, сонсгол хийдэг. Тухайлбал, Словени зэрэг зарим оронд өргөдлийн дагуу сонсгол явуулах тогтолцоотой. Нээлттэй хуралдаан, сонсгол хийх зорилго нь нийтийн ашиг сонирхол, өргөн хүрээний асуудалтай холбоотой өргөдлийг хэлэлцэх явдал юм.


Гэсэн хэдий ч саналын босго тогтоосон ч парламентууд заавал сонсгол хийнэ гэсэн үг биш юм. Тухайлбал, Германд “олон нийтийн өргөдөл”-ийг Өргөдлийн хороо гишүүдийн 2/3-ын олонхын саналаар шийдвэрлэдэг. Харин Болгар саналын босго байхгүй ч бүх тохиолдолд өргөдөл гаргагчдыг сонсдог байна.

Европын Парламентад өргөдөл гаргагч хорооны хуралдаанаар өргөдлийг нь хэлэлцэх үед түүнд оролцох эрхтэй. Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал батлагдсаны дараа өргөдөл гаргагчдад түүний өргөдлийг хэлэлцэх эсэхийг шуурхай мэдэгдэнэ. Хорооны хуралдаанд оролцохыг урина. Тухайн өргөдлийг сонирхож буй Парламентын гишүүн улсын төлөөлөлд урьдчилан мэдэгдэж, хорооны хуралдаанд оролцож, мэдэгдэл хийхийг урьж болно. Хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох бусад оролцогч талуудад ижил зарчмыг баримтална.

#### *1.4.4. Бусад байгууллагыг сонсох*

Судалгаанд хамрагдсан улсуудад байгууллагын төлөөлөгчдийг хорооны хуралдаанд урьж болно. Тухайлбал, Чехэд өргөдлийг 10.000-аас доошгүй хүн, Германд 50.000 гаруй хүн тус тус дэмжсэн бол парламентын холбогдох хороо нь бусад байгууллагуудын төлөөлөгчдийг хуралдаандаа урьж оролцуулдаг.

*Зураг 7. Өргөдөл гаргагчдыг нэмэлт мэдээлэл өгөхийг урьдаг парламентууд*



Өргөдлийг хэлэлцэхдээ зарим парламент өргөдөл гаргагчид нэмэлт мэдээлэл өгөх замаар оруулахыг хүсэж буй нэмэлт саналыг харгалздаг. Өргөдөл гаргагчид Болгар, Европын Парламент, Эстони, Герман, Унгар, Итали, Латви, Румын, Словени, Турк зэрэг улсад өргөдөл гаргах явцад өргөдөлд холбогдох мэдээллийг нэмж оруулах эрхтэй. Бельги, Францын парламентууд ийм боломжийг олгодоггүй.

#### *1.4.5. Бусад байгууллагын шинжээч, албан тушаалтныг сонсох*

Судалгаанд хамрагдсан 18 парламент нь бусад байгууллагын шинжээч, албан тушаалтныг сонсдог байна. Үүний үр дүнд хариуцсан хороод нь хөндлөнгийн шинжээчид, эсхүл холбогдох салбарын мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж, өргөдлийн асуудлаар тэдний санал, дүгнэлтийг авах боломжтой.

Харин Итали, Унгарын парламентад үүнийг хэрэгжүүлдэггүй байна.

Люксембургийн хувьд шинжээчдийг сонгох санаачилга нь Парламент, эсхүл Парламентын гишүүдээс бус өргөдөл гаргагчид өөрсдөө (Парламентад хэлэлцэх үед, өөрөөр хэлбэл 4500-аас дээш хүний гарын үсэгтэй өргөдлийн хувьд) санаачилга гаргадаг байна.

#### *1.4.6. Мэтгэлцээн явуулах*

Өргөдлийн асуудлыг парламентын хороогоор, ялангуяа чуулганы нэгдсэн хуралдаанаар авч хэлэлцэх, мэтгэлцээн явуулах нь хамгийн чухал үйл явц юм.



Парламентын хэлэлцэх асуудлын дараалалд өргөдлийн асуудал орох нь өргөдөл гаргагчдын хувьд хамгийн их хүлээгдэж байдаг үйл явц бөгөөд ихэнх улс орнуудын парламентад мэтгэлцээний ач холбогдлыг тусгасан байдаг.

Мэтгэлцээн нь өргөдлийн асуудлыг хэлэлцэх боломжийг олгохоос гадна асууж буй байгууллагуудын (төрийн байгууллага гэх мэт) өгсөн хариултууд хангалттай байсан эсэхийг үнэлэх боломжийг олгодог.

Ийнхүү парламентын хэлэлцэх асуудлын дараалалд орох өргөдлийн хувьд ихэвчлэн иргэдийн гарын үсгийн тооны доод босготой холбоотой бөгөөд саналын босго нь судалгаанд хамрагдсан орнуудад мөн харилцан адилгүй байна. Хамгийн бага босгыг Португал, хамгийн их босгыг Франц тавьсан байна. Францад 500.000 хүний гарын үсэг шаардагддаг. Их Британид 100.000 гаруй хүний гарын үсэгтэй өргөдлийн асуудлаар мэтгэлцээн явуулах боломжтой. Португал, Словак улсад босгонд хүрсэн өргөдлийн хувьд мэтгэлцээн заавал явуулна.

#### *Хүснэгт 5. Парламентын мэтгэлцээнд оруулах саналын босго*

<b>Улсын нэр</b>	<b>Саналын Босго</b>
Португал	2.500 (хорооны мэтгэлцээн)
	7.500 (нэгдсэн хуралдааны мэтгэлцээн)
Их Британи, Словак	100.000 (нэгдсэн хуралдааны мэтгэлцээн)
Франц	500.000 (нэгдсэн хуралдааны мэтгэлцээн)

#### *1.4.7.Баримт цуглуулах*

Өргөдлийн асуудлаар баримт цуглуулах ажиллагаа нь Франц, Гүрж, Герман, Румын, Словени зэрэг 12 парламентад байдаг. Европын Парламент нь өргөдлийн асуудлаар энэ ажиллагааг чухалчилж авч үздэг бол энэ ажиллагааг журамд заасан боловч Италид хэрэгжүүлж байгаагүй, Португал, Унгарт ховор хэрэгжүүлдэг байна.

#### **1.5.Өргөдлийг авч үзсэний дараа авах арга хэмжээ**

Судалгаанд хамрагдсан улсуудын парламентад иргэдийн өргөдлийг авч үзсэний дараа дор дурдсан арга хэмжээнүүдийг авдаг:

- **олон нийтэд мэдээлэх:** өргөдөл, түүний хянан шийдвэрлэх явцыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод болгох, аливаа иргэн, тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгсэлд энэ үйл явцад хяналт тавих боломжийг олгодог;

- **мэдээлэл цуглуулах:** өргөдлийн асуудлын ач холбогдлыг авч үзэн баримт, нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулах нь өргөдлийн үндэслэлийг илүү сайн шалгах боломжийг олгодог. Мөн дараа дараагийн үйлдлүүдийн чухал үндэс суурь болдог;
- **өргөдөл гаргагчидтай харилцах:** өргөдөл гаргагчид өргөдлийнх нь хянан шийдвэрлэх явцын талаар мэдээлэл өгөх, тодруулдаг;
- **бусад байгууллагад шилжүүлэх:** өргөдлийг бусад холбогдох байгууллагуудад шилжүүлэх, хариу өгөх магадлалыг нэмэгдүүлдэг;
- **мэтгэлцээн явуулах:** өргөдөл гаргагчдын дуу хоолойг парламентад дэвшүүлдэг чухал үр дүн бөгөөд мэтгэлцээнийг хороод, эсхүл нэгдсэн хуралдаанд явуулж, энэ талаар тайлагнадаг;
- **шийдвэр гаргах:** тодорхой асуудлыг шийдвэрлэх, тэр дундаа хариуцлага хүлээж болзошгүй албан тушаалтны талаар санал хураалт явуулж шийдвэрлэдэг;
- **бодлогын санаачилга:** өргөдөл гаргагч нь хууль санаачлах үйл ажиллагаанд оролцох боломжтой.

Судалгаанаас үзэхэд, парламентад иргэдийн өргөдлийг авч үзсэний дараа авдаг арга хэмжээнүүдийг төрлөөр нь дараах хүснэгтэд бүлэглэв.

Хүснэгт 6. Авах арга хэмжээ

Авах арга хэмжээ	Жишээ
Олон нийтэд мэдээлэх	цахим хуудас, парламентын суваг, статистикийн тайлан, албан ёсны сэтгүүлд нийтлэх
Мэдээлэх	тайлагнах, хариулах, газар дээр нь танилцах
Парламентын гишүүдийн санал	мэтгэлцээн явуулах
Өргөдөл гаргагчидтай харилцах	хуралдаанаар сонсох, цахим порталаар өргөдөл дэмжигчидтэй харилцах, сонсгол зохион байгуулах
Шилжүүлэх (ихэвчлэн эрх бүхий байгууллагад)	бусад байгууллагад, тухайлбал, засгийн газар, омбудсмэн, орон нутгийн засаг захиргаа, шүүх, эсхүл цагдаа (хэрэв гэмт хэргийн нотлох баримт байгаа бол)-д шилжүүлэх
Асуулт тавих	засгийн газар, бусад байгууллага, мэргэжилтнүүдэд асуулт тавих
Мэтгэлцээн явуулах	хорооны болон нэгдсэн хуралдаанд мэтгэлцээн явуулах, нэгдсэн хуралдаан/хороонд танилцуулах, тогтоолын төсөл хэлэлцүүлэх
Зөвлөгөө өгөх	ихэнхдээ эрх бүхий байгууллагад ханддаг
Зуучлах	эрх бүхий байгууллагатай уулзаж асуудлыг шийдвэрлэх
Шийдвэр гаргах	өргөдлийн сэдвээр санал хураалт явуулах
Улс төрийн санаачилга гаргах	боломжит хууль тогтоомжийг улс төрийн бүлэгт шилжүүлэх

## 1.6.Өргөдлийг хаах

### 1.6.1.Өргөдлийг хаах шалгуур

Судалгаанд хамрагдсан улсуудын парламентад иргэдийн өргөдлийг авч үзээд хаах шалгуурыг дараах үндсэн дөрвөн төрөлд хуваасныг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 7. Өргөдлийг хаах шалгуур

Шалгуур	Жишээ
Өргөдлийг өөр хороонд шилжүүлсэн бол	Австри
Өргөдлийг бусад байгууллагад шилжүүлсэн бол	Австри, Бельги (Сенат), Герман, Португал
Цаашид арга хэмжээ авахаар өргөдлийг Омбудсмэнд шилжүүлсэн бол	Австри, Бельги (Сенат), Португал
Хорооны дүгнэлтийн дагуу асуудлыг парламентаар хэлэлцэхийг шаардсан бол	Австри
Сонсгол хийсэн бол	A Люксембург
Хүлээн зөвшөөрөх тухай шийдвэр гарсан бол	Европын Парламент, Португал*
Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх/шийдвэр гарсан бол	Португал, Турк
Хорооны саналаар	Испани (Сенат)
Чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан бол	Испани (Сенат), Швейцар
Босгодоо хүрээгүй бол	Гүрж, Люксембург
Парламентын бүрэн эрхийн хугацаа дууссан бол	B Бельги, Итали, Испани, Их Британи
Эрх бүхий байгууллага хариу өгсөн бол	Хорват, Герман**, Словени, Испани (Сенат), Их Британи
Өргөдлийн асуудлаар хуулийн төсөл боловсруулагдсан бол	Франц (Сенат)
Тогтоол батлагдсан бол	C Итали, Польш, Герман***
Өргөдлийн асуудал нь хэдийнээ хэлэлцэж байгаа хуулийн төсөлд туссан бол	Итали
Засгийн газар энэ асуудлаар шийдвэр гаргасан бол	Бельги
Өргөдлийн асуудал нь хамааралгүй болсон бол	D Бельги
Өөр хүчин чармайлт гаргах шаардлагагүй гэж үзсэн бол	Европын Парламент, Португал

Тайлбар: \* <101 гарын үсэг бүхий өргөдлийн хувьд

\*\*хороо өргөдлийн хариуг хангалттай гэж үзсэн бол

\*\*\*Засгийн газрын үйл ажиллагаа хүлээгдэж байгаа бол

Дээрх хүснэгтээс үзэхэд, парламентад иргэдийн өргөдлийг авч үзээд хаах шалгуурыг А, В, С, D гэсэн дөрвөн үндсэн төрөлд хуваасан байна:

- **А төрлийн шалгуур:** эдгээр нь зөвхөн парламентаас хамаарч, түүний хяналтад байдаг. Парламентаас тогтоосон процедурын дагуу хийгддэг;
- **В төрлийн шалгуур:** эдгээр нь тодорхой бөгөөд ихэвчлэн хууль, журмаар тогтоосон байдаг. Тухайлбал, хэрэв парламентын бүрэн эрхийн хугацаа нь дууссан бол өргөдлийг хаадаг жишээ хэд хэдэн парламентад байдаг;
- **С төрлийн шалгуур:** эдгээр нь гаднын байгууллагын хариу үйлдэл зэрэг гуравдагч этгээдийн үйл ажиллагаанаас хамаарна. Зарим парламент өргөдлийг хаахаас өмнө эдгээр хариуг хүлээх бөгөөд хэрэв хариу өгөхгүй бол өргөдлийг хаах хугацаа хойшлогдох магадлалтай;
- **D төрлийн шалгуур:** эдгээр нь өргөдлийн хэлэлцүүлгийг зогсоох нь зүйтэй, эсхүл цаашид авч үзэх шаардлагагүй болсон үед парламент (эсхүл хороо) шийдвэрлэнэ.

#### *1.6.2.Өргөдлийг хянан шийдвэрлэх хугацаа*

Парламентын өргөдлийн системд түүнийг хянан шийдвэрлэх хугацаа чухал ач холбогдолтой. Хугацаа нь давж заалдах гомдолд хариу авах эрхтэй нягт холбоотой. Энэхүү эрхийг хангахын тулд өргөдлийг цаг тухайд нь шийдвэрлэх нь чухал байдаг.

Мөн энэ хугацаа нь өргөдлийн системийн үр дүнтэй байдлын чухал үзүүлэлт болдог. Өргөдлийг удаан хугацаанд хянан үзэх нь хариу арга хэмжээний үр ашгийг бууруулж болзошгүй, ялангуяа тухайн асуудал нь шуурхай арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд.

Өргөдлийг анхааралтай авч үзэх, цаг тухайд нь хариу өгөх хоёрын тэнцвэрийг бий болгох асуудал парламентад тулгарч байна. Энэ нь ялангуяа нарийн төвөгтэй асуудал бүхий өргөдлийг хянан шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг.

Бусад байгууллагуудын хариу удаашрах зэрэг зарим хүчин зүйл нь парламентаас өргөдөлд цаг тухайд нь хариу өгөхөд саад учруулах эрсдэлтэй. Эдгээр байгууллагууд болон хоорондын үр дүнтэй уялдаа холбоо, хамтын ажиллагаа нь уг асуудлыг шийдвэрлэх нэг механизм болдог.

## Хүснэгт 8. Өргөдлийг хянан шийдвэрлэх хугацаа

<b>Улсын нэр</b>	<b>Өргөдлийг хянан шийдвэрлэх хугацаа (ойролцоогоор)</b>
Болгар	12 сар
Эстони	10 сар
Испани (Сенат)	8 сар
Итали	7.4 сар
Европын Парламент	6-аас 12 сар
Франц (Сенат)	4-өөс 8 сар
Литва, Польш	3 сар
Словак	2-оос 3 сар
Люксембург, Словени, Турк	2 сар
Португал	1.5-аас 12 сар

## 1.6.3. Олон нийтэд мэдээлэх

Судалгаанаас үзэхэд, улс орнуудын парламентын өргөдлийн систем дэх олон нийтэд мэдээлэх үүргийг дараах байдлаар авч үзсэн байна:

- **цахим хуудас ашиглах:** судалгаанд хамрагдсан ихэнх парламентууд өргөдөл гаргагч болон олон нийтэд мэдээлэл өгөх гол суваг нь тусгайлсан өргөдлийн цахим хуудастай (платформ), эсхүл өөрийн цахим хуудастаа багтаасан. Уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээг иргэдийн төлөөлөгчийн байгууллагуудтай харьцуулахад бага ашиглаж байна;
- **өргөдлийн цахим хуудасны чиг үүрэг:** парламентууд өргөдлийн цахим хуудас (платформ)-аараа дамжуулан иргэдээс ирүүлсэн өргөдлийн бүрэн текст, холбогдох огноо, дэмжигчдийн тоо, түүнийг хянан шийдвэрлэх үйл явцын талаар цогц мэдээлэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг иргэдийн бүртгэлээр нь санал болгох, дэмжсэн гарын үсгийг нэмэх замаар харилцан үйлчлэлийг хөнгөвчилж байна;
- **олон нийтийн анхаарлыг татах:** олон парламентууд өргөдөл гаргах үйл явцын парламентын сонсгол, мэтгэлцээн зэрэг чухал хэсгүүдийг цахим дата урсгал, парламентын телевиз зэрэг сувгуудаар дамжуулан олон нийтэд нээлттэй хүргэж байна;
- **хугацаанд хяналт тавих:** өргөдөл хянан шийдвэрлэх үйл явцын товыг цахим хуудсанд байршуулснаар иргэд парламент болон бусад байгууллагаас ирүүлсэн хариу арга хэмжээг цаг тухайд нь авч байгаа эсэхийг хянах боломжтой болж, парламентын үйл ажиллагааг үр дүнтэй, шуурхай явуулахад дэмжлэг үзүүлнэ.

## Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ИРГЭДИЙН ЦАХИМ ӨРГӨДЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ПАРЛАМЕНТААР ХЭЛЭЛЦЭХ ТУРШЛАГА

### 2.1. Бүгд Найрамдах Эстони Улс

Бүгд Найрамдах Эстони Улс (БНЭУ) бодлого боловсруулах, хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2014 оноос Иргэдийн санал санаачилга портал [Rahvaalgatus.ee](http://Rahvaalgatus.ee)-ийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ нь БНЭУ-ын иргэд Парламентад хүсэлт гаргах хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх дижитал шийдэл юм.

Энэхүү портал нь БНЭУ-ын Парламент (Рийгикогу) болон орон нутгийн засаг захиргаанд мөрдөж буй хууль, журамд өөрчлөлт оруулах, хэлэлцэгдэж буй хууль, журамд санал өгөх, нийгмийн нөхцөл байдлыг сайжруулах талаар санал гаргах, хэлэлцүүлэг явуулах, цахим гарын үсэг бүхий хамтын саналаа бичих, өргөн мэдүүлэх боломжийг олгодог байна. Энэ нь Рийгикогуд суудалтай улс төрийн намуудад зориулагдаагүй.

[Rahvaalgatus.ee](http://Rahvaalgatus.ee) порталыг ашиглахдаа үзэн ядсан болон доромжлолын шинжтэй үг хэллэг хэрэглэхийг хориглоно. БНЭУ-ын Хамтын Ажиллагааны Ассамблей<sup>2</sup> ашиглалтын нөхцөлийг зөрчсөн аливаа бичлэг, бичвэрийг нэмэлт тайлбаргүйгээр устгах эрхтэй.<sup>3</sup>

[Rahvaalgatus.ee](http://Rahvaalgatus.ee) порталын үйл ажиллагаа нь Санамж бичиг, тайлбар, хүсэлтэд хариу өгөх, хамтын хаяг илгээх тухай хуулиар (Response to Memoranda and Requests for Explanations and Submission of Collective Addresses Act)<sup>4</sup> зохицуулагдана. Энэ порталаар дамжуулан парламентад илгээсэн саналтай холбогдох асуудлыг Рийгикогугийн дэгийн дүрэм, дотоод журмын тухай хуулиар (Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act) зохицуулсан байна.

### *Парламентаар авч хэлэлцэх иргэдийн саналын тооны босго*

Санамж бичиг, тайлбар, хүсэлтэд хариу өгөх, хамтын хаяг илгээх тухай хуульд зааснаар Рийгикогуд илгээх саналд БНЭУ-ын 16-аас дээш насны 1000-аас доошгүй иргэдийн гарын үсгийг цуглуулсан байх шаардлагатай. Хамтын саналын гарын үсгийг 18 сарын хугацаанд цуглуулна<sup>5</sup>.

<sup>2</sup> БНЭУ-ын Хамтын Ажиллагааны Ассамблей (ЕСА) нь тус улсын урт хугацааны хөгжилд зориулагдсан төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны сүлжээ юм. Тус Ассамблейг БНЭУ-ын Ерөнхийлөгч үүсгэн байгуулсан бөгөөд одоогоор 77 байгууллага уг сүлжээний гишүүнээр нэгдсэн байна. ЕСА-ийн зорилго нь эдгээр байгууллагуудын санал бодлыг хуваалцах, зохицуулах, үүний үндсэн дээр улс орны ирээдүйд чухал ач холбогдолтой асуудлуудын талаар үнэлгээ, санал зөвлөмж гаргахад оршдог байна.

<sup>3</sup> <https://rahvaalgatus.ee/about>

<sup>4</sup> Response to Memoranda and Requests for Explanations and Submission of Collective Addresses Act, Chapter 3, <https://www.riigiteataja.ee/en/eli/501112016001/consolide>.

<sup>5</sup> <https://rahvaalgatus.ee/about>

Рийгикогугийн Удирдах зөвлөл<sup>6</sup> тухайн саналыг ирүүлснээс хойш хуанлийн 30 хоногийн дотор саналыг хүлээн авсан, эсхүл хүлээн авахаас татгалзсан тухай санал ирүүлсэн хүмүүст мэдэгдэнэ.

Рийгикогу нь хүлээн авсан саналыг Рийгикогугийн дэгийн дүрэм, дотоод журмын тухай хуульд<sup>7</sup> заасны дагуу шийдвэрлэх ба шаардлага хангасан бүх саналыг тухайн асуудлыг хариуцах парламентын нэг, эсхүл хэд хэдэн хороодод хэлэлцүүлэхээр шилжүүлнэ. Хороо саналыг хэлэлцээд 6 сарын дотор шийдвэрээ гаргана. Ийнхүү хэлэлцэх явцад шаардлагатай үед санал ирүүлсэн хүмүүсийг хорооны хуралдаанд урин оролцуулж тухайн саналтай холбогдох тайлбарыг сонсож болно.

Хорооноос тухайн саналыг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь зөвшөөрөх, эсхүл зөвшөөрөөгүй гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргах ба энэ тухай санал ирүүлсэн хүмүүст хариу илгээнэ.

### ***Иргэдийн саналыг парламентын хэлэлцүүлэгт оруулах, хууль тогтоомжид тусгах процедур***

Хороо саналтай холбоотой дараах шийдвэрийг гаргана<sup>8</sup>:

- улс орны хувьд чухал асуудал гэж үзээд хуулийн төсөл, эсхүл тогтоолын төсөл санаачлах;
- ард нийтийн хэлэлцүүлэг явуулах;
- саналыг эрх бүхий байгууллагад уламжлах;
- саналыг Засгийн газарт уламжлах;
- саналаас татгалзах (2 жил хүрэхгүй хугацааны өмнө тухайн саналтай ижил агуулга бүхий саналыг хэлэлцэж байсан, эсхүл тухайн санал нь Үндсэн хуулийн зарчим болон олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу Эстони Улсын хүлээсэн үүрэгтэй нийцэхгүй байх тохиолдолд). Энэ тохиолдолд Хороо санал ирүүлсэн хүмүүст татгалзах үндэслэлээ тайлбарлах ёстой.
- бусад аргаар шийдвэрлэх.

<sup>6</sup> Энэ зөвлөл нь парламентын дарга, дэд дарга нараас бүрддэг., Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act, § 12. Membership of the Board of the Riigikogu, <https://www.riigiteataja.ee/en/eli/518112014003/consolide>

<sup>7</sup> Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act, Chapter 18<sup>2</sup>. Rules for proceedings on collective proposals, §152<sup>12</sup>. Conduct of proceedings on the proposal, <https://www.riigiteataja.ee/en/eli/518112014003/consolide>

<sup>8</sup> Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act, Chapter 18<sup>2</sup>. Rules for proceedings on collective proposals, §152<sup>13</sup>. Decisions concerning the proposal, <https://www.riigiteataja.ee/en/eli/518112014003/consolide>

## **2.2.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс**

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (Их Британи)-ын Парламент нь иргэдийн өмнөөс Засгийн газрын үйл ажиллагааг хянах, шалгах, үр нөлөө бүхий хууль тогтоомж боловсруулах, батлах болон өдөр тутмын амьдрал дахь томоохон асуудлаар мэтгэлцэх, шийдвэр гаргах чиг үүрэгтэй ажилладаг. Энэ хүрээнд иргэдээс цахим өргөдөл хүлээн авах, түүнийг хэлэлцэх үүрэгтэй. Олон нийтээс Парламентын Нийтийн танхим болон Засгийн газарт цахим өргөдөл гаргах, зургаан сарын хугацаанд 10.000 буюу түүнээс дээш гарын үсэг цугларсан цахим өргөдөлд Засгийн газар бичгээр хариу өгөх, түүнийг Парламентын Өргөдлийн хороо хэлэлцэж, мэтгэлцэнэ.<sup>9</sup>

### ***Парламентаар авч хэлэлцэх иргэдийн саналын тооны босго***

Их Британийн Засгийн газар болон Парламент (House of Commons) нь цахим өргөдөл гаргах тусдаа платформ ажиллуулдаг бөгөөд энэ нь Засгийн газар болон Парламентын эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх боломжтой асуудлуудын талаар өргөдөл гаргах боломжтой платформ юм.

Цахим өргөдөл гаргахад зөвхөн Их Британийн иргэд болон оршин суудаг иргэд өргөдөл гаргах боломжтой. Тухайн өргөдөл гаргагчийг дэмжсэн 5 хүн байх бөгөөд өргөдөл гаргахдаа тэдний цахим хаягийг оруулснаар баталгаажна.

Мөн өргөдөл нь Их Британийн Засгийн газар болон Парламентын хариуцсан асуудал байх бөгөөд тэдний баталсан хууль тогтоомжийг шүүмжилсэн, өөрчлөхийг шаардсан байх боломжтой.

Их Британийн Парламент нь Өргөдлийн хороотой бөгөөд олон нийтээс ирүүлсэн цахим өргөдлийг хүлээн авч шаардлага хангасан тохиолдолд шийдвэрлэх дараагийн шат руу шилжүүлнэ. Өргөдлийн хороо нь Парламентын гишүүдээс бүрддэг.

Цахим өргөдөл нь 10.000 хүний гарын үсэг цугларсан тохиолдолд Засгийн газар өргөдөлд хариу хүргүүлнэ.

100.000 хүний гарын үсэг цугларсан тохиолдолд тухайн асуудлыг Парламент авч хэлэлцэнэ. Хэдийгээр гарын үсэг цугларсан ч гэсэн Парламентын хэлэлцүүлэгт оруулахаар төлөвлөсөн байвал тухайн асуудлыг өргөдөл байдлаар хэлэлцүүлэгт оруулахгүй байж болно.

<sup>9</sup> <https://www.zms.mn/a/81961>



Шаардлагатай тохиолдолд өргөдөл гаргагч иргэдийн төлөөлөлтэй сонсгол хийх боломжтой.

### **Өргөдөл гаргах үйл явц:<sup>10</sup>**

- Их Британийн иргэд болон оршин суугчид Их Британийн Засгийн газар, Парламентын сайтаар дамжуулж өргөдөл гаргана;
- өргөдлийг дэмжих таван хүний санал байна;
- өргөдлийг шалгаад, өргөдөлд тавигдах шаардлагыг хангаж байвал нийтэлнэ;
- гаргасан өргөдөлд Их Британийн иргэд болон оршин суугчид дэмжиж, гарын үсэг зурах бөгөөд зөвхөн нэг удаа гарын үсэг зурах боломжтой;
- өргөдлийн хороо бүх өргөдлийг хянана. Тэд анхаарал татсан асуудалтай өргөдлийг Засгийн газар, эсхүл парламентад танилцуулж арга хэмжээ авахыг шаардах эрхтэй;
- гаргасан өргөдөлд 10.000 хүн гарын үсэг зурснаар Их Британийн Засгийн газар болон парламентаас бичгээр хариу хүргүүлнэ;
- гаргасан өргөдөлд 100.000 хүн гарын үсэг зурснаар тухайн асуудлыг парламентаар хэлэлцүүлэх болдог.

### **Иргэдийн саналыг парламентын хэлэлцүүлэгт оруулах, хууль тогтоомжид тусгах процедур**

Өргөдлийн хороог Нийтийн танхимаас байгуулах бөгөөд [petition.parliament.uk](http://petition.parliament.uk) сайтад ирүүлсэн цахим өргөдлүүд болон Парламентад ирүүлсэн олон нийтийн (цаасан) өргөдлийг судлах, шийдвэрлүүлэх үндсэн үүрэгтэй. Үүнд дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана:<sup>11</sup>

- Засгийн газар болон бусад холбогдох хүн, байгууллагаас өргөдөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг өргөдөл гаргагчид бичгээр хүргүүлэх;
- Засгийн газар болон бусад холбогдох хүн, байгууллагатай өргөдөл гаргагчийг биечлэн уулзуулж, дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлэх;
- Өргөдлийн дагуу арга хэмжээ авахыг Засгийн газар болон бусад төрийн байгууллагад бичгээр шаардлага хүргүүлэх;
- Өргөдөл гаргасан асуудлыг судалж үзэхийг парламентын бусад хорооноос хүсэх;
- Нийтийн танхимд хэлэлцүүлэхээр өргөдөлд тусгагдсан асуудлыг дэвшүүлэх.

<sup>10</sup> <https://petition.parliament.uk/help>

<sup>11</sup> <https://committees.parliament.uk/committee/326/petitions-committee/role/>

Өргөдлийн хороо нь the Backbench Business Committee-д танхимын мэтгэлцээн хийх зөвшөөрөл авна.

100.000 гарын үсэг цуглуулсан олон нийтийн өргөдлийг Парламентын Westminster Hall Chamber хуралдааны үеэр хэлэлцэх асуудлуудад оруулах ёстой. Мөн цөөн гарын үсэгтэй хэдий ч танхимын гишүүдийн дийлэнх дэмжсэн тохиолдолд хэлэлцүүлэгт оруулах боломжтой.

Олон нийтээс ирүүлсэн цахим өргөдлийг Парламентын гишүүн танхимд танилцуулах боломжтой хэдий ч тухайн өргөдлийг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

Парламентын гишүүн танхимд өргөдөл танилцуулах хоёр арга бий:

- Албан ёсны танилцуулга: Танхимын хуралдааны үеэр өргөдлийн тухай ерөнхий мэдээллийг танилцуулж Парламентын даргын нарийн бичигт хүлээлгэн өгөх буюу саналын хайрцагт хийх;
- Албан бус танилцуулга: Танхимын хуралдаанд танилцуулах шаардлагагүй саналын хайрцагт шууд хийх.

House of Lords танхимд өргөдөл гаргах нь ховор бөгөөд хэрэв шаардлагатай бол танхимын гишүүдэд хандан өргөдөл гаргах боломжтой.<sup>12</sup>

### 2.3. Канад Улс

Иргэд нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн аливаа асуудалд анхаарал хандуулах, шийдвэрлэхийг Нийтийн танхим, Канадын засгийн газар, сайд, парламентын гишүүдээс хүссэн, эсхүл мөнхүү үр дагавартай шийдвэр, үйл ажиллагаагаа зогсоохыг шаардсан өргөдөл, хүсэлтийг цахим хэлбэрээр илгээж болно. Олон нийтийн дэмжлэг авах зорилгоор тухайн өргөдлийг веб сайтад нийтлэхэд хамгийн багадаа 5, ихдээ 10 хүн тус өргөдлийг дэмжсэн байх шаардлагатай. Өргөдлийг журамд заагдсан шаардлага, шалгуурыг хангуулж, Нийтийн танхимын гишүүнд гаргана. Тухайн гишүүн өргөдлийг цахим хэлбэрээр нийтлэхийг зөвшөөрсний дараа өргөдөл гаргагчийн сонгосон хугацаа (30, 60, 90, 120 хоног)-аар веб сайтад байршуулж дэмжигчдийн гарын үсэг цуглуулна. Хугацаа дуусахад 500-аас<sup>13</sup> доошгүй хүчинтэй гарын үсэг цугларсан тохиолдолд өргөдлийг нийтлэх зөвшөөрөл өгсөн гишүүнд тусгай зөвшөөрөл олгодог. Ингэснээр тухайн өргөдлийг Танхимд танилцуулж, хэлэлцүүлэх эрхтэй болдог. Танхимын хуралдаанаар тухайн өргөдлийг хэлэлцүүлсэн танилцуулга, хэлэлцүүлгийн тэмдэглэл, гаргасан шийдвэрийг өргөдөл гаргагч, дэмжигч нарт цахим хэлбэрээр хүргүүлдэг байна.

<sup>12</sup> <https://committees.parliament.uk/committee/326/petitions-committee/news/99341/committee-opens-consultation-on-its-working-methods/>

<sup>13</sup> <https://petitions.ourcommons.ca/en/Home/AboutContent?guide=PIElectronicGuide>

## ***Парламентаар авч хэлэлцэх иргэдийн саналын тооны босго***

***Цахим өргөдөлд саналаа өгөхдөө*** өргөдлийн цахим хуудас руу орж түлхүүр үг, сэдэв, өргөдлийн дугаар, эсхүл тухайн асуудлаар эрх олгосон парламентын гишүүний нэрээр хайлт хийж өөрийн сонгосон цахим өргөдөлд саналаа өгнө. Цахим өргөдөлд саналаа өгөхөд тухайн хүн дараах шаардлагыг хангасан байна.

- Канад Улсын иргэн, эсхүл оршин суугч байх ёстой;
- Канадын Засгийн газар, эсхүл Канадын Парламенттай холбоотой и-мэйл хаяг, эсхүл IP хаягтай төхөөрөмжийг ашиглаж болохгүй;
- тухайн цахим өргөдөл гаргагчийн хувийн мэдээллийг ашиглахыг зөвшөөрөх ёстой. Учир нь парламентын танхим өргөдөл гаргагчийн өргөдлийг баталгаажуулахын тулд тодорхой мэдээллийг авч шалгадаг байна.

***Цахим өргөдөл гаргах, илгээх:*** Цахим өргөдөл гаргах эхний алхам бол өргөдлийн вэбсайт дээр бүртгэл үүсгэнэ. Өргөдөл гаргагчийн хувьд холбоо барих мэдээллээ өгөх, Канадын иргэншил, эсхүл оршин суух газраа баталгаажуулж нэр, амьдарч буй хот, муж хаяг, утасны дугаар, цахим хаягаар бүргүүлнэ. Өргөдөл гаргагч өөрийн нэр дээр зөвхөн нэг цахим өргөдөл гаргана. Цахим өргөдөл гаргагч нь дэвшүүлж буй асуудлын хүрээнд тохирох харьяа байгууллагад хаяглан, 250 үгээс хэтрэхгүй өргөдөл гаргах ёстой. Үүнд:


- Нийтийн танхим;
- Канадын Засгийн газар;
- Салбар хариуцсан сайд;
- Парламентын гишүүн.

Цахим өргөдлийн агуулгын хувьд ойлгомжтой ёс бус үг хэллэг агуулагдаагүй, хэн нэгний нэр хүндэд халдсан буруу ташаа мэдээлэл оруулахыг хориглодог ба Англи, эсхүл Франц хэл дээр байна.

Өргөдөл нь шүүхийн шатанд байгаа асуудал, тухайлбал, шүүхээр хянан шийдвэрлэх асуудал, эсхүл одоо шүүх дээр байгаа асуудалд хамаарч болохгүй.

Ижил төстэй цахим өргөдөл гаргасан иргэдийн хувьд нэгэн зэрэг ижил сэдэв дээр гарын үсэг цуглуулах боломжгүй ба өмнөх цахим өргөдөл хаагдахыг хүлээх шаардлагатай.

*Зураг 8. Доорх зурагт цаасан болон цахим өргөдөл гаргах үе шатуудыг үзүүлсэн болно*



***Иргэдийн саналыг парламентын хэлэлцүүлэгт оруулах, хууль тогтоомжид тусгах процедур***

Өргөдлийн төслийг боловсруулж өргөдлийн цахим хуудас руу оруулахад хамгийн багадаа 5, ихдээ 10 дэмжигч байх ба эдгээр хүмүүс Канад Улсын иргэн, оршин суугч байх ёстой ба шаардлагын дагуу хувийн мэдээллээ өгнө. Хэрэв өргөдөл шаардлагуудыг хангаж цахим хуудсанд нийтлэгдсэн тохиолдолд дэвшүүлсэн саналаас хамаарч 30, 60, 90, эсхүл 120 хоногийн хугацаатай санал буюу гарын үсэг цуглуулах ба 500-аас доошгүй хүчинтэй гарын үсэг цугларвал өргөдлийн бичиг хэргийн ажилтан өргөдлийг парламентын гишүүн, нийтийн танхим, салбар хариуцсан сайд руу илгээнэ. Ингэснээр гишүүн чуулганд танилцуулж өргөдөл гаргагчид цахим шуудангаар мэдээлдэг. Хэрэв цахим өргөдөл хаагдах өдөр хүртэл хамгийн бага босго гарын үсэг цуглуулаагүй бол цаашид үргэлжлэхгүй хаагдах ба саналын дүн зэрэг бүх мэдээлэл онлайнаар харагдах болно.

**Цахим өргөдлийн хариу:** Парламентын Доод танхим цахим өргөдөлтэй холбоотой асуудлыг хэлэлцэж, Засгийн газраас хуанлийн 45<sup>14</sup> хоногийн дотор өргөдлийн хариуг өгөхийг шаарддаг. Хэрэв тухайн өдөр чуулган хуралдаагүй бол дараагийн хуралдаанд хариуг нь танилцуулах ёстой. Засгийн газар өргөдлийн хариуг хуанлийн 45 хоногийн дотор өгөөгүй тохиолдолд Засгийн газар хариу өгөөгүй асуудлыг хүсэлт гаргасан Парламентын гишүүний томилсон байнгын хороонд автоматаар шилжүүлдэг. Хорооны дарга ийм санал гаргаснаас хойш тав хоногийн дотор уг асуудлыг хэлэлцэхээр хурлаа хийх ёстой. Өргөдөл гаргагч, дэмжигчид, гарын үсэг зурсан хүмүүст парламентын гишүүн цахим өргөдлийг чуулганд хэлэлцсэн талаар цахим шуудангаар мэдэгдэнэ. Мөн хуулбарыг өргөдлийн эх хуудасны хамт өргөдлийн вэбсайтаас авах боломжтой.

Цахим өргөдлийн хугацаа сунгахад парламентын хоёр чуулганы хоорондох хугацаанд үргэлжлүүлэн өргөдөл гаргаж, гарын үсэг цуглуулж болно. Цахим өргөдлийн дагуу хангалттай санал авсан хэлэлцэх асуудал заавал дэмжигдэх албагүй ба тухайн асуудлыг хэлэлцэж, холбогдох яам, мэргэжлийн байгууллагын судалгаанд тулгуурлан шийдвэр гарна. Өргөдөл гаргагч, дэмжигчид, гарын үсэг зурсан хүмүүсийн хувийн мэдээлэл үнэн зөв байх ёстой. Худал мэдээлэл ашиглах, өгөхийг хориглох ба зөрчсөн тохиолдолд цахим өргөдлийн бүртгэлийг хаах, гарын үсгийг хүссэн үедээ хасах боломжтой. Дараах тохиолдлуудад цахим өргөдлийг хүчингүй болгоно. Үүнд:

- хуурамч мэдээлэл ашиглах;
- гүтгэлэг, хууран мэхлэх шинж чанартай мэдэгдэл;
- шүүхийн шийдвэрээр хамгаалагдсан мэдээлэл ;
- хуулийн хэрэг хянан шийдвэрлэхэд хамаарах асуудал;
- шаардлагагүй, эсхүл зохисгүй асуудал;
- Тухайн салбарын сайд, парламент, эсхүл шүүхийг үл хүндэтгэсэн, эсхүл доромжилсон үг хэллэг.

Цахим өргөдөл гаргагч нь товлосон хугацаа дуусахад 500-аас<sup>15</sup> доошгүй хүчинтэй гарын үсэг цугларсан тохиолдолд өргөдлийг нийтлэх зөвшөөрөл өгсөн гишүүнд тусгай зөвшөөрөл олгодог. Ингэснээр тухайн өргөдлийг Танхимд танилцуулж, хэлэлцүүлэх эрхтэй болдог. Танхимын хуралдаанаар тухайн өргөдлийг хэлэлцүүлсэн танилцуулга, хэлэлцүүлгийн тэмдэглэл, гаргасан шийдвэрийг өргөдөл гаргагч, дэмжигч нарт цахим хэлбэрээр хүргүүлдэг байна.

<sup>14</sup> [https://www.ourcommons.ca/procedure/procedure-and-practice-3/ch\\_22\\_2-e.html](https://www.ourcommons.ca/procedure/procedure-and-practice-3/ch_22_2-e.html)

<sup>15</sup> <https://petitions.ourcommons.ca/en/Home/AboutContent?guide=PIElectronicGuide>

## 2.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

### *Парламентаар авч хэлэлцэх иргэдийн саналын тооны босго*

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Парламент нь цахим өргөдөл ашиглан олон нийтийн асуудлыг хөндсөн өргөдөл гаргах, түүнийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх боломжийг бий болгож өгсөн.

Олон нийтийн өргөдөл нь ижил төстэй өргөдлийг нэгтгэсэн байх ба гол агуулга, хүсэлт нь нийтийн ашиг сонирхлын үндсэн дээр үүссэн тодорхой шаардлагыг хангасан санал, гомдол байх ёстой. ХБНГУ-ын Парламентын Өргөдлийн хороо нь олон нийтээс хууль тогтоомжийн талаар хөндөгдөж буй хамгийн өргөн хүрээний асуудлуудыг нэгтгэн өргөдөл хүлээн авах бөгөөд тухайн асуудлыг платформдоо нийтлэн иргэдийн саналыг цуглуулна.

Олон нийтийн өргөдлийг дараах тохиолдолд хүлээн авахгүй байх боломжтой:

- хувийн хүсэлт, гомдлыг агуулсан шинжтэй;
- герман хэл дээр бичигдээгүй;
- хүний нэр төрд халдсан;
- худал, гуйвуулсан мэдээлэл агуулсан;
- Үндсэн хуулийн дэг журам, эрүүгийн гэмт хэрэг, захиргааны зөрчил гаргах магадлалтай;
- парламентын ёс суртахуунд үл нийцсэн үг хэллэг ашигласан зэрэг тохиолдолд өргөдлийг хүлээн авахгүй байж болно.

Платформд нийтлэгдсэн олон нийтийн өргөдөлд 50.000 гарын үсгийг 4 долоо хоногийн хугацаатай<sup>16</sup> цуглуулах бөгөөд хэрэв гарын үсэг цуглуулах хугацаанд бодитой хэлэлцүүлэг хийгдээгүй, эсхүл шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд хугацаанаас нь өмнө өргөдлийг хааж болно.<sup>17</sup> Гарын үсэг цугларч дууссан олон нийтийн өргөдлийг, өргөдөл шийдвэрлэх ерөнхий процедурын дагуу шийдвэрлэнэ.<sup>18</sup>

### *Иргэдийн саналыг парламентын хэлэлцүүлэгт оруулах, хууль тогтоомжид тусгах процедур*

ХБНГУ-ын E-Petition буюу цахим өргөдөл гаргах систем нь 2005 онд Бундестагийн цахим өргөдлийн платформ нэртэйгээр анх бий болсон юм.

<sup>16</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.1-ийн хавсралт 8

<sup>17</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.1-ийн хавсралт 9.3

<sup>18</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.1-ийн хавсралт 10

ХБНГУ-ын Үндсэн хуульд заасны дагуу иргэн бүр дангаараа, эсхүл нэгдэж эрх бүхий байгууллагад өргөдөл гаргах эрхтэй гэж заасан байдаг. Үүнтэй холбоотойгоор 1975 онд ХБНГУ-ын Парламентад хандсан өргөдөл, гомдлыг хянан Үндсэн хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд шийдвэрлэх үүрэгтэй Өргөдлийн хороог байгуулсан.

ХБНГУ-ын Парламентын Өргөдлийн хороо нь Холбооны Засгийн газрын хариуцах чиглэлээр (жишээлбэл, холбооны хууль тогтоомжийн талаарх хүсэлт, холбооны эрх бүхий байгууллагад гомдол гаргасан тохиолдолд) асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй.

Парламентад ирүүлсэн өргөдөл шийдэх ерөнхий процедур нь дараах байдлаар явагдана:<sup>19</sup>

Өргөдлийн хороо олон нийт болон хувь хүнээс ирсэн өргөдлийг хүлээн авч, тухайн өргөдлийн шаардлага хангасан эсэхийг шалган<sup>20</sup> шийдвэрлэх боломжтой дараагийн алхам руу шилжүүлнэ. Мөн шаардлагатай тохиолдолд өргөдлийн нэмэлт санал авах, материалыг дахин бэлдүүлэх арга хэмжээ авах боломжтой.<sup>21</sup>

Шаардлага хангасан өргөдлийг Өргөдлийн хороо ХБНГУ-ын Парламентын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах бөгөөд тухайн өргөдөл нь Холбооны хууль тогтоомжийн талаарх хүсэлт, холбооны эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны талаарх гомдлын талаар байх ёстой. Холбооны хууль тогтоомжийн харьяалалд хамаарахгүй бусад өргөдөл, гомдлыг тухайн Мужийн өргөдлийн хороогоор шийдвэрлэнэ.<sup>22</sup>

Парламентын гаргасан шийдвэрийн дагуу Холбооны Засгийн газар, эсхүл Үндсэн хуулийн өөр бусад байгууллагад шилжүүлэхийг шаардаж болно.

Эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу Холбооны Засгийн газар Парламентаас гаргасан шийдвэрийг эсэргүүцэх эрхтэй. Холбооны Засгийн газар өргөдлийг дахин авч хэлэлцэн, тэдгээрийг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.

Өргөдөл шийдвэрлэх явцын мэдээллийг өргөдөл гаргагчид цаг тухайд нь мэдэгдэх шаардлагатай. Холбооны Парламентын хэлэлцүүлгийн явцад олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх болон сонсгол явуулах шаардлагатай эсэхийг Өргөдлийн хороо шийднэ.<sup>23</sup>

<sup>19</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7-р бүлэг

<sup>20</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.1, 7.2, 7.3

<sup>21</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.12, 7.13

<sup>22</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.5

<sup>23</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.1-ийн хавсралт 11

Өргөдлийн эцсийн шийдвэр буюу үр дүнг олон нийтийн цахим сүлжээгээр мэдээлнэ.<sup>24</sup> Цахим өргөдөл гаргах платформ нь ХБНГУ-ын Парламентын цахим хуудастай хамт буюу нэг платформ ашигладаг. Мөн Өргөдлийн хороо нь жил бүр Парламентад үйл ажиллагааныхаа тайланг танилцуулах ёстой байдаг.

## 2.5.Шинэ Зеланд Улс

### ***Парламентаар авч хэлэлцэх иргэдийн саналын тооны босго***

Шинэ Зеланд Улсын Парламентаар хэлэлцэх хуулийн төсөл, төрийн бодлого, орон нутгийн болон хувийн асуудлаар Төлөөлөгчдийн танхимд (парламент) өргөдөл гаргаж болно.<sup>25</sup>

Өргөдлийг цаасан, цахим, хабрид (дээрх 2 хэлбэрээр зэрэг гаргах) гэсэн 3 хэлбэрээр гаргаж болно.

Цахим хэлбэрээр өргөдөл гаргахад [www.parliament.nz/en/pb/petitions/](http://www.parliament.nz/en/pb/petitions/) хуудсанд хандана. Өргөдөлд өөрийн овог, нэр цахим шуудангийн хаяг, утасны дугаарыг заавал бичнэ. Цахим өргөдөл гаргасан өргөдөл гаргагчийн нэрийг парламентын цахим хуудаснаас харах боломжтой.

Өргөдөл гаргагч нь хувь хүн, байгууллага байна.<sup>26</sup> Өөрөөр хэлбэл насанд хүрсэн байх, Шинэ Зеландын иргэн байх, эрх зүйн чадвар чадамжтай байхыг шаардахгүй.

***Саналын тооны босго:*** Шинэ Зеланд Улсад иргэдийн өргөдлийг парламентаар авч хэлэлцэх саналын тооны босго тогтоогоогүй. Өөрөөр хэлбэл нэг гарын үсэгтэй байсан ч тухайн өргөдлийг парламентаар хэлэлцэх боломжтой.

***Гарын үсэг цуглуулах:*** Өргөдөл гаргагч өөрийн өргөдөлд бусад иргэдийн гарын үсэг цуглуулах эсэхийг өөрөө шийдэх ба энэ тухай өргөдлөө цахим хуудсанд байршуулахдаа гарын үсэг цуглуулах хугацаагаа оруулна.

***Иргэдийн саналыг парламентын хэлэлцүүлэгт оруулах, хууль тогтоомжид тусгах процедур***

***Өргөдөл танилцуулах:*** Өргөдөлд гарын үсэг цуглуулж дууссаны дараа парламентад танилцуулахад бэлэн болно.

<sup>24</sup> ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.1-ийн хавсралт 12

<sup>25</sup> <https://petitions.parliament.nz/>

<sup>26</sup> <https://www.parliament.nz/en/get-involved/have-your-say/guide-for-petitions/>



Цахим хэлбэрээр гаргасан өргөдлийг Өргөдлийн хорооны ажилтан хүлээн авч баталгаажуулна. Хэрэв өргөдөл хэлбэрийн болон агуулгын шаардлага хангаагүй бол Өргөдлийн хорооны ажилтнууд өргөдөл гаргагчид энэ тухай тайлбарлаж, өргөдлийг хэрхэн эмх цэгцтэй болгох талаар зөвлөгөө өгнө. Цахим өргөдөлд гарын үсэг зурах хугацаа хаагдсаны дараа Сонгон шалгаруулалтын хороогоор хэлэлцэхийн өмнө өргөдлөө парламентад танилцуулах парламентын гишүүнийг өргөдөл гаргагч олно.

**Парламентын гишүүнд хандах:** Парламентын аль ч гишүүнд хандан өөрийн өргөдлийг парламентад хэлэлцүүлэхээр оруулахыг хүсэж болно. Парламентын гишүүдтэй хэрхэн холбогдох тухай дэлгэрэнгүй мэдээллийг <http://bit.ly/ContactMP-NZ> парламентын цахим хуудсаар авах боломжтой. Иргэдээс сонгогдсон төлөөлөгчийн хувьд аль ч гишүүн тухайн өргөдлийг парламентаар хэлэлцүүлэхээр оруулж болдог. Гэхдээ гишүүд өргөдөл гаргахаас татгалзаж болдог байна.

Аль нэгэн гишүүн парламентад өргөдөл гаргахыг зөвшөөрсний дараа дараах алхмуудыг хийнэ:

- 1) цахим өргөдлийн хувьд гишүүн өргөдөл гаргах хүсэлтэй тухайгаа Өргөдлийн хорооны ажилтнуудад бичгээр мэдэгдэнэ.
- 2) гишүүн чуулганы хуралдаантай өдөр 13.00 цагаас өмнө дээрх хүсэлтээ гаргана. Энэ нь 14.00 цагаас өмнө өргөдлийг хянах хугацаа олгодог. Харин чуулганы хуралдаангүй өдөр ажлын аль ч цагт гаргаж болно.
- 3) Өргөдлийн хорооны ажилтнууд гишүүний өргөдөл гаргах хүсэлтийг баталгаажуулсны дараа өргөдлийг албан ёсоор танилцуулна.
- 4) Төлөөлөгчдийн танхимын нарийн бичгийн дарга парламентын дараагийн хуралдаанд өргөдлийн танилцуулгыг хийнэ.

Өргөдлийн хороогоор хэлэлцэх:<sup>27</sup> Өргөдлийн хороо өргөдлийг хэлэлцэхдээ өргөдлийн дагуу тавьсан асуудлын талаар нэмэлт мэдээлэл, нотлох баримт цуглуулна. Хороо өргөдөл гаргагчаас бичгээр мэдүүлэг өгөхийг хүсэх, хороонд биечлэн, эсхүл утсаар мэдээлэл өгөхийг хүсдэг. Хороо нь холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас нотлох баримт, хариулт авна.

Парламентын бусад хороо тухайн өргөдөлд холбогдох мэргэжил, туршлагатай бол Өргөдлийн хороо өргөдлийг Сонгон шалгаруулах хороонд шилжүүлэх бөгөөд Өргөдлийн хороо нь өргөдлийн шийдвэрлэлтэд хяналт тавих үүрэгтэй хэвээр байна. Мөн уг өргөдлийг тухайн сонгон шалгаруулах хороотой хамтран хэлэлцэхээр шийдвэрлэж болно.

<sup>27</sup> <https://www.parliament.nz/en/get-involved/have-your-say/guide-for-petitions/>

Өргөдлийн хороо мөн өргөдлийг сайдад шууд шилжүүлж, энэ тухай хариу өгч болно. Сайд өргөдлийн хариуг ажлын 60 хоногийн дотор нийтэлж, танилцуулна.

Өргөдлийн хороо нь өргөдлийг хэлэлцэхдээ:

- ижил төстэй өргөдлийг хамтад нь хэлэлцэх;
- Омбудсмэнээс тусламж хүсэх;
- парламентаар хэлэлцүүлэхээр өргөдлөө дэвшүүлэх;
- өргөдөлтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэж, парламентад мэдээлэх үүрэгтэй.

**Өргөдлийн талаар олон нийтэд мэдээлэх:** Хороо өргөдлийг хэлэлцсэний дараа парламентад өгөх дүгнэлтээ тайлагнана. Хорооны тайланг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Хорооны тайланд өргөдлийн дагуу тавьсан асуудлын талаар хийсэн шалгалтын хураангуй мэдээллийг оруулдаг. Заримдаа тайланд өргөдлийн дагуу хорооноос авахыг хүсэж буй арга хэмжээ, алхмуудын талаар Засгийн газарт өгөх зөвлөмжийг багтаана. Бусад тохиолдолд хороо ямар нэгэн зөвлөмжгүй тайлан гаргаж болно.

Хорооноос Засгийн газарт зөвлөмж бүхий тайланг танилцуулахад Засгийн газар ажлын 60 хоногийн дотор хариу өгнө. Засгийн газрын хариуг парламентын хэвлэлд нийтэлнэ.

Хариу мэдэгдэх: Өргөдлийн хорооны ажилтнууд өргөдлийг хэлэлцэж дуусаад өргөдөл гаргагчтай холбогдоно. Тэд цахим хуудас дээрх хорооны тайлангийн холбоосыг өргөдөл гаргагчид цахим шуудангаар илгээнэ. Мөн хороо өргөдөлтэй холбоотой нотлох баримт, хариуг нийтэлнэ.

Хэрэв өргөдлийн талаарх хорооны тайланд Засгийн газарт өгөх зөвлөмж байгаа бол хороо хариу ирэх хугацааг өргөдөл гаргагчид мэдэгдэж, парламентад танилцуулсны дараа хариуны хуулбарыг өргөдөл гаргагчид илгээнэ.

**Өргөдлийг хасах:** Өргөдөл гаргагч цахим өргөдөлд гарын үсэг цуглуулахаар шийдсэн ба гарын үсэг зурах товлот хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор өөрийн өргөдлийг парламентаар хэлэлцүүлэх парламентын гишүүнийг олох ёстой. Хэрэв дээрх хугацаанд өргөдлийг парламентад хэлэлцүүлэх гишүүн олдоогүй бол тухайн өргөдлийг цахим хуудаснаас хасна.

## **Гурав. ПАРЛАМЕНТЫН E-PETITION СИСТЕМИЙН ЗАРИМ АСУУДЛУУД**

Сүүлийн үед иргэд, олон нийтийн зүгээс төрийн бодлого, шийдвэрт сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлэх, шууд ардчиллын зарчмаар хууль тогтоох, төрийн бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож улс төрийн оролцоогоо нэмэгдүүлэх, парламентаар батлан гаргаж байгаа хууль тогтоомжид санаа бодлоо тусгуулах хүсэл эрмэлзэл илт нэмэгдэж байна. Энэхүү хэрэгцээ шаардлагад тулгуурлан дэлхийн улс орнуудын Парламент, Засгийн газраас иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах цахим систем буюу “E-petition” системийг хөгжүүлж байна.

E-petition систем хөгжүүлэлтийн хүрээнд *парламент ба олон нийтийн харилцааны* асуудал, тухайлбал, парламентын зүгээс иргэдийн өгсөн саналыг хэрхэн хүлээн авч, хэрхэн шийдвэр гаргах процесст тусгах арга механизмыг тодорхойлох асуудал чухлаар тавигдаж байна. Учир нь иргэдийг төлөөлөх дээд байгууллага болохын хувьд аливаа улс орны парламент хууль тогтоох үйл ажиллагаандаа олон нийтийн оролцоог хангах, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн хууль тогтоомжийг батлан гаргах нь ардчилсан парламентын зарчмуудын нэг юм. Гэвч цахим өргөдлийн системээр дамжуулан иргэдийн саналыг авах нь нэг хэрэг, хамгийн гол нь тэрхүү саналыг парламент нь хэрхэн авч хэлэлцэх процедурыг тодорхойлох нь дэлхийн улс орнуудын парламентад чухал ач холбогдолтойд тооцогдож байна.

E-petition системийн 2 янзын хэлбэр байна. (*Парламент дангаараа ажиллуулах, Засгийн газартайгаа хамтран ажиллуулах*)

### ***Жишээ болгон Английн Парламентын туршлагыг онцлон авч үзье.***

2015 онд Английн Парламент Засгийн газартайгаа хамтран E-petition системийг нэвтрүүлсэн. Өмнө нь Английн Засгийн газар E-petition системийг нэлээд олон жил ажиллуулсан туршлагатай байсан бол парламентын хувьд энэ нь шинэ систем төдийгүй, Засгийн газартайгаа хамтран ажиллуулж эхэлсэн гэдгээрээ онцлогтой байлаа.

Уг системийн шинэчлэлийн гол өөрчлөлт нь Парламентын Өргөдлийн хороог уг системийн үйл ажиллагаанд хяналт тавих, өргөдөл гаргагчидтай харилцах, цахим өргөдөлд хариу өгөх илүү тодорхой сувагтай болгож, 100.000 хүний гарын үсэг цугларсан тохиолдолд асуудлыг Өргөдлийн хороо авч хэлэлцдэг болсон явдал байв.

Засгийн газрын хариуцан ажиллуулж байсан өмнөх цахим системд ирүүлсэн өргөдөл хүсэлтийг Засгийн газар дангаараа шийдвэрлэж чадахгүй, амласан амлалтаа биелүүлж чадахгүй байгаад олон нийтийн

урам хугарч, урт хугацаандаа иргэдийн зүгээс улс төрийн тогтолцоонд итгэх итгэл улам буурах хандлагатай байсан нь энэхүү системийн шинэчлэлтийг хийхэд хүргэсэн. 2015 онд шинээр нэвтрүүлсэн цахим өргөдлийн систем нь өргөдөл гаргагч олон нийтийн төлөөлөл болон тэднийг төлөөлөн сонгогдсон парламентын гишүүд хоорондын харилцааг мэдэгдэхүйц сайжруулах боломжтой болгосон гэж үздэг.

Түүнээс хойш цахим өргөдлийн систем нь парламентын үйл ажиллагаанд тодорхой хувь нэмэр оруулж, Өргөдлийн хорооноос Твиттер гэх мэт олон нийтийн мэдээллийн олон сувгуудыг ашиглан олон нийтийн оролцоог хангах арга механизмуудыг бий болгосон. Гэвч энэхүү мэдээллийн шинэ тогтолцоо нь олон нийт болон парламентын гишүүдийн хоорондын харилцааг хэр зэрэг сайжруулсан, тухайлбал цахим систем нь олон нийтээс тавьсан асуудлыг парламентаар авч хэлэлцэх үйл явцад ахиц дэвшил гаргахуйц нөлөө үзүүлж буй эсэх нь тодорхойгүй байгаа юм. Гэсэн хэдий ч Дэлхийн үнэ цэний судалгаа (World values survey, WVS, 2017) (WVS, 2017) нь Их Британийн Аудитын байгууллагаас хийсэн судалгаагаар эрх бүхий албан ёсны байгууллагуудаас олон нийттэй харилцах харилцаагаа бэхжүүлэхийн тулд онлайн өргөдлийн системийг ашиглаж байгаа явдал нь иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чухал арга хэрэгсэлд тооцогдож байна. 20-р зууны сүүлчээр онлайн өргөдлийн PetitionOnline, Change.org зэрэг албан бус цахим өргөдлийн платформууд ашиглагдаж байсан бол орчин үед E-petition зэрэг илүү боловсронгуй системүүд ашиглагдаж байна.

Эрх бүхий төлөөллийн байгууллагадаа өргөдөл, хүсэлт гаргах нь олон зууны туршид байсан үзэгдэл хэдий ч төлөөллийн ардчиллын институцууд бие даан өргөжихийн хэрээр иргэдийн санаа бодлыг сонсох нь багасаж, энэ хэрээр иргэд улс төрийн шийдвэрт эргэлзэх, санаа бодлоо хүргэхийг эрмэлзэх болсон. Тиймээс иргэд, олон нийтийн санаа бодлыг хүлээн авах боловсронгуй систем болох онлайн өргөдлийн системүүд үүсэн бий болж эхэлсэн байна. Цахим өргөдлийн системийг анх 2004 онд Шотландын Парламент нэвтрүүлсэн бол 2005 онд Германы Бундестаг, 2015 онд Их Британийн Парламент, 2016 онд Ирландын Парламент нэвтрүүлжээ.

Гэсэн хэдий ч улс орнуудын нэвтрүүлсэн цахим өргөдлийн системүүдийн хэрэглээнд ялгаа бий. Тухайлбал, тухайн улс орны парламентад Өргөдлийн хороо бий юу, өргөдөл гаргагчийн хүсэлтийг хэрхэн авч үздэг вэ, цахим системээр ирүүлсэн өргөдлийг парламентын хэлэлцүүлэг, сонголд оруулах эрх зүйн механизм бий юу гэх мэтчилэн парламент ба иргэдийн хоорондын харилцааны асуудлуудыг хэрхэн шийдвэрлэснээрээ ялгаатай байна. Тиймээс парламентын зүгээс E-petition системийг практикт хэрхэн ашиглаж байгаа нь чухал бөгөөд энэхүү системийг зохистой ашиглаж хууль тогтоох үйл ажиллагааны нэгэн хэсэг болгох нь иргэдийн зүгээс парламентад итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Жишээлбэл, Өмнө нь ажиллаж байсан Английн Засгийн газрын E-petition систем нь төдийлөн сайн ажиллаж чадаагүй бөгөөд иргэдийн өгсөн өргөдөл хүсэлтийг шийдвэрлэж чадахгүй, олон нийтэд бодит бус хүлээлт үүсгэсээр байсан нь шүүмжлэл дагуулсан. 100.000 хүний гарын үсэг цугларвал уг асуудлыг Парламентаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ гэж амласан ч парламентад уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх албан ёсны дэг байгаагүй учраас хоосон амлалт болж хувирч байв.

Харин 2015 онд шинээр нэвтрүүлсэн цахим өргөдлийн платформд иргэд тухайн асуудлыг дэмжиж гарын үсэг зурах боломжтой болсон. Энэхүү системд, хэрэв цахим өргөдөлд 10.000 хүн гарын үсэг зурвал Засгийн газар 21 хоногийн дотор хариу өгөх ёстой. Хэрэв 100.000 хүн гарын үсэг зурсан тохиолдолд Парламентын Өргөдлийн хороо уг асуудлыг шийдвэрлэх эсэхийг хэлэлцэнэ. Хэрэв тухайн асуудлыг ойрын хугацаанд парламентаар хэлэлцээгүй л бол Өргөдлийн хороо ихэвчлэн асуудлыг авч хэлэлцдэг.

Өргөдлийн хорооноос уг асуудлыг Нийтийн танхимын нэгдсэн хэлэлцүүлэгт оруулах хүсэлт гаргаж болох ч ихэнх өргөдлийн хэлэлцүүлгийг зэрэгцээ хуралдааны танхим буюу Вэстминстерийн танхимын хуралдаанаар хэлэлцдэг бөгөөд уг хуралдаанд өргөдлийн хэлэлцүүлэгт зориулсан тусгайлсан цагийг Даваа гарагийн 16:30-19:30 цагийн хооронд товлодог журамтай. Өргөдөлд гарын үсэг зурсан хүн бүхэнд тухайн өргөдөлтэй холбоотой арга хэмжээ авах бүрд ( жишээ нь, Засгийн газраас хариу арга хэмжээ авах гэх мэт) Хорооноос хариу өгдөг.

Зарим тохиолдолд Хорооноос асуулга тавих, аман сонсох ажиллагаа явуулах, цахим форум зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч болно. Өргөдөл гаргагчийн цахим хуудсанд парламентын холбогдох хуралдааны бичлэгийн холбоос, цахим дамжуулалт зэрэг авсан бүх арга хэмжээнүүдийн холбоосыг байршуулна. Тиймээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үйл явц нь тодорхой, ил тод, гарын үсэг зурагч талуудтай тогтмол харилцаатай байх боломжийг бүрдүүлсэн байдаг.

Английн Парламент анх 2015 оны 07 дугаар сард цахим өргөдлийн шинэ системээ нээхэд эхний өдрөө 9 хүн өргөдөл гаргаж, 60.580 хүний гарын үсэг нэмэгдсэн бөгөөд тэр цагаас хойш олон нийтийн сонирхлыг ихээхэн татсаар байна. 2015-2017 онд 14 сая гаруй идэвхтэй цахим шуудангийн хэрэглэгчдийн гарын үсэг зурсан 10.950 өргөдлийг хүлээн авчээ. 2017 оны Аудитын тайланд дурдсанаар судалгаанд хамрагдагсдын 23 хувь нь уг системийг ашигласан байна.

Ийнхүү маш их хэмжээний цахим өргөдөл, гарын үсэг хүлээн авахаас гадна Хороо нь 2 бүрэн хэмжээний лавлагаа, олон нийтийн оролцоог

хангах өргөн хүрээтэй санаачилгуудыг боловсруулан гаргасан байна. Тиймээс Английн парламентын энэхүү шинэ систем нэлээд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

### ***E-petition системийн талаарх твиттер анализын дүн***

2019 онд Английн Лийдсийн их сургуулийн профессор Molly Asher нарын эрдэмтэд 2015 онд эхэлсэн E-petition системд тулгуурласан парламентын хэлэлцүүлэг нь олон нийт болон парламентын харилцаанд хэр зэрэг нөлөө үзүүлж байна вэ гэдгийг твиттерийн мэдээлэлд тулгуурлан дата анализ хийж, судалгааны өгүүлэл нийтлүүлсэн байна. Энэхүү судалгааны үр дүнг тоймлон танилцуулбал:

Твиттерээр хэлэлцэгдэж буй жиргээнүүдэд дүн шинжилгээ хийх нь олон нийт цахим өргөдлийг хэрхэн хүлээн авч байгаа, үүнийг парламент хэрхэн ашиглаж олон нийттэй хэрхэн харилцаж байгааг ойлгоход тустай байна.

Өмнө нь 2013 онд сошиал мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ нь цахим өргөдлийн систем хэрхэн ажиллаж буйг ойлгох, иргэдийн онлайн идэвхжлийг тодорхойлоход дэмжлэг болсон. Энэхүү судалгаанаас парламент тэдний цахим өргөдлийг хэрхэн хүлээн авч, хэрхэн авч үзэж байгааг олон нийтийн зүгээс хэрхэн хүлээж авч байгааг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго чиглэгдсэн. Ийнхүү олон нийтийн хандлагыг тодорхойлоход:

1. олон нийт өргөдөл гаргахын ач холбогдол, үнэ цэнийг ойлгоход тус нэмэр болсон;
2. “илүү их оролцоо нь илүү ардчилал гэсэн үг биш” бөгөөд иргэдийн цахим өргөдлийн амжилтыг зөвхөн тоон үзүүлэлтээр (гарын үсэг, жиргээний тоо) хэмжих нь учир дутагдалтай. Үүний цаана хамгийн гол нь иргэд дэвшүүлсэн саналаа шийдвэрлүүлж, парламенттай харилцаагаа гүнзгийрүүлж чадсан уу гэдэг асуудал байна гэж үзсэн.

Судалгааны үр дүнд:

- Цахим өргөдлийн шинэ системийг нэвтрүүлж байгаа нь цахим өргөдөлд илэрхийлсэн иргэдийн санал хүсэлтийг эрх бүхий байгууллага сонсдог гэсэн ойлголтыг бий болгож байна. 100.000 гаруй хүний гарын үсэгтэй цахим өргөдлийн парламентын хэлэлцүүлгийг системийн оргил үе гэж үздэг ч мэтгэлцээний хүрээнд яг юу болж байгааг төдийлөн мэдэх боломжгүй. Харин твиттерийн хэлэлцүүлгүүд нь тэдний өргөдлийг парламент хэрхэн хэлэлцэж байгаа талаарх олон нийтийн хариу үйлдлийг илэрхийлж байна.

- Ерөнхийдөө цахим өргөдөлд маш олон тооны гарын үсэг цуглуулсан нь олон нийт уг асуудалд хүчтэй оролцож байна гэсэн үг биш гэдгийг харуулж байна. Учир нь янз бүрийн зорилготой хүмүүс цахим өргөдөл ирүүлдэг. Үүнийг ирүүлсэн цахим өргөдлийн төрлөөс харж болно. Ерөнхийдөө цахим өргөдлийг эсэргүүцлийн өргөдөл, бодитой өргөдөл гэж 2 хуваадаг. Эсэргүүцлийн өргөдөл нь түр зуурын үйл явдлуудыг дурдах хандлагатай байдаг бөгөөд голчлон сэтгэл хангалуун бус байгаагаа харуулах зорилготой байдаг бол бодитой өргөдөл гаргагч нь урт хугацаандаа санаа зовоох тодорхой асуудлаар нэлээд судалгаа тооцоотой, үндэслэлтэй санал гаргадаг. Ийм төрлийн томоохон асуудлыг шийдвэрлэхэд твиттерийн оролцоо эерэг нөлөөтэй бөгөөд олон нийтээс тогтвортой дэмжлэг авахад нөлөө үзүүлж байна гэж үзсэн.

Судлаачдын баг кейс судалгаанд тулгуурлан дараах 2 дүгнэлтийг гаргасан байна:

**Нэг.** Парламентын гишүүдийн ирц сайтай, өргөн бүрэлдэхүүнтэй хэлэлцсэн асуудлаар гаргасан шийдвэр олон нийтэд заавал таалагдах албагүй. Харин хэлэлцүүлгийн үеэр гишүүдийн хэлсэн үг, дэвшүүлсэн санаа нь тухайн цахим өргөдлийн зорилгыг хэр зэрэг илэрхийлж байгаа нь чухал ач холбогдолтой. Өргөдлийн хэлэлцүүлэг нь парламентын бусад хэлэлцүүлгийн адилаар мэтгэлцээний зарчмаар явагддаг.

**Хоёр.** Олон нийт парламентын хэлэлцүүлгийг аман нотлох баримт мэтээр туйлширсан байдлаар хүлээж авах хандлагатай байна. Гэхдээ Вестминстерийн системд энэ нь гайхах зүйл биш бөгөөд парламентын мэтгэлцээн нь улс төрийн тэмцлийн хэлбэрээр уламжлалын дагуу явагддаг. Тэгвэл үүний эсрэгээр, хороодын түвшинд явагддаг аман нотлох хуралдаан нь зөвшилцлийн зарчмаар явагдах хандлагатай байдаг. Баримт, нотлох баримтыг үнэлэхийн тулд гэрчүүдээс асуулт асуух, байцаахад гол анхаарлаа хандуулах жишээтэй. Твиттерийн жиргээнд хийсэн дүн шинжилгээгээр олон нийт аман нотлох баримтын хуралдаанаас илүү парламентын мэтгэлцээнд сөрөг ханддаг нь тодорхой болсон. Энэ нь Хансардын нийгэмлэгийн Ерөнхий сайд нарын асуултад (2014) хандах олон нийтийн хандлагын талаарх дүгнэлттэй нийцэж байгаа бөгөөд энэ нь олон нийт сөргөлдөөнтэй мэтгэлцээнд сөрөг хариу үйлдэл үзүүлж байгааг харуулж байна” гэжээ.

Эдгээр дүгнэлтүүдээс үзэхэд парламентын зүгээс иргэдийн өргөдлийн анхны зорилгыг авч үзэх тал дээр илүү анхаарал хандуулах хэрэгтэйг харуулж байна. Тэгвэл Парламентын өргөдлийн бусад системүүд (жишээлбэл, Европ, Герман, Шотландад) мэтгэлцээнд төдийлөн анхаарал



хандуулдаггүй бөгөөд өргөдөл гаргагчдын асуудалд чиглэсэн нотлох баримтын хуралдааныг урьтал болгодог байна.

Уг дүн шинжилгээний үр дүнд, цахим өргөдөл гэх мэт орчин үеийн хэрэгслүүдийн ач холбогдлыг үнэлэхийн тулд олон нийтийн хариу үйлдлийг бодит цаг хугацаанд ажиглаж, томоохон хэмжээний мэдээллийн шинжилгээ хийж байх нь үр дүнтэй гэж дүгнэсэн байна. Парламентууд олон нийттэй харилцах арга барилаа сайжруулахын тулд техник-технологийн шинэ шийдлүүдийг ашиглаж болох ч хамгийн гол нь эдгээр арга хэрэгслийг олон нийт хэрхэн ашиглаж, хэрхэн хүлээж авч байгааг үнэлэх нь чухал ач холбогдолтой гэж үзсэн.

*Жишээ болгон, Шинэ Зеландын Парламентад өргөдөл хэлэлцэх журмыг авч үзье.*

### **Өргөдлийг хэлэлцэх**

Шинэ Зеландад иргэдийн гаргасан аливаа өргөдлийг Өргөдлийн хороонд шилжүүлдэг. Өргөдлийн хороо нь бусад сонгогдсон хороодын адилаар олон намын төлөөллөөс бүрдсэн хороо бөгөөд асуудлыг нарийвчлан авч үздэг. Тухайн асуудлын талаар нэмэлт нотлох баримт цуглуулах шаардлагатай гэж үзвэл олон нийтийн төлөөллөөс мэдүүлэг авч болох ч энэ нь төдийлөн түгээмэл хэрэглэдэг практик биш юм.

Өргөдлийн хороо нь өргөдлийг цаг тухайд нь авч үзэх, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих үндсэн үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд тухайн асуудлыг хариуцсан хороонд шилжүүлж, хамтран хэлэлцэх маягаар шийдвэрлэж болно. Мөн зарим өргөдлийг Засгийн газрын холбогдох сайдад шилжүүлэх ба сайд өргөдлийг 60 хоногийн дотор шийдвэрлэж хариуг олон нийтэд нийтэлж танилцуулах ёстой.

Өргөдлийн хороо нь асуудлыг дараах байдлаар шийдвэрлэж болно. Үүнд;

- Ижил төстэй өргөдлүүдийг бүлэглэж, хамтатган авч үзэх;
- Иргэдийн төлөөллөөс асуудлыг шийдвэрлэхэд тусламж хүсэх;
- Өргөдлийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх санал гаргах;
- Өргөдөлтэй холбоотой асуудлыг хэлэлцэж чуулганы хуралдаанд мэдээлэл хийх.

### **Өргөдлийн хариу өгөх**

Хороогоор иргэдийн өргөдлийг хэлэлцэж дуусаад парламентад танилцуулах дүгнэлтээ нэгтгэнэ. Асуудлыг шийдвэрлэсэн Хорооны тайланг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.



Хорооны тайланд өргөдлийн дагуу тавьсан асуудлын хүрээнд хяналт шалгалт хийсэн дүнгийн талаарх хураангуй мэдээллийг оруулна. Зарим тохиолдолд уг асуудлыг шийдвэрлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газарт үүрэг чиглэл болгосон асуудлуудыг тусгана. Бусад тохиолдолд ямар нэгэн зөвлөмжгүй тайлан гаргаж болно. Хорооноос Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн тохиолдолд Засгийн газар асуудлыг 60 хоногт багтаан шийдвэрлэж хариуг парламентад хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

Өргөдлийн хорооны ажилтнууд иргэний хүсэлтийг хэлэлцэж дуусахад өргөдөл гаргагчтай холбогдож хорооны тайлангийн холбоосыг цахим шуудангаар илгээнэ. Уг цахим шуудангаар өргөдөл шийдвэрлэх явцад хүлээн авсан нотлох баримт, чухал гэж үзсэн бусад мэдээллийн линкийг мөн явуулна. Эдгээр мэдээллээс өргөдөл гаргагч асуудлыг шийдвэрлэсэн үндэслэлтэй танилцах боломжтой болно.

Хэрэв тухайн өргөдөлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхийг Засгийн газарт үүрэг чиглэл болгосон бол өргөдлийн хариуг хэзээ өгөх ёстой талаар өргөдөл гаргагчид мэдэгдэж, Засгийн газраас парламентад асуудлыг танилцуулсны дараа хариуны хуулбарыг өргөдөл гаргагчид илгээнэ.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Rules, procedures and practices of the right to petition parliaments. Tiago Tib rcio (Ph.D. in Political Science from ISCTE - University Institute of Lisbon). Policy Department for Citizens’ Rights and Constitutional Affairs Directorate-General for Internal Policies, European Parliament. September 2023. [https://www.europarl.europa.eu/thinktank/en/document/IPOL\\_STU\(2023\)753105](https://www.europarl.europa.eu/thinktank/en/document/IPOL_STU(2023)753105)

### Бүгд Найрамдах Эстони Улс

- Response to Memoranda and Requests for Explanations and Submission of Collective Addresses Act, Chapter 3, <https://www.riigiteataja.ee/en/eli/501112016001/consolide>.
- <https://rahvaalgatus.ee/about>
- <https://www.riigiteataja.ee/en/eli/518112014003/consolide>

### Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

- <https://petition.parliament.uk/help>
- <https://committees.parliament.uk/committee/326/petitions-committee/role/>
- <https://committees.parliament.uk/committee/326/petitions-committee/news/99341/committee-opens-consultation-on-its-working-methods/>

### Канад Улс

- Канадын парламентын албан ёсны цахим хуудас <https://petitions.ourcommons.ca/en/Home/AboutContent?guide=PIGuideForPetitioners>

### Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

- ХБНГУ-ын Өргөдлийн хорооны өргөдөл шийдвэрлэх процедурын зарчим 7.1-ийн хавсралт 8

### Шинэ Зеланд Улс

- <https://petitions.parliament.nz/>
- <https://www.parliament.nz/en/get-involved/have-your-say/guide-for-petitions/>
- <https://www.parliament.nz/en/get-involved/have-your-say/guide-for-petitions/#committee-consideration>

**ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ: УЛС ТӨРИЙН НАМЫН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨРҮҮДЭД ТУСГАСАН БАЙДАЛ, ХОЛБОГДОХ  
ХУУЛЬ БА ИНСТИТУТУУД**

(Тойм судалгаа)

*Г.Билгээ, О.Нарантуяа*

**АГУУЛГА**

Нэг.УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОВЧООН

Хоёр.МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТОВЧООН

Гурав.АЛСЫН ХАРАА-2050 БА “ЗАСАГЛАЛ”-Д ХАМРАХ АСУУДЛУУД

Дөрөв.УЛСЫН БАГА ХУРЛААР БАТЛАГДСАН ЗАСАГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ  
ХУУЛИУД БА ИНСТИТУТУУД

Тав. ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ: УЛС ТӨРИЙН НАМЫН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨРҮҮДЭД ТУСГАСАН БАЙДАЛ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ  
БА ИНСТИТУТУУД

- 5.1. Анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ (1992-1996 он)
- 5.2. Хоёр дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (1996-2000 он)
- 5.3. Гурав дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2000-2004 он)
- 5.4. Дөрөв дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2004-2008 он)
- 5.5. Тав дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2008-2012 он)
- 5.6. Зургаа дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2012-2016 он)
- 5.7. Долоо дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2016-2020 он)
- 5.8. Найм дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2020-2024 он)

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. УИХ-ын ээлжит сонгуулийн товчоон (1992-2020 он)
- Хүснэгт 2. Сонгуулийн дүнгээр УИХ-д суудал авсан нам, эвсэл (1992-2020 он)
- Хүснэгт 3. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон товчоон (1992-2021 он)
- Хүснэгт 4. “Алсын хараа-2050”-д тусгасан засаглалтай холбоотой зорилго, зорилтууд
- Хүснэгт 5. УБХ-аар батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд
- Хүснэгт 6. УИХ-д суудал авсан нам, эвслийн 1992 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал
- Хүснэгт 7. УИХ-ын 1992-1996 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд
- Хүснэгт 8. УИХ-д суудал авсан нам, эвслийн 1996 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал
- Хүснэгт 9. УИХ-ын 1996-2000 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд
- Хүснэгт 10. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2000 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал
- Хүснэгт 11. УИХ-ын 2000-2004 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд
- Хүснэгт 12. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2004 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал
- Хүснэгт 13. УИХ-ын 2004-2008 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд
- Хүснэгт 14. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2008 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал
- Хүснэгт 15. УИХ-ын 2008-2012 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд
- Хүснэгт 16. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2012 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал
- Хүснэгт 17. УИХ-ын 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд
- Хүснэгт 18. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал
- Хүснэгт 19. УИХ-ын 2016-2020 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд
- Хүснэгт 20. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2020 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал
- Хүснэгт 21. УИХ-ын 2020-2024 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд.

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

АН	Ардчилсан нам
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНН	Бүгд Найрамдах нам
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ИЗН	Иргэний Зориг нам
ИЗН-НН эвсэл	Иргэний Зориг-Ногоон намын эвсэл
ИЗНН	Иргэний Зориг Ногоон нам
МАН	Монгол Ардын нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт нам
МоАН	Монголын Ардчилсан нам
МСДН	Монголын Социал Демократ нам
МУНН	Монголын Уламжлалын Нэгдсэн нам
МҮАН	Монголын Үндэсний Ардчилсан нам
МҮАН	Монгол Үндэсний Ардчилсан нам
МҮДН	Монголын Үндэсний Дэвшлийн нам
МШАН	Монголын Шашинтны Ардчилсан нам
НН	Ногоон нам
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБХ	Улсын Бага Хурал
УИХ	Улсын Их Хурал
ХҮН	Хөдөлмөрийн Үндэсний нам
Эх орон-МАШСН	Эх орон-Монголын Ардчилсан Шинэ Социалист нам

## Нэг. УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОВЧООН

1992 онд батлагдсан ардчилсан шинэ Үндсэн хуулийн хүрээнд Монгол Улсад ардчиллыг тогтоох үйл явц өрнөсөн. Үндсэн хуулийн ерөнхий зорилт нь ардчилсан нийгэмд шилжих, хүний эрхийг хамгаалах, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн үндсийг бий болгох явдал байсан гэж энэ үйл явцад гар бие оролцсон хүмүүс дүгнэжээ.

Эдгээр зорилтыг Үндсэн хуулийн оршил болгон: “Монголын ард түмэн бид: улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж тодорхойлсон байдаг.<sup>28</sup>

Монгол Улсын Үндсэн хуульд “Төрийн эрх барих дээд байгууллага нь Улсын Их Хурал байна” гэж заагаад “Монгол Улсын хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” хэмээн баталгаажуулсны дагуу манай улс нэг танхимтай парламентын тогтолцоонд шилжиж, бүрэлдэхүүний хувьд 76 гишүүнтэй болсон.

Ийнхүү ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улс Улсын Их Хурал (УИХ)-ын найман удаагийн ээлжит сонгуулийг зохион байгуулсан.

<sup>28</sup> Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ. Ч.Энхбаатар ба бусад. УИХ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл. “Мөнхийн Үсэг” ХХК, 2015 он. 8 дахь тал.

Хүснэгт 1. УИХ-ын ээлжит сонгуулийн товчоон (1992-2020 он)

№	Үзүүлэлт	1992 он	1996 он	2000 он	2004 он	2008 он	2012 он	2016 он	2020 он
1	Хүн амын тоо	2.154.646	2.231.363	2.382.525	2.407.568	2.564.285	2.801.136	3.057.778	3.328.315
2	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогч	1.085.129	1.147.260	1.247.033	1.279.516	1.542.617	1.840.824	1.911.047	2.003.969
3	Санал өгсөн	1.037.392	1.057.182	1.027.985	1.051.812	1.179.448	1.238.537	1.406.123	1.475.780
	сонгогчид хувь	95.60	92.10	82.40	82.20	76.46	67.28	73.58	73.60
4	Тойрог, нутаг дэвсгэрийн хороо	26	76	76	76	26	26	22	29
5	Сонгуульд оролцсон нам, эвсэл	8 нам, 2 эвсэл	5 нам, 2 эвсэл	13 нам, 3 эвсэл	7 нам, 1 эвсэл	12 нам, 1 эвсэл	11 нам, 2 эвсэл	12 нам, 3 эвсэл	14 нам, 3 эвсэл
6	Нийт нэр дэвшигч	293	302	602	244	356	544	498	606
7	Нам, эвслээс	275	267	575	229	311	518	429	485
8	Бие дааж	18	35	27	15	45	26	69	121
9	Сонгууль зарласан огноо	1992.04.13	1996.04.16	2000.04.17	2004.04.12	2008.05.14	2012.04.28	2016.04.08	2020.01.30
10	Сонгууль явагдсан огноо	1992.06.28	1996.06.30	2000.07.02	2004.06.27	2008.06.29	2012.06.28	2016.06.29	2020.06.24

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – [www.ges.gov.mn](http://www.ges.gov.mn)

Өнгөрсөн найман удаагийн сонгуульд МАХН, эсхүл МАН нийт 5 удаа, АН-ын тэргүүлсэн эвсэл 2 удаа ялж, 2 удаа (2004 онд) эвслийн буюу “Эв нэгдлийн Засгийн газар” байгуулагдаж байжээ.

*Хүснэгт 2. Сонгуулийн дүнгээр УИХ-д суудал авсан нам, эвсэл (1992-2020 он)*

<b>№</b>	<b>УИХ-ын ээлжит сонгууль болсон он</b>	<b>Улс төрийн нам, эвслийн нэр (УИХ-д авсан суудлын тоо)</b>
1	1992 он	МАХН 70 МоАН, МҮДН, НН-ын “Ардчилсан холбоо” эвсэл 4 МСДН 1 Бие даагч 1
2	1996 он	МҮАН, МСДН-ын “Ардчилсан холбоо” эвсэл 50 МАХН 25 МУНН 1
3	2000 он	МАХН 72 ИЗ-НН эвсэл 1 МҮАН, АН-ын “Ардчилсан холбоо” эвсэл 1 Эх орон - МАШСН 1 Бие даагч 1
4	2004 он	МАХН 37 АН, Эх орон-МАШСН, ИЗН-ын “Эх орон-Ардчилал” эвсэл 35 БНН 1 Бие даагч 3
5	2008 он	МАХН 46 АН 27 ИЗН 1 Бие даагч 1
6	2012 он	АН 34 МАН 26 МАХН, МҮАН-ын “Шударга ёс эвсэл” 11 ИЗНН 2 Бие даагч 3
7	2016 он	МАН 65 АН 9 МАХН 1 Бие даагч 1
8	2020 он	МАН 62 АН 11 ХҮН, МСДН, Зүй ёс намын “Зөв хүн электорат” эвсэл 1 Бие даагч 1

*Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – [www.ges.gov.mn](http://www.ges.gov.mn)*



## Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТОВЧООН

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэж заасан дагуу ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн найман удаагийн ээлжит сонгууль болжээ.

Өнгөрсөн найман удаагийн сонгуульд анхны Ерөнхийлөгч эвслийн буюу МҮАН, МСДН-ын эвслээс сонгогдсон бол МАХН, эсхүл МАН 4 удаа, АН 3 удаа ялалт байгуулсан байна.

*Хүснэгт 3. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон товчоон (1992-2021 он)*

№	Сонгууль болсон он	Сонгогдсон Ерөнхийлөгчийн нэр	Улс төрийн нам, эвслийн нэр	Сонгогдсон саналын хувь	Тайлбар
1	1993 он	П.Очирбат	МҮАН, МСДН	57.8	Энэхүү хуралдаанаас Монгол Улсын анхны Ерөнхийлөгч ба Дэд ерөнхийлөгчийг сонгов. Дэд ерөнхийлөгч нь УБХ-ын даргыг давхар гүйцэтгэж байв. БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр П.Очирбатыг сонгож байжээ.
2	1997 он	Н.Багабанди	МАХН	60.81	Монгол Улсын хоёр дахь Ерөнхийлөгчөөр сонгогджээ.
3	2001 он	Н.Багабанди	МАХН	58.13	Монгол Улсын Ерөнхийлөгчөөр дахин сонгогдсон.
4	2005 он	Н.Энхбаяр	МАХН	53.44	Монгол Улсын 3 дахь Ерөнхийлөгчөөр сонгогджээ.
5	2009 он	Ц.Элбэгдорж	АН	51.21	Монгол Улсын 4 дэх Ерөнхийлөгчөөр сонгогджээ.
6	2013 он	Ц.Элбэгдорж	АН	50.23	Монгол Улсын Ерөнхийлөгчөөр дахин сонгогдсон.
7	2017 он	Х.Баттулга	АН	50.61	Монгол Улсын 5 дахь Ерөнхийлөгчөөр сонгогджээ.
8	2021 он	У.Хүрэлсүх	МАН	67.69	Монгол Улсын 6 дахь Ерөнхийлөгчөөр сонгогджээ.

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – [www.ges.gov.mn](http://www.ges.gov.mn)

## Гурав. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**1992-2019 оны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн талаарх товч тойм:** Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдан, Монгол Улс хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах, чөлөөт зах зээлийн эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, эдийн засаг дахь төрийн оролцоо эрс багасав.

1990 онд Нийгэм, эдийн засгийн улсын хороо, Үндэсний хөгжлийн яам нэртэйгээр зохион байгуулагдан хоёр жил ажиллаж байжээ. 1992-1996 онуудад Монгол Улсын Засгийн газрын үндсэн бүтцэд “Үндэсний хөгжлийн газар”-ыг байгуулжээ.

1996 онд УИХ-ын 26 дугаар тогтоолоор **“Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал”**, 1998 онд Засгийн газрын 82 дугаар тогтоолоор хоёр дахь баримт бичиг **“Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”**-ийг баталжээ. 2001 онд УИХ-ын 57 дугаар тогтоолоор Монгол Улсын **“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”**-ыг батлав.

2008 онд УИХ-ын 12 дугаар тогтоолоор Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтод суурилсан **“Үндэсний хөгжлийн цогц бодлого”**-ыг баталж, мөрдөж эхлэв. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Эдийн засгийн хөгжлийн яам байгуулах замаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хийхийг оролдсон боловч үр дүнд хүрээгүй.

2010 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын Хөгжлийн банкныг байгуулахаар шийдвэрлэж, 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр УИХ-аас **Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг** баталж, Хөгжлийн банкныг Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй, ашгийн төлөө, төрийн өмчит хуулийн этгээд байхаар хуульчилсан. Монгол Улсын Хөгжлийн банк 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдөр албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр УИХ-аас **Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг** баталж, 2016 онд “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго-2030” баримт бичгийг үндэслэн УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор **“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”** урт хугацааны бодлогын баримт бичгийг батлав.

2017 онд Олон улсын валютын сангийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдаж, төсвийн хатуу бодлого явуулах болов.

Гэвч уур амьсгалын эрс тэс нөхцөлтэй, цаг агаараас ихээхэн хамааралтай, далайд гарах шууд гарцгүй, хүн амын нягтшил бага, тархай суурьшилтай, хязгаарлагдмал хөрөнгө санхүү, валютын нөөцтэйн дээр Засгийн газар болон төрийн бодлого нь тогтворгүй, залгамж холбоогүй, сонгууль дагасан дөрвөн жилийн циклтэй, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах институт бүрдээгүй зэрэг олон хүчин зүйлээс хамаарч дээр дурдсан хөгжлийн бодлогын баримт бичгүүд хангалттай хэрэгжиж чадаагүй.

**Алсын хараа-2050 ба “засаглал”-д хамрах асуудлууд:** УИХ-аас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж, 25.1.7-д “...Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж тус тус заасан бөгөөд гадаад, дотоод нөхцөл байдал, түүнчлэн Үндсэн хуулийн үзэл баримтлал, шинэ зохицуулалтын хүрээнд урт хугацаагаар төсөөлөх хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах хууль зүйн үндэслэл, практик шаардлага бий болсон.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго-2030” хөтөлбөрийг НҮБ-ын гишүүн улс бүр хэрэгжүүлэх үүрэг амлалт авч, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилгыг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газар төрийн холбогдох байгууллага, НҮБ-ын системийн байгууллагууд, Олон улсын санхүүгийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжин, үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилготой ажиллаж байна.<sup>29</sup>

Ийнхүү Монгол Улс өнгөрсөн 30 жилийг бүхэлд нь дүгнэж, ирэх 30 жилийг урт хугацаагаар төсөөлөх **“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого**-ыг УИХ-аас 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан.<sup>30</sup>

<sup>29</sup> “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн танилцуулга. 31 дэх тал. <https://cabinet.gov.mn>

<sup>30</sup> Мөн тэнд. 3 дахь тал.

Уг баримт бичигт “Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно.” гэсэн алсын хараатайгаар дараах эрхэм зорилгыг дэвшүүлсэн:

- үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлж;
- үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж;
- хүн төрөлхтний дэвшилтэт ололтыг дэмжиж;
- хөрст дэлхий, унаган байгалиа хайрлан хамгаалж;
- амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож;
- ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлж;
- өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн;
- эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжинө.

“Алсын хараа-2050” нь 9 зорилго, 47 зорилттой бөгөөд 2021-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттайгаар зорилт тус бүрийн хүрэх үр дүнг тодорхойлж өгсөн. Эдгээр 9 зорилгын хэрэгжилтийг үнэлэх 73 шалгуур үзүүлэлтийг мөн баримт бичигт тусгажээ.

Эдгээр зорилго, зорилтын 2021-2030 онд хэрэгжүүлэх I үе шатны зорилтууд нь НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго-2030” хөтөлбөрийн 17 зорилго, 169 зорилтуудтай уялдуулж баталсан байна.

Энэхүү судалгаанд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 9 зорилгоос “Засаглал” гэсэн 5 дахь зорилго, “Амар тайван, аюулгүй нийгэм” гэсэн 7 дахь зорилгод тусгасан зорилтуудын дагуу “засаглал”-д хамаарах асуудлуудыг тогтоосон.

Мөн УИХ-аас 2020 оны 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2021 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4. “Алсын хараа-2050”-д тусгасан засаглалтай холбоотой зорилго, зорилтууд

Зорилго	Зорилтууд
<p><b>Ухаалаг засаглал</b></p> <p><b>Зорилт 5.1.</b> Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана.</p>	
<p><b>Ухаалаг бүтэц</b></p>	
<p><b>Зорилго 5.</b></p>	<p><b>Зорилт 5.2.</b> Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.</p>
<p><b>Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.</b></p>	<p><b>Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)</b></p> <p><b>Зорилт 5.3.</b> Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.</p> <p><b>Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба</b></p> <p><b>Зорилт 5.4.</b> Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.</p> <p><b>Хүний эрхийг дээдэлсэн нийгэм</b></p> <p><b>Зорилт 5.5.</b> Иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ.</p>
	<p><b>Авлигагүй засаглал</b></p> <p><b>Зорилт 5.6.</b> Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.</p>

<p><b>Амар тайван, аюулгүй нийгэм</b></p> <p><u><b>Зорилго 7.</b></u></p> <p>Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.</p>	<p><b>Зэвсэгт хүчин</b></p> <p><b>Зорилт 7.1.</b> Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ.</p> <p><b>Дархан хил</b></p> <p><b>Зорилт 7.2.</b> Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг ханган хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ.</p> <p><b>Хүн, нийгмийн амар тайван байдал</b></p> <p><b>Зорилт 7.3.</b> Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ.</p> <p><b>Хууль сахиулах салбарын хөгжил</b></p> <p><b>Зорилт 7.4.</b> Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчны сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.</p> <p><b>Мэдээллийн аюулгүй байдал</b></p> <p><b>Зорилт 7.5.</b> Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.</p>
--	--

## **Дөрөв. УЛСЫН БАГА ХУРЛААР БАТЛАГДСАН ЗАСАГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛИУД БА ИНСТИТУТУУД**

**Улсын Бага Хурлын гүйцэтгэсэн түүхэн үүрэг:** Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Ардын Их Хурал (АИХ)-ын 430 депутатаас сонгогдсон 50 гишүүнтэй Улсын Бага Хурал нь 1990-1992 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн.

БНМАУ-ын Улсын Бага Хурал (УБХ) Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн байгууллыг шинэтгэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар түүхэн гавьяа байгуулсан парламент юм. Юуны өмнө Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулан батлуулсныг онцлон тэмдэглэх учиртай.

УБХ-аас боловсруулж, АИХ-ын чуулганд оруулан хэлэлцүүлсэн Монгол Улсын шинэ Үндсэн хууль 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсанаар нийгмийн бүх хүрээнд ардчилсан зарчмыг тууштай хэрэгжүүлэх эрх зүйн харилцааны тулгуур эхлэл тавигдсан юм. Тухайлбал, улс төрийн харилцааны хувьд олон намын тогтолцоог баталгаажуулсан ардчилсан дэглэмд шилжсэн. Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрч, түүний баталгааг хангах үүргийг төр хариуцах болсон. Өөрөөр хэлбэл, олон ургалч үзлийг нийгмийн оюун санааны эш үндэс болгосон. Энэ бол ардчиллын чухал үнэт зүйлсийн нэг юм. Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурлын тухай, Үндсэн хуулийн цэцийн тухай болон БНМАУ-ын шүүхийн байгууламжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталж, төрийн байгууллын шинэ тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Эдийн засгийн харилцааны хувьд нийтийн өмчид суурилсан аж ахуйн социалист тогтолцоо дангаар ноёрхож байсныг халж, олон хэвшилт эдийн засагтай болох харилцааг хуульчлан баталгаажуулсан. Шударга өрсөлдөөнд үндэслэсэн зах зээлийн эдийн засгийн харилцааг тогтоож, түүнд төрийн оролцоог хязгаарлаж өгсөн. Хувийн ба нийтийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, төрийн өмчийг задлан хувьчлах, иргэд хувийн аж ахуй эрхлэх эрх зүйн үндсийг тогтоож, банк, гааль, албан татварын зэрэг хуулиудыг шинэчлэн баталжээ.<sup>31</sup>

**УБХ-аар батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд ба институтууд:** Дараах хүснэгтэд УБХ-аар батлагдан, өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа, эсхүл УИХ-аас хүчингүй болгосон засаглалтай холбоотой (бие даасан) хуулиудыг оруулсан.

<sup>31</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nn/2348/>

Дараах 14 хуулийн 5-ийг нь анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ хүчингүй болгожээ. Энэ нь хуучин БНМАУ-ын Засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг институттэй холбоотой эрх зүйн орчныг 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуульд нийцүүлэх шаардлагын дагуу хүчингүй болжээ.

*Хүснэгт 5. УБХ-аар батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд*

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо	Хуулийн дагуу байгуулагдсан институт
1	БНМАУ-ын Засгийн газрын бүтцийн тухай	1990.09.26	1992.07.30 (Анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ)	
2	БНМАУ-ын Засгийн газрын бүрэлдэхүүнийг тогтоох тухай	1990.09.26	1992.07.31 (Анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ)	
3	Цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлэх баталгааны тухай	1990.10.05	1993.12.13 (Анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ)	
4	БНМАУ-ын Засгийн газрын тухай	1991.01.04	1993.11.05 (Анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ)	Засгийн газар
5	БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тухай	1991.01.04	1993.11.05 (Анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ)	Ерөнхийлөгч
6	БНМАУ-ын Бага хурлын тухай хууль (Үндсэн хуулийн Хавсралт хуулиар)	1991.01.04		
7	Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай	1991.08.28		
8	Монгол Улсын Үндсэн хууль	1992.01.13		



9	Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хууль	1992.01.16		
10	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль	1992.04.04	2005.12.29 (Дөрөв дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ)	УИХ-ын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо (УБХ-ын 1992.04.10-ны өдрийн №18 тогтоолоор байгуулагдсан)
11	Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай	1992.05.04	2016.09.01 (Долоо дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ)	
12	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай	1992.05.08		Үндсэн хуулийн цэц (1992.07.01-ний өдөр байгуулагдсан)
13	Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль	1992.05.13	2001.12.27 (Гурав дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ)	
14	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай	1992.05.29		Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөл (1992.08.08-ны өдөр байгуулагдсан)

## **Тав. ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ: УЛС ТӨРИЙН НАМЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРҮҮДЭД ТУСГАСАН БАЙДАЛ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ БА ИНСТИТУТУУД**

### **5.1. Анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ (1992-1996 он)**

**УИХ-ын сонгуулийн дүн:** УИХ-ын гишүүдийг сонгуулийн мажоритар тогтолцоогоор, 2-4 мандат бүхий томсгосон 26 тойргоос шууд сонгосон. Уг сонгуульд улс төрийн 8 нам, 2 эвсэл, 18 бие даан нэр дэвшигч өөрсдийн мөрийн хөтөлбөртэй оролцжээ.

1992 оны 06 дугаар сарын 28-ны өдөр болсон УИХ-ын анхдугаар сонгуулийн дүнд МАХН 70, МоАН, МҮДН, НН-ын “Ардчилсан холбоо” эвсэл 4, МСДН 1, бие даан нэр дэвшигч 1 суудал (Г.Зуунай) тус тус авсан. Ийнхүү МАХН Парламентын үнэмлэхүй олонх болж, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө дараагийн 4 жил хэрэгжүүлэхээр болов.<sup>32</sup>

**УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан засаглалын талаар:** Намууд гишүүнчлэлийн зэрэгцээ нийгмийн бүхий л хүрээний дэмжлэгийг өөртөө татах мөрийн хөтөлбөрүүдийг<sup>33</sup> боловсруулан сонгуульд оролцдог билээ.

1992 онд УИХ-ын анхдугаар сонгуулийн үр дүнд УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрт Монгол Улсад ардчилал, төрийн шинэ тогтолцоог төлөвшүүлэн баталгаажуулах, хууль тогтоомжийг Монгол Улсын шинэ Үндсэн хуультай нийцүүлэн шинэчлэх, хуулийн өмнө төр-иргэний тэгш эрхийг хангахад чиглэсэн байв.

<sup>32</sup> Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – [www.ges.gov.mn](http://www.ges.gov.mn)

<sup>33</sup> Монголын нийгмийн өөрчлөлт. Даш-Ёндон Б (Редактор). Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрхийн хүрээлэн. УБ., 2008, 269 дэх тал.

*Хүснэгт 6. УИХ-д суудал авсан нам, эвслийн 1992 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал*

<b>№</b>	<b>Нам, эвслийн нэр</b>	<b>Сонгуульд оролцсон уриа, эрмэлзэл</b>	<b>Мөрийн хөтөлбөрт засаглалын талаар тусгасан гол агуулга</b>
1	МАХН (70 суудал)	<b>Уриа</b> – Эх орон ард түмний төлөө! <b>Эрмэлзэл</b> – Бүтээлч хөдөлмөр, ардчилал, шударга ёс, сахилга, зохион байгуулалт.	МАХН сонгуулийн мөрийн хөтөлбөртөө “Төрт ёсны түүхэн уламжлал, дэлхий дахины хөгжлийн чиг хандлагад тулгуурлан, монгол оронд ардчилал, төрийн шинэ тогтолцоог төлөвшүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор цогцолбор бодлого боловсруулж хэрэгжүүлэх” хэмээн тусгасан байна. <i>Эх сурвалж: “Үнэн” сонин. 1992.04.25, №45.</i>
2	МоАН, МҮДН, НН-ын “Ардчилсан холбоо” эвсэл (4 суудал)		Тус эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө “Монгол Улсад ардчилсан нийгмийн тогтолцоонуудыг төлөвшүүлэн баталгаажуулах, ардчилалт үнэлэмжийг нийгмийн сэтгэлгээний салшгүй хэсэг болгон төлөвшүүлэх...”-ийг тусгажээ. <i>Эх сурвалж: Х.Дашзэвэг. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996).</i>
3	МСДН (1 суудал)		МСДН сонгуулийн мөрийн хөтөлбөртөө “...нийгмийн бүхий л бүлэг, хувь хүмүүс бүрийн хоорондох нийгмийн харилцааг зохицуулах, хуулийн өмнө төр-иргэний тэгш эрхийг хангах, нийгмийн амьдралын хэм хэмжээг тогтоох, хуулийн хяналтад улс төрийн бүлэглэл, хувь хүмүүс, иргэдийн зүгээс оролцох боломжийг нь олгох...” хэмээн тусгажээ. <i>Эх сурвалж: “Үг” сонин. 1992.04.09, №7, 8.</i>

**“Анхны УИХ”-ын онцлог:** УИХ-ыг сонгох анхдугаар сонгуулиар байгуулагдсан УИХ нь Монголын парламентын хөгжлийн түүхэнд онцгой байр суурь эзэлдэг. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн дагуу эрх зүйн шинэтгэл хийх ажлыг эхлүүлж, Үндсэн хуулийн үзэл санааны дагуу нийгмийн бүх салбарын харилцааг эрх зүйн хүрээнд шинээр уялдуулан зохицуулах өргөн хүрээтэй ажлыг хийжээ.<sup>34</sup>

### **Батлагдсан онцлог хуулиуд:**

- Шинэ Үндсэн хуулийн дагуу эрх зүйн шинэтгэл хийх ажлыг эхлүүлсэн. Үндсэн хуулийн үзэл санааны дагуу нийгмийн бүх салбарын харилцааг эрх зүйн хүрээнд шинээр уялдуулан зохицуулах өргөн хүрээтэй ажлыг хийжээ.
- Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн засаглалын байгууллагуудыг шинээр бүрдүүлэн бататгаж, тэдгээрийн статус, хоорондын харилцааны тэнцвэрийг эрх зүйн хүрээнд бий болгож өгсөн.  
УИХ-аас тэргүүн ээлжинд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг баталж, цаашлаад Засгийн газар, Ерөнхийлөгч, Шүүхийн зэрэг хуулиудыг шинэчлэн баталжээ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль батлан орон нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлсэн байна.
- Ерөнхийлөгчийн хувьд, уг албан тушаалыг анх 1990 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиар бий болгож, улмаар Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг илүү дэлгэрэнгүй тогтоож өгсөн.<sup>35</sup> 1993 оны 02 дугаар сарын 15-ны өдөр УИХ-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг баталж, 1993 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүх нийтийн анхдугаар сонгуулийг явуулжээ.
- Энэ парламентын үед зах зээлийн эдийн засгийн харилцааны тулгуур хуулиудыг баталсан. Тухайлбал, Улсын төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэл, Татварын багц хууль, Онцгой албан татвар, Гаалийн болон Гаалийн тарифын тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиудыг дурдаж болно.
- Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хийх өмч хувьчлал дуусч, үнэт цаасны хоёр дахь зах зээлийг нээж ажиллуулсан нь шинэ нийгмийн эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэхэд чухал алхам болсон.

<sup>34</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>, Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.

<sup>35</sup> Энхбаатар Ч. ба бусад. Монгол Улсын төрийн тогтолцоон дахь ерөнхийлөгчийн байр суурь: бүрэн эрхийн шинжилгээ (Судалгааны тайлан). Удирдлагын академи. УБ., 2019 он. 27 дахь тал.

**Байгуулагдсан институтууд:** УИХ-ын 1992-1996 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан хуулиудын дагуу хэд хэдэн институт байгуулагдсанаас заримыг нь тодруулж үзвэл:

- Үндсэн хуулийн 49.3-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор **Шүүхийн ерөнхий зөвлөл** ажиллана.” гэж, 49.4-т “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.” гэж тус тус заасан. 1993 онд УИХ-аас Монгол Улсын Шүүхийн тухай хуульд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тодорхойлон хуульчилсан.<sup>36</sup>
- Үндсэн хуулийн 1.2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан. 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийг 1995 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсөнөөр төрийн албаны төв байгууллага **Төрийн захиргааны албаны зөвлөлийн** (хуучин нэрээр) үйл ажиллагаа эхэлсэн байна.<sup>37</sup>
- 1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 1996 оны 177 дугаар тогтоолоор **Төрийн өмчийн хороог** байгуулж, 184 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн хорооны зохион байгуулалтын бүтэц, дүрмийг баталжээ.<sup>38</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10-т заасны дагуу Төрийн өмчийн хороо нь “төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын үндсэн бүтцийн байгууллага мөн.”

1992-1996 оны УИХ-аас засаглалтай холбоотой баталсан (бие даасан) хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтуудын талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

<sup>36</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас - [https://www.judcouncil.mn/site/status\\_page/shezhistory](https://www.judcouncil.mn/site/status_page/shezhistory)

<sup>37</sup> Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас - <https://csc.gov.mn/content/63e0cab987fcd1bb4003fb1a>

<sup>38</sup> Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудас - [https://pcsp.gov.mn/?page\\_id=4544](https://pcsp.gov.mn/?page_id=4544)

*Хүснэгт 7. УИХ-ын 1992-1996 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд*

<b>№</b>	<b>Хуулийн нэр</b>	<b>Батлагдсан огноо</b>	<b>Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо</b>	<b>Хуулийн дагуу байгуулагдсан институт</b>
1	Монгол Улсын Их Хурлын тухай	1992.07.06	1997.02.06	
2	Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай	1992.07.30	1993	
3	Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	1992.07.31	1996.07.25	
4	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	1992.08.18	2006.12.15	
5	Захиргааны хариуцлагын тухай	1992.11.27	2015.12.04	
6	Монгол Улсын Шүүхийн тухай	1993.02.04	2002.07.04	Шүүхийн ерөнхий зөвлөл
7	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	1993.02.15	2012.12.21	Монгол Улсын Ерөнхийлөгч
8	Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль	1993.04.23	2002.07.04	
9	Монгол Улсын Засгийн газрын тухай	1993.05.06		Монгол Улсын Засгийн газар
10	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль	1993.06.05		
11	Шүүх байгуулах тухай	1993.06.14	2013.01.24	

12	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай	1993.06.17		
13	Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай	1993.07.05	2000.05.12	(Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар нь Засгийн газрын 2004 оны №222 тогтоолоор Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд тохируулагч агентлаг болсон.)
14	Монгол Улсын батлан хамгаалах тухай	1993.10.12	2016.09.01	
15	Монгол Улсын хилийн тухай	1993.10.21	2016.12.28	
16	Төр, сүм хийдийн харилцааны тухай	1993.11.11		
17	Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай	1993.12.02	2013.07.05	
18	Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай	1993.12.06	1996.11.31	
19	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай	1993.12.20		
20	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай	1993.12.24	2010.07.08	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх зөвлөл (1994 он Засгийн газрын №107 тогтоолоор Хууль зүйн яамны дэргэд байгуулагдсан.)
21	Статистикийн тухай	1994.03.17	1997.07.03	Үндэсний статистикийн хороо

22	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	1994.05.09	2002.04.01	
23	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай	1994.05.10	1996.11.15	Хорих байгууллагуудыг удирдах газар (1992-1996 онд)
24	Иргэний хамгаалалтын тухай	1994.05.24	2003.06.20	Иргэний хамгаалалтын байгууллага (1994-2003 онд)
25	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай	1994.07.05	2021.07.07	
26	Жагсаал, цуглаан хийх журмын тухай	1994.07.07		
27	Монгол Улсын Иргэний хууль	1994.11.01	2002.01.10	
28	Өмгөөллийн тухай	1994.12.09	2002.05.16	
29	Төрийн албаны тухай	1994.12.30	2002.06.28	Төрийн захиргааны албаны зөвлөл (1995.06.02)
30	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	1995.03.27	2003.01.03	
31	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	1995.04.17		
32	Төрийн нууцын тухай	1995.04.18	2016.12.01	
33	Хувь хүний нууцын тухай	1995.04.21	2021.12.17	
34	Байгууллагын нууцын тухай	1995.05.16		
35	Харьяатын тухай	1995.06.05		
36	Төрийн нууцын жагсаалт батлах тухай	1995.07.04	2004.01.02	
37	Дотоодын цэргийн тухай	1995.10.17	2014.01.16	
38	Ард нийтийн санал асуулгын тухай	1995.10.19	2016.02.05	



39	Гадаад худалдааны арбитрын тухай	1995.10.26	2003.05.09	
40	Онц байдлын тухай	1995.11.14		
41	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай	1995.12.11	1996.11.15	
42	Авилгалын эсрэг хууль	1996.04.05	2006.07.06	
43	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	1996.04.30	2015.07.08	
44	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	1996.05.27		Төрийн өмчийн хороо (1996.07.31-ний өдөр Засгийн газрын №177 тогтоолоор байгуулагдсан. 2016.01.04-ний өдөр татан буугдсан.)

**Монгол Улсын Засгийн газар:** Үндсэн хуулийн 39-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ, мөн хуулийн 41-д заасны дагуу Засгийн газрын тэргүүн буюу Ерөнхий сайд Засгийн газрыг удирдан зохион байгуулж, төрийн бодлогыг хэрэгжүүлж, хууль сахиулах ажлыг УИХ-ын өмнө хариуцна, мөн Засгийн газар үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнана.

Сонгуульд ялалт байгуулсан улс төрийн хүчин улс орны хэмжээнд хэрэгжүүлэх нийгэм-эдийн засаг-улс төрийн зорилтуудаа тодорхойлсон мөрийн хөтөлбөрийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлдэг.

1992 оны 07 дугаар сард УИХ-аас Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай болон Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулиудыг шинэчлэн баталж, 1990 онд батлагдсан хуулиудыг хүчингүй болгожээ. Шинэчлэн баталсан хуулиудын дагуу Засгийн газар нь бүтцийн хувьд 16 яам, бүрэлдэхүүний хувьд дараах 19 сайдтай ажиллахаар тогтжээ.<sup>39</sup> Үүнд:

<sup>39</sup> Хэрлэн Г. Засгийн газар (1990-2016). 102-108 дахь тал.

- 1) Монгол Улсын Ерөнхий сайд;
- 2) Монгол Улсын Ерөнхий сайдын орлогч;
- 3) Засаг захиргааны сайд;
- 4) Үндэсний хөгжлийн сайд;
- 5) Байгаль орчны сайд;
- 6) Барилга, хот байгуулалтын сайд;
- 7) Батлан хамгааллын сайд;
- 8) Шинжлэх ухаан, боловсролын сайд;
- 9) Гадаад харилцааны сайд;
- 10) Геологи, эрдэс баялгийн сайд;
- 11) Зам тээвэр, холбооны сайд;
- 12) Сангийн сайд;
- 13) Соёлын сайд;
- 14) Түлш, эрчим хүчний сайд;
- 15) Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд;
- 16) Хүнс, хөдөө аж ахуйн сайд;
- 17) Худалдаа, үйлдвэрийн сайд;
- 18) Хууль зүйн сайд;
- 19) Эрүүл мэндийн сайд.

Үндсэн хуулийн 40.1-т заасны дагуу Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Энэ хугацааг дуустал ажилласан хоёр Засгийн газрын нэг нь 1992-1996 онд ажилласан энэхүү Засгийн газар ажээ. (Нөгөө нь 2000-2004 онд ажилласан Засгийн газар байв.)

Шинэ Үндсэн хуульд Монгол Улсын Засгийн газрын эрх хэмжээ, эрх зүйн байдал, чиг үүрэг, бүрэн эрхийн хугацаа, эмхлэн байгуулах, Засгийн газрын тэргүүний эрх зүйн байдлын үндсийг тодорхойлсон. Үүний дагуу хожим нь 1993 онд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд түүнээс хойш уг хуульд 85 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт ороод байна. (2023.06.19-ний байдлаар)

## **5.2.Хоёр дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (1996-2000 он)**

**УИХ-ын ээлжит сонгуулийн дүн:** 1996 оны 06 дугаар сарын 30-ны өдөр болсон ээлжит сонгуулиар УИХ-ын гишүүнийг нэг мандат бүхий 76 тойргоос шууд сонгосон. Уг сонгуульд улс төрийн 5 нам, 2 эвсэл, 35 бие даан нэр дэвшигч өөрсдийн мөрийн хөтөлбөртэй оролцжээ. Сонгуулийн дүнд МҮАН, МСДН-ын “Ардчилсан холбоо” эвсэл 50, МАХН 25, МУНН 1 суудал тус тус авсан.<sup>40</sup>

<sup>40</sup> Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)

**УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан засаглалын талаар:** Намуудын мөрийн хөтөлбөр дэх засаглалын талаар дэвшүүлснийг үзэхэд, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, улс төрийн шинэчлэлтийг зах зээлийн болон ардчилсан нийгэм дэх шаардлагын дагуу хөгжүүлэх, төрийн тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн байв.

*Хүснэгт 8. УИХ-д суудал авсан нам, эвслийн 1996 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал*

<b>№</b>	<b>Нам, эвслийн нэр</b>	<b>Сонгуульд оролцсон уриа, эрмэлзэл</b>	<b>Мөрийн хөтөлбөрт засаглалын талаар тусгасан гол агуулга</b>
1	“МҮАН, МСДН-ын ардчилсан холбоо” эвсэл (50 суудал)		Тус эвслийн “Сонгогчидтой байгуулах гэрээ”-нд <b>төрийн захиргааны төв байгууллагын бүтцийг өөрчлөх</b> ба ингэхдээ Засгийн газрын үүргийг зах зээлийн болон ардчилсан нийгэм дэх шаардлагад нийцүүлэн үйл ажиллагааг нь иргэдэд үйлчлэх, нийгмийн эрүүл орчин бий болгоход чиглүүлэх”-ээр тусгасан байна. <i>Эх сурвалж: Х.Дашзэвэг. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996).</i>
2	МАХН (25 суудал)	<b>Уриа</b> – Эх орон, ард түмний төлөө! <b>Эрмэлзэл</b> – Хүн-хөдөлмөр-хөгжил.	Туснамаас <b>“Эрхзүйт төрийн бэхжилт нь иргэдийн амгалан аж төрөх баталгаа”</b> хэмээн дэвшүүлээд ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс төрийн шинэчлэлтийг гүнзгийрүүлэн, төрийн тогтолцоог бэхжүүлэхээр мөрийн хөтөлбөртөө тусгажээ. <i>Эх сурвалж: “Үнэн” сонин. 1996.04.26, №48.</i>
3	МУНН (1 суудал)	<b>Уриа</b> – Монголын ард түмний төлөө.	Тус намаас төрийн үндсэн үүрэг нь үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг сахиулах явдал гэж үзэн төрийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, шүүх засаглалыг жинхэнэ утгаар нь бүрдүүлэн тогтооход чухалчлан анхаархаа амлажээ. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – www.gec.gov.mn</i>

**“Улс төрийн шинэ хүчин давамгайлсан УИХ”-ын онцлог:** Энэ удаагийн сонгуулиар сонгогчид олон шинэ залуу ардчилсан хүчнийхэнд итгэл найдвар хүлээлгэж, төрийн эрх мэдэл анх удаа улс төрийн шинэ хүчинд шилжсэн онцлогтой Парламент байгуулагдсан. Олон жил төрийн эрх барьсан, туршлагатай улс төрийн том хүчин болох МАХН анх удаа цөөнх болж, засгийн эрх барих нам, хүчний байр суурьт эргэлт болжээ.<sup>41</sup>

**Батлагдсан онцлог хуулиуд:** Энэ удаагийн Улсын Их Хурал Банкны тухай, Дампуурлын тухай, Даатгалын тухай, Компанийн тухай, Төрийн бус байгууллагын тухай, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай, Ашигт малтмалын тухай, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай, Орон сууц хувьчлалын тухай зэрэг эдийн засаг, нийгмийн шинэчлэлийг гүнзгийрүүлэн бататгахад зарчмын ач холбогдол үзүүлсэн олон хуулийг баталжээ. Мөн иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн Төрийн бус байгууллагын тухай зэрэг бие даасан хуулийг батлан гаргажээ.

1996 онд УИХ-аас жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны өдрийг “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр” болгон тэмдэглэж байхаар тогтон УИХ-ын тогтоол гаргасан. Энэ дагуу 1996 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх цуглаан жанжин Д.Сүхбаатарын талбайд болж, Монголын төр ард түмнийхээ өмнө анх удаа уучлал гуйсан байна.<sup>42</sup>

Түүнчлэн Улсын Их Хурлаас баталсан Ажлын таван өдөртэй долоо хоногт шилжих тухай хуулийн дагуу 1998 оноос Монгол Улс ажлын таван өдөртэй долоо хоногт шилжжээ.

**Байгуулагдсан институтууд:** 1993 онд УИХ-аас Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг баталсан боловч энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий **Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрыг** хожим нь буюу Засгийн газрын 2004 оны 222 дугаар тогтоолоор Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд тохируулагч агентлагийн статустайгаар байгуулжээ.<sup>43</sup>

1996-2000 оны УИХ-аас засаглалтай холбоотой баталсан (бие даасан) хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтуудын талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

<sup>41</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>, Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.

<sup>42</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>

<sup>43</sup> Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын цахим хуудас - <https://afccp.gov.mn/content/71>

**Хүснэгт 9. УИХ-ын 1996-2000 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан  
засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу  
байгуулагдсан институтууд**

<b>№</b>	<b>Хуулийн нэр</b>	<b>Батлагдсан огноо</b>	<b>Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо</b>	<b>Хуулийн дагуу байгуулагдсан институт</b>
1	Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль	1996.07.25	2000.08.03	
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай	1996.08.27	2007.01.18	
3	Төв банк /Монголбанк/-ны тухай	1996.09.03		Монголбанк
4	Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай	1996.11.15	2002.05.10	Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар (1996 оны 12 дугаар сараас)
5	Төрийн бус байгууллагын тухай	1997.01.31		
6	Монгол Улсын Их Хурлын тухай хууль	1997.02.06	2001.06.21	
7	Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг	1997.02.06	2001.06.21	
8	Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай	1997.02.06	2006.01.26	
9	Аудитын тухай	1997.05.01	2015.06.19	
10	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай	1997.05.01		
11	Нотариатын тухай	1997.05.02	2011.02.10	
12	Статистикийн тухай	1997.06.05		
13	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай	1997.06.13	2001.11.08	

14	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	1997-12-05	2019.06.06	
15	Гүйцэтгэх ажлын тухай	1997.12.19		
16	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай	1998.01.02		
17	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай	1998.08.28		
18	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай	1999.07.01		
19	Тагнуулын байгууллагын тухай	1999.07.08		
20	Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай	2000.01.28	2015.12.04	
21	Цөмийн зэвсгээс ангид байх тухай	2000.02.03		
22	Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай	2000.05.12	2010.06.10	(Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар нь Засгийн газрын 2004 оны №222 тогтоолоор Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд тохируулагч агентлаг болсон.)

**Монгол Улсын Засгийн газар:** Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг баригч, доктор, профессор Б.Чимид өгүүлэхдээ “Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн хоёр нь шүтэлцээтэй, гэхдээ бүтэц нь нэлээд өргөн ойлголт бөгөөд үндсэн ба дэд бүтэц гэж хоёр ангилна” гэсэн байна<sup>44</sup>:

- **үндсэн бүтэц** бол Монгол Улсын яамд болон Засгийн газрын гишүүний тэргүүлдэг гүйцэтгэх эрх мэдлийн бусад төв байгууллагын тогтолцоог;
- **дэд бүтэц** бол Засгийн газрын гишүүний харьяанд (хуульд томъёолсноор “эрхлэх асуудлын хүрээнд”) байгуулагдсан бөгөөд яамнаас бие даасан агентлагийг.

<sup>44</sup> Чимид Б. 2008. 276-281 дахь тал.

Шинэ Парламент Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. 1996 оны 07 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн<sup>45</sup> дагуу Засгийн газар нь Ерөнхий сайд болон 9 яамны сайд нарын бүрэлдэхүүнтэй ажиллахаар тогтжээ. Энэ үед яамдыг “ерөнхий чиг үүргийн” ба “чиглэлийн” гэж ангилсан байна. Үүнд:

***Ерөнхий чиг үүргийн яам:***

- 1) Сангийн яам;
- 2) Гадаад харилцааны яам;
- 3) Хууль зүйн яам;

***Чиглэлийн яам:***

- 4) Байгаль орчны яам;
- 5) Батлан хамгааллын яам;
- 6) Гэгээрлийн яам;
- 7) Дэд бүтцийн хөгжлийн яам;
- 8) Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам;
- 9) Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам.

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн тухай” УИХ-ын 1996 оны 40 дүгээр тогтоолоор<sup>46</sup> Засгийн газар 23 тохируулагч агентлаг, 35 хэрэгжүүлэгч агентлагтай байхаар тогтсон.

Энэ Парламентын үед Засгийн газрыг огцруулах тухай хоёр удаа санал гарсан нь Монголын төрийн түүхэн дэх ардчилсан засаглалын тогтолцооны хариуцлагын нэгэн хэлбэр болж тогтсоноороо онцлог байв<sup>47</sup>:

- 1997 онд УИХ дахь МАХН-ын бүлгийн нэр бүхий 24 гишүүний гаргасан саналыг УИХ хэлэлцэн олонхын саналаар Ерөнхий сайд М.Энхсайханы Засгийн газарт итгэл хүлээлгэсэн;
- 1998 онд УИХ дахь ардчилсан хүчний олонхын нэр бүхий 11 гишүүний гаргасан мэдэгдлийг үндэслэн Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын мэдэгдлийг УИХ хэлэлцэн “Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах тухай” УИХ-ын тогтоол баталсан.

<sup>45</sup> Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль. **1996.07.25.** Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1996 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>46</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн тухай” УИХ-ын **1996.08.30**-ны өдрийн №40 тогтоол.

<sup>47</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>

### 5.3. Гурав дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2000-2004 он)

**УИХ-ын ээлжит сонгуулийн дүн:** УИХ-ын гишүүдийг сонгох сонгуульд 602 хүний нэр дэвшигдсэний 575 нь улс төрийн 13 нам, 3 эвслээс, 27 нь бие даан нэр дэвшигч байв. Энэ удаагийн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн тоо 1996 оныхтой харьцуулахад хоёр дахин илүү байсан.

2000 оны 07 дугаар сарын 02-ны өдөр болсон УИХ-ын сонгуулийн дүнд МАХН 72, МҮАН-МШАН-ын “Ардчилсан холбоо” эвсэл, ИЗН-НН эвсэл, Эх орон-МАШСН, бие даан нэр дэвшигч тус бүр 1 суудал (Л.Гүндалай) авч<sup>48</sup>, МАХН дахин Парламентад үнэмлэхүй олонх болжээ.

**УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан засаглалын талаар:** Намуудын мөрийн хөтөлбөр дэх засаглалын талаар дэвшүүлснийг үзэхэд, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах, гэмт хэрэг, авлигатай хийх тэмцлийг чангатган нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, төрийн албаны хариуцлагын тогтолцоог сайжруулах зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн байна.

*Хүснэгт 10. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2000 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал*

№	Нам, эвслийн нэр	Сонгуульд оролцсон уриа, эрмэлзэл	Мөрийн хөтөлбөрт засаглалын талаар тусгасан гол агуулга
1	МАХН (72 суудал)	<b>Уриа</b> – Эх орон, ард түмний төлөө! <b>Эрмэлзэл</b> – Хүн-хөдөлмөр-хөгжил.	МАХН-аас сонгуульд “Шударга төр, Журамт нийгэм”-ийн төлөө “Засаглалын хямралыг арилгах, дэг журмыг бэхжүүлэх бодлого”-ыг дэвшүүлсэн байна. <i>Эх сурвалж: “Үнэн” сонин. 2000.05.23, №96.</i>
2	МҮАН-МШАН-ЫН “Ардчилсан холбоо” эвсэл (1 суудал)		Тус эвсэл нь сонгуулийн хөтөлбөрөө “Сонгогчидтой байгуулах гэрээ” хэлбэрээр гаргасан бөгөөд гэрээндээ “төрийн байгууллагуудын удирдлагад хүйсийн зохистой харьцааг буй болгох, эмэгтэйчүүдийг дэмжсэн бодлого” явуулахаа амласан байна <i>Эх сурвалж: Х.Дашзэвэг. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996).</i>
3	ИЗН-НН эвсэл (1 суудал)		Эвсэл нь “Хүчтэй шударга төр, цэгцтэй зах зээлийн төлөө” хуулийн өмнө иргэн бүр адил тэгш захирагдахын төлөө байхаа амласан байна. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – www.ges.gov.mn</i>
4	Эх орон-МАШСН (1 суудал)	<b>Уриа</b> – Өөртөө итгэж, өөрсдөө хийцгээе.	Эх орон - МАШСН <b>авлига, хуйвалдааныг таслан зогсооход</b> голлон анхаарна гэсэн байна. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – www.ges.gov.mn</i>

<sup>48</sup> Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – www.ges.gov.mn



“Үнэмлэхүй олонхын УИХ”-ын онцлог: 2000-2004 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн УИХ-ын үйл ажиллагааны гол онцлог, үр дүн нь төрийн бодлогын тогтвортой шинж, үйл ажиллагааны нэгдмэл цогц байдлыг хангаж, төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлсэн, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, бодлогын чанартай болон эрх зүйн томоохон шийдлүүдийг гаргахад бодитой алхам хийсэн Парламент байв.<sup>49</sup>

Тухайлбал, Сонгуулийн нэгэн бүрэн эрхийн хугацаа дуусаж, дараагийн сонгуулийг товлон зарлахаас нэг сарын өмнө улс орны эдийн засаг, нийгмийн болон санхүүгийн байдлыг мэдээлдэг шинэ жишиг тогтоосон нь төр, засгийн байгууллага сонгогчдын өмнө хүлээсэн үүргээ хэр зэрэг биелүүлж байгаагаа үнэлүүлэх боломжийг бүрдүүлсэн.<sup>50</sup>

**Батлагдсан онцлог хуулиуд:** УИХ бүрэн эрхийнхээ хугацаанд зарим **хуулиудыг шинэчлэн баталснаар** УБХ, түүнээс өмнө батлагдсан дараах хуулиудыг хүчингүй болгосон байна:

- 1962 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг;
- 1990 онд батлагдсан Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хуулийг;
- 1990 онд батлагдсан Монгол Улсын иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай хуулийг;
- 1992 онд батлагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг;
- 1992 онд батлагдсан Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийг.

УИХ-аас Төрийн албаны тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай болон Төрийн аудитын тухай хуулиуд батлагдаж, эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн шинэ орчин бүрдэв.

Газрын шинэтгэлийн бодлогыг тодорхойлсон газрын тухай багц хууль, түүний дотор Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлан гаргасан нь иргэний нийгмийн баталгааг хангах, газрыг аж ахуйн эргэлтэд оруулах хийгээд **анх удаа иргэд газраа өмчлөх эрхийг нээж өгсөн** чухал ач холбогдолтой болжээ.

<sup>49</sup> Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.

<sup>50</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>

Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Монголын төр, засгийн бодлого, тогтвортой үйл ажиллагаа нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсныг онцлох нь зүйтэй юм. Тухайлбал, **дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт анх удаагаа 10 орчим хувиар нэмэгджээ.**

**Байгуулагдсан институтууд:** УИХ бүрэн эрхийнхээ хугацаанд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай, Төрийн албаны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай болон Төрийн аудитын тухай хуулиудыг баталж, эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн шинэ орчныг бүрдүүлжээ.

Тухайлбал, УИХ Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах эрхэм зорилгын хүрээнд Хүний эрхийн Үндэсний хөтөлбөрийг баталж, Хүний эрхийн үндэсний комиссыг байгуулсан. Тодруулбал, 2000 оны 12 дугаар сард УИХ-аас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль батлагдаж, тус Комиссын анхны 3 гишүүнийг томилсноор хүний эрхийн үндэсний байгууллага үүссэн байна. **Хүний эрхийн Үндэсний комисс** нь Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага юм.<sup>51</sup>

2002 онд УИХ-аас Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай болон Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн баталснаар 1996 онд байгуулагдсан Төрийн захиргааны албаны зөвлөлийг **Төрийн албаны зөвлөл** болгон өөрчилж үйл ажиллагаа нь улам өргөжин тэлсэн. Төрийн албаны төв байгууллага нь хамтын удирдлагын зарчмаар ажиллаж, төрийн албан хаагчийн стандартын удирдлагыг улсын хэмжээнд нэгдсэн аргачлалаар хангах, хэрэгжүүлэх ажлыг эрхэлдэг, үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнадаг хараат бус, бие даасан байгууллага юм.<sup>52</sup>

УИХ-аас 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих орон тооны бус **Үндэсний зөвлөлийг** байгуулж ажиллуулсан.

Мөн УИХ-аас Монгол Улсын Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг томоохон хуулиудыг шинээр баталсан.

<sup>51</sup> Хүний эрхийн Үндэсний Комиссын цахим хуудас - <https://nhrcm.gov.mn/page/17>

<sup>52</sup> Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас - <https://csc.gov.mn/content/63e0cab987fcd1bb4003fb1a>

2002 онд УИХ-аас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг баталснаар Монгол Улсад **Захиргааны хэргийн дагнасан шүүх** байгуулагдах эрх зүйн үндсийг бүрдүүлж, 2004 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагджээ. Захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг хамгаалж, сэргээн тогтоох чиг үүрэгтэй бөгөөд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1-т заасны дагуу төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус акттай холбоотой хэрэг, маргааныг харьяалан шийдвэрлэдэг.<sup>53</sup> УИХ-аас засаглалтай холбоотой баталсан (бие даасан) хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтуудын талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

*Хүснэгт 11. УИХ-ын 2000-2004 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд*

<b>№</b>	<b>Хуулийн нэр</b>	<b>Батлагдсан огноо</b>	<b>Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо</b>	<b>Хуулийн дагуу байгуулагдсан институт</b>
1	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль	2000.12.07	2020.01.23	Хүний эрхийн Үндэсний комисс (2001.02.02-нд байгуулагдсан)
2	Галт зэвсгийн тухай	2001.04.26	2015.08.07	
3	Монгол Улсын Их Хурлын тухай	2001.06.21	2006.01.26	
4	Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай	2001.06.21	2009.07.16	
5	Харилцаа холбооны тухай /Шинэчилсэн найруулга/	2001.10.18		
6	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай	2003.06.12	2015.02.18	
7	Үндэсний аюулгүй байдлын тухай	2001.12.27		
8	Эрүүгийн хууль	2002.01.03		
9	Эрүүгийн байцаан шийтгэх хууль	2002.01.10	2017.05.18	
10	Иргэний хууль	2002.01.10		
11	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	2002.01.10		

<sup>53</sup> Монгол өмгөөлөгч Хууль зүйн фирм - <https://advocate.mn/news/73/single/50>

12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай	2002.01.10	2017.06.09	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (2002 оноос)
13	Монгол Улсын хилийг шалгасан баримт бичиг батлах тухай	2002.01.10		
14	Зэвсэгт хүчний тухай	2002.05.16	2016.09.01	
15	Өмгөөллийн тухай	2002.05.16	2012.03.07	
16	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай	2002.06.27	2011.12.23	
17	Төрийн албаны тухай	2002.06.28	2017.12.07	Төрийн албаны зөвлөл (2002.06.07-ны өдрийн хуулиар Төрийн захиргааны албаны зөвлөл нь Төрийн албаны зөвлөл болж өөрчлөгдсөн.)
18	Шүүхийн тухай	2002.07.04	2012.03.07	
19	Прокурорын байгууллагын тухай	2002.07.04	2017.06.09	
20	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай	2002.12.06	2016.02.04	
21	Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай	2002.12.26	2013.01.24	Захиргааны хэргийн шүүх
22	Төрийн хяналт шалгалтын тухай	2003.01.03		
23	Арбитрын тухай	2003.05.09	2017.01.26	
24	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай	2003.05.30		
25	Төрийн аудитын тухай	2003.06.01	2020.05.01	
26	Гамшгаас хамгаалах тухай	2003.06.20	2017.02.02	Онцгой байдлын байгууллага (2003 онд Иргэний хамгаалалтын байгууллагыг Онцгой байдлын байгууллагад нэгтгэн зохион байгуулсан.)
27	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль	2004.04.15		
28	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль	2004.04.15		
29	Терроризмтой тэмцэх тухай	2004.04.23		

**Монгол Улсын Засгийн газар:** Үндсэн хуулийн 40.1-т заасны дагуу Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Энэ хугацааг дуустал ажилласан хоёр Засгийн газрын нэг нь 2000-2004 онд ажилласан энэхүү Засгийн газар ажээ. (Нөгөө нь 1992-1996 онд ажилласан Засгийн газар байв.)

2000 оны 08 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн<sup>54</sup> дагуу Засгийн газар нь Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ)-ын дарга, Монгол Улсын 2 сайд болон дараах 11 яамны сайд нарын бүрэлдэхүүнтэй ажиллахаар тогтсон. Үүнд:

***Ерөнхий чиг үүргийн яам:***

- 1) Гадаад хэргийн яам;
- 2) Санхүү, эдийн засгийн яам;
- 3) Хууль зүй, дотоод хэргийн яам;

***Чиглэлийн яам:***

- 4) Байгаль орчны яам;
- 5) Батлан хамгаалах яам;
- 6) Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 7) Дэд бүтцийн яам;
- 8) Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;
- 9) Үйлдвэр, худалдааны яам;
- 10) Хүнс, хөдөө аж ахуйн яам;
- 11) Эрүүл мэндийн яам.

2000-2004 онд ажилласан Засгийн газар нь Үндсэн хуулийн 40.1-д заасан 4 жилийн бүрэн эрхийн хугацааг дуустал ажилласан хоёр дахь Засгийн газар юм. УИХ-ын 2000 оны 32<sup>55</sup>, 2001 оны 45<sup>56</sup>, 2002 оны 24 дүгээр<sup>57</sup> тогтоолуудаар Засгийн газар 17 тохируулагч, 31 хэрэгжүүлэгч агентлагтай ажиллаж байгаад 2002 оны 58 дугаар тогтоолоор<sup>58</sup> 8 тохируулагч, 35 хэрэгжүүлэгч агентлагтай ажиллажээ.

<sup>54</sup> Засгийн газрын бүтцийн тухай хууль; Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль. 2000.08.03. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2000 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>55</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын **2000.09.01**-ны өдрийн №32 тогтоол.

<sup>56</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын **2001.05.25**-ны өдрийн №45 тогтоол.

<sup>57</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын **2002.05.30**-ны өдрийн №24 тогтоол.

<sup>58</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын **2002.07.10**-ны өдрийн №58 тогтоол.

#### **5.4. Дөрөв дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2004-2008 он)**

**УИХ-ын ээлжит сонгуулийн дүн:** Энэ удаагийн УИХ-ын сонгуульд улс төрийн 7 нам, 1 эвсэл, мөн 15 бие даан нэр дэвшигчид оролцов.

2004 оны 06 дугаар сарын 27-ны өдөр болсон УИХ-ын сонгуулийн дүнд МАХН 37, АН, Эх орон-МАШСН, ИЗН-ын “Эх орон-Ардчилал” эвсэл 35, БНН 1 суудал, бие даан нэр дэвшигч 3 суудал (Р.Амаржаргал, Д.Одхүү, Я.Санжмятав) авчээ.<sup>59</sup> Ингэж сонгуулийн дүнд улс төрийн томоохон хүчнүүдийн харьцангуй тэнцвэртэй төлөөлөл бүхий парламентын олонх, цөөнхгүй өвөрмөц Парламент бүрдсэн нь парламентад суудалтай улс төрийн гол хүчнүүдэд хамтран зөвшилцөж ажиллах түүхэн шинэ боломж нээж өгсөн онцлогтой юм. Тиймээс МАХН, “Эх орон-Ардчилал” эвсэл ард түмнийхээ нийтлэг эрх ашиг, улс нийгмийнхээ хөгжил дэвшлийн төлөө харилцан хяналттай, хамтран ажиллах улс төрийн зөвшилцөөнд хүрч, “Зөвшилцлийн гэрээ” байгуулан хамтарсан Засгийн газар байгуулж ажиллуулсан.

УИХ дахь “Эх орон-Ардчилал” эвсэл 2004 оны 12 дугаар сард татан буугдсан ч төр, Засгийн газрын тогтвортой ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор Ардчилсан намын болон ИЗБН-аас УИХ-д сонгогдсон нийт 26 гишүүн УИХ дахь МАХН-ын бүлэгт өөрсдийн саналаар нэгдэн орж ажиллажээ. Харин 2005 оны 07 дугаар сард УИХ дахь МАХН-ын бүлэг дангаараа ажиллах болсон тухай шийдвэр гаргаснаа мэдэгдсэнээр “Үндэсний эв нэгдлийн Засгийн газар” өөрчлөгдөн хамтарсан шинэ Засгийн газар байгуулагдсан. Ийм нөхцөл байдалд Парламентын баримтлах гол зарчим нь улс төрийн намууд харилцан зөвшилцөж, өөр өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэхийн зэрэгцээ улс орон, ард түмнийхээ эрх ашиг, үндэсний эв нэгдлийг дээдлэн ажиллах явдал байв.<sup>60</sup>

**УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан засаглалын талаар:** Намуудын мөрийн хөтөлбөр дэх засаглалын талаар дэвшүүлснийг үзэхэд, ардчилал, сайн засаглалыг хүний төлөө төлөвшүүлж, төрийн байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, нийгмийн дэг журам, сахилга, хариуцлагыг дээшлүүлэн шүүх эрх мэдэл, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг эрс сайжруулах, ажилтнуудын хариуцлага, сахилга, дэг журам, ёс зүйн хэм хэмжээг өндөржүүлэн хариуцлага тооцох, мэдээлэл, эрх чөлөөг хангахад чиглэсэн байв.

<sup>59</sup> Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn).

<sup>60</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>

*Хүснэгт 12. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2004 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал*

№	Нам, эвслийн нэр	Сонгуульд оролцсон уриа, эрмэлзэл	Мөрийн хөтөлбөрт засаглалын талаар тусгасан гол агуулга
1	МАХН (37 суудал)		МАХН-ын “Таны төлөө тантай хамт” мөрийн хөтөлбөрт “Хүний хөгжлийн төлөө ардчилсан, сайн засаглалыг төлөвшүүлнэ” хэмээн тусгажээ. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.gec.gov.mn">www.gec.gov.mn</a></i>
2	“Эх орон-Ардчилал” эвсэл (35 суудал)		Эвслийн мөрийн хөтөлбөрт <b>захиргаадалтын дарамтыг арилгахаар</b> дэвшүүлж, улс төрийн бүх хүчнүүд улс орондоо иргэний нийгмийг бэхжүүлж улс орноо хамтарч хөгжүүлэхийн төлөө төрийн албан хаагчдыг намын харьяалалгүй болгох, “Электрон засаглал” хөтөлбөр хэрэгжүүлэх, Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нийт иргэдийн хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцэж тэдэнд үйлчилдэг байх шударга шаардлагыг хэрэгжүүлэхээ амлажээ. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.gec.gov.mn">www.gec.gov.mn</a></i>
3	БНН (1 суудал)	<b>Уриа</b> – Бид боломж олгоно. Та бүтээж чадна.	Тус намаас “хүн бүрийн тэгш эрх ардчилсан төрт ёсны мөн чанарыг дээдлэн хүндэтгэсэн, улс төрийн боловсронгуй тогтолцоо зөв бүтэц, сахилга хариуцлагын өндөр зарчимд түшиглэсэн парламентын засаглалын үйл ажиллагааг бүхий л талаар хэрэгжүүлэхийг” эрмэлзэхээ амласан. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.gec.gov.mn">www.gec.gov.mn</a></i>

**“Тэнцвэртэй парламент”-ын онцлог:** 2005 оны 07 дугаар сард УИХ дахь МАХН-ын бүлэг дангаараа ажиллах болсон тухай шийдвэр гаргаснаа мэдэгдсэнээр “Үндэсний эв нэгдлийн Засгийн газар” өөрчлөгдөн хамтарсан шинэ Засгийн газар байгуулагдсан юм. Ийм нөхцөл байдалд парламентын баримтлах гол зарчим нь улс төрийн намууд харилцан зөвшилцөж, өөр өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэхийн зэрэгцээ улс орон, ард түмнийхээ эрх ашиг, үндэсний эв нэгдлийг дээдлэн ажиллах явдал байв. Энэ удаагийн УИХ ийм хариуцлагатай үүргийг нэр төртэй биелүүлж, Монголын парламентат ёсны хөгжлийн ээдрээтэй бөгөөд сургамжтай үеийн түүхийг бүтээсэн гэж үзэж болно.<sup>61</sup>

<sup>61</sup> Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.



**Батлагдсан онцлог хуулиуд:**

- Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл батлан гаргаснаар эрх зүйн шинэчлэлийн бодлогыг гүнзгийрүүлсэн;
- Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг баталсан;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (шинэчилсэн найруулга) хуулийг баталсан;
- Монгол Улсын Их Хурлын тухай (шинэчилсэн найруулга), Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай (шинэчилсэн найруулга) зэрэг хуулиудыг баталсан.
- 2005 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар 1990 оны 05 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Улс төрийн намуудын тухай хуулийг хүчингүй болгосон.

**Байгуулагдсан институтууд:** УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрт Үндэсний телевиз, радиог төрийн хяналтаас гарган бие даасан байдлыг хангах талаар дэвшүүлсэн байсан. Үүний дагуу 2005 оны 01 дүгээр сард УИХ-аас хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт өрсөлдөөнийг дэмжин **Үндэсний радио, телевизийг** Засгийн газрын хараат бус болгож, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль баталж, өөрчлөн зохион байгуулсан. Энэ хуулийн 3-т зааснаар Олон нийтийн радио, телевиз хуулиар байгуулагдах (өөрчлөн байгуулах, нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх, татан буулгах) ба гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн.

2006 оны 01 дүгээр сард Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийг баталсан. Анх УБХ-ын 1992 оны 18 дугаар тогтоолоор УИХ-ын дэргэд байгуулагдаж байсан **Сонгуулийн ерөнхий хорооны** эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэхүү бие даасан хуулиар баталгаажуулсан.<sup>62</sup>

2005 онд УИХ-аас НҮБ-ын Авлигын эсрэг конвенцыг соёрхон баталсан. 2003 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Авлигын эсрэг конвенцыг баталсан билээ. Авлигын улмаас нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсч буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байгааг Авлигын эсрэг конвенцын удиртгал хэсэгт хамгийн эхэнд дурдсан байдаг.

<sup>62</sup> Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn).



2006 онд УИХ-аас шинэчлэн баталсан Авлигын эсрэг хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага болох **Авлигатай тэмцэх газар** байгуулагдан 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхлэв.

Дөрөв дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2004-2008 он)-аас Засаглалтай холбоотой баталсан (бие даасан) хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтуудын талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

*Хүснэгт 13. УИХ-ын 2004-2008 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд*

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо	Хуулийн дагуу байгуулагдсан институт
1	Олон нийтийн радио, телевизийн тухай	2005.01.27		
2	Улс төрийн намын тухай / шинэчилсэн найруулга/	2005.01.28		
3	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай	2005.11.17		Санхүүгийн зохицуулах хороо
4	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай	2005.12.29	2011.12.15	
5	Сонгуулийн төв байгууллагын тухай хууль	2006.01.12		Сонгуулийн ерөнхий хороо (1992.04.10-нд байгуулагдсан)
6	Монгол Улсын Их Хурлын тухай	2006.01.26	2020.05.01	
7	Авлигалын эсрэг хууль	2006.07.06		Авлигатай тэмцэх газар (2007.01.11-нд байгуулагдсан)
8	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	2006.12.15		
9	Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай	2007.01.18	2012.09.14	
10	Улсын нөөцийн тухай	2007.07.05		
11	Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай	2007.08.03		
12	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай	2007.10.11	2020.05.13	

**Монгол Улсын Засгийн газар:** 2004 оны 08 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн<sup>63</sup> дагуу Засгийн газар нь Ерөнхий сайд, Шадар сайд, ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын 2 сайд болон яамд хариуцсан 13 сайд, нийт 18 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар тогтсон. Хуулийн дагуу дараах 13 яам байгуулагдсан:

***Ерөнхий чиг үүргийн яам:***

- 1) Гадаад хэргийн яам;
- 2) Сангийн яам;
- 3) Хууль зүй, дотоод хэргийн яам;

***Чиглэлийн яам:***

- 4) Байгаль орчны яам;
- 5) Батлан хамгаалах яам;
- 6) Барилга, хот байгуулалтын яам;
- 7) Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 8) Зам тээвэр, аялал жуулчлалын яам;
- 9) Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;
- 10) Хүнс, хөдөө аж ахуйн яам;
- 11) Түлш, эрчим хүчний яам
- 12) Эрүүл мэндийн яам;
- 13) Үйлдвэр, худалдааны яам.

УИХ-ын 2004 оны 14<sup>64</sup>, 2008 оны 35<sup>65</sup>, 45<sup>66</sup> дугаар тогтоолуудаар Засгийн газар 12 тохируулагч, 23 хэрэгжүүлэгч агентлагтай ажиллажээ.

**5.5.Тав дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2008-2012 он)**

**УИХ-ын ээлжит сонгуулийн дүн:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай шинэчлэн найруулсан хуулийн дагуу тав дахь удаагийн УИХ-ын гишүүдийг 76 мандаттай, томсгосон 26 тойргоос шууд сонгосон. УИХ-ын ээлжит сонгуульд улс төрийн 12 нам, 1 эвсэл, 45 бие даан нэр дэвшигч өөрсдийн мөрийн хөтөлбөртэй оролцжээ.

<sup>63</sup> Засгийн газрын бүтцийн тухай хууль; Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль. **2004.09.22.** Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2004 оны 37 дугаарт нийтлэгдсэн. ШАЛГАХ, ХҮСНЭГТ 12Т БАЙГААГҮЙ

<sup>64</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын **2004.09.22**-ны өдрийн №14 тогтоол.

<sup>65</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын **2008.05.25**-ны өдрийн №35 тогтоол.

<sup>66</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын **2008.05.22**-ны өдрийн №45 тогтоол.

2008 оны 06 дугаар сарын 29-ний өдөр болсон УИХ-ын ээлжит сонгуулийн дүнд УИХ-д МАХН 46, АН 27, ИЗН, НН, бие даан нэр дэвшигч (З.Алтай) тус бүр 1 суудал авсан байна.<sup>67</sup>

**УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан засаглалын талаар:** Намуудын мөрийн хөтөлбөр дэх засаглалын талаар дэвшүүлснийг үзэхэд, эрх зүйн шинэтгэлийг зохистой үргэлжлүүлэх, хууль дээдлэх ёсыг хэвшүүлэх, төвлөрлийг сааруулах, төрийн албаны ардчилсан тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэх, төрийн бүхий л үйл ажиллагаанд шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад иргэдийн оролцоог хангахад чиглэсэн байв.

*Хүснэгт 14. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2008 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал*

№	Нам, эвслийн нэр	Сонгуульд оролцсон уриа, эрмэлзэл	Мөрийн хөтөлбөрт засаглалын талаар тусгасан гол агуулга
1	МАХН (46 суудал)	Уриа – Шударга ёс – хариуцлагатай төр, Дэвших хөгжил – дэвших амьдрал.	Тус нам нь <b>эрх зүйт төрийн төгөлдөршлийн төлөө Иргэдийн оролцоо, иргэний нийгмийг төгөлдөршүүлэхийг</b> зорьсон байна. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – www.ges.gov.mn</i>
2	АН (27 суудал)	Уриа – Иргэн бүрт – эрдэнийн хувь.	<b>“Эзэн монгол хүн”</b> нь эрх чөлөөтэй, баян чинээлэг, эрдэм чадал бүрэн, ёс суртал өндөр, эрүүл чийрэг байхын хэрээр эх орон нь хөгжилтэй, хүчирхэг болдог шалгарсан чиглэлийг Монгол Улсын хөгжлийн баримжаагаа болгон <b>Монголд шударга ёс тогтоох, иргэний нийгэм цогцлоон хөгжүүлэх нь Ардчилсан намын язгуур зорилт</b> хэмээсэн байна. <i>Эх сурвалж: Х.Дашзэвэг. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996).</i>
3	ИЗН (1 суудал)		Тус намаас “Шударга бус явдал, авлига, хээл хахуулиас болж алдагдаж буй монгол хүний эх оронч, үндэсний үзэл, хүнлэг чанар, хүмүүжлийг иргэдэд төлөвшүүлэх ажилд төр засаг, иргэний нийгмийн анхаарлыг хандуулах”-ыг зорьсон байна. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – www.ges.gov.mn</i>
4	НН (1 суудал)		Тус намаас <b>“Иргэний хяналттай төрийн тогтолцоо, Иргэндээ үйлчилдэг төрийн байгууллага”-ын төлөө ажиллахаа амласан байна.</b> <i>Эх сурвалж: Х.Дашзэвэг. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996).</i>

<sup>67</sup> Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – www.ges.gov.mn.

**“Улсын хөгжил, төрийн тогтвортой байдлыг эрхэмлэсэн УИХ”-ын онцлог:** Улс төрийн зөвшилцлөөр хамтарсан Засгийн газар байгуулан мөрийн хөтөлбөрөө хамтарч хэрэгжүүлэх томоохон зорилт тавьж ажилласнаар улс төрийн тогтвортой байдлыг хангаж, улмаар нийгмийн өмнө тулгамдсан олон чухал зорилтыг шийдвэрлэсэн.<sup>68</sup>

Энэ удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаа нь улс орны эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн суурийг тавьсан жилүүд байв. 2009 оны эхээр дэлхий дахиныг хамраад байсан санхүүгийн хямрал манай улсын эдийн засаг, нийгмийн байдалд сөргөөр нөлөөлж эхэлсэн тул 2009 оны 02 дугаар сарын 12-ны өдөр **санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний төлөвлөгөөг** баталсан. Энэ хүрээнд Атрын 3 дахь аян, 100 мянган айлын орон сууцны хөтөлбөр, уул уурхайн салбарыг дэмжиж экспортын орлогыг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд банк, санхүү, төсөв, бодит салбарын үйл ажиллагааг дэмжих, тогтворжуулахад шаардлагатай хөрөнгийг гадаад, дотоодын эх үүсвэрээс шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

#### **Батлагдсан онцлог хууль тогтоомжууд:**

- **Оюутолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай тогтоол** баталж, ордыг ашиглах, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. Түүнчлэн **Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах** зарим асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоол баталж, тус ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч **“Эрдэнэс-Тавантолгой” компанийн хувьцааны 10 хүртэл хувийг Монгол Улсын нийт иргэнд адил тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн.**
- Нийгмийн халамжийн бодлогод шинэчлэл хийж, Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн баталснаар урьд нь хавтгайруулан олгодог байсан халамжийн хэлбэрийг өөрчилж, төрийн халамж, үйлчилгээг нийгмийн зайлшгүй шаардлагатай зорилтот хэсэг рүү чиглүүлсэн.
- **Хүний хөгжил сангийн тухай хууль** батлан гаргасан нь ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх боломж бүрдүүлэв.
- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд илүүтэй анхаарч хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлж ажиллажээ.**

<sup>68</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>, Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.

- Нийгэмд шударга ёсыг төлөвшүүлэх, **төрийн дээд, өндөр албан тушаалтны ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх үүднээс Улсын Их Хурлын гишүүний Ёс зүйн дүрмийг** баталсны зэрэгцээ энэ асуудлыг хариуцан ажилладаг **Ёс зүйн дэд хороо**ны эрх зүйн орчныг бүрдүүлж өгөв. Түүнчлэн төрийн албаны сонирхлын зөрчлийн асуудлыг нухацтай авч үзэж тусгайлан хууль баталсны зэрэгцээ Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хуульд холбогдох заалтууд нэмсэн байна.<sup>69</sup>
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан нь энэ парламентын түүхэн шийдвэрийн нэг юм. Сонгуулийн үед иргэдийн саналыг мөнгөөр худалдан авахыг санаархдаг, биелэх үндэслэлгүй амлалт өгдөг, санал хураалтын дүнг хэн нэгэн нэр дэвшигч, аль нэг улс төрийн хүчний ашиг сонирхолд нийцүүлэхийг оролддог бусармаг аргыг шинэ хуулиар хааж өгсөн нь нийгэмд шударга ёсыг тогтоох, төрд итгэх иргэд сонгогчдын итгэлийг сэргээхэд чиглэсэн чухал алхам болсон билээ.  
УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгч, мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбоотой харилцааг нэг хуулиар зохицуулж, эдгээр сонгуулийг нэг ижил хугацаанд явуулж байхаар тогтож, үндсэн зарчим, журмыг нэг мөр тодорхойлж өгөв.
- Зарим бодлогын баримт бичгүүд: Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого (2009.10.15, 64), Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого (2009.06.25, 45), Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал (2011.02.10, 10).
- 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдөр УИХ-аас Монгол Улсын Шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг, мөн оны 05 дугаар сарын 22-ны өдөр Шүүхийн захиргааны тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиудыг тус тус баталсан нь 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлжээ.

**Байгуулагдсан институт:** Үндсэн хуулийн 49.5-д “Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж заасны дагуу **Шүүхийн ерөнхий зөвлөлийн** бүтэц, чиг үүрэг, бүрэн эрхийг Шүүхийн захиргааны тухай бие даасан хуулиар зохицуулсан нь Монгол Улсад шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах институцийн баталгааг бүрдүүлсэн.<sup>70</sup>

<sup>69</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>

<sup>70</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл - [https://www.judcouncil.mn/site/status\\_page/shezhistory](https://www.judcouncil.mn/site/status_page/shezhistory)

Тав дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2008-2012 он)-аас Засаглалтай холбоотой баталсан (бие даасан) хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтуудын талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

*Хүснэгт 15. УИХ-ын 2008-2012 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд*

<b>№</b>	<b>Хуулийн нэр</b>	<b>Батлагдсан огноо</b>	<b>Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо</b>	<b>Хуулийн дагуу байгуулагдсан институт</b>
1	Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай	2009.06.04		
2	Шүүхийн шинжилгээний тухай	2009.12.03	2022.12.23	
3	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай	2010.12.23		
4	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай	2010.12.31	2013.01.24	
5	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай	2011.06.16	2021.10.29	
6	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай	2011.11.10		
7	Цахим гарын үсгийн тухай	2011.12.15	2021.12.17	
8	Хүн худалдаалахтай тэмцэх тухай	2012.01.19		
9	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	2012.01.19		
10	Монгол Улсын шүүхийн тухай	2012.03.07	2021.01.15	
11	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай	2012.03.07	2021.01.15	
12	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай	2012.04.27	2015.12.15	
13	Шүүхийн захиргааны тухай	2012.05.22	2021.03.01	Шүүхийн ерөнхий зөвлөл
14	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай	2012.05.22	2021.01.15	
15	Эвлэрүүлэн зуучлалын тухай	2012.05.22		
16	Засгийн газрын бүтцийн тухай	2012.08.16	2014.12.04	

17	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	2012.08.16	2014.12.04	
18	Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай	2012.09.14	2015.12.15	
19	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай /Шинэчилсэн найруулга/	2012.12.21	2015.12.25	
20	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай /Шинэчилсэн найруулга/	2015.12.15	2011.12.15	

**Монгол Улсын Засгийн газар:** 2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн<sup>71</sup> дагуу Засгийн газар нь Ерөнхий сайд, Тэргүүн Шадар сайд, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга болон яамд хариуцсан 11 сайд, нийт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар тогтсон. Хуулийн дагуу дараах 11 яам байгуулагдсан:

***Ерөнхий чиг үүргийн яам:***

- 1) Гадаад харилцааны яам;
- 2) Сангийн яам;
- 3) Хууль зүй, дотоод хэргийн яам;

***Чиглэлийн яам:***

- 4) Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- 5) Батлан хамгаалах яам;
- 6) Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 7) Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам;
- 8) Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;
- 9) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 10) Эрдэс баялаг, эрчим хүчний яам;
- 11) Эрүүл мэндийн яам.

УИХ-ын 2008 оны 43<sup>72</sup>, 2009 оны 54<sup>73</sup>, 2012 оны 14<sup>74</sup> дүгээр тогтоолуудаар Засгийн газар 13 тохируулагч, 33 хэрэгжүүлэгч агентлагтай ажиллажээ.

<sup>71</sup> Засгийн газрын бүтцийн тухай хууль; Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль. **2008.09.17.** Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2008 оны 35 дугаарт нийтлэгдсэн.

<sup>72</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын **2008.12.19**-ны өдрийн №43 тогтоол.

<sup>73</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын **2009.07.13**-ны өдрийн №54 тогтоол.

<sup>74</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын **2012.01.27**-ны өдрийн №14 тогтоол.



## 5.6.Зургаа дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2012-2016 он)

**УИХ-ын ээлжит сонгуулийн дүн:** УИХ-ын зургаа дахь удаагийн сонгууль хэд хэдэн онцлогтой явагдсан: хууль эрх зүйн шинэ орчинд сонгуулийн хосолсон тогтолцоогоор анх удаа зохион байгуулсан, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн дагуу сонгуулийн санал авах, тоолох, дүн гаргах болон сонгогчийн бүртгэл хяналтын үйл ажиллагаанд автоматжуулсан системийг анх удаа ашигласан, гадаад оронд байгаа сонгогчдынхоо саналыг анх удаа авсан, УИХ-ын 2012 оны ээлжит сонгууль болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль 06 дугаар сарын 28-ны өдрийн Пүрэв гарагт улс орон даяар зэрэг явагдсан зэрэг байв.<sup>75</sup>

УИХ-ын ээлжит сонгуульд улс төрийн 11 нам, 2 эвсэл, 26 бие даан нэр дэвшигч өөрсдийн мөрийн хөтөлбөртэй оролцжээ.

УИХ-ын ээлжит сонгуулийг сонгуулийн хосолсон тогтолцоогоор анх удаа зохион байгуулахад УИХ-ын 76 гишүүний 48 нь мандатын журмаар 26 тойргоос, үлдсэн 28 нь сонгуулийн дүнгээр улс төрийн намуудын авсан саналын дүнгээр гишүүнээр сонгогдсон.

Сонгуулийн дүнгээр АН-аас 34, МАН-аас 26, МАХН, МҮАН-ын “Шударга ёс” эвслээс 11, ИЗНН-аас 2, бие даан нэр дэвшсэн 3 хүн (С.Ганбаатар, Х.Болорчулуун, Ц.Даваасүрэн) тус тус УИХ-ын гишүүнээр сонгогдсон байна.<sup>76</sup> Энэ удаагийн Парламент нь УИХ-д гурван намын бүлэг байгуулагдаж, тэдгээрийг төлөөлсөн УИХ-ын гурван дэд даргатай, хамгийн олон намын төлөөлөлтэй байсан.

**УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан засаглалын талаар:** Намуудын мөрийн хөтөлбөр дэх засаглалын талаар дэвшүүлснийг үзэхэд, ил тод, мэргэшсэн, иргэдийн оролцоог хангасан төрийн боловсронгуй бүтэцтэй бөгөөд хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлэх, улс төрийн нөлөөнөөс ангид, хүний эрхийг дээдэлсэн, шударга шүүх эрх мэдлийг төлөвшүүлэх зэрэгт чиглэсэн байв.

<sup>75</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>

<sup>76</sup> Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn).



*Хүснэгт 16. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2012 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал*

№	Нам, эвслийн нэр	Сонгуульд оролцсон уриа, эрмэлзэл	Мөрийн хөтөлбөрт засаглалын талаар тусгасан гол агуулга
1	АН (34 суудал)		Тус намаас <b>Эрх чөлөөтэй Монгол хүний төлөө</b> төрийн албан тушаалтны эрх мэдлийг тодорхойлсон хууль зүйн бодлогыг өөрчилж иргэний эрхийг хамгаалж, иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчилэхийг зорьсон. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.gec.gov.mn">www.gec.gov.mn</a></i>
2	МАН (26 суудал)	<b>Уриа –</b> Иргэнд тэгш боломж, Нийгэмд шударга ёс.	Тус намаас <b>Төрийн үйлчилгээг сайжруулъя, түмний оролцоог хангахын</b> тулд илтөд, мэргэшсэн, иргэдийн оролцоог хангасан, иргэдийнхээ итгэл дэмжлэгийг хүлээсэн төрийн хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлэхээ амлажээ. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.gec.gov.mn">www.gec.gov.mn</a></i>
3	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвсэл (11 суудал)	<b>Уриа –</b> Хүн ард минь нэгдээрэй, Хөх Монгол минь сэрээрэй.	Тус эвслээс Олигархи дэглэмээс салгахын төлөө <b>Улс төрийн хувьсгал</b> , ард түмний хяналтыг тогтоохын төлөө <b>Шударга ёсны хувьсгал</b> хийхийг зорьсон. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.gec.gov.mn">www.gec.gov.mn</a></i>
4	АН (34 суудал)		<b>Иргэний зориг-ногоон намын мөрийн хөтөлбөр</b> (2 суудал) <b>шинэ засаглал - ард түмний засаглал</b> Монголын төр нь хувь хүний эрх, эрх чөлөө, хувийн өмчийн халдашгүй байдлыг дархалсан, монгол хүний тайван, сайхан амьдралын нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй тунгалаг, эрүүл байх учиртай. Өөрөө бүгдийг хэрэгжүүлэгч төр байж, хувь хүнийг төр өөрөөсөө хамааралтай болгох учиргүй. <i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.gec.gov.mn">www.gec.gov.mn</a></i>

**“Сонгуулийн холимог тогтолцоогоор бүрдсэн УИХ”-ын онцлог<sup>77</sup>:** УИХ 2013 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхээс гадна УИХ, түүний Байнгын болон дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судлах, шийдвэрлэх; өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах чиг үүрэгтэй **Өргөдлийн байнгын хороо**г шинээр байгуулснаар

<sup>77</sup> Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.

зургаа дахь удаагийн УИХ зохион байгуулалтын бүтцийн хувьд 8 Байнгын хороотойгоор үйл ажиллагаагаа явуулсан.

Аль ч нам Засгийн газраа дангаар байгуулах хэмжээний олонхын суудал аваагүй тул олон суудал авсан Ардчилсан нам МАХН, МҮАН-ын “Шударга ёс” эвсэлтэй хамтран “Шинэчлэлийн” хэмээх тодотголтой Засгийн газрыг байгуулан ажилласан бөгөөд 2015 онд МАН-тай богино хугацаанд хамтарч “Шийдлийн” Засгийн газар байгуулан ажилласан.

Зургаа дахь удаагийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд дэлхийн эдийн засагт хямрал нүүрлэсэн цаг үе тохиосон тул үүссэн хүндрэлийг гарз хохирол багатай даван туулах, улс орны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хөгжил дэвшил, бүтээн байгуулалтыг өрнүүлэх арга хэмжээ авч ажилласан юм.

- Энэ УИХ **хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, бизнесийн салбарыг дэмжихэд онцгой анхаарал хандуулсан** бөгөөд Хөрөнгө оруулалтын тухай, Үйлдвэрлэлийг дэмжих тухай, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Ногоон хөгжлийн бодлого зэрэг баримт бичгүүдийг баталжээ.
- Түүнчлэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталсан нь Монгол Улс хөгжлөө бодлого, төлөвлөлтөөр удирдах эрх зүйн үндсийг тавьж, **“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”** баримт бичгээр улс орны ойрын 15 жилийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон.
- **Хууль хяналтын байгууллагын тогтолцоонд эрх зүйн шинэтгэл хийсэн** гэсэн тодорхойлолт энэ парламентад хамаарна. Учир нь Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай, Хууль сахиулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн албаны тухай, Прокурорын байгууллагын тухай хуулиудын шинэчилсэн найруулгыг баталсан юм.
- Намуудын сонгуульд өрсөлдсөн мөрийн хөтөлбөрт “Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ, шаардлага, хэрэгжилтийг үнэлдэг болох”-ыг зорьсон байсан. Үүний дагуу 2015 оны 05 дугаар сард УИХ-аас **Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан**. Энэ хууль батлагдсанаар хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, УИХ-д өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцаа илүү тодорхой болсон байна.

**Байгуулагдсан институтууд:** 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Тахарын албаны тухай хуулийн 1.1-д заасны дагуу шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий **Тахарын албыг** байгуулжээ. Тус албаны тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, Тахарын албаны алба хаагчийн эрх зүйн байдлыг уг хуулиар тогтоосон байна.

Шүүх байгуулах тухай хуулийн зарим зүйл, заалт нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөж буй талаарх нэр бүхий иргэдийн гаргасан гомдлыг Үндсэн хуулийн Цэцийн их суудлын хуралдаанаар хэлэлцэн Шүүх байгуулах тухай хууль Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн дүгнэлтийг УИХ хүлээн авч 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Шүүх байгуулах тухай хуулийг шинэчлэн баталсан. Энэ хуулийн дагуу Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх нь Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх нь **Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх** болон өөрчлөгдөж, хэрэг, маргааныг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяалал, тэдгээрийн байршлыг шинэчлэн тогтоож нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийн хэрэг, маргааныг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхээр болсон.<sup>78</sup>

Зургаа дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2012-2016 он)-аас засаглалтай холбоотой баталсан (бие даасан) хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтуудын талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

<sup>78</sup> Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн цахим хуудас - <https://appealcourt.mn/site/tuuu.html>

*Хүснэгт 17. УИХ-ын 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтууд*

<b>№</b>	<b>Хуулийн нэр</b>	<b>Батлагдсан огноо</b>	<b>Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо</b>	<b>Хуулийн дагуу байгуулагдсан институт</b>
1	Засгийн газрын бүтцийн тухай	2012.08.16	2014.12.04	
2	Засгийн газрын бүтцийн тухай	2014.12.04	2016.07.21	
3	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	2012.08.16	2014.12.04	
4	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль	2012.12.21	2015.12.25	
5	Шүүх байгуулах тухай / Шинэчилсэн найруулга/	2013.01.24	2015.06.19	
6	Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай	2013.07.03		
7	Тахарын албаны тухай	2013.07.05	2016.07.21	Тахарын алба
8	Цагдаагийн албаны тухай	2013.07.05	2017.02.09	
9	Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай	2013.07.05	2022.07.01	
10	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай	2013.07.05		
11	Шилэн дансны тухай	2014.07.01		
12	Засгийн газрын бүтцийн тухай	2014.12.04	2016.07.21	
13	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	2014.12.04	2016.07.21	
14	Хууль тогтоомжийн тухай / Шинэчилсэн найруулга/	2015.05.29		
15	Шүүх байгуулах тухай / Шинэчилсэн найруулга/	2015.06.19		Давж заалдах шатны шүүх байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосон.
16	Аудитын тухай /Шинэчилсэн найруулга/	2015.06.19		
17	Захиргааны ерөнхий хууль	2015.06.19		
18	Нийтийн сонсголын тухай	2015.07.08		

19	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай	2015.08.07		
20	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай	2015.11.26	2020.05.07	
21	Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/	2015.12.03		
22	Зөрчлийн тухай	2017.05.11	2015.12.04	
23	Сонгуулийн тухай хууль	2015.12.25		
24	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/	2016.02.04		
25	Ард нийтийн санал асуулгын тухай /Шинэчилсэн найруулга/	2016.02.05		

**Монгол Улсын Засгийн газар:** 2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн<sup>79</sup> дагуу Засгийн газар нь Ерөнхий сайд, Шадар сайд, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга болон яамд хариуцсан 16 сайд, нийт 19 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар тогтсон. Хуулийн дагуу дараах яамд байгуулагдсан:

***Ерөнхий чиг үүргийн яам:***

- 1) Гадаад харилцааны яам;
- 2) Сангийн яам;
- 3) Хууль зүйн яам;
- 4) Байгаль орчин, ногоон хөгжлийн яам;

***Чиглэлийн яам:***

- 5) Батлан хамгаалах яам;
- 6) Барилга, хот байгуулалтын яам;
- 7) Боловсрол, шинжлэх ухааны яам;
- 8) Зам, тээврийн яам;
- 9) Соёл, спорт, аялал жуучлалын яам;
- 10) Уул уурхайн яам;
- 11) Хөдөлмөрийн яам;
- 12) Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам;
- 13) Үйлдвэр, хөдөө аж ахуй яам;
- 14) Эдийн засгийн хөгжлийн яам;
- 15) Эрчим хүчний яам;
- 16) Эрүүл мэндийн яам.

<sup>79</sup> Засгийн газрын бүтцийн тухай хууль; Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль. **2012.08.16.** Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2012 оны 33 дугаарт нийтлэгдсэн.

УИХ-ын 2012 оны 14<sup>80</sup>, 67<sup>81</sup>, 2013 оны 76<sup>82</sup>, 2014 оны 55 дугаар<sup>83</sup> тогтоолуудаар Засгийн газар 13 тохируулагч, 18 хэрэгжүүлэгч агентлагтай ажиллаж байгаад УИХ-ын 2014 оны 75<sup>84</sup>, 2015 оны 100 дугаар<sup>85</sup> тогтоолоор 9 тохируулагч, 18 хэрэгжүүлэгч агентлагтай ажилласан байна.

### **5.7.Долоо дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2016-2020 он)**

**УИХ-ын ээлжит сонгуулийн дүн:** УИХ-ын долоо дахь удаагийн сонгуулийг 2016 оны 06 дугаар сарын 29-ний өдөр орон даяар явуулж, УИХ-ын гишүүдийг 76 мандат бүхий жижигсгэсэн 76 тойргоос шууд сонгосон. Ээлжит сонгуульд улс төрийн 12 нам, 3 эвсэл, 69 бие даан нэр дэвшигч өөрсдийн мөрийн хөтөлбөртэй оролцжээ.

Сонгуулийн дүнгээр УИХ-ын гишүүнээр МАН-аас 65, АН-аас 9, МАХН-аас 1, бие даан нэр дэвшигч 1 хүн (С.Жавхлан) тус тус сонгогдсон юм.<sup>86</sup> УИХ-д сонгогдсон гишүүдийн 13 нь буюу 17.1 хувь нь эмэгтэйчүүд байсан нь өмнөх парламентуудаас хамгийн өндөр үзүүлэлт байв.

УИХ-ын ээлжит сонгууль анх удаа Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай хамт явагдсан, сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн утгаар нь төгс хэрэгжүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ сонгох эрхийг хангахад илүү анхаарсан, саналын хуудас нь өндөр нууцлалтай, бар кодтой, брайль үсгийн хавтастай болсон зэрэг олон шинэчлэлийг хэрэгжүүлсэн онцлог сонгууль байв.<sup>87</sup>

**УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан засаглалын талаар:** Намуудын мөрийн хөтөлбөр дэх засаглалын талаар дэвшүүлснийг үзэхэд, МАН-ын хувьд эрх мэдлийн харилцан хяналт, тэнцэлтэй, тогтвортой, хариуцлагатай төрийг бий болгохын төлөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан ард түмнээсээ асууж шийдвэрлэхэд, АН-ын хувьд хүний жам ёсны, заяагдмал эрх, хувийн өмчийг дээдэлсэн, хуулийн засаглалыг тогтооход,

<sup>80</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын 2012.08.12-ны өдрийн №14 тогтоол.

<sup>81</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын 2012.12.12-ны өдрийн №67 тогтоол.

<sup>82</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын 2013.12.26-ны өдрийн №76 тогтоол.

<sup>83</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын 2014.10.07-ны өдрийн №55 тогтоол.

<sup>84</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын 2014.12.04-ны өдрийн №75 тогтоол.

<sup>85</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай” УИХ-ын 2015.11.13-ны өдрийн №100 тогтоол.

<sup>86</sup> Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn).

<sup>87</sup> Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>

МАХН-ын хувьд төрийн эрх мэдлийг олигархуудын гараас ард түмний гарт хуулийн хүрээнд сонгуулиар шилжүүлэх “сонгуулийн хувьсгал” хийхэд энэ тэргүүнд тавьсан байв.

*Хүснэгт 18. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал*

№	Нам, эвслийн нэр	Сонгуульд оролцсон уриа, эрмэлзэл	Мөрийн хөтөлбөрт засаглалын талаар тусгасан гол агуулга
1	МАН (65 суудал)	Уриа – Бид зүтгэнэ, хамтдаа хөгжинө.	<p><b>“Бид хамтдаа чадна”</b> нэртэй тус намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт сайн засаглалыг хөгжүүлэх (ажлын байрын тогтвортой байдлыг бий болгох, цалин нэмэх, төрийн албан хаагчдын нийгмийн халамжийг сайжруулах, УИХ-ын гишүүдийг “давхар дээлгүй” болгох, намуудын төсвийн ил тод байдлыг хангах) талаар түлхүү тусгасан байна.</p> <p><i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.hec.gov.mn">www.hec.gov.mn</a></i></p>
2	АН (9 суудал)	Уриа – Ахиулан хийх ажил их байна, Шинэчлэлээс шийдэл рүү.	<p>АН “Монгол хүн 2020” хөтөлбөрөө шинэчлэн, үргэлжлүүлж 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр болгосон байв. АН уг хөтөлбөрөө амжилттай үргэлжлүүлснээр бодит, эерэг үр дүнд хүрнэ гэсэн үндэслэлийг дэвшүүлсэн байв. Тус намын мөрийн хөтөлбөрт “Хүний жам ёсны, заяагдмал эрх, хувийн өмчийг дээдэлсэн, хуулийн засаглалыг тогтооно.” гэж тусгаад засаглалын төвлөрлийг сааруулах бодлого (орон нутгийн өөрөө удирдах нэгжүүдэд захиран зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, 15.000-аас илүү хүн амтай суурьшмал газруудыг хот болгох), дэд бүтцийг хөгжүүлэх (Тээврийн тухай шинэ хууль, дотоодын төмөр замыг хөгжүүлэх) болон эдийн засгийг солонгоруулах (газар тариаланчдыг болон залуу малчдыг дэмжих төсөл) зэрэгт оршиж байв.</p> <p><i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.hec.gov.mn">www.hec.gov.mn</a></i></p>
3	МАХН (1 суудал)	Уриа – Сонгуулийн хувьсгалаас, Хөгжлийн хувьсгалд.	<p>МАХН-ын мөрийн хөтөлбөрт “Сонгуулийг улс төр бизнесийн бүлэглэлүүдээс хараат бус хөндлөнгийн, шударга иргэдийн хяналтад явуулдаг “Сонгуулийн хувьсгал” хийхээр тусгасан байна.</p> <p><i>Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо – <a href="http://www.hec.gov.mn">www.hec.gov.mn</a></i></p>

**“Үндсэн хуулийн шинэчлэлийн парламент”-ын онцлог<sup>88</sup>:** Энэ Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт зэрэг эрх зүйн томоохон шинэчлэл хийсэн парламент юм. Арав гаруй жил яригдаж, дөрвөн төсөл өргөн мэдүүлсэн ч амжилтад хүрээгүй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ 158 хоног тасралтгүй хэлэлцэн, баталсан бол 2019 оны 03 дугаар сараас хойш намар-хавар-намрын гэсэн 3 чуулган завсарлагагүй хуралдаж олон чухал хуулийг баталсан.

Парламентын шинэчлэлийг эхлүүлж, гишүүдийн ирц, үг хэлэх, санал хураахад хурууны хээгээр бүртгэдэг болсноор хуралдааны ирц дээшилсэн. Төрийг удирдах үйл хэрэгт иргэдийг оролцуулах зорилгоор **Зөвлөлдөх санал асуулгыг** анх удаа зохион байгуулсан. Баялгийн өгөөжийг иргэддээ тэгш, шударга хуваарилах Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг хэрэгжүүлж эхэлсэн.

Энэ Улсын Их Хурал нь КОВИД-19-ийн цар тахлын үед үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, анх удаа цахимаар хуралдсан парламент бөгөөд улсын эдийн засаг, иргэдийнхээ амьжиргааг цар тахлын нөлөөллөөс үүдсэн бэрхшээл хямралд нэрвүүлэхгүй байх чиглэлээр олон чухал шийдвэр гаргаж хэрэгжүүлсэн.

Мөн зарим **хуулиудыг** боловсронгуй болгон шинэчлэн баталснаар УБХ-аас баталсан батлан хамгаалахын багц хууль, тэр дундаа Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг хүчингүй болгожээ.

Долоо дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2016-2020 он)-аас Засаглалтай холбоотой баталсан (бие даасан) хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтуудын талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

<sup>88</sup> Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.



*Хүснэгт 19. УИХ-ын 2016-2020 оны бүрэн эрхийн хугацаанд  
батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу  
байгуулагдсан институтууд*

<b>№</b>	<b>Хуулийн нэр</b>	<b>Батлагдсан огноо</b>	<b>Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо</b>	<b>Хуулийн дагуу байгуулагдсан институт</b>
1	Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай	2016.07.21		
2	Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	2016.07.21		
3	Монгол Улсын Батлан хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/	2016.09.01		
4	Зэвсэгт хүчний тухай /Шинэчилсэн найруулга/	2016.09.01		
5	Цэргийн албаны тухай	2016.09.01		
6	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай	2016.09.01		
7	Төрийн болон албаны нууцын тухай	2016.12.01		
8	Монгол Улсын хилийн тухай /Шинэчилсэн найруулга/	2016.12.28		
9	Арбитрын тухай /шинэчилсэн найруулга/	2017.01.26		
10	Цагдаагийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/	2017.02.09		
11	Зөвлөлдөх санал асуулгын тухай	2017.02.09		
12	Дотоодын цэргийн тухай	2017.02.09		
13	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/	2017.05.18		
14	Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/	2017.05.11		
15	Зөрчил шалган шийдвэрлэх тухай	2017.05.18		
16	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /Шинэчилсэн найруулга/	2017.06.09		
17	Прокурорын тухай /Шинэчилсэн найруулга/	2017.06.09		
18	Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай	2017.07.10		
19	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/	2017.12.07		

20	Өмгөөллийн тухай	2019.10.18		
21	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай	2019.11.14		
22	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай	2019.12.20		
23	Монгол Улсын Их Хурлын тухай хууль	2020.05.07		Хянан шалгах түр хороо
24	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай /Шинэчилсэн найруулга/	2020.01.23		
25	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай	2020.01.30		
26	Төрийн аудитын тухай /Шинэчилсэн найруулга/	2020.05.01		
27	Монгол Улсын Их Хурлын тухай /Шинэчилсэн найруулга/	2020.05.07		
28	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/	2020.05.07		
29	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай /Шинэчилсэн найруулга/	2020.05.13		

**Монгол Улсын Засгийн газар:** 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай болон Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн<sup>89</sup> дагуу Засгийн газар нь Ерөнхий сайд, Шадар сайд, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга болон яамд хариуцсан 13 сайд, нийт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар тогтсон. Хуулийн дагуу дараах 13 яам байгуулагдсан:

***Ерөнхий чиг үүргийн яам:***

- 1) Гадаад харилцааны яам;
- 2) Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- 3) Батлан хамгаалахын яам;
- 4) Сангийн яам;
- 5) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
- 6) Хууль зүй, дотоод хэргийн яам;

***Чиглэлийн яам:***

- 7) Барилга, хот байгуулалтын яам;
- 8) Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;

<sup>89</sup> Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль; Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль. 2016.07.21. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2016 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

- 9) Зам, тээврийн хөгжлийн яам;
- 10) Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- 11) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 12) Эрчим хүчний яам;
- 13) Эрүүл мэндийн яам.

УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор<sup>90</sup> байгуулсан Засгийн газрын агентлагийн тоо хэд хэдэн удаа өөрчлөгдөн 11 тохируулагч, 24 хэрэгжүүлэгч агентлагтай ажиллажээ. Тус тогтоолд дахин нэмэлт, өөрчлөлт ороогүй байна.

### **5.8. Найм дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2020-2024 он)**

**УИХ-ын ээлжит сонгуулийн дүн:** 2019 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу УИХ-ын гишүүдийг мажоритар тогтолцоогоор, томсгосон 29 тойргоос шууд сонгосон. УИХ-ын сонгуульд улс төрийн 14 нам, 3 эвсэл, 121 бие даан нэр дэвшигч өөрсдийн мөрийн хөтөлбөртэй оролцжээ. УИХ-ын энэ удаагийн сонгуульд бие даан нэр дэвшигчдийн тоог 2016 оныхтой харьцуулахад, нэг дахин нэмэгджээ.

2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр болсон сонгуулийн дүнд МАН-аас 62, АН-аас 11, МАХН, ИЗНН, МУНН-ын “Та бидний эвсэл”-ээс 1, Хөдөлмөрийн Үндэсний нам (одоогийн ХҮН нам), МСДН, Зүй ёс намын “Зөв хүн электорат” эвслээс 1, бие даан нэр дэвшигч 1 хүн (Н.Алтанхуяг) УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Ийнхүү МАН дахин Парламентын үнэмлэхүй олонх болж, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө дараагийн 4 жил хэрэгжүүлэн ажиллаж байна.

**УИХ-д суудал авсан намуудын мөрийн хөтөлбөрүүдэд тусгасан засаглалын талаар:** Мөрийн хөтөлбөрүүд дэх засаглалын талаар дэвшүүлснийг үзэхэд, шударга ёсны засаглал, цахим Монгол – хүнд сурталгүй, авлигагүй төрийн үйлчилгээ, мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба, ардчилсан, хүний эрхийг дээдэлсэн улс, иргэнээ хамгаалдаг хууль болоход чиглэжээ.

<sup>90</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын 2016.07.21-ны өдрийн №12 тогтоол.

*Хүснэгт 20. УИХ-д суудал авсан нам, эвслийн 2020 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд засаглалын талаар тусгасан байдал*

№	Нам, эвслийн нэр	Сонгуульд оролцсон уриа, эрмэлзэл	Мөрийн хөтөлбөрт засаглалын талаар тусгасан гол агуулга
1	МАН (62 суудал)	Уриа – Хүчээ нэгтгэе, Багаар нь дэмжье.	<p><b>Нийгэм дэх тэгш бус байдлыг багасгах, нийгмийн хөгжил иргэн бүрт тэгш шударга хүрэх, дундаж давхаргыг дэмжих</b> зорилтуудыг мөрийн хөтөлбөртөө онцлон тусгажээ.</p> <p>Мөрийн хөтөлбөрөө боловсруулж батлахдаа “Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын төсөл зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг үндэс болгосон байна.</p> <p><i>Эх сурвалж: МОНЦАМЭ – <a href="https://montsame.mn/mn/read/227291">https://montsame.mn/mn/read/227291</a></i></p>
2	АН (11 суудал)		<p>Монгол өрх, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн “Монгол өрх-Хөгжлийн бодлого” мөрийн хөтөлбөртөө <b>“Иргэнээ хамгаалдаг хууль, Иргэндээ үйлчилдэг засаглал, Хөгжлийг дэмждэг хууль”</b> гэж тусгажээ.</p> <p><i>Эх сурвалж: МОНЦАМЭ – <a href="https://montsame.mn/mn/read/227291">https://montsame.mn/mn/read/227291</a></i></p>
3	МАХН-ИЗНН-МУНН-ын “Та бидний эвсэл” (1 суудал)		<p>“Монголын гурван баялаг” хөтөлбөрт дараах гурван баялгийн амин холбоог сэргээх бодлогыг тодорхойлжээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• эх орныхоо эзэн, эрүүл саруул, өргүй, өндөр боловсролтой <b>Монгол хүн</b> – Монголын суурь баялаг;</li> <li>• ажилтай, орлоготой, орон сууцтай <b>Монгол өрх</b> – Монголын тулгуур баялаг;</li> <li>• хүнээ хамгаалдаг, авлигаас ангид <b>Монгол төр засаг</b> – Монголын түшиг баялаг.</li> </ul> <p>Тус эвсэл нь ард түмэнтэйгээ хамтдаа <b>Ард түмний төр засгийг</b> эмхлэн байгуулах ба Хууль тогтоох, Хууль хэрэгжүүлэх, Шүүх, Хянах харилцан тэнцвэртэй хараат бус засаглалын эрх мэдэлд хуваарилахыг ард түмнээсээ асууж зөвхөн дэмжсэн тохиолдолд цогцоор нь шийдвэрлэхээр мөрийн хөтөлбөртөө тусгажээ.</p> <p><i>Эх сурвалж: МОНЦАМЭ – <a href="https://montsame.mn/mn/read/227717">https://montsame.mn/mn/read/227717</a></i></p>
4	Хөдөлмөрийн үндэсний нам, МСДН, Зүй ёс намын “Зөв хүн электорат” эвсэл (1 суудал)	Уриа – Зөвхөн зөв хүн.	<p>Мөрийн хөтөлбөртөө “Төрөө цэвэрлэж, хүчтэй болгож байж Монгол Улс сэргэн хөгжинө.” гэж тусгажээ.</p> <p><i>Эх сурвалж: МОНЦАМЭ – <a href="https://montsame.mn/mn/read/227503">https://montsame.mn/mn/read/227503</a></i></p>

**“Шинэ ирээдүйн төлөөх УИХ”-ын онцлог<sup>91</sup>:** Шинэ парламентын бүрэлдэхүүний 42.6 хувийг анх удаа сонгогдсон 32 гишүүн бүрдүүлж байгаа нь шинэ залуу гишүүд шинэчлэл өөрчлөлт, шинэ ирээдүйд тэмүүлсэн шинэ бодлого шийдвэр гаргаж, Монгол Улсаа сэргээн мандуулах шинэ алхам хийнэ гэж олон нийт итгэл хүлээлгэж байгаа билээ.

Энэ удаагийн парламент 2019 оны **Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг “амилуулж”**, эрх зүйн томоохон шинэтгэл хийх үүргийг хүлээж байгаа. Нөгөө талаар дэлхий дахиныг хамарсан цар тахлын таагүй нөлөөллөөс улсаа, эдийн засгаа, иргэдээ хамгаалах, цаашид тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх, нэгэнт эрчээ авч эхэлсэн шударга ёсны төлөөх тэмцлийг үр дүнд хүргэх бодлого, шийдвэр гаргах, төрд сахилга хариуцлага, ёс зүйг хэвшүүлэх чиглэлээр үлгэр дуурайл үзүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Энэ Улсын Их Хурлаас засаглалыг сайжруулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг сайжруулах чиглэлээр дараах томоохон хууль, эрх зүйн шинэчлэлийг хийгээд байна. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль;
- Кибер аюулгүй байдлын тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль;
- Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль;
- Нийгмийн даатгалын багц хуулиуд;
- Боловсролын салбарын багц хуулиуд;
- Улс төрийн намын тухай хууль;

<sup>91</sup> Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.

- “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоол;
- Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм” УИХ-ын тогтоол;
- “Шинэ сэргэлтийн бодлого” УИХ-ын тогтоол;
- “Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” УИХ-ын тогтоол;
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” УИХ-ын тогтоол.

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу улс төрийн намын чиг үүрэг, дотоод зохион байгуулалтыг ардчилсан зарчимд нийцүүлэх, намын үйл ажиллагаа, хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг ил тод, нийтэд нээлттэй болгохтой холбогдсон харилцааг **Улс төрийн намын тухай хууль** /Шинэчилсэн найруулга/-аар зохицуулсан. Энэ хуулиар нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл байх; нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгийн төлөөлөл, оролцоог хангах зэрэг олон чухал зохицуулалтыг хийсэн.

БНМАУ-ын Ардын Их Хурал дөрөв дэх буюу Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хуулийг батлах үед Улсын Их Хурлын гишүүний тоог тухайн үеийн нийт хүн амын тоонд үндэслэн нэг гишүүн дунджаар 27 мянган иргэнийг төлөөлөх замаар 76 гишүүнтэй байхаар хуульчилсан байсан. **Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт**өөр хүн амын тоо, газар нутгийн хэмжээнээс хамаарч парламентын гишүүдийн тоог тогтоож, иргэдийг төлөөлөх парламентын чадамжийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүдийн тоог хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлсэн. Хуульд “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэсэн өөрчлөлтийг оруулсан.

Найм дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ (2020-2024 он)-аас Засаглалтай холбоотой баталсан (бие даасан) хуулиуд, тэдгээрийн дагуу байгуулагдсан институтуудын талаар дараах хүснэгтээс үзнэ үү.

*Хүснэгт 21. УИХ-ын 2020-2024 оны бүрэн эрхийн хугацаанд  
батлагдсан засаглалтай холбоотой хуулиуд, тэдгээрийн дагуу  
байгуулагдсан институтууд*

<b>№</b>	<b>Хуулийн нэр</b>	<b>Батлагдсан огноо</b>	<b>Хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан огноо</b>	<b>Хуулийн дагуу байгуулагдсан институт</b>
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай /Шинэчилсэн найруулга/	2020.12.24		
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	2020.12.24		
3	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/	2020.12.24		
4	Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/	2021.01.15		Шүүхийн сахилгын хороо
5	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай	2021.04.02		
6	Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай	2021.06.11		
7	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/	2021.07.07		
8	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /Шинэчилсэн найруулга/	2021.12.17		
9	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/	2021.12.17		
10	Цахим гарын үсгийн тухай /Шинэчилсэн найруулга/	2021.12.17		
11	Кибер аюулгүй байдлын тухай	2021.12.17		
12	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль	2021.12.24		Хянан шалгах түр хороо
13	Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/	2022.06.17		

14	Хууль зүйн туслалцааны тухай /Шинэчилсэн найруулга/	2022.07.01		
15	Засгийн газар дахь хяналтын тухай хууль	2022.11.11		Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар (Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгаж, шинээр байгуулсан.)
16	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай	2022.12.09		
17	Шүүх шинжилгээний тухай /Шинэчилсэн найруулга/	2022.12.23		
18	Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай	2023.01.06		
19	Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай	2023.01.20	2023.03.30	
20	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	2023.05.04		
21	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт	2023.05.31		
22	Улс төрийн намын тухай /Шинэчилсэн найруулга/	2023.07.07		

**Монгол Улсын Засгийн газар:** 2016 онд батлагдсан Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулиудад 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж, Засгийн газар нь Ерөнхий сайд, Шадар сайд, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Үндэсний хорооны 3 дарга болон яамд хариуцсан 16 сайд, нийт 22 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар тогтсон. Хуулийн дагуу дараах 16 яам байгуулагдсан: 2022 онд өөрчлөлт оруулсан.

***Ерөнхий чиг үүргийн яам:***

- 1) Гадаад харилцааны яам;
- 2) Сангийн яам;
- 3) Хууль зүй, дотоод хэргийн яам;
- 4) Эдийн засаг, хөгжлийн яам;



**Чиглэлийн яам:**

- 5) Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- 6) Батлан хамгаалах яам;
- 7) Барилга, хот байгуулалтын яам;
- 8) Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 9) Зам, тээврийн хөгжлийн яам;
- 10) Соёлын яам;
- 11) Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- 12) Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, яам;
- 13) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 14) Цахим хөгжил, харилцаа холбооны яам;
- 15) Эрчим хүчний яам;
- 16) Эрүүл мэндийн яам.

УИХ-ын 2020 оны 22 дугаар тогтоолоор<sup>92</sup> байгуулсан Засгийн газрын агентлагийн тоо хэд хэдэн удаа өөрчлөгдөн 9 тохируулагч, 29 хэрэгжүүлэгч агентлагтай ажиллаж байна.

---

<sup>92</sup> “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын 2016.07.21-ны өдрийн №12 тогтоол.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Эмхэтгэл, эрдэм шинжилгээний бүтээл:

- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн танилцуулга. <https://cabinet.gov.mn>
- Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ-ын Тамгын газар. 2020 он.
- Дашзэвэг Х. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989-1996).
- Хэрлэн Г. Засгийн газар (1990-2016).
- Энхбаатар Ч. ба бусад. Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ. УИХ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл. “Мөнхийн Үсэг” ХХК, 2015 он.
- Энхбаатар Ч. ба бусад. Монгол Улсын төрийн тогтолцоон дахь ерөнхийлөгчийн байр суурь: бүрэн эрхийн шинжилгээ (Судалгааны тайлан). Удирдлагын академи. УБ., 2019 он.

Цахим хуудас:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудас - [https://pcsp.gov.mn/?page\\_id=4544](https://pcsp.gov.mn/?page_id=4544)
- Монгол өмгөөлөгч Хууль зүйн фирм - <https://advocate.mn/news/73/single/50>
- Монгол Улсын Их Хурлын цахим хуудас - <https://www.parliament.mn/nc/658/>
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн цахим хуудас - [https://www.conscourt.gov.mn/?page\\_id=756](https://www.conscourt.gov.mn/?page_id=756)
- Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн цахим хуудас - <https://nsc.gov.mn/mn/p/118>
- Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн цахим хуудас - <https://appealcourt.mn/site/tuuh.html>
- Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудас – [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)
- Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас - <https://csc.gov.mn/content/63e0cab987fcd1bb4003fb1a>
- Хүний эрхийн Үндэсний Комиссын цахим хуудас - <https://nhrcm.gov.mn/page/17>
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын цахим хуудас - <https://afccp.gov.mn/content/71>
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас - [https://www.judcouncil.mn/site/status\\_page/shezhhistory](https://www.judcouncil.mn/site/status_page/shezhhistory)

Сонин хэвлэл:

- МОНЦАМЭ – <https://montsame.mn>
- “Үг” сонин. 1992.04.09, №7, 8.
- “Үнэн” сонин. 1992.04.25, №45. 1996.04.26, №48. 2000.05.23, №96.

**ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД БА  
МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ:  
ЗАСАГЛАЛ, ТҮҮНИЙГ ХЭМЖИХ НЬ**

(Тойм судалгаа)

*Д.Халиун*

**АГУУЛГА**

**САЙН ЗАСАГЛАЛЫН ОЛОН УЛСЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

**1.ДЭЛХИЙН НИЙТИЙН ЗАСАГЛАЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

- 1.1.Дэлхийн нийтийн засаглалын шалгуур үзүүлэлт ба Монгол Улс  
Бүс нутгийн тойм:
- 1.2.Иргэдийн дуу хоолой ба хариуцлага
- 1.3.Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/терроризмгүй байх
- 1.4.Засгийн газрын үр нөлөө
- 1.5.Зохицуулалтын чанар
- 1.6.Эрх зүйт ёс
- 1.7.Авлигын хяналт

**2.АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС**

- 2.1.Авлигын төсөөллийн индексийн талаар  
Бүс нутгийн тойм:
- 2.2.Авлигын төсөөллийн индекс ба Монгол Улс

**3.“БИЗНЕС ЭРХЛЭХҮЙ” ТАЙЛАН**

- 3.1.Бизнес эрхлэхүй тайлангийн талаар  
Бүс нутгийн тоймууд

**4.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС**

- 4.1.Хүний хөгжлийн индексийн талаар
- 4.2. Монгол Улсын үзүүлэлт

**5.БЕРТЕЛСМАНЫ ШИЛЖИЛТИЙН ИНДЕКС**

- 5.1.Бертелсманы Шилжилтийн индексийн талаар
- 5.2.Бертелсманы Шилжилтийн индекс ба Монгол Улс

## 6.ЭРХ ЗҮЙТ ЁСНЫ ИНДЕКС

6.1.World Justice Project байгууллагын Эрх зүйт ёсны индексийн талаар

6.2.Эрх зүйт ёсны индекс ба Монгол Улс

## 7.ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

7.1.Цахим засаглалын хөгжлийн индексийн талаар

7.2.Цахим засаглалын хөгжлийн индекс ба Монгол Улс

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Дэлхийн нийтийн засаглалын шалгуур үзүүлэлт ба Монгол Улс, 1996-2021 он

Хүснэгт 2. Авлигын төсөөллийн индекс ба Монгол Улс, 2012-2022 он

Хүснэгт 3. Монгол Улсын Авлигын төсөөллийн индексийн тооцоонд ашигласан эх сурвалж

Хүснэгт 4. Эрх зүйт ёсны индекс ба Монгол Улс (2016-2022 он)

Хүснэгт 5. Цахим засаглалын хөгжлийн индекс, Монгол Улсын үзүүлэлт (2004-2022 он)

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Монгол Улсын Дэлхийн нийтийн засаглалын шалгуур үзүүлэлт, (1996-2021 он)

Зураг 2. Иргэдийн дуу хоолой ба хариуцлага (1996-2021 он)

Зураг 3. Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/терроризмгүй байх (1996-2021 он)

Зураг 4. Засгийн газрын үр нөлөө (1996-2021 он)

Зураг 5. Зохицуулалтын чанар (2021 он)

Зураг 6. Эрх зүйт ёс (1996-2021 он)

Зураг 7. Авлигын хяналт (1996-2021 он)

Зураг 8. Авлигын төсөөллийн индекс, Транспэрэнси Интернэшнл (2022 он)

Зураг 9. Бертелсманы Шилжилтийн индексийн Засаглалын үзүүлэлт, Монгол Улс (2022 он)

Зураг 10. Бертелсман сангийн Шилжилтийн индексийн Засаглалын үзүүлэлт, Монгол Улс (2022 он)

Зураг 11. Эрх зүйт ёсны индекс ба Монгол Улсын дэд үзүүлэлт (2022 он)

Зураг 12. Эрх зүйт ёсны индекс ба Монгол Улсын эрэмбэ (2022 он)

Зураг 13. Эрх зүйт ёсны индекс, Монгол Улсын үзүүлэлт, Зүүн Ази ба Номхон далайн бүс нутгийн хувьд (2022 он)

Зураг 14. Эрх зүйт ёсны индекс, Монгол Улсын үзүүлэлт, дундаас доогуур орлоготой орнуудын хувьд (2022 он)

## ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД БА МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ: ЗАСАГЛАЛ, ТҮҮНИЙГ ХЭМЖИХ НЬ

**Засаглал** гэдэг нь анх [*kubernáo*] буюу “залуурдах, жолоодох” гэсэн утгатай грек үгнээс гарч латин болон бусад хэлэнд шилжсэн байна. “Засаглах” гэдгийг толь бичигт “үйл ажиллагаа, харилцаа, бодлого, чиг үүргийг чиглүүлэх, хянах”, “хязгаарлалт хийх, зохицуулах, чиглүүлэх, захирах” хэмээн тодорхойлсон бол “засаглал”-ыг “төр засаг, хяналт, эрх мэдэл” гэжээ.<sup>93</sup>

Харин НҮБХХ-оос **сайн засаглалын** шинж байдлыг иргэдийн өргөн оролцоог хангах, эрх зүйт ёсонд үндэслэн шийдвэр гаргах, засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах, иргэдийн хэрэгцээ, сонирхолд соргог мэдрэмжтэй байх, бүх иргэдэд тэгш шударгаар хандах, төрийн сангийн эх үүсвэрийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах, улс төрийн хариуцлагатай байх, хөгжлийн төлөвлөлтөө алсын хараатай харах явдал хэмээн тодорхойлсон байна.<sup>94</sup>

Сүүлийн үед засаглалын үнэлгээ нь зөвхөн эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд төдийгүй донор байгууллага, улс орнуудын хувьд чухал байр суурийг эзэлж байна. Засаглалын үзүүлэлт, төлөв байдлыг тодорхойлоход чиглэсэн судалгаа ийнхүү өргөжин тэлэхэд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн гэж үздэг. Үүнд 1980-90-ээд онд хөгжиж буй орнуудад гадаадын хөрөнгө оруулалт хэд дахин нэмэгдсэн, олон арван улс ардчилалд шилжиж эхэлснээр улс төрийн хөгжлийн асуудалд илүү анхаарал хандуулах болсон, мөн 1980-аад онд дэлхий дахинд хөгжилд хандах хандлага өөрчлөгдсөн, тухайлбал, эдийн засгийн өсөлт, нийгмийн салбарын хөгжил, байгаль орчны тогтвортой байдлын зэрэгцээ улс орны хөгжилд удирдлагын болон засаглалын хүчин зүйлийн гүйцэтгэх үүргийг чухалчлан үзэх болсон зэргийг нэрлэж болно.<sup>95</sup>

<sup>93</sup> Ц.Даваадулам. (2010). Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. “Засаглалын үзэл баримтлал төрийн удирдлагын шинжлэх ухаанд 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхнээс нэвтэрч эхэлсэн байна. НҮБХХ засаглалыг төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хоорондын харилцаагаар дамжуулан улс орон өөрийн нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаагаа зохицуулах эрхэмлэх зүйлс, бодлого, институцийн тогтолцоо хэмээн тодорхойлжээ. Засаглал нь иргэд болон нийгмийн бүлгүүд ашиг сонирхол, өөр хоорондын ялгаатай байдлаа илэрхийлэх, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх механизм, үйл явцаас бүрддэг. Энэ нь бас хувь хүн, байгууллага, компаниудын үйл ажиллагаанд зарим төрлийн хязгаарлалт тогтоох, эсвэл урамшуулал бий болгох дүрэм журам, институт, практикийг бий болгодог.

Дэлхийн банк (1992) засаглалыг улс төрийн дэглэмийн хэлбэр, улс орныг хөгжүүлэх нийгэм эдийн засгийн эх үүсвэрийг захиран зарцуулах эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл явц, засгийн газрын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, чиг үүргээ гүйцэтгэх чадавх хэмээн тодорхойлсон байна.

Жосеф Ни *‘Даяаршиж буй нийгэм дэх засаглал’* (2000) номдоо засаглалыг ‘аливаа нэг бүлгийн хамтын үйл ажиллагааг чиглүүлэх, эсвэл хязгаарлах албан болон албан бус үйл явц, институци’ гэж тодорхойлоод энд төр засаг нь эрх мэдлийг хэрэгжүүлж, албан ёсны үүргийг бий болгодог. Засаглалыг хэрэгжүүлэх субъект нь дан ганц төр засаг биш, засаглал бий болгохын тулд хувийн компани, төрийн бус байгууллага, тэдгээрийн холбоод бүгд, ихэнх тохиолдолд засгийн газрын байгууллагуудтай хамтран, заримдаа бие даасан хэлбэрээр оролцдог гэжээ.”

<sup>94</sup> Мөн тэнд.

<sup>95</sup> П.Доржсүрэн. (2008). Засаглалын төлөв байдлыг хэмжихүй. *Шинэ Толь*, 62. <https://academy.edu.mn/content/626208-2/>

Засаглалын үнэлгээ нь засаглалын төлөв байдалд гарч буй алдаа дутагдал, ахиц дэвшлийг үнэлэхэд ашиглаж болох томоохон арга хэрэгсэл юм. Иймд засаглалын үнэлгээний аргачлал боловсруулах, үнэлгээ хийх үйл ажиллагааг Засгийн газрууд, хандивлагч байгууллагууд, улс орон, иргэний нийгмийн байгууллагууд дэмжин, санхүүжүүлж байна.<sup>96</sup>

Өдгөө засаглалын багц үзүүлэлтээр улс орнуудыг байр эзлүүлэн дүгнэх, тухайн улс оронд гарч буй засаглалын өөрчлөлтийг судлах зориулалт бүхий аргыг багтаасан олон төрлийн аргачлал, глобал индексүүд бий болоод байна.

Эдгээр индекс, үнэлгээний хамгийн чухал давуу тал бол тэдгээрийн хараат бус байдал болон нэг улсын тодорхой үзүүлэлтийн өсөлт, хөгжлийн хандлагын динамикийг харах, түүнчлэн бусад улс орнуудыг өөр хооронд нь харьцуулах боломж юм. Эдгээр давуу талууд нь олон улсын үнэлгээний сул тал болох үндэсний онцлогийг харгалзан үзэх боломжгүй байдлыг нөхдөг гэж үздэг байна.<sup>97</sup>

Судлаачид засаглалыг хэмжихээр боловсруулсан үзүүлэлтийг янз бүрээр ангилсан байдаг. Тухайлбал, 2007 онд Их Британид төвтэй *ODI* буюу Далайн чанад дахь хөгжлийн институтээс Засаглалын үнэлгээнүүдийг үнэлгээ хийх санаачилгыг гаргасан субъектээр бүлэглэх зарчмыг санал болгосон юм.<sup>98</sup> Үүнд:

1. Судалгааны бие даасан байгууллагуудын санаачилсан үнэлгээ. Тухайлбал, Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэн (*IDEA*)-ийн Ардчиллын үнэлгээ (*Global State of Democracy Initiatives*)<sup>99</sup>, Фрийдом Хаус байгууллагын Дэлхийн эрх чөлөөний индекс (*Freedom in the World*)<sup>100</sup>, Бертелсманы сангийн Бертелсманы Шилжилтийн индекс, Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын талаарх төсөөллийн индекс (*Corruption Perceptions Index*), Дэлхийн шударга ёсны төсөл (*World Justice Project*) олон улсын иргэний нийгмийн байгууллагаас эрхлэн гаргадаг Эрх зүйт ёсны индекс (*Rule of Law Index*).

<sup>96</sup> П.Доржсүрэн. (2010). Засаглалын үнэлгээ, үзүүлэлтийн төрөл. *Шинэ Толь*, 69. <https://academy.edu.mn/content/691069-2/>

<sup>97</sup> Бычкова, С. Г. (2022). *Социальная статистика*. Издательство Юрайт.

<sup>98</sup> П.Доржсүрэн. (2010). Засаглалын үнэлгээ, үзүүлэлтийн төрөл. *Шинэ Толь*, 69. <https://academy.edu.mn/content/691069-2/>

<sup>99</sup> <https://idea.int/democracytracker/country/mongolia>

<sup>100</sup> АНУ-ын Вашингтон хотноо төвтэй ардчилал, хүний эрх, улс төрийн эрх чөлөөний төлөөх олон улсын “Freedom House” ашгийн бус байгууллагаас гаргадаг “Freedom in the World” буюу Дэлхийн эрх чөлөөний нөхцөл байдлын үнэлгээний тайлангаа 50 дахь жилдээ гаргаж байгаа бөгөөд уг тайлангаас үзвэл Манай улс уг судалгаагаар сүүлийн 7 жил тасралтгүй ардчилал, эрх чөлөөтэй оронд тооцогдож байна. Тухайлбал, Монгол Улс 2014-2023 онд 84-86 оноо авсан байна. 2023 оны хувьд (улс төрийн эрх чөлөөний үзүүлэлтээр 40, иргэний эрх чөлөөгөөр 60 оноо буюу боломжит хамгийн өндөр оноог авахаас) улс төрийн эрх чөлөөний үзүүлэлтээр 36, иргэний эрх чөлөөгөөр 48 оноо, нийт 84 оноо авсан байна. <https://freedomhouse.org/explore-the-map?type=fiw&year=2023&country=MNG>

2. Олон талт хамтын ажиллагаанд оролцогч байгууллагуудын санаачилсан үнэлгээ. Тухайлбал, НҮБХХ-ийн Засаглалын үзүүлэлтүүд төсөл (*UNDP's Governance Indicators Project*), Дэлхийн банкны Дэлхий дахины засаглалын үзүүлэлтүүд (*The Worldwide Governance Indicators*).
3. Хоёр талын хамтын ажиллагааны байгууллагуудаас санаачилсан үнэлгээнүүд. Тухайлбал, АНУ-ын Хөгжлийн Агентлагийн Ардчилал, засаглалын үнэлгээ, Их Британийн Олон улсын хөгжлийн газрын Улс орны засаглалын үнэлгээ, Данийн Засаглал, авлигын стратегийн үнэлгээ, Шведийн олон улсын хөгжил хамтын ажиллагааны агентлаг (*SIDA*)-ийн зөрчилдөөний шинжилгээ.

## САЙН ЗАСАГЛАЛЫН ОЛОН УЛСЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 1. ДЭЛХИЙН НИЙТИЙН ЗАСАГЛАЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Дэлхийн банкны Дэлхийн нийтийн засаглалын шалгуур үзүүлэлт (*Worldwide Governance Indicators*) нь 1996 оноос хойш засаглалын зургаан үндсэн шалгуур үзүүлэлтээр дэлхийн улс орнуудын төрийн удирдлагын чанар, үр ашгийн чиглэлээр гаргасан ололт амжилтыг үнэлэн хэмжиж иржээ. Үндсэн зургаан шалгуур үзүүлэлтэд дараах шалгуур багтаж байна.<sup>101</sup> Үүнд:

- Эрх мэдэлтнүүдийг сонгох, солих үйл явцтай холбоотой:
  - Иргэдийн дуу хоолой ба хариуцлага (*Voice and Accountability*)
  - Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/ терроризмгүй байх (*Political Stability and Absence of Violence/Terrorism*)
- Засгийн газрын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадавхтай холбоотой:
  - Засгийн газрын үр нөлөө (*Government Effectiveness*)
  - Зохицуулалтын чанар (*Regulatory Quality*)
- Хоорондын харилцааг нь зохицуулагч институцэд иргэд болон төрийн зүгээс хүндэтгэлтэй хандах байдалтай холбоотой:
  - Эрх зүйт ёс (*Rule of Law*)
  - Авлигын хяналт (*Control of Corruption*)

<sup>101</sup> Энэхүү шалгуур үзүүлэлт нь дэлхийн 200 гаруй улс орны засаглалын чанарыг 30 гаруй олон улсын нэр хүнд бүхий байгууллагын 400 орчим хувьсагч дээр тулгуурлан хэмждэг. Тухайлбал, Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, Латинбарометр, Афробарометр, Фрийдом хаус, Хил хязгааргүй сэтгүүлчид, Улс төрийн эрсдэлийн үйлчилгээ зэрэг төрийн, хувийн, төрийн бус байгууллага, шинжээч, экспертүүд зэрэг маш олон сурвалжаас мэдээллийн эх үүсвэрээ авдаг.



Дээрх шалгуур үзүүлэлтүүд нь 1996-2002 оны хооронд хоёр жил тутамд шинэчлэгдэж байсан бол 2002 оноос хойш жил бүр шинэчлэгдэх болжээ.<sup>102</sup>


### 1.1. Дэлхийн нийтийн засаглалын шалгуур үзүүлэлт ба Монгол Улс

*Хүснэгт 1. Дэлхийн нийтийн засаглалын шалгуур үзүүлэлт ба Монгол Улс, 1996-2021 он*

(үзүүлэлт нь 1-100 хүртэл ба 100 гэх утга руу дөхөх тусам засаглалын чанар сайн байгааг илтгэнэ)

	1.Иргэдийн дуу хоолой ба хариуцлага	2.Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/терроризмгүй байх	3.Засгийн газрын үр нөлөө	4.Зохицуулалтын чанар	5.Эрх зүйт ёс	6.Авлигын хяналт
1996	63.00	71.81	42.62	48.91	58.29	60.75
2000	59.70	75.66	45.90	43.48	51.74	46.28
2004	57.21	73.79	44.78	33.33	57.69	47.78
2008	56.25	64.42	35.44	42.23	44.71	30.58
2012	52.11	62.09	31.28	45.97	43.19	35.07
2016	56.65	73.33	50.48	50.96	46.15	36.54
2020	58.45	71.23	39.42	49.52	45.67	35.10
2021	57.49	66.98	34.62	44.71	46.15	33.65


*Зураг 1. Монгол Улсын Дэлхийн нийтийн засаглалын шалгуур үзүүлэлт, 1996-2021 он*



Эх сурвалж: <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Reports>

<sup>102</sup> Анхны шалгуур үзүүлэлт 1996 онд танилцуулагдаж байх үед эх сурвалжийн тоо 10 хүрэхгүй байсан бол жил ирэх тусам нэмэгдсэн байна. Дэлхийн банкнаас хамгийн сүүлд 2021 оны шалгуур үзүүлэлтүүдийг албан ёсоор гаргаж ирсэн байна.

**Бүс нутгийн тойм:**



Notes: Eastern Europe refers to the former socialist Central & Eastern European countries. Emerging East Asia refers to China, Hong Kong, Indonesia, the Republic of Korea, Malaysia, Philippines, Singapore, Thailand, and Vietnam. Belize, Suriname, French Guiana and Guyana were assigned to the Caribbean group of countries. High Income countries comprise those whose income per capita is above US\$12,696 according World Bank classification and income per capita data. Source for the calculation of WGI average scores: Worldwide Governance Indicators <http://www.govindicators.org>

BROOKINGS

Эх сурвалж: <https://www.brookings.edu/articles/its-complicated-lessons-from-25-years-of-measuring-governance/>

**1.2. Иргэдийн дуу хоолой ба хариуцлага**


Тухайн улс орны иргэд төр засгаа сонгох үйл явцад оролцож чадаж байгаа эсэх, түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, чөлөөт хэвлэл мэдээлэл байгаа эсэх шалгуур үзүүлэлтүүдийг хүснэгтээр авч үзвэл дараах байдалтай байна. Энэхүү хэсгийг Скандинав болон Баруун Европын орнууд тогтмол тэргүүлж ирсэн байна. Манай хоёр хөршийн хувьд улс төрийн дотоод нөхцөл байдалтай холбоотойгоор үнэлгээ багатай гарчээ. Монгол Улсын хувьд 2021 онд 206 орноос 89 дүгээр байранд орж, өмнөх жилээс 2 байр доошилсон байна.

Манай улсын хувьд энэхүү шалгуур үзүүлэлтээр ижил төстэй пост-социалист зарим орнуудтай харьцуулахад тэргүүлэх байр эзэлсэн байна. (Зураг 2)

Манай улсын хувьд энэ шалгуур үзүүлэлтээр 1996 онд анх 63.0 оноо авч байсан бол 2011 онд хамгийн бага 51.64 оноо, 1998 онд 65.17 хамгийн өндөр үнэлгээг авчээ.

Иргэдийн дуу хоолой ба хариуцлага шалгуур үзүүлэлтээр манай улс харьцангуй тогтвортой, хэлбэлзэл багатай үнэлгээ авч иржээ. Тухайлбал, 2014 оноос хойш тогтмол 56-аас дээш оноо авч байна.

Зураг 2. Иргэдийн дуу хоолой ба хариуцлага (1996-2021 он)



Эх сурвалж: <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Reports>


### 1.3. Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/терроризмгүй байх

Улс төрийн тогтворгүй байдал, төрийн эрх мэдлийг үндсэн хуулийн бус аргаар, эсхүл хүчээр булаан авах, терроризм гарах магадлал, нөхцөлтэй холбоотой шалгуур үзүүлэлтийг хүснэгтээр харвал дараах байдалтай байна. Шалгуур үзүүлэлтийн хувьд Баруун Европын хамгийн жижиг газар нутагтай орнууд тэргүүлж байна. Манай улсын хувьд 2021 оны байдлаар тус шалгуур үзүүлэлтээр харьцангуй өндөр үнэлгээ авч 212 улсаас 71 дүгээр байранд орсон бол өмнөх оноос 9 байр ухарсан байна.

Манай улсын хувьд 1996 онд анх 71.81 үнэлгээ авч байсан бөгөөд 2017 он хүртэл хугацаанд шалгуур үзүүлэлтүүдийн хувьд харьцангуй хэлбэлзэлтэй явж иржээ. 2002 онд Монгол Улс хамгийн тайван буюу 88.36 оноо авч байсан бол хамгийн тогтворгүй гэх үнэлгээг 1998 онд 59.57

оноогоор авчээ. Манай улсын хувьд энэхүү шалгуур үзүүлэлтээр ижил төстэй пост-социалист зарим орнуудтай харьцуулахад тэргүүлэх байр эзэлсэн байна. (Зураг 3)

Зураг 3. Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/терроризмгүй байх (1996-2021 он)




Эх сурвалж: <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Reports>

#### 1.4. Засгийн газрын үр нөлөө

Төрийн үйлчилгээ, төрийн албаны чанар, түүний улс төрийн нөлөөллөөс ангид байгаа эсэх, бодлого боловсруулалт, хэрэгжилтийн чанар, Засгийн газрын бодлогод тавих хяналт, хариуцлагын шалгуур үзүүлэлтийг хүснэгтээр харвал дараах байдалтай байна. Жагсаалтыг Сингапур Улс тэргүүлж, Баруун Европ тэр дундаа Скандинавын орнууд эхний байранд жагсжээ. Манай улсын хувьд 2021 оны байдлаар хоёр хөрш болон бүс нутгийн орнуудаасаа үнэлгээ доогуур гарч 209 оноос 137 дугаар байранд жагсаж өмнөх оныхоос 10 байраар ухарсан байна.

Манай улсын хувьд анх 1996 онд 42.62 оноо авсан, 2002 онд хамгийн өндөр буюу 52.97 оноо авч байсан бол хамгийн муу үнэлгээг 2009 онд 30.14 оноогоор авчээ. Манай улсын хувьд энэхүү шалгуур үзүүлэлтээр ижил төстэй пост-социалист зарим орнуудтай харьцуулахад Гүрж, Азербайжан, Казахстан, Орос, Узбекистан, Арменийн дараа орсон бол Молдова, Украинтай нэг түвшинд, Тажикистан, Киргиз, Беларусь, Туркменистан улсуудаас өндөр оноо авчээ. (Зураг 4)

Зураг 4. Засгийн газрын үр нөлөө (1996-2021 он)




Эх сурвалж: <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Reports>

### 1.5. Зохицуулалтын чанар

Засгийн газрын зөв бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадвар болон хувийн хэвшлийг дэмжих, эрх зүйн таатай орчин, зах зээлийн чөлөөт эдийн засагт харшлах арга хэмжээтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүдийг хүснэгтээр харвал дараах байдалтай байна. Жагсаалтыг Сингапур, Шинэ Зеланд улсууд тэргүүлж Баруун Европын орнууд болон БНХАУ-ын Хонконг, Макао удаалсан байна. Манай улсын хувьд 2021 онд 209 орноос 116 дугаар байранд орсон нь өмнөх оноос 10 байр ухарсан үзүүлэлт юм. Монгол Улсын хувьд анх 1996 онд 48.91 оноо авч байсан бол 2004 онд

хамгийн бага буюу 33.33 оноо, 2018 онд хамгийн өндөр 57.21 оноо авч байжээ. 2021 онд 44.71 оноо авсан өмнөх жилээс 4.8 оноогоор буурчээ. Манай улсын хувьд энэхүү шалгуур үзүүлэлтээр ижил төстэй пост-социалист зарим орнуудтай харьцуулахад Гүрж, Армени, Казахстан, Молдова, Азербайжаны дараа орсон бол Орос, Киргиз, Узбекистан, Беларусь, Тажикистан, Туркменистанаас өндөр оноо авчээ. (Зураг 5)

Зураг 5. Зохицуулалтын чанар (2021 он)



Эх сурвалж: <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Reports>


### 1.6. Эрх зүйт ёс

Нийгмийн дүрэм журмыг сахих итгэл үнэмшлийн хэр хэмжээ, гэрээний хэрэгжилт, өмчлөх эрх, цагдаа болон шүүхийн чанар, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлалын шалгуур үзүүлэлтийг хүснэгтээр харвал дараах байдалтай байна. Жагсаалтыг Скандинав болон Баруун Европын орнууд түүнчлэн Сингапур Улс тэргүүлж байгаа бөгөөд манай улсын хувьд 2021 онд 209 орноос 113 дугаар байранд жагссан нь өмнөх оноос 1 байраар өссөн үзүүлэлт юм.

Манай улсын хувьд анх 1996 онд 58.29 оноо авч байсан бөгөөд 2015 онд хамгийн бага буюу 42.31 оноо, 2003 онд хамгийн өндөр буюу 61.19 оноо тус тус авч байжээ. 1996-2004 онд харьцангуй өндөр буюу 51-61 оноотой байсан бол 2005 оноос хойш 42-48 оноо авч байна.

Манай улсын хувьд энэхүү шалгуур үзүүлэлтээр ижил төстэй пост-социалист зарим орнуудтай харьцуулахад Гүрж, Армени улсуудын дараа орсон бол Молдова, Казахстан, Азербайжан, Орос, Узбекистан, Киргиз, Беларусь, Тажикистан, Туркменистанаас өндөр оноо авчээ. (Зураг 6)

Зураг 6. Эрх зүйт ёс (1996-2021 он)



Эх сурвалж: <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Reports>

### 1.7. Авлигын хяналт

Хувийн зорилгоор төрийн эрх мэдлийг ашиглаж буй байдал, жижиг болон том хэмжээний авлигын хэлбэрүүд, улс төрийн өндөр түвшинд авлига байгаа эсэх, авлига дахь элитүүдийн оролцооны түвшин, авлигын эдийн




засгийн хөгжилд үзүүлэх нөлөө зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг хүснэгтээр харвал дараах байдалтай байна. Жагсаалтыг Дани Улс тэргүүлж, Скандинавын орнууд удаалжээ. Манай улсын хувьд 2021 онд 214 орноос 139 дүгээр байранд орсон нь өмнөх оноос 3 байраар ухарсныг харуулж байна.

Монгол Улсын хувьд анх 1996 онд 60.75 оноо авч байсан бөгөөд 2009 онд хамгийн бага 24.40 оноо, 1996 онд хамгийн өндөр 60.75 оноо тус тус авч байжээ. Монгол Улсын хувьд 2002-2011 он хүртэл шалгуур үзүүлэлт тогтмол унасаар 25.12 оноо авч 2012 онд 10 оноогоор нэмэгдэн 35.07 оноо авсан байна.

Манай улсын хувьд энэхүү шалгуур үзүүлэлтээр ижил төстэй пост-социалист зарим орнуудтай харьцуулахад Гүрж, Армени, Беларусь, Казахстан, Молдова улсуудын дараа орсон бол Узбекистан, Азербайжан, Орос, Киргиз, Тажикистан, Туркменистан улсуудаас өндөр оноо авчээ. (Зураг 7)

Зураг 7. Авлигын хяналт (1996-2021 он)



Эх сурвалж: <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Reports>



## 2. АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС

### 2.1. Авлигын төсөөллийн индексийн талаар

Авлига нь улс орны газар зүйн байршил, нийгэм-эдийн засаг, улс төр, соёлын зэрэг маш олон хүчин зүйлээс хамаардаг цогц үзэгдэл учир шууд хэмжих боломжгүй хувьсагч юм. Тиймээс авлигыг хэмжихэд чиглэсэн олон янзын судалгаа, индексийн тоо, ялангуяа, сүүлийн арван жилд асар хурдацтай нэмэгдсэн.

Авлигын түвшний талаарх бодит мэдээллийг олж авахад төвөгтэй байдаг бөгөөд улс орны болон цаашлаад дэлхийн түвшинд авлигын бодит түвшинг үнэн зөв тооцдог хэмжүүрийн систем хараахан бүрдээгүй байна. Учир нь авлигыг бүс нутаг, үндэсний болон дэлхийн хэмжээнд хэмжиж, мэдээлэл цуглуулахад төсөөллийн судалгааг голчлон ашигладаг. Тиймээс одоогийн судалгаа, индексүүд нь авлигын талаарх төсөөллийн хэмжүүр юм.

Авлигын талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төсөөллийн судалгааны нэг нь ХБНГУ-ын Берлин хотноо төвтэй “Транспэрэнси Интернэшнл” олон улсын төрийн бус байгууллагаас 1995 оноос хойш жил бүр гаргадаг Авлигын төсөөллийн индекс (*Corruption Perception Index*) юм.

Авлигын төсөөллийн индекс бол мэргэжилтнүүдийн үнэлгээ болон санал асуулгын дүнгээр тодорхойлсон төрийн байгууллагын авлигын түвшингээр нь улс орнуудыг эрэмбэлдэг индекс юм. Энэ нь нэгдмэл аргачлал бүхий бие даасан судалгаа биш, харин АНУ, ХБНГУ, Их Британи, Швейцар, Хонконгод байрлан үйл ажиллагаа явуулдаг 13 байгууллага (Монгол Улсын хувьд 9 эх сурвалж)-ын судалгаа, үнэлгээний зарим буюу авлига, түүнд холбогдох хэсгийн үзүүлэлтийг сонгон авч тодорхой аргачлалын дагуу дэлхийн 180 улс орон (1995 онд 41 улс)-ыг 0-100 оноогоор үнэлдэг индекс юм. Индексийн 0 оноо нь хамгийн өндөр авлигатай, 100 оноо нь цэвэр гэсэн утгатай.


Авлигын индекст:

- Улсын төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаа эсэх;
- Төрийн нийтийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа эсэх;
- Төр засаг нь авлигын эсрэг үр дүнтэй тэмцэж, шударга байдлыг төрийн салбарт хэрэгжүүлж байгаа эсэх;
- Авлигын хэрэгт холбогдсон төрийн албан тушаалтанд хариуцлага тооцож байгаа эсэх;
- Авлигыг мэдээлсэн шүгэл үлээгч, сэтгүүлч нарыг хамгаалсан хууль эрх зүйн орчин гэх мэтчилэн асуудлыг хамааруулан хэмждэг

бол авлига авсан өгсөн тохиолдол тус бүр, татвараас зугтааж зайлсхийсэн эсэх, хууль бус санхүүгийн гүйлгээ, мөнгө угаах гэмт хэрэг, далд эдийн засаг, тухайн улсын Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, үр нөлөө зэргийг хэмждэггүй.

2022 оны хувьд 26 улс тэр дундаа Катар (58), Гватемал (24), Их Британи (73) нь түүхэндээ хамгийн доод оноог авчээ. Харин Дани Улс энэ жилийн индексийг 90 оноо авч тэргүүлэн, Финланд, Шинэ Зеланд Улс 87 оноотойгоор удаалав.

Зураг 8. Авлигын төсөөллийн индекс, Транспэрэнси Интернэшнл (2022 он)



#cpi2022

www.transparency.org/cpi

This work from Transparency International (2022) is licensed under CC BY-ND 4.0

2017 оноос хойш 10 улсын хувьд АТИ-н оноо нь мэдэгдэхүйц буурсан:

Люксембург (77), Канад (74), Их Британи (73), Австрали (71), Малайз (47), Монгол (33), Пакистан (27), Хондурас (23), Никарагуа (19), Хаити (17) байн. Харин өнгөрсөн 5 жилд 8 улс орны хувьд АТИ-н оноо сайжирчээ.

Тодруулбал: Ирланд (77), Өмнөд Солонгос (63), Армени (46), Вьетнам (42), Мальдив (40), Молдова (39), Ангол (33), Узбекистан (31).

АТИ судалгаанд хамрагдсан 180 улсын 95 хувийнх нь авлигын түвшин бага зэрэг буурсан, зарим бүс нутагт өссөн бол Скандинавын улс оронд авлигын индекс бага болжээ. Түүнчлэн авлигажсан улс оронд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэж чадахгүй байгааг судалгааны үр дүн харуулсан бол Вьетнам, БНСУ нь авлигаа тогтвортой бууруулж чадсан байна.

### **Бүс нутгийн тойм:**

Ази, Номхон далайн бүс нутагт орших улс орнууд дөрөв дэх жилдээ дунджаар 45 оноо авч үнэлэгдсэн байна.<sup>103</sup> Энэ нь 2022 оны дэлхийн дунджаас “ялимгүй дээгүүр” буюу 43 оноогоор үнэлэгдсэнийг илтгэнэ. Харин Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн улс орнууд дунджаар 35 оноогоор үнэлэгдсэн байна. Төв Азийн таван орноос зөвхөн Казахстан Улс 36 оноогоор үнэлэгдсэн байна. Харин БНАСАУ (17), Туркменистан (19) зэрэг улсууд чансаагаар сүүлийн байрт орсон бол тус бүс нутагт чансаагаараа Шинэ Зеланд (87) тэргүүлж, Сингапур (83) удаалсан нь Ази тивийн орнуудаас хамгийн өндөр оноогоор үнэлэгдсэн байна.

Тогтворгүй байдал, ардчилал, хүний эрхэд халдсан хориг, хязгаарлалт тавих явдал үргэлжилсэн нь иргэний орон зай, үндсэн эрх чөлөөг хязгаарлаж, халдаж байна гэж Транспэрэнси Интернэшнл тэмдэглэв. Түүнчлэн тус байгууллага (Транспэрэнси Интернэшнл)-ын зүгээс “эл хандлага үлэмж даамжирсаар Ази, Номхон далайн янз бүрийн орнуудад авторитаризм нэмэгдэх шалтгаан болж, улмаар иргэний нийгмийн “хоточ нохой”-н үүргийг сулруулж, олон удирдагчид авлигатай тэмцэх хүчин чармайлтаас илүүтэйгээр эдийн засгаа сэргээхийг урьтал болгох болсон гэж дурджээ.

## **2.2. Авлигын төсөөллийн индекс ба Монгол Улс**

Монгол Улс авлигын индексээр 2012 онд 36 оноо авч, 176 улсаас 94 дүгээрт, 2016 онд 87 дугаарт, 2020 онд 111 дүгээрт, 2021 онд 110 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Манай улсын хувьд 2014-2015 онд хамгийн сайн үзүүлэлт буюу 39 оноо авч байсан бол 2022 оны “Авлигын төсөөллийн индекс”-ээр 33 оноо авч, 2018 оноос хойш тасралтгүй буурсан 10 улсын тоонд орсон байна. Тус үзүүлэлт нь өмнөх оноос зургаан байр ухарсан үзүүлэлт бөгөөд нийт

<sup>103</sup> <https://iaac.mn/post/104857>

180 улсаас 116 дугаарт бичигдэж байна.<sup>104</sup> Транспэрэнси Интернэшнл байгууллага “Өнгөрсөн жил Монгол Улс авлигатай тэмцэх тогтолцоогоо сэргээхийн тулд зарим нааштай алхмуудыг хийсэн боловч авлигын эрсдэлтэй тэмцэх арга хэмжээ нь төдийлөн хангалттай байсангүй” хэмээн тайландаа тэмдэглэсэн байна.

**Хүснэгт 2. Авлигын төсөөллийн индекс ба Монгол Улс, 2012-2022 он**

(АТИ нь улс орны засаг төрийн байгууллагын авлигын төсөөллийг 0 /маш их авлигатай/-ээс 100 /маш цэвэр/ оноогоор эрэмбэлдэг)

Он	Судалгаанд хамрагдсан улсын тоо/ Эрэмбэ	Өмнөх онтой харьцуулахад гарсан өөрчлөлт	Оноо
2012	94/176	-	36/100
2013	83/177	+2	38/100
2014	80/175	+1	39/100
2015	72/168	=	39/100
2016	87/176	-1	38/100
2017	103/180	-2	36/100
2018	93/180	+1	37/100
2019	106/180	-2	35/100
2020	111/180	=	35/100
2021	110/180	=	35/100
2022	116/180	-2	33/100

Эх сурвалж: <https://www.transparency.org/en/cpi/2022/index/mng>

**Хүснэгт 3. Монгол Улсын Авлигын төсөөллийн индексийн тооцоонд ашигласан эх сурвалж**

№	Эх сурвалжийн нэр	Тайлбар
1	Бертелсманы сан	Шилжилтийн индекс
2	Эдийн засгийн мэдээллийн нэгж	Улс орнуудын эрсдэлийн үйлчилгээ
3	Глобал Инсайт	Улс орнуудын эрсдэлийн түвшин
4	Швейцарын “Ай Эм Ди” Дэлхийн өрсөлдөх чадварын төв	Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн эмхэтгэл: Үзэл бодлын судалгаа
5	АНУ-ын “Пи Ар Эс” групп	Улс орнуудын эрсдэлийн хөтөч
6	Дэлхийн банк	Улс орны бодлого, институцийн үнэлгээ
7	Дэлхийн эдийн засгийн форум	Үзэл бодлын судалгаа
8	Дэлхийн эрх зүйн төсөл	Хууль дээдлэх ёсны индекс
9	Ардчиллын олон талт байдлын төсөл (V-Dem v.10)	

Эх сурвалж: <https://iaac.mn/uploads/users/1278/files/ATG%20report%202022%20part%201.pdf>

<sup>104</sup> <https://www.transparency.org/en/cpi/2021/index/mng>

### 3. “БИЗНЕС ЭРХЛЭХҮЙ” ТАЙЛАН

#### 3.1. Бизнес эрхлэхүй тайлангийн талаар

Doing business буюу “Бизнес эрхлэхүй” тайланг 2002 оноос жил бүр Дэлхийн банкнаас эрхлэн гаргасан. Бизнес эрхлэхэд илүү таатай улс орнуудын талаарх судалгааны мэдээллийг зөв боловсруулж байгаа эсэхийг шалгах зорилгоор тайлангаа нийтлэхээ түр зогсоож байгаагаа Дэлхийн банк 2021 онд мэдэгдсэн.

Хамгийн сүүлд нийтлэгдсэн 2019 оны судалгааны үр дүнгээр **бизнес эрхлэх орчин хамгийн их сайжирсан арван улсын тоонд** Саудын Араб, Йордан, Того, Бахрейн, Тажикистан, Пакистан, Кувейт, БНХАУ, Энэтхэг болон Нигери улс тодорлоо. Хамгийн их дэвшилттэй арван улсын жагсаалтанд БНХАУ ба Того улс тус тус хоёр жил дараалан орсон бол, Энэтхэг гурав дахь жилдээ дараалан орж байгаа нь бизнес зохицуулалтын реформ нь олон жил үргэлжлэх үйл явц гэдгийг харуулж байна. Бахрейн хамгийн олон тооны реформуудыг хэрэгжүүлсэн ба тайлангийн хэмждэг арван бүлэг үзүүлэлтийн есөд нь дэвшил гаргасан байна. Араас нь БНХАУ ба Саудын Араб улсууд тус бүр найман реформтой удаалж байна.

Бизнес эрхлэх таатай орчны үнэлгээгээр **хамгийн өндөр үнэлгээ авсан арван улсаар** Шинэ Зеланд, Сингапур, Хонг Конг БНХАУ-н ТЗБ, Дани, БНСУ, АНУ, Гүрж, Их Британи, Норвеги ба Швед улсууд тодорсон. Шилдэг үзүүлэлттэй улсууд ихэвчлэн аж ахуйн нэгж шинээр үүсгэн байгуулах онлайн систем, татвараа мэдүүлэх цахим платформтой төдийгүй цахимаар эд хөрөнгө шилжүүлдэг байна.

Дээрхтэй эн зэрэгцэн, 26 улс бизнес үйл ажиллагаа явуулахад шинэ саад бэрхшээл бий болгох алхмуудыг хийсэн байна. Эдгээрээс ихэнх нь бизнес эрхлэх өртгийг нэмэгдүүлэв.

Бизнес эрхлэгчийн гарааны зам дээд ба доод үзүүлэлттэй улс орнуудын хооронд асар их ялгаатай байна. Жишээ нь, үнэлгээний доод үзүүлэлттэй 50 эдийн засагт бизнес шинээр үүсгэн байгуулах хугацаа, жагсаалтын топ 20 улс оронтой харьцуулахад дунджаар зургаа дахин удаан байна. Топ 20 эдийн засагт хөрөнгө шилжүүлэх нь хоёр долоо хоногоос бага хугацаа шаарддаг бол доод 50 улсад гурван сар болдог. Доод 50 дундаж эдийн засагт цахилгаан холболт хийлгүүлэхэд топ 20 дундаж улстай харьцуулахад хоёр дахин удаан байдаг; энэхүү холболтын өртгийг нэг хүнд ногдох орлогын хувиар авч үзвэл 44 дахин өндөр байна.

Тус тайланд хэмжсэн 10 бүлэг үзүүлэлт: *шинээр бизнес эхлүүлэх, барилгын зөвшөөрөлтэй холбогдох ажиллагаа, цахилгаан холбуулах,*

*хөрөнгө бүртгүүлэх, зээл авах, жижиг хөрөнгө оруулагч нарыг хамгаалах, татвар төлөх, хил дамнасан худалдаа эрхлэх, гэрээний хэрэгжилтийг хангах ба дампуурлыг шийдвэрлэх.* Нэмэлт нэг бүлэг нь ажлын байраар хангах ба үүнийг хэмждэг боловч үнэлгээнд харгалзаагүй болно.

Тайлант хугацаанд шинээр бизнес эхлүүлэх, барилгын зөвшөөрөлтэй холбогдох ажиллагаа, цахилгаан холбуулах ба татвар төлөх чиглэлээр хамгийн их реформ хийгдсэн байна. Барилгын зөвшөөрөлтэй холбогдох ажиллагаа ба цахилгаан холбуулах үйл явцад хамаарах реформууд сүүлийн жилүүдэд хамгийн их нэмэгдсэн. Барилгын зөвшөөрөл авах үйл явцыг хялбарчилсан 37 улс орны ихэнх нь урьдчилан батлах ба шалгах явцыг илүү дөхөм болгохоор холбогдох байгууллагуудтай ажилласан. Бизнесүүдийг цахилгааны сүлжээнд илүү үр ашигтай холбох зорилгоор 16 эдийн засаг цахилгаан дэд бүтцээ шинэчлэхэд дорвитой хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс гарсан нэг үр дүнг онцлоход, дэлхийн дундаж цахилгааны тасалдал 2017 ба 2018 онуудын хооронд 8 гаруй хувиар буурсан.

“Бизнес эрхлэхүй” тайлан 2003 онд үүсгэн байгуулагдсанаас хойш үнэлгээнд хамрагддаг нийт 190 улсаас 186 нь 3.500 гаруй бизнес реформ хийгдсэн байна.<sup>105</sup>

Хамгийн сүүлд нийтлэгдсэн 2019 оны тайланд Монгол Улс 190 улсаас 81 дүгээрт бичигджээ.

### **Бүс нутгийн тоймууд:**

**Зүүн Ази ба Номхон далайн бүс нутаг:** Тус бүсийн эдийн засгууд 2019 оны туршид бизнесийн орчныг сайжруулах 33 реформ хийсэн. Эдгээр нь ихэнхдээ жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаа эрхлэх орчныг нь дэлхийн стандартын дагуу таатай болгож өгсөн ч нийт реформуудын хурд саарсан. 2019 оны хугацаанд бүсийн нийт реформын тоо арваар буурсан. Нийт улс орнуудын талаас багад нь реформууд хэрэгжсэн (25-с 12). Хэдий тийм боловч тухайн бүсээс таван улс дэлхийн топ 25 үзүүлэлттэй эдийн засагт багтаж байна, үүнд Сингапур (2), Хонг Конг (БНХАУ-ын ЗЗОБ) (3), Малайз (12), Тайвань (15) ба Тайланд (21). БНХАУ хоёр жил дараалан сайжирч буй 10 улсын тоонд орж байна.

**Европ ба Дундад Ази:** Тус бүсийн эдийн засгууд өөрсдийн бизнес орчныг таатай болгох чиглэлээр хийж буй ажлуудаа улам идэвхжүүлж, нийт 56 реформ хийсэн ба татвар төлөх, гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлийн реформуудаараа дэлхийд тэргүүлж байна. Дэлхийн хамгийн

<sup>105</sup> <https://www.worldbank.org/mn/news/press-release/2019/10/24/governments-worldwide-launched-294-reforms-over-the-past-year-to-make-doing-business-easier>

таатай бизнес орчинтой 20 улсын хоёр нь Европ ба Дундад Азид байрлаж байна – Гүрж (7) ба Умард Македон (17). Тажикистан Улс дэлхийн топ арван дэвшилттэй эдийн засгуудын тоонд орж байна.

**Өмнөд Ази:** Өмнөд Азийн дийлэнх эдийн засгууд бизнес зохицуулалтын реформуудыг дорвитой хийсэн хэвээр байгаа ба энэ дунд Энэтхэг, Пакистан улсууд бизнес эрхлэх таатай орчны үзүүлэлтүүдээ сайжруулж, дэлхийн хамгийн дэвшилттэй топ аравт зүй ёсоор орж байна. Бүсийн эдийн засгууд дотоодын бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх чиглэлээр нийт 17 реформ хийсэн байна. Дөрвөн реформ хийснээрээ Энэтхэг бүсийн хамгийн өндөр үзүүлэлттэй орон хэвээр байгаа ба бизнесийн таатай орчноороо дэлхийд 63-т орж байна. Пакистанд цахилгааны холболт хийлгүүлэх хугацаа 49 өдрөөр багассан.

## 4. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС

### 4.1. Хүний хөгжлийн индексийн талаар

Сүүлийн үед дэлхий нийтээрээ хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас зайлсхийж, хүний хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Улс үндэстний гол баялаг, хөгжлийн хүч, ирээдүйг тодорхойлогч үнэт зүйл бол хүн өөрөө байдаг. Хүний хөгжил гэдэг бол товчхондоо хүн төвтэй хөгжил - үйл явц хийгээд үр дүн юм. Өөрөөр хэлбэл, хүмүүсийг хөгжүүлэх, хөгжлийг хүмүүст зориулах, хүмүүсийн өөрсдийнх нь оролцоотойгоор хөгжлийг хангана гэсэн үг. Хүний хөгжил, түүний зорилго, ач холбогдол Хөгжлийн үндсэн зорилго нь хүнийг эрүүл саруул байх, урт удаан наслах, бүтээлчээр ажиллаж амьдрах таатай орчин, нөхцөлийг хүмүүст бүрдүүлэхэд чиглэж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хүний хөгжил улам бүр чухал болж байгааг тодорхойлох зорилгоор үндэстний хүний хөгжлийн илтгэлийг гаргаж байхыг гишүүн орнууддаа уриалан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) 1990 онд дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэлийг боловсруулсан. Энэхүү илтгэл нь хүний хөгжлийн үзэл баримтлалыг танин мэдэх, тухайн улс оронд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх нөөц бололцооны талаарх нэгдсэн мэдээлэл, судалгаа бий болгох зорилготой. Өнгөрсөн хугацаанд дэлхийн 140 гаруй улс орны нийт 700 гаруй илтгэл боловсруулагдан бэлэн болсон байна.

Дэлхийн улс орнуудыг хөгжлийн түвшнээр нь дээд (*very high*), дээгүүр (*high*), дундаж (*medium*), доогуур (*low*) гэж зэрэглэн ангилахад ашигладаг холимог статистик хэмжигдэхүүнийг хүний хөгжлийн индекс гэнэ.



Хүний хөгжлийн индекс нь хүний хөгжлийг урт удаан, эрүүл амьдарч байгаа байдлыг нь наслалтаар, мэдлэг эзэмших чадварыг нь суралцсан бодит болон суралцах хугацаагаар, зохистой амьдралын түвшинд хүрэх чадварыг нь нэг хүнд ногдох үндэсний орлогоор тооцох үндсэн гурван үзүүлэлтээр дүгнэдэг цогц индекс юм.

Дэлхийн улс орны хөгжлийн түвшинд илүү бодит үнэлгээ өгөх зорилгоор хүний амьдралын гол гурван хэмжигдэхүүн болох дундаж наслалт, боловсролын түвшин, амьжиргааны зохистой түвшний хэм хэмжээгээр харьцуулан цогц индексүүдийн статистик тооцоолол хийдэг.

Хүний хөгжлийн индекс (ХХИ) нь:

- Хүний амьдрах хугацааг тодорхойлох үзүүлэлт болох хүн амын дундаж наслалтын индекс;
- Бичиг үсэг тайлагдалтын байдал буюу боловсролын индекс: 25 ба түүнээс дээш насны хүн амын амьдралынхаа туршид эрдэм мэдлэг эзэмшин, суралцсан дундаж хугацаа болон сургуульд элсэх насны хүүхдийн бүх шатны сургуульд суралцах хугацааны квадрат дунджаас тооцсон боловсролын индекс;
- Нэг хүнд ногдох ДНБ буюу ҮНО орлогын индекс /Орлогын индексийг улсын түвшинд нэг хүнд ногдох ҮНО-ыг аймаг, нийслэлийн түвшинд нэг хүнд ногдох ДНБ-ийг худалдан авах чадварын паритетад харьцуулж тооцно. Ингэхдээ нэг хүнд ногдох ҮНО болон ДНБ-ийг долларт шилжүүлэн тооцно/ гэсэн үндсэн 3 индексийг тооцно.
- Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс (ХХТББЗИ) нь хүн амын дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох орлогын хэмжээг хүйсийн тэгш бус байдлаар засварласан нийлмэл индекс юм. Жендерийн тэгш бус байдлын индекс (ЖТББИ) нь хүйсийн тэгш бус байдлаас шалтгаалан нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсролын байдал болон шийдвэр гаргах эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоогоор хэмжигдэх нийлмэл индекс юм.

### **Хүний хөгжлийн индексийг тооцох арга зүй:**

Монгол Улс хүний хөгжил, түүний бүрэлдэхүүн индексүүдийг 2000 оноос эхлэн анх удаа тооцож эхэлсэн бөгөөд 2007 оноос Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс, жендерийн хөгжлийн индекс (ЖХИ), жендерийн тэгш бус байдлын индексийг улс, бүс, аймаг, нийслэлийн түвшинд албан ёсоор тооцон статистикийн эмхэтгэлд тархааж байна. НҮБ-ын Хүний хөгжлийн илтгэлийн газар Хүний хөгжлийн индексийг тооцох арга зүйд 2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу Монгол Улсын Үндэсний статистикийн хороо ХХИ-ийг тооцох аргачлалыг олон




улсын арга зүйд нийцүүлэн 2014 онд шинэчлэн доорх схемийн дагуу тооцож байна. Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индексийг тооцоход дараах зарчим баримталж байна. Үүнд:

- Шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйтэй байх;
- Олон улсын нийтлэг аргачлалтай нийцсэн байх;
- Үзүүлэлтүүд өөр хоорондоо хамааралтай байх;
- Мэдээллийн эх үүсвэр тодорхой, тогтмол, үнэн бодитой байх;
- Хэмжих боломжтой, тодорхой үзүүлэлтийг сонгосон байх.

#### **4.2. Монгол Улсын үзүүлэлт**

Монгол Улс 1997 оноос хойш 3 жилийн давтамжтайгаар нийт 6 илтгэлийг боловсруулаад байна. Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хүн бүрийг эрүүл саруул аж төрөх, урт наслах, амар тайван байх, түүх соёлоо хүндлэх, бүтээлчээр ажиллах, байнга суралцах оюун ухаан, авьяас чадвараа нээн хөгжүүлэх сонголттой байх таатай орчныг бүрдүүлэн “Монгол хүний амьдралын чанар”-ыг тасралтгүй дээшлүүлж, 2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтуудыг бүрэн биелүүлж, хүний хөгжлийн индексийг 0.83-т хүргэх бодлого баримталсан байдаг. Энэ хөтөлбөр 2015 онд дуусгавар болж дараагийн буюу “Тогтвортой хөгжлийн зорилго” болж, 17 зорилго 169 зорилтыг баталж, үргэлжлүүлэн 2016 оноос албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Энэхүү зорилгууд нь хүний хөгжлийн үзүүлэлттэй шууд болон шууд бусаар холбогдож байгаа юм. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж, хүний хөгжлийн индексийг 2025 онд 0.77, 2030 онд 0.85, 2050 онд 0.9-д хүргэхээр зорилт тавьсан байна. Хүний хөгжлийн индексийн бүрэлдэхүүн индекс болох Орлогын индексийг гаргахдаа аймаг, нийслэлийн түвшинд Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийг, улсын хэмжээнд Үндэсний нийт орлого (ҮНО)-ыг ашигласан. 2021 онд, дотоодын нийт бүтээгдэхүүний суурь 2015 оноор солигдон 2015-2020 оны ДНБ-ийн дүн шинэчлэгдсэн тул 2015-2020 оны Хүний хөгжлийн индексийн тооцоог дахин хийв.



### ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ИНДЕКСҮҮД

www.1212.mn



## 5. БЕРТЕЛСМАНЫ ШИЛЖИЛТИЙН ИНДЕКС

### 5.1. Бертелсманы Шилжилтийн индексийн талаар

ХБНГУ-ын Берлин хотноо төвтэй Бертелсман сангаас эрхлэн гаргадаг Шилжилтийн индекс (*Bertelsmann Transformation Index*) нь дэлхийн улс орнуудын ардчилсан, чөлөөт эдийн засгийн тогтолцоонд хэрхэн амжилттай шилжиж буй талаарх үнэлгээ юм. Уг индексийг 2005 оноос хойш 2 жил тутам тогтмол тооцон гаргаж байгаа ба хамгийн сүүлд 2022 онд 137 улсаар гаргасан байна.

Бертелсманы Шилжилтийн индекс нь нөхцөл байдлын индекс (Улс төрийн шилжилт, Эдийн засгийн шилжилт) болон Засаглалын индексийг нийт 17 шалгуур үзүүлэлт (1-10 үнэлгээ бүхий 49 асуулт)-ээр гаргадаг байна.

Засаглалын чанарыг нийт 4 үзүүлэлт, 21 дэд үзүүлэлтээр үнэлдэг байна. Үүнд:

1. Удирдах чадвар (*Steering Capability*)
2. Нөөцийг үр ашигтай ашиглах (*Resource Efficiency*)
3. Зөвшилцөл (*Consensus-Building*)
4. Олон улсын хамтын ажиллагаа (*International Cooperation*)


Үнэлгээг боловсруулахад улс орнуудыг Ази болон далайн орнууд (22 улс), Латин Америк, Карибын тэнгисийн орнууд (22 улс), Төв-Зүүн ба Өмнөд Европ (17 улс), Пост-социалист Евроази бүс нутаг (13 улс), Ойрх Дорнод болон Зүүн ба Хойд Африк (19 улс), Баруун ба Төв Африк (22 улс), Өмнөд ба Зүүн Африк (22 улс) гэсэн нийт 7 бүс нутагт хуваан авч үзэх ба Монгол Улсын хувьд Пост-социалист Евроази бүс нутагт хамаарна.

## 5.2. Бертелсманы Шилжилтийн индекс ба Монгол Улс

2022 оны байдлаар Монгол Улс нь 5.9 оноогоор “сайн” дүн авсан 29 улсын нэг бөгөөд судалгаанд авагдсан нийт 137 улсаас 26 дугаарт жагссан байна. (Зураг 9)

*Зураг 9. Бертелсманы Шилжилтийн индексийн Засаглалын үзүүлэлт, Монгол Улс (2022 он)*


*(Үзүүлэлт нь 1-10 хүртэл ба 10 гэх утга руу дөхөх тусам засаглалын чанар сайн байгааг илтгэнэ.)*



Эх сурвалж: <https://bti-project.org/en/index/governance>

Монгол Улсын хувьд анх 2006 онд хамгийн өндөр буюу 6.30 оноо авч байсан бол 2016 онд хамгийн бага буюу 5.83 оноо авсан байна. (Зураг 10)

**Зураг 10. Бертелсман сангийн Шилжилтийн индексийн Засаглалын үзүүлэлт, Монгол Улс (2022 он)**



Эх сурвалж: <https://bti-project.org/en/index/governance>

## 6.ЭРХ ЗҮЙТ ЁСНЫ ИНДЕКС

### 6.1. World Justice Project байгууллагын Эрх зүйт ёсны индексийн талаар

Дэлхий даяар эрх зүйт ёсыг хөгжүүлэх зорилготойгоор 2006 онд АНУ-ын Хуульчдын холбооны ерөнхийлөгч Уильям Х.Нейкомын санаачлан үүсгэн байгуулсан Дэлхийн шударга ёсны төсөл (*World Justice Project*) олон улсын иргэний нийгмийн байгууллагаас эрхлэн гаргадаг Эрх зүйт ёсны индекс (*Rule of Law Index*)-ээр улс орнуудыг нэг хүртэлх оноогоор дүгнэж, эрэмбэлдэг.

Эрх зүйт ёсны индексийг нийт 8 үзүүлэлт, 44 дэд үзүүлэлтээр гаргадаг. Үүнд:

1. Засгийн эрх мэдлийг хязгаарлах хязгаарлалтууд (*Constraints on Government Powers*)
  - 1.1. Хууль тогтоогч институцээр хязгаарлагдсан байдал
  - 1.2. Шүүх засаглалын хязгаарлагдсан байдал
  - 1.3. Хараат бус аудитын үйл ажиллагаа
  - 1.4. Төрийн болон сонгууль албан тушаалтны зүй бус үйлдэл, үйл ажиллагаанд ногдуулах хариуцлага
  - 1.5. Төрийн бус хяналт
  - 1.6. Эрх мэдлийг хууль ёсоор шилжүүлэх

2. Авлигагүй байдал (Absence of Corruption)
  - 2.1. Гүйцэтгэх засаглалд
  - 2.2. Шүүх засаглал, шүүхийн тогтолцоонд
  - 2.3. Цагдаа, цэргийн байгууллагад
  - 2.4. Хууль тогтоох байгууллагад
3. Нээлттэй засгийн газар (Open Government)
  - 3.1. Хууль тогтоомж болон Засгийн газрын мэдээ, мэдээллийн ил тод байдал
  - 3.2. Мэдээлэл авах эрх
  - 3.3. Иргэний оролцоо
  - 3.4. Гомдол гаргах, гомдол барагдуулах механизм
4. Үндсэн эрх (Fundamental Rights)
  - 4.1. Ялгаварлан гадуурхахгүй байх
  - 4.2. Амьд явах, аюулгүй байх эрх
  - 4.3. Шударгаар шүүлгэх эрх
  - 4.4. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
  - 4.5. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө
  - 4.6. Хувийн нууцтай байх эрх
  - 4.7. Эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөө
  - 4.8. Хөдөлмөрлөх эрх
5. Дэг журам, аюулгүй байдал (Order and Security)
  - 5.1. Гэмт хэрэггүй байдал
  - 5.2. Дотоодын мөргөлдөөнгүй байдал
  - 5.3. Асуудлыг хүчирхийллээр шийдвэрлэдэггүй байдал
6. Хууль дүрэм үйлчилдэг, хэрэгждэг байх (Regulatory Enforcement)
  - 6.1. Хууль дүрэм үйлчилдэг, хэрэгждэг байх
  - 6.2. Зүй бусаар үл нөлөөлөх
  - 6.3. Хэт удаашруулахгүй байх
  - 6.4. Шүүхээр шударга ёс тогтоох үйл явцыг хүндэтгэх
  - 6.5. Зохистой хэмжээний нөхөн төлбөргүйгээр төрийн мэдэлд авахгүй байх
7. Иргэний шүүх, шүүн таслах ажиллагаа (Civil Justice)
  - 7.1. Хүртээмжтэй, үнийн хувьд боломжтой байх
  - 7.2. Үл ялгаварлах
  - 7.3. Авлигагүй байх
  - 7.4. Засгийн газрын зүгээс зүй бусаар нөлөөлөхгүй байх
  - 7.5. Хэт удаашруулахгүй байх
  - 7.6. Хууль дүрэм хэрэгждэг, үйлчилдэг байх
  - 7.7. Маргаан шийдэх шүүхийн бус, хараат бус үр дүнтэй механизмтай байх
8. Эрүүгийн шүүн таслах ажиллагаа (Criminal Justice)
  - 8.1. Үр дүнтэй мөрдөн шалгах
  - 8.2. Хэргийг цаг алдалгүй, үр дүнтэй шүүн таслах
  - 8.3. Үр дүнтэй засан хүмүүжүүлэх тогтолцоо
  - 8.4. Үл ялгаварлах
  - 8.5. Авлигагүй байх
  - 8.6. Засгийн газрын зүгээс зүй бусаар нөлөөлөхгүй байх
  - 8.7. Шүүхээр шударга ёс тогтоох үйл явц



## 6.2. Эрх зүйт ёсны индекс ба Монгол Улс

Монгол Улсын хувьд 2012 оноос энэ судалгаанд хамрагддаг болсон бөгөөд үндэсний 23 экспертийн судалгаа болон мэргэжлийн судалгааны байгууллагаар тусгайлсан аргачлалын дагуу иргэдээс судалгааг авч гаргадаг байна.


Хүснэгт 4. Эрх зүйт ёсны индекс ба Монгол Улс (2016-2022 он)

	Ерөнхий эрэмбэ	1.Засгийн эрх мэдлийг хязгаарлах хязгаарлалт ууд	2.Авлигагүй байдал	3.Нээлттэй засгийн газар	4.Үндсэн эрх	5.Дэг журам, аюулгүй байдал	6.Хууль дүрэм үйлчилдэг, хэрэгждэг байх	7.Иргэний шүүх, шүүн таслах ажиллагаа	8.Эрүүгийн шүүн таслах ажиллагаа
2016	55/113	64/113	80/113	74/113	54/113	32/113	72/113	55/113	53/113
2020	57/128	65/128	83/128	70/128	61/128	45/128	82/128	68/128	52/128
2022	62/140	68/140	84/140	73/140	67/140	58/140	77/140	65/140	68/140

Эх сурвалж: <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/factors/2022/Mongolia/>

Зураг 11. Эрх зүйт ёсны индекс ба Монгол Улсын дэд үзүүлэлт (2022 он)


(Үзүүлэлт нь 0-1 хүртэл ба 1 гэх утга руу дөхөх тусам эрх зүйт ёс дээд зэргээр баримтлагдаж буйг илтгэнэ.)



Эх сурвалж: <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/factors/2022/Mongolia/>

Дээрх байгууллагын 2022 оны судалгааны үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан 140 улсаас 0.54 оноогоор 62 дугаар байрт жагссан (Зураг 9) бол Зүүн Ази ба Номхон далайн бүс нутгийн хувьд 15 улсаас 8 дугаарт (Зураг 10), орлогын түвшин ойролцоо буюу дундаас доогуур орлоготой 38 улсаас 3 дугаарт (Зураг 11) тус тус жагссан байна.

Зураг 12. Эрх зүйт ёсны индекс ба Монгол Улсын эрэмбэ (2022 он)



Эх сурвалж: <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/factors/2022/Mongolia/>

Зураг 13. Эрх зүйт ёсны индекс, Монгол Улсын үзүүлэлт, Зүүн Ази ба Номхон далайн бүс нутгийн хувьд (2022 он)

Country/Jurisdiction	Regional Rank	Overall Score*	Change in Overall Score*	% Change in Overall Score*	Global Rank	Change in Global Rank†						
New Zealand	1/15	0.83	0.00	-0.5%	7	0						
Australia	2/15	0.79	0.00	0.1%	13	0						
Japan	3/15	0.79	0.00	0.0%	16	1 ▼						
Singapore	4/15	0.78	0.00	-0.5%	17	0						
Korea, Rep.	5/15	0.73	0.00	-0.4%	19	1 ▲						
Hong Kong SAR, China	6/15	0.73	-0.02	-2.8%	22	3 ▼						
Malaysia	7/15	0.57	-0.01	-1.7%	55	1 ▼						
Mongolia	8/15	0.54	-0.01	-1.3%	62	1 ▼						
Indonesia	9/15	0.53	0.01	1.6%	64	4 ▲						
Thailand	10/15	0.50	0.00	-0.2%	80	0						
Vietnam	11/15	0.49	0.00	0.1%	84	4 ▲						
China	12/15	0.47	0.00	0.5%	95	3 ▲						
Philippines	13/15	0.47	0.01	1.4%	97	5 ▲						
Myanmar	14/15	0.36	-0.03	-7.7%	132	3 ▼						
Cambodia	15/15	0.31	-0.01	-2.0%	139	0						

Эх сурвалж: <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/factors/2022/Mongolia/>

Зураг 14. Эрх зүйт ёсны индекс, Монгол Улсын үзүүлэлт, дундаас доогуур орлоготой орнуудын хувьд (2022 он)

Country/Jurisdiction	Income Rank	Overall Score*	Change in Overall Score*	% Change in Overall Score*	Global Rank	Change in Global Rank†						
Senegal	1/38	0.56	0.01	1.2%	56	1 ▲						
Ghana	2/38	0.55	0.00	-0.3%	58	0						
Mongolia	3/38	0.54	-0.01	-1.3%	62	1 ▼						
Indonesia	4/38	0.53	0.01	1.6%	64	4 ▲						
Nepal	5/38	0.52	0.00	0.2%	69	1 ▲						
Tunisia	6/38	0.52	-0.01	-1.9%	71	6 ▼						
Sri Lanka	7/38	0.50	0.00	-0.3%	74	2 ▲						
Ukraine	8/38	0.50	-0.01	-2.0%	76	2 ▼						
India	9/38	0.50	0.00	-0.4%	77	2 ▲						
Uzbekistan	10/38	0.50	0.01	1.0%	78	7 ▲						
Vietnam	11/38	0.49	0.00	0.1%	84	4 ▲						
Belize	12/38	0.49	0.01	2.0%	85	8 ▲						
Benin	13/38	0.49	0.00	0.4%	88	3 ▲						
Algeria	14/38	0.49	-0.01	-1.1%	89	7 ▼						
Morocco	15/38	0.48	-0.01	-1.5%	94	4 ▼						
Philippines	16/38	0.47	0.01	1.4%	97	5 ▲						
Tanzania	17/38	0.47	0.00	-0.8%	98	2 ▲						
Kyrgyz Republic	18/38	0.46	-0.01	-1.3%	100	1 ▼						
El Salvador	19/38	0.46	-0.02	-4.1%	102	7 ▼						
Zambia	20/38	0.45	0.01	1.5%	103	4 ▲						
Kenya	21/38	0.45	0.00	1.0%	104	2 ▲						
Côte d'Ivoire	22/38	0.45	0.00	-0.3%	108	3 ▼						
Angola	23/38	0.43	0.00	-0.3%	113	1 ▲						
Nigeria	24/38	0.41	0.00	-1.1%	118	3 ▲						
Iran, Islamic Rep.	25/38	0.41	-0.01	-2.6%	119	0						
Congo, Rep.	26/38	0.41	-0.01	-3.0%	120	2 ▼						
Honduras	27/38	0.41	0.01	3.1%	121	5 ▲						
Zimbabwe	28/38	0.39	0.00	-0.4%	124	3 ▲						
Bangladesh	29/38	0.39	-0.01	-1.5%	127	2 ▼						
Pakistan	30/38	0.39	0.00	-0.2%	129	2 ▲						
Bolivia	31/38	0.38	-0.01	-3.0%	130	0						
Mauritania	32/38	0.37	0.00	0.4%	131	3 ▲						
Myanmar	33/38	0.36	-0.03	-7.7%	132	3 ▼						
Nicaragua	34/38	0.36	-0.02	-4.6%	133	1 ▼						
Cameroon	35/38	0.36	0.00	1.0%	134	2 ▲						
Egypt, Arab Rep.	36/38	0.35	0.00	1.4%	135	2 ▲						
Haiti	37/38	0.35	-0.02	-6.4%	136	3 ▼						
Cambodia	38/38	0.31	-0.01	-2.0%	139	0						

Эх сурвалж: <https://worldjusticeproject.org/rule-of-law-index/factors/2022/Mongolia/>



## 7. ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

### 7.1. Цахим засаглалын хөгжлийн индексийн талаар

Дэлхийн улс орнуудад хийгдэж байгаа дижитал шилжилт, цахим засаглалыг хэмждэг гол шалгуур үзүүлэлт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн салбар байгууллагаас 2 жил тутам буюу тэгш тоотой жилүүдэд хийгддэг “Цахим засаглалын хөгжлийн индекс (E-Government Development Index (EGDI)” юм.

Уг судалгаа нь 1 жил гаруй хугацаанд үргэлжилдэг бөгөөд улс орнуудын ялгаатай байдал, онцлог зэрэгт тохируулж 65 орчим хэл дээр хийгддэг. Тус судалгааг гаргадаг судалгааны баг нь 100 орчим хараат бус хөндлөнгийн судлаачаас бүрддэг бөгөөд сайн дурын судлаачдыг мөн оролцуулдаг гэдгээрээ онцлогтой.

Судалгаанд нийт 193 орныг хамруулдаг ба энэхүү судалгаа 3 үндсэн индикаторыг гол үзүүлэлтээ болгон авдаг. Тухайлбал:

- Онлайн үйлчилгээний индекс – Online Service Index (OSI)
- Харилцаа холбоо, дэд бүтцийн индекс – Telecommunication Infrastructure Index (TII)
- Хүний капиталын индекс – Human capital index (HCI)

Энэхүү гурван бүлэг үзүүлэлт дээр тулгуурлан 193 орны цахим засгийн хөгжлийн индексийг тооцоолон гаргаж улс орнуудыг эрэмбэлдэг.

- Харилцаа холбоо, дэд бүтцийн индексээр тухайн улсын харилцаа холбооны хөгжлийг тодорхойлдог. Тухайлбал, харилцаа холбооны суурь, дэд бүтэц хэр зэрэг хөгжсөн, хүн амын хэдэн хувь интернэтийн болон харилцаа холбооны үйлчилгээг авдаг, үйлчилгээний хүртээмж зэргийг тооцож үздэг. Мөн харилцаа холбооны үйлчилгээг ашиглахдаа ямар тоног төхөөрөмж ашиглаж байна, ухаалаг утас, таблет, компьютерийн хэрэглээний түвшин, интернэтийн хурдны үзүүлэлт хот, хөдөөд ямар байна гэх зэргээр дэд бүтцийн бүхий л суурь үзүүлэлтийг нарийвчлан судалдаг.
- Харин Онлайн үйлчилгээний индексээр хүн амын түгээмэл ашигладаг төрийн үйлчилгээ онлайн хэлбэрт шилжсэн үү, хэдэн үйлчилгээг онлайнгаар авах боломжтой, үүнд мэдээллийн аюулгүй байдлыг хангаж байна уу, хүний хувийн мэдээллийг хамгаалах тогтолцоо, хууль эрх зүйн орчин бүрдсэн үү, цахим засаглалын суурь болсон зөөлөн дэд бүтцийн хөгжил ямар үе шатандаа явж байна зэрэг олон хүчин зүйлсийг судалдаг.

- Хүний капиталын индексээр иргэдийн цахим ур чадварын түвшин, бичиг үсэг тайлагдалт, боловсролын түвшин, иргэдийн цахим оролцоо зэрэг үзүүлэлтийг судлан жигнэсэн дунджаар энэхүү индексийг гаргадаг.

“Цахим засаглалын хөгжлийн индекс” улс орнуудын дижитал шилжилт, цахим засаглал, харилцаа холбооны хөгжлийг цогцоор нь үнэлж чаддаг гол индекс шалгуур үзүүлэлт юм.

## 7.2. Цахим засаглалын хөгжлийн индекс ба Монгол Улс

2022 оны судалгааны үр дүнг харахад Монгол Улс 18 байраар урагшилж 193 орноос 74-р байранд эрэмбэлэгдсэн бол 2020 онд 92-р байранд эрэмбэлэгдэж байсан юм.

2022 онд гарсан энэхүү судалгаагаар дээрх Цахим засаглалын хөгжлийн индексээр Монгол Улс хэрхэн үнэлэгдсэнийг 3-н үзүүлэлт тус бүрээр сүүлийн 2 судалгаатай харьцуулж харвал индекс тус бүр дээр 2022 онд огцом өсөлт үзүүлсэн байна:

*Хүснэгт 5. Цахим засаглалын хөгжлийн индекс, Монгол Улсын үзүүлэлт, (2004-2022 он)*

	2004	2008	2012	2016	2020	2022
Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI) эрэмбэ	75	82	76	84	92	74
Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI) үзүүлэлт	0.42	0.47	0.54	0.52	0.65	0.72
Онлайн үйлчилгээний индекс – Online Service Index (OSI)	0.19	0.42	0.59	0.51	0.53	0.63
Харилцаа холбоо, дэд бүтцийн индекс – Telecommunication Infrastructure Index (TII)	0.19	0.09	0.18	0.28	0.61	0.70
Хүний капиталын индекс – Human capital index (HCI)	0.87	0.91	0.87	0.76	0.81	0.84

Эх сурвалж: <https://publicadministration.un.org/egovkb/en-us/Data/Country-Information/id/113-Mongolia/dataYear/2004>

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- WGI-Interactive Data Access. (n.d.). WGI-Interactive Data Access. Retrieved June 20, 2023, from <https://info.worldbank.org/governance/wgi/Home/Reports>
- *WJP Rule of Law Index*. (n.d.). WJP Rule of Law Index. <https://worldjusticeproject.org/rule-of-law-index>
- Governance. (n.d.). BTI 2022. <https://bti-project.org/en/index/governance>
- Ц. Даваадулам. (2010). Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг.
- П.Доржсүрэн. (2008). Засаглалын төлөв байдлыг хэмжихүй. *Шинэ Толь*, 62. <https://academy.edu.mn/content/626208-2/>
- П.Доржсүрэн. (2010). Засаглалын үнэлгээ, үзүүлэлтийн төрөл. *Шинэ Толь*, 69. <https://academy.edu.mn/content/691069-2/>
- Бычкова, С. Г. (2022). *Социальная статистика*. Издательство Юрайт.

**ЖЕНДЭРИЙН АСУУДЛААРХ ПАРЛАМЕНТЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТОЙМ СУДАЛГАА: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

*Ц.Норовдондог (Ph.D.), О.Нарантуяа, Б.Батцэцэг*

**АГУУЛГА**

**УДИРТГАЛ**

**СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ**

- Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо
- Хууль, эрх зүйн бодлого, тогтолцоо
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал
- Парламент дахь жендэрийн соёл, орчин

**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АБГББХ	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОХХААБХ	Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо
БСШУБХ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
БХ	Байнгын хороо
ЁЗСХБХ	Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо
ЕНБД	Ерөнхий нарийн бичгийн дарга
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЖҮХАА	Жендэрийн үндэсний хорооны ажлын алба
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАН	Монгол Ардын Нам
МУХЭҮК	Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс
НББХ	Нийгмийн бодлогын байнгын хороо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУПХ	Олон улсын парламентын холбоо
ӨБХ	Өргөдлийн байнгын хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын Их Хурал
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮББХ	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо

## УДИРТГАЛ

Олон Улсын Парламентын Холбоо (ОУПХ) нь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын зарчим, хэм хэмжээ, механизмыг улс орнуудын парламент хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлэхэд зориулсан парламентын өөрийн үнэлгээний аргачлалыг НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар (ХЭДКГ) болон бусад байгууллагуудтай хамтран боловсруулж, үе шаттайгаар хэрэглээнд нэвтрүүлж байна.

Энэ хүрээнд ОУПХ-ны боловсруулсан аргачлалын хүрээнд хүний эрхийн болон жендэрийн мэдрэмжийн асуудлаарх 2 төрлийн үнэлгээг хамтатган Монгол Улсын парламент, ажлын алба зохион байгуулав.

Жендэрийн өөрийн үнэлгээг сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд дэлхийн 10 гаруй улс орны парламентад явуулсан бөгөөд жендэрийн асуудлаар парламент өнөөгийн нөхцөл байдлаа дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлдог.

ОУПХ-ны 2022-2026 оны стратегид заасны дагуу парламентуудын нийтлэг ашиг сонирхлыг хангах чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх үндэс суурийг тавих зорилгоор 2022 оны 08 дугаар сард ОУПХ болон Монгол Улсын Их Хурал харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Энэ хамтын ажиллагаа нь хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бүрдүүлэх замаар парламентын шийдвэр, үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад чиглэнэ. Хүний эрх, жендэрийн асуудал нь Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилго 3-т “Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, парламентад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх.” бодлогын зорилгод хамаарах юм.

### **Судалгааны зорилго:**

Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх тойм судалгаа, мэдээлэл бэлтгэх. Тойм судалгааг Өөрийн үнэлгээний дагуу дараах үндсэн асуултуудын хүрээнд гаргав. Үүнд:

- Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо (тоо, албан тушаал)
- Хууль, эрх зүйн бодлого, тогтолцоо
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал
- Парламент дахь жендэрийн соёл, орчин

## АСУУЛТ 1 - ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТОО, БАЙР СУУРЬ

- 1.1 Эмэгтэйчүүдийг парламентад сонгох, томилоход ямар хүчин зүйл нөлөөлөв?  
Парламентад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд юу саад болж байна вэ?
- 1.2 Төлөөллийн өнөөгийн түвшин (парламентын гишүүдийн хувьд; тойргийн хувьд; үндэсний болон олон улсын зорилтуудын дагуу) хангалттай байна уу?  
Эмэгтэйчүүдийн тодорхой тооны төлөөллийг хангахын тулд ямар механизмууд байдаг эсвэл байж болох вэ?
- 1.3 Нөөц суудлаар сонгогдсон эсвэл томилогдсон эмэгтэйчүүдийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгогдсон эрэгтэйчүүдтэй адил хүлээн зөвшөөрдөг үү?
- 1.4 Удирдах албан тушаалын хэдэн хувийг эмэгтэйчүүд эзэлдэг вэ?  
Эмэгтэйчүүд парламентад ямар удирдах албан тушаал хашдаг вэ?  
Удирдах албан тушаалыг хэрхэн хуваарилдаг вэ?
- 1.5 Эмэгтэйчүүдийг парламентад удирдах албан тушаалд томилох боломжийг баталгаажуулах арга хэмжээ бий юу?  
Хэрэв тийм бол ямар арга хэмжээ байдаг вэ? Хэрвээ үгүй бол байх ёстой юу?  
Хороо тус бүрийг эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран даргалж болох уу?
- 1.6 Бүх хороонд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөөлөл байгаа юу?  
Ямар хороодод эмэгтэйчүүдийн төлөөлөл түлхүү байдаг вэ?  
Аль хороонд эмэгтэйчүүдийн төлөөлөл дутуу буюу байхгүй вэ?  
Хорооны гишүүнчлэлийг хэрхэн шийддэг вэ?  
Эмэгтэйчүүдийн эрх ашгийн талаарх хэвшмэл ойлголтыг хорооны гишүүнчлэлээр бэхжүүлж байна уу?
- 1.7 Парламентад ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо, удирдах албан тушаалд байгаа эмэгтэйчүүдийн тоонд хэрхэн хяналт тавьж байна вэ?  
Хэрэв тусгайлсан хяналтын байгууллага байдаг бол тухайн байгууллага нь Парламент, олон нийтэд нээлттэй, тогтмол тайлагнаж байх ёстой юу?

## АСУУЛТ 2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГО, ТОГТОЛЦОО

### Үндэсний хамрах хүрээ

- 2.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний ямар хууль тогтоомжууд байдаг вэ?  
Тус улсын Үндсэн хууль жендэрийн мэдрэмжтэй байдаг уу?  
Сүүлийн 2-5 жилийн хугацаанд парламентаас жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр баталсан хамгийн чухал хуулиуд юу вэ?

- 2.2 Парламентад жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хуулиудыг хэрхэн санаачилж баталдаг вэ? Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулдаг уу? Дээрх үйл ажиллагааг сайжруулах шаардлага бий юу?
- 2.3 Засгийн газар, парламентад жендэрийн асуудлыг тусгасан хууль, бодлого бий юу?  
Хэрэв тийм бол түүний хэрэгжилтэд УИХ-аар хэн, хэрхэн хяналт тавих үүрэгтэй вэ?  
Хэрэв тийм биш бол ийм хууль, бодлого хэрэгтэй юу?

#### Парламентын үйл ажиллагаа

- 2.4 Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй болон санал болгож буй хуулиудыг Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, жендэрийн тэгш байдлыг хангах олон улсын болон бүс нутгийн бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэгт нийцэж байгаа эсэхийг парламент хэрхэн баталгаажуулдаг вэ?
- 2.5 Парламент хуулиудад эрэгтэй, эмэгтэй хүмүүст үзүүлэх нөлөөллийн ялгааг хэмжихийн тулд жендэрийн үүднээс авч үздэг үү?  
Хэрэв тийм бол парламентад дээрх хяналт, шинжилгээг хэн, эсвэл аль байгууллага хариуцах вэ?

#### Парламентын бодлого

- 2.6 Парламентын дүрэм жендэрийн мэдрэмжтэй юу?  
Парламентын дүрэмд жендэрийн үүднээс дүн шинжилгээ хийсэн бол тэр шинжилгээг хэн хийсэн бэ?
- 2.7 Парламентад жендэрийн тэгш байдлыг хангасан стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө бий юу?  
Хэрэв тийм бол дээрх төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж, хянаж, үнэлж байна вэ?  
Хэрэв тийм биш бол жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөөг хэрхэн боловсруулах вэ?
- 2.8 УИХ-д өөр үйл ажиллагааны төлөвлөгөө бий юу?  
Хэрэв тийм бол тэд жендэрийн мэдрэмжтэй юу? Эдгээр төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх механизм бий юу?  
Хэрэв тийм биш бол эдгээр төлөвлөгөө хэрхэн жендэрийн мэдрэмжтэй болох вэ?



**АСУУЛТ 3 - ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ**

- 3.1 Парламентын үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад ямар механизм, бүтцийг ашигладаг вэ? Тухайлбал, Жендэрийн тэгш байдлын асуудал эрхэлсэн хороо, УИХ дахь эмэгтэйчүүдийн бүлэг байдаг уу? Жендэрийн суурь нэгжүүд байдаг уу? Мэдээлэл, зөвлөгөө өгөх тусгайлсан жендэрийн нэгж байдаг уу? Дээр дурдсан нэг буюу хэд хэдэн механизм, бүтцийг бий болгох шаардлагатай юу?
- 3.2 Парламент жендэрийн тэгш байдлыг хангах ямар арга хэрэгслийг бий болгосон бэ?  
Парламент хууль тогтоомжийг жендэрийн үүднээс үнэлэх хяналтын хуудас боловсруулсан уу?  
Парламентад хүйсээр ангилсан мэдээлэл авах боломжтой юу, хэрэв байгаа бол тэдгээрийг хэрхэн ашигладаг вэ?  
Парламентын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын асуудлыг тусгахад тустай өөр хэрэгсэл бий юу?  
Жендэрийн тэгш байдлыг хангахад хангалттай нөөц хуваарилагдсан уу?
- 3.3 Парламентад жендэрийн тэгш байдлыг хангах үүрэгтэй байгууллагууд хэр үр дүнтэй ажиллаж байна вэ?  
Тэдгээр нь үндэсний эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах механизм, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл болон бусад байгууллагуудтай ямар харилцаатай байдаг вэ?  
Дээрх байгууллагууд хангалттай эрх мэдэлтэй юу?  
Тэд хэр сайн нөөцтэй вэ (ажилтан, хурлын өрөө, төсөв гэх мэт)?  
Тэд жендэрийн тэгш байдлыг хангахад ямар өөрчлөлт хийж чадсан бэ?  
УИХ-ын байгууллага дахь тэдний байр суурийг шинэчлэн сайжруулах уу?
- 3.4 Парламентад эмэгтэйчүүдийн бүлэг байдаг бол хэрхэн ажилладаг вэ?  
Үйл ажиллагааг нь хэрхэн зохион байгуулдаг вэ? Шийдвэрүүд хэрхэн гардаг вэ?  
Тухайн бүлгийн гишүүн бус хүмүүс хэрхэн хүлээж авч байна вэ?
- 3.5 Жендэрийн тэгш байдлыг хангах асуудал эрхэлсэн нэгээс олон байгууллага парламентад байгаа тохиолдолд тэдгээр нь хоорондоо ямар уялдаа холбоотой вэ?  
Тэдний хооронд албан ёсны зохицуулалтын механизм бий юу?  
Ажлын харилцаа үр дүнтэй байдаг уу?
- 3.6 Төсөв болон төсвийн хяналтын үйл явцад жендэрийн тэгш байдлыг тусгасан уу?  
Хэрэв тийм бол энэ үйл явцад ямар нэгэн бэрхшээл тулгарсан уу?  
Хэрэв тийм биш бол энэ үйл явцад жендэрийг хэрхэн голчлон оруулах вэ?

**АСУУЛТ 4 - ПАРЛАМЕНТЫН СОЁЛ, ОРЧИН, БОДЛОГО**

- 4.1 Парламентад жендэрийн тэгш байдлыг хэрхэн хүлээж авч байна вэ? Жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, дэмжлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байгаа юу?  
Парламент дахь жендэрийн тэгш байдлыг хангах дэмжлэгийг нэмэгдүүлэхийн тулд (өөр) ямар арга хэмжээ авах нь үр дүнтэй вэ?
- 4.2 Парламентын соёлыг (хэл, зан заншил, хувцаслалтын дүрэм) жендэрийн хувьд Та хэрхэн тодорхойлох вэ: энэ нь жендэрийн мэдрэмжтэй юу, жендэрийн хувьд төвийг сахисан уу, эсвэл хүйсийн ялгаа өндөртэй юу?
- 4.3 Парламентад эмэгтэйчүүдийг гадуурхсан, доромжилсон хэвшмэл ойлголт байдаг уу? Хэрэв тийм бол эдгээрийг хэрхэн арилгах вэ?
- 4.4 Парламентын байрыг жендэрийн үүднээс авч үзсэн үү?  
Боломжит үйлчилгээнд эмэгтэйчүүдийн голчлон эрэлхийлдэг үйлчилгээ багтдаг уу?  
Парламентын ордон тэнд ажиллаж байгаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хэрэгцээг хэрхэн хангаж байна вэ?  
Нялх балчир хүүхэдтэй УИХ-ын гишүүдийг УИХ-ын ордон тохирох нөхцөлөөр хэр хангадаг вэ? Жишээлбэл, хөхүүл эхчүүдэд зориулсан тусгай өрөө, хүүхэд асрах газар эсвэл гэр бүлийн өрөө байдаг уу?  
УИХ хүүхэд харах үйлчилгээ үзүүлдэг үү?  
Парламентад ийм дэд бүтэц байх нь хэр чухал вэ?
- 4.5 УИХ-ын ажлын нөхцөл нь УИХ-ын гишүүдэд ажил, гэр бүлийн үүргээ тэнцвэржүүлэх боломжийг олгож байна уу?  
УИХ-ын гишүүдийн ажиллах цаг нь гэр бүлдээ хангалттай цаг зарцуулах боломжийг олгодог уу?  
УИХ-ын гишүүдэд хүүхэд асран хүмүүжүүлэх чөлөө хангалттай байдаг уу?  
Хүүхэд асрах, жирэмсний болон амаржсаны амралттай байх үед тухайн гишүүний саналыг хэрхэн авдаг вэ?
- 4.6 Парламентын ордонг барилга байгууламжийн хувьд болон бэлгэдлийн хувьд жендэрийн мэдрэмжтэй ажлын байр гэж үзэж болох уу?  
Парламентын ажлын байр, тоног төхөөрөмжийн хуваарилалтыг ямар шалгуураар тодорхойлдог вэ?  
Парламентын ажлын өрөөнүүдийн нэрс эрэгтэй, эмэгтэй гишүүдийг адилхан тусгасан байдаг уу?  
Энэ талаар шийдвэр гаргах үүрэгтэй албан тушаалтан хэн бэ?  
Барилгад тавигдсан уран бүтээлийг эмэгтэй, эрэгтэй зураачдад адил тэгш захиалж хийлгэсэн үү?
- 4.7 УИХ-д ажлын байранд ялгаварлан гадуурхах, хүйсээр ялгаварлах, дарамтаас сэргийлэх бодлого бий юу?  
Ёс зүйн дүрэм байдаг уу? Үүнийг парламентад зохистой ёс зүйг хангахад үр дүнтэй ашиглаж чадаж байна уу?

Ёс зүйн дүрэм хэрхэн жендэрийн мэдрэмжтэй болох вэ?

Ажлын байрны дарамттай тэмцэх бодлого, дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг шийдвэрлэх механизм бий юу? Өргөдөл гомдлыг үр дүнтэй шийдвэрлэж чаддаг уу? Ялгаварлан гадуурхахын эсрэг бодлого байдаг уу?

4.8 УИХ-ын гишүүдийн зорчих боломжийг ямар шалгуураар тодорхойлдог вэ?

Энэ нь эрэгтэй, эмэгтэй парламентын гишүүдэд тэгш хуваарилагддаг гэдэгтэй санал нэг байна уу? Хэрэв тийм биш бол шударга хуваарилалтад юу саад болж байна вэ?

4.9 Парламентын харилцаа холбоо (эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл) болон олон нийттэй харилцах бодлого нь жендэрийн мэдрэмжтэй, жендэрийн хувьд төвийг сахисан, эсвэл жендэрийн хувьд алсын хараа муутай байдаг уу?

Эдгээр бодлогод парламентын жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг хэрхэн илүү сайн тусгаж харуулах вэ?

Парламентын бэлтгэсэн харилцаа холбооны (хэвлэл мэдээлэл) материалыг жендэрийн үүднээс хянаж, аудит хийж байсан уу? Шалгалтанд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан тогтоосон харилцаа холбоо орсон уу?

Парламентад олон нийтийг хамарсан арга хэмжээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэнцүү оролцдог уу?

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### **АСУУЛТ 1. ПАРЛАМЕНТ ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТОО, АЛБАН ТУШААЛ**

Парламент дахь хүйсийн төлөөллийн асуудал нь ардчилсан парламентын суурь зарчмуудын нэг болох төлөөллийг хангах шалгуур үзүүлэлтийн хүрээний асуудал юм. Эрх зүйн орчны хүрээгээр нь авч үзвэл, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдал, бүх шатны төлөөллийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон тэдгээрийн агуулга, үзэл санаанд нийцүүлэн баталсан үндэсний хууль тогтоомжоор хангалттай хэмжээнд зохицуулсан гэж хэлж болохоор байна.

Судалгаанаас үзэхэд, 1992 оноос хойш Улсын Их Хурал (УИХ)-д парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо харьцангуй цөөн байсан бол 2012 оноос хойших сүүлийн 3 парламентад сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо өмнөх жилүүдээс нэмэгдэж, энэ үзүүлэлт тогтвортой хадгалагдаж байна. Парламентад сонгогдсон эмэгтэй гишүүдийг парламентын удирдах албан тушаалд томилох тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд өнгөрсөн хугацаанд УИХ-ын удирдах албан тушаалд эмэгтэй гишүүд харьцангуй цөөн ажилласан. Сүүлийн жилүүдэд Байнгын хорооны даргаар ажилласан эмэгтэй гишүүдийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд 2020-2024 оны УИХ-д 4 эмэгтэй Байнгын хорооны дарга ажиллаж байна. Түүнчлэн УИХ-ын дэд даргаар сөрөг хүчний нам (АН)-аас эмэгтэй гишүүн сонгогдон ажиллаж байна.

Эмэгтэйчүүд парламентын сонгуульд нэр дэвшиж сонгогдоход үндэсний хэмжээнд өрнөсөн идэвхтэй санал, санаачилгууд болон квотын механизм, улс төрийн намын дэмжлэг, сонгуулийн тогтолцооны ээлтэй байдал зэрэг хүчин зүйлс эерэг нөлөө үзүүлсэн бол эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн гарааны тэгш бус байдал, сонгуулийн санхүүжилтийн зардлын өсөлт, эмэгтэй нэр дэвшигчдийн санхүүгийн чадавх болон нийгэм дэх жендэрийн хэвшмэл үзэлтэй холбоотой олон хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр УИХ-ын гишүүдийн тоог 126 болгон нэмэгдүүлж, сонгуулийн холимог тогтолцоог баталгаажуулсан нь цаашид парламентад сонгогдох эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхүйц алхам болсон.

### АСУУЛТ 1.1. Эмэгтэйчүүдийг Улсын Их Хуралд сонгох, томилоход ямар хүчин зүйл нөлөөлөв?

Монгол Улс 1924 онд тусгаар тогтнолоо тунхаглан зарласнаас хойш 4 удаа (1924, 1940, 1960, 1992) Үндсэн хууль батлахдаа эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийн үзэл санааг Үндсэн хуулиараа ямагт баталгаажуулж ирсэн. 1981 онд Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Эмэгтэйчүүдийн Улс төрийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсноор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил аливаа алагчлалгүйгээр, эрх тэгш байдлаар бүх шатанд сонгох, сонгогдох, томилогдон ажиллах эрх нь баталгаажсан бөгөөд энэхүү эрхийг үндэсний хууль тогтоомжуудаар баталгаажуулсан байдаг.

1992 онд батлагдсан Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн хуулиар эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсны дагуу эмэгтэйчүүдийн парламентад сонгогдох, томилогдохтой холбоотой харилцааг Улсын Их Хурал (УИХ)-ын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулж байна.

#### Эмэгтэйчүүдийг парламентад сонгох, томилохтой холбоотой эрх зүйн орчны лавлагаа

Хуулийн нэр	Хуулийн холбогдох зохицуулалт
Монгол Улсын Үндсэн хууль	14.2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. 16.11.улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй.
Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө)	4.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 126 гишүүнийг дараах байдлаар сонгоно: 4.3.1.Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/ аргаар; 4.3.2.Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар. <u>30.2.Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.</u> /Энэ хэсэгт "нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй" гэснийг "нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй" гэж 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

<p>Улс төрийн намын тухай хууль  (2024.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)</p>	<p>8.1. Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно. 8.2.3.нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх. 15.2.Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана: 15.2.8.төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журам батлах; 17.7.Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.</p>
<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль</p>	<p>5.1.1.жендэрийн тэгш эрхийн зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах; 6.1.Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглоно. 7.2.2.улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангах зорилгоор суудал хадгалах зэргээр квотын хэлбэрийг хэрэгжүүлэх; <b>8 дугаар зүйл.Улс төрийн хүрэн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгаа</b> 8.1.Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно. 8.2.Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна. 8.3.Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна. 8.4.Улс төрийн нам нь энэ хуулийн 8.2, 8.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтийн тайланг энэ хуулийн 18.1-д заасан Жендэрийн үндэсний хороонд жил тутам хүргүүлж байна. <b>15 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи Улсын Их Хурлын бүрэн эрх</b> Хэвлэх 15.1.Улсын Их Хурал жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.1.1.төрийн бодлого, хууль тогтоомжийг хүний эрхэд суурилсан жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байхаар тодорхойлох; 15.1.2.энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтоосон жендэрийн эрх тэгш байдлын зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох; 15.1.3.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эмэгтэй, эрэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон төрийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүнгийн хэрэгжилтийг хангахуйц хөрөнгө батлах;</p>

<p>15.1.4.дараахь тайлан, илтгэлийг 2 жил тутам хэлэлцэж, дүгнэлт гаргах:                  15.1.4.а.жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаархи Засгийн газрын тайлан;                  15.1.4.б.жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаархи Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл;                  15.1.4.в.төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаархи Төрийн албаны зөвлөлийн тайлан;                  15.1.4.г.Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын ээлжит тайлан.                  15.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.</p>
---

1992 онд ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш УИХ-ын 8 удаагийн сонгууль зохион байгуулагдсан бөгөөд эдгээр сонгуульд нийт 3445 хүн нэр дэвшсэнээс 577 эмэгтэй нэр дэвшиж, 65 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогдсон байна.

**УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо**

Он	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
УИХ-д нийт нэр дэвшигчдийн тоо	293	302	602	244	356	544	498	606
УИХ-д нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо	-	8	9	40	66	174	129	151
УИХ-д сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо	3	8	9	5	3	11	13	13
УИХ-д эзлэх хувь	3.9%	10.5%	11.8%	6.6%	3.9%	14.5%	17.1%	17.1%

Хүснэгтээс үзэхэд, 1992 оноос хойш эмэгтэйчүүд УИХ-д цөөн боловч суудал авч сонгогдсоор ирсэн байх ба эмэгтэйчүүд харьцангуй олон сонгогдсон үе нь 1996-2000, 2000-2004, 2012-2016, 2016-2020, 2020-2024 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацааны сонгуулийн жилүүд байна. Үүнээс сүүлийн 3 сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд буюу 2012 оноос хойш УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо тогтвортой өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2016, 2020 оны сонгуулиар эмэгтэйчүүд хамгийн их буюу 13 (17.1%) суудлыг тогтвортой хадгалсан байна.

**УИХ-д эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлс:**

**Квотын механизм.** Улс төрийн нам нь төрийн байгуулалтад голлох үүрэгтэй оролцдог. 2023 оноос өмнө Улс төрийн намын тухай хуульд жендэрийн харилцааг “хүйсээр ялгаварлахгүй” (5.1.3), намын дүрэмд



тусгах нийтлэг зүйл (11.2.8) зэрэг ерөнхий зарчмын утгатай хоёр заалтаар тусгасан байсан. УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулиудад жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтыг нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар томьёолж нэг заалтаар тусгасан байсан. Анх 2005 оны УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 28.2-т “Нам, эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэй байх” гэсэн заалтыг баталсан ч 2011 онд 20 хувь болгож бууруулснаар ухралт хийсэн гэж үздэг. Эмэгтэйчүүдийн квотыг хуульчилсны үр дүнг квотгүй явагдсан сонгуулиудын үр дүнтэй харьцуулахад 2012-2020 онд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн тоо 2008 оноос нэмэгдсэн байгаа нь квотын механизм тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгснийг харуулж байна. (*Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021*)

Харин 2023 онд Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар хуульчилсан. Түүнчлэн Улс төрийн намын тухай хуульд бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байхаар хуульчилсан нь цаашид парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байгаа юм.

**Улс төрийн намын санхүүжилтийн дэмжлэг.** УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлсэн санхүүгийн дэмжлэг 2012 оноос хойш эрс өссөн дүнтэй байна.

УИХ-ын 2008 оны сонгуульд 7.8 тэрбум төгрөг, 2012 онд 35.6 тэрбум төгрөг, 2016 онд 34.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Харин 2020 оны сонгуульд 43.0 тэрбум төгрөг зарцуулсны 20.5 тэрбум төгрөгийг УИХ-ын сонгуульд зарцуулсан байна.

Үндэсний Аудитын газрын (ҮАГ)-ын мэдээллээр нэг нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг тогтоохдоо жендэрийг харгалздаггүй бөгөөд УИХ-ын сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийн хэмжээг хүйсээр ангилан гаргасан статистик тоо баримт, судалгаа одоогоор байхгүй байна.

**Сонгуулийн тогтолцооны өөрчлөлт.** 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр УИХ-ын гишүүдийн тоог 126 болгон нэмэгдүүлж, сонгуулийн холимог тогтолцоог баталгаажуулсан бөгөөд үүнээс 78 гишүүнийг сонгуулийн тойргоос олныг төлөөлөх /мажоритар/



аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар сонгохоор хуульчилсан нь парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдлыг бий болгож байна. Олон улсын судалгаанаас үзэхэд, холимог болон пропорционал сонгуулийн тогтолцоотой үед эмэгтэй нэр дэвшигчид сонгогдох магадлал илүү байгаа нь харагддаг. (*Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орнуудын туршлага, LEOS, KOICA, UNDP, 2022 он, 46 дахь тал*)

### **УИХ-д эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд саад болж буй хүчин зүйлс**

**Сонгуулийн тогтолцоо.** Улс орнуудын сонгуулийн тогтолцоо ба хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жинг харьцуулсан судалгаанаас үзэхэд, дэлхийн 194 орноос 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар сүүлийн сонгуульдаа пропорционал буюу хувь тэнцүүлэх тогтолцоог ашигласан 82 оронд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин хамгийн өндөр буюу 27.6%, холимог тогтолцоог ашигласан 29 оронд 26.1% байгаа бол мажоритар/олонхын тогтолцоог ашигласан 71 оронд 18.5% хувьтай байна. (*“Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орнуудын туршлага” судалгааны тайлан, KOICA, UNDP, LEOS, 2022 он, 47 дахь тал*)

Монгол Улсад УИХ-ын өмнөх сонгуулиуд ихэвчлэн мажоритар тогтолцоогоор явагдаж ирсэн нь парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд саад болж байсан бол 2023 онд Монгол Улсын Үндсэн хууль, УИХ-ын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулж сонгуулийн холимог тогтолцоог хуульчилсан нь энэхүү бэрхшээлийг арилгахад дөхөм болохоор байна.

**Улс төрийн гарааны тэгш бус байдал.** Одоо хэрэгжиж буй хуулиудад сонгуулийн кампанит ажлын санхүүжилт босгох арга замын тухай тодорхой заалт байхгүй, харин зардлыг хэрхэн зарцуулах тухайд заалтууд бий. Зардлыг хязгаарлах заалт сул байгаа нь хөрөнгөтэй нэр дэвшигч, улс төрийн намуудад илүү боломж олгож байна. Монгол Улс эрэгтэйчүүд давамгайлсан парламенттай бөгөөд эрэгтэй гишүүдийн дунд бизнес эрхэлдэг гишүүд олон байдаг. Тиймээс улс төрд бизнесийн ашиг сонирхлын нөлөө их, томоохон компаниуд сонгуулийг санхүүжүүлж байгаа нь улс төрд орж буй эмэгтэйчүүд болон бага орлоготой эрэгтэй нэр дэвшигч сонгогдоход саад бэрхшээл болсоор байна”. Энэ нь улс төрийн гараа тэгш бус байгааг, мөн нэгэнт парламентад эрэгтэйчүүд давамгайл байгаа тул дахин сонгогдох боломж мөн эрэгтэйчүүдэд илүү байгааг харуулж байна. (*Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021, 45 дахь тал*)

**Санхүүгийн бэрхшээл.** Монгол Улсад эмэгтэй нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаа явуулахад шаардлагатай хөрөнгө босгоход ихээхэн бэрхшээл хүндрэлтэй тулгардаг байна. Мөн сонгуульд нэр дэвшихдээ хөрөнгө босгодог нээлттэй тогтолцоо болон эмэгтэй нэр дэвшигчдээ дэмжсэн бодлого, санхүүгийн болон арга зүйн дэмжлэг байхгүй байна.

Дэлхийн 30 гаруй улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нам нь эмэгтэйчүүдийн квотоо баримталж чадсан, төсвөөс 10-20 хувийн санхүүжилт олгохоор хуульчилж өгсөн жишээ байна. Зарим орны улс төрийн нам нь санхүүжилтийнхээ 25-аас доошгүй хувийг сонгуульд нэр дэвшиж байгаа эмэгтэй нэр дэвшигчиддээ зарцуулах хууль хэрэгжиж байгаа юм. Жендэрийн тэгш оролцоо, цөөнхийн төлөөллийг улс төрд хангах зорилгын үүднээс эмэгтэйчүүд, залуучууд, нутгийн уугуул иргэдийг дэмжиж тодорхой хувийг төсвөөс санхүүжүүлдэг туршлага ч олон улсад бий.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХТХ)-ийн 4.1.4-т заасан жендэрийн ялгаварлан гадуурхалтын хүрээнд авч үзэхэд, улс төрийн сонгуульд нэр дэвших болон нэр дэвшигчдэд зарцуулах санхүүжилтийн дэмжлэгт ялгаварлан гадуурхалт байна гэж дүгнээд жендэрийн тэгш оролцоог улс төрд хангах зорилгоор эмэгтэйчүүдийг дэмжиж, сонгуулийн зардлын тодорхой хувийг төсвөөс санхүүжүүлдэг болох шаардлагатай байгааг зөвлөсөн. *(Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021, 46 дахь тал)*

**Эмэгтэй нэр дэвшигчийн татвар (дэнчин).** Монгол Улсад улс төрийн нам дотроо нэр дэвших эрх авахад “нэр дэвшигчийн татвар” гэсэн өндөр босго тавьдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд ялгаварлал, бэрхшээл учруулж байна. Улс төрийн намуудын дүрэм дэх нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохицуулсан заалтууд хэт ерөнхий байдаг. *(Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021, 46 дахь тал)*

**Сонгуулийн санхүүжилтийн зардлын өсөлт.** Сонгуульд зарцуулах зардлын хэмжээг УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 50.2-т “Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагыг харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхий аудитор хамтран батална” хэмээн заасан. 2016 оны УИХ-ын ээлжит сонгуулийн жилд нам эвсэл 3.4 тэрбумаар тогтоож байсан бол 2020 оны ээлжит сонгуулийн зардлын дээд хэмжээг 5.9 тэрбумаар

тогтоосон. УАГ-ын мэдээлснээр 2016 оны ээлжит сонгуулийн дүнгээр нэг нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээ 322 сая төгрөг байсан бол 2020 онд 410 сая төгрөг болж нэмэгдсэн байна. Нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг тогтоохдоо жендэрийн ялгамжтай тогтоодоггүй нь эмэгтэй нэр дэвшигчдэд хүндээр тусч байна. *(Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021, 45 дахь тал)*

**Жендэрийн хэвшмэл үзэл.** Эрэгтэй, эмэгтэйчүүдийн дийлэнхэд өрхийн хөдөлмөрийн хуваарийн хэвшмэл үзэл илэрч байгаа бөгөөд ар гэрээ авч явах, хүүхдээ асрах үүргийг эмэгтэйд түлхүү оногдуулах хандлага байна. Эрчүүдийг алсын хараатай, шийдэмгий, зоригтой, шулуун шударга байж чадна хэмээн дэмжиж байгаагаас гадна захирах, засаглах эрх мэдлийг эрэгтэй хүнд оноодог хэвшмэл үзлээр хандаж байна. *(Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл судалгааны тайлан, SPDRI, KOICA, UNDP, GENDER EQUALITY, 2022, 8,9 дэх тал)*

Мөн эмэгтэйчүүдийг сонгуульд нэр дэвшээд амжилт олоогүй шалтгааныг хувийн зан чанар, гадаад харагдах байдал, боловсрол мэдлэг, эдийн засгийн нөөц боломж гэсэн дөрвөн хүчин зүйлээр ялгаж тодруулсан байна. *(Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл судалгааны тайлан, SPDRI, KOICA, UNDP, GENDER EQUALITY, 2022, 10 дахь тал)*

Олон нийтийн судалгааны хариултаас харахад, олон нийт ихэвчлэн эрэгтэй улс төрчдөд хамаатуулдаг шийдэмгий, зоригтой, тэмцэгч чанарыг улс төрийн манлайлагчаас хүлээдэг буюу улс төрчийг эрэгтэй чанараар харж байна. Эмэгтэй улс төрчдөөс манлайлагч чанарыг хүлээж байна. *(Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл судалгааны тайлан, SPDRI, KOICA, UNDP, GENDER EQUALITY, 2022, 11 дахь тал)*

**Улс төрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах 5 үндсэн зарчмын хэрэгжилт**

<b>Зарчим</b>	<b>Агуулга</b>	<b>Дүгнэлт</b>
Жендэрийн тэгш эрхийн зарчим	эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөлийг хангах	Эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төрийн харилцаанд эрх тэгш байх, улс төрд оролцох боломж, нөхцөлийг хангах зарчим хууль эрх зүйн хүрээнд тодорхой хэмжээнд хангагдаж байгаа хэдий ч хуулийн хэрэгжилтийн түвшинд хангалттай бус байна. Үүний гол шалтгаан нь хуулийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл улс төрийн намуудад бага байна.
Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим	эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх	Хууль тогтоомжийн хүрээнд ялгаварлан гадуурхалт, хүний эрх эрх чөлөөг хязгаарлах байдал байхгүй хэдий ч нийгмийн дундах жендэрийн хэвшмэл ойлголт өөрчлөгдөхгүй хэвээр оршоор байна. Улс төрийн хүрээнд аль нэг хүйсийг илт ялгаварлан гадуурхсан зүйл байхгүй ч квотыг хэрэгжүүлэхгүй байх, дэмжлэг үзүүлэхгүй байх явдал байсаар байна.
Төрийн хариуцлагын зарчим	төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх	Улс төрийн хүрээнд төрөөс бодлого, хууль тогтоомжийг батлан гаргаж байгаа хэдий ч хуулийн хэрэгжилт, хариуцлага хүлээх байдал хангалтгүй байна.
Жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим	хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох	Улс төрийн харилцааны хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах чиглэлд сүүлийн жилүүдэд ахиц дэвшил гараагүй байна.
Жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим	хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах.	Улс төрийн намууд хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдал хангалтгүй байгаагаас гадна улс төрийн харилцааны хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд судалгаа, мэдээлэл хангалттай бус хэвээр байна.

**Улс төр дэх хүйсийн тэгш бус байдал.** Парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгаа нь эмэгтэйчүүдийн мэргэжлийн чадавх, туршлага сул байгаагаас бус улс төрийн институт, бүтэц нь өөрөө эрэгтэйчүүд давамгайлсан байгаатай илүү холбоотой гэсэн дүн гарчээ. (*Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа, ШХА, IRIM, 2014 он, 36 дахь тал*)

2016 болон 2020 оны УИХ-ын сонгуульд УИХ-д суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн хүйсийн байдлыг авч үзвэл, 21.9-26.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь хуульд заасан нийт нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна гэсэн заалтыг хангаж байгаа боловч Улс төрийн намын тухай хуулийн 5.1.3, 11.2.8 дахь заалтын хэрэгжилт хангалттай гэж үзэхэд эргэлзээтэй. УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн 606 нэр дэвшигчдийн 455 нь буюу 75.08 хувь нь эрэгтэй, 151 нь буюу 24.92 хувь нь эмэгтэй нэр дэвшигч байна. Үүнээс МАН-ын 76 нэр дэвшигчээс 16 буюу 21.05 хувь нь эмэгтэй, АН-ын 76 нэр дэвшигчээс 17 буюу 22.36 хувь нь эмэгтэй, “Та бидний эвсэл”-ийн 74 нэр дэвшигчээс 17 буюу 23 хувь, “Зөв хүн электорат эвсэл”-ийн 53 нэр дэвшигчээс 16 буюу 32 хувь нь тус тус эмэгтэй нэр дэвшигч байсан. (*Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021, 40 дахь тал*)

### **УИХ-д суудал бүхий намуудаас нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа**

Он	Хүйс	МАН	АН	МАХН	ХҮН
2016	Эрэгтэй	77.9%	78.9%	82.5%	-
	Эмэгтэй	22.1%	21.9%	18.5%	-
2020	Эрэгтэй	78.9%	77.6%	88.5%	73.6%
	Эмэгтэй	21.9%	22.4%	21.5%	26.4%

**Улс төрийн хүрээн дэх ялгаварлан гадуурхалт.** “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь” судалгааны тайланд оролцогчид намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход ялгаварлан гадуурхалт түгээмэл байна. Улс төрийн намуудын сонгуульд нэр дэвшигчдэд тавьдаг “дэнчин” мөнгөний хэмжээ нь хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхах үндэс болж байна гэж хариулсан байна.

Сонгуульд хэнийг нэр дэвшүүлэх, эмэгтэйчүүдийг дэмжих эсэх, тэднийг улс төрийн албан тушаалд дэвшүүлэх асуудалд улс төрийн нам болон намын удирдлагын шийдвэр нөлөөлж байгааг УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн, сонгогдсон эмэгтэйчүүдийн тоон үзүүлэлтээс харж болно. (*Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал, МУХЭҮК, KOICA, UNDP, 2023, 11-13 дахь тал*)

Сүүлийн сонгуулиудын жишээнээс харахад, намууд жендэрийн квотыг зөрчөөгүй боловч эмэгтэй нэр дэвшигчдийг сонгогдох магадлал багатай тойргуудад өрсөлдүүлсэн нь бодит байдалд жендэрийн тэгш байдлыг хангах улс төрийн хүсэл зориг дутаж буйн илрэл болно. (*“Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин”, ННФ, 16 дахь тал*)

**Эмэгтэй улс төрчдийн чадавх.** Улс төрийн шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүдийг чадавхжуулахад анхаарахын зэрэгцээ УИХ-ын болон орон нутгийн сонгуульд нэр дэвшүүлэх, суудал хадгалах, намын бүтэц зохион байгуулалтын бүхий л шатанд эмэгтэйчүүдийг дэмжих квот тогтоох, сонгуулийн санхүүжилт болон тогтолцоог жендэрийн хувьд тэгш шударга болгохыг чиглэсэн үйл ажиллагаанд харгалзан үзэх хэрэгцээ үүсэж байна. (*“Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт бас сорилт, сургамж”, ХНХЯ, ЖҮХ, АХБ, УБ хот., 2019 он, 53 дахь тал*)

**Улс төрийн намын бодлогын дэмжлэг.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна” гэж хуульчилсан.

Сонгуульд нэр дэвшихийн тулд эмэгтэйчүүд янз бүрийн бэрхшээлтэй тулгардаг ба түүний дотор эдийн засгийн хүртээмж хязгаарлагдмал, санхүүгийн боломжгүй байдал гол бэрхшээлийн нэг болж байна. Эмэгтэй улс төрчдийн хувьд сонгуулийн сурталчилгаандаа зориулан мөнгө, хөрөнгө босгох нь эрэгтэйчүүдийг бодвол илүү төвөгтэй байдаг. Олон улсад улс төрийн намын тухай хуульд жендэрийн санхүүжилт буюу эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд зорилтот санхүүжилтийг өгөх нь зүйтэй гэсэн санал, зөвлөмжийг өгчээ.

Улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдэд тусгайлан чиглэсэн санхүүжилт байдаггүй. Эмэгтэйчүүдийн хувьд санхүүгийн боломж бололцоо тааруу, ар гэртээ үүрэх ачаалал ихтэйн улмаас эдийн засгийн боломж хязгаарлагдмал байдаг, сонгуульд нэр дэвших санхүүгийн боломж хомс талаар судалгаанд оролцогчид ярилцлагадаа дурдсан.

Аливаа сонгуульд нэр дэвшихэд гол асуудлын нэг нь санхүүгийн хувьд бэрхшээлгүй, хүрэлцээтэй байх явдал юм. Улс төрийн намын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас үзэхэд, бүх шатны улс төрийн сонгуульд нэр дэвшихэд эмэгтэйчүүдэд шаардлагатай санхүүжилт байхгүй болох нь нотлогдож байна. (*ХЭҮК, Социологийн боловсрол төв, Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтийг үнэлэх судалгааны тайлан, УБ, 2022 он.*)



Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын ээлжит аравдугаар илтгэлийг хэлэлцсэн дүгнэлтэд улс төрийн намуудын сонгуулийн жагсаалтад эмэгтэй нэр дэвшигчдийг 30-аас доошгүй хувиар оролцуулахаар квот тогтоох, сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, эмэгтэй нэр дэвшигчдэд сургалт явуулдаг улс төрийн намуудад санхүүгийн урамшуулал, хөнгөлөлт олгох, эмэгтэй нэр дэвшигчдэд ихээхэн саад учруулж буй “нэр дэвшигчийн татвар, татаас”-ыг хасах зэрэг асуудлыг хуульд тусгах, сонгуулийн тухай холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах”-ыг Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах хорооноос Монгол Улсад зөвлөжээ. *(Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал, МУХЭҮК, KOICA, UNDP, 2023, 20 дахь тал)*

Эмэгтэйчүүд бүх шатны сонгуульд нэр дэвшихгүй байхад нөлөөлсөн хүчин зүйлсийг дараах 4 түвшинд авч үзсэн байна.

**Эмэгтэйчүүд сонгуульд нэр дэвшихгүй байхад нөлөөлсөн хүчин зүйлс**

Нөлөөлж буй хүчин зүйлс	Аль нэг намын гишүүн	Бие даан нэр дэвшигч буюу намын харьяалалгүй
Хувь хүний түвшинд	Сонгуульд зарцуулах төсөв мөнгө байхгүй; Өөрийн хүслээр нэр дэвшээгүй; Нас залуу байх, эсвэл ахих тусам дэмжлэг авах боломжгүй.	Сонгуульд зарцуулах төсөв мөнгө байхгүй; Эрүүл мэндийн нөхцөл байдал.
Гэр бүлийн түвшинд	Гэр бүлийн гишүүд дэмждэггүй, ялангуяа нөхөр, хамтран амьдрагч эсэргүүцэх; Гэр бүлийн зүгээс санхүүгийн дэмжлэг байхгүй; Гэр бүлээрээ өөр газар шилжин суурьших; Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд нөхцөл байдал нөлөөлөх.	Гэр бүлийн гишүүдийн эсэргүүцэлтэй тулгарах; Гэр бүлийн зүгээс санхүүгийн дэмжлэг байхгүй.

<p>Орон нутгийн түвшинд</p>	<p>Иргэдийн дэмжлэг сул, хардалт их байх; Иргэд мөнгөний төлөөх сонголт хийх; Иргэдийн сонгуулийн боловсрол доогуур байх; Иргэд, олон нийтийн зүгээс гүтгэлэг, дайралтад өртөх; Улс төрөөс хэт хараат байснаар ажлын байраа алдах эрсдэлийг бий болгох; Намын удирдлагуудтай үзэл бодол зөрчилдөх, нэр төрд халдах, дарамт үзүүлэх; Ажлын ачаалал ихтэй байх; Намын дотооддоо зөрчилтэй байх; Намд олон жил ажилласан хүнд шагнал болгож албан тушаал олгох; Залуучуудыг дэмждэггүй; Нэг намын гишүүд бие биеэ дэмждэггүй, өрсөлдөгчийн байр сууринаас нэр хүндийг унагаах, гэр бүлд нь сэтгэл санааны дарамтад оруулах маркетинг хийх; Сөрөг хүчинд ялах магадлалтай тойрогт гол төлөв эрэгтэй нэр дэвшигчдийг хуваарилах.</p>	<p>Иргэдийн мөнгөний төлөөх сонголт, шударга бус байдлыг хөхиүлэн дэмжих хандлага түгээмэл; Иргэдийн дэмжлэг сул, гүтгэн доромжлох нь их; Ажлын ачаалал ихтэй байх</p>
<p>Тогтолцоо, намын түвшинд</p>	<p>Намын эрэгтэй гишүүдийн дэмжлэг сул; Намын удирдлагын жендэрийн талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй; Намын зүгээс санхүүгийн дэмжлэг байхгүй; Намын дотоод зохион байгуулалт муу, нэр хүнд нь унах (нам доторх фракцуудын бодлого, үйл ажиллагаа, зөрчилдөөн газар авах).</p>	

Улс төрийн намын түвшинд эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлж байгаа боловч сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо цөөн байгаа нь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт тааруу, нэр дэвшүүлэлт нь квотыг хадгалах хэлбэрээр нэр төдий хэрэгждэг, улс төрийн дэмжлэг хангалтгүй, албан тушаалын томилгоо хийхдээ эрэгтэй, эмэгтэй хүний тэгш байдлыг хангаж чадахгүй байгаа нь ажиглагдаж байна.

Эмэгтэйчүүд улс төрд олон жил байх тусам олон нийтийн зүгээс нэр хүндэд нь халдах, хэл амаар доромжлох асуудал тулгардаг байна. Уг асуудал тухайн эмэгтэй намын гишүүн эсвэл намын харьяалалгүй байгаагаас үл хамааран гарч байгаа нь жендэрийн хэвшмэл үзэл олон нийтийн дунд өнөөг хэр нь бат бөх оршин буйг харуулж байна. Тухайлбал: 2020 онд нийтлэгдсэн “Цахим ташаа мэдээлэл нь жендэрийн талаарх үзэн ядалтыг өдөөх нь” судалгааны тайланд дурдсанаар, эмэгтэй улстөрчдийн талаар жендэрийн хэвшмэл ойлголт бүхий мэдээ, нийтлэл тэдний эсрэг хүчирхийллийн шинжтэй, олон нийтэд хандан үзэн ядалт төрүүлэх, улс



төрд ажиллуулахгүй байх, эмэгтэйчүүдийг сонгохгүй байхыг уриалсан, эмэгтэй хүн улстөрч байгаад ямар ч өөрчлөлт авчрахгүй, хэрэггүй амьтан гэх мэтээр өдөөн турхирчээ.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгарч буй цахим хориг саад цахим орчинд байгаа жендэрийн хэвшмэл ойлголт, мэдээлэл нь эмэгтэй улстөрч болон улс төрд дөнгөж хөл тавьж буй залуу эмэгтэйчүүдийг улс төрийн амьдралаас холдуулах, улс төрд оруулахгүй байх, тэднийг зүй бусаар доромжлох, нэр төрд нь халдах, тэдний дуу хоолойг чухал биш гэж олон нийтэд итгүүлэх зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулж байна. Улс төрийн хүрээн дэх жендэрийн ялгаварлан гадуурхалтад улстөрч, улс төрийн албан тушаалд ажилладаг болон нэр дэвшиж буй эмэгтэйчүүд илүү өртдөг төдийгүй цахим орчинд эмэгтэйчүүдийг хүйсээр нь ялгаварлах, нэр төрд нь халдах, доромжлох хандлага түгээмэл байна.

Дээрх судалгаанд оролцсон эрэгтэйчүүд эрэгтэй хүнийг шийдвэр гаргах түвшинд дэмжих хандлага 58.9 хувь, эмэгтэйчүүд эмэгтэй хүнийг дэмжих хандлага 28.5 хувьтай илэрснээс эрэгтэй хүн эрэгтэйгээ дэмжих хандлага эмэгтэйчүүдтэй харьцуулахад даруй 30 гаруй хувиар илүү байгааг харж байна. Харин эмэгтэйчүүдийн 48.3 хувь нь аль аль хүйсийн хүнийг дэмжиж байгаа бөгөөд эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжих хандлага эрэгтэйчүүд эмэгтэй хүнийг дэмжсэнээс 17 хувиар илүү байна. Энэ нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэхгүй байгааг “эмэгтэйчүүд нэгнээ дэмждэггүй” гэж чанарын судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн өгсөн мэдээллийг үгүйсгэж байна. *(Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал, МУХЭҮК, KOICA, UNDP, 2023, 50-55 дахь тал)*

*1.2. Төлөөллийн өнөөгийн түвшин (парламентын гишүүдийн хувьд; тойргийн хувьд; үндэсний болон олон улсын зорилтуудын дагуу) хангалттай байна уу?*

*Эмэгтэйчүүдийн тодорхой тооны төлөөллийг хангахын тулд ямар механизмууд байдаг, эсхүл байж болох вэ?*

Монгол Улс 1992 оноос хойш УИХ-ын сонгуулийг 8 удаа хийсэн. Үүнээс 1992, 2008, 2020 онд УИХ-ыг “олон мандаттай” олонхын тогтолцоогоор, 1996, 2000, 2004, 2016 онд “нэг мандаттай” тойрог бүхий олонхын тогтолцоогоор, 2012 онд УИХ-ын 48 суудлыг олон мандаттай олонхын тогтолцоогоор, 28 суудлыг хувь тэнцүүлсэн тогтолцоогоор хослуулж (холимог тогтолцоо) сонгосон. Ерөнхийд нь дүгнэхэд бид өнгөрсөн 30 жилийн хугацаанд УИХ-ын сонгуульд сонгуулийн олонхын тогтолцооны хувилбаруудыг ашиглаж ирсэн байна. *(МУҮХ-д оруулах өөрчлөлтийн төслийн танилцуулга, мэдээлэл, лавлагаа, УИХТГ, 2023, 21 дэх тал)*

УИХ-ын гишүүдийн төлөөлөх чадамжийг нэмэгдүүлэх, ялангуяа шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын болон үндэсний түвшинд дараах тодорхой зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд:

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго-2030-ийн зорилт 5.5-д заасан улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд бүх шатны төлөөллийн байгууллагууд буюу парламент болон нутгийн удирдлагын байгууллага, тэдгээрийн удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлж байна.

Олон Улсын Парламентын Холбоо (ОУПХ)-оос жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгын хүрээнд дараах 3 зорилтыг дэвшүүлж байгаа бөгөөд УИХ тус байгууллагын гишүүний хувьд энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллах ёстой. Үүнд: парламент дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх, парламент дахь эмэгтэйчүүдийг дэмжих, парламентыг эмэгтэйчүүдийн эрхийг хангадаг жендэрийн мэдрэмжтэй байгууллага болгох<sup>106</sup>.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд, ЖЭТБХТХ-д заасан квотын шууд механизмыг баримталж байна. 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, УИХ-ын сонгуулийн тухай хууль болон Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн баталснаар Улсын Их Хурал болон улс төрийн нам, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын удирдах албан тушаалд ажиллах аль нэг хүйсийн төлөөллийн квотыг 30% болгож нэмэгдүүлсэн бөгөөд 2028 оны УИХ-ын сонгуулийн жилд 40% болгож нэмэгдүүлэхээр эрх зүйн орчныг бүрдүүлсэн. 2020 оны УИХ-ын сонгуулийн дүнгээр байгуулагдсан 8 дахь удаагийн УИХ-ын төлөөллийн байдлыг тойргийн төлөөллөөр нь авч үзвэл, нийт 21 аймгийн 20 тойргоос 52 УИХ-ын гишүүн сонгогдсоноос эрэгтэй 47, эмэгтэй 5 гишүүн байна. Харин Улаанбаатар хотын 9 тойргоос нийт 24 УИХ-ын гишүүн сонгогдсоноос эрэгтэй 16, эмэгтэй 8 гишүүн байна. Одоогийн байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлж буй УИХ-ын гишүүдийн тоо 73, үүнээс эмэгтэй гишүүдийн тоо 13 буюу 17.8%-тай байна. *(Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт-1-ээс үзнэ үү.)*

Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоог авч үзвэл, саналын эрхтэй нийт 2.003.969 сонгогчоос орон нутгийн сонгогчдын тоо 1.010.031, Улаанбаатар хотын сонгогчдын тоо 993.938 байна.

<sup>106</sup> <https://www.ipu.org/impact/gender-equality>

**1.3. “Суудал хадгалах”-ын зарчмаар сонгогдсон эсвэл томилогдсон эмэгтэйчүүдийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгогдсон эрэгтэйчүүдтэй адил хүлээн зөвшөөрдөг үү?**

Улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих квотын механизмыг дараах байдлаар ангилдаг.

1. Хуулиар нэр дэвшигчийг дэмжих квот (Legal quota)
2. Хууль тогтоох байгууллагад суудал хадгалах квот (Reserved seats quota)
3. Улс төрийн нам доторх квот (Voluntary quota)

*(Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, МУЗГ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021, 319 дахь тал)*

Монгол Улсын ЖЭТБХтХ-ийн 7 дугаар зүйлд төрийн бодлогын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүний нийгэм, гэр бүлийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгах зорилгоор улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангахад чиглэсэн суудал хадгалах зэргээр квотын хэлбэрүүдийг хэрэгжүүлж болохоор заасан. Уг хуулиар сонгогдох, томилогдох улс төрийн албан тушаал, төрийн захиргааны удирдах албан тушаал, төрийн тусгай албан тушаал, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд квотын механизмыг ашиглахаар хуульчилсан. *(ЖЭТБХтХ-ийн 10 дугаар зүйл)*

УИХ-ын болон орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүд хуульд заасан квотыг баримтлан нэр дэвших, сонгогдох боломжтой байдаг бөгөөд сонгогдсон гишүүд эрэгтэй, эмэгтэй хүйсийн ялгаваргүйгээр тэгш эрхтэй. Мөн түүнчлэн улс төрийн намын удирдах албан тушаалд томилогдох эмэгтэйчүүдэд хүйсийн квот тогтоосон хуулийн зохицуулалттай.

УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулиудад жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтыг нам эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар заасан. Харин Улс төрийн намын тухай хуульд жендэрийн харилцааг “хүйсээр ялгаварлахгүй” (5.1.3), намын дүрэмд тусгах (11.2.8) зэрэг ерөнхий утгатай заалтуудаар хуульчилсан байх бөгөөд улс төрийн намуудын дүрэмд заасан эмэгтэйчүүдийн хүйсийн квот 20-30 хувь байна.

**Улс төрийн намуудын дүрэмд хүйсийн квотыг тусгасан байдал**

Намын нэр	Хүйсийн квот тусгасан заалт
МАН	1.5.8.намын бүх шатны сонгуульд байгууллагад 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. Санал хураалтыг энэ шаардлагад нийцүүлэн зохион байгуулна.
АН	5.10.11.3.Тухайн шатны ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг батлах; Нийт нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна. 5.9.5. Намын анхан шатны байгууллагын тэргүүлэгчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна. 6.4.1.ҮБХ-ны гишүүний суудлын тоо 410 байна. Үүнээс 90-ээс доошгүй суудал нь эмэгтэй гишүүдэд ногдоно.
ХҮН	4-р бүлэг.Намын их хурлын төлөөлөгчдийг сонгоходоо 30-аас доошгүй хувь нь эмэгтэй гишүүн байх зарчмыг баримтална.
ИЗНН	20.4.Үндэсний хорооны нийт гишүүдийн 30-аас доошгүй хувийг эмэгтэйчүүдийн төлөөлөл /суудал хадгалах квот/ бүрдүүлнэ. Энэ заалт Улс төрийн зөвлөлийг сонгож бүрдүүлэхэд нэг адил хамаарна.
МҮАН	9.2.10.Сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгоходоо хүйсийн тэгш байдлыг хангах зарчмыг баримтална.

*Эх сурвалж: “Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага” судалгааны тайлан, Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан ТББ. 2022 он*

Эмэгтэйчүүдийн квотыг хуульчилсны үр дүнг квотгүй явагдсан сонгуулиудын үр дүнтэй харьцуулан судалсан судалгааны дүнгээс үзэхэд, 2012 онд холимог тогтолцоогоор явуулсан УИХ-ын сонгуульд тойрогт нэр дэвшүүлсэн 354 хүний 84 нь буюу 23.7 хувь нь эмэгтэй байна. Харин жагсаалтаар нэр дэвшүүлсэн 190 хүний 90 нь буюу 46.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Тухайн онд УИХ-д сонгогдсон 11 эмэгтэйгээс 6 нь мажоритар тойргоос, 5 нь намын жагсаалтаас сонгогдсон байна. *(Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага, судалгааны тайлан, LOES. KOICA, UNDP, 2022, 15 дахь тал)*

**1.4 Удирдах албан тушаалын хэдэн хувийг эмэгтэйчүүд эзэлдэг вэ?**

Улс төрийн намын гишүүдийн 50 гаруй хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг хэр нь шийдвэр гаргах түвшин буюу УИХ, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ), улс төрийн намын удирдлагад тэдний төлөөлөл хангалтгүй байна. УИХ-ын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байхаар заасан. Мөн ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлд томилогдох улс төрийн албан тушаалтны квотыг тогтоож өгсөн байна. Үүнд:

**Хуульд заасан төрийн улс төрийн албан тушаалд сонгогдох болон томилогдох квотыг зохицуулсан байдал**

	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.1	МУИХ-ын сонгуулийн тухай хууль 30.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль 29.2
<b>УИХ</b>	-	20 хувиас доошгүй	
<b>Засгийн газар, аймаг, нийслэлд</b>	15 хувиас доошгүй	-	20 хувиас доошгүй
<b>Дүүрэгт</b>	20 хувиас доошгүй	-	20 хувиас доошгүй
<b>Суманд</b>	25 хувиас доошгүй	-	20 хувиас доошгүй
<b>Хороонд</b>	30 хувиас доошгүй	-	20 хувиас доошгүй

Дээрх хүснэгтэд тусгагдсан сонгогдох болон томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны томилгоог 2022 оны байдлаар авч үзвэл,

Албан тушаалын нэр	Нийт тоо	Эмэгтэйчүүдийн тоо	Хувь	Хуульд заасан квот	Хэрэгжилт
УИХ-ын гишүүд	76	13	17.1%	20%	Биелээгүй
Сайд	16	3	18.7%	15%	Биелсэн
Дэд сайд	16	2	12.5%	15%	Биелээгүй
Аймаг, нийслэлийн Засаг дарга	22	1	4.5%	15%	Биелээгүй
Аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч	22	2	9%	15%	Биелээгүй
Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга	22	2	9%	15%	Биелээгүй
Дүүргийн ИТХ-ын дарга	9	3	33.3%	20%	Биелсэн
Дүүргийн Засаг дарга	9	1	11.1%	20%	Биелээгүй
Дүүргийн Засаг даргын орлогч	9	3	33.3%	20%	Биелсэн

*Эх сурвалж: Улс төрийн хүрэн дэх жендэрийн эрх тэгш байдал, 27 дахь тал*

Харин **Төрийн албаны хувьд**, ЖЭТБХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.4.в-д Төрийн албаны зөвлөл нь төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх тайланг 2 жил тутам УИХ-аар хэлэлцүүлэх, дүгнэлт гаргуулахаар заасан. Гэвч өнөөгийн байдлаар Төрийн албаны зөвлөлөөс энэхүү тайланг УИХ-д ирүүлээгүй, хэлэлцүүлээгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар нийт 225.205 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 145.554 буюу 64.6 хувийг эмэгтэй албан хаагч, 79.651 буюу 35.4 хувь нь эрэгтэй албан хаагчид эзэлж байна. Үүнийг ангилан авч үзвэл:

Албан хаагч	Тоо
Төрийн улс төрийн албан хаагч	3.759 буюу 1.7%
Төрийн захиргааны албан хаагч	22.023 буюу 9.8%
Төрийн тусгай албан хаагч	47.158 буюу 20.9%
Төрийн үйлчилгээний албан хаагч	152.265 буюу 67.6%

Төрийн албан хаагчдыг албан тушаалын төрлөөр нь авч үзвэл,

Албан хаагч	Тоо	Хүйс
Удирдах ажилтан	16.847	Эмэгтэй 7.275 буюу 43% Эрэгтэй 9.572 буюу 57%
Гүйцэтгэх ажилтан	149.450	Эмэгтэй 106.107 буюу 71% Эрэгтэй 43.343 буюу 29%
Туслах ажилтан	58.908	Эмэгтэй 32.172 буюу 55% Эрэгтэй 26.736 буюу 45% байна

*Эмэгтэйчүүд парламентад ямар удирдах албан тушаал хашдаг вэ?  
Удирдах албан тушаалыг хэрхэн хуваарилдаг вэ?*

Монгол Улс 1992 онд анхны ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталж, УИХ-ын анхны сонгуулийг 1992 онд зохион байгуулснаас хойш 8 удаагийн УИХ-ын сонгууль болсон. Эдгээр 8 удаагийн сонгуульд нийт 570 эмэгтэй нэр дэвшиж, давхардсан тоогоор 65 эмэгтэй сонгогджээ. Манай улсын хувьд, нийт сонгогчдын 51 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг боловч УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 17.3 хувь буюу дэлхийн дунджаас 7.6 хувиар бага байгаа юм.

**УИХ-ын удирдах албан тушаалд эмэгтэй гишүүдийг ажиллуулсан байдал**

	1992-1996		1996-2000		2000-2004		2004-2008		2008-2012		2012-2016		2016-2020		2020-2024	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
УИХ-ын дарга	1	-	1	-	2	-	3	-	1	-	1	-	2	-	1	-
УИХ-ын дэд дарга	1	-	2	-	1	-	3	1	2	-	5	-	3	-	3	1
Байнгын хорооны дарга	16	1	7	1	7	1	19	2	21	2	21	3	21	4	27	4
УИХ дахь намын бүлгийн дарга							1									

1992 оноос хойш УИХ-ын даргаар нийт 12 хүн ажилласнаас УИХ-ын даргаар нэг ч эмэгтэй сонгогдоогүй байна. Энэ хугацаанд УИХ-ын дэд даргаар хоёр эмэгтэй УИХ-ын гишүүн С.Оюун (2004-2005), УИХ-ын гишүүн С.Одонтуяа (2020-) нар сонгогдон ажиллажээ. УИХ дахь нам, эвслийн бүлгийн даргаар 2004-2005 онд УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга С.Оюун УИХ дахь “Эх орон-Ардчилал” эвслийн бүлгийн даргаар ажиллаж байжээ.

Байнгын хорооны даргаар нийт 139 хүн ажилласнаас 18 эмэгтэй байнгын хорооны даргаар сонгогдон ажиллажээ.

**2012-2024 оны бүрэн эрхийн хугацаанд БХ-ны даргаар ажилласан УИХ-ын эмэгтэй гишүүд**

Байнгын хороод	2012-2016	2016-2020	2020-2024
БОХХААБХ	Л.Эрдэнэчимэг (2015-2016)	Ц.Гарамжав (2016-2017)	Б.Саранчимэг (2022-)
НББХ	З.Баянсэлэнгэ (2012-2013)		М.Оюунчимэг (2020-2022) П.Анужин (2022-)
НББСШУБХ		Д.Оюунхорол (2019-2020)	
ӨБХ	Р.Бурмаа (2012-2015)	Д.Сарангэрэл (2016-2017) М.Оюунчимэг (2017-2020)	
БСШУСБХ			Г.Мөнхцэцэг (2022-)

*1.5.Эмэгтэйчүүдийг парламентад удирдах албан тушаалд томилох боломжийг баталгаажуулах арга хэмжээ бий юу? Хэрэв тийм бол ямар арга хэмжээ байдаг вэ? Хэрэвээ үгүй бол байх ёстой юу?*



УИХ-ын удирдах албан тушаалд УИХ-ын эмэгтэй гишүүн томилох тусгайлсан зохицуулалт байхгүй байна. УИХ-ын бүтцийн схемээс үзэхэд, УИХ-ын удирдах албан тушаал гэдэгт УИХ-ын дарга, УИХ-ын дэд дарга, УИХ дахь нам, эвслийн бүлгийн дарга, Байнгын хороодын дарга болон Улсын Их Хурал (УИХ)-ын Ерөнхий нарийн бичгийн дарга (ЕНБД) хамаарч байна. Түүнчлэн тусгайлсан асуудлаар байгуулагддаг Дэд, Түр хороо, Хяналтын түр хороодын дарга нарыг УИХ-ын удирдах албан тушаалд хамруулан авч үзэх боломжтой. (2020 оны УИХ-ын бүтцийн схемийг хэвсэргэв)

2020-2024 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд Байнгын хороодын даргаар давхардсан тоогоор нийт 4 эмэгтэй гишүүн ажилласан ба одоогийн байдлаар 3 эмэгтэй гишүүн Байнгын хорооны дарга (БОХХААБХ-ны даргаар Б.Саранчимэг, НББХ-ны даргаар П.Анужин, БСШУБХ-ны даргаар Г.Мөнхцэцэг)-аар ажиллаж байна. Түүнчлэн Хүний эрхийн дэд хорооны даргаар УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг ажиллаж байна.



Эх сурвалж: Parliament.mn



## УИХ-ын удирдах албан тушаалтныг томилох процедур

**УИХ-ын дарга:** УИХ-ын тухай хуульд зааснаар сонгуулийн дүнгээр УИХ-д олонх болсон нам, эвсэл УИХ-ын даргад нэр дэвшүүлнэ. Аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн, ийнхүү зөвшилцөж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн Үндсэн хуульд заасны дагуу олонхыг бүрдүүлж, нам, эвсэл зөвшилцөн УИХ-ын даргад нэр дэвшүүлэн, УИХ-ын даргыг хэлэлцүүлэггүйгээр томилох бөгөөд гишүүн саналаа илээр гаргаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжсэн бол УИХ-ын даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно. (УИХ-ын тухай хуулийн 12 дугаар зүйл) 1992 оноос хойш Улсын Их Хурлын даргаар нийт 12 хүн ажилласнаас УИХ-ын даргаар нэг ч эмэгтэй сонгогдоогүй байна.

**УИХ-ын дэд дарга:** УИХ-ын дэд даргыг Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, илээр санал хурааж сонгоно. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно. (УИХ-ын тухай хуулийн 15 дугаар зүйл)

УИХ-ын дэд даргаар УИХ-ын гишүүн С.Оюун (2004-2005), УИХ-ын гишүүн С.Одонтуяа (2020-) нар сонгогдон ажиллажээ.

**Байнгын хорооны дарга:** УИХ-ын Байнгын хороо 19 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүн нэгэн зэрэг гурваас илүүгүй Байнгын хороонд харьяалагдан ажиллаж болно. Байнгын хороог Улсын Их Хурлаас нэг жилийн хугацаагаар сонгосон дарга тэргүүлнэ. Байнгын хорооны даргыг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно. (УИХ-ын тухай хуулийн 26 дугаар зүйл)

**УИХ дахь нам, эвслийн бүлгийн дарга:** Бүлгийн даргыг чөлөөлөх, огцруулах, шинээр томилох асуудлыг бүлгийн нийт гишүүдийн олонхын саналаар шийдэж, шийдвэрээ Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлнэ. Улсын Их Хурлын дарга уг шийдвэрийг нэгдсэн хуралдаанд уншиж сонсоно. (УИХ-ын тухай хуулийн 31.12 дугаар зүйл)

**УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга:** 2020 онд УИХ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хуулиар УИХ-ын Тамгын газрын дарга нь УИХ-ын ЕНБД бөгөөд Улсын Их Хурлын дэгийн зөвлөх байхаар хуульчилсан. УИХТГ-ын дарга нь УИХ-ын удирдах албан тушаалтан байхаас гадна төрийн захиргааны албан тушаалтанд тооцогддоогоороо онцлогтой. ЕНБД-ыг УИХ-ын даргын санал болгосноор

чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн томилно. (УИХ-ын тухай хуулийн 14.1.19 дүгээр зүйл)

УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар нийт 11 хүн ажилласнаас 2019 онд анх удаа эмэгтэй ЕНБД (Л.Өлзийсайхан) томилогдон ажиллаж байна.

**Хороо тус бүрийг эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран даргалж болох уу?**

УИХ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар Байнгын хороо (БХ) нь 19 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд УИХ-аас нэг жилийн хугацаагаар сонгосон дарга тэргүүлнэ. БХ-ны даргыг УИХ-д сонгогдон ажилласан туршлагыг нь харгалзан тухайн БХ-ны гишүүдээс сонгохоор заасан. БХ нь нэг даргатай бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран даргалах зохицуулалт байхгүй.

1992 оноос хойш БХ-ны даргаар нийт 139 хүн ажилласнаас 18 эмэгтэй гишүүн сонгогдон ажиллажээ.

**1992 оноос хойш БХ-ны даргаар ажилласан эмэгтэй гишүүд, БХ-ны нэр**

Бүрэн эрхийн хугацаа	БХ-дын дарга		Байнгын хорооны нэр	БХ-ны даргаар ажилласан эмэгтэй гишүүний нэр
	нийт	эм		
1992-1996	16	1	Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хангамжийн байнгын хороо	Д.Мөнхөө
1996-2000	7	1	Нийгмийн бодлогын байнгын хороо	Х.Хулан
2000-2004	7	1	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Т.Ганди
2004-2008	19	2	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	Б.Мөнхтуяа
			Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Т.Ганди
2008-2012	21	2	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Д.Оюунхорол Д.Арвин
2012-2016	21	3	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Л.Эрдэнэчимэг
			Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	З.Баянсэлэнгэ
			Өргөдлийн байнгын хороо	Р.Бурмаа
2016-2020	21	4	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Ц.Гарамжав
			Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Д.Оюунхорол
			Өргөдлийн байнгын хороо	Д.Сарангэрэл М.Оюунчимэг
2020-2024	27	4	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Б.Саранчимэг
			Нийгмийн бодлогын байнгын хороо	М.Оюунчимэг П.Анужин
			Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо	Г.Мөнхцэцэг

### 1.6 Бүх хороонд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн төлөөлөл байгаа юу?

Байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлахдаа УИХ дахь олонх, цөөнхийн харьцаа болон нам, эвслийн УИХ-д авсан суудлын хувийг харгалздаг. УИХ-ын сүүлийн 3 бүрэн эрхийн хугацаанд БХ-д харьяалагдсан байдлыг авч үзье. (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2-оос үзнэ үү)

#### **Эмэгтэй гишүүдийн Байнгын хороонд харьяалагдсан байдал**

2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын 8 байнгын хороо ажилласан бөгөөд нэг УИХ-ын гишүүн 3 хүртэл байнгын хороонд орж ажиллах эрхтэй байсан. Үүнээс НББХ-нд хамгийн олон эмэгтэй гишүүн буюу 6, БОХХААБХ болон ӨБХ-нд тус бүр 5, ХЗБХ-нд 3 эмэгтэй гишүүн харьяалагдан ажилласан байна. Харин АБГББХ, ТББХ, ТБХ, ЭЗБХ-ны тус бүрд 2 эмэгтэй гишүүн харьяалагджээ.

2016-2020 оны бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын 8 байнгын хороо ажилласан бөгөөд нэг УИХ-ын гишүүн 3 хүртэл байнгын хороонд орж ажиллах эрхтэй байсан. Үүнээс НББСШУБХ-нд хамгийн олон эмэгтэй гишүүн буюу 9, ЭЗБХ болон ӨБХ-нд тус бүр 4, АБГББХ, БОХХААБХ болон ТБХ-нд тус бүр 3 эмэгтэй гишүүн харьяалагдан ажилласан байна. Харин ТББХ (1), ХЗБХ (2)-д хамгийн цөөхөн эмэгтэй гишүүн харьяалагджээ.

2020-2024 оны бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын 11 байнгын хороо ажиллаж байгаа бөгөөд нэг УИХ-ын гишүүн 3 хүртэл байнгын хороонд орж ажиллах эрхтэй. Үүнээс НББХ-нд хамгийн олон эмэгтэй гишүүн буюу 8, БСШУСБХ-нд 6, ТББХ-нд 4, БОХХААБХ, ЭЗБХ болон ТБХ-нд тус бүр 3 эмэгтэй гишүүн харьяалагдан ажиллаж байна. Харин ЁЗСХБХ, ҮББХ болон ХЗБХ-нд хамгийн цөөхөн буюу тус бүр 1 эмэгтэй гишүүн харьяалагджээ. Байнгын хороодын гишүүдийн нэрсийг 2023.10.23-ны өдрийн байдлаар хавсралт 2-оос үзнэ үү.

**БХ-ын нийт гишүүдийн тоо, үүнээс эмэгтэй гишүүдийн тоо  
(сүүлийн 3 бүрэн эрхийн хугацаагаар)**

БХ-ны нэр	2012-2016		2016-2020		2020-2024	
	БХ-ны нийт гишүүний тоо	БХ-ны эмэгтэй гишүүний тоо	БХ-ны нийт гишүүний тоо	БХ-ны эмэгтэй гишүүний тоо	БХ-ны нийт гишүүний тоо	БХ-ны эмэгтэй гишүүний тоо
АБГБХ	19	2	19	3	19	2
БОХХААБХ	19	5	19	3	19	3
НББХ	21	6	19	9	17	8
ӨБХ	15	5	16	4	-	-
ХЗБХ	21	3	19	2	19	1
ТББХ	19	2	19	1	19	4
ТБХ	19	2	19	3	19	3
ЭЗБХ	19	2	19	4	19	3
БСШУСБХ					16	6
ЁЗСХБХ					10	1
ИЦББХ					11	2
ҮББХ					17	1

**Ямар хороодод эмэгтэйчүүдийн төлөөлөл түлхүү байдаг вэ?**

2012 оноос хойших гурван бүрэн эрхийн хугацаанд Нийгмийн бодлогын болон Боловсролын байнгын хороонд хамгийн олон эмэгтэй гишүүн буюу нийт 23 эмэгтэй гишүүн харьяалагдсанаас 18 эмэгтэй БХ-ны даргаар ажилласны 8 нь нийгмийн бодлого болон боловсролын асуудал хариуцсан БХ-ны даргаар ажилласан байна.

2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын 8 байнгын хороо ажилласан бөгөөд НББХ-нд 6 эмэгтэй гишүүн, 2016-2020 оны бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын 8 байнгын хороо ажилласан бөгөөд НББСШУБХ-нд 9 эмэгтэй гишүүн, 2020-2024 оны бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын 11 байнгын хороо ажиллаж байгаа бөгөөд НББХ-нд 8 эмэгтэй гишүүн, БСШУСБХ-нд 6 эмэгтэй гишүүн харьяалагдаж байна.

**Аль хороонд эмэгтэйчүүдийн төлөөлөл дутуу буюу байхгүй байгаа вэ?**

УИХ-ын эмэгтэй гишүүдийн БХ-д харьяалагдсан байдлыг авч үзвэл, НББХ, БСШУБХ гэх мэт боловсрол, нийгэм, байгаль орчны чиглэлийн байнгын хороодод түлхүү харьяалагдаж байгаа бол төсөв, эдийн засаг, төрийн байгуулалт, аюулгүй байдлын чиглэлийн байнгын хороодод эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн буюу 1-2 төлөөлөлтэй байна. Түүнчлэн УИХ-ын Ёс зүйн байнгын хороонд одоогоор 1 эмэгтэй гишүүний төлөөлөл байна.

2012 оноос хойших гурван бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын гишүүдийн байнгын хороонд харьяалагдсан байдлыг авч үзвэл:

2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд АБГББХ, ТББХ, ТБХ, ЭЗБХ-ны тус бүрд 2 эмэгтэй гишүүн харьяалагджээ.

2016-2020 оны бүрэн эрхийн хугацаанд ТББХ (1), ХЗБХ (2)-д хамгийн цөөхөн эмэгтэй гишүүн харьяалагджээ.

2020-2024 оны бүрэн эрхийн хугацаанд ЁЗСХБХ, ҮББХ болон ХЗБХ-нд хамгийн цөөхөн буюу тус бүр 1 эмэгтэй гишүүн харьяалагджээ.

### Хорооны гишүүнчлэлийг хэрхэн шийддэг вэ?

УИХ-ын ээлжит сонгууль бүрээр байгуулагдсан УИХ-ын анхдугаар чуулганаар байнгын болон дэд хорооны бүрэлдэхүүнийг баталж, байнгын хорооны дарга нарыг сонгодог. Байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлахдаа УИХ дахь олонх, цөөнхийн харьцаа болон нам, эвслийн УИХ-д авсан суудлын хувийг харгалзах бөгөөд УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (МУИХЧХДтХ)-ийн 26 дугаар зүйлд заасан журмыг баримтлан батална. МУИХЧХДтХ-д зааснаар БХ-ны бүрэлдэхүүнийг батлахдаа дараах журмыг баримтална. Үүнд:

- Гишүүн Байнгын хороонд харьяалагдах саналаа нам, эвслийн бүлэгт, бүлэгт харьяалагдаагүй гишүүн саналаа УИХ-ын даргад хүргүүлэх;
- Нам, эвслийн бүлэг Байнгын хорооны тоо, олонх, цөөнхийн харьцаа зэргийг харгалзан гишүүнийг Байнгын хороонд хуваарилах саналаа УИХ-ын даргад хүргүүлэх;
- УИХ-ын дарга ирүүлсэн саналыг нэгтгэн, нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж, БХ-ны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах;
- Нэгдсэн хуралдаан УИХ-ын даргын танилцуулсан саналыг хэлэлцэж, Байнгын хорооны бүрэлдэхүүнийг УИХ-ын тогтоолоор батална.

Хэрэв УИХ-ын гишүүн БХ-ны харьяаллаа өөрчлөх хүсэлт гаргавал дээрх журмын дагуу шийдвэрлэнэ.

### Эмэгтэйчүүдийн эрх ашгийн талаарх хэвшмэл ойлголтыг хорооны гишүүнчлэлээр бэхжүүлж байна уу?

Эмэгтэйчүүдийг УИХ-ын Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүнд тусгайлан оруулах ямар нэгэн зохицуулалт байхгүй.

**1.7. Парламентад ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо, удирдах албан тушаалд байгаа эмэгтэйчүүдийн тоонд хэрхэн хяналт тавьж байна вэ?**

Парламентад ажиллаж буй эмэгтэйчүүд гэдэгт УИХ-ын эмэгтэй гишүүдээс гадна УИХТГ-т ажиллаж буй эмэгтэй ажилтнуудыг хамааруулан ойлгож байна. УИХ-д ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо, үүнээс удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоонд УИХ болон Тамгын газрын зүгээс тухайлан хяналт тавих зохицуулалт байдаггүй.

Гэвч ЖЭТБХТХ, УИХ-ын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хуульд заасан квотын хэрэгжилтэд эрх бүхий байгууллагуудын зүгээс хяналт тавих үүрэгтэй бөгөөд энэхүү харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

ЖЭТБХТХ-д заасны дагуу төрийн улс төрийн болон төрийн захиргааны албан тушаалд ажиллаж буй удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын жендэрийн харьцаа, жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд Төрийн албаны зөвлөл хяналт тавина. УИХ болон улс төрийн намын удирдах албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн тоонд Жендэрийн үндэсний хороо (ЖҮХ) болон Сонгуулийн ерөнхий хороо хяналт тавьж ажилладаг.

УИХТГ-т ажиллаж буй ажилтнуудын хүйсийн тэгш байдалд Төрийн албаны зөвлөл хяналт тавина.

**Эдгээр хяналтын байгууллагуудын хуулиар хүлээсэн хяналтын чиг үүрэг**

Жендэрийн үндэсний хороо	Төрийн албаны зөвлөл	Сонгуулийн ерөнхий хороо	Хүний эрхийн Үндэсний комисс
<p>-эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна.</p> <p>-жендэрийн салбар хороо, зөвлөлийн тайлан, мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт гаргах; жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлын талаарх тайланг бэлтгэж Засгийн газарт оруулна;</p> <p>-ЖҮХ нь Улс төрийн нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх, намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх гэсэн шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.</p>	<p>-төрийн албаны хүйсээр ангилсан статистик мэдээ, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, уг мэдээллээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар бусад сонирхогч этгээдийг хангах;</p> <p>-төрийн албыг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгахад чиглэсэн хэм хэмжээ, стандарт нэвтрүүлэх, тухайн асуудлаар энэ хуулийн 18.4-т заасан салбар, зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;</p> <p>-төрийн албан дахь жендэрийн ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавих;</p> <p>-дээрх 3 заалтын биелэлтэд хяналт тавих.</p> <p>-төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулна.</p>	<p>ЖҮХ-ны жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн зөрчлийг арилгах талаарх шаардлагыг тухайн намд хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дотор уг зөрчлийг арилгаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсооно.</p>	<p>7.1.9. жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.</p>

## **АСУУЛТ 2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО, ТОГТОЛЦОО**

Монгол Улс Үндсэн хуулиараа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх, жендэрийн тэгш байдлыг хангах үзэл санааг баталгаажуулж, бүх шатны сонгогдох болон томилогдох албан тушаалд жендэрийн тэгш байдлыг хангах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжуудад тусгасан. 2011 онд УИХ-аас баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль нь жендэрийн харилцааны асуудлыг тусгайлан зохицуулсан суурь хууль юм. Хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тогтолцоо бүрдэж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах, хяналт тавих механизмууд бий болсон.

УИХ-аас жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд идэвх санаачлагатай ажиллахын зэрэгцээ олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг амлалтууд болон ТХЗ-2030-ийн жендэрийн тэгш байдлыг хангах зорилтуудыг биелүүлэхийн төлөө олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, үндэсний хэмжээнд төдийгүй бүс нутаг, олон улсын хэмжээнд манлайлал үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал, 2023 онд ТХЗ-ийн жендэрийн тэгш байдлын асуудлаар “Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээр-жендэрийн эрх тэгш байдал ба тогтвортой хөгжил” чуулга уулзалт, “Эмэгтэй парламентчдын чуулган-2022”, “Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалт” зэрэг арга хэмжээнүүдийг Монгол Улсад зохион байгуулсан.

Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих, УИХ дахь эмэгтэй гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, жендэрийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх зорилтот арга хэмжээнүүдийг УИХ-ын 2020-2024 оны стратеги төлөвлөгөө, УИХ-ын Тамгын газрын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд УИХ-аас батлан гаргаж байгаа хууль тогтоомжид хүний эрх, жендэрийн дүн шинжилгээ хийх чадавх, тогтолцоог бүрдүүлэх, холбогдох арга, аргачлалыг боловсруулан мөрдөх ажлуудыг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлж байна.

### **ҮНДЭСНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ**

Жендэрийн үндэсний эрх зүйн зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль зэрэг хуульд хүйсийн тэгш байдлыг хангах болон улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг зохицуулжээ.



**2.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний ямар хууль тогтоомжууд байдаг вэ?**

Монгол Улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах, улс төрийн хүрээн дэх жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн 10 гаруй олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, тэдгээрийн зарчим, заалтуудыг үндэсний хууль тогтоомж, бодлого хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлж байна.

**Жендэрийн асуудлыг зохицуулж буй Монгол Улсын хууль тогтоомж**

Хууль тогтоомжийн нэр	Хууль тогтоомжийн зохицуулалт
1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)	<p>14.2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.</p> <p>16.11.Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;</p>
2. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль	<p><b>14 дүгээр зүйл. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх</b></p> <p>1.Хүний эрх, эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна.</p> <p><b>20 дугаар зүйл. Засгийн газрын бүрэлдэхүүн</b></p> <p>4.Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудал хамаарна: -жендэрийн хөгжлийн асуудал;</p>
3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)	<p><b>8 дугаар зүйл. Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгаа</b></p> <p>8.1.Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.</p> <p>8.2.Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.</p> <p>8.3.Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна.</p>

	<p><b>10 дугаар зүйл. Төрийн албан дахь жөндөрийн эрх тэгш байдлын баталгаа</b></p> <p>10.1.Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд дараахь бодлого хэрэгжүүлнэ:</p> <p>10.1.1.томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх;</p> <p>10.1.2.төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх;</p> <p>10.1.3.зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх;</p> <p>10.1.4.төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд 40:60 гэсэн харьцааг хангах бодлого, арга хэмжээг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.</p> <p>10.2.Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс (цаашид “хороо” гэх) зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна.</p> <p>10.3.Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.</p>
<p>4.Төрийн албаны тухай хууль (2017)</p>	<p>31.4.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.</p>
<p>5.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (2020)</p>	<p>12.9.Комиссын гишүүнийг томилохдоо жөндөрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд энэ хуулийн 12.1-д заасан гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.</p>

<p>6.Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)</p>	<p>2024.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. 30.2.Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.</p>
<p>7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (2020)</p>	<p>29.2.Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.</p>
<p>8.Улс төрийн намын тухай хууль (2023)</p>	<p>2024.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. 8.1. Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно. 8.2.3.нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх. 15.2.Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана: 15.2.8.төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журам; 17.7.Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.</p>
<p>9.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)</p>	<p>6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:</p>
<p>10.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол)</p>	<p>4.2.7.Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална. 4.2.8.Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.</p>

<p>11.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031) (2022.10.05-ны өдөр ЖҮХ-ны тогтоолоор баталсан)</p>	<p>Энэхүү стратеги төлөвлөгөө нь нийт 5 үндсэн зорилготой.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зорилго-1. Охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ.</li> <li>• Зорилго-2. Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж, тэгш оролцоог дэмжинэ.</li> <li>• Зорилго-3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлнэ.</li> <li>• Зорилго-4. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ.</li> <li>• Зорилго-5.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангана.</li> </ul>
<p>12. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол</p>	<p><b>Зорилт 2.1.</b> Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. <i>1 үе шат (2021-2030):</i>Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе.</p> <p>2.Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн байна.</p> <p><b>Зорилт 3.3.</b> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. <i>1 үе шат (2021-2030):</i> Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үе.</p>
<p>13. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол)</p>	<p><b>Зорилго 2.</b> Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.</p> <p>Зорилт 2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.</p>

**Монгол Улс олон улсын гэрээ, конвенцоор** хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор 1996 оноос хойш дараах үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (1996)
- Эмэгтэйчүүдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2000)
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008-2021)
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах Дунд хугацааны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө (2013-2016)
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр (2005-2015)
- Хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгт өртөхөөс сэргийлэх Үндэсний хөтөлбөр (2005-2014)
- Эрүүл мэндийн салбарын Мастер төлөвлөгөө (2005-2015)
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн 3 дахь хөтөлбөр (2007-2011)
- Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлого (2004-2015)
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах Үндэсний стратеги (2014-2018)
- Ядуурлыг бууруулж, ажил эрхлэлтийг дэмжих бодлого (2010-2014)
- Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого (2011-2015)
- Нийгмийн халамж, хөдөлмөрийн бодлого (2011-2015).

#### *Тус улсын Үндсэн хууль жендэрийн мэдрэмжтэй байдаг уу?*

1990 оноос өрнөж эхэлсэн нийгмийн шинэчлэлийн хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах талаар илүүтэй анхаарах болсон бөгөөд 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд хүйсийн тэгш байдлыг хангах талаар тусгайлан заасан байдаг. Тухайлбал,

**Үндсэн хуулийн 14-р зүйлд:** Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Мөн Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

**Үндсэн хуулийн 16-р зүйлд:** “Эрэгтэй эмэгтэй хүмүүс нь гэр бүлийн дотор ба соёл, нийгэм, эдийн засгийн болон улс төрийн хувьд ижил тэгш эрхтэй байна.” гэж заажээ.

#### *Сүүлийн 2-5 жилийн хугацаанд парламентаас жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр баталсан хамгийн чухал хуулиуд юу вэ?*

УИХ-аас жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд хүчин чармайлт гарган ажиллаж байна. Тухайлбал, сүүлийн 2 жилд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн дараах чухал хууль тогтоомжуудыг баталсан байна. Үүнд:

**Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө**  
(УИХ-ын 2019 оны 106 дугаар тогтоолоор баталсан)

Энэхүү стратеги төлөвлөгөөний гуравдугаар зорилт:

- Жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих;
- Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх механизмыг бүрдүүлж, жендэрийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх;
- Залуучуудыг улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд оролцуулах оролцоог нэмэгдүүлэх, залуучуудын хөгжлийн бодлогыг тодорхойлж, тэдний улс төр, нийгмийн идэвхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхээр заасан.

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд** 2023 оны 06 дугаар сард өөрчлөлт оруулж, УИХ-ын сонгуульд Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.

**Улс төрийн намын тухай хуульд** намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгох бөгөөд нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх, түүнчлэн намын дүрэмд төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журмыг баримтлахаар зохицуулсан юм. Дээрх олон улсын болон үндэсний хууль тогтоомжоос гадна дэлхий нийтээрээ нэг зорилго болгон хэрэгжүүлэхээр хүчин чармайлт гаргаж буй үүрэг, амлалтууд байна. Тухайлбал,

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 онд баталсан 2030 он хүртэлх Дэлхийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт “Жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн 5 дугаар зорилтыг биелүүлнэ.” гэж;
- Бээжингийн тунхаглалын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Засгийн газар бүр өөрийн бүх бодлого, хөтөлбөрт жендэрийн үзэл баримтлалыг тусгана. Жендэрийн асуудал нь тухайлан нэг салбарын асуудал бус салбар дундын асуудал тул тогтолцоог тасралтгүй бэхжүүлэх.” гэж;

- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцын хорооны 2016 оны 1382 дугаар хуралдааны зөвлөмжийн 13(а)-д конвенцыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааны төвлөрлийг сааруулах зарчмаар явуулахад нь хүний нөөцийн, техникийн болон санхүүгийн хөрөнгө нөөцөөр хангах замаар ЖҮХ-г бэхжүүлэх үүрэг амлалтыг авчээ.

*2.2 Парламентад жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хуулиудыг хэрхэн санаачилж баталдаг вэ? Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулдаг уу? Дээрх үйл ажиллагааг сайжруулах шаардлага бий юу?*

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйл.** Хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаараар УИХ-ын гишүүн нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хууль санаачлах боломжтой бөгөөд хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- УИХ-ын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг зөвхөн УИХ-ын гишүүн санаачилна.
- Ерөнхийлөгч энэ хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3-т зааснаас бусад асуудлаар хууль санаачилна. Ерөнхийлөгч хууль санаачлахдаа Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтална.
- Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна.

*2.3. Засгийн газар, парламентад жендэрийн асуудлыг тусгасан хууль, бодлого бий юу? Хэрэв тийм бол түүний хэрэгжилтэд УИХ-аар хэн, хэрхэн хяналт тавих үүрэгтэй вэ? Хэрэв тийм биш бол ийм хууль, бодлого хэрэгтэй юу?*

**1.УИХ-аас батлан гаргасан төрийн бодлогод жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай асуудлыг тусгасан байдал**

ЖЭТБХтХ-ийг хэрэгжүүлсэн сүүлийн 10 жилийн хугацаанд УИХ-аас 982 тогтоолыг батлан гаргаснаас 70 нь бодлогын баримт бичиг батлах тухай тогтоол байжээ. Бодлогын баримт бичиг гэдэгт төрөөс баримтлах бодлого, үндсэн чиглэл, хөтөлбөр, стратеги зэргийг хамруулан авч



үзсэн. Эдгээр бодлогын баримт бичигт жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай асуудлыг тусгасан эсэхийг тодорхойлоходоо тус хуулийн 5 дугаар зүйлд заасан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлогыг тодорхойлох түлхүүр үгс болох “жендэр”, “тэгш эрх”, “эрх тэгш байдал”, “ялгаварлан гадуурхахгүй байх”, “хүйс”, “эрэгтэй, эмэгтэй” зэрэг үгээр тухайн баримт бичигт хайлт хийж, илэрцүүдээр нь тодорхойлсон. Ийнхүү тодорхойлоход 2011-2020 оны хооронд УИХ-аас батлан гаргасан 70 бодлогын баримт бичгийн 16 баримт бичигт буюу 22.9%-д жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай асуудлыг тусгажээ.

### **УИХ-ын тогтоол, батлан гаргасан бодлогын баримт бичгийн тоо, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг хөндсөн баримт бичгийн тоо**

<b>Он</b>	<b>Тогтоолын тоо</b>	<b>Бодлогын баримт бичиг баталсан тогтоолын тоо</b>	<b>Тэдгээрээс жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай асуудлыг тусгасан баримт бичгийн тоо</b>
2011	67	9	4
2012	131	8	1
2013	75	6	-
2014	88	11	-
2015	119	14	4
2016	132	7	1
2017	86	4	1
2018	89	4	1
2019	106	4	1
2020	89	3	3
<b>Бүгд</b>	<b>982</b>	<b>70</b>	<b>16</b>

*Эх сурвалж: (Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дэлгэрэнгүй тайлан, МУЗГ, ЖҮХ, UNFPA, ММСГ, 2021, 187 дахь тал)*

## **2.Хуульд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай заалтыг тусгасан байдал**

ЖЭТБХТХ-ийг хэрэгжүүлсэн сүүлийн 10 жилийн хугацаанд УИХ-аас 447 хуулийг батлан гаргаснаас 194 нь хууль хүчингүй болсонд тооцох тухай болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд байгааг хасаж тооцвол, 253 хуулийг УИХ-аас батлан гаргажээ. Эдгээр 253 хуулийг жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг агуулж байгаа байдлаар нь дараах байдлаар ангилж авч үзлээ:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шууд чиглэгдсэн: Суурь хууль буюу ЖЭТБХТХ, ЖЭТБХТХ-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2011);



2. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг шууд агуулсан: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016), Сонгуулийн тухай хууль (2015); Төрийн албаны тухай хууль (2017) гэх мэт.

3. Жендэрийн холбогдолтой: Улсын бүртгэлийн ерөнхий хууль (2018), Иргэний улсын бүртгэлийн тухай хууль (2018), Цагдаагийн албаны тухай хууль (2018) гэх мэт.

4. Жендэрийн холбогдолгүй: тодорхой салбарын зохицуулалтын хуулиуд, тухайлбал, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012), Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль (2014), Малын генетик нөөцийн тухай (2017), Хэмжил зүйн тухай хууль (2019) гэх мэт.

Ийнхүү ангилж авч үзэхэд 2011-2020 он хүртэлх хугацаанд батлагдсан 253 хуулийн 140 нь жендэрийн холбогдолгүй буюу тодорхой салбарын зохицуулалтын хуулиуд байжээ. Ийнхүү авч үзэхэд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг шууд агуулсан, жендэрийн холбогдолтой 74 хууль батлагдан гарчээ. Төсвийн тухай хуультай холбоотой 37 хууль батлагдсаныг дараагийн хэсэгт тусад нь авч үзэх болно.

**УИХ-аар батлан гаргасан хуулийн тоо (2011-2020 он)**

Он	Батлан гаргасан хуулийн тоо - бүгд	Хууль хүчингүй болсонд тооцох болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль	Тодорхой салбарын зохицуулалтын хууль	Төсвийн тухай хууль	Үүнээс ЖЭТБХТХ (суурь) хууль болон дагаж мөрдөх журам	Үүнээс жендэрийн үзэл баримтлалыг шууд агуулсан болон жендэрийн холбогдолтой хууль
2011	38	13	10	4	2	9
2012	55	25	12	5	-	13
2013	32	15	10	4	-	3
2014	21	3	12	4	-	2
2015	54	21	22	4	-	7
2016	59	27	20	3	-	9
2017	68	33	18	4	-	13
2018	35	17	7	4	-	7
2019	50	29	12	4	-	5
2020	35	11	17	1	-	6
<b>Бүгд</b>	<b>447</b>	<b>194</b>	<b>140</b>	<b>37</b>	<b>2</b>	<b>74</b>

*Эх сурвалж: (Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дэлгэрэнгүй тайлан, МУЗГ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021, 195 дахь тал)*

**ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

*2.4 Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй болон санал болгож буй хуулиудыг Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц болон жендэрийн тэгш байдлыг хангах олон улсын болон бүс нутгийн бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэгт нийцэж байгаа эсэхийг парламент хэрхэн баталгаажуулдаг вэ?*

**1. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал**

Монгол Улсын Засгийн газраас Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)-ын хэрэгжилтийн талаарх тав, зургаа, долоодугаар илтгэлийг хамтатган 2008 оны 09 дүгээр сард хүргүүлж, хэлэлцүүлсэн илтгэлтэй холбоотой гаргасан Конвенцын хорооноос Монгол Улсын ээлжит 8 ба 9 дүгээр илтгэлийн талаарх ажиглалтын дүгнэлтүүдэд дараах дүгнэлт, зөвлөмжийг өгчээ. Үүнд:

- Конвенцын хороо нь энэхүү Конвенцын заалтуудыг системтэйгээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг Гишүүн оронд уриалж байна. Иймд Конвенцын хороо энэхүү дүгнэлтийг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн албан ёсны хэл дээр Засгийн газар, яамд, УИХ, шүүхийн

байгууллага зэрэг төв, бүс нутгийн болон орон нутгийн бүхий л холбогдох байгууллагуудад түгээхийг Гишүүн оронд зөвлөж байна.

- Конвенцын хороо дараагийн ээлжит 10 дугаар илтгэлээ 2020 оны 03 дугаар сард ирүүлэх хүсэлтийг Гишүүн оронд тавьж байна.

ЖЭТБХТХ-ийг хэрэгжүүлсэн 2011 оноос хойших хугацаанд Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх илтгэлийг нэг удаа буюу 2014 онд гаргажээ. ЖЭТБХТХ-ийн 15.1.4-т Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг УИХ 2 жил тутам хэлэлцэж, дүгнэлт гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан боловч ЖЭТБХТХ-ийн 15.1.4-т заасан УИХ-ын бүрэн эрхийн хэрэгжилт хангалтгүй түвшинд байна гэж үзсэн. *(Монгол Улсын Засгийн газрын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит илтгэлийг хэлэлцсэн дүгнэлт, 2022 он)*

**ЖЭТБХТХ-ийн 5.1.4-т заасан тайлан, илтгэлийг 2 жил тутам хэлэлцэж дүгнэлт гаргаж буй байдал**

Заалт	Тайлан, илтгэл	Хэлэлцсэн байдал	Дүгнэлт гаргасан байдал
5.1.4.а	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайлан	Засгийн газраас тайланг гаргаж хэлэлцүүлж байгаагүй.	-
5.1.4.б	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх Монгол Улсын ХЭҮК-ын илтгэл	Уг агуулгаар нь бус Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн хүрээнд 13 дахь (2014), 16 дахь (2017), 18 дахь (2019), 19 дэх илтгэл (2020)-д тус тус энэ асуудлыг хөндөж УИХ-аар хэлэлцүүлсэн.	УИХ-аас Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019 оны 62 дугаар тогтоолоор ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, ЖҮХ-ны үйл ажиллагааг идэвхжүүлэх, хариуцлагыг сайжруулж, гишүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлж, холбогдох зардал, төсвийн асуудлыг шийдвэрлэх

5.1.4.в	Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайлан	ТАЗ-өөс тайланг гаргаж, УИХ- аар хэлэлцүүлж байгаагүй.	
5.1.4.г	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайлан	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх илтгэлийг нэг удаа буюу 2014 онд гаргасан. Хуульд заасны дагуу 2 жил тутам хэлэлцэж байгаагүй.	8, 9 дэх удаагийн илтгэлийг УИХ- аар хэлэлцэж, дүгнэлт гаргасан талаарх мэдээлэл байхгүй.

*Эх сурвалж:(Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дэлгэрэнгүй тайлан, МУЗГ, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021, 205 дахь тал)*

**2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай** хуульд 2021 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, тус хуулийн 112 дугаар зүйлд заасны дагуу жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны талаарх тайлан, илтгэлийг УИХ-ын Байнгын хороод өөрийн харьяаллаар хэлэлцэхээр зохицуулсан. Үүнд:

- эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын (ХЭҮК) гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хууль зүйн байнгын хороонд жил бүрийн эхний улиралд;
- жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын болон ХЭҮК-ийн илтгэлийг Нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хоёр жил тутам.

**2.5 Парламент хуулиудад эрэгтэй, эмэгтэй хүмүүст үзүүлэх нөлөөллийн ялгааг хэмжихийн тулд жендэрийн үүднээс авч үздэг үү?**

Хууль тогтоомжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 12.1-д заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг батлан гаргасан байдаг. Гэсэн хэдий ч аргачлалд хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэхийг хэрхэн тодорхойлох талаарх тодорхой зааварчилгаа байхгүй байна.

Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд заалтын хэрэгжилтийг хангах талаар “Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэхэд хэрхэн үнэлгээ дүгнэлт өгөх талаар ЖҮХАА-наас 2019 онд боловсруулж, холбогдох асуудлын талаар хэлэлцүүлсэн “Хууль тогтоомжийн жендэрийн үнэлгээ хийх удирдамж, аргачлал”-ыг УИХ-ын Тамгын газар, ХЗДХЯ-тай хамтран эцэслэн албажуулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэсэн дүгнэлт гаргажээ. (*Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дэлгэрэнгүй тайлан, МУЗГ, ЖҮХ, UNFPA, ММСГ, 2021, 198 дахь тал*)

*Хэрэв тийм бол парламентад дээрх хяналт, шинжилгээг хэн, эсхүл аль байгууллага хариуцах вэ?*

УИХ-д өргөн барьсан хуулийн төсөлд жендэрийн үүднээс дүн шинжилгээ хийх чиг үүргийг УИХТГ-ын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар хариуцан хэрэгжүүлнэ.

**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах баталгааны хэрэгжилтэд үйлдвэрчний эвлэл болон ТББ, иргэд, олон нийт хяналт тавьж буй байдал**

**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 27.2-т жендэрийн эрх тэгш байдлыг хангах, түүнчлэн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааны хэрэгжилтэд үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллага, иргэд олон нийтийн хяналт тавина гэж заасан.**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого, бусад шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавихад Төрийн бус байгууллага (ТББ)-уудыг оролцуулах эрх зүйн зохицуулалт, тогтолцоо нь бүрдсэн, нэг талаас ЖҮХ ТББ-уудыг оролцуулах тал дээр хангалттай ажиллаж ирсэн бол нөгөө талаас ТББ-ууд нь идэвхтэй хамтран ажиллаж иржээ. Иргэд олон нийт жендэрийн эрх

тэгш байдлын баталгааны хэрэгжилтэд шууд хяналт тавихаас илүүтэй үйлдвэрчний эвлэл, ТББ-аар дамжуулан хяналт тавьж байна.

## ПАРЛАМЕНТЫН БОДЛОГО

*2.6 Парламентын дэг, дүрэм, журам жендэрийн мэдрэмжтэй юу? Парламентын дүрэмд жендэрийн үүднээс дүн шинжилгээ хийсэн бол тэр шинжилгээг хэн хийсэн бэ?*

УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023.03.24-ний өдрийн 187 дугаар захирамжаар “УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан. Харин Жендэрийн үүднээс дүн шинжилгээ хийх аргачлалыг одоогоор батлаагүй байгаа бөгөөд энэ чиглэлээр УИХ-ын багц хууль, дүрэм, журамд жендэрийн мэдрэмжийн үнэлгээ хийгдээгүй байна.

*2.7 Парламентад жендэрийн тэгш байдлыг хангасан стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө бий юу?*

Монгол Улсын Их Хурлын 2019-2024 стратеги төлөвлөгөө, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын стратеги төлөвлөгөө /2020-2024/ нь УИХ, түүний Тамгын газрын үйл ажиллагааг боловсронгуй болгох стратегийн төлөвлөгөө юм. Эдгээр бодлогын баримт бичгүүдэд парламентын түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах талаар тодорхой зорилтууд тусгагдсан.

*Хэрэв тийм бол дээрх төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж, хянаж, үнэлж байна вэ?*

**Жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой УИХ,  
түүний Тамгын газрын стратеги төлөвлөгөөний зорилтууд**

Төлөвлөгөө	Зүйл заалт
<b>УИХ-ын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө</b>	3.1.2.Жендэрийн тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих, Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх механизмыг бүрдүүлж, жендэрийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх;
<b>Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын стратеги төлөвлөгөө /2020-2024/</b>	3.2.3.Улсын төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл нь эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгаа болон тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн, ядуурлыг бууруулахад чиглэсэн, жендэрийн тэгш байдлыг хангасан, хүний эрхэд суурилсан эсэхэд шинжилгээ хийж, дүгнэлт гарган Байнгын хороодод мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай тооцоолол, динамик судалгаагаар шуурхай хангах механизм бүрдүүлэх; 3.7.2.3.Тамгын газрын удирдах болон бусад ажилтны дотор жендэрийн тэгш байдлыг хангах, энэ талаар холбогдох хууль тогтоомжид заасан механизмыг хэрэгжүүлэх;
<b>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр</b>	3.4.6.ажлын байранд болон байгууллагаас зохион байгуулж буй хамт олны нэгдсэн арга хэмжээнд жендэрийн ялгаварлан гадуурхалт бүхий үг хэллэг, үйлдэл гаргаж, сэтгэл санааны дарамт учруулсан албан хаагчид хариуцлага тооцох.

**Тамгын газар стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар:**

УИХТГ-ын стратеги төлөвлөгөөний 3.7.2.3-т тусгасан “Тамгын газрын удирдах болон бусад ажилтны дотор жендэрийн тэгш байдлыг хангах, энэ талаар холбогдох хууль тогтоомжид заасан механизмыг хэрэгжүүлэх” дэд арга хэмжээний хэрэгжилтийг “Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар үнэлгээ хийхтэй холбогдсон хуулийн үндэслэл, зохицуулалтыг бий болгох зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан Тамгын газрын удирдлагад танилцуулахаар бэлтгэсэн.” гэж тайлагнасан байна. (Эх сурвалж: УИХТГ-ын ХШҮГ-ийн Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга, 2023 он)

*Хэрэв тийм биш бол жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөөг хэрхэн боловсруулах вэ?*

ЖЭТБХТХ-ийн 16 дугаар зүйлд зааснаар жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хэмжээний бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын бүрэн эрхэд хамааруулсан. Үүнд: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөр, хуулийн 7 дугаар зүйлд заасан эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангах тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх, эдгээрийн хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн эх үүсвэрийг батлуулах гэж заасан байна.

### *2.8. УИХ-д өөр үйл ажиллагааны төлөвлөгөө бий юу?*

*Хэрэв тийм бол тэд хүйсийн мэдрэмжтэй юу?*

*Эдгээр төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх механизм бий юу?*

*Хэрэв тийм биш бол эдгээр төлөвлөгөө хэрхэн жендэрийн мэдрэмжтэй болох вэ?*

УИХ-аар жендэрийн мэдрэмжтэй хууль тогтоомжийг батлан гаргах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрх УИХ-д хадгалагдах бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд УИХ-аас дараах чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.

### **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд:**

- Төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулахад жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах үүрэг, хариуцлагыг ногдуулах;
- ХЭҮК-т Үндсэн хууль болон бусад хуульд орсон жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн зүйл, заалтын хэрэгжилтэд хяналт тавих эрхийг олгох;
- УИХ, Засгийн газар, Ерөнхий сайд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах шаардлага тавих;
- ЖҮХ, төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгсөн байна.

Түүнчлэн иргэний нийгэм болон ТББ-уудын үүрэг оролцоог хангах хүрээнд дараах чиглэлээр хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, төрийн бодлого, бусад шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавихад оролцох, иргэний зөрчигдсэн эрхийг хамгаалах;



- Төрийн байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой мэдээлэл, санхүү, арга зүйн болон бусад дэмжлэг авах;
- Жендэрийн эрх тэгш байдлын талаар саналаа илэрхийлэх гэж тусгажээ. (Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа, Швейцарын Хөгжлийн Агентлаг, IRIM судалгааны хүрээлэн, 21 дэх тал)

### **АСУУЛТ 3. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ**

УИХ-аас өөрийн үйл ажиллагаандаа болон УИХ-аар батлан гаргаж байгаа хууль тогтоомжийн хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудалд тусгайлан анхаарч үүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн механизм, тусгайлсан бүтцийг бий болгоход тодорхой ахиц дэвшил гарган ажилласан.

Үндэсний хэмжээнд ЖЭТБХТХ болон холбогдох бусад хууль тогтоомжуудад тусгагдсан зарчмуудыг дагаж мөрдөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах механизмыг Засгийн газар, түүний бүтцэд Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллаж буй ЖҮХ хариуцан ажиллаж байна.

Парламентын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудал нь НББХ-ны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байгаа бөгөөд УИХ-ын холбогдох байнгын болон дэд, түр хороод, УИХ-ын Тамгын газрын холбогдох нэгжүүдээр дамжуулан хууль тогтоомжийн төсөлд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтэд хяналт тавих, асуудлыг хэлэлцэн батлах, холбогдох байгууллагууд, иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлыг зохион байгуулж байна.

#### **3.1. Парламентын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангахад ямар механизм, бүтцийг ашигладаг вэ?**

Улс төрийн тэгш эрхийн тухай ойлголтын хүрээнд авч үзвэл, Монгол Улсад эмэгтэйчүүд хүн амын тал хувийг эзэлж байгаагийн хувьд хууль тогтоох, төрийн шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүдтэй адил тэгш оролцох ёстой гэж үздэг билээ. Нийгэмд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх тэгш оролцоог тогтоох нь нэг талаас хүний эрхийг ханган хэрэгжүүлэх, нөгөө талаас шударга ёсыг сахиулах ач холбогдолтой юм. УИХ-аас өөрийн үйл ажиллагаанд болон УИХ-аар батлан гаргаж байгаа хууль тогтоомжийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах асуудалд тусгайлан анхаарч үүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн механизм, тусгайлсан бүтцийг бий болгоход тодорхой ахиц дэвшил гарган ажиллаж байна.

Эрх зүйн механизмын хүрээнд ЖЭТБХТХ-д дараах зарчмуудыг тусгасан. Үүнд:

- төрийн хариуцлагын зарчим: төр эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах талаар Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжоор ногдуулсан үүргээ биелүүлэх, түүний үр дүнгийн төлөө хариуцлага хүлээх;
- жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим: хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөлд жендэрийн үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн агуулгатай болгох гэж тусгасан байна.

Бүтцийн тухайд, жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын асуудал нь УИХ-ын НББХ-ны эрхлэх асуудлын хүрээнд хамаарна. Тамгын газрын холбогдох нэгжүүдээс хууль тогтоомжийн төсөлд дүн шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үргийг хариуцан хэрэгжүүлнэ. Тухайлбал:

- ХЭЗГ-ын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн чиг үүрэгт зааснаар тус нэгж нь “УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх талаар эрх зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах” чиг үүрэгтэй.
- Хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь УИХ-ын хянан шалгах чиг үргийг хэрэгжүүлэхэд УИХ, БХ-оос өгсөн чиглэлийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийг хангах чиг үүрэгтэй гэж заасан.

УИХ-ын түвшинд жендэрийн асуудлыг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороо хариуцан ажиллаж байгаа бөгөөд жендэрийн асуудлыг нэг зөвлөх, нэг референт хариуцан ажиллаж байна.

*Тухайлбал, жендэрийн эрх тэгш байдлын асуудал эрхэлсэн хороо, парламент дахь эмэгтэйчүүдийн бүлэг байдаг уу? Жендэрийн суурь нэгжүүд байдаг уу? Мэдээлэл зөвлөгөө өгөх тусгайлсан жендэрийн нэгж байдаг уу? Дээр дурдсан нэг буюу хэд хэдэн механизм, бүтцийг бий болгох шаардлагатай юу?*

УИХ-д жендэрийн эрх тэгш байдлыг НББХ эрхлэх асуудлынхаа хүрээнд тусгайлан харьяалах ба ХЗБХ-ны харьяанд Хүний эрхийн дэд хороо, ЭЗБХ-ны харьяанд Тогтвортой хөгжлийн зорилтын дэд хороо тус тус ажиллаж байна.

УИХ-ын тухай хуулиар эмэгтэй гишүүд албан ёсны бүлэг байгуулах эрх зүйн зохицуулалт байхгүй боловч эмэгтэй гишүүд сайн дурын үндсэн дээр нам харгалзахгүйгээр эвлэлдэн нэгдэж албан бус бүлэг байгуулах хэлбэрээр ажиллаж байна. Тухайлбал, 2020-2024 оны парламентад сонгогдсон 13 эмэгтэй гишүүн нам харгалзахгүйгээр хамтран ажиллахаар эмэгтэй гишүүдийн бүлэг байгуулсан. Уг бүлгийг УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл даргалж байна.

Түүнчлэн ХЗБХ-ны Хүний эрхийн дэд хороог УИХ-ын эмэгтэй гишүүн Ц.Мөнхцэцэг даргалж байна. Тус дэд хороо нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын асуудлыг дагнан хариуцаж, санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй.

Жендэрийн тэгш байдлын асуудлаар УИХ-д мэдээлэл, зөвлөгөө өгөх үндсэн чиг үүргийг УИХ-ын бүтцийн хороодууд, Тамгын газрын холбогдох нэгжүүд хариуцан хэрэгжүүлж байна. Тухайлбал, Тамгын газрын үндсэн нэгжүүд болох Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн, Хяналт шалгалт, үнэлгээний газар, Хууль, эрх зүйн газар зэрэг холбогдох нэгжүүд өөр өөрсдийн чиг үүргийн хүрээнд УИХ-ын гишүүдийг мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээгээр хангах үүрэгтэй.

Сүүлийн жилүүдэд УИХ-ын үйл ажиллагааг ардчилсан парламентын зарчмуудад нийцүүлэн боловсронгуй болгох, хууль тогтоох, хянан шалгах, төлөөлөл хэрэгжүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь УИХ-д мэргэжил, арга зүй, мэдээллийн дэмжлэг үзүүлэх мэргэшсэн албадыг Тамгын газрын бүтцэд байгуулан ажиллуулах, мэргэшүүлэхэд түлхүү анхаарч ажилласан. Одоогийн байдлаар Тамгын газрын бүтцэд Парламентын судалгаа сургалтын хүрээлэн, Хяналт шалгалт, үнэлгээний газар (Хяналт шалгалтын хэлтэс, Төсвийн хяналт шинжилгээний хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний албатай), Хууль эрх зүйн газар (Зөвлөхүүдийн алба, Байнгын хороодын асуудал хариуцсан хэлтэс, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэстэй) байгуулагдан ажиллаж байгаа нь дээр дурдсан механизмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Цаашид эдгээр мэргэшсэн албадыг чадавхжуулах, хүний эрх, жендэрийн чиглэлээр тусгайлсан үүрэгтэй ажиллаж байгаа ХЭҮК, ЖҮХ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, хуулийн механизмыг хамтран хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох чиглэлд ахиц дэвшил гаргах шаардлагатай.

Эрх зүйн механизмыг боловсронгуй болгох хүрээнд УИХ-д өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх

талаар үнэлгээ хийхтэй холбогдсон хуулийн зохицуулалтыг тодорхой болгох, үнэлгээ, дүн шинжилгээ хийхтэй холбоотой арга, аргачлалыг батлуулах, мэдээллийн эх сурвалжуудыг татан төвлөрүүлэх сүлжээ, тогтолцоог бий болгох, мөн Тамгын газрын холбогдох нэгжүүдийн тухайн асуудал хариуцсан ажилтнуудын жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээний чадавхыг сайжруулах, энэ чиглэлээр гаргасан дүгнэлт, үнэлгээний тайлангуудыг УИХ-аар авч хэлэлцэх механизмыг бүрдүүлэх шаардлага байна гэж үзэж байна.

### **3.2 Парламент жендэрийн тэгш байдлыг хангах ямар арга хэрэгслийг бий болгосон бэ?**

УИХ-ын тухайд, парламентын түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах асуудал бодлогын түвшинд баталгаажсан бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тухайлбал:

**Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд** жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих, УИХ дахь эмэгтэй гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх механизмыг бүрдүүлж, жендэрийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх гэж тусгаж өгсөн. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийжээ. Үүнд:

- Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуульд эмэгтэйчүүдийн оролцох оролцоог нэмэгдүүлж хуульчилсан.
- 2020 онд баталсан МУИХЧХДтХ-д жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын болон ХЭҮК-ын илтгэлийг Нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хоёр жил тутам сонсож байх зохицуулалт тусгагдсан.
- Улс төрийн хүрээн дэх хүйсийн тэнцвэрийг хангах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих УИХ-д суудалтай улс төрийн намуудын төлөөлөл бүхий гишүүд санал нэгдэн Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих лобби бүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 24-нд байгуулан ажиллаж байна.
- УИХ, ОУПХ хооронд хүний эрх, жендэрийн асуудлаар хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр санамж бичгийг солилцов. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаа болон түүний бүтэц, үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг дэмжих, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тунхагласан.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 70%.

### **Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын стратеги төлөвлөгөө /2020-2024/**

3.2.3. Улсын төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл нь эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгаа болон тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн, ядуурлыг бууруулахад чиглэсэн, жендэрийн тэгш байдлыг хангасан, хүний эрхэд суурилсан эсэхэд шинжилгээ хийж, дүгнэлт гарган Байнгын хороодод мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай тооцоолол, динамик судалгаагаар шуурхай хангах механизм бүрдүүлэх;

3.7.2.3. Тамгын газрын удирдах болон бусад ажилтны дотор жендэрийн тэгш байдлыг хангах, энэ талаар холбогдох хууль тогтоомжид заасан механизмыг хэрэгжүүлэх гэж тусгаж өгсөн.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 70%.

*Парламент хууль тогтоомжийг жендэрийн үүднээс үнэлэх хяналтын хуудас боловсруулсан уу?*

Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний 3.1.8 дахь заалтад заасан УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлалыг баталсан боловч, жендэрийн эрх тэгш байдлыг хангах аргачлал тусгайлан батлаагүй байна.

УИХ 2015 онд баталж, 2017, 2020, 2023 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан. Уг хуулийн 17 дугаар зүйлд хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага, үр нөлөөг урьдчилан үнэлэх шаардлагыг хуульчилсан бөгөөд энэхүү үнэлгээний аргачлалыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан. Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 6.2-т заасны дагуу төслийн хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлах бөгөөд үүнийг үнэлэх суурь асуултуудыг батлан гаргасан. Тухайлбал, хяналтын хуудсын Хүний эрхийн үнэлгээний суурь асуултуудын 5-д

заасан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх” бүлэг асуултын хүрээнд дараах хяналтын асуултуудаар үнэлгээ хийсэн байх шаардлагатай. Үүнд:

- Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх;
- Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх.

Хууль санаачлагчаас эдгээр хяналтын асуултуудыг бөглөж холбогдох судалгаа, үнэлгээний тайлангуудын хамтаар УИХ-д өргөн мэдүүлэх журамтай.

*Парламентад хүйсээр нь ангилсан мэдээлэл авах боломжтой юу, хэрэв байгаа бол тэдгээрийг хэрхэн ашигладаг вэ?*

УИХ-ын тухай хуулийн 8.1.16-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд УИХ-ын гишүүн УИХ-ын бусад шийдвэрийн биелэлтийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл шаардаж авах; 8.1.17-д заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, хэнтэй ч хүлээгдэлгүй уулзах, шаардлагатай асуудлаар тайлбар, мэдээлэл авах эрхтэй.

Монгол Улс жендэрийн статистикийг хөгжүүлэх үйл ажиллагаандаа Статистикийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль ба холбогдох олон улсын гэрээ, конвенцуудын зарчмыг суурь болгоно гэж заасны дагуу Монгол Улсын статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг 2011, 2017 онд хоёр удаа батлан гаргахдаа жендэрийн статистик мэдээллийн асуудлыг тусгасан нь ЖЭТБХТХ-ийн 5.1.5-д заасан жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал алхам болсон. Хүйсээр ангилсан статистик мэдээллийн сан бүрдүүлэх хүрээнд дараах бодлого, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

**Монгол Улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр** (УИХ-ын 2011 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан):

4.1.3.10. жендэрийн статистикийн аргачлалыг боловсруулах, мөрдөх.

5.4.2.1. нийгмийн салбарын статистикийг боловсронгуй болгох, үүний дотор захиргааны статистик мэдээллийн хамрах хүрээ, чанарыг сайжруулна. Захиргааны мэдээллийг албан ёсны статистикт ашиглах ажиллагааг сайжруулна. Олон улсын нийтлэг арга зүйд нийцсэн жендэрийн статистикийг бий болгоно.

5.4.3.4. захиргааны мэдээллээс гарч байгаа үзүүлэлтийг жендэрийн мэдрэмжтэй болгох. 5.4.4.2. салбарын үзүүлэлтүүд жендэрийн мэдрэмжтэй болж, жендэрийн үзүүлэлтүүдийг тогтмол гаргаж хэвшинэ.

**Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр** (УИХ-ын 2017 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан):

Хөтөлбөрийн үр дүнд бий болох статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дараах үндсэн шалгуур, зарчмыг хангасан байна: 1.2.7.жендэрийн мэдрэмжтэй байх: статистикийн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тархаах зэрэг бүх үйл ажиллагаанд жендэрийн асуудлыг хамтад нь авч үзэх; 2.6.1.4.захиргааны статистикийн мэдээллийн үзүүлэлтийг жендэрийн мэдрэмжтэй болгох, жендэрийн статистикийн үзүүлэлтэд үндэслэж, дүн шинжилгээ хийнэ гэж заасан.

Үндэсний Статистикийн хороо (ҮСХ)-оос Жендэрийн статистикийн үзүүлэлтийн жагсаалтыг 2013 онд 14 бүлгийн 216 үзүүлэлттэйгээр, 2019 онд ЖҮХАА-тай хамтран Жендэрийн статистик үзүүлэлтийн хамрах хүрээ, аргачлалыг шинэчлэн баталжээ. Жендэрийн статистик үзүүлэлтийн хүрээнд нийт 14 бүлгийн 241 үзүүлэлтийг хамруулжээ. ҮСХ нь албан ёсны статистикийн мэдээлэл буюу статистикийн мэдээ, судалгаа, тооллогын мэдээллийг хүйсээр ангилж цуглуулах, дүн шинжилгээ хийх, тархаах чиглэлд ихээхэн ахиц дэвшилтэй ажиллаж байна.

*Парламентын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын асуудлыг тусгахад тустай өөр хэрэгсэл бий юу?*

Дээр дурдсан арга механизмуудаас өөр арга хэрэгсэл байхгүй. (Хууль зүйн байнгын хороонд Хүний эрхийн дэд хороо ажиллаж байна)

*Жендэрийн тэгш байдлыг хангахад хангалттай нөөц хуваарилагдсан уу?*

УИХ болон Тамгын газрын бүтцэд ажиллаж буй Байнгын, түр хороод болон Тамгын газрын холбогдох нэгжүүдийн хүний нөөц:

- Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний алба нь 1 зөвлөх, 3 референттэй.
- Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс 7 ахлах зөвлөхтэй.
- Хууль, эрх зүйн газрын Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх 1, референт 1, 1 нарийн бичгийн даргатай.
- Хууль, эрх зүйн газрын Эдийн засгийн байнгын хорооны Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороог байнгын хорооны ажлын алба хариуцдаг бөгөөд ахлах зөвлөх 1, референт 1, 1 нарийн бичгийн даргатай.

Жендэрийн тэгш байдлыг хангахад зориулсан тусгайлсан төсвийн ангилал байдаггүй бөгөөд УИХ-ын даргын төсвийн багцад хамаарна.



### 3.3. Парламентад жендэрийн тэгш байдлыг хангах үүрэгтэй байгууллагууд хэр үр дүнтэй ажиллаж байна вэ?

Жендэрийн тэгш байдлыг хангах үүрэгтэй байгууллагуудаас УИХ-тай хамтран ажиллах үйл ажиллагаа дараах байдалтай байна.

**Хүний эрхийн Үндэсний Комисс:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх ХЭҮК-ын илтгэлийг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал:

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан үүргийн хэрэгжилт:

“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс” гэж Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага юм.

ХЭҮК нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

Хэрэгжилт:

- ХЭҮК нь ЖЭТБХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.4.б-д заасан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх илтгэл гэдэг утгаар бус Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11-д заасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн хүрээнд уг асуудлыг тусгаж, УИХ-аар хэлэлцүүлж иржээ. УИХ-аас Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019 оны 62 дугаар тогтоолын 1 дэх заалтад Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр дараах асуудалд анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосон бөгөөд ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж ЖҮХ-ний үйл ажиллагааг идэвхжүүлэх, хариуцлагыг сайжруулж, гишүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлж, холбогдох зардал, төсвийн асуудлыг шийдвэрлэх үүрэг өгсөн. Энэ хүрээнд ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт 2022 онд үнэлгээ хийгдсэн.



## **Засгийн газар**

*Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үр дүнгийн талаар УИХ-д тайлагнасан байдал:*

Засгийн газраас жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар УИХ-д тайлагнасан мэдээ одоогоор алга байна. Хууль тогтоогч, бодлого тодорхойлогчид буюу УИХ-ын түвшинд асуудлыг тавьж, хэлэлцүүлж дүгнэлт гаргуулж чадахгүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад хүргэж байна.

## **Төрийн албаны зөвлөл**

*Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал:*

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.2-т ТАЗ үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнана гэж заасны дагуу үйл ажиллагаагаа тайлагнаж байгаа хэдий ч ЖЭТБХТХ-ийг хэрэгжүүлэх хугацаанд хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т заасны дагуу Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх тайланг нэг ч удаа УИХ-аар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулаагүй байна. (*Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, МУЗГ, ЖҮХ, UNFPA, MMSG, 2021, 243 дэх тал*)

*Тэдгээр нь үндэсний эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах механизм, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл болон бусад байгууллагуудтай ямар харилцаатай байдаг вэ?*

## **Жендэрийн үндэсний хороо**

Монгол Улсын Ерөнхий сайд ЖҮХ-г тэргүүлж, үйл ажиллагааг нь удирдлагаар хангана.

ЖЭТБХТХ батлагдахаас өмнө Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2002-2015) болон Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцын хүрээнд жендэрийн нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнадаг байсан. Хууль батлагдсантай холбоотойгоор үндэсний, салбарын, орон нутгийн хэмжээний бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах тогтолцоо бүрдсэн байна.

ЖҮХ нь жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах чиг үүргийнхээ хүрээнд Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэгтэй хамтран ЖЭТБХТХ-ийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратегийн баримт бичиг (2013-2016)-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж, нийтэд мэдээлсэн. Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг хэрэгжүүлсэн.

Хууль, бодлогын баримт бичгийг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх, үр нөлөөг нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалын хувьд үнэлэх практик туршлагыг бэхжүүлэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд ЖҮХ-ний 2022 оны тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөг баталж, үндсэн 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

ЖҮХ нь [www.gender.gov.mn](http://www.gender.gov.mn) цахим хуудсыг Монгол, Англи хэл дээр ажиллуулж байна. Тус вэб сайтад ЖҮХАА-ны цаг үеийн мэдээ, мэдээлэл, хэвлэгдэн гарсан ном товхимол, фото болон видео мэдээлэл, сургагч багш нарын мэдээлэл, салбарын жендэрийн бодлого, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн мэдээлэл тогтмол нийтлэгдэж байна.

### **Дээрх байгууллагууд хангалттай эрх мэдэлтэй юу?**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд зааснаар **Жендэрийн Үндэсний хороо** дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр болон олон улсын гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцах, зөвлөгөө өгөх;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- Жендэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн сүлжээ байгуулах, жендэрийн мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалахад олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангах;

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх;
- Жендэрийн салбар хороо, зөвлөлийн тайлан, мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт гаргах.

ЖҮХ ажлаа Засгийн газарт тайлагнана.

*Тэд хэр сайн нөөцтэй вэ (ажилтан, хурлын өрөө, төсөв гэх мэт)?*

### **Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль:**

ХЭҮК нь 6 гишүүн болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн 1 гишүүнтэй байна. Комиссын Тамгын газар нь гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах үүрэгтэй. Тамгын газар нь Тамгын газрын дарга, орон нутагт Комиссын чиг үүргийг хэрэгжүүлэх орон тооны ажилтан, нийтдээ 76 албан хаагчтай байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар комиссын төсөв үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, дэмжих, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх, шинжээч томилон ажиллуулахад шаардагдах зардал болон бусад зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдана. Комиссын Тамгын газрын дүрмийг баталж, орон тоо, цалингийн санг УИХ-аас баталсан төсөвт багтаан тогтооно гэж заасан.

### **Жендэрийн үндэсний хороо нь:**

- Хэлтсийн дарга
- Салбар дундын бодлого зохицуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Орон нутгийн хөгжлийн бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Эмэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Эрэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Олон улсын гэрээ конвенц, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн
- Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
- Жендэрийн үндэсний чадавх хариуцсан мэргэжилтэн
- Олон нийтийн жендэрийн боловсрол, соён гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

- Хэвлэл мэдээллийн ажилтан
- Бичиг хэрэг, архив, дотоод асуудал хариуцсан ажилтан
- Санхүү төсөв хариуцсан ажилтан гэсэн 12 орон тоотой ажиллаж байна.

ЖҮХ-ны төсөв нь Ерөнхий сайдын багцад хамаардаг байна.

ЖҮХ-ны дэргэд Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн төслийн хүрээнд 2019 онд “Сургалт, судалгааны танхим”, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны техник туслалцааны төслийн хүрээнд иж бүрэн тоноглогдсон “Мэдээлэл, судалгааны танхим”-ыг 2020 онд тус тус байгуулсан нь ЖҮХ төдийгүй жендэрийн чиглэлээрх сургалт, семинар зохион байгуулах бусад этгээдүүдэд нээлттэй боломжийг олгож байна.

### *Тэд жендэрийн тэгш байдлыг хангахад ямар өөрчлөлт хийж чадсан бэ?*

ХЭҮК нь ЖЭТБХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.4.б-д заасан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх илтгэл гэдэг утгаар бус Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11-д заасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийн хүрээнд уг асуудлыг тусгаж, УИХ-аар хэлэлцүүлж иржээ.

УИХ-аас Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019 оны 62 дугаар тогтоолын 1 дэх заалтад Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр дараах асуудалд анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газарт даалгасугай гэсний дотор 7.б-д Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж ЖҮХ-ны үйл ажиллагааг идэвхжүүлэх, хариуцлагыг сайжруулж, гишүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлж, холбогдох зардал, төсвийн асуудлыг шийдвэрлэхээр тусгажээ. Энэ хүрээнд ЖЭТБХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх энэхүү ажил хийгдэж байна.

**Жендэрийн Үндэсний хороо**-2011 онд ЖЭТБХТХ батлагдсанаар тус хорооны чиг үүрэг тодорхой болж, хуулийг хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалтуудыг хийх, үндэсний жендэрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавихад Хороо үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллажээ. Тухайлбал, Хороо үндэсний хэмжээний жендэрийн бодлого хоёрыг боловсруулж, 10 салбарын жендэрийн бодлого, орон нутгийн жендэрийн 30 бодлогыг боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлсэн, хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлж хяналт тавьж ажилласан.

ЖҮХ нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, УИХ-ын болон орон нутгийн хурлын сонгуулийн тухай, Улс төрийн намын тухай, Хууль тогтоомжийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон “Алсын хараа–2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг” болон холбогдох бусад бодлого хөтөлбөр, төлөвлөгөөнүүдэд саналаа өгч ажилласан байна.

*УИХ-ын байгууллага дахь тэдний байр суурийг шинэчлэн сайжруулах уу?*

Засгийн газрын 2011 оны 323 дугаар тогтоолоор ЖҮХ-г шинэчлэн байгуулж, хорооны дүрэм, бүрэлдэхүүн, ажлын албаны орон тоог баталсан. ЖҮХ нь дэргэдээ үндэсний чадавх бүрдүүлэх зорилтын хүрээнд жендэрийн асуудлаар зөвлөх эрх бүхий Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг /2014 он/, жендэрийн боловсролыг дэмжих Жендэрийн консорциум /2012 он/, хэвлэл мэдээллийн нийтлэлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгоход дэмжлэг үзүүлэх Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулан ажиллаж байна.

*3.4 Парламентад эмэгтэйчүүдийн бүлэг байдаг бол хэрхэн ажилладаг вэ?*

*Үйл ажиллагааг нь хэрхэн зохион байгуулдаг вэ?*

*Шийдвэрүүд хэрхэн гардаг вэ?*

*Тухайн бүлгийн гишүүн бус хүмүүс хэрхэн хүлээж авч байна вэ?*

УИХ-ын тухай хуулиар эмэгтэй гишүүд албан ёсны бүлэг байгуулах эрх зүйн зохицуулалт байхгүй боловч эмэгтэй гишүүд сайн дурын үндсэн дээр нам харгалзахгүйгээр эвлэлдэн нэгдэж албан бус бүлэг байгуулах хэлбэрээр ажиллаж байна. Тухайлбал, 2020-2024 оны парламентад сонгогдсон 13 эмэгтэй гишүүн нам харгалзахгүйгээр хамтран ажиллахаар эмэгтэй гишүүдийн бүлэг байгуулсан. Уг бүлгийг УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл даргалж байна.

*3.5 Жендэрийн тэгш байдлыг хангах асуудал эрхэлсэн нэгээс олон байгууллага парламентад байгаа тохиолдолд тэдгээр нь хоорондоо ямар уялдаа холбоотой вэ?*

*Тэдний хооронд албан ёсны зохицуулалтын механизм бий юу?*

*Ажлын харилцаа үр дүнтэй байдаг уу?*

УИХ-д жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын асуудлыг хамаарах Нийгмийн бодлогын байнгын хороо байдаг. УИХ-ын бүтцэд ажилладаг нэгжүүд нь чиг үүргийнхээ хүрээнд хамтран ажиллах боломжтой. Тамгын

газрын холбогдох нэгжүүдээс хууль тогтоомжийн төсөлд жендэрийн үнэлгээ, хууль тогтоомжийн үр нөлөөний үнэлгээ, дүн шинжилгээ хийсэн тохиолдолд уг тайланг УИХ-ын түвшинд авч хэлэлцэх эрх зүйн механизм одоогоор байхгүй.

*3.6 Төсөв болон төсвийн хяналтын үйл явцад жендэрийн тэгш байдлыг тусгасан уу?*

*Хэрэв тийм бол энэ үйл явцад ямар нэгэн бэрхшээл тулгарсан уу?*

*Хэрэв тийм биш бол энэ үйл явцад жендэрийг хэрхэн голчлон оруулах вэ?*

ЖЭТБХТХ-ийн 19 дүгээр зүйлд төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах гэж заасан байдаг.

Европын Холбоо (ЕХ)-ны санхүүжилттэйгээр Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ)-ийг Монгол Улсад нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд ЖМТ-ийн аргачлал боловсруулах, нэвтрүүлэх, турших ажлыг 2019 оноос эхлүүлээд байна. Жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг нэвтрүүлэх хуулийн зорилт өнөөгийн байдлаар зөвхөн эхлэлийн байдалтай байна.

УИХ-ын ЕНБД-ын 2022 оны 347 дугаар захирамжаар Тамгын газраас тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлалыг баталсан. Тус аргачлалын хавсралт 5-д төсвийн төсөл жендэрийн мэдрэмжтэй боловсрогдсон эсэхийг шинжлэх шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан. Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газарт Төсвийн дүн шинжилгээний хэлтэс ажилладаг боловч УИХ-аар хэлэлцэн баталж буй тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлд жендэрийн мэдрэмжийн дүн шинжилгээ хийгээгүй байна.

Одоогийн байдлаар Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төсөл жендэрийн мэдрэмжтэй боловсрогдсон эсэхийг шинжлэхэд шаардагдах мэдээлэл, тайланг тусгаж хэвшээгүй байна.

**Монгол Улсын Засгийн газар холбогдох хууль тогтоомж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль** тогтоомж, түүнийг дагаж гарсан бодлого, салбар дундын жендэрийн эрх тэгш байдлыг хангах 10 жилийн стратеги төлөвлөгөөг баталж, салбар яамдын жендэрийн бодлогуудад тусгагдсан ЖМТ-ийг хэрэгжүүлэхээр Сангийн яам, Европын Холбоо, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 2020 оноос салбарын зарим сонгосон яамдын хөтөлбөрүүд дээр туршин нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.



## **АСУУЛТ 4. ПАРЛАМЕНТ ДАХЬ БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, ОРЧИН, БОДЛОГО**

УИХ-ын үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмуудаар эмэгтэй гишүүдийн парламент дахь үүрэг оролцоо, ажиллах орчин, дэг, соёлтой холбоотой асуудлыг тусгайлан зохицуулдаггүй бөгөөд эрэгтэй, эмэгтэй гишүүд ижил нөхцөлд, нийтлэг зохицуулалтын горимоор ажилладаг. Парламентад сонгогдсон эмэгтэй гишүүдийн ажлын байр, хувцаслалт зэрэгт тусгайлсан шаардлага тавигддаггүй.

УИХ-д сонгогдсон, УИХ-ын удирдах албан тушаалд томилогдсон гишүүдийн тоо харьцангуй цөөн боловч УИХ-ын эмэгтэй гишүүд улс төрийн нам харгалзахгүйгээр УИХ дахь Эмэгтэйчүүдийн албан бус бүлэг байгуулан ажилладаг. Одоогоор УИХ-д УИХ дахь Эмэгтэй гишүүдийн бүлгэм, Эмэгтэй парламентчдын орон тооны бус зөвлөл ажиллаж байна. Түүнчлэн улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн лобби бүлэг, олон талт зөвлөл, санамж бичиг байгуулах зэрэг олон талт арга механизмуудыг улс төрийн нам харгалзахгүйгээр зохион байгуулж байгаа бөгөөд эмэгтэй гишүүд үүнд идэвхтэй оролцдог.

### **4.1. Парламентад жендэрийн тэгш байдлыг хэрхэн хүлээж авч байна вэ?**

УИХ дахь жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлд өнөөгийн байдлаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал:

**Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн бүлгэм:** Бүлгэмийн даргаар УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл ажиллаж байна.

**“Эмэгтэй парламентчдын орон тооны бус зөвлөл”:** УИХ-ын даргын дэргэд ажиллах тус зөвлөлийн даргаар УИХ-ын дэд дарга С.Одонтуяа ажиллаж байна. Энэ зөвлөлд үе үеийн Улсын Их Хуралд сонгогдон ажиллаж байсан эмэгтэй парламентчдын хууль тогтоох, боловсруулах явцад саналыг нь сонсох, тодорхой хэмжээгээр шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх боломжийг бүрдүүлсэн механизм юм.

**Хамтын ажиллагааны санамж бичиг:** УИХ, ОУПХ хооронд хүний эрх, жендэрийн асуудлаар хамтран ажиллах санамж бичгийг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан. Тус санамж бичигт Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа болон түүний бүтэц, үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг дэмжих, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тунхагласан.

**Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих лобби бүлэг:** Улс төрийн хүрээн дэх хүйсийн тэнцвэрийг хангах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих УИХ-д суудалтай улс төрийн намуудын төлөөлөл бүхий гишүүд санал нэгдэн 2023 оны 01 дүгээр сарын 24-нд байгуулагдсан.

**Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөл<sup>107</sup>:** Тус зөвлөл нь Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд Монгол Улсын Засгийн Газарт дэмжлэг үзүүлэх, мөн Тогтвортой Хөгжлийн Үндэсний Зөвлөлийг бэхжүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2022 оны 03 дугаар сард байгуулагдсан. Тус зөвлөл нь:

- 1) ТХЗ-ыг дэмжсэн хууль, тогтоомжийг боловсруулах, шинэчлэх, батлахад парламентад дэмжлэг үзүүлэх;
- 2) ТХЗ-д үзүүлэх улсын төсвийн нөлөөллийг үнэлэхэд парламентад туслах;
- 3) ТХЗ-д чиглэсэн хууль, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих парламентын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 4) ТХЗ-д тулгарах хөгжлийн сорилт, бэрхшээлийг шийдвэрлэх асуудлаар парламентад туслах;
- 5) ТХЗ-д хүрэхийн тулд боловсруулсан хууль тогтоомжид иргэдийн үзэл бодол, ашиг сонирхлыг тусгах асуудлаар зөвлөгөө өгөх;
- 6) ТХЗ-ын талаар олон нийтэд хамтран мэдээлж, олон нийтийн оролцоог дэмжих;
- 7) ТХЗ-ын хэрэгжилтийн талаар салбар хоорондын болон үндэсний хэмжээнд туршлага солилцох форумыг зохион байгуулж, оролцогч талууд тогтвортой хөгжлийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлж, санал, санаачилгыг уламжлах, холбогдох асуудлаар эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийг татан оролцуулах зэрэг стратегийн чиглэлд хяналт тавих, удирдах, чиглүүлэх үүргийг нарийвчлан гүйцэтгэх юм.

Зөвлөл нь Төр, засгийн байгууллагууд, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт 23 гишүүнтэй бөгөөд үүнээс 14 эрэгтэй, 9 эмэгтэй гишүүнтэй.

*Жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, дэмжлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байгаа юу? Парламент дахь жендэрийн тэгш байдлыг хангах дэмжлэгийг нэмэгдүүлэхийн тулд (өөр) ямар арга хэмжээ авах нь үр дүнтэй вэ?*

Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, дэмжлэгийг нэмэгдүүлэх хүрээнд 5.2.1, 5.2.2-т заасан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр

<sup>107</sup> <https://www.parliament.mn/nn/16430/>



заасны дагуу УИХТГ-аас анх удаа УИХ-ын гишүүдэд зориулсан сургалтын дэд хөтөлбөрийг УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын гишүүнд зориулсан чиглүүлэх мэдээлэл, сургалтын дэд хөтөлбөр (MP-01),
- Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаа ба УИХ-ын гишүүний бүрэн эрх сургалтын дэд хөтөлбөр (MP-02)-ийг тус тус хэрэгжүүлж байна.

Түүнчлэн УИХТГ-ын ажилтнууд, УИХ дахь намын бүлгийн ажилтнууд, УИХ-ын гишүүний зөвлөх, туслахуудын жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах, чадавх бэхжүүлэх зорилгоор “Жендэрийн мэдрэмж” сургалтын дэд хөтөлбөр (SS-02)-ийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд нийт 14 сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 476 албан хаагчийг хамруулсан байна.

*4.2. Парламентын соёлыг (хэл, зан заншил, хувцаслалтын дүрэм) жендэрийн хувьд Та хэрхэн тодорхойлох вэ: энэ нь жендэрийн мэдрэмжтэй юу, жендэрийн хувьд төвийг сахисан уу эсвэл хүйсийн ялгаа өндөртэй юу?*

Монгол Улсын Үндсэн хуульд монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн гэж заасан. Гэхдээ хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг хөндөөгүй. Монгол хэлний тухай хуульд зааснаар “төрийн албан ёсны хэл” гэж төрийн байгууллага, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөх орчин цагийн утга зохиолын монгол хэлийг хэлнэ гэж тодорхойлсон. Иймээс үндэстний хэл, соёлын хүрээнд жендэрийн ямар нэгэн ялгаварлалт байхгүй бөгөөд Монгол Улсын хэмжээнд төрийн бүх үйл хэргийг монгол хэлээр явуулна.

**Хувцаслалтын дүрэм:** Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу УИХ, түүний Тамгын газрын ажилтнууд болон Төрийн ордонд үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагын ажилтнууд хувцаслалтын дараах дүрмийг мөрдөнө. Үүнд:

Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 10 дугаар зүйл:

10.7. Төрийн ордонд ажилладаг албан хаагч нь ажлын байрандаа албаны хувцастай байна.

10.8. Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний ажилтан нь тус бүрийн ажлын онцлог, шаардлагад тохирсон нэг ижил хийц, загварын ажлын хувцастай байна.

2008 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, УИХТГ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Тагнуулын ерөнхий газрын дарга нарын хамтарсан тушаалаар баталсан “Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний журам”-ын 3.18 дахь заалтын дагуу Төрийн ордонд хувцаслалтын дараах хязгаарлалт тавигдана. Үүнд:

- “Хамгаалалт, үйлчилгээний болон цэрэг, цагдаагийн ажилтнууд дүрэмт хувцастай бусад хүмүүс албаны болон үндэсний хувцастай Төрийн ордонд нэвтэрнэ. Биеийн тамирын, чөлөөт амралтын, ажлын болон этгээд загварын, нуруу, хэнхдэг ил гарсан, гэрэлтдэг нимгэн хувцас, өвдөгнөөс дээш богино банзал, бохирдсон хувцастай иргэд, ажилтнуудыг нэвтрүүлэхгүй.” гэж заасан байдаг.

Төрийн ордонд нэвтрэх иргэдийн хувцаслалтын тухайд, УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 185 дугаар захирамжаар “Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой иргэд, зочид, төлөөлөгчдийг танилцуулах журам” шинэчлэгдэн баталсан бөгөөд тус журмын 3.5-д заасны дагуу:

- “Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцах иргэд Төрийн ордон руу энгийн, чөлөөт хувцастай нэвтэрч болох бөгөөд нуруу, хэнхдэг ил гаргасан, гэрэлтдэг нимгэн хувцастай тохиолдолд нэвтрүүлэхгүй.” гэж тус тус заасан.

Эдгээр хууль, журмын зохицуулалтаас үзэхэд, Төрийн (парламентын) ордонд нэвтрэхэд албан хаагчид болон иргэдэд хувцаслалтын тодорхой шаардлага тавигддаг бөгөөд ялангуяа эмэгтэй хүйсийн тухайд ил задгай, дүрмийн бус хувцаслалттай нэвтрэн орохыг хориглосон журамтай байна.

#### *4.3. Парламентад эмэгтэйчүүдийг гадуурхсан, доромжилсон хэвшмэл ойлголт байдаг уу?*

*Хэрэв тийм бол эдгээрийг хэрхэн арилгах вэ?*

Тодорхой мэдээлэлгүй байна.

#### *4.4. Парламентын байрыг жендэрийн үүднээс авч үзсэн үү?*

*Боломжит үйлчилгээнд эмэгтэйчүүдийн голчлон эрэлхийлдэг үйлчилгээ багтдаг уу?*

*Парламентын ордон тэнд ажиллаж байгаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хэрэгцээг хэрхэн хангаж байна вэ?*

Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Төрийн ордны үйлчилгээ нь түүнд байрлаж байгаа байгууллагын хэвийн

үйл ажиллагаа явуулах, ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлийн жишиг шаардлагыг хангасан байна.” гэж заасны дагуу “Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний журам”-ын 5.5-д “Төрийн ордонд байрладаг байгууллага, ажиллагсдад эмийн сан, номын худалдаа, кофе шоп, оёдол, угаалга, эрэгтэй, эмэгтэй үсчин, гоо сайхан, эмнэлгийн анхан шатны тусламж, олон улсын болон орон нутгийн нислэгийн тийзийн үйлчилгээ, банкны бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх тооцооны төв, цэвэрлэгээ, ариутгал, зөөврийн үйлчилгээг үзүүлэх”-ээр заасан байна.

Одоогоор Төрийн ордонд эрэгтэй, эмэгтэй үсчин, эмнэлгийн анхан шатны тусламж, кофе шоп, зоогийн газар, банкны салбар тооцооны төв, түргэн үйлчилгээний сүлжээ дэлгүүр ажиллаж байна. Мөн Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газраас цэвэрлэгээ, ариутгал, зөөврийн үйлчилгээг үзүүлж байна.

Мөн Тамгын газрын бялдаржуулах танхимаар гишүүн, Тамгын газар, УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан, гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахууд үнэ төлбөргүй үйлчлүүлнэ.

УИХ тусгайлсан парламентын ордонгүй бөгөөд одоогоор Төрийн ордонд УИХ, түүний Тамгын газар, Ерөнхийлөгч, түүний Тамгын газар, Засгийн газар, түүний Хэрэг эрхлэх газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Төр, засгийн үйлчилгээ аж ахуйн газар, Төрийн ордны онцгой байдлын алба болон Төрийн ордны хамгаалалтын газар зэрэг 7 байгууллагын 1500 гаруй хүн ажиллаж байгаа нь багтаамж, зай талбайн хувьд хүртээмжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Ялангуяа УИХ, түүний Тамгын газар, УИХ-ын гишүүдийн Ажлын алба, Намын бүлгийн ажилтнуудын хувьд өрөө тасалгаа хүрэлцээгүй учраас 1 өрөөнд хэт олуулаа шахаж суух, жөндөрийн хувьд зохистой байдлаар өрөө тасалгааны хуваарилалт хийх боломжгүй байдалтай байна.

*Нялх балчир хүүхэдтэй УИХ-ын гишүүдийг УИХ-ын ордон тохирох нөхцөлөөр хэр хангадаг вэ? Жишээлбэл, хөхүүл эхчүүдэд зориулсан тусгай өрөө, хүүхэд асрах газар, эсвэл гэр бүлийн өрөө байдаг уу? УИХ хүүхэд харах үйлчилгээ үзүүлдэг үү? Парламентад ийм дэд бүтэц байх нь хэр чухал вэ?*

Төрийн ордонд нялх балчир хүүхэдтэй УИХ-ын эмэгтэй гишүүдэд зориулсан өрөө, хүүхэд асрах, саатуулах өрөө, гэр бүлийн өрөө, үүнтэй холбоотой ямар нэгэн үйлчилгээ байдаггүй.

*4.5. УИХ-ын ажлын нөхцөл нь УИХ-ын гишүүдэд ажил, гэр бүлийн үүргээ тэнцвэржүүлэх боломжийг олгож байна уу?*

УИХ-ын гишүүний ажил, амралтын цагийг тусгайлан зохицуулаагүй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу УИХ-ын намрын ээлжит чуулган 10 дугаар сарын 01-ний өдрөөс, хаврын ээлжит чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс тус тус эхлэн 75-аас доошгүй ажлын өдөр чуулах ба ээлжит чуулганы чөлөө цагт ээлжит бус чуулган зарлан хуралдуулж болно. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.20-д УИХ-ын гишүүн өвчтэй, чөлөөтэй, дотоод, гадаадад томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдаанд товлосон хугацаанд хүрэлцэн ирж оролцохоор зохицуулсан.

МУИХЧХДТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.8-д “хүндэтгэн үзэх шалтгаантай гишүүнд чөлөө өгнө;” гэж заасны дагуу хуралдаан даргалагч чөлөө өгнө.

УИХ-ын гишүүнд орон нутагт ажиллах албан томилолтыг олгохдоо УИХ-ын даргын 2010 оны 15 дугаар захирамжаар баталсан “Улсын Их Хурлын гишүүнд дотоод албан томилолт олгох журам”-ын дагуу УИХ-ын гишүүн сонгогдсон тойрогтоо ажиллах бол түүний саналыг, Байнгын болон түр, дэд хорооны эрхэлсэн асуудлаар бол тухайн Байнгын болон түр, дэд хорооны даргын баталсан удирдамжийг үндэслэн УИХ-ын дарга олгодог. УИХ-ын гишүүн албаны болон хувийн ажлаар гадаадад явах тухай бүрд зөвшөөрөл хүссэн хүсэлтээ явахаасаа ажлын таваас доошгүй өдрийн өмнө УИХ-ын даргад албан бичгээр ирүүлнэ. УИХ-ын гишүүн гадаадад Улсын Их Хурал, Монголын парламентын бүлгэмийн шугамаар айлчлал хийх, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдын хийх төрийн болон албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох, олон улсын хурал, зөвлөгөөн болон бусад арга хэмжээнд оролцох, өөрийн сонгогдсон тойргийн болон хувийн ажлаар явах, амрах, эмчлүүлэх зорилгоор гадаадад явахад УИХ-ын даргын 2013 оны 10 дугаар захирамжаар баталсан “Монгол Улсын Их Хурлын гишүүн гадаадад явахад мөрдөх журам”-ыг баримтална.

*УИХ-ын гишүүдийн ажиллах цаг нь гэр бүлдээ хангалттай цаг зарцуулах боломжийг олгодог уу?*

УИХ-ын тухай хууль болон МУИХЧХДТХ-д заасны дагуу УИХ-аар дараа 7 хоногийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, дарааллын хуваарийг УИХ-ын даргын дэргэдэх зөвлөлийн саналыг харгалзан УИХ-ын дарга батална.

## УИХ-ын гишүүний 7 хоногийн хуралдааны хуваарь

Хуралдааны 7 хоногийн хуваарь		
<b>Даваа</b>	Нам, эвслийн бүлгийн болон ажлын хэсгийн хуралдаан	<ul style="list-style-type: none"> <li>- “Их эзэн Чингис хаан” танхим</li> <li>- “Жанжин Д.Сүхбаатар” танхим</li> <li>- Баруун жигүүрийн 3 давхрын 334 тоот өрөө</li> </ul>
<b>Мягмар, Лхагва</b>	Байнгын, дэд, түр хороодын хуралдаан	<ul style="list-style-type: none"> <li>- “Их эзэн Чингис хаан” танхим</li> <li>- “Жанжин Д.Сүхбаатар” танхим</li> <li>- “Үндсэн хууль” танхим</li> <li>- “Их засаг” танхим</li> </ul>
<b>Пүрэв, Баасан</b> өглөө 10:00-13:00 үдээс хойш 14:00-18:00 өглөө 09.00 цагаас эхлэн ирцэд бүртгүүлнэ	Нэгдсэн хуралдаан	<ul style="list-style-type: none"> <li>- “Их Хуралдай” танхим</li> </ul>

*УИХ-ын гишүүдэд хүүхэд асран хүмүүжүүлэх чөлөө хангалттай байдаг уу?*

*Хүүхэд асрах, жирэмсний болон амаржсаны амралттай байх үед тухайн гишүүний саналыг хэрхэн авдаг вэ?*

УИХ-ын гишүүдэд хүүхэд асрах чөлөө олгох талаар тусгайлан зохицуулсан хууль байхгүй бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

УИХ-ын гишүүн эмэгтэй хүүхэд асрах, жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаандаа Байнгын болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэрхэн оролцох, хэрхэн санал өгөх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй.

*4.6. Парламентын ордонг барилга байгууламжийн хувьд болон бэлгэдлийн хувьд жендэрийн мэдрэмжтэй ажлын байр гэж үзэж болох уу? Парламентын ажлын байр, тоног төхөөрөмжийн хуваарилалтыг ямар шалгуураар тодорхойлдог вэ?*

Төрийн ордны тухай хуулийн 6.1-т Төрийн ордны дотоод зохион байгуулалт, өрөө, тасалгааны хуваарилалтыг УИХ-ын ЕНБД, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нар санал солилцсоны үндсэн дээр УИХ-ын дэд даргад танилцуулж, ажлын байрны жишиг шаардлагад нийцүүлэн тогтоохоор заасан.

Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” журмыг баримтлан төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, тавилга хэрэгслийн хуваарилалтыг хийдэг. Төрийн ордны албан өрөөний хүрэлцээ дутагдалтай байдгийн улмаас албан өрөөний хуваарилалтад батлагдсан хэмжээсийг дагаж мөрдөх, зохистой хуваарилах боломжгүй байдаг.

УИХ-ын болон түүний Тамгын газрын ажилтнуудын ажлын өрөөний хуваарилалтыг УИХ-ын дэд дарга захирамж гаргаж шийдвэрлэдэг. Ажилтнуудын тоног төхөөрөмжийн хуваарилалтыг дээрх тогтоолоор батлагдсан жагсаалтын дагуу албан хэрэгцээнд зориулан дараах байдлаар хийдэг. Үүнд:

### Нэг. Тэргүүн түшмэл, түүнтэй адилтгах албан тушаалтан

Тавилга, хэрэгслийн төрөл	Тоо ширхэг
1.Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2.Шалны дэвсгэр	1
3.Номын тавиур (ханын шүүгээ)	1
4.Бичгийн ширээ	1
5.Бичгийн ширээний сандал	1
6.Компьютер (иж бүрдэл)	1
7.Зөвлөлгөөний ширээ	1
8.Зөвлөлгөөний ширээний сандал	10
9.Телефон утас	1
10.Тооны машин	1
11.Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1
12.Компьютерийн ширээ	1

Албан ажлын өрөөний талбайн хэмжээ: 36 ам метр хүртэл

### Хоёр. Эрхэлсэн түшмэл болон түүнтэй адилтгах албан тушаалтан

Тавилга, хэрэгслийн төрөл	Тоо ширхэг
1. Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2. Шалны дэвсгэр	1
3. Бичгийн ширээ	1
4. Бичгийн ширээний сандал	1
5. Компьютер (иж бүрдэл)	1
6. Зөвлөлгөөний ширээ	1
7. Зөвлөлгөөний ширээний сандал	10 хүртэл
8. Телефон утас (дотоод холбооны утас орохгүй)	1
9. Тооны машин	1

10. Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1
11. Компьютерийн ширээ	1
12. Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1

Албан ажлын өрөөний талбайн хэмжээ: 24 ам метр хүртэл.

### **Гурав.Ахлах түшмэл /түүнтэй адилтгах албан тушаалтан/**

<b>Тавилга, хэрэгслийн төрөл</b>	<b>Тоо ширхэг</b>
1. Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2. Шалны дэвсгэр	1
3. Бичгийн ширээ	1
4. Бичгийн ширээний сандал	1
5. Компьютер (иж бүрдэл)	1
6. Телефон утас	1
7. Тооны машин	1
8. Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1
9. Компьютерийн ширээ	1
10. Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1

Тайлбар: Нэг ахлах түшмэлд ногдох албан ажлын өрөөний талбай дунджаар 8 ам метр байна. Хэд хэдэн ажилтан нэг өрөөнд суудаг бол дундаа ашиглах телефон утас, нэгдсэн холболт бүхий принтер, хувцасны өлгүүртэй байна.

### **Дөрөв. Дэс түшмэл /түүнтэй адилтгах албан тушаалтан/**

<b>Тавилга, хэрэгслийн төрөл</b>	<b>Тоо ширхэг</b>
1. Хувцасны өлгүүр (шүүгээ)	1
2. Шалны дэвсгэр	1
3. Бичгийн ширээ	1
4. Бичгийн ширээний сандал	1
5. Компьютер (иж бүрдэл)	1
6. Телефон утас	1
7. Тооны машин	1
8. Сэтгүүлийн ширээ (утасны тавиур)	1
9. Компьютерийн ширээ	1
10. Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1

Тайлбар: Нэг дэс түшмэлд ногдох албан ажлын өрөөний талбай дунджаар 8 ам метр байна. Хэд хэдэн ажилтан нэг өрөөнд суудаг бол дундаа ашиглах телефон утас, нэгдсэн холболт бүхий принтер, хувцасны өлгүүртэй байна.

*Парламентын ажлын өрөөнүүдийн нэрс эрэгтэй, эмэгтэй гишүүдийг адилхан тусгасан байдаг уу? Энэ талаар шийдвэр гаргах үүрэгтэй албан тушаалтан хэн бэ?*

УИХ-ын гишүүдийн ажлын өрөөний хаяг, нэрсийг бичихэд ямар нэгэн ялгаварлалт байхгүй бөгөөд ижил стандартаар бичигдэнэ. УИХ-ын Тамгын газрын хэвлэх цехэд гишүүдийн ажлын өрөөний хаяг, нэрс болон гишүүдийн нэрийн хуудас, албан бланкны бичилтийг нэг ижил стандартаар хэвлэдэг.

*Барилгад тавигдсан уран бүтээлийг эмэгтэй, эрэгтэй зураачдад адил тэгш захиалж хийлгэсэн үү?*

Төрийн ордонд нийт 27 зураг байдаг бөгөөд эдгээрийг нийт 30 зураач зурснаас 2 нь нь хамтарсан уран бүтээл байна. Эдгээр зурагнуудаас 29 нь эрэгтэй, 1 нь эмэгтэй зураачийн уран бүтээл байна. Бүтээлийн агуулгын хувьд ихэвчлэн аж байдлын, өв соёлын, байгалийн дүрслэлтэй зураг байгаа бөгөөд Тэнгэрийн ташуур-Чингис хаан, Эртний сайхан Ану хатан, Д.Сүхбаатар, Анд хэмээх Монголын төрт ёсны бахархлыг харуулсан 4 хөрөг зураг байна.

### **Төрийн ордонд уран бүтээлээ байршуулсан зураачдын нэрс**

№	Уран бүтээлчийн нэр	Зургийн нэр	Огноо
1	Н.Лхагвасүрэн	Хан төрийн долоон эрдэнэ	1998
2	Ц.Даваахүү	Монгол зураг	1986
3	Д.Төртогтох, Ц.Нарангэрэл	Бурхан Халдун	2009
4	Д.Эрдэнэбилэг	Тэнгэрийн ташуур- Чингис хаан	1998
5	Д.Эрдэнэбилэг	Эртний сайхан Ану хатан	1998
6	Д.Төртогтох	Чулуун шигтгэмэл	2009
7	Ё.Өлзийхутаг	Д.Сүхбаатар	1996
8	Ш.Чинбат	Өвөлжөө	1994
9	Н.Содном	Нүүдэл	1997
10	Н.Даваахүү	Дархан цаазат ан амьтад	1998
11	Н.Даваахүү	Үндэсний дуу бүжиг	1998
12	М.Цэмбэлдорж	Отгонтэнгэр	1996
13	Довчин	Орхоны хүрхрээ	1961
14	М.Цэмбэлдорж	Түмэн эх	1996



15	О.Дарамбазар	Хүрмэн цав	1994
16	Г.Ичинноров	Хөвсгөл нуур	1998
17	Дүйхэржав	Дэлхийг амлая	1995
18	Д.Болд	Сутай хайрхан	1997
19	Г.Дунбүрээ	Цамбагарав хайрхан	1997
20	Ц.Амгалан	Бага богд	1986
21	Г.Төмөрбаатар	Тэрхийн цагаан нуур	1997
22	О.Дарамбазар	Амарбаясгалант хийд	1997
23	Ш.Чинбат	Орхоны намар	1994
24	Ш.Чинбат	Өвөлжөө	1994
25	Т.Оросоо	Анд	1961
26	Н.Амгаланбаатар	Дөрвөн улирлын өнгө	2009
27	Б.Гомбосүрэн, Г.Батчулуун, Д.Болд	Манай эх орон туурган хивс	1986

Эх сурвалж: УИХТГ-ын Санхүү, хангамж, үйлчилгээний хэлтэс

#### 4.7. УИХ-д ажлын байранд ялгаварлан гадуурхах, хүйсээр ялгаварлах, дарамтаас сэргийлэх бодлого бий юу?

УИХ-д ажлын байранд ялгаварлан гадуурхах, хүйсээр ялгаварлах, дарамтаас сэргийлэх бодлогын ямар нэгэн баримт бичиг байхгүй.

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэмд зааснаар УИХ-ын гишүүн Төрийн ёслол, хүндэтгэлийн журам болон Төрийн ордны дэг журмыг чанд баримтлахаас гадна УИХ-ын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны танхимд биеэ зөв авч явах үүрэгтэй ба бусдыг ялгаварлан гадуурхах, зохисгүй үйлдэл гаргахыг хориглосон.

#### Ёс зүйн дүрэм байдаг уу? Үүнийг парламентад зохистой ёс зүйг хангахад үр дүнтэй ашиглаж чадаж байна уу? Ёс зүйн дүрэм хэрхэн жендэрийн мэдрэмжтэй болох вэ?

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийг анх 2009 онд баталж, 2021 онд шинэчлэн баталсан. Энэхүү дүрэмд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан гишүүний бүрэн эрх, гишүүний бүрэн эрхийн баталгаа, гишүүн хавсран гүйцэтгэж болох ажил, албан тушаал, гишүүнд хориглох үйл ажиллагаа, МУИХЧХДТХ-д заасан хуралдааны дэгтэй холбоотой зохицуулалт, хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлага зэрэг гишүүний ёс зүйн хэм хэмжээ, шаардлага, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан.

*Ажлын байрны дарамттай тэмцэх бодлого, дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг шийдвэрлэх механизм бий юу? Өргөдөл гомдлыг үр дүнтэй шийдвэрлэж чаддаг уу?*

Ажлын байрны дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгайлсан зохицуулалт байхгүй. Харин УИХ-ын гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэмд зааснаар шийдвэрлэнэ.

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэмд зааснаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо нь гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой дараах гомдол, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авна: Үүнд:

- УИХ-ын даргын нэр дээр иргэд, хуулийн этгээдээс гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой бичгээр ирүүлсэн гомдол, мэдээлэл;
- БХ-нд иргэн, хуулийн этгээдээс бичгээр ирүүлсэн гомдол, мэдээлэл;
- авлига, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл гишүүн Байнгын хороонд шалгуулахаар бичгээр хандсан хүсэлт;
- УИХТГ-аас гаргасан мэдээ, тайлан.

БХ-ны гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль УИХ-ын гишүүний ёс зүйн дүрмийн дагуу хянан шийдвэрлэнэ. Гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Байнгын хорооны дарга хүлээн авч Байнгын хорооны аль нэг гишүүнд хянуулахаар шилжүүлэх бөгөөд шалгалтын явцад гишүүний ёс зүйн зөрчлийн шинж байдал нь ёс зүйн хариуцлага тооцохооргүй бол шалгалтын дүнг үндэслэн Байнгын хорооны дарга тухайн гишүүнийг дуудаж уулзан зөвлөгөө өгнө.

Шалгалтын явцад гомдол, мэдээлэлд дурдсан гишүүний ёс зүйн зөрчлийн асуудлыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзвэл шалгалтын дүнг БХ-ны даргад танилцуулах ба дараах тохиолдолд БХ-ны хуралдаанд оруулж, хэлэлцүүлнэ. Үүнд:

- Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.25-д заасан хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрэн эрхийн хугацаанд зохих журмын дагуу 2 ба түүнээс дээш удаа үнэн зөв гаргаж өгөөгүй бол;
- МУИХЧХДТХ-ийн 18.1-д заасан хариуцлагыг хуралдаан даргалагчаас тухайн жилд 3 ба түүнээс дээш удаа ногдуулсан бол;
- хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг тухайн жилд хуралдааны /цахим/ ирцэд бүртгүүлсэн дүнгээр хоцорсон буюу тасалсан цаг нь ажлын 5 өдрийн цагаас дээш гарсан бол.

2020 оноос хойш Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд УИХ-ын гишүүний ёс зүйтэй холбоотой 14 (үүнээс УИХ-ын эмэгтэй гишүүн 1) өргөдөл, гомдол ирүүлснийг тухай бүр нь тайлбар авч, холбогдох байгууллагуудад шилжүүлжээ.

*4.8. УИХ-ын гишүүдийн зорчих боломжийг ямар шалгуураар тодорхойлдог вэ?*

*Энэ нь эрэгтэй, эмэгтэй парламентын гишүүдэд тэгш хуваарилагддаг гэдэгтэй санал нэг байна уу? Хэрэв тийм биш бол шударга хуваарилалтад юу саад болж байна вэ?*

УИХ-ын гишүүн нь албан болон хувийн ажлаар гадаадад зорчих тухай бүрдээ УИХ-ын даргаас зөвшөөрөл авах бөгөөд УИХ-ын дарга холбогдох хууль тогтоомжийг үндэслэн захирамж гаргана.

Хэрэв УИХ-ын гишүүн айлчлалын бүрэлдэхүүнд орохыг хүсвэл УИХ-ын даргатай урьдчилан хүсэлтээ тавьж зөвшилцөх бөгөөд УИХ-ын дарга айлчлалын бүрэлдэхүүнд орох УИХ-ын гишүүнийг томилж захирамж гаргана. Харин УИХ-ын даргын албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тухай улсын парламенттэй харилцах бүлгийн дарга, гишүүдээс голчлон оруулах зарчим баримталдаг. УИХ-ын гишүүн гадаад айлчлал хийхэд “УИХ-ын гишүүн гадаадад явахад мөрдөх журам”-ыг баримтална.

*4.9. Парламентын харилцаа холбоо (эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл) болон олон нийттэй харилцах бодлого нь жендэрийн мэдрэмжтэй, жендэрийн хувьд төвийг сахисан эсвэл жендэрийн хувьд алсын хараа муутай байдаг уу?*

*Эдгээр бодлогод парламентын жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг хэрхэн илүү сайн тусгаж харуулах вэ?*

ХМОНХГ-аас олон нийтэд түгээх мэдээллийг жендэрийн ялгаваргүйгээр нийтлэг байдлаар түгээдэг бөгөөд үүнийг хянах, зохицуулах албан ёсны батлагдсан дүрэм, журам байдаггүй.

*Парламентын бэлтгэсэн харилцаа холбооны (хэвлэл мэдээлэл) материалыг жендэрийн үүднээс хянаж, аудит хийж байсан уу? Шалгалтанд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан тогтоосон харилцаа холбоо орсон уу?*

УИХ-ын даргын Ажлын алба, УИХТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах нэгжээс бэлтгэсэн хэвлэлийн мэдээ, материалыг жендэрийн үүднээс хянах, аудит хийх дүрэм журам, тогтолцоо байхгүй. Мэдээллийг нийтлэг байдлаар ямар нэгэн ялгаваргүйгээр олон нийтэд түгээдэг.

*Парламентад олон нийтийг хамарсан арга хэмжээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэнцүү оролцдог уу?*

УИХ, түүний Тамгын газраас Зөвлөлдөх санал асуулга, хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг, нээлттэй сонголт, эрдэм шинжилгээний хурал, семинар, сургалт, сонгогчидтой уулзалт хийх, хууль сурталчлах өдөрлөг зэрэг олон нийтийг хамарсан олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг. Эдгээр арга хэмжээнд олон нийтийг оролцуулахад жендэрийн хувьд ямар нэгэн хязгаарлалт тавьдаггүй.

Гэвч сүүлийн жилүүдэд парламентаас зохион байгуулж буй арга хэмжээнд аль болохоор хүйсийн тэнцвэрт байдлыг хангахыг эрмэлзэж байгаа бөгөөд оролцогчдын бүртгэлийг хүйсээр ангилан гаргаж байна. Тухайлбал:

- 2023 оны 02 дугаар сард зохион байгуулсан “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулсан. Тус санал асуулгын 2 дахь шатны санал асуулгад оролцсон 795 иргэн оролцсон бөгөөд оролцогчдын 53.8 хувь нь эмэгтэйчүүд, 46.2 хувь нь эрэгтэйчүүд байсан.
- Тамгын газраас зохион байгуулж буй сургалт, семинарт оролцогчдын хүйсийн ялгавартай бүртгэлийг хийж хэвшүүлж байна.

Хавсралт-1. УИХ-ын 2020 оны сонгуулийн дүнгийн мэдээлэл

№	Тойргийн дугаар	Мандатын тоо	Аймаг, дүүргийн нэр	Нэр дэвшүүлсэн субъект	Нэр дэвшигчийн эцэг /эхийн/ нэр, өөрийн нэр	Хүйс
1	1	3	Архангай	Монгол Ардын Нам	Ё.БААТАРБИЛЭГ	эр
2				Монгол Ардын Нам	Ж.МӨНХБАТ	эр
3				Монгол Ардын Нам	Г.ТЭМҮҮЛЭН	эр
4	2	3	Баян-Өлгий	Монгол Ардын Нам	Х.БАДЕЛХАН	эр
5				Монгол Ардын Нам	Т.АУБАКИР	эр
6				Ардчилсан Нам	Б.БЕЙСЕН	эр
7	3	3	Баянхонгор	Монгол Ардын Нам	Г.ЗАНДАНШАТАР	эр
8				Ардчилсан Нам	Д.ГАНБАТ	эр
9				Ардчилсан Нам	А.АДЪЯАСҮРЭН	эм
10	4	2	Булган	Монгол Ардын Нам	Ц.АНАНДБАЗАР	эр
11				Монгол Ардын Нам	Ж.БАТ-ЭРДЭНЭ	эр
12	5	2	Говь-Алтай	Монгол Ардын Нам	Б.ЭНХ-АМГАЛАН	эр
13				Монгол Ардын Нам	Ш.РАДНААСЭД	эр
14	6	2	Дундговь, Говьсүмбэр	Монгол Ардын Нам	С.БАТБОЛД	эр
15				Монгол Ардын Нам	Г.МӨНХЦЭЦЭГ	эм
16	7	2	Дорнод	Монгол Ардын Нам	Х.БОЛОРЧУЛУУН	эр
17				Монгол Ардын Нам	Ц.СЭРГЭЛЭН	эр
18	8	2	Дорноговь	Монгол Ардын Нам	Б.ДЭЛГЭРСАЙХАН	эр
19				Монгол Ардын Нам	Т.ЭНХТҮВШИН	эр

20	9	2	Завхан	Монгол Ардын Нам	Ц.ЦЭРЭНПУНЦАГ	эр
21				Монгол Ардын Нам	Б.БАЯРСАЙХАН	эм
22	10	3	Өвөрхангай	Монгол Ардын Нам	С.ЧИНЗОРИГ	эр
23				Монгол Ардын Нам	Д.ТОГТОХСҮРЭН	эр
24				Монгол Ардын Нам	Г.ГАНБОЛД	эр
25	11	2	Өмнөговь	Монгол Ардын Нам	Н.НАРАНБААТАР	эр
26				Ардчилсан Нам	Д.БАТ-ЭРДЭНЭ	эр
27	12	2	Сүхбаатар	Ардчилсан Нам	Ж.БАТСУУРЬ	эр
28				Ардчилсан Нам	Н.ГАНИБАЛ	эр
29	13	3	Сэлэнгэ	Монгол Ардын Нам	Ж.ЭРДЭНЭБАТ	эр
30				Монгол Ардын Нам	Ч.УНДРАМ	эм
31				Монгол Ардын Нам	Д.ӨНӨРБОЛОР	эм
32	14	3	Төв	Монгол Ардын Нам	Ж.БАТЖАРГАЛ	эр
33				Ардчилсан Нам	Ц.ТУВААН	эр
34				Монгол Ардын Нам	Н.ЭНХБОЛД	эр
35	15	3	Увс	Ардчилсан Нам	О.ЦОГТГЭРЭЛ	эр
36				Монгол Ардын Нам	Ч.ХҮРЭЛБААТАР	эр
37				Монгол Ардын Нам	Б.ЧОЙЖИЛСҮРЭН	эр
38	16	3	Ховд	Ардчилсан Нам	Ш.АДЬШАА	эр
39				Ардчилсан Нам	Б.ПҮРЭВДОРЖ	эр
40				Монгол Ардын Нам	С.БЯМБАЦОГТ	эр
41	17	3	Хөвсгөл	Монгол Ардын Нам	Ц.ДАВААСҮРЭН	эр
42				Монгол Ардын Нам	Л.МӨНХБААТАР	эр
43				Монгол Ардын Нам	Л.ЭНХ-АМГАЛАН	эр

44	18	3	Хэнтий	Монгол Ардын Нам	У.ХҮРЭЛСҮХ Ц.ИДЭРБАТ	эр
45				Монгол Ардын Нам	Л.ОЮУН-ЭРДЭНЭ	эр
46				Монгол Ардын Нам	Б.БАТ-ЭРДЭНЭ	эр
47	19	3	Дархан-Уул	Монгол Ардын Нам	Б.ЖАВХЛАН	эр
48				Монгол Ардын Нам	Г.ДАМДИННЯМ	эр
49				Монгол Ардын Нам	Б.БАТТӨМӨР	эр
50	20	3	Орхон	Монгол Ардын Нам	Д.БАТЛУТ	эр
51				Бие даан нэр дэвшигч	Н.АЛТАНХУЯГ	эр
52				"ТА БИДНИЙ ЭВСЭЛ" /МАХН-ИЗНН-МУНН/	С.ГАНБААТАР	эр
53	21	2	Багануур, Багахангай, Налайх дүүрэг	Монгол Ардын Нам	С.АМАРСАЙХАН	эр
54				Монгол Ардын Нам	Ц.САНДАГ-ОЧИР	эр
55	22	2	Баянзүрх дүүрэг	Монгол Ардын Нам	Б.ЭНХБАЯР	эр
56				Монгол Ардын Нам	Б.САРАНЧИМЭГ	эм
57	23	3	Баянзүрх дүүрэг	Монгол Ардын Нам	Ж.ЧИНБҮРЭН	эр
58				Монгол Ардын Нам	Х.БУЛГАНТУЯА	эм
59				Монгол Ардын Нам	Э.БАТ-АМГАЛАН	эр
60	24	3	Сүхбаатар дүүрэг	Монгол Ардын Нам	Д.ЦОГТБААТАР	эр
61				Монгол Ардын Нам	Ц.МӨНХ-ОРГИЛ	эр
62				Монгол Ардын Нам	Ц.МӨНХЦЭЦЭГ	эм
63	25	3	Чингэлтэй дүүрэг	Монгол Ардын Нам	Т.АЮУРСАЙХАН	эр
64				Монгол Ардын Нам	М.ОЮУНЧИМЭГ	эм
65				Монгол Ардын Нам	Ж.СҮХБААТАР	эр

66	26	3	Баягол дүүрэг	Монгол Ардын Нам	Х.ГАНХУЯГ	эр
67				Монгол Ардын Нам	Ж.ГАНБААТАР	эр
68				Ардчилсан Нам	С.ОДОНТУЯА	эм
69	27	2	Сонгинохайрхан дүүрэг	Монгол Ардын Нам	Х.НЯМБААТАР	эр
70				Монгол Ардын Нам	Б.ЖАРГАЛМАА	эм
71	28	3	Сонгинохайрхан дүүрэг	Монгол Ардын Нам	Н.УЧРАЛ	эр
72				Монгол Ардын Нам	Д.СУМЪЯАБАЗАР Э.БАТШУГАР	эр
73				Монгол Ардын Нам	П.АНУЖИН	эм
74	29	3	Хан-Уул дүүрэг	Монгол Ардын Нам	Г.АМАРТҮВШИН	эр
75				Монгол Ардын Нам	Д.САРАНГЭРЭЛ	эм
76				"ЗӨВ ХҮН ЭЛЕКТОРАТ" эвсэл	Т.ДОРЖХАНД	эр



Хавсралт-2. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬАЛАЛ  
/2023.10.23-ны өдрийн байдлаар/

№	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо	Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо	Илоовч, нахам бодлогын байнгын хороо	Нийгмийн бодлогын байнгын хороо	Төрийн байгууллагын байнгын хороо	Төсвийн байнгын хороо	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо	Хууль зүйн байнгын хороо	Эдийн засгийн байнгын хороо
1	Б.Энх-Амгалан	Б.Саранчимэг	Г.Мөнхлэнцэг	Б.Батгомөр	Э.Батшүгар	П.Амужин	Н.Энхболд	Г.Тэмүүлэн	Т.Энхтүвшин	Д.Цогтбаатар	Ц.Цэрэнпунцаг
2	Г.Амартүвшин	Ц.Ананлбазар	А.Алъяасүрэн	Ш.Алшаа	Э.Бат-Амгалан	Д.Бэлдүт	С.Амарсайхан	Г.Амартүвшин	А.Алъяасүрэн	Ш.Алшаа	Д.Бэлдүт
3	Н.Алтанхуяг	Т.Аубакир	П.Амужин	Х.Балелхан	Х.Ганхуяг	Б.Баярсайхан	Б.Алъяасүрэн	Ц.Ананлбазар	Н.Алтанхуяг	Н.Алтанхуяг	Б.Батгомөр
4	П.Амужин	Ж.Бат-Эрдэнэ	Т.Аубакир	Б.Баярсайхан	Н.Ганбал	Б.Бейсен	Б.Баярбилэг	Х.Булгантуяа	Т.Аубакир	С.Бямбацогт	Д.Бат-Эрдэнэ /Бүрэн эрхийг түдгэлзүүлсэн/
5	Т.Авурсайхан /Бүрэн эрхийг түдгэлзүүлсэн/	Ж.Батжаргал	Б.Баатарбилэг	Б.Бат-Эрдэнэ	Т.Доржханд	Х.Булгантуяа	Ж.Батсуурь	Ж.Батжаргал	Ж.Бат-Эрдэнэ	Д.Ганбат	Ж.Бат-Эрдэнэ
6	Б.Батгомөр	Х.Болорчулуун	Б.Баярсайхан	С.Бямбацогт	Ц.Идэрбат	С.Ганбат	С.Бямбацогт	Х.Балелхан	Ж.Батжаргал	Б.Дэлгэрсайхан	Ж.Ганбат
7	Х.Балелхан	Б.Бейсен	Э.Батшүгар	Х.Бейсен	Ц.Сэргэлэн	Ц.Идэрбат	Г.Ганболд	Ж.Батсуурь	Д.Бэлдүт	Ц.Мөнхлэнцэг	Н.Ганбал
8	С.Батболд	Г.Ганболд	Х.Ганхуяг	Л.Энх-Амгалан	Б.Саранчимэг	М.Оюунчимэг	М.Доржханд	С.Ганбат	Г.Ганболд	Ц.Мөнх-Оргил	Х.Ганхуяг
9	Э.Бат-Амгалан	Н.Ганбал	Г.Дамдинням	Б.Энхбаяр	Н.Учрал	Ц.Салдаг-Очир	Г.Занданшатар	Ц.Даваасүрэн	С.Ганбат	Л.Мөнхбаатар	Ц.Даваасүрэн
10	Б.Бат-Эрдэнэ	Г.Дамдинням	Б.Жаргалмаа	Н.Энхболд	Ч.Ундрам	Д.Сарангэрэл	Ц.Мөнх-Оргил	Б.Жавхлан	Г.Дамдинням	Э.Бат-Амгалан	Т.Доржханд
11	Д.Бат-Эрдэнэ /Бүрэн эрхийг түдгэлзүүлсэн/	Ц.Идэрбат	Ц.Мөнхлэнцэг	Н.Энхболд	Ж.Чинбүрэн	Б.Саранчимэг	Ц.Мөнхлэнцэг	Л.Мөнхбаатар	Н.Наранбаатар	Б.Пүрэвдорж	Б.Жавхлан
12	Д.Ганбат	Г.Мөнхлэнцэг	Ж.Чинбүрэн	Ж.Чинбүрэн	Ц.Мөнх-Оргил	М.Оюунчимэг	М.Оюунчимэг	С.Одонтуяа	О.Цогтгэрэл	Ш.Раднаасэд	М.Оюунчимэг
13	Б.Дэлгэрсайхан	Н.Наранбаатар	Ч.Ундрам	Ч.Ундрам	С.Одонтуяа	Д.Оюун-Эрдэнэ	Д.Оюун-Эрдэнэ	Д.Өнөрболор	Ш.Раднаасэд	Ц.Салдаг-Очир	Д.Өнөрболор
14	Н.Наранбаатар	Д.Өнөрболор	Н.Учрал	Н.Учрал	Б.Жаргалмаа	Б.Пүрэвдорж	Б.Пүрэвдорж	Б.Пүрэвдорж	Г.Тэмүүлэн	Ж.Сүхбаатар	Ч.Ундрам
15	Ц.Сэргэлэн	С.Чинзориг	С.Чинзориг	С.Чинзориг	Ц.Туваан	Д.Сарангэрэл	Д.Сарангэрэл	Ц.Салдаасэд	Ц.Туваан	Ц.Сэргэлэн	Ч.Хүрлбаатар
16	Цогтбаатар	Ц.Туваан	Л.Энх-Амгалан	Л.Энх-Амгалан	С.Чинзориг	Ж.Сүхбаатар	Ж.Сүхбаатар	Ц.Салдаг-Очир	Ж.Эрэнлэнбат	Н.Учрал	О.Цогтгэрэл
17	Н.Энхболд	О.Цогтгэрэл	О.Цогтгэрэл	Ж.Чинбүрэн	Ж.Чинбүрэн	Д.Тогтохсүрэн	Д.Тогтохсүрэн	Д.Тогтохсүрэн	Д.Тогтохсүрэн	Б.Энхбаяр	С.Чинзориг
18	Ж.Эрэнлэнбат	Ц.Цэрэнпунцаг	Ц.Цэрэнпунцаг	Ж.Эрэнлэнбат	Ж.Эрэнлэнбат	Ч.Хүрлбаатар	Ж.Эрэнлэнбат	Ч.Хүрлбаатар	Б.Энх-Амгалан	Б.Энх-Амгалан	Б.Энхбаяр
19	С.Одонтуяа	Т.Энхтүвшин	Т.Энхтүвшин	Т.Энхтүвшин	Б.Жаргалмаа	Б.Чойжилсүрэн	Б.Жаргалмаа	Б.Чойжилсүрэн	Г.Амартүвшин	Г.Амартүвшин	Т.Энхтүвшин

**ДЭД ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬАЛАЛ**

№	Тусгай хяналтын дэд хороо	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо	Нутгийн удирдлагын дэд хороо	Улсын Их Хурлын халдлагын байдлын дэд хороо	Сонгогчийн ирсэйн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо	Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэд хороо	Хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо	Хүнд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо	Хүний эрхийн дэд хороо	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо
1	С.Батболд	Г.Ганболд	Б.Баатарбилэг	Ц.Мөнх-Оргил С.Батболд	Г.Ганболд Ц.Мөнх-Оршил	Б.Пүрэвдорж Г.Амаргүвшин	Ж.Бат-Эрдэнэ А.Адъяасүрэн	Ц.Анаулбазар А.Адъяасүрэн	Г.Тэмүүлэн Ц.Анаулбазар	Ц.Мөнхпилэг Ш.Алшаа	Х.Булгантуяа Б.Батгомөр
2	Н.Алтанхуяг	Т.Аубакир	Ж.Батсуурь	С.Батболд	Ц.Мөнх-Оршил	Г.Амаргүвшин	А.Адъяасүрэн	Ц.Анаулбазар	Г.Тэмүүлэн	Ц.Мөнхпилэг	Х.Булгантуяа
3	Т.Аюурсайхан /Бүрэн эрхийг түдгэлзүүлсэн/	Г.Дамдинням	Г.Ганболд	Б.Бат-Эрдэнэ	Ж.Батсуурь	Ц.Анаулбазар	Ж.Батжаргал	Т.Аубакир	Н.Наранбаатар	Н.Алтанхуяг	Д.Бат-Эрдэнэ /Бүрэн эрхийг түдгэлзүүлсэн/
4	Д.Бат-Эрдэнэ /Бүрэн эрхийг түдгэлзүүлсэн/	Б.Саранчимэг	Ж.Сүхбаатар	С.Бямбацогт	Ж.Батжаргал	Ж.Батжаргал	Д.Батлуг	Ш.Раднаасэд	Ц.Туваан	Д.Ганбат	Н.Ганбал
5	Б.Дэлгэрсайхан	Ц.Туваан		Н.Энхболд		Ж.Батсуурь	Г.Ганболд	Г.Тэмүүлэн	О.Цогтэрэл	Ш.Раднаасэд	Х.Ганхуяг
6	Ц.Сэргэлэн					Х.Булгантуяа	С.Ганбаатар	Ц.Туваан	Т.Энхтүвшин	Ц.Сандаг-Очир	Т.Доржсанд
7	Б.Энх-Амгалан					С.Ганбаатар	Т.Энхтүвшин			Ж.Сүхбаатар	Б.Жавхлэн
8	Б.Батгомөр					Г.Тэмүүлэн	Ж.Эрдэнэбат			Н.Учрал	
9	Д.Ганбат									Б.Энхбаатар	

**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗАР**

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
- Улс төрийн намын тухай хууль
- Засгийн газрын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Монгол Улсын Төрийн ордны тухай хууль
- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө
- Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө
- Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын стратеги төлөвлөгөө /2020-2024/
- Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой иргэд, зочид, төлөөлөгчдийг танилцуулах журам
- Улсын Их Хурлын 2011 оны 59 дүгээр тогтоол (Монгол Улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр)
- Улсын Их Хурлын 2011 оны 59 дүгээр тогтоол (Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр)
- Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоол (“Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай”)
- УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ийн бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлал

### Ном, гарын авлага

- “Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орны туршлага” судалгааны тайлан, Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан ТББ. 2022 он

- “Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт бас сорилт, сургамж”, ХНХЯ, ЖҮХ, АХБ, УБ хот., 2019 он
- Бүх түвшний төлөөллийн институцэд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх боломж, арга зам судалгаа, ОТИС, 2023
- Монгол дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, гадаад орнуудын туршлага-судалгааны тайлан, KOICA, UNDP, LEOS, 2022 он
- Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа, ШХА, IRIM, 2014 он
- Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа, Швейцарын Хөгжлийн Агентлаг, IRIM судалгааны хүрээлэн
- Байнгын ажиллагаатай парламент-30, УИХ, 2020
- Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, ЖҮХ, UNFPA, MMCG, 2021
- Монгол Улсын Засгийн газрын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх ээлжит илтгэлийг хэлэлцсэн дүгнэлт, 2022 он
- Байнгын ажиллагаатай парламентын Тамгын газар 1990-2020, УБХ, УИХ, 2020
- Монгол Улсын Их Хурлын түүхэн товчоон 2016-2020, УИХТГ, 2020
- Монголын Улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин-дүн шинжилгээ, санал зөвлөмж, ННФ, IDEA, 2018
- МУҮХ-д оруулах өөрчлөлтийн төслийн танилцуулга, мэдээлэл, лавлагаа, УИХТГ, 2023
- Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
- УИХТГ-ын ХШҮГ-ийн Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний танилцуулга, 2023 он
- Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтийг үнэлэх судалгааны тайлан, ХЭҮК, Социологийн боловсрол төв, УБ, 2022 он.
- Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал, МУХЭҮК, KOICA, UNDP, 2023
- Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл судалгааны тайлан, SPDR1, KOICA, UNDP, GENDER EQUALITY, 2022

### Цахим хуудас

- Улсын Их Хурал <https://www.parliament.mn/nn/16430/>
- Жендэрийн үндэсний хороо [www.gender.gov.mn](http://www.gender.gov.mn)
- Олон улсын парламентын холбоо <https://www.ipu.org/impact/gender-equality>

**ХҮНИЙ ЭРХИЙН МЭДРЭМЖТЭЙ ПАРЛАМЕНТЫН  
ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТОЙМ СУДАЛГАА:  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

*Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, Э.Дашзэвэ*

**АГУУЛГА**

**УДИРТГАЛ**

**СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ**

- Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаа
- Парламентын хяналтыг бэхжүүлэх
- Парламентын зүгээс НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд оролцох оролцоог нэмэгдүүлэх нь
- Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь

**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АБГББХ	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
БОХХААБХ	Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо
БСШУБХ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
ЁЗСХБХ	Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо
ЕНБД	Ерөнхий нарийн бичгийн дарга
ЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББХ	Нийгмийн бодлогын байнгын хороо
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУПХ	Олон улсын парламентын холбоо
ӨБХ	Өргөдлийн байнгын хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ТБХ	Төсвийн байнгын хороо
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын Их Хурал
УИХТГ	Улсын Их Хурлын Тамгын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮББХ	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХШҮГ	Хяналт шинжилгээ, үнэлгээний газар
ХҮЭК	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЭДХ	Хүний эрхийн дэд хороо
ХЭЗГ	Хууль, эрх зүйн газар
ХЭНБҮ	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ
ХЭХҮХ	Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо
ЭЗДШХ	Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс

## УДИРТГАЛ

Олон Улсын Парламентын Холбоо (ОУПХ) нь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын зарчим, хэм хэмжээ, механизмыг улс орнуудын парламент хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлэхэд зориулсан парламентын өөрийн үнэлгээний аргачлалыг НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар (ХЭДКГ) болон бусад байгууллагуудтай хамтран боловсруулж, үе шаттайгаар хэрэглээнд нэвтрүүлж байна.

Энэ хүрээнд ОУПХ-ны боловсруулсан аргачлалын хүрээнд хүний эрхийн болон жендэрийн мэдрэмжийн асуудлаарх 2 төрлийн үнэлгээг хамтатган Монгол Улсын парламент, ажлын алба зохион байгуулав.

Хүний эрхийн өөрийн үнэлгээний аргачлал нь хүний эрх болон Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ) хоорондын уялдаа холбоонд тулгуурлан олон улсын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжийг харгалзан үзэхэд нь парламентад дэмжлэг үзүүлэх зорилготой. Улсын Их Хурал, түүний Тамгын газарт хийх хүний эрхийн өөрийн үнэлгээ нь олон улсад энэ чиглэлээр хийгдэх анхны үнэлгээ болсон.

ОУПХ-ны 2022-2026 оны стратегид заасны дагуу парламентуудын нийтлэг ашиг сонирхлыг хангах чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх үндэс суурийг тавих зорилгоор 2022 оны 08 дугаар сард ОУПХ болон Монгол Улсын Их Хурал харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Энэ хамтын ажиллагаа нь хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бүрдүүлэх замаар парламентын шийдвэр, үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад чиглэнэ. Хүний эрх, жендэрийн асуудал нь Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилго 3-т “Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, парламентад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх.” бодлогын зорилгод хамаарах юм.

### **Судалгааны зорилго:**

Монгол Улс дахь хүний эрх, тэгш байдлын талаарх тойм судалгаа, мэдээлэл бэлтгэх. Тойм судалгааг Өөрийн үнэлгээний дагуу дараах үндсэн асуултуудын хүрээнд гаргав. Үүнд:

- Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаа
- Парламентын хяналтыг бэхжүүлэх
- Парламентын зүгээс НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд оролцох оролцоог нэмэгдүүлэх нь
- Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь.

**АСУУЛТ 2: Хүний эрхийг дэмжих талаар хууль тогтоомж гаргаж байгаа юу? (Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагаа)**

2.1. Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг үнэлж дүгнэх, эсхүл эрх зүйн шинэчлэлийг санаачлах эрх парламентад бий юу?

2.2. Хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколыг Засгийн газар соёрхон баталсан эсэхийг парламент тогтмол үнэлж дүгнэдэг үү? Хэрэв тийм бол, тухайн улс эдгээр олон улсын механизм, арга хэлбэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа алхмыг хийсэн үү?

2.3. ХЭҮК байдаг уу? Хэрэв байдаг бол өнөөгийн байдлаар Парисын зарчмыг хэр хэмжээнд дагаж мөрдөж байгаа вэ?

2.4. Улс орны эрх зүйн тогтолцоо, үндэсний бодлого болон үйл ажиллагаа нь ардчилсан орон зайг хэр зэрэг хамгаалж, иргэний нийгмийг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх боломжоор хангадаг вэ?

2.5. Парламент аливаа ялгаварлан гадуурхалд хамгийн их өртөж болзошгүй тодорхой бүлгүүдийн талаар болон эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалахтай холбоотой Системийн сорилтуудын талаар мэддэг үү?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Парламент хүний эрхийн талаар тодорхой зохицуулалт бүхий хууль тогтоомж батлах буюу нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх, мөн бүс нутгийн/ олон улсын хүний эрхийн гэрээг баталсан уу? Хэрэв ийм хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол эдгээр нэмэлт, өөрчлөлт нь батлагдсан уу?
- Хүний эрхийн гэрээ, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан уу?
- Парламент эмзэг бүлгийн иргэдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах зорилготой хууль тогтоомжид үнэлгээ хийх, эсхүл баталсан уу?

**АСУУЛТ 3: Парламентын хяналтыг бэхжүүлэх нь**

3.1. Танай улсад хүний эрхийн үндэсний хэмжээний хөтөлбөр, стратеги байгаа юу?

3.2. Танай улсын Үндсэн хууль, эсхүл бусад хууль тогтоомжоор парламент нь асуулга авах, сонсгол хийх, тодруулга авах, газар дээр нь очиж үзэх



зэргээр засгийн газрын хариуцлагын тогтолцоог сайжруулж чадаж байна уу?

3.3. Парламент хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүний эрхийн үр нөлөөг дүгнэх, үнэлэх журам, аргачлалыг боловсруулсан уу? Үүнд тодорхой эмзэг бүлгийн хувьд ялгаварлан гадуурхлын үр нөлөөг бий болгож болзошгүй хуулиудад хийх үнэлгээ дүгнэлт мөн багтдаг уу?

3.4. Олон улсын хүний эрхийн ямар гэрээнд танай улс нэгдэн ороогүй байгаа вэ? Танай улс нэгдэн орсон хүний эрхийн гэрээний ямар заалтуудыг түр зогсоосон бэ? Түр зогсоосон шийдвэртэй холбоотойгоор гэрээний байгууллагуудаас хийсэн сүүлийн үеийн дүгнэлт ажиглалтыг уншиж танилцсан уу?

Сүүлийн 12 сарын хугацаанд:

- Засгийн газар олон улсын хэмжээнд сүүлийн үед хийж буй үйл ажиллагааны талаар парламентад мэдээлэл хийсэн үү?
- Чуулганаар хүний эрхийн асуудлаар Засгийн газарт асуулт, асуулга тавьж, хангалттай мэдээлэл авч чадсан уу?
- Хуулийн хэрэгжилт хүний эрхийн хувьд үзүүлж буй үр нөлөөг үнэлэх асуудлыг тогтмол (чуулганаар/ хорооны хурлаар) хэлэлцдэг үү?
- Хүний эрхийн тодорхой асуудлаар парламент судалгаа хийх, асуулга явуулах, эсхүл баримт нотолгоо илрүүлэх ажлыг хийсэн үү? Хэрэв тийм бол, эдгээр ажлын үр дүн, үр нөлөө юу байв?

## **АСУУЛТ 5: НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизм дахь Парламентын оролцоог нэмэгдүүлэх нь**

5.1. Парламентад тухайн улс ба НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны статусыг баталгаажуулах механизм байгаа юу? (тухайлбал, парламентын хүний эрхийн хороо, ажлын хэсэг, бүлэг, тусгай комисс)

5.2. НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын талаар парламентад байнга мэдээлэл өгдөг үү? Парламентын ажлын албаны ажилтнууд, ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагууд холбогдох мэдээллийг тогтмол авах боломжтой байдаг уу?

5.3. Парламент, эсхүл эрх бүхий хороо улс орны хүний эрхийн тайланг боловсруулахад оролцдог уу?

5.4. Хүний эрхийн гэрээний байгууллагуудад улс орны өргөн мэдүүлэх үндэсний тайлантай холбоотой тайлагнах хуваарийн талаар парламентын гишүүд мэддэг үү?

5.5. Олон улсын хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч, төлөөлөгч парламентад ирж ажилласан эсэх. УИХ-ын гишүүдтэй уулзалт хийсэн байдал

5.6. НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодод хүргүүлэх тайлангийн боловсруулалт, тайлагнах процесст парламентын гишүүд орж ажилласан байдал

Сүүлийн 24 сарын хугацаанд:

- НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороодод явуулах илтгэл, тайлангийн төслийг УИХ-аар авч хэлэлцсэн эсэх талаарх мэдээлэл
- НҮБ-ын гэрээний хороод, UPR-т хүний эрхийн асуудлаарх үндэсний илтгэлийг танилцуулахад парламентын гишүүд оролцсон байдлын талаарх мэдээлэл
- Олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмж, дүгнэлтийг парламент авч хэлэлцэх процесс

### **АСУУЛТ 8: Олон нийт ба хүний эрхийн бусад байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь**

8.1. УИХ, түүний Тамгын газраас хүний эрхийн талаар явуулдаг гол олон нийтийн арга хэмжээний талаарх мэдээ, мэдээлэл

8.2. УИХ-аас ХЭҮК-ын илтгэлийг хэрхэн авч хэлэлцсэн талаарх мэдээлэл

8.3. Парламентаас иргэний нийгмийн байгууллагуудтай тогтмол харилцдаг суваг, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл.

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### **АСУУЛТ 2. ХҮНИЙ ЭРХИЙН МЭДРЭМЖТЭЙ ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **Сэдвийн тойм**

Монгол Улсын Их Хурал нь хүний эрхийг хангах үндэсний тогтолцооны гол оролцогчийн хувьд хүний эрхийн үндсэн зарчимд нийцсэн хууль тогтоомжийг батлан гаргах замаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэхэд тэргүүлэх үүрэг хүлээж байдаг. Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хууль болон олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн суурь гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколуудад нийцүүлэн хүний эрхийг хамгаалах үндэсний эрх зүйн орчныг бүрдүүлж, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, түүний бүрдэл хэсэг, механизм, институцүүдийг байгуулан ажиллуулж байна. Түүнчлэн Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд хүний эрхийг хангах, хамгаалах тодорхой зорилтуудыг дэвшүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2000 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, УИХ-аас Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комиссыг байгуулсан. Тус Комисс нь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх үндэсний илтгэлүүд, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүр УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулдаг бөгөөд тус байнгын хорооны дэргэд хүний эрхийн асуудлыг дагнан эрхэлдэг Хүний эрхийн дэд хороо ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд НҮБ-ын Хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх Парисын зарчимд нийцүүлэн хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал, гишүүдийн томилгоог улс төрөөс ангид байлгах чиглэлд дорвитой өөрчлөлт хийхийг НҮБ-аас Монгол Улсад зөвлөсний дагуу 2021 онд тус хуулийг шинэчлэн найруулж баталсан болно.

Улсын Их Хурлаас хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл байдал үүсгэж буй хууль тогтоомжид үнэлгээ, дүгнэлт хийх, УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх зэргээр учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, арилгах механизм бүрдүүлэх зорилгоор холбогдох журам, аргачлалуудыг батлан мөрдүүлж байна.

Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжилтийг хангах үе шат бүхэнд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх, эрх бүхий байгууллагаас тайлбар тодруулга авах, илтгэл, мэдээлэл сонсох, хяналтын сонгол хийх зэрэг олон талт механизмуудыг ашиглаж байгаа хэдий ч эдгээр арга механизмуудыг тогтмол ашиглаж хэвшүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтнуудыг мэргэшүүлж чадавхжуулах, оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах зайлшгүй шаардлага тулгамдаж байна.

**2.1. Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг үнэлж дүгнэх, эсхүл эрх зүйн шинэчлэлийг санаачлах эрх парламентад бий юу?**

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах нь түүний онцгой бүрэн эрхэд хамаардаг.

Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “зөвхөн Засгийн газар санаачлахаас бусад асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах эрхтэй”. Иймээс УИХ-ын гишүүд хууль санаачлагчийн хувиар хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах аливаа хуулийн анхдагч, шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийн төслийг санаачлан өргөн мэдүүлэх эрхтэй бөгөөд түүнийгээ парламентаар хэлэлцэн батлуулах, эрх зүйн шинэчлэл хийх бүрэн боломжтой.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэц, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комиссоос бүрдэх бөгөөд хүний эрхийг хангах үндэсний тогтолцооны гол оролцогч болохын хувьд УИХ-аас хууль тогтоомжийг батлан гаргахдаа Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэхээс гадна баталсан хуулийн хэрэгжилтийн байдлыг үнэлж дүгнэх механизм ажиллуулдаг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар Улсын Их Хурлын түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх үйл ажиллагааг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран хэрэгжүүлэх (*Хууль тогтоомжийн тухай хуулийн §49.1*) зохицуулалт үйлчилж байна. Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газар (УИХТГ)-ын

Хяналт шинжилгээ, үнэлгээний газар (ХШҮГ)-аас Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” ашигладаг.

Уг аргачлалын 3.2-т зааснаар тодорхой 5 чиглэлийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж болно гэж заасан бөгөөд эдгээр 5 чиглэлийн нэг нь хүний эрх, чөлөөг хамгаалах, хангахад чиглэж байна. Тодруулбал, аргачлалын 3.2.5-д “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа нөхцөл байдал үүссэн бол” гэж нарийвчлан заажээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурал, УИХ-ын гишүүн хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй. Үүнд:

- Асуулт, асуулга тавих: Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд хүний эрх, эрх чөлөө хангагдаж байгаа эсэх асуудлаар бичгээр хандаж, мэдээлэл авдаг. (*Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн §12.1; §12.2*);
- Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг жил бүр, мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд тус тус УИХ хэлэлцдэг. (*Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн §16.1.3; §16.1.6*);
- Хүний эрхийг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийх: УИХ хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үр нөлөөг сайжруулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэдээлэл авах, үнэлэх зорилгоор хяналтын сонсгол явуулдаг (*Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн §26.12*).

Хууль санаачлагчаас хуулийн төсөл боловсруулахдаа тус хуулийн төслийн хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь заалтаар зохицуулсан билээ. Энэ хүрээнд УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний 187 дугаар захирамжаар

“УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлал”-ыг батлан мөрдүүлж байна.

*2.2. Хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколыг Засгийн газар соёрхон баталсан эсэхийг парламент тогтмол үнэлж дүгнэдэг үү? Хэрэв тийм бол, тухайн улс эдгээр олон улсын механизм, арга хэлбэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа алхмыг хийсэн үү?*

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, мөн зүйлийн 4-т “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэж тус тус заажээ. Монгол Улсын үндэсний хууль тогтоомжийн зохицуулалт Монгол Улсын олон улсын гэрээний заалттай зөрчилдвөл олон улсын гэрээг дагаж мөрдөнө. Өөрөөр хэлбэл эрх зүйн хүчин чадлын эрэмбийн хувьд зөвхөн соёрхон баталсан олон улсын гэрээ дотоодын хуулиас дээгүүр хүчин чадалтай байна гэж ойлгоно<sup>108</sup>.

“Хүний салшгүй эрхтэй холбогдсон олон улсын гэрээ”-г Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн §8.1 дэх хэсэгт заасан ёсоор заавал Улсын Их Хурал соёрхон баталдаг. Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн §7.1.3-т заасан журмын дагуу хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаарх саналыг УИХ-аас байгуулдаг, хараат бус статустай байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комиссоос УИХ-д ирүүлэх боломжтой.

Монгол Улс хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколуудаас “Бүх цагаач ажилчин, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц<sup>109</sup>-оос бусад бүх гэрээ, нэмэлт протоколыг соёрхон баталж, нэгдэн орсон.

<sup>108</sup> Монгол Улсын дээд шүүх, Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоол

<sup>109</sup> United Nations General Assembly, International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families, 18 Dec 1990

*Хүснэгт 1: Монгол Улсын соёрхон баталсан хүний эрхийн суурь гэрээ, тэдгээрийн нэмэлт протокол*

№	Гэрээ, конвенцын нэр	Батлагдсан огноо	Монгол Улс соёрхон баталсан, хүчин төгөлдөр болсон огноо.
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.	Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, бусад хэм хэмжээг зөвшөөрч, 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр гишүүнээр элссэн юм.
2	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) тогтоолоор баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) тогтоолоор баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	Монгол Улсын Бага Хурлын 1991 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор нэгдэн орж, 1991 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 44/128 тогтоолоор баталж, 1991 оны 07 дугаар сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон.	2012 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2012 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
3	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) тогтоолоор баталж, 1976 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.	1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1976 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2008 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 63/117 тогтоолоор баталж, 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.



4	Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1965 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 2106 (XX) тогтоолоор баталж, 1969 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр хүчин төгөлдөр болсон.	1969 оны 03 дугаар сарын 31-ний өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1969 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 34/180 тогтоолоор баталж, 1981 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	1981 оны 05 дугаар сарын 14-ний өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1981 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
5	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1999 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 54/4 тогтоолоор баталж, 2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	1999 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.
	Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1995 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 50/202 тогтоолоор баталсан. Одоогоор хүчин төгөлдөр болоогүй байна.	1997 оны 10 дугаар сарын 03-ны өдөр соёрхон баталсан.
	Хүүхдийн эрхийн тухай конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 44/25 тогтоолоор баталж, 1990 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	1990 оны 07 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1990 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
6	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 54/263 тогтоолоор баталж, 2002 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орох тухай хуулийг баталж, Монгол Улсад 2001 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 54/263 тогтоолоор баталж, 2002 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орох тухай хуулийг баталж, Монгол Улсад 2013 оны 07 дугаар сарын 27-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.



	Хүүхдийн эрхийн тухай конвенцын мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 66/138 тогтоолоор баталж, 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон.	2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 61/106 тогтоолоор баталж, 2008 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2009 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 61/106 тогтоолоор баталж, 2008 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2009 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
8	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 39/46 тогтоолоор баталж, 1987 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2001 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орох тухай хуулийг баталж, Монгол Улсад 2002 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.
	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 57/119 тогтоолоор баталж, 2006 оны 06 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.
9	Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 61/177 тогтоолоор баталж, 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.	2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр соёрхон батлах тухай хуулийг баталж, Монгол Улсад 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Эдгээр хүний эрхийн суурь гэрээнээс гадна Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 87 дугаар конвенц, Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтээр алагчлахгүй байх тухай 111 дүгээр конвенц, Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц гэх зэрэг нийт 21 гэрээ, конвенцод Монгол Улс нэгдэн орж, соёрхон баталжээ.

Монгол Улсын Их Хуралд хүний эрхийн асуудлыг дагнан эрхэлдэг Хүний эрхийн дэд хороо ажилладаг. Энэхүү дэд хороо нь Хууль зүйн байнгын хорооны дэргэд хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын асуудлыг хариуцан ажилладаг (*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн §28.2.11*).

Хүний эрхийн дэд хороо нь парламентын хүний эрхийн хорооны нийтлэг жишгийн дагуу эрхлэх асуудлаа дагнан хариуцаж санал дүгнэлт гаргах, түүнийгээ Хууль зүйн байнгын хороонд, шаардлагатай бол Хууль зүйн байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, хариуцсан асуудлын хүрээндээ хянан шалгах үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй (*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн §24.3*).

Мөн УИХ дахь бусад дэд хорооны нэгэн адил дараах бүрэн эрхтэй: хүний эрхийн, эсхүл эрхлэх бусад асуудлаар хяналт шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авах, ажлын хэсэг байгуулах, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулж харьяалах байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг эрхтэй (*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн §28.4*).<sup>110</sup>

Тус дэд хороо 2021 оны намрын ээлжит чуулганаас хойш өнөөдрийг хүртэлх ээлжит болон ээлжит бус 5 чуулганы хугацаанд 1 удаа хуралдсан байна. Тус 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...” гэж заасан эрхийн талаар болон Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх асуудлыг хэлэлцсэн бөгөөд хуралдаанд холбогдох хууль, хяналтын байгууллагын албан хаагчид,ТББ, иргэдийн төлөөлөл оролцжээ<sup>111</sup>.

<sup>110</sup> О.Мөнхсайхан, Р.Очирбал, “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл” (тойм судалгаа), Улаанбаатар хот, 2021 он. 439-442 дахь тал.

<sup>111</sup> УИХТГ, “Хүний эрхийн дэд хороо хүний эрхийн талаар болон Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар мэдээлэл сонслоо” веб мэдээ, Дэлгэрэнгүйг: <https://www.parliament.mn/nn/15266/> (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.03)

Дээр дурдсан олон улсын гэрээ, түүний Нэмэлт протоколын дагуу манай улсын зүгээс эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн зэрэг эрхээ зөрчүүлсэн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I протокол, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын нэмэлт протокол, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн тухай конвенцын Мэдээлэл хүргүүлэх тухай нэмэлт III протокол), Эрүүгийн хуульд заасан ялын төрлөөс цаазаар авах ялыг 2015 онд халсан (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протокол), Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм 2022 оны 06 дугаар сард байгуулсан (Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протокол), мөн нээлттэй хяналт-шалгалт хийх журмыг (inquiry procedure) хүлээн зөвшөөрсөн билээ.

### *2.3. ХЭҮК байдаг уу? Хэрэв байдаг бол өнөөгийн байдлаар Парисын зарчмыг хэр хэмжээнд дагаж мөрдөж байгаа вэ?*

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий Улсын Их Хурлаас байгуулагддаг, хараат бус, бие даасан үндэсний байгууллага юм.

Улсын Их Хурлаас 2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг баталж, Комиссын 3 гишүүнийг томилсноор үйл ажиллагаагаа эхэлжээ. НҮБ-аас 1993 онд баталсан Парисын зарчимд ХЭҮК-ын үйл ажиллагааг нийцүүлэх зорилгоор Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, тус Комиссын үндсэн бүрэлдэхүүнийг 6 гишүүнтэй болгож, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрх, чиг үүргийг нь өргөжүүлсэн болно. Уг шинэчилсэн найруулгыг баталснаар ХЭҮК-ын хараат бус, төсвийн бие даасан байдлыг бататгаж, Комиссын гишүүдийг томилох үйл явцад шинэчлэл хийсэн. Мөн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор хүлээсэн үүргийн дагуу Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий үндэсний механизмыг хариуцсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг УИХ-аас 6 жилээр томилдог болсон. Тус гишүүн нь ХЭҮК-ын бусад гишүүнээс харьцангуй бие даасан статустай

бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31-36 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Тэрбээр дэргэдээ түүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгжтэй байх ба Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлдэг.

Тус Комисс нь 2002 онд Ази, Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулганы бүрэн эрхт гишүүнээр, 2003 онд Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Дэлхийн Холбооны санал өгөх бүрэн эрхтэй гишүүнээр, 2018 онд Евразийн Омбудсмэний Холбооны гишүүнээр элссэн. Комисс нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон хүний эрхийн гэрээний хороодод хүний эрхийн асуудлаар хөндлөнгийн мэдээлэл хүргүүлэх, хуралд хараат бусаар оролцох эрхтэй.

Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооноос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг Парисын зарчимд нийцсэн хэмээн 2003, 2008, 2014, 2021 онуудад “А” статусаар магадлан итгэмжилсэн юм. Ийнхүү магадлан итгэмжилсэн ч тус зохицуулах хорооны Магадлан итгэмжлэх дэд хорооны зүгээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Парисын зарчмыг бүрэн биелүүлэх тухай зөвлөмж, үнэлгээ өгч байгааг заавал харгалзан үзэж, хэрэгжүүлбэл зохино.<sup>112</sup> Ялангуяа магадлан итгэмжлэх бүрд өөрийн ажлын байргүй<sup>113</sup>, хангалттай төсөв хуваарилаагүй, нэр дэвшүүлэх, томилох үйл явц ил тод, нээлттэй бус байхын<sup>114</sup> зэрэгцээ 2021 онд Иргэний нийгмийн зөвлөлдөө нийгмийн олон янз байдал, олон талт төлөөлөл хангах, өөрийн алба хаагчдаа шууд ажилд авдаг байх талаар Магадлан итгэмжлэх дэд хороо тайландаа зөвлөжээ.<sup>115</sup>

Улсын Их Хурал 2001 оноос хойш төсвийг өсөн нэмэгдүүлэх байдлаар хуваарилж байсан ч Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв 2009, 2015, 2016 онд буурч, үйл ажиллагааны зардлыг Сангийн яамны саналаар танаж байсан болно. Энэхүү туршлагыг халах үүднээс Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль шинэчлэн найруулахдаа “Комиссын дарга Байнгын хороогоор зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын нэгдсэн төсвийн төсөлд нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлнэ” гэж зааснаар Хууль зүйн байнгын хорооны оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлжээ. Уг комиссын гишүүдийг томилохдоо Хууль зүйн байнгын хороо томилгооны сонсгол

<sup>112</sup> Б.Болорсайхан, “Хүний эрхийн үндэсний байгууллагыг үнэлэх нь” нийтлэл, “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүл (2014/02), Улаанбаатар хот, 2014 он. 28 дахь тал.

<sup>113</sup> Засгийн газрын байранд ажлын байраа одоо хүртэл түрээслэн байрладаг.

<sup>114</sup> Б.Болорсайхан, “Хүний эрхийн үндэсний байгууллагыг магадлан итгэмжлэх үйл явцад Монгол Улс” нийтлэл, “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүл (2015/02), Улаанбаатар хот, 2015 он. 29-35 дахь тал.

<sup>115</sup> Магадлан итгэмжлэх дэд хороо, Цахим хуралдааны тайлан, зөвлөмж, 2021 оны 10 дугаар сарын 18-29 -ний өдрийн хуралдаан. 12-15 дахь тал. Дэлгэрэнгүйг: [https://ganhri.org/wp-content/uploads/2021/12/SCA-Report-October-2021\\_EN.pdf](https://ganhri.org/wp-content/uploads/2021/12/SCA-Report-October-2021_EN.pdf) (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.04)

зохион байгуулахаар хариуцуулсан нь дэвшилтэт алхам байсан (*Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн §32.3*).

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 2015-2018 онд Ази, Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн байгууллагын Чуулганыг даргалж, 2022 оноос Ази, Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн байгууллагын Чуулганы дэд даргаар сонгогдон ажиллаж байна. Түүнчлэн Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах” чиг үүргийнхээ хүрээнд хууль тогтоомж, захиргааны акт, төрийн болон төрийн бусад байгууллагаас гаргасан шийдвэр хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэхэд тодорхой саналуудыг өгч ажиллаж байна.<sup>116</sup>

*2.4. Улс орны эрх зүйн тогтолцоо, үндэсний бодлого болон үйл ажиллагаа нь ардчилсан орон зайг хэр зэрэг хамгаалж, иргэний нийгмийг үйл ажиллагаагаа хэрэжүүлэх боломжоор хангадаг вэ?*

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд “Монголын ард түмэн бид: ... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.” хэмээн зарлан тунхагласан. Мөн Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан нь ардчилал, ардчилсан ёс нь Монголын нийгмийн тулгуур үнэт зүйлийн нэг мөн болохыг бататгасан хэрэг юм. Түүнчлэн “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа” болно гэж Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.4-т тусгажээ.

Манай улсын Үндсэн Хуульд заасны дагуу төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээдэг. Улсын Их Хурлаас 2003 онд баталсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-т төрөөс тэрхүү үүргээ үр дүнтэй гүйцэтгэж, хүний эрхийн баталгааг хангалттай бүрдүүлэхийн тулд Хүний эрхийг хангах үндэсний механизм (тогтолцоо)-ыг бүрдүүлж, тус механизмын бүрдэл хэсгийн чадавх, хүний эрхийг сахин биелүүлэх, бэхжүүлэх, хамгаалах, хангах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга зам, үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

<sup>116</sup> Хүний эрхийн Үндэсний Комисс, Танилцуулга. Дэлгэрэнгүйг: <https://nhrcm.gov.mn/> (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.03)

Хүний эрхийг хангах үндэсний механизм дараах бүрдэл хэсэгтэй. Үүнд:

- хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага;
- Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх, прокурор, өмгөөлөх гэх мэт хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд;
- нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн бүх байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл;
- бүх төрлийн бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа;
- хүний эрхийг хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах дотоодын хэрэглүүрүүд.

Хожим Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалах энэхүү үндэсний тогтолцоо (механизм)-г Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар баталгаажуулан нарийвчлан хуульчилсан билээ. Тодруулбал, 2020 оны 01 дүгээр сард баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар анх удаа хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоонд төр эн тэргүүнд үүрэг хүлээж, иргэний нийгмийг татан оролцуулан ажиллах хууль зүйн баталгааг хангасан билээ.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, боловсронгуй болгох ажлын хүрээнд хамгийн сүүлд 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” хуулийг хэлэлцэн батлав. Энэхүү хуульд “хүний эрхийн хамгаалагч” гэж хэн болох, “хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаа” гэж юу болох, “хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах”, “хүний эрхийн хамгаалагчийн эрхэд халдах” зэрэг ойлголтыг тодруулан томъёолсны зэрэгцээ хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай эрхийг улам өргөжүүлж, тусгайлан баталгаажуулж, үйл ажиллагаа явуулахдаа хориглох зүйл, мөн хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны санхүүгийн ил тод, нээлттэй байдлын талаар; төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, тэдний үйл ажиллагааг дэмжих, хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хуулиар хариуцсан чиг үүргийн хүрээнд шуурхай арга хэмжээ авч ажиллах, байгууллагынхаа дотоод журамд хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг тусгах тодорхой үүрэг хүлээхээр зааж өгсөн. Түүнчлэн Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороог ХЭҮК-ын эргэд байгуулж, хорооны бүрэлдэхүүнд ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлд тодорхой шалгуур тавьсан нь иргэний нийгмийг чадавхжуулах, дэмжих зорилготой бөгөөд хамтын шийдвэрээр анх удаа нэр дэвшүүлж, нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгох зэрэг олон шинэлэг зохицуулалтыг тусгасан байна.



Энэ хууль батлагдсанаар Монгол Улс хүний эрхийн асуудал, зөрчлийн талаар тэмцэж байгаа хүмүүсийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн Ази тивийн анхны улс болсон байна.<sup>117</sup>

1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсад ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр томоохон ахиц дэвшил, ололт, амжилтууд гаргасан хэдий ч цаашид засаж залруулах, сайжруулах, төгөлдөршүүлэх олон тулгамдсан асуудал, сорилт, бэрхшээлүүд байсаар байна.

Монгол Улс Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2021 онд 68 дугаар байрт байсан бол 2022 онд 180 улсаас 90 дүгээрт орж 20 орчим байраар ухарсан. Мөн ардчиллын индексээр 2022 онд 6.35 оноо авч, “Сул ардчилалтай” улс орны ангилалд орж байна.

Төрийн бус байгууллагын тухай 1997 оны хууль нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулахад чухал алхам болсон хэдий ч төрийн бус байгууллагын тогтвортой, үр нөлөөтэй хөгжлийг дэмжих болон ашгийн төлөө бус, нийтэд тустай үйл ажиллагааг оновчтой зохицуулах хэрэгцээ шаардлага тулгамдаж байна. Монгол Улсад ИНБ-ын тоо жилээс жилд хурдацтай өсөж 1998 онд 1075 ТББ бүртгэлтэй байсан бол 2005 онд 3492, 2010 онд 6915, 2015 онд 11.879, 2017 оны 04 дүгээр сарын байдлаар 17.685, 2018 оны 06 дугаар сарын байдлаар нийт 17.634 болсон бол 2022 оны байдлаар 25.000 хүрсэн байна.

Монгол Улсад бүртгэлтэй ТББ-ын дийлэнх нь төрд тавих иргэдийн хяналтыг сайжруулах буюу нийгэмд үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ чиглэлийн ТББ-ын тоо сүүлийн 5 жилд 2.2 дахин өсжээ. ТББ-ыг үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 72.8 хувь нь үйлчилгээний салбарт, 11.7 хувь нь боловсрол, 5.8 хувь нь мэдээлэл, холбоо, 3.7 хувь нь урлаг, үзвэр, тоглоом наадам, 2.3 хувь нь мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, үлдэх 3.7 хувь нь бусад салбарт бүртгэлтэй байна.<sup>118</sup>

Иргэний нийгмийн байгууллагууд, түүний үйл ажиллагаа нь хууль тогтоох үйл ажиллагааны бүхий л үе шат болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж байна. Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-д иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх талаар тусгаж, хэрэгжүүлж байна.

<sup>117</sup> УИХ-ын 2021 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга (2021.03.15-2021.07.08)-ын 122 дахь тал

<sup>118</sup> Конрад-Адэнауэр-Сан, МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим, “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж, Улаанбаатар хот, 2020. 221 дэх тал

Мөн иргэний нийгмийн үйл ажиллагааг зохицуулж буй гол хуулиудаас гадна Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай (1991), Төр, сүм хийдийн харилцааны тухай (1993), Жагсаал, цуглаан хийх журмын тухай (1994), Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай (1997), Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай (2021) зэрэг хуулиуд нь иргэний, ардчилсан орон зайг тэлэх хамгаалалт, баталгаа болж байна.

Сүүлд хийгдсэн 2019, 2022 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь парламентат ёсыг хөгжүүлэх, бэхжүүлэхэд чиглэсэн маш том шинэчлэл болсон. Энэ хүрээнд хүний эрх, иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн олон хууль тогтоомжуудыг шинэчлэн баталсан. Жишээлбэл, Төрийн өндөр албан тушаалтнуудын томилгооны сонгол хийх, улс төрийн намыг бодлогын нам болгон төлөвшүүлэх, намын дотоод ардчиллыг бэхжүүлэх, санхүүжилтийг ил тод, боловсронгуй болгох зэрэг зохицуулалтуудыг оруулсан.

Түүнчлэн Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн нэг дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэсэн заалтыг амьдралд бодитоор хэрэгжүүлэх “Парламентын боловсрол”, D-Parliament, D-Petition хөтөлбөрүүдийг Парламентын удирдлагын зүгээс санаачлан хэрэгжүүлсэн нь амжилттай нэвтэрч, тодорхой ахиц дэвшил үзүүлж байна. Мөн УИХ-ын гишүүдийн тоог нэмэгдүүлж 126 болгон сонгуулийн холимог тогтолцоог хуульчилснаар Парламент дахь нийгмийн тодорхой бүлгүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмэр үзүүлэх нь дамжиггүй. Дашрамд дурдахад Үндсэн хуулийн эдгээр нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ зөвлөлдөх ардчиллын нэг хэлбэр болох зөвлөлдөх санал асуулгаар ард нийтийн санаа бодлыг тусган, тэдний оролцоог хангасан.

*Хүний эрхийн Үндэсний Комиссоос иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж буй байдал:*

2000 оны 12 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт “Комисс нь үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий өмгөөлөгчдийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбоо, хүний эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл байгуулж болно” гэж заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2002 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 6 дугаар тушаалаар анхны орон тооны бус зөвлөлийг 11 гишүүний бүрэлдэхүүнтэй 3 жилийн хугацаатайгаар байгуулсан бөгөөд 2014 оноос эхлэн Иргэний нийгмийн зөвлөл нэрээр 7 дахь бүрэлдэхүүн үйл ажиллагаагаа явуулж байна.



2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Комисс үйл ажиллагаагаа явуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий иргэний нийгмийн зөвлөлтэй байна” гэж заасны дагуу Комиссын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Иргэний нийгмийн зөвлөлийн дүрэм”-ийг баталж 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/16 тушаалаар Иргэний нийгмийн зөвлөл 18 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус Комисс 2011-2021 онд 58 судалгааны ажил хийснээс 15 судалгаа иргэний нийгмийн байгууллагатай хамтран хийсэн байна. Тухайлбал: Шашны сургууль, сүм хийдэд шавилан суралцаж буй хүүхдийн эрхийн нөхцөл байдалд хийсэн хяналт, үнэлгээний ажлыг НҮБ-ын Хүүхдийн сан, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ, “Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын салбар” судалгааны ажлыг ОУХБ, Европын холбоо, “Карьер хөгжлийн хүрээлэн” ТББ-тай тус тус гүйцэтгэсэн байна.<sup>119</sup>

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, хүний эрхийн төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий Хүний эрхийг хангах Үндэсний хороо 2023 онд Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг илтгэх, тайлагнах журам баталж, өнгөрөгч оны буюу 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд орон нутагт хүний эрхийн төлөв байдал ямар байгааг Засаг дарга нараар тайлагнуулж, илгээсэн тайланг олон талын төлөөлөлтэй хэлэлцжээ.<sup>120</sup> Энэхүү шинэ тутам илтгэх, тайлагнах механизм нь Хүний эрхийн Үндэсний Комисс, мэргэжлийн холбоод, хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, шинжээч, судлаач бүтээлчээр хамтран оролцох иргэний шинэ орон зай болж байна.

*2.5. Парламент аливаа ялгаварлан гадуурхалд хамгийн их өртөж болзошгүй тодорхой бүлгүүдийн талаар болон эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хамгаалахтай холбоотой Системийн сорилтуудын талаар мэддэг үү?*

Аливаа ялгаварлан гадуурхалд хамгийн их өртөж болзошгүй тодорхой бүлгийн эрхэд хүүхдийн эрх, ахмад настны эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, үндэсний цөөнхийн эрх, жендэрийн эрх болон бэлгийн цөөнхийн эрхүүд хамаардаг. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн

<sup>119</sup> Хүний эрхийн Үндэсний Комисс, Танилцуулга. Дэлгэрэнгүй: <https://nhrcm.gov.mn/> (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.03)

<sup>120</sup> ЗГХЭГ, “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын тайланг илтгэж эхэллээ” мэдээ. Дэлгэрэнгүй: <https://cabinet.gov.mn/8984.html>

дээд комиссарын газарт Монгол Улсаас хүргүүлдэг хүний эрхийн суурь гэрээний хэрэгжилтийн талаарх дүгнэлт зөвлөмж, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-т дурдсан бүлгийн эрхийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, бэрхшээл, шийдлийн талаар санал, зөвлөмж гаргаж, тэдгээрээс тодорхой зарим асуудлыг парламентын түвшинд шийдвэрлэж ирсэн болно. Тухайлбал, сүүлийн жилүүдэд УИХ-аас авч хэрэгжүүлсэн дараах арга хэмжээг дурдаж болно. Үүнд:

1. Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын суурь стандарт Монгол Улсад үйлчилдэг. Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцыг, 2003 онд Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцын нэмэлт протоколыг, 2004 онд Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцын 2 дугаар протоколыг, 2015 онд Мэдээлэл хүргүүлэх журмын тухай Хүүхдийн эрхийн конвенцын 3 дугаар нэмэлт протоколыг тус тус соёрхон баталсан. Түүнчлэн 2001 онд Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182-р конвенц, 2002 онд Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай 138-р конвенцыг мөн соёрхон баталжээ.

Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн үндэсний хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох ажлын хүрээнд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг 2016 онд шинэчлэн найруулж баталсан бөгөөд эрүү, иргэн, зөрчлийн, боловсролын гэх зэрэг салбарын болон салбар дундын зохицуулалтай 20 шахам хуулиар хүүхдийн эрхийг хангахтай холбоотой энэхүү харилцааг зохицуулж байна. Мөн тухайн асуудлаар Засгийн газар, асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан 30 гаруй дүрэм, журам, стандарт мөрдөгдөж байна. Түүнчлэн Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичиг үндэсний хэмжээнд хэрэгжиж байна.

Хүүхдийн эрхийг хангах олон улсын болон үндэсний тогтолцооны хүрээний бодлого, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд Монгол Улсад тус чиглэлд гарсан ахиц дэвшлийг ерөнхийлөн тоймловол:

- Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээрх олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орж соёрхон баталсан;
- Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн орчныг хангалттай хэмжээнд бүрдүүлсэн;
- Хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны байгууллага, институцүүд байгуулагдсан;
- Хүүхэд, гэр бүлийг хамгаалах чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг зохих түвшинд боловсруулан баталсан;

- Энэ чиглэлийн олон улсын байгууллага, төр, иргэний нийгмийн байгууллагуудаас олон тооны суурь болон бусад судалгаа, үнэлгээ хийгдэж, олон төрлийн төсөл, арга хэмжээнүүд хэрэгжиж байна.

Хэдий тийм боловч хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, төсөв, санхүүгийн хомсдол, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, чадавх сул, олон улсын байгууллага, хандивлагчийн зүгээс тулгамдсан асуудал, хэрэгцээнээс илүүтэй өөрийн хөтөлбөр, санаачилгыг тулгах, хөгжлийн байгууллагын зүгээс эрхэд суурилсан бус хэрэгцээнд суурилсан хандлагыг удирдлага болгон ажиллах, мөн хүүхдийн эрхэм чанар, эрх, эрх чөлөө, дээд ашиг сонирхлыг хүндэтгэх талаарх нийгмийн сэтгэл зүй, хандлага дулимаг, ядуурал, ажилгүйдэл гэх зэрэг улс төр, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлээс шалтгаалан хүүхдийн эрхийн ноцтой зөрчил, дутагдал арилахгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан илтгэлийг хэлэлцээд тодорхой чиглэлд төрөлжүүлэн нэгтгэсэн зөвлөмж ирүүлсэн нь цаашид энэ чиглэлээр анхаарах шаардлагатай үндсэн асуудал болно.<sup>121</sup> Хүний эрхийн Үндэсний Комисс анх 2005 онд Эрүүдэн шүүхийн эсрэг үндэсний хяналт-шалгалт (national inquiry) хийж байсан туршлагадаа тулгуурлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын хамтарсан 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Нээлттэй хяналт-шалгалт хийх тухай” А/34,12 дугаар тушаал, хоёрдугаар хавсралтаар удирдамж баталж, мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 03 дугаар сарын 27-оос 04 дүгээр сарын 25-ны хугацаанд зохион байгуулжээ. Одоогийн хүүхэд хамгааллын тогтолцоонд оролцогч төрийн байгууллагуудыг татан оролцуулахын зэрэгцээ хүүхдийн эрхийн тодорхой чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсгийн гишүүд болон аймаг, дүүргийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүний эрхийн Үндэсний Комиссын ажилтнууд хамтран ажиллажээ. Энэхүү Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хийсэн нээлттэй хяналт шалгалт нь 17 жилийн дараах үндэсний хяналт-шалгалт бөгөөд цаашид хүүхдийн эрхийн баталгааг хэрхэн хангах талаар тухайлан дүгнэлт, зөвлөмж боловсруулсан юм.<sup>122</sup>

Хүүхдийн эрхийн зөрчлийг арилгах талаарх шаардлага, дээр дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын

<sup>121</sup> О.Мөнхсайхан, Р.Очирбал, “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл” (тойм судалгаа), Улаанбаатар хот, 2021 он. 355 дахь тал.

<sup>122</sup> Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд нээлттэй хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж. дэлгэрэнгүйг: <https://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/209> (Сүүлд нэвтэрсэн: 2023.11.04)

хорооноос 2023.07.05-нд Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийсэн. Улмаар 2023.10.06-нд УИХ-ын чуулганы хуралдаанаар Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг сонсож, хүүхдийн эрхийн нээлттэй сонсгол хийхийг холбогдох байнгын хороонд даалгасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос 2023.10.25-нд Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар хяналтын сонсгол зохион байгуулав.

2. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь илтгэлийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.3-т заасны дагуу 2023 оны 04 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд, хоёр өдрийн турш олон нийтэд нээлттэй, ил тод, сэдэв тус бүрээр хэлэлцсэн билээ.

Илтгэлд ахмад настны ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх эрхийн зохицуулалт, нөхцөл байдал, шийдвэрлэх арга замын талаар дурджээ.

Судалгаануудаас үзэхэд ахмад настнууд хүчирхийллийн бүхий л хэлбэрт өртөж байх бөгөөд энэ нь дан ганц хүчирхийллийн нэг хэлбэрээр хязгаарлахгүй байна. Ялангуяа эдийн засагт суурилсан сэтгэл санааны болон бие махбодын хүчирхийлэл, үр хүүхэд, ойрын хамаарал бүхий хүмүүсийн зүгээс үл хайхрагдах хүчирхийлэлд өртөх нь түгээмэл бөгөөд хүчирхийллийг гол төлөв эхнэр, нөхөр, хүү, охин зэрэг ойрын хүмүүсийн зүгээс үйлддэг байна. Гэвч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ахмадууд холбогдох байгууллагад төдийлөн мэдээлдэггүй байна. ХЭҮК-ын судалгаанд оролцогч ахмадуудын зөвхөн 15 хувь нь цагдаа, хороо, хэсгийн ахлагч, нийгмийн ажилтанд мэдэгдсэн бол 85 хувь мэдээлээгүй гэж хариулжээ. Мэдэгдээгүй шалтгаанаа хаана хандахаа мэдэхгүй, үр хүүхдийнхээ нэр төрийг бодсон, дарамт шахалтаас айсан, хандаад нэмэргүй байсан, өвчтэй, хэвтэрт, гарах боломжгүй гэж тайлбарлажээ. УИХ-аас тус илтгэлийн дээрх нөхцөл байдлыг хэлэлцээд 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоол баталж, Ахмад настны эрхийн хэрэгжилтийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгажээ. Үүнд:

а/ ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

б/ ахмад настныг ажлын байраар хангаж байгаа ажил олгогч, аж ахуйн нэгжүүдийг татварын болон бусад бодлогоор дэмжих;

в/ ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

Мөн УИХ үндэсний цөөнх, бэлгийн цөөнхийн асуудлаар ХЭҮК-ын илтгэлд дурдсан асуудлаар арга хэмжээ авах талаар тогтоолууд гаргаж байв.

### **Сүүлийн 12 сарын хугацаанд:**

*Парламент хүний эрхийн талаар тодорхой зохицуулалт бүхий хууль тогтоомж батлах буюу нэмэлт, өөрчлөлт оруулсан эсэх, мөн бүс нутгийн/ олон улсын хүний эрхийн гэрээг баталсан уу? Хэрэв ийм хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол эдгээр нэмэлт, өөрчлөлт нь батлагдсан уу?*

УИХ-аас батлан гаргаж буй бүх хууль тогтоомж нь ямар нэг хэмжээгээр хүний эрхийг хангаж, хамгаалах чиг үүргийг агуулж байдаг. Тухайлбал:

Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц зэрэг олон баримт бичгээр хамгаалсан сурч боловсрох эрхийг хангаж, баталгаажуулсан Боловсролын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-ийг УИХ 2023.07.07-ны өдөр хэлэлцэн баталсан. Энэ нь сүүлийн 12 сарын хугацаанд батлан гаргасан хуулиудаас хүний эрхийн талаар тодорхой зохицуулалт бүхий суурь хуулийн нэг жишээ юм. Тус хуулиар боловсролын тогтолцоог шинэчилж, боловсролыг заавал танхимд суун эзэмшиж байгааг өөрчилж, албан, албан бус болон амьдралын орчинд суралцахуйн тогтолцоотой байхаар хуульчилсан. Энэ хүрээнд хүний амьдралын орчинд суралцахуйн замаар эзэмшсэн боловсролыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, мөн боловсролыг танхимын, танхимын бус, эдгээрийн хосолсон хэлбэрээр эзэмших боломж бүрдсэн. Мөн багшийн хөгжлийн тасралтгүй үйл ажиллагаа, чанар, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, сургалтын хөтөлбөр агуулгын талаар зохицуулсан төдийгүй сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байх бөгөөд суралцагчийн эх хэлээрээ суралцах болон бусад гадаад хэл суралцах эрхийг үл хөндөнө хэмээн заасан. Тус хуульд тусгагдсан хүний эрх, хүний эрхийн боловсролын суурь үзэл баримтлалын шинжтэй онцлох заалтуудаас дурдвал:

Боловсролын зарчмыг тодорхойлсон 5 дугаар зүйлд “тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх; хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх.” гэж тусгасан. Суралцагч нь

“бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх” үүрэгтэй (*Боловсролын ерөнхий хууль, §10.2.6*). Мөн “хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал”-ыг бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ (*Боловсролын ерөнхий хууль, §14.4.3.*) хэмээн тус тус заажээ.

Дурдсан хугацаанд УИХ-аас хүний эрхэд шууд холбогдолтой 1 илтгэл, 1 тайланг хэлэлцэж, 1 тогтоол гаргав. Мөн 5 хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд байна. Үүнд:

1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоол (2023.05.04-ний өдөр) баталсан;
2. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Гэр бүлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль зэрэг хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн, хэлэлцүүлгийн шатанд байна.

*Хүний эрхийн тухай гэрээ, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан уу?*

Сүүлийн 12 сард Монгол Улсын Их Хурал болон Засгийн газар Хүний эрхийн талаарх олон улсын аливаа нэг гэрээ, конвенц, протоколд нэгдэн ороогүй байна. (асуулт 2.2-ыг үзнэ үү)

*Парламент эмзэг бүлгийн иргэдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах зорилготой хууль тогтоомжид үнэлгээ хийх, эсхүл баталсан уу?*

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2023.07.05-ны өдөр Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийсэн. Улмаар 2023.10.06-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг сонсож, хүүхдийн эрхийн нээлттэй сонсгол хийхийг холбогдох Байнгын хороонд даалгасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос 2023.10.25-ны өдөр Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар хяналтын сонсгол зохион байгуулав.



### АСУУЛТ 3. ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫГ БЭХЖҮҮЛЭХ

#### Сэдвийн тойм

1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хууль, түүнд оруулсан 2019, 2023 оны нэмэлт, өөрчлөлтүүд нь Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хангах, парламентад ёсыг төлөвшүүлэх, бэхжүүлэхэд чиглэгдэж байсан. Ялангуяа 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хууль тогтоох байгууллагын үндсэн чиг үүргийн нэг болох хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхийн хүрээ, хязгаарыг өргөжүүлж тодорхойлсон. Энэ хүрээнд 2021 онд УИХ-аас парламентын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг батлан гаргасан.

Үндсэн хуульд заасан ёсоор төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн байдаг. Төрийн зүгээс энэхүү үүргээ хэрэгжүүлэхийн тулд урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, зорилтот хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж ирснээс хамгийн чухал, тулгуур баримт бичиг нь УИХ-аас 2003 онд баталсан “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр” юм. Бодлогын баримт бичгүүд нь хүний эрхийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан байдгаараа Парламентаас тухайн тодорхой эрхийг хангах, хамгаалах арга хэмжээний биелэлт, хэрэгжилтийг нь үнэлж дүгнэх, хянах боломжийг олгож байдаг. Энэ утгаараа уг хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх, шинэчлэх, хэрэгжилтийг сайтар хангах шаардлага бий.

УИХ хяналтын чиг үүргээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан 7 арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлдэг. Тэдгээр арга хэрэгслүүд нь Засгийн газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа хүний эрх, эрх чөлөөг хангаж буй эсэхэд хяналт тавихад чиглэгдсэн ба асуулт, асуулга тавих, тайлан илтгэл, мэдээлэл хэлэлцэх, хүний эрхийг хангахтай холбоотой хяналтын сонголт хийх зэрэг олон төрлийн хяналтын механизмуудыг багтааж байдаг.

Парламентын түвшинд Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт болон өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Хүний эрхийн олон улсын конвенцууд, НҮБ-аас хүний эрхийн талаар гаргасан зөвлөмжүүдэд нийцэж буй эсэхэд тус тус нөлөөллийн үнэлгээ хийж хэвших зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газрын ХЭЗГ-ын бүтцэд Эрх зүйн

дүн шинжилгээний хэлтэс, Мөн ХШҮГ-ын бүтцэд Төсвийн шинжилгээний хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээний алба байгуулагдсан бөгөөд эдгээр нэгжүүд нь УИХ-д өргөн барьсан хуулийн төсөл болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэгтэй ажиллаж байна.

### **3.1. Танай улсад хүний эрхийн үндэсний хэмжээний хөтөлбөр, стратеги байгаа юу?**

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад түлхэц болсон, бодлогын чухал баримт бичиг болсон юм.

Хөтөлбөрийн 4-р бүлэгт хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн асуудлыг тусгасан бөгөөд хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий Үндэсний хөтөлбөрийн хороо, түүний Ажлын алба 2006 оноос ажиллаж эхэлсэн билээ. Энэхүү ажлын алба нь Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд ажиллаж байсан боловч уг алба татан буугдсанаар хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах үйл ажиллагаа нэг хэсэг зогсонги байдалд орсон юм. Тиймээс 2022 оны 09 дүгээр сард Хүний эрхийг хангах Үндэсний хороог байгуулж, Ажлын албыг ЗГХЭГ-ын дэргэд байгуулсан болно. Тус хөтөлбөр хэрэгжээд 20 жил болж буй ч үндсэндээ 10 гаруй жилийн хугацаанд хэрэгжилтийг хариуцах бүтэц алдагдаж, зохион байгуулалтгүй явж ирсэн нь хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байх үндэс болжээ.

Энэ хугацаанд хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ, түргэвчилсэн үнэлгээг тус бүр нэг удаа хийжээ. Анх 2011 онд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээг үндэсний хэмжээнд өргөн далайцтай хийсэн боловч зорилт тус бүрийн хэрэгжилтийн мэдээллийг харах боломжгүй байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийг цогцоор нь үнэлсэн гэж үзэх боломжгүй байна. Хэдийгээр зорилт тус бүрийн хүрэх түвшин, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулсан, үндэсний хөтөлбөр батлахаас өмнөх болон хэрэгжилтийн эхний шатны нөхцөл, өнөөгийн хүрсэн түвшнийг харьцуулсан талаар арга зүй, мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн тайлбарт бичсэн ч тайланд энэ мэдээлэл тусаагүй. Тайлангаас Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2-р бүлгийн гурван дэд хэсэг, 3-р бүлгийн зорилт тус бүрийн хэрэгжилтийн түвшинг харах боломжгүй бөгөөд энэ нь нийт 146 зорилт буюу нийт зорилтын 60 хувь юм. 2011 оны байдлаар 243 зорилтоос бүрэн хэрэгжсэн 7, хэрэгжилтийн шатанд тодорхой үр дүн гарсан 144, хэрэгжиж эхэлж байгаа 36, ямар нэгэн арга хэмжээ аваагүй 56 зорилт байжээ.<sup>123</sup>

<sup>123</sup> Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБХХ "Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц" хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, Улаанбаатар хот, 2011 он.



Хожим Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар (2022.09.06, №44) “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах Ажлын хэсэг” хүний эрхийн шинжээч, судлаачийн бүрэлдэхүүнтэй байгуулж, Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг удаан хугацаанд хэрэгжих төлөвлөгөө хэлбэрээр боловсруулах санал гаргажээ. Үүнтэй зэрэгцэн 2022 оны 04-10 дугаар сард Стратеги Академи ТББ-ын зүгээс Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр хэрэгжсэн талаарх түргэвчилсэн үнэлгээ хийж, 2022 оны хагас жилийн байдлаар 243 зорилтоос хэрэгжсэн 26, хэрэгжилт ахицтай 63, хэрэгжилт удаашралтай 83, хэрэгжилт муу 71 хэмээн үнэлсэн байна.<sup>124</sup>

Үүнтэй уялдан Хүний эрхийг хангах Үндэсний Хорооны санаачилга, шийдвэрийн дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын манлайлал дор Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулж УИХ-д хүргүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн “Алсын хараа - 2050”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд хүний эрхийг хангах, хамгаалах бодлого, зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа - 2050”-ын 5.5 дахь зорилт “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм” хэсэгт “Иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ.” хэмээн зорилгоо тодорхойлж, энэхүү зорилгоо 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд: I үе шат (2021-2030): Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх үе; II үе шат (2031-2040): Хүний эрхийг хангах бодлого, хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт хүргэх үе; III үе шат (2041-2050): Нийгмийн бүх харилцаанд хүний эрхийг бүрэн хангасан тогтолцоог төлөвшүүлэх үе.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын дараах зорилтот хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлнэ. Үүнд:

<sup>124</sup> Стратеги Академи, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр хэрэгжсэн талаарх түргэн үнэлгээ, Улаанбаатар хот, 2022 он.

- 1.хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 2.нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 3.эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 4.байгаль орчны зорилтот хөтөлбөр;
- 5.засаглалын зорилтот хөтөлбөр;
- 6.бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 7.үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр.

Эдгээр зорилтот хөтөлбөр тус бүр нь Хүний тухайлсан эрхийг хангах, хамгаалах чиглэлээр нарийвчилсан тодорхой бодлого, зорилт дэвшүүлэх, үр нөлөө үзүүлэх боломжтой. Ялангуяа хүний хөгжлийн болон засаглалын зорилтот хөтөлбөрүүд нь хүний эрхийг хангах, хамгаалахтай шууд холбогдолтой бөгөөд Засгийн газраас эдгээр хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн хүрээнд 28 зорилго, 95 зорилт, 374 үйл ажиллагааг томъёолон тусгасан төслийг 2022 оны 07 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлсэн боловч хэлэлцүүлгийн шатанд буцаан татсан байна.

*3.2. Танай улсын Үндсэн хууль, эсхүл бусад хууль тогтоомжоор парламент нь асуулга авах, сонсгол хийх, тодруулга авах, газар дээр нь очиж үзэх зэргээр засгийн газрын хариуцлагын тогтолцоог сайжруулж чадаж байна уу?*

Парламентаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болох асуулт, асуулга тавих, газар дээр нь танилцах, хяналт шалгалт хийх бүрэн эрхийг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулсан. 2015 онд Нийтийн сонсголын тухай хууль батлагдсанаар төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн нийтийн сонсголыг төрийн байгууллага, албан тушаалтан зохион байгуулахаар зохицуулсан. Энэ хуулиар сонсголын 9 төрлийг ангилсан бөгөөд сонсгол тус бүрийг зохион байгуулах дэгийг Нийтийн сонсголын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар тогтоосон. Үүнд: хууль тогтоох сонсгол, ерөнхий хяналтын сонсгол, төсвийн хяналтын сонсгол, томилгооны сонсгол, захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн сонсгол, орон нутгийн сонсгол, танилцах сонсгол, зөвшилцөх сонсгол болон хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол хамаарна.

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр парламентын хяналтын зарим бүрэн эрхийг нэмэгдүүлсэн. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан. Тус хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах 7 арга хэрэгслээр хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

1. асуулт тавих;
2. асуулга тавих;
3. хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;
4. мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх;
5. төсвийн хяналт;
6. хяналтын сонсгол хийх;
7. хянан шалгах түр хороо байгуулах.

УИХ-аас хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах зарчмуудыг хуулийн 4 дүгээр зүйлд тусгасны нэг нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зарчим юм. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг; 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг; 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг; 26 дугаар зүйлд хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэгдсэн тодорхой заалтууд байдаг. Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүрэгтэй байгуулагдсан Хянан шалгах түр хороо, Түр хороо, ажлын хэсэг болон ерөнхий хяналтын сонсголын талаарх мэдээллийн тойм:

***Хууль хэрэгжиж эхэлснээс хойш хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын ажлууд:***

- УИХ-ын гишүүний асуулга, асуулт-24;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн - 2;
- Хянан шалгах Түр хороо байгуулсан - 1;
- Түр хороо байгуулсан - 2;
- Ажлын хэсэг байгуулсан - 6;
- Хяналтын сонсгол хийсэн – 2.

***Хянан шалгах түр хороо, хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр явуулсан үйл ажиллагаа:***

Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 56 хяналт шалгалтын ажил хийгдсэнээс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиглэлээр 9 удаа Хянан шалгах Түр хороо, Түр хороо, Ажлын хэсгүүд байгуулагдан ажилласан. Үүнээс:

- Хянан шалгах Түр хороо - 1;
- Түр хороо - 2;
- Ажлын хэсэг - 6.

***Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол:***

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу нийт 14 удаа хяналтын сонсгол зохион байгуулснаас Хүний эрх, эрх

чөлөөг хамгаалахтай холбоотой 2 удаагийн хяналтын сонсголыг зохион байгуулсан. Үүнд:

- **2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр** Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны *“Дотоод орчны агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, үр нөлөөг сайжруулах, тухайн чиг үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэдээлэл авах”* сэдэвт Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, сонсголын тайланг [parliament.mn](http://parliament.mn) цахим хаягт байршуулсан.
- **2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр** Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны *“Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах”* сэдэвт Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, сонсголын тайланг [parliament.mn](http://parliament.mn) цахим хаягт байршуулсан.

***УИХ-д Засгийн газар, холбогдох төрийн байгууллагуудаас хүний эрхийн асуудлаар илтгэл, тайлан хэлэлцүүлсэн байдал:***

УИХТГ-ын ХШҮГ-ын мэдээллийн санд 2022.10.17-2023.10.17-ны өдрийн хооронд Засгийн газар, холбогдох төрийн байгууллагуудаас УИХ-д хүний эрхийн асуудлаар дараах 2 асуудлыг хэлэлцүүлсэн талаар бүртгэгдсэн байна. Үүнд:

- УИХ-ын НББХ-ны 2022.11.15-ны өдрийн хуралдаанаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх асуудлыг”; <https://www.parliament.mn/nn/18922/>
- УИХ-ын БСШУСБХ, НББХ хамтарсан 2023.04.12-ны өдрийн хуралдаанаар БШУ-ны сайд Л.Энх-Амгалан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын талаарх асуудлыг” тус тус хэлэлцүүлсэн. <https://www.parliament.mn/nn/29902/>

***УИХ-ын гишүүдээс Хүний эрхийн асуудлаар тавьсан асуулт, асуулга:***

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдсанаас хойш 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд Хүний эрхийн асуудлаар Улсын Их Хурлын 9 гишүүнээс 4 асуулт, 20 асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас

бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагуудад хандаж тавьсан.

Эдгээрээс 6 асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар, 1 асуултын хариуг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн болно.

### ***УИХ-аас ХЭҮК-ын илтгэлийг хэрхэн авч хэлэлцсэн талаарх мэдээлэл***

УИХ-аас ХЭҮК-ын тайлан илтгэлийг авч хэлэлцүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссын тухай хуулиудын дагуу авч, хэлэлцэж байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Улсын Их Хурал жил бүр хэлэлцэх тухай, мөн 16.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийж, шинжилгээ хийсэн талаарх танилцуулгыг холбогдох Байнгын хороонд хүргүүлэх тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.3 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Хууль зүйн байнгын хороо болон холбогдох бусад байнгын хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэх тухай, Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлэх тухай, мөн 9.2 дахь хэсэгт Комиссын илтгэлийг жил бүрийн Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурал тогтоол гаргахаар заасан.

УИХ нь тогтоол гаргахдаа ХЭҮК-ын илтгэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ЗГ-г чиглэл өгдөг бөгөөд хэрэгжилт нь зарим талаар хангалтгүй байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль 2020 онд шинэчлэн батлагдсан бөгөөд түүнээс хойш хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20, 21, 22 дахь илтгэлийг бэлтгэн УИХ-д хүргүүлж, хэлэлцүүлсэн.

*3.3. Парламент хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүний эрхийн үр нөлөөг дүгнэх, үнэлэх журам, аргачлалыг боловсруулсан уу? Үүнд тодорхой эмзэг бүлгийн хувьд ялгаварлан гадуурхлын үр нөлөөг бий болгож болзошгүй хуулиудад хийх үнэлгээ дүгнэлт мөн багтдаг уу?*

Парламентын түвшинд Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 77 дугаар захирамжаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх журам”-д үнэлгээ хийх ажлыг төлөвлөхдөө Монгол Улсын ХЭҮК-оос хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал ирүүлсэн бол төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар боловсруулахдаа харгалзан үзнэ гэж тусгасан ба одоогоор энэ зохицуулалтын дагуу хууль тогтоомжид тусгайлан хүний эрхийн үнэлгээ хийгдээгүй байна.

УИХ-ын хууль тогтоох, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх чадавхыг бэхжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний 3.1.8-д “хуулийн төслүүд хүний эрхийг хангасан эсэхэд нөлөөллийн үнэлгээ хийж, Хүний эрхийн олон улсын конвенц болон НҮБ-аас хүний эрхийн талаар гаргасан зөвлөмжүүдтэй нийцүүлж баталдаг болох” зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд УИХ-ын Тамгын газрын ХЭЗГ-ын бүтцэд Эрх зүйн дүн шинжилгээний хэлтэс, мөн ХШҮГ-ын бүтцэд Төсвийн шинжилгээний хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний алба байгуулагдсан бөгөөд эдгээр нэгжүүд нь УИХ-д өргөн барьсан хуулийн төсөл болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэгтэй ажилладаг. ЭЗДШХ 2021 онд 3 хуулийн төсөлд, 2022 онд 5 хуулийн төсөлд, 2023 онд 3 хуулийн төсөлд эрх зүйн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зарчмыг баримтлахыг хуульчилсан. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3-т Улсын Их Хурал Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг жил бүр хэлэлцэнэ гэж заасан. Хуулийн 16.1-д тайланд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараана гэснийг удирдлага болгон УИХТГ-аас 2021 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 2022 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлд тус тус шинжилгээ хийсэн.

2023 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг УИХ-аар хэлэлцсэн боловч УИХТГ-аас шинжилгээ хийгээгүй байна.



ХЭҮК 2001 оноос хойш хүний эрхийн асуудлаар 108 судалгааны ажлыг хийсэн. Үүнээс 2011-2021 онд 58 судалгааны ажил хийжээ. Судалгаа, үнэлгээний үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг хүний эрх, чөлөөний байдлын талаарх илтгэлд тусган УИХ-д танилцуулж байна.

Мөн ХЭҮК-ын зүгээс Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ)-ний аргачлал боловсруулсан ба ХЭНБҮ нь тодорхой бодлого, хөтөлбөр, төсөл, бизнесийн үйл ажиллагааны улмаас хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, арилгах буюу бууруулах арга хэмжээ авах үйл явц юм. ХЭНБҮ нь хэт ерөнхий, хийсвэр хандлагаар хандаж үр дүн багатай байсан хүний эрхийн асуудлыг нарийвчлан тодорхойлох, баримтаар үндэслэх, шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Ялангуяа бизнесийн байгууллагуудад хүний эрхийн ойлголтыг бодит туршлагаар, хөрсөнд буулгаж ойлгуулах, хэрэгжүүлэх хандлагыг төлөвшүүлэхэд үр дүнтэй байдаг. ХЭНБҮ-ний нэг чухал давуу тал нь байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгагдаагүй асуудлыг нарийвчлан авч үзэх бололцоог олгодгоороо чухал ач холбогдолтой юм.<sup>125</sup>

Цаашилбал ХЭҮК-ын зүгээс хүний эрхийн нэр томъёоны тайлбар боловсруулж, эрдэмтэн судлаач төдийгүй иргэд, олон нийтийн хүний эрхийн боловсрол, хүний эрхийн түгээмэл соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулж байна. ХЭҮК-ын зүгээс Үндэсний статистикийн хороо, Хүний эрхийг хангах Үндэсний хороотой хамтран, манай улсад анх удаа Хүний эрхийн үндэсний индекс боловсруулж, нийгмийн бүлгийн мэдээлэл, тэдэнд тулгамдсан асуудлыг бодитой, итгэхүйц, найдвартай байдлаар баримтжуулан судлах, мөшгих, сан бүрдүүлэх зорилготой ажиллаж байна.

*3.4. Олон улсын хүний эрхийн ямар гэрээнд танай улс нэгдэн ороогүй байгаа вэ? Танай улс нэгдэн орсон хүний эрхийн гэрээний ямар заалтуудыг түр зогсоосон бэ? Түр зогсоосон шийдвэртэй холбоотойгоор гэрээний байгууллагуудаас хийсэн сүүлийн үеийн дүгнэлт ажиглалтыг уншиж танилцсан уу?*

Монгол Улс Хүний эрхийн суурь 10 гэрээ, тэдгээрийн Нэмэлт Протоколуудаас “Бүх цагаач ажилчид, тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц” (International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families 18 Dec 1990)-д нэгдэн ороогүй. Тус конвенцод Монгол Улс хоёр их гүрний дунд орших, далайд гарцгүй, цөөн хүн амтай орны хувьд эдийн засаг, хүн ам зүйн бодлого болоод үндэсний аюулгүй байдлын үүднээс одоогоор нэгдэн ороогүй байна.

<sup>125</sup> ХЭҮК, Бодлогын инновацийн хүрээлэн, НҮБХХ, Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) гарын авлага, Улаанбаатар хот, 2020 он. 9 дэх тал.

**Сүүлийн 12 сарын хугацаанд:**

*Засгийн газар олон улсын хэмжээнд сүүлийн үед хийж буй үйл ажиллагааны талаар парламентад мэдээлэл хийсэн үү?*

Сүүлийн 12 сарын хугацаанд тухайн асуудлаар мэдээлэл хийгдээгүй байна.

*Чуулганаар хүний эрхийн асуудлаар засгийн газарт асуулт, асуулга тавьж, хангалттай мэдээлэл авч чадсан уу?*

2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанаас 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд хүний эрхийн асуудлаар Улсын Их Хурлын 9 гишүүнээс Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагуудад хандаж нийт **4** асуулт, **20** асуулга тавьж, хариултаа авсан байна. Үүнд:

**Асуулт:**

1. УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт хандаж “Шүүхийн шийдвэргүйгээр цагдан хорих явдал онцгой тохиолдол гэхээсээ илүү жирийн үзэгдэл хэвээр байгаа, мөн иргэдийг цагдаагийн байгууллагад хуульч байлцуулахгүйгээр байцаалт авдаг байдал хэвшмэл байгаа”, “эрүүгийн мөрдөн байцаагч, прокурорууд асар их, хяналтгүй эрх мэдэл эдэлж байхад талуудын эрх тэгш байдлыг үл тоомсорлон шүүгдэгчдэд зохих хууль эрх зүйн журмын бүхий л баталгааг хангаж өгөхгүй байгаа нь санаа зовоож байна”, “хүний эрхийг хамгаалагчдын хууль ёсны ажилд саад учруулах, ялангуяа тэдний стратегийн хөгжлийн төслүүдийг эсэргүүцэж, тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх, цуглаан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад ашиглагдаж болзошгүйд анхаарал хандуулж байна” зэрэг олон асуудлуудын талаар “Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай”;
2. УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд хандаж “Сургуулийн орчинд үйлдэгддэг зарим гэмт хэргийн талаар”;
3. УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт хандаж “Сургуулийн орчинд үйлдэгддэг зарим гэмт хэргийн талаар”;
4. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлд хандаж “Коронавируст халдвар “КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар” зэрэг асуултуудыг тус тус асуусан байна.



**Асуулга:**

1. УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж ““Элэг бүтэн Монгол” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар”;
2. УИХ-ын гишүүн Ц.Туваанаас Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хандаж “Эм үйлдвэрлэл, эмийн үнийн талаар”;
3. УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Эмийн үйлдвэрлэл, чанар, хяналт, хүртээмжийн зэрэг асуудал болон энэ талаарх цаашдын бодлого, зорилтын талаар”;
4. УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Иргэний улс төрийн эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаар”;
5. УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатараас Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хандаж “Махны чанар, түүнд тавих хяналтын талаар”;
6. УИХ-ын гишүүн Б.Баярсайханаас Эрүүл мэндийн сайд С.Энхболдод хандаж “Хүн амын нийтийн эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай”;
7. УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар”;
8. УИХ-ын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж ““Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний үр дүнгийн талаар”;
9. УИХ-ын гишүүн Б.Баярсайханаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд хандаж “Малчдын өмнө тулгамдаж буй асуудлын талаар”;
10. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
11. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
12. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
13. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Зам, тээврийн хөнжлийн сайд С.Бямбацогтод хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;

14. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
15. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Сангийн сайд Б.Жавхланд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
16. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
17. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваад хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
18. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
19. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Сангийн сайд Б.Жавхланд хандаж ““КОВИД-19” цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар”;
20. УИХ-ын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахмал түлшний талаар” зэрэг асуулгуудыг тус тус тавьсан байна.

*Хуулийн хэрэгжилт хүний эрхийн хувьд үзүүлж буй үр нөлөөг үнэлэх асуудлыг тогтмол (чуулганаар/ хорооны хурлаар) хэлэлцдэг үү?*

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2023.07.05-ны өдөр Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол хийсэн. Улмаар 2023.10.06-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг сонсож, хүүхдийн эрхийн нээлттэй сонсгол хийхийг холбогдох байнгын хороонд даалгасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос 2023.10.25-ны өдөр Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудлаар хяналтын сонсгол зохион байгуулсан.

*Хүний эрхийн тодорхой асуудлаар парламент судалгаа хийх, асуулга явуулах, эсхүл баримт нотолгоо илрүүлэх ажлыг хийсэн үү? Хэрэв тийм бол, эдгээр ажлын үр дүн, үр нөлөө юу байв?*

УИХТГ-ын бүтцэд Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн ажилладаг бөгөөд тус хүрээлэн нь УИХ-ын гишүүдийг судалгаа, мэдээллээр хангаж

ажилладаг. Тус хүрээлэнгээс хүний эрхийн чиглэлээр УИХ-ын гишүүдийн санаачлан боловсруулж буй хуулийн төсөл болон УИХ-аар хэлэлцэн баталж буй асуудалд хамаарах дараах судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Улсын төсвийн тухай хуулийн төсөл хүний эрхэд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, ядуурлыг бууруулахад чиглэсэн эсэх шалгуур үзүүлэлтийг шалгах хуудас боловсруулах судалгаа СТ-21/250;
- Хүний эрхийн боловсрол олгох тогтолцоо ба парламентын оролцооны талаарх харьцуулсан судалгаа СТ-21/234;
- Үндсэн хуулийн цэц (шүүх)-ээр хүний эрхийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой бусад орнуудын туршлага СТ-23/207;
- Хуулийн төсөлд хууль зүйн дүгнэлт гаргах болон хүний эрхийг хангасан эсэхэд үнэлгээ хийх аргачлалын талаарх бусад орны туршлага СТ-21/252;
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын зохицуулалт: гадаадын зарим орны туршлага СТ-21/209;
- Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх ба хүний эрхийн боловсрол СТ-21/411;
- Хүний эрхийн институцийн загварууд, омбудсмэний тогтолцоо, үйл ажиллагааны хэлбэр, эрх зүйн байдал СТ-19/201;
- Парламентын Хүний эрхийн хороод, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх гадаадын зарим орны туршлага СТ-18/221;
- Мандатын эрх, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, Байцаан шинжих түр хороо, түүний бүрэн эрх, Хүний эрхийн омбудсмэн, Авлигатай тэмцэх омбудсмэн, Төсвийн аудитын талаарх харьцуулсан судалгаа СТ-09/217.

Хүний эрхийн шууд холбогдолтой, тодорхой асуудлаар баримт нотолгоо илрүүлэх ажлын хүрээнд УИХ-ын зарим гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын холбогдох сайд нараас дараах асуулт, асуулгад хариулт авсан байна. Үүнд:

- УИХ-ын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт хандаж “Шүүхийн шийдвэргүйгээр цагдан хорих явдал онцгой тохиолдол гэхээсээ илүү жирийн үзэгдэл хэвээр байгаа, мөн иргэдийг цагдаагийн байгууллагад хуульч байлцуулахгүйгээр байцаалт авдаг байдал хэвшмэл байгаа”, “эрүүгийн мөрдөн байцаагч, прокурорууд асар их, хяналтгүй эрх мэдэл эдэлж байхад талуудын эрх тэгш байдлыг үл тоомсорлон шүүгдэгчдэд зохих хууль эрх зүйн журмын бүхий л баталгааг хангаж өгөхгүй байгаа нь санаа зовоож байна”, “хүний эрхийг

- хамгаалагчдын хууль ёсны ажилд саад учруулах, ялангуяа тэдний стратегийн хөгжлийн төслүүдийг эсэргүүцэж, тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх, цуглаан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад ашиглагдаж болзошгүйд анхаарал хандуулж байна” зэрэг олон асуудлуудын талаар “Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай”;
- УИХ-ын гишүүн Т.Доржхандаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Иргэний улс төрийн эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн талаар”.

## **АСУУЛТ 5. НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТАЙЛАГНАХ МЕХАНИЗМ ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ**

### **Сэдвийн тойм**

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үндэсний тайланг боловсруулах үүргийг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлдэг бөгөөд тайланг бэлтгэх ажлыг зохион байгуулах, хүргүүлэх, хэлэлцүүлэхтэй холбоотой журам болон тайланг хариуцан боловсруулах байгууллагын хуваарийг Засгийн газраас баталдаг.

Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоонд онцгой үүрэгтэй субъектын хувьд УИХ-аас хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд НҮБ-ын хүний эрхийн тайлагнах механизмд оролцож байна. Тухайлбал, УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, түүний бүрэлдэхүүнд ажилладаг Хүний эрхийн дэд хороогоор хүний эрхийн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, НҮБ-ын гэрээний байгууллагуудад илгээж буй Засгийн газрын тайлан, эдгээр байгууллагуудаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт зэргийг хэлэлцэн санал дүгнэлт гаргах, шаардлагатай зарим асуудлыг Хууль зүйн байнгын хороогоор дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулах боломжтой. Мөн УИХ-ын бусад байнгын хороод өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүний эрхийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газраас боловсруулсан тайлангийн төслийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргах боломжтой.

Одоогийн байдлаар Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль болон ЗГ-ын “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-ын хүрээнд НҮБ-ын хүний эрхийн үндэсний тайланг боловсруулахад УИХ-ын зүгээс шууд оролцох зохицуулалт байхгүй. Хэдий тийм ч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн үндэсний тайлан, гаргасан шийдвэрийг холбогдох хуульд заасны дагуу УИХ-д хүргүүлдэг бөгөөд энэ хүрээндээ УИХ-ын гишүүд мэдээлэл авч ажиллаж байна. Харин хүний эрхийн олон талт гэрээг Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар зохицуулсан. Иймд цаашид соёрхон баталж нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн байдлыг Улсын Их Хурлаар тогтмол хэлэлцдэг байх нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх ажилд ахиц авчрах юм.

НҮБ-ын хүний эрхийн мониторингийн чухал механизмын нэг болох тусгай илтгэгч, төлөөлөгч, ажлын хэсэг ихэвчлэн Монгол Улсын Засгийн газрын урилгаар ирдэг боловч УИХ-ын дарга, гишүүд болон холбогдох Байнгын

хорооны гишүүдтэй уулзаж бодлого, эрх зүйн орчин, тогтолцооны талаар мэдээлэл авахаас гадна хүний эрхийн тодорхой асуудлаар нөхцөл байдлыг үнэлэхэд шаардлагатай мэдээлэл авдаг. 2017 оноос хойш Монгол Улсад НҮБ-ын тусгай илтгэгч, төлөөлөгч 6 удаа ирсэн бөгөөд хамгийн сүүлд хэдхэн хоногийн өмнө Шүүгч, өмгөөлөгчдийн хараат бус байдлын асуудал хариуцсан НҮБ-ын тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт хүрэлцэн ирж УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг нартай уулзсан байна.

*5.1. Парламентад тухайн улс ба НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны статусыг баталгаажуулах механизм байгаа юу? (тухайлбал, парламентын хүний эрхийн хороо, ажлын хэсэг, бүлэг, тусгай комисс)*

## НҮБ-ын Хүний эрхийн механизмууд

НҮБ-ын хүний эрхийн механизмд 1) Хүний эрхийн суурь гэрээний байгууллагууд, 2) Хүний эрхийн зөвлөл, 3) Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR - Universal Periodic Review) хамаарч байна.

### 1. Хүний эрхийн суурь гэрээний байгууллагууд

Хүний эрхийн тухай суурь 9 гэрээ, тэдгээрийн нэмэлт протоколын хэрэгжилтийг хангах бие даасан шинжээчдээс бүрдсэн байгууллагуудыг хэлнэ. Үүнд:<sup>126</sup>

1. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц;
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт;
3. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт;
4. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;
5. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц;
6. Хүүхдийн эрхийн тухай конвенц;
7. Бүх цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц /Монгол Улс хараахан соёрхон батлаагүй/;
8. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц;
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц.

<sup>126</sup> <https://www.ohchr.org/en/core-international-human-rights-instruments-and-their-monitoring-bodies>

## **2. Хүний Эрхийн зөвлөл (Хүний Эрхийн Комисс)<sup>127</sup>**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 03-р сарын 15-ны өдрийн 60/251 тоот тогтоолоор<sup>128</sup> НҮБ-ын Хүний эрхийн Комиссыг Хүний эрхийн зөвлөл болгон өөрчлөн байгуулж, “гишүүн бүх улсынхаа хүний эрхийн үүрэг, амлалтынх нь биелэлтийн талаар үнэн бодит мэдээлэлд үндэслэн, тэдэнд шударга бөгөөд бүхий л хүрээний асуудлыг хамруулан дүгнэлт хэлэлцүүлэг хийх” эрхийг Хүний эрхийн зөвлөлд олгосон.

2007 оны 06-р сарын 18-нд Хүний эрхийн зөвлөлийн шинэ гишүүд баталсан зөвлөлийн ирээдүйн ажлын удирдамжийг агуулсан зохион байгуулалтын баримт бичиг<sup>129</sup> (А/ХЭЗ/шийдвэр/5/1)-ийн нэг үндсэн хэсэг нь Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг - UPR-ийн тухай байсан юм.

## **3. UPR-ийн тухай ойлголт**

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR - Universal Periodic Review) нь НҮБ-ын гишүүн 192 орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутам дүгнэн хэлэлцэх механизм юм.

UPR нь бүх улс оронд ялгаваргүй, тэгш хандах, хэлэлцүүлэгт орж байгаа улстай хамтран ажиллах зарчимд үндэслэдэг ба улс орнууд дахь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүний эрхийг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулахад төр засагт туслах, техникийн туслалцааны асуудлыг ч мөн авч үздэг нэгэн онцлогтой юм.

**UPR-ийн зорилго** нь дэлхийн бүх хүний тусын тулд улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлыг газар дээр нь сайжруулахад оршино. Энэ зорилгодоо хүрэхийн тулд улс орнууд дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, хүний эрх зөрчигдөх тохиолдол бүрд анхаарлаа хандуулах боломжийг эрэлхийлэх бөгөөд улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн салбар дахь сайн туршлагаа хуваалцах, бие биенээсээ суралцах боломжийг олгох, хүний эрхийн асуудлаа сайнаар шийдвэрлэх чадавхыг бэхжүүлдэг байна.

## **Монгол Улсын хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо**

Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог өргөн хүрээгээр авч үзвэл, Ерөнхийлөгч, УИХ, ЗГ, Хүний эрхийн үндэсний комисс, шүүх, прокурор, ҮХЦ, өмгөөлөх гэх мэт хүний эрхийг хамгаалах шууд үүрэг, зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд, бүх шатны төрийн захиргааны болон нутгийн

<sup>127</sup> <https://www.ohchr.org/en/hrbodies/hrc/home>

<sup>128</sup> <https://www.ohchr.org/en/hr-bodies/upr/basic-facts>

<sup>129</sup> <https://upr-mongolia.mn/images/xupld/51mon.pdf>



өөрөө удирдах байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшил, хүний эрхийн хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах дотоодын хэрэгслүүдийг багтаадаг. Үүнээс УИХ буюу УИХ дахь Хүний эрхийн дэд хорооны талаар дэлгэрүүлж авч үзэв.

### ***УИХ-ын Хүний эрхийн дэд хороо (ХЭДХ)***

Улсын Их Хурал нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд онцгой хариуцлага хүлээдэг. УИХ энэ чиглэлд хууль тогтоомж баталдаг, хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орох эсэхийг шийддэг. УИХ улсын төсвийг батлахдаа хүний эрхийг хангахад шаардлагатай төсөв хуваарилагдаж, зориулалтын дагуу зарцуулагдсан эсэхийг хянан шалгадаг. УИХ нь мөн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт тавих үүрэгтэй. Тиймээс, УИХ бүхэлдээ болон Хууль зүйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо зэрэг бүх байнгын хорооны үйл ажиллагаа хүний эрхийг хамгаалахад шийдвэрлэх нөлөөтэй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар хүний эрх, эрх чөлөө, түүний баталгааг хангах үүрэг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд багтдаг бөгөөд түүний бүрэлдэхүүнд Хүний эрхийн дэд хороо (ХЭДХ) ажиллаж байна.<sup>130</sup>

ХЭДХ нь парламентын хүний эрхийн хорооны нийтлэг жишгийн дагуу эрхлэх асуудлаа дагнан хариуцаж, санал, дүгнэлт гаргах, түүнийгээ Хууль зүйн байнгын хороонд, шаардлагатай бол Хууль зүйн байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, хариуцсан асуудлынхаа хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ХЭДХ нь УИХ-ын бусад дэд хорооны нэгэн адил дараах бүрэн эрхтэй. Үүнд: хүний эрхийн, эсхүл эрхлэх бусад асуудлаараа хяналт-шалгалт, судалгаа хийх, холбогдох мэдээлэл авах, зохих албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авах, ажлын хэсэг байгуулах, эрхэлсэн асуудлынхаа хүрээнд тогтоол гаргах, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулж, харьяалах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй. Жишээлбэл, хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагыг судалж, хүний эрх зөрчигдөх үндэслэлийн талаар санал, дүгнэлт гаргаж Хууль зүйн байнгын хороогоор дамжуулан УИХ-д уламжилж болно. Түүнчлэн ХЭДХ нь хүний эрхийн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, НҮБ-ын гэрээний байгууллагуудад илгээж буй засгийн газрын тайлан, эдгээр байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт зэргийн талаар санал, дүгнэлт гаргах боломжтой.

<sup>130</sup> Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл. Улаанбаатар, 2021 он, О.Мөнхсайхан, Р.Очирбал



Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудлыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч, авч хэлэлцдэг.

*5.2. НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын талаар парламентад байнга мэдээлэл өгдөг үү? Парламентын ажлын албаны ажилтнууд, ХЭҮК, иргэний нийгмийн байгууллагууд холбогдох мэдээллийг тогтмол авах боломжтой байдаг уу?*

НҮБ-ын хүний эрхийн мониторингийн байгууллагын талаарх мэдээлэл болон хүний эрхийн талаарх асуудал нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд зааснаар Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооны харьяалах асуудалд хамаарч, тус хуульд заасны дагуу эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцан санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлдэг. Тодруулбал,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хүний эрхийн асуудлаар тайлан, илтгэл, мэдээллийг сонсох, хэлэлцэх дэгийг зохицуулсан бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар 2 жил тутам, Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэлийг жил бүр Хууль зүйн байнгын хороо болон холбогдох байнгын хороогоор мэдээлэл сонсож, хэлэлцэж байна.

УИХ-аас 2021 онд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд, тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, НҮБ-аас өгсөн зөвлөмжийг судлан Улсын Их Хуралд танилцуулах Ажлын хэсгийг байгуулж, уг ажлын хэсгээс гаргасан тайлан, дүгнэлтийг 2023 оны хаврын чуулганы хугацаанд ХЗБХ, АБГББХ, НББХ зэрэг УИХ-ын байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд УИХ-аас Засгийн газарт чиглэл өгсөн тогтоолын төслийг боловсруулж байна. Уг ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил ахлан ажиллаж байна.

УИХ-аас жил бүр ХЭҮК-ын тайланг хэлэлцэхдээ Монгол Улсын хүний эрхийн үндэсний тайлангийн мониторингийн дүн, холбогдох зөвлөмжийн талаар мэдээлэл авч, Засгийн газраас оруулсан саналын дагуу бодлого, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэдэг.

*5.3. Парламент, эсхүл эрх бүхий хороо улс орны хүний эрхийн тайланг боловсруулахад оролцдог уу?*

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд

хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулахаар (*Монгол Улсын Олон Улсын гэрээний тухай хуулийн §24.4.*) заасан байдаг.

Мөн Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”<sup>131</sup>-ыг 2017 онд шинэчлэн баталсан бөгөөд уг журмаар тайлан бэлтгэх ажлыг зохион байгуулах, хүргүүлэх, хэлэлцүүлэх асуудлыг зохицуулахаас гадна олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан хариуцан боловсруулах байгууллагын хуваарийг баталсан байна. Энэ хуваарийн дагуу холбогдох байгууллагууд үндэсний тайланд орох мэдээ, мэдээллүүдийг гаргаж байна.

Монгол Улсаас НҮБ-ын Хүний эрхийн механизмд хүргүүлэх Үндэсний тайланг 2010 оноос хойш 3 удаа явуулсан.

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар болон ЗГ-ын “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-аар Парламент болон эрх бүхий хороо энэ тайланг боловсруулахад оролцох зохицуулалт байхгүй байна.

**5.4. Хүний эрхийн гэрээний байгууллагуудад улс орны өргөн мэдүүлэх үндэсний тайлантай холбоотой тайлагнах хуваарийн талаар парламентын гишүүд мэддэг үү?**

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулах (*Монгол Улсын Олон Улсын гэрээний тухай хуулийн §24.4.*) үүрэгтэй.

Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”<sup>132</sup>-ыг 2017 онд шинэчлэн баталсан бөгөөд тус журам нь тайлан бэлтгэх ажлыг зохион байгуулах, хүргүүлэх, хэлэлцүүлэх талаар зохицуулахаас гадна олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг хариуцан боловсруулах байгууллагын хуваарийг хавсралтаар гаргасан байна. Энэ хуваарийн дагуу холбогдох байгууллагууд үндэсний тайланд орох мэдээ, мэдээллүүдийг гаргаж байна.

Тус журамд зааснаар Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх (журмын 2.8.) бөгөөд засгийн газраас гарсан тогтоолыг

<sup>131</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12817>, Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, МУЗГ-ын 2017.07.04-ны өдрийн 193-р тогтоол.

<sup>132</sup> <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12817>, Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, МУЗГ-ын 2017.07.04-ны өдрийн 193-р тогтоол.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу УИХ-д хүргүүлж, түүний дагуу УИХ-ын гишүүдийг мэдээлэлжүүлж ажиллаж байна.

*5.5. Олон улсын хүний эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч, төлөөлөгч парламентад ирж ажилласан эсэх. УИХ-ын гишүүдтэй уулзалт хийсэн байдал*

### **Хүний эрхийн зөвлөл (НҮБ, ХЭДКГ)-ийн тусгай илтгэгч, төлөөлөгч**

Тусгай илтгэгч, төлөөлөгчийн тогтолцоо нь НҮБ-ын хүний эрхийн механизмын чухал бүрэлдэхүүн юм. Эдгээр хүмүүс нь хүний эрхийн талаар сэдэвчилсэн мэдээлэл хийх, улс орны онцлогийг таньж мэдэх, зөвлөгөө өгөх эрх бүхий хараат бус, бие даасан хүний эрхийн шинжээчид юм. Тэд НҮБ-ын ажилтан биш бөгөөд санхүүгийн урамшуулал авдаггүй. Тэднийг гурван жилээр сонгодог бөгөөд дахин гурван жилээр сунгах боломжтой.<sup>133</sup> НҮБ-ын тусгай илтгэгч, төлөөлөгчид ихэвчлэн Монгол Улсын Засгийн газрын урилгаар ирдэг бөгөөд ингэхдээ УИХ-ын дарга, гишүүд болон холбогдох байнгын хороотой уулзаж хууль эрх зүйн орчин, тогтолцооны талаар мэдээлэл авдаг. 2017 оноос хойш Монгол Улсад ирсэн олон улсын тусгай илтгэгч, төлөөлөгчдийн мэдээлэл:

#### ***2023.11.06-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт Монгол Улсад хийсэн айлчлал***

Шүүгч, өмгөөлөгчдийн хараат бус байдлын асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт 2023 оны 11 дүгээр сарын 06-наас 15-ны өдрүүдэд ажлын айлчлал хийсэн.

Айлчлалын үеэр 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр УИХ-ын гишүүн, ХЗБХ-ны дарга Д.Цогтбаатар, УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг нартай албан уулзалт хийж, шүүгч, шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах, хуульчийн мэргэшлийн үйл ажиллагааг хараат бусаар эрхлэх нөхцөл, шүүгчдийн нийгмийн асуудал, тус салбарын шинэчлэлийн талаар санал солилцов.

#### ***2022.10.14-ний өдөр НҮБ-ын ажлын хэсэг Монгол Улсад хийсэн айлчлал***

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хууль бусаар саатуулах ажлын хэсэг Засгийн газрын урилгаар 2022 оны 10-р сарын 03-аас 10-р сарын 14-ний өдрүүдэд Монгол Улсад ажилласан.

<sup>133</sup> <https://www.ohchr.org/en/special-procedures-human-rights-council/special-procedures-human-rights-council>

Ажлын хэсэг нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2020)-ын зэрэг өөрчлөлтүүдийг сайшааж мөн Хүний эрхийг хамгаалагчийн тухай, Өршөөлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг хэд хэдэн хуулийн ололт, сорилтыг тодорхойлсон.

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай уулзахын зэрэгцээ УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны даргатай уулзсан.<sup>134</sup>

***2021.12.08-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч Рим Алсалемын Монгол Улсад хийсэн айлчлал***

НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаарх тусгай илтгэгч Рим Алсалем 2021 оны 11-р сарын 29-нөөс 12-р сарын 08-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилсан.

Айлчлалын зорилго нь эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх эрх зүйн болон институцийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлыг үнэлж дүгнэх, ололт, амжилтыг тэмдэглэх явдал байв.

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай уулзахын зэрэгцээ УИХ-ын дарга болон УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны даргатай уулзсан.<sup>135</sup>

***2019.09.11-ний өдөр НҮБ-ын шинжээч Хуан Пабло Бохославскийн Монгол Улсад хийсэн айлчлал***

НҮБ-ын Хүний бүхий л эрх, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ бүрэн эдлэхэд улс орнуудын гадаад өр болон бусад холбогдох олон улсын санхүүгийн үүргийн нөлөөллийн талаарх хараат бус шинжээч Хуан Пабло Бохославский 2019 оны 09-р сарын 02-ноос 09-р сарын 11-ний өдрүүдэд Монгол Улсад айлчилсан.

Айлчлалын зорилго нь а) өрийн болон макро эдийн засгийн бодлогыг хүний эрхийн үүднээс судлах, б) ашигт малтмалын түрээсийг нийгэм, байгаль орчныг хамарсан, цогц бодлого болгон хувиргаж, хүний эрхийг шат дараатай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, в) хууль бус санхүүгийн урсгал, түүний хүний эрхэд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлж буй зарим хүчин чармайлтыг үнэлэх; г) дэд бүтэц, уул уурхайн төслүүд болон гадаадын бусад шууд хөрөнгө оруулалтын зээлийг хүний эрхийн үүднээс авч үзэх гэсэн 4 асуудлын хүрээнд байв.

<sup>134</sup><https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G23/129/21/PDF/G2312921.pdf>

<sup>135</sup><https://www.ohchr.org/en/statements/2021/12/united-nations-special-rapporteur-violence-against-women-its-causes-and>

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай уулзахын зэрэгцээ Төрийн өндөр албан тушаалтнуудтай уулзсан.<sup>136</sup>

***2019.05.13-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч Мишель Форстын Монгол Улсад хийсэн айлчлал***

НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлын тусгай илтгэгч Мишель Форст 2019 оны 04-р сарын 30-наас 05-р сарын 13-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилсан.

Айлчлалын гол зорилго нь хүний эрхийг хамгаалагчдын нөхцөл байдлыг олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэг, амлалтын хүрээнд үнэлэх явдал байв.

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай уулзахын зэрэгцээ УИХ-ын дарга болон УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны даргатай уулзсан.<sup>137</sup>

***2017.09.27-ны өдөр НҮБ-ын тусгай илтгэгч Жон Х.Ноксын Монгол Улсад хийсэн айлчлал***

НҮБ-ын Хүний эрх, байгаль орчны асуудал хариуцсан Тусгай илтгэгч Жон Х.Нокс 2017 оны 09-р сарын 19-өөс 09-р сарын 27-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилсан.

Айлчлал нь аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой байгаль орчинтой холбоотой хүний эрхийн үүргийн хэрэгжилтийг дэмжих үүргийг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн.

Айлчлалын хүрээнд холбогдох албан тушаалтнууд, иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэн судлаачидтай уулзахын зэрэгцээ парламентын гишүүдтэй уулзсан.<sup>138</sup>

***5.6. НҮБ-ын Хүний эрхийн гэрээний хороодод хүргүүлэх тайлангийн боловсруулалт, тайлагнах процесст парламентын гишүүд орж ажилласан байдал***

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар болон Засгийн газрын “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн

<sup>136</sup><https://www.ohchr.org/en/statements/2019/09/end-mission-statement-independent-expert-effects-foreign-debt-visit-mongolia>

<sup>137</sup><https://www.ohchr.org/en/statements-and-speeches/2019/05/visit-mongolia-30-april-13-may-2019-end-mission-statement>

<sup>138</sup><https://www.ohchr.org/en/statements/2017/09/statement-united-nations-special-rapporteur-john-h-knox-conclusion-his-mission>

хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-аар Хүний эрхийн гэрээний хороодод хүргүүлэх тайлангийн боловсруулалт, тайлагнах явцад Улсын Их Хурлын гишүүд шууд оролцох, хувь нэмэр оруулах талаар нарийвчлан зохицуулаагүй байна. Өмнө дурдсан журмын дагуу олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан хариуцан боловсруулах байгууллагын буюу яамдын оролцоонд тулгуурлан тайланг бусад талтай хамтран боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлдэг. Энэ шатанд Улсын Их Хурлын гишүүн бөгөөд Засгийн газрын гишүүн асуудлыг нягтлах, нарийвчлан хэлэлцэх бүрэн боломжтой.

#### **Сүүлийн 24 сарын хугацаанд:**

*НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороодод явуулах илтгэл, тайлангийн төслийг УИХ-аар авч хэлэлцсэн эсэх талаарх мэдээлэл*

Монгол Улсын Их Хурал нь НҮБ-ын хүний эрхийн гэрээний хороодод явуулах илтгэл, тайлангийн төслийг УИХ-ын холбогдох байнгын хороо (АБГББХ) болон парламентаар авч хэлэлцээгүй байна. Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолын Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журмын дагуу яамд, бусад төрийн байгууллага тайланг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн илгээдэг. Өмнө нь Гадаад харилцааны яам дангаар бүх олон улсын гэрээний хороодод илгээх илтгэл, тайланг хариуцаж, зарим талаар тайлагнах хугацаанаас хоцроож байсан учир олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг Яамдууд чиг үүргийн хүрээнд боловсруулдаг жишиг тогтсон юм. Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сард байгуулсан Хүний эрхийг хангах Үндэсний хорооны хуралдааны үеэр Үндэсний тайлан хянах мэдээллийн сан (National Recommendations Tracking Database), Хэрэгжилт, тайлан, биелэлт хариуцсан үндэсний механизм (National Mechanisms for Implementation, Reporting and Follow-up) бий болгох, шинэ бүтэц байгуулах талаар санал хэлэлцэж байжээ.

*НҮБ-ын гэрээний хороод, UPR-т хүний эрхийн асуудлаарх үндэсний илтгэлийг танилцуулахад парламентын гишүүд оролцсон байдлын талаарх мэдээлэл*

#### **Монгол Улсын Хүний эрхийн үндэсний тайлангийн тухай**

Монгол Улс нь НҮБ-ын гэрээний хороод болон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт (UPR) 2010 оноос хойш 3 удаа үндэсний тайлангаа явуулжээ.

Эхний мөчлөг /2010.11.02/

Монгол Улс 2010 оны 11-р сарын 02-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-т анх удаа оролцсон. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан нийт 129 зөвлөмжөөс 126 зөвлөмжийг хэрэгжүүлэх амлалт авсан бөгөөд Монгол Улсын Засгийн газар нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдөр зөвлөмжүүдийг хэрхэн биелүүлсэн талаарх Үндэсний хоёрдугаар илтгэлээ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлсэн.

Хоёр дахь мөчлөг /2015.05.05/

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт 2 дахь удаа орж, 2015 оны 05-р сарын 05-ны өдөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Нэгдсэн чуулганы үеэр 164 зөвлөмж өгснөөс 150 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан.

Гурав дахь мөчлөг /2020.05.05/

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн Ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлж, 170 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан.

**Олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмж, дүгнэлтийг парламент авч хэлэлцэх процесс**

УИХ-ын Аюулгүй байдлын байнгын хороо нь “Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал” (Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн §24.1.6.)-ыг авч үзэх тул тус байнгын хороо нь шаардлагатай гэж үзвэл тайлангийн төслийг хэлэлцүүлэх асуудлаар санал, дүгнэлт гаргах боломжтой юм. Мөн Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар “Монгол Улсын олон улсын гэрээний үүргийн биелэлтэд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар зөвлөмж, чиглэл өгч, шаардлагатай бол энэ тухай санал боловсруулж Улсын Их Хурал, эсхүл Засгийн газарт танилцуулна” (Олон улсын гэрээний тухай хуулийн §24.3.) гэсний дагуу УИХ-ын бусад байнгын хороод өөрийн эрхлэх асуудлын хүрээний зөвлөмж, дүгнэлтийг авч хэлэлцэх боломжтой.

Сүүлийн 24 сарын хугацаанд Монгол Улсын Их Хурал нь Олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан зөвлөмж, дүгнэлтийг парламентаар авч хэлэлцээгүй байна.



## **АСУУЛТ 8. ОЛОН НИЙТ БА ХҮНИЙ ЭРХИЙН БУСАД БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ НЬ**

### **Сэдвийн тойм**

Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газраас нээлттэй парламентыг төлөвшүүлэх, олон нийттэй харилцах үйл ажиллагааныхаа хүрээнд хүний эрхийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, хүний эрхийн зөрчил, тулгамдсан асуудлуудыг тандан судлах, илрүүлэх, хүний эрхийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт, үнэлгээ хийх хүрээнд хүний эрхийг хамгаалах байгууллагууд болон иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж, хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр идэвхтэй харилцаж байна.

УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо болон холбогдох бусад байнгын хороодоос хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын илтгэлийг жил бүр тогтмол хэлэлцэж, хүний эрх зөрчигдсөн тодорхой асуудлаар хяналт шалгалт хийх, хүний эрхийн асуудлаар хяналтын болон нээлттэй сонсгол хийх, хуулийн төсөлд хүний эрхийн дүн шинжилгээ хийх байдлаар ажиллаж байна.

УИХТГ-аас УИХ-ын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд ХЭҮК-ын илтгэл болон хууль тогтоомжийн төсөлд дүн шинжилгээ хийх, судалгаа, мэдээллээр хангах, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаандаа хүний эрхийн чиг хандлагыг төлөвшүүлэх, үүнд шаардагдах тогтолцоо, чадавхыг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна. Тухайлбал:

Улсын Их Хурлын Тамгын газраас хэрэгжүүлж буй “Парламентын боловсрол”, “Өсвөрийн парламент” зэрэг олон нийтэд зориулсан хөтөлбөрүүдийн хүрээнд ардчиллын үнэт зүйлс, Үндсэн хууль, хүний эрх, хууль тогтоох байгууллагын талаарх мэдлэг олгох хөтөлбөрийг насны ангиллаар боловсруулж, олон нийтэд нээлттэй хэрэгжүүлж байна. Түүнчлэн УИХ-ын гишүүд болон УИХТГ-ын ажилтнууд, УИХ-ын гишүүдийн ажлын албаны ажилтнуудын хүний эрхийн мэдлэг, хандлагыг сайжруулахад чиглэсэн сургалтын багц хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажилтнуудынхаа хүний эрхийн мэдрэмжтэй хуулийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн төсөл болон хэрэгжилтэд хүний эрхийн дүн шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйг сайжруулахад анхаарч байна.



УИХ, түүний Тамгын газраас иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцахдаа уламжлалт харилцаанаас гадна сонин, сайт, радио, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн суваг, сэтгүүлчдээр дамжуулан харилцахаас гадна сүүлийн жилүүдэд нийгмийн сүлжээний платформуудыг ашиглан УИХ-аас гарч буй шийдвэр, үйл ажиллагаа, өдөр тутмын мэдээ, мэдээллийг түгээх ажлыг идэвхтэй зохион байгуулж, эргэх холбоотой ажиллаж байна.

Тухайлбал, иргэдээс хуулийн төсөлд санал авах [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим систем, өргөдөл, мэдээлэл хүлээн авах [www.petition.parliament.mn](http://www.petition.parliament.mn) цахим өргөдлийн системийг өнгөрсөн оноос эхлэн ажиллуулж байгаа бөгөөд иргэд эдгээр платформуудыг идэвхтэй ашиглаж байна. Одоогийн байдлаар [www.d.parliament.mn](http://www.d.parliament.mn) цахим системд 180 гаруй хуулийн төсөл байршуулж, давхардсан тоогоор 7 мянга гаруй иргэний саналыг хүлээн авсан бол [petition.parliament.mn](http://petition.parliament.mn) цахим системд улс орны тулгамдсан асуудлаар одоогийн байдлаар 20 гаруй өргөдөл байршиж, иргэдээс санал цуглуулж байна.

Монгол Улсад 2010 онд Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум байгуулагдсан бөгөөд эгнээндээ 40 гаруй төрийн бус байгууллагыг нэгтгэсэн энэхүү байгууллага нь Монгол Улсад хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, зөрчигдсэн эрхийг хамгаалах, Засгийн газарт хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүргийг сануулах, санал, шаардлагаа хүргүүлэх зэргээр ажиллаж байна. Тус байгууллагын [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn) вэб сайтыг “Глоб Интернэшнл” ТББ ажиллуулж, “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” (UPR) механизмын талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байгаа нь хүний эрхийн талаарх төр- иргэний нийгмийн харилцааг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж байна.

**8.1. УИХ, түүний Тамгын газраас хүний эрхийн талаар явуулдаг гол олон нийтийн арга хэмжээний талаарх мэдээ, мэдээлэл**

## **УИХ болон холбогдох байнгын хороо**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хүний эрх, эрх чөлөө, түүний баталгааг хангах үүрэг багтдаг бөгөөд түүний бүрэлдэхүүнд ХЭДХ багтаж байна. Энэ дэд хороо нь УИХ-аас хүний эрхийн талаар явуулах үйл ажиллагаанд тэргүүлэх үүрэгтэй оролцдог бөгөөд УИХ-ын бусад байнгын хороо нь салбарын асуудлаар холбогдох хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

**Хүний эрхийн дэд хороо нь** өнгөрсөн хугацаанд Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ХЭҮК-ын илтгэлийг хэлэлцэх, тодорхой хүний эрхийн зөрчлийн талаар шалгалт хийх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн төсөл, Хууль сахиулах тухай хуулийн төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зэрэг хуулийн төсөлд хүний эрх хэрхэн хангагдаж байгаад дүгнэлт гаргах, бэлгийн дарамт зэрэг хүний эрхийн асуудлаар нээлттэй сонсгол хийх байдлаар ажиллаж ирсэн.

Жишээлбэл, Мөн Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хорооноос 2023.10.25-ны өдөр УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар хяналтын сонсголыг зохион байгуулж, холбогдох байгууллагууд оролцож, илтгэл хэлэлцүүлж, асуудлаа тодорхойлсон.

**Нийгмийн бодлогын байнгын хорооноос** 2023.07.05-ны өдөр “Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт заасан хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах” хяналтын сонсголыг зохион байгуулж, асуудлаа тодорхойлсон.

**УИХ-ын Тамгын газар**

УИХ-ын Тамгын газар нь УИХ болон УИХ-ын байнгын, дэд, түр хороодод мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх хүрээнд дээр дурдсан үйл ажиллагаануудад оролцохын зэрэгцээ олон нийттэй харилцах болон сургалтын үйл ажиллагааны хүрээнд хүний эрхийн талаар үйл ажиллагаануудыг явуулж байна.

**Сургалт:** УИХ-ын Тамгын газрын зүгээс УИХ-ын гишүүд болон УИХ-ын Тамгын газрын ажилтнуудад сургалтын бодлогоор дамжуулан мэдлэг, мэдээлэл, ур чадварыг байнга нэмэгдүүлдэг билээ. Энэ хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

№	Сургалтын нэр	Хугацаа
1	Хүний эрхэд суурилсан хандлага	2020.12.08
2	Хүний эрхэд суурилсан хандлага	2021.11.04
3	Тэгш эрхийн зарчим ба ялгаварлан гадуурхалтыг хориглох нь	2022.10.31
4	Парламент болон хүний эрхийн үндэсний байгууллагууд хоорондын харилцааны тухай Белградын зарчмуудын талаарх хэлэлцүүлэг	2022.11.21
5	Хүний эрхийн талаарх төрийн үүрэг, хүний эрхийг хамгаалах Олон улсын болон Монгол Улсын тогтолцоо	2022.11.25

6	Ажил эрхлэлт, хөдөлмөрийн хүрээний дарамт, хүчирхийллийг танин мэдэж, урьдчилан сэргийлэх нь	2022.12.23
7	Хүний эрхэд суурилсан бодлого төлөвлөлт	2023.03.03
8	Технологи, хувь хүний мэдээлэл, хүний эрхийн эрсдэл	2023.04.21
9	Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламент: өөрийн үнэлгээ	2023.09.27

**Парламентын боловсрол хөтөлбөр:** “Парламентын боловсрол” хөтөлбөр хууль тогтоох үйл ажиллагаанд мэдээлэлтэйгээр идэвхтэй оролцдог, хариуцлагатай иргэдийг бэлтгэх, төлөвшүүлэх зорилготой. Хөтөлбөрийн агуулгад парламент гэж юу болохоос эхлээд, парламент ямар үйл ажиллагаа явуулдаг, хууль батлах үйл явц хэрхэн өрнөдөг, үүнд иргэд, хүүхэд, залуучууд хэрхэн оролцох боломжтой байдаг зэрэг өргөн хүрээтэй сэдвүүд багтсан. Мөн хүн бүрийн мэдвэл зохих, бидний хамтын үнэт зүйл болсон Ардчилал, Хүний эрх, Үндсэн хуулийн тухай мэдлэг энэ хөтөлбөрт шингэсэн. Монгол хүн бүрийн бахархал, омогшлыг төрүүлдэг Төрийн сүлд, төрийн дуулал, туг далбаа зэрэг төрийн бэлгэдлийн утга, учрыг сонирхолтой агуулга, хэлбэрээр тайлбарлан тусгасан.

Хөтөлбөрийн агуулгыг 12-14 нас, 15-17 нас, 18-аас дээш гэсэн насны ангиллаар боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлээд байна. Багш, сурагчдад зориулсан гарын авлагууд тусдаа бий.

Өнгөрсөн онд УИХ-аас энэ хөтөлбөрийн 102 сургагч багшийг бэлдсэн. Тэдгээр сургагч багш нар Ерөнхий боловсролын сургууль дээр гарын авлагын дагуу сургалтууд явуулсан. Жишээ нь, Баянзүрх дүүргийн 148 дугаар сургуулийн сургагч багш өөрийн санаачлагаар “Парламентын боловсролын клуб” байгуулж, хичээлийн жилийн туршид маш амжилттай ажилласан. УИХТГ-аас клубын үйл ажиллагаатай очиж танилцсан. Мөн Дархан-Уул аймагт “Өсвөрийн парламент” хоёр жилийн турш ажилласан гэх мэт сайн туршлагауд нэмэгдсээр байна.

**Хуулийн төсөл боловсруулагчдын сургалт:** Улсын Их Хурлын Тамгын газраас Монголын Хуульчдын холбоо, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран (2023.05.24-05.26) Хуулийн төсөл боловсруулагчдын сургалтыг зохион байгуулжээ.

Сургалтаар хуулийн төсөл боловсруулагчид хууль, хууль зүйн техникийн талаар суурь ойлголтоос эхлээд хуульд тавигддаг агуулгын болон хэлбэрийн шаардлага, төсөл боловсруулах арга ажиллагаа, эрх зүйн рецепци, хууль тогтоомжийн системчлэл зэрэг зайлшгүй тулгамддаг олон асуудлыг эрх зүйн онол, практикийн үүднээс иж бүрнээр авч үзэхийн зэрэгцээ хүний эрхэд суурилсан хандлага, хууль тогтоомжийн төслийн хүний эрхийн үнэлгээний талаар мэдлэг, мэдээллийг авсан.

Тус сургалтад Улсын Их Хурлын Тамгын газрын хуулийн төслийн эхийг баригч, хуульч нар, мөн төрийн захиргааны төв байгууллагуудын Хууль, эрх зүйн газар, хэлтсийн ажилтнуудаас бүрдсэн 50 хуульч, эрх зүйч хамрагдсан бөгөөд оролцогчдод 3.0 кредит олгож, батламж гардуулсан юм. Энэ сургалт нь цаашид тогтмол үргэлжлэх юм.

## **8.2. УИХ-аас ХЭҮК-ын илтгэлийг хэрхэн авч хэлэлцсэн талаарх мэдээлэл**

УИХ-аас ХЭҮК-ын тайлан илтгэлийг авч хэлэлцүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний Комиссын тухай хуулиудын дагуу авч, хэлэлцэж байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Улсын Их Хурал жил бүр хэлэлцэх тухай, мөн 16.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийж, шинжилгээ хийсэн талаарх танилцуулгыг холбогдох Байнгын хороонд хүргүүлэх тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.3 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Хууль зүйн байнгын хороо болон холбогдох бусад байнгын хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэх тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлэх тухай, мөн 9.2 дахь хэсэгт Комиссын илтгэлийг жил бүрийн Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар **Улсын Их Хурал тогтоол** гаргах тус тус хуулийн заалттай бөгөөд үүний дагуу хэрэгжүүлж байна.

УИХ нь тогтоол гаргахдаа ХЭҮК-ын илтгэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ЗГ-т чиглэл өгдөг бөгөөд хэрэгжилт нь зарим талаар хангалтгүй байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль 2020 онд шинэчлэн батлагдсан бөгөөд түүнээс хойш хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20, 21, 22 дахь илтгэлүүдийг бэлтгэн УИХ-д хүргүүлж, хэлэлцүүлсэн байна. Үүнд:

**Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэл:**

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэл болон тус илтгэлд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийсэн танилцуулгын хамт Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтсон.

Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэн.

Комисс нь 2 илтгэл нийт 63 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолыг баталсан. Тус илтгэлүүдэд ХЭҮК-оос нийт 40 санал зөвлөмж гарсан.

**Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл:**

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл болон тус илтгэлд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийсэн танилцуулгын хамт Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтсон.

Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэн.

Комисс нь нийт 30 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 49 дүгээр тогтоолыг баталсан.

**Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл:**

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 04

дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтсон.

Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцсэн.

Комисс нь нийт 43 санал, зөвлөмжийг Улсын Их Хуралд хүргүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолыг баталсан.

### *8.3. Парламентаас иргэний нийгмийн байгууллагуудтай тогтмол харилцдаг суваг, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл*

Улсын Их Хурал нь УИХТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газраараа дамжуулан иргэд олон нийт болон иргэний нийгмийн байгууллагуудтай уламжлалт хэвлэл мэдээллийн суваг болох сонин, сайт, радио, телевиз, сэтгүүлчдээр дамжуулан харилцахын зэрэгцээ нийгмийн сүлжээний платформуудыг ашиглаж өдөр тутмын мэдээ, мэдээллийг идэвхтэй түгээж байна.

Мөн 2022 оны 07-р сарын 05-ны өдөр УИХ-ын тухай хуульд УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах (МУИХТХ 39<sup>1</sup>.1-39<sup>1</sup>.3) нэмэлт, өөрчлөлт оруулан ажиллаж байна. Ингэхдээ [d.parliament.mn](http://d.parliament.mn) болон [petition.parliament.mn](http://petition.parliament.mn) системээр дамжуулан хуулийн төсөлд санал авч, улс орны тулгамдсан асуудлын талаарх цахим өргөдлийг иргэдээс хүлээн авч байна.

### **УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах суваг**

Өнөөгийн байдлаар Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах хүрээнд дараах байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

#### **Өдөр тутмын сонин**

1. “Өнөөдөр”
2. “Өдрийн сонин”
3. “Өглөөний шуудан”
4. “Зууны мэдээ”

**Цахим сайт**

5. Zarig.mn	14. Mpress.mn	23. Time.mn
6. Gogo.mn	15. See.mn	24. Isee.mn
7. News.mn	16. Focus.mn	25. Eguur.mn
8. 24tsag.mn	17. Ivoice.mn	26. Times.mn
9. Ikon.mn	18. Zindaa.mn	27. Ublife.mn
10. Itoim.mn	19. Tovch.mn	
11. Ubn.mn	20. Newspress.mn	
12. Mand.mn	21. Ergelt.mn	
13. Livetv.mn	22. Zuv.mn	

**Радио**

28. МҮОНРадио FM 106.0	29. ЭмЖиЭл радио FM 88.3
------------------------	--------------------------

**Телевиз**

30. МҮОНТВ	36. ETV	42. Парламент ТВ
31. Eagle TV	37. TM	43. Малчин ТВ
32. NTV	38. TV8	44. C1
33. TV9	39. TM	45. Сүлд
34. TV5	40. Channel 11	
35. MN25	41. TV 2	

**Парламентын сэтгүүлчид**

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааг сурвалжлах эрх бүхий сэтгүүлчдэд сурвалжлах үнэмлэх олгодог. 2023 оны 10 дугаар сарын байдлаар 280 гаруй парламентын сэтгүүлч, зурагчин, зураглаач Төрийн ордноос сурвалжилга хийж байна.

**Бусад байгууллага**

“Улсын Их Хурал – Энэ 7 хоногт” тойм нэвтрүүлэг бэлтгэхэд “Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо” ТББ-тай гэрээ байгуулж, сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах зорилтын хүрээнд 7 хоног бүр бэлтгэдэг нэвтрүүлэг дохионы хэлмэрчтэй олон нийтэд хүрдэг. Түүнчлэн, Төрийн ордонд зохион байгуулагдах олон нийтийн арга хэмжээнд дохионы хэлний хэлмэрчтэй хамтран ажилладаг.

**Цахим хуудас**

Улсын Их Хурлын parliament.mn цахим хуудсыг хөгжүүлэхэд Айдиа Девелопмент ХХК-аар гүйцэтгүүлж, харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах хүрээнд тус цахим хуудсанд байршуулагдсан мэдээ мэдээллийн үсгийн хэмжээг томруулах боломжтойгоор захиалга өгч,



хэрэгжүүлсэн. Мөн Улсын Их Хурлаар батлагдсан хуулиудыг харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах хүрээнд аудио хэлбэрт хувирган байршуулсан.

### **Нийгмийн сүлжээний хаяг**

Улсын Их Хурлын Тамгын газраас УИХ-аас гарч буй хууль, тогтоомж, шийдвэр, үйл ажиллагааны талаар нийгмийн сүлжээний Facebook, X (twitter), Instagram цахим аппликейшн, платформуудыг идэвхтэйгээр ашиглаж иргэд, олон нийтэд мэдээллийг байнга хүргэж байна. Одоогийн байдлаар Facebook хаяг 69 мянга, X (twitter) хаяг 32 мянга, Instagram хаяг 2 мянга тус тус дагагчтайгаар УИХ-ын мэдээ, мэдээллийг хүргэж байна.

### **D.PARLIAMENT.MN болон PETITION.PARLIAMENT.MN систем**

Тус системүүд нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах хүрээнд хийгдсэн юм.

Системүүдийн зорилго нь хууль тогтоох үйл хэрэгт олон нийтийн санал бодлыг тусгах, иргэдийн эрх ашигт нийцсэн бодлого, шийдвэрийг гаргахад тэдний дуу хоолойг хүргэх, ард олны засаглах эрхийг вэб болон аппликейшнаар дамжуулан хангахад оршиж байна.

D.parliament.mn цахим систем нь УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022.05.25-ны өдрийн 321 дүгээр захирамжаар батлагдсан “D.PARLIAMENT” цахим системийг эрхлэн хөтлөх журмын дагуу ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт 180 орчим хуулийн төсөл (идэвхтэй боловсруулагдаж байгаа 49)-д 7 мянга гаруй иргэд давхардсан тоогоор санал өгсөн байна.

Petition.parliament.mn цахим систем нь Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023.01.18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журам”-ын дагуу ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 20 гаруй цахим өргөдөлд иргэдээс идэвхтэй гарын үсэг цуглуулж байна.

### **Монголын Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын форум**

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг дүгнэн хэлэлцэхтэй холбогдуулан 2010 оны 01 дүгээр сард төрийн бус байгууллагуудын дунд зохион байгуулсан сургалтын үр дүнд Монголын хүний эрхийн ТББ-уудын Форум байгуулагдсан юм.



Тэр цагаас хойш Хүний эрхийн ТББ-уудын Форум эгнээндээ 40 гаруй ТББ-ыг нэгтгэн Монгол Улсад хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хөхиүлэн дэмжих, зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Форум нь анх Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR - Universal Periodic Review) хэмээх цоо шинэ механизмыг Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахад үр дүнтэй ашиглахыг эрмэлзэж байгуулагдсан бол одоо хүний эрхийн асуудлаар үр дүнтэй хамтран ажилладаг, Засгийн газарт хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүргийг сануулж, алдаа дутагдлаа засаж залруулахыг шаарддаг, НҮБ-ын хүний эрхийн бусад механизмыг ч үр дүнтэй ашиглахыг зорьж буй, хүний эрхийн хамгийн олон ТББ-ыг эгнээндээ нэгтгэсэн, хүний эрхийн өргөн хүрээний асуудлаар ажилладаг сайн дурын холбоо болж өргөжсөн.

**www.upr-mongolia.mn** вэб сайтыг Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR) хэмээх шинэ механизмын тухай олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, энэ асуудлаарх нийгмийн үзэл бодлыг төлөвшүүлэх зорилгоор Австралийн Засгийн газрын Хүний эрхийн жижиг тэтгэлгийн хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хэрэгжүүлсэн “UPR-ийг мэдээлэл, сурталчилгаагаар хангах нь” төслийн хүрээнд 2010 онд нээж “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага хариуцан ажиллуулж байна.

Вэб сайт дахь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн гаргасан шийдвэрүүд, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг – UPR явуулах удирдамж зэрэг Хүний эрхийн зөвлөлийн бусад баримт бичгийг “Хүний эрх хөгжил” төв монгол хэлнээ орчуулан бэлтгэсэн юм.

Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд (2017.03.15-ны байдлаар шинэчилсэн)

1. Айвуун
2. Байгаль орчин эрүүл мэнд төв
3. Бодлогод залуусын хяналт
4. Булаг шанд мөрний эхийг хамгаалах сан
5. Бүсгүйчүүд 21-р зуун
6. “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвсэл
7. Глоб интернэшнл төв
8. Гүнж төв
9. Залуус эрүүл мэнд төв
10. Захиргааны шинэ санаачилга
11. Заша Өвс Төв
12. Зориг сан
13. Зөвт ёс

14. Иргэдэд туслах хүний эрхийн төв
15. Ирээдүйн босго
16. Их Бага Баяншарга
17. Казах эмэгтэйчүүдийн Арулар холбоо
18. ЛГБТ төв
19. Митчелл сан
20. Монголын Дүлий Иргэдийн Үндэсний Холбоо
21. Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Холбоо
22. Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо
23. Монголын Эмнести интернэшнл
24. Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо
25. Монголын эрэгтэйчүүдийн холбоо
26. МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ
27. Ногоон соёл иргэншил хөгжил сан
28. Мэдээллийн Орхон XXI зуун төв
29. Оюу Толгойн хяналт
30. Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүдийн клуб
31. Саяана Сайн Сайхны нийгэмлэг
32. Сэтгэлзүйн мэдрэмж
33. Татварт иргэний хяналт
34. Төр иргэн түншлэл
35. Тува эмэгтэйчүүдийн “Авам” холбоо
36. Тулгат залуу гэр бүл
37. Түгээмэл хөгжил төв
38. Үндсэн уртраг
39. Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг
40. Хил хязгааргүй алхам
41. Хил хязгааргүй гол мөрөн
42. Хөгжлийн хэлхээ төв
43. Хууль хүний эрх төв
44. Хүйсийн тэгш эрхийн төв
45. Хүний аюулгүй байдлын судалгааны төв
46. Хүний эрх хөгжил төв
47. Хүнсний тусгаар тогтнолын төлөө Хүнс эвсэл
48. Хүүхдийн Эрх Хамгаалал Төв
49. Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв
50. Хэрэглэгч сан
51. Эвт сайн хөрш

Сүүлийн байдлаар ХЭҮК-оос иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй “Цахим орчинд хүний эрхийг хамгаалах”, “Төр, иргэний нийгмийн түншлэлийн асуудал”-аар санал солилцох, зөвлөлдөх уулзалтыг 2023 оны 03 дугаар сард зохион байгуулсан.

Зөвлөлдөх уулзалтын үеэр Иргэний нийгмийн зөвлөл болон Хүний

эрхийн форумын гишүүн байгууллагын зүгээс Цахим орчинд хүний эрхийг хамгаалах тухай хуультай холбогдуулан олон улсын сайн туршлагыг судлах, хуулийн нэр болон цахим орчин дахь зөрчилтэй контент гэдгийг оновчтой тодорхойлох, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахаас сэргийлэх зэрэг асуудлаар санал илэрхийллээ.

Уулзалтад ХЭҮК-ын дарга Ж.Хунан, Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн С.Дондов, Комиссын гишүүн Х.Мөнхзул, Г.Нарантуяа, Б.Энхболд болон дараах төлөөлөл оролцов.

Уулзалтад хүрэлцэн ирсэн Хүний эрхийн форумын гишүүн байгууллагууд. Үүнд:

1. ЗГХЭГ-ын Хүний эрхийн дэд хорооны ажилтан М.Баянжаргал
2. “Эмнести интернейшнл” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа
3. “Эмнести интернейшнл” ТББ-ын компанит ажлын зохицуулагч Г.Амарзаяа
4. “Эмнести интернейшнл” ТББ-ын Өсөлт, хөгжилт хариуцсан зохицуулагч Г.Сүхбат
5. “Цогц Хөгжлийн Үндэсний Төв”-ийн гүйцэтгэх захирал М.Энхбадрал
6. Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн. Нийгмийн бодлогын Хорооны зөвлөх. Европ дахь Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны тэргүүн Д.Амараа
7. Монголын Улс Төрийн Хэлмэгдэгсдийн Холбоо Х.Мөнхбаяр
8. Эрдэм сургалт судалгааны хүрээлэн ТББ-ын захирал Б.Өлзийсайхан
9. Монголын эрэгтэйчүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Чинзориг
10. Монголын ахмадын холбооны Ажлын албаны ахлах мэргэжилтэн Б.Цэцэгсүрэн
11. “ЛГБТ Төв” ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Энхмаа
12. “Хөгжил төв”-ийн тэргүүн Г.Уранцоож
13. “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хэрэглэгчийн мэдээллийн сан” ТББ зохицуулагч Г.Оюунтуяа
14. “Сэтгэл зүйн мэдрэмж” ТББ-ын тэргүүн Ч.Сэмжидмаа
15. “Эмэгтэйчүүд амьдрал” ТББ-ын Тэргүүн Ж.Адъяа
16. “Түгээмэл эрх хөгжил” ТББ-ын тэргүүн Т.Саруул
17. “Баяншарга” ТББ-ын тэргүүн Л.Борхүү
18. “Оюу толгойн хяналт” ТББ-ын тэргүүн Д.Сүхгэрэл
19. Хөгжлийн хэлхээ ТББ-ын тэргүүн А.Долгор
20. “Саяана сайн сайхны нийгэмлэг” Д.Мөнхсайхан
21. Хэвлэлийн хүрээлэнгийн захирал М.Мөнхмандах
22. Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжинэ нийгэмлэг Ш.Ариунаа
23. Бие даасан шинжээч Д.Сүхжаргалмаа

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Хууль, тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын Чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль
- Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, МУЗГ-ын 2017.07.04-ний өдрийн 193-р тогтоол.
- Монгол Улсын дээд шүүхийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоол;

### Олон улсын баримт бичиг:

- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт;
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт;
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц;
- Хүүхдийн эрхийн тухай конвенц;
- Бүх цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц /Монгол Улс хараахан соёрхон батлаагүй/;
- Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц.

### Ном, гарын авлага:

- United Nations General Assembly, International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families, 18 Dec 1990;
- О.Мөнхсайхан, Р.Очирбал, “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл” (тойм судалгаа), Улаанбаатар хот, 2021 он;
- УИХТГ, “Хүний эрхийн дэд хороо хүний эрхийн талаар болон Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар мэдээлэл сонслоо” веб мэдээ, Дэлгэрэнгүйг: <https://www.parliament.mn/nn/15266/> ;
- Б.Болорсайхан, “Хүний эрхийн үндэсний байгууллагыг үнэлэх нь” нийтлэл, “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүл (2014/02), Улаанбаатар хот, 2014 он;

- Магадлан итгэмжлэх дэд хороо, Цахим хуралдааны тайлан, зөвлөмж, 2021 оны 10 дугаар сарын 18-29 -ний өдрийн хуралдаан. 12-15 дахь тал. Дэлгэрэнгүйг: [https://ganhri.org/wp-content/uploads/2021/12/SCA-Report-October-2021\\_EN.pdf](https://ganhri.org/wp-content/uploads/2021/12/SCA-Report-October-2021_EN.pdf)
- Хүний эрхийн Үндэсний Комисс, Танилцуулга. Дэлгэрэнгүйг: <https://nhrcm.gov.mn/>;
- УИХ-ын 2021-2023 оны ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны танилцуулгууд;
- Конрад-Адэнауэр-Сан, МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим, “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж, Улаанбаатар хот, 2020 он;
- Хүний эрхийн Үндэсний Комисс, Танилцуулга. Дэлгэрэнгүйг: <https://nhrcm.gov.mn/>;
- ЗГХЭГ, “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын тайланг илтгэж эхэллээ” мэдээ. Дэлгэрэнгүйг: <https://cabinet.gov.mn/8984.html>;
- Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд нээлттэй хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж. дэлгэрэнгүйг: <https://irgen-tur.mn/mn/blog/ogp/single/209>;
- Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБХХ “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц” хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, Улаанбаатар хот, 2011 он;
- Стратеги Академи, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр хэрэгжсэн талаарх түргэн үнэлгээ, Улаанбаатар хот, 2022 он;

### Цахим эх сурвалж:

- [www.petition.parliament.mn](http://www.petition.parliament.mn)
- [www.d.parliament.mn](http://www.d.parliament.mn)
- [www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn)
- <https://www.ohchr.org/en/core-international-human-rights-instruments-and-their-monitoring-bodies>;
- <https://www.ohchr.org/en/hrbodies/hrc/home>;
- <https://www.ohchr.org/en/hr-bodies/upr/basic-facts>;
- <https://upr-mongolia.mn/images/xupld/51mon.pdf>;
- <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G23/129/21/PDF/G2312921.pdf>;
- <https://www.ohchr.org/en/statements/2021/12/united-nations-special-rapporteur-violence-against-women-its-causes-and> ;
- <https://www.ohchr.org/en/statements/2019/09/end-mission-statement-independent-expert-effects-foreign-debt-visit-mongolia>
- <https://www.ohchr.org/en/statements-and-speeches/2019/05/visit-mongolia-30-april-13-may-2019-end-mission-statement> ;
- <https://www.ohchr.org/en/statements/2017/09/statement-united-nations-special-rapporteur-john-h-knox-conclusion-his-mission>.

**ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА БА  
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ТАЛААРХ  
ТОЙМ**

(Мэдээлэл, лавлагаа)

*Г.Билгээ, П.Уранчимэг, Ц.Ариунаа*

**АГУУЛГА**

**УДИРТГАЛ**

**НЭГ. ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА**

**ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ТАЛААРХ  
ТОЙМ**

**2.1.АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС**

- 2.1.1.Эрх зүйн орчин
- 2.1.2.Холбооны Парламентын ордон
- 2.1.3.Парламентын ордны танхимууд
- 2.1.4.Парламентын хэвлэл мэдээлэл
- 2.1.5.Парламентын үйлчилгээний газар
- 2.1.6.Парламентын номын сан, судалгааны алба
- 2.1.7.Австралийн ардчиллын музей
- 2.1.8.Аюулгүй байдлын алба
- 2.1.9.Парламентын ордныг түрээслэх

**2.2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**

- 2.2.1.Эрх зүйн орчин
- 2.2.2.Үндэсний Ассамблейн ордон
- 2.2.3.Үндэсний Ассамблейн Тамгын газар
- 2.2.4.Үндэсний Ассамблейн Номын сан
- 2.2.5.Үндэсний Ассамблейн Төсвийн алба
- 2.2.6.Үндэсний Ассамблейн Судалгааны алба
- 2.2.7.Үндэсний Ассамблейн Фьючерс институт
- 2.2.8.Үндэсний Ассамблейн Харилцаа холбооны танхим
- 2.2.9.Үндэсний Ассамблейн Музей

**2.3.ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС**

- 2.3.1. Парламентын буюу Вэстминстерийн ордон
- 2.3.2. Эрх зүйн орчин
- 2.3.3. Вэстминстерийн ордны сэргээн засварлах хөтөлбөр
- 2.3.4. Вэстминстерийн ордны танхимууд
- 2.3.5. Парламентын номын сангууд
- 2.3.6. Виктория цамхаг буюу Парламентын архив

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

## УДИРТГАЛ

“Парламентын ордны хөгжлийн чиг хандлага ба гадаадын зарим орны парламентын ордны талаарх тойм” сэдэвт мэдээлэл, лавлагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (ПССХ)-д гүйцэтгэв.

### **Судалгааны захиалгын даалгавар:**

- бусад улсад төрийн ордны (парламентын ордны) эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам байдаг эсэх;
- бусад улсын парламентын ордны дотоод зохион байгуулалт, нэгж, албадын нийтлэг болон онцлог зохицуулалтын тухай;
- бусад улсын парламентын музейн тухай;
- бусад улсын парламентын номын сангийн тухай;
- бусад улсын парламентын төрийн ёслол, харуул, хамгаалалтын тухай;
- бусад улсын парламентын ордны засвар, үйлчилгээ, аюулгүй байдлын тухай.

### **Судалгааны зорилго:**

Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийг боловсронгуй болгох, шинэчлэн найруулах ажлын хүрээнд гадаадын зарим орны туршлагыг судлах.

### **Судалгааны хамрах хүрээ:**

Гадаадын зарим орны Төрийн ордны (Парламентын ордон) талаарх хууль эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, парламентын музей, номын сан, төрийн ёслол, харуул хамгаалалт болон парламентын ордны засвар үйлчилгээ, аюулгүй байдлыг дараах улсуудын хүрээнд авч үзлээ:

- Австралийн Холбооны Улс;
- Бүгд Найрамдах Солонгос Улс;
- Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс.

### **Судалгааны бүтэц:**

Судалгаа нь бүтцийн хувьд (1) Парламентын ордны хөгжлийн чиг хандлага, (2) Гадаадын зарим орны парламентын ордны талаарх тойм гэсэн үндсэн хоёр хэсэгтэй. Хоёрдугаар хэсэгт Австралийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын парламентын ордны талаар мэдээллийг оруулсан болно.



**Түлхүүр үг:** парламентын ордон, төрийн ордон, ордны тухай хууль тогтоомж.

**Key words:** parliamentary building, house of parliament, regulation for parliamentary building.

## НЭГ. ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Парламентын байр буюу ордон нь хууль тогтоох байгууллагын хууль тогтоомжийг хэлэлцэн баталдаг барилга юм. Олон улсад парламентын байрыг үндэсний хэлний онцлогоос хамаарч “building”, “capitol”, “hall”, “house”, эсхүл “palace” гэх мэт олон нэр томьёо хэрэглэж байна.

Аливаа парламентын ордон нь тухайн улсын алсын хараа, уламжлал, соёлыг илтгэж байдаг. Шилжилтийн үеийн орнууд өөрсдийн үзэл санаа, зорилгыг илэрхийлэх, үндэсний соёл, өвөрмөц онцлогийг бэхжүүлэхийн тулд парламентын ордноо дахин төлөвлөж байна. Мөн эртний уламжлал бүхий парламентууд ч түүхэн өвийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн хадгалахын зэрэгцээ шинэ технологи, ирээдүйн олон төрлийн шаардлагад нийцүүлэн өөрчлөхийн тулд ордноо сэргээн засварлаж, шинэчилж байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн улс орнуудын парламентын барилгуудын ирээдүйд технологийн дэвшил, тогтвортой байдлын асуудал, хувьсан өөрчлөгдөж буй улс төрийн динамик, хөгжиж буй архитектурын чиг хандлага зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

Энд дан ганц парламентын барилгын архитектур, төлөвлөлтийн асуудал бус, нэг талаар парламентын тогтвортой үйл ажиллагаа, түүний ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, татвар төлөгчдийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, нөгөө талаар иргэдийн төрөө дээдлэх ёс уламжлал зэрэг асуудлууд болон парламентын ордноос гадна түүний нутаг дэвсгэр дээр баригдсан бусад барилгууд буюу олон нийттэй шууд харилцах, парламентын боловсрол олгох зэргийг дэмжсэн иж бүрэн цогцолборыг хөндөж байгаа хэрэг юм.

Парламентын барилгуудын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг багцалж үзвэл:

- **тогтвортой байдал ба байгаль орчны талаар** – тогтвортой байдлыг хангах, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хариуцлагыг чухалчилж байна. Нүүрстөрөгчийн ул мөрийг багасгахын тулд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, эрчим хүч болон усны хэмнэлттэй систем, материалыг ашиглах, хог хаягдлыг бууруулах;
- **хүртээмжтэй байдал** – хүн бүр, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настай хүмүүс бүрэн ашиглах боломжтой, тэдэнд хүртээмжтэй байхаар гадаад болон дотоод төлөвлөлтийг нэн тэргүүнд тавих;
- **технологийн интеграц** – парламентын хуралдааны танхимуудын үйл ажиллагааны үр ашиг, ил тод байдал, холболтыг сайжруулахын тулд сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

- **аюулгүй байдал** – хууль тогтоогчид, ажилтнууд болон зочдыг хамгаалахын тулд аюулгүй байдлын арга хэмжээг нэн тэргүүнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, аюул заналхийллийг шийдвэрлэх хамгийн сүүлийн үеийн аюулгүй байдлын технологи, шилдэг туршлагын талаар мэдээлэлтэй байх;
- **төлөвлөлтийн уян хатан байдал** – цаг хугацааны явцад парламентын барилгуудын өөрчлөгдөж буй хэрэгцээ, чиг үүргийн дагуу уян хатан байдлаар төлөвлөх, мөн орчин, гадаад ба дотоод талбай нь төрөл бүрийн үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулахад хялбар байх;
- **соёл, нийгмийн орон зай** - парламентын ордны төлөвлөлтийн уян хатан байдлаас хамаарч ордон дотор урлагийн галерей, үзэсгэлэнгийн талбай, олон нийтийг хамарсан соёл, нийгмийн арга хэмжээ зохион байгуулах санал санаачилгыг дэвшүүлэх;
- **соёл, архитектурын өвөрмөц байдал, бүтээлч хандлага** – парламентын барилгуудын соёл, түүх, архитектурын өвөрмөц байдлыг хадгалахын зэрэгцээ шинэлэг дизайны элементүүдийг бий болгох;
- **олон нийтийн оролцоо** – хууль тогтоогчид болон ард иргэд хоорондын харилцааг дэмжих олон нийтийн уулзалтын талбай, боловсролын байгууламж, зочдын төв зэрэг парламентын барилгуудыг төлөвлөх замаар олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;
- **ил тод байдал ба хариуцлага** – мэдээллийг нээлттэй олон нийтэд хүргэх шинэ санаачилга нэвтрүүлэх замаар иргэдийн оролцоог хангах буюу парламентын үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх технологийг нэвтрүүлэх;
- **зайнаас ажиллах боломж** – коронавируст халдвар (COVID-19)-ын тахлын үеийн туршлагыг харгалзан парламентын барилгуудыг зайнаас ажиллах, цахим хуралдааныг дэмжих үүднээс загварчлах, шинэчлэх шаардлагатай бөгөөд энэ нь онцгой нөхцөл байдлын үед ч парламентын төдийгүй төрийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг баталгаажуулах.

Парламентын барилгуудын цаашдын хөгжил нь орчин үеийн засаглалын хувьсан өөрчлөгдөж байгаа хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд түүх, соёлын ач холбогдол, өвөрмөц байдлыг хадгалах болон дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх хоёрын тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхыг парламентууд анхаарч байна.

## ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ТАЛААРХ ТОЙМ

### 2.1. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

Холбооны Парламентын ордон бол Австралийн Холбооны Улсын ардчиллын бэлгэдэл байдаг. Тус ордны барилга нь хүрээлэн буй орчинтойгоо бүрэн зохицдог бөгөөд барилгын дээвэр дээр зүлэг тарьснаар иргэд, зочид ордны дээвэр дээр алхах боломжтой болсон. Энэ нь ард түмэн төрөөс дээгүүр гэсэн санааг илэрхийлж байдаг. Тийм ч учраас Парламентын ордон нь Зул сарын баярын өдрөөс бусад өдрүүдэд олон нийтэд нээлттэй, үнэ төлбөргүй байдаг.

Түүнээс гадна энэ жил Холбооны Парламентын ордны 35 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Ням гарагт “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулах тухай цахим хуудсаараа дамжуулан олон нийтийг оролцохыг урьсан байна.

Тус ордонд Австралийн Холбооны Улс (Австрали Улс)-ын Холбооны Парламентын хоёр танхим, Засгийн газар байрладаг.



#### 2.1.1. Эрх зүйн орчин

Австрали Улсад Холбооны Парламентын ордонтой холбоотой харилцааг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд тус ордны барилгыг барих,

засварлах, Холбооны Парламентын ордон, түүний нутаг дэвсгэр дээр байрлах барилгыг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан хэд хэдэн хууль тогтоомж үйлчилж байна. Тухайлбал:

1. Барилгын тухай хууль<sup>139</sup>, барилгын холбогдох стандартууд – Барилгын тухай хуулиар ерөнхийдөө барилга, барилгын ажил болон бусад холбогдох эрх зүйн харилцааг зохицуулна. Харин барилгын стандартууд нь барилгын аюулгүй байдал, тусгай хэрэгцээт иргэдэд хүртээмжтэй байдал, дэд бүтцэд тавигдах зэрэг шаардлагуудыг тогтоож өгсөн байдаг.
2. Австрали Улсын дэлхийн өвийн тухай хууль<sup>140</sup> – Энэ хууль нь тус улсын үндэсний байгалийн, соёл, түүхийн өвийг хамгаалах, хадгалах, танилцуулах, хойч үедээ өвлүүлэхтэй холбоотой эрх зүйн харилцааг зохицуулах ба энэ хуулиар түүхэн соёлын өвийн үнэт барилгыг бүрэн бүтнээр нь хамгаалах, түүний бүтцийг өөрчлөхийг хориглож, зарим хязгаарлалтыг тогтоож өгсөн. Парламентын ордон нь соёлын өвийн үнэт барилга учраас энэ хуулиар хамгаалагддаг.
3. Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын журам, стандарт – Парламентын гишүүд, Парламентын ордонд ажиллагсад болон түр нэвтэрсэн зочдын аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын хууль тогтоомжийг дагаж мөрддөг. Эдгээрт, Яаралтай нүүлгэн шилжүүлэх журам, Галын аюулгүй байдлын журам, Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт зэрэг орно.
4. Хүртээмжтэй байдлын тухай хууль<sup>141</sup> – Парламентын ордныг хүн бүхэн тэр дундаа тусгай хэрэгцээт хүмүүсийн хүртээмжтэй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн харилцааг Хүртээмжтэй байдлын тухай хуулиар зохицуулдаг. Энэ хуулиар тогтоосон шаардлагын дагуу Парламентын ордон доторх тэргэнцэр болон бусад хэрэгсэл ашиглах хөгжлийн бэрхшээлтэй иргэнд, өндөр настай иргэнд зориулсан налуу зам, цахилгаан шат, ариун цэврийн өрөөг төлөвлөх, болзошгүй аюулын талаарх мэдээлэл (анхааруулах, шаардлагатай бол)-ийг байрлуулах зэрэг төлөвлөлтийн онцлог шаардлагуудыг тодорхойлсон байна.
5. Парламентын ордонд мөрдөх бусад эрх зүйн актууд<sup>142</sup> – Парламентын үйлчилгээний газар (Department of Parliamentary Services)-аас эрх бүхий бусад байгууллагатай хамтран баталсан Парламентын ордонд мөрдөх дараах эрх зүйн актууд үйлчилж байна. Үүнд:

<sup>139</sup> Building Act 2004. <https://www.legislation.act.gov.au/View/a/2004-11/current/html/2004-11.html>

<sup>140</sup> Australian World Heritage laws. <https://www.dcceew.gov.au/parks-heritage/heritage/laws/world>

<sup>141</sup> Disability Discrimination Act 1992. <https://www.legislation.gov.au/Details/C2018C00125>

<sup>142</sup> [https://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_departments/Department\\_of\\_Parliamentary\\_Services/policies](https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_departments/Department_of_Parliamentary_Services/policies)



- Парламентын ордны CCTV ашиглалтын заавар (Australian Parliament House CCTV Code of Practice Guidance);
- Парламентын ордны цахилгааны хяналтын системийн ашиглалтын заавар (Australian Parliament House EACS Code of Practice Guidance);
- Парламентын ордонд ёслолын арга хэмжээ зохион байгуулах (Use of the Parliament House facilities for functions and events);
- Парламентын ордны тамхины бодлого (Parliament House smoking policy);
- Парламентын номын сангийн үйлчилгээний журам (Parliamentary Library Statement of Client);
- Парламентын ордон түүний тойрогт жагсаал, цуглаан болох үед баримтлах бодлого (Protest and other assemblies in the Parliamentary precincts policy);
- Парламентын ордны хувийн автомашины зогсоолын бодлого (Parliament House Private Car Parks Policy);
- Парламентын ордны тусгай бүсэд нэвтрэх бодлого (Parliament House Private Area Access Policy).

### 2.1.2.Холбооны Парламентын ордон

Австрали Улсын нийслэл Канберра хотын төв цэг болох Капитал толгод дээр байрладаг Холбооны Парламентын шинэ ордон (Парламентын ордон) нь 1988 онд ашиглалтад орсон бөгөөд 200 жил ашиглах зориулалттай ажээ.




Парламентын ордон нь 250.000м<sup>2</sup> талбайтай, 4700 өрөө тасалгаатай, нийт 3 давхар (газар дор 1 давхар, газар дээр 2 давхар) бөгөөд Парламентын хуралдаантай үед 5000 албан хаагч ажилладаг томоохон байгууламж юм.<sup>143</sup>

Парламентын ордны гол онцлог нь барилгыг үндсэн дөрвөн хэсэгт хуваасан бумеранг хэлбэртэй хоёр муруй хана юм. Энэхүү хоёр муруй хана нь Сенат болон Төлөөлөгчдийн танхимыг тусгаарлаж, Австрали Улсын хоёр танхимтай парламентын тогтолцоог илэрхийлдэг.<sup>144</sup>

Парламентын ордны барилгын бүтэц нь:

- зүүн хэсэгт - Төлөөлөгчдийн танхим болон гишүүдийн ажлын өрөө
- баруун хэсэгт - Сенат болон сенаторуудын ажлын өрөө;
- төв хэсэгт - урд талбай буюу Их веранда;
- урд хэсэгт - Ерөнхий сайд, сайд нарын өрөө тус тус байрладаг байна.



### 2.1.3. Парламентын ордны танхимууд

Сенатын болон Төлөөлөгчдийн хуралдааны танхимууд нь Парламентын ордон доторх хамгийн том танхимууд бөгөөд танхимууд нь тус улсын байгалийн унаган төрхийг илэрхийлсэн улаан хүрэн болон саарал ногоон өнгөтэй байдаг.

Холбооны Парламентын хоёр танхимуудын гэрэлтүүлгийг нарны эрчим хүчээр бүрэн хангасан нь цахилгааны зардлыг нэг жилд 17.000 доллар

<sup>143</sup> <https://peo.gov.au/>


<sup>144</sup> <https://peo.gov.au/understand-our-parliament/parliament-house/australias-parliament-house/>

хэмнэдэг ажээ. Ордны энэхүү эрчим хүчний шийдэл нь Австрали Улсын Цэвэр эрчим хүчний зөвлөлөөс «цахилгаан эрчим хүчний системийн шилдэг дизайн, суурилуулалт» шагналыг хүртэж байжээ.<sup>145</sup>

**а) Төлөөлөгчдийн танхимын нэгдсэн хуралдааны танхим**

Төлөөлөгчдийн танхим 151 гишүүдээс бүрдэх ба гурван жилийн хугацаагаар ард түмнээс сонгогддог. Төлөөлөгчдийн танхимын нэгдсэн хуралдааны танхим нь бүхэлдээ тус улсын байгалийн унаган төрхийг илэрхийлсэн саарал ногоон өнгөтэй. Хуралдааны танхим доторх суудлуудыг англи хэлний “U” хэлбэрээр байрлуулсан байдаг. Төлөөлөгчдийн танхимын дарга нь “U” хэлбэрээр байрлуулсан суудлуудын төвийн дээд хэсэгт тусгайлан зассан суудалд сууж, хуралдааны дэгийг сахиулдаг.

Түүний баруун талд Засгийн газрын гишүүд, зүүн талд сөрөг хүчний гишүүд сууна. Ерөнхий сайд нь Засгийн газрын гишүүдийнхээ өмнөх төв суудалд, сөрөг хүчний дарга нар өөрсдийн бүлгийн гишүүдийн өмнөх төв суудалд тус тус сууна. Төлөөлөгчдийн танхим дахь жижиг намууд болон бие даагчид “U” хэлбэрээр байрлуулсан суудлуудын дугуйрсан хэсэгт сууна.



Хуралдааны танхимын дүр төрх, зарим дотоод зохион байгуулалт, зарим үйл ажиллагаа нь Их Британийн Парламентаас гаралтай ч Австрали Улсын Үндсэн хуулийн төслийг боловсруулагчид парламентын зохион

<sup>145</sup> Summit 2021, Australian Clean Energy.



байгуулалтыг шийдэхдээ АНУ-ын Конгрессын загварыг харгалзан үзсэн ажээ. Тухайлбал, “Төлөөлөгчдийн танхим”, “Сенат” гэсэн нэрийг АНУ-аас нутагшуулж авсан байна. Иймд өнгөрсөн зуунд Австрали Улсын Төлөөлөгчдийн танхим нь Их Британийн Парламент болон АНУ-ын Конгрессын аль алиных нь шинж, өнгө төрхийг агуулсан өөрийн гэсэн өвөрмөц хэв маяг, дэг журамтай болсон.

Танхимын бельэтаж (хуралдаан даргалагчийн ар талд болон танхимын хоёр талаар)-д зочид, төлөөлөгчид, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, иргэд, олон нийтэд хуралдааны үйл явцыг ажиглах боломжтой нээлттэй хэсэг (нийт 528 хүний суудалтай) байдаг.

### б) Сенатын нэгдсэн хуралдааны танхим

Сенат нь 76 сенатораас бүрдэнэ. Сенатын нэгдсэн хуралдааны танхим нь бүхэлдээ улаан хүрэн өнгөтэй. Хуралдааны танхим доторх суудлуудын зохион байгуулалт нь Төлөөлөгчдийн танхимынхтай адилхан байдаг. Сенатын Ерөнхийлөгч нь “U” хэлбэрээр байрлуулсан суудлуудын төвийн дээд хэсэгт тусгайлан зассан суудалд сууж, хуралдааны дэгийг сахиулдаг. Түүний баруун талд Засгийн газрын гишүүд, зүүн талд Сенат дахь сөрөг хүчний гишүүд сууна. Ерөнхий сайд нь Засгийн газрын гишүүдийнхээ өмнөх төв суудалд, сөрөг хүчний дарга нар өөрсдийн бүлгийн гишүүдийн өмнөх төв суудалд тус тус сууна. Сенат дахь жижиг намууд болон бие даагчид “U” хэлбэрээр байрлуулсан суудлуудын дугуйрсан хэсэгт сууна.



Тус танхимын зочид, төлөөлөгчид, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, иргэд, олон нийтэд хуралдааны үйл явцыг ажиглах боломжтой нээлттэй хэсэг нь мөн Төлөөлөгчдийн танхимынхтай адилхан хуралдаан даргалагчийн ар талд болон танхимын хоёр талд бельэтажид байдаг.


### **в) Парламентын хороодын танхимууд**

Парламентын ордон нь хороодын 19 танхимтай. Эдгээрийн хамгийн том нь Үндсэн хорооны танхим юм. Энэ танхимыг Үндсэн хорооны хуралдаан, нийтийн сонгогчид, хурал, хэвлэлийн бага хурал хийх зориулалттай болгон тохижуулсан байна.



### **г) Их танхим**


Их танхим (The Great Hall) бол ёслолын болон бусад албан ёсны арга хэмжээнд зориулагдсан том танхим юм. Австралид ургадаг модоор цонхны хүрээ, шал, ханын хавтанг хийсэн байна.



### **д) Гишүүдийн танхим**

Парламентын ордны төв хэсэгт Гишүүдийн танхим (the Members Hall) байрладаг. Тодруулбал, танхим нь барилгын хойд-өмнөд тэнхлэг ба зүүн-баруун тэнхлэгийн огтлолцол дээр, Сенат ба Төлөөлөгчдийн танхимын дунд байрладаг.

Энэхүү танхим нь Парламентын гишүүдийн албан бус уулзалтын газар нь болдог.



### е) Засгийн газрын танхим

Парламентын ордны 1 дүгээр давхарт Ерөнхий сайдын өрөөний эсрэг талд, бусад сайд нарын өрөөтэй нэг жигүүрт Засгийн газрын танхим байрладаг.

Засгийн газрын танхим нь байгалийн гэрэлгүй барилгын цөөхөн өрөөнүүдийн нэг ажээ.



### 2.1.4. Парламентын хэвлэл мэдээлэл

Парламентын ордон доторх хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг дараах эрх зүйн актуудаар зохицуулж байна. Үүнд:

1. Парламентын ордон, түүний тойрогт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулах журам<sup>146</sup> – Уг журмыг парламентын ордонд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчид дагаж мөрдөнө. Эдгээрт Хэвлэлийн галерейн (Press Gallery) үндсэн ажилчид, Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын гишүүд, Парламентын ордонд зочилж байгаа бусад хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, гадаадын хүндэт зочдыг дагалдан яваа олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчид тус тус хамаарна;
2. Парламентын ордонд гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх журам<sup>147</sup> – Парламентын ордонд ажилладаг улс төрчид, албан хаагчид, Парламентын ордонд нэвтрэх үнэмлэх эзэмшигчид болон түр нэвтэрсэн зочдод мөн хамаарна;
3. Парламентын үйл ажиллагааг радиогоор дамжуулахад баримтлах зарчим<sup>148</sup> болон холбогдох тогтоолууд<sup>149</sup>.

Парламентын үйл ажиллагааг ABC телевиз, радио, А-РАС (Австралийн олон нийтийн суваг) болон Парламентын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд дамжуулдаг.<sup>150</sup>

<sup>146</sup> The Rules for Media Related Activity in Parliament House, 2016

<sup>147</sup> Guidelines for filming and photography in Parliament House, 2008

<sup>148</sup> General principles relating to the radio broadcasting of parliamentary proceedings - [https://www.aph.gov.au/Parliamentary\\_Business/Committees/House\\_of\\_Representatives\\_Committees?url=jcbpp/principles.htm](https://www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/House_of_Representatives_Committees?url=jcbpp/principles.htm)

<sup>149</sup> Standing determinations relating to the radio broadcasting of parliamentary proceedings - [https://www.aph.gov.au/Parliamentary\\_Business/Committees/House\\_of\\_Representatives\\_Committees?url=jcbpp/determinations.htm](https://www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/House_of_Representatives_Committees?url=jcbpp/determinations.htm)

<sup>150</sup> <https://peo.gov.au/understand-our-parliament/parliament-and-its-people/house-of-representatives/house-of-representatives/>

### **а) Парламентын хэвлэлийн галерей (press gallery)**

Австрали Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт зааснаар “Хэвлэлийн галерей” нь Холбооны Парламентын үйл ажиллагааг ард түмэндээ тайлагнах эрхэм зорилготой.

Хэвлэлийн галерей нь телевиз, радио, сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг 250 орчим итгэмжлэгдсэн сэтгүүлч, зураглаач, редактор зэрэг ажилтнуудаас бүрддэг.<sup>151</sup> Хэвлэлийн галерей нь Парламентын ордонд өргөн нэвтрүүлгийн студи, сэтгүүлчдийн ажлын өрөө, Сенат болон Төлөөлөгчдийн танхимын хуралдааныг дээрээс нь үзэж нэвтрүүлэх тусгай талбайтай.




Хэвлэлийн галерей нь Парламентын ордны Сенатын жигүүрийн 2 дугаар давхарт байрладаг.

### **б) Хэвлэлийн галерейн гишүүнчлэл**

Хэвлэлийн галерейд ажиллах зөвшөөрлийг Парламентын үйлчилгээний газраас олгодог ба энэхүү зөвшөөрлийг олгохдоо дараах шалгуурыг хангасан эсэхийг харгалзан үздэг. Эдгээрт:

- зөвшөөрөл хүсэгч хэвлэл мэдээллийн байгууллага нь Хэвлэлийн галерейд гишүүнээр элсэх болзол хангасан эсэх;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын уншигч, сонсогч, эсвэл үзэгчдийн тоо;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын үзэгч, сонсогч голчлон Австрали Улсад байдаг эсэх;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын улс төр, парламентын ордны мэдээнд ажиллах нийт сэтгүүлчдийн тоо;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын хэдэн сэтгүүлч өдөр бүр Хэвлэлийн галерейд ажиллах боломжтой тухай;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллага одоогоор Хэвлэлийн галерейд ажиллах зөвшөөрөлтэй сэтгүүлч, ажилтнууд ажиллуулж буй эсэх;
- хүсэлт гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага чухал гэж үзсэн бусад хүчин зүйлсийг нэрлэж болно.

<sup>151</sup> <https://pressgallery.net.au/>




### 2.1.5. Парламентын үйлчилгээний газар

Парламентын үйлчилгээний газар (Department of Parliamentary Services) нь Австрали Улсын Парламентад бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Парламентын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг дөрвөн газрын нэг бөгөөд үйл ажиллагаагаа Сенатын Ерөнхийлөгч ба Төлөөлөгчдийн танхимын даргад тайлагнадаг. Парламентын үйлчилгээний газар 3500 гаруй ажилтантай.<sup>152</sup> Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын холбогдох нэгжтэй хамтран Парламентын үйлчилгээний газар дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

<sup>152</sup> [https://www.aph.gov.au/about\\_parliament/parliamentary\\_departments/department\\_of\\_parliamentary\\_services](https://www.aph.gov.au/about_parliament/parliamentary_departments/department_of_parliamentary_services)



- номын сан, судалгааны үйлчилгээ;
- мэдээлэл, харилцаа холбооны технологийн үйлчилгээ;
- аюулгүй байдлын үйлчилгээ;
- барилга, өвийн менежментийн үйлчилгээ;
- аудио дүрс болон хансард (hansard) үйлчилгээ;
- урлагийн бүтээлийн цуглуулга, үзэсгэлэнгийн үйлчилгээ;
- тавилга, хөрөнгийн менежментийн үйлчилгээ;
- зочдод зориулсан үйлчилгээ, Парламент бэлэг дурсгалын дэлгүүр;
- зоогийн газар, үсчин гоо сайхны үйлчилгээ;
- танхимуудын түрээсийн үйлчилгээ;
- зөвшөөрөлтэй жижиглэн худалдаа, эрүүл мэнд, банк санхүү, хүүхэд асрах үйлчилгээ;
- Парламентын үйлчилгээний газарт зориулсан корпорац, захиргааны үйлчилгээ.<sup>153</sup>



### 2.1.6. Парламентын номын сан, судалгааны алба

Парламентын номын сан нь Парламентын ордны 2 дугаар давхарт Сенатын жигүүрт байрладаг. Парламентын номын сан анх 1901 онд байгуулагдсан ба Парламентад мэдээлэл, дүн шинжилгээ, зөвлөгөө өгөх найдвартай эх сурвалж болж ирсэн байна.<sup>154</sup>

<sup>153</sup> Department of Parliamentary Services Annual Report 2022

<sup>154</sup> [https://www.apf.gov.au/about\\_parliament/parliamentary\\_departments/parliamentary\\_library](https://www.apf.gov.au/about_parliament/parliamentary_departments/parliamentary_library)

Парламентын үйлчилгээний тухай хуульд<sup>155</sup> зааснаар номын сан нь Парламентын үйлчилгээний газарт харьяалагддаг. Номын сан нь:

- номын сан;
- судалгааны алба;
- мэдээллийн албанаас бүрдэнэ.

Судалгааны алба нь 80 гаруй судлаач, ажилтантай бөгөөд судалгааг дараах зохион байгуулалтаар хуваарилан гүйцэтгэдэг. Үүнд:

- Эдийн засгийн судалгааны хэсэг;
- Гадаад хэрэг, аюулгүй байдлын судалгааны хэсэг;
- Эрх зүй болон хуулийн төслийн шинжилгээний хэсэг;
- Улс төр болон нийтийн удирдлагын судалгааны хэсэг;
- Шинжлэх ухаан, технологи, хүрээлэн буй орчин, байгалийн баялгийн судалгааны хэсэг;
- Нийгмийн бодлогын судалгааны хэсэг;
- Статистик, график дүрслэлийн судалгааны хэсэг.

Судалгааны алба судалгаа, шинжилгээ хийхдээ Судалгааны захиалга хүлээн авах журам, Судалгааны ажил гүйцэтгэх заавар, Хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх журам болон холбогдох бусад заавар, журмыг дагаж мөрдөнө.

Номын сан болон судалгааны албаны харилцагчид нь:

- Парламентын гишүүд, сенаторууд, улс төрийн намууд;
- хоёр танхимын Тамгын газрын болон Байнгын хорооны ажлын албаны ажилчид, албан хаагчид байна.<sup>156</sup>

### **2.1.7. Австралийн ардчиллын музей**

Парламент нь шинэ ордон руу нүүсний дараа Парламентын хуучин ордныг 2009 оноос Австралийн ардчиллын музей болгон өөрчилсөн байна.

Ардчиллын музей үнэ төлбөргүй бөгөөд иргэдэд нээлттэй. Энд сурагчдын аялал, бүлгийн аялал, кафе түрээс, бэлэг дурсгалын дэлгүүр байрладаг бөгөөд парламентын ордны танхимууд, цэцэрлэгт хүрээлэнг олон нийтийн арга хэмжээнд зориулан түрээсэлж болдог байна. Хуучин парламентын ордон нь соёлын өвд тооцогдох бөгөөд байгалийн гэрэл сайтай, үзэмж төгс өв соёлыг агуулсан гайхалтай газар юм. Энд гала оройн зоог, хурим зэрэг 50-500 зочид бүхий арга хэмжээ зохион байгуулж болдог байна.<sup>157</sup>

<sup>155</sup> Parliamentary Service Act 1999. <https://www.legislation.gov.au/Details/C2019C00092>

<sup>156</sup> Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба. УИХ-ын Тамгын газар. 2012 он.

<sup>157</sup> <https://www.moadoph.gov.au/about/venue-hire>



### 2.1.8. Аюулгүй байдлын алба

Аюулгүй байдлын алба (Parliamentary Security Service) нь Парламентын ордонд орчин үеийн олон төрлийн хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Парламентын үйлчилгээний газарт харьяалагддаг. Аюулгүй байдлын алба нь 24 цагийн турш ажилладаг бөгөөд дараах чиг үүрэгтэй. Үүнд:

1. хүн болон эд хөрөнгийн Парламентын ордонд нэвтрэх шалгалт;
2. хандалтын хяналт;
3. хөдөлгөөнт эргүүл;
4. аюулгүй байдлын зөрчилд яаралтай хариу арга хэмжээ авах;
5. анхны тусламж, яаралтай тусламж үзүүлэх зэрэг орно. Гэхдээ тухайн нөхцөл байдлаас шалтгаалан нэмэлт хариу арга хэмжээ авахыг хуулиар зөвшөөрдөг байна.<sup>158</sup>

### 2.1.9. Парламентын ордныг түрээслэх

Австрали Улсын Парламентын ордонд ёслол хүндэтгэлийн арга хэмжээнүүдийг түрээсээр зохион байгуулахыг зөвшөөрдөг дэлхийн цөөхөн парламентын ордны нэг юм. Канберра хотод зохион байгуулагддаг томоохон ёслолын арга хэмжээний ихэнхийг тус ордонд зохион байгуулдаг бөгөөд тус улсын хамгийн том, хамгийн чухал үйл явдлууд энд өрнөдөг ажээ.

Парламентын ордонд 20 зочны оройн зоогоос эхлээд 1000 хүний томоохон арга хэмжээ хүртэл бүх төрлийн хурал, уулзалт, оройн, өдрийн зоогийн арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг байна.<sup>159</sup> Тухайлбал, тус ордны Их танхим, Ханын танхим, Хатан хааны дэнж, галерей, кафе, Гантиг үүдний танхим (фойе), Театр, урд талбай буюу Их веранда, хоолны өрөөнүүд, цэцэрлэгүүд зэрэг нийт 14 талбайд түрээсийн үйлчилгээ үзүүлдэг талаар Парламентын ордны цахим хуудсанд мэдээлсэн байна. Түрээсийн үйл ажиллагааг Парламентын үйлчилгээний газрын тусгай арга хэмжээний менежментийн баг хариуцдаг.<sup>160</sup>

<sup>158</sup> [https://www.aph.gov.au/About\\_Parliament/Employment/Department\\_of\\_Parliamentary\\_Services/Role\\_of\\_the\\_Parliamentary\\_Security\\_Service](https://www.aph.gov.au/About_Parliament/Employment/Department_of_Parliamentary_Services/Role_of_the_Parliamentary_Security_Service)

<sup>159</sup> <http://www.parliamentcateringbyihg.com.au/>

<sup>160</sup> [https://www.aph.gov.au/Visit\\_Parliament/Venue\\_Hire#greathall](https://www.aph.gov.au/Visit_Parliament/Venue_Hire#greathall)

Эдгээрээс Парламентын ордны урд талбай буюу Их верандаг авч үзвэл, 196 метр квадрат мозайкаар Австрали Улсын үүслийг дүрсэлсэн ажээ. Уг дүрслэлийг зохион бүтээсэн зураач Майкл Нелсон Жагамар бүтээлээ хүмүүс бүгд цугларан уулзалддаг газрыг илэрхийлсэн, эдгээр мөрөөдөл бол бидний амьдарч буй энэ улсын нэг хэсэг бөгөөд энэ газар нутаг бид бүх австраличуудын хувьд ямар утгатай болохыг тайлбарлахыг хичээсэн хэмээн өгүүлжээ.




Урд талбай буюу Их веранда бол Парламентын ордны олон нийтийн нүүр царай болж зочдыг хүлээн авах, ёслолын арга хэмжээ зохион байгуулагддаг.

## 2.2. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс (Солонгос Улс)-ын Үндэсний Ассамблейн эрх мэдлийг хэрэгжүүлэх, хууль тогтоох үйл ажиллагааг мэргэжлийн, үр дүнтэйгээр зохион байгуулах, дэмжих бүрэлдэхүүн харьяа байгууллагуудтайгаа цогцолбор байдлаар оршдог.



Үндэсний Ассамблей цогцолбор нь Солонгос Улсын Сөүл хотод байрлах 330.000м<sup>2</sup> талбайд баригдсан бөгөөд Үндэсний Ассамблейн ордон, Гишүүдийн ажлын байр, Номын сан, Төсвийн алба, Судалгааны алба зэрэг нийт 12 барилга байгууламж бүхий цогцолбор юм.



### 2.2.1. Эрх зүйн орчин

Үндэсний Ассамблейн бүрэлдэхүүн байгууллагууд нь Солонгос Улсын Үндсэн хууль, Үндэсний Ассамблейн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллахаас гадна зарим байгууллагууд нь бие даасан хуулиудаар үйл ажиллагаагаа зохицуулдаг байна. Үүнд:

- Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай хууль (National Assembly Secretariat Act);
- Үндэсний Ассамблейн Номын сангийн тухай хууль (National Assembly Library Act);
- Үндэсний Ассамблейн Судалгааны албаны тухай хууль (National Assembly Research Service Act)

Үндэсний Ассамблейн Фьючерс Институт (National Assembly Futures Institute) нь бие даасан хуулийн төслөө боловсруулан хэлэлцүүлж байна. Үндэсний Ассамблейн барилгуудын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс аюулгүй байдал, галын аюулгүй байдлын хамгаалалт, Үндэсний Ассамблейн танхимын ашиглалт, зочид, иргэд, олон нийт дотогш нэвтрэх, хүн бүр (тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн)-д хүртээмжтэй байлгах, барилгын бүрэн бүтэн байдлыг хамгаалах, засварлах зэрэг олон чиглэлийн дүрэм, журам, стандартуудыг мөрддөг байна.

## 2.2.2. Үндэсний Ассамблейн ордон

Үндэсний Ассамблейн ордон нь газар доор 1, дээш долоон давхар чулуун байгууламж бөгөөд зүүн хэсэгтээ байрлах Үндэсний Ассамблейн цогцолборын хамгийн том, дан барилга юм.

Боржин чулуун 24 багана, цэнхэр бөмбөгөр орой, цагаан гадна талтай Үндэсний Ассамблейн ордон нь архитектурын үзэсгэлэнт бүтээл юм. Энэхүү түүхэн барилгыг зургаан жил барьсны эцэст 1975 онд барьж дуусгажээ. Боржин чулуун 24 багана, цэнхэр бөмбөгөр орой нь нэгдмэл байдал, олон нийтийн олон ургалч үзлийг бэлгэддэг байна.



Бусад орны парламентын ордны нэгэн адил Үндэсний Ассамблей нь Зочны төвтэй бөгөөд энэ нь Үндэсний Ассамблейн үндсэн чиг үүрэг болон барилгын бүтцийн талаар мэдээлэл өгөх бөгөөд барилга доторх нийтийн эзэмшлийн зарим хэсгийг үзэж, танилцах нэвтрэх эрхийг журмын дагуу олгоно. Мөн урьдчилан захиалга өгсөн зочдод Үндэсний Ассамблейн номын сан, Үндэсний Ассамблейн ордон, чуулганы танхим зэрэг бусад газруудаар аялах боломжтой аж.

Үндэсний Ассамблейн ордонд зочлохын тулд Зочдын төвд хүсэлт гаргана. Ингэхдээ иргэний үнэмлэхтэй байх ёстой. Хэрэв улс төрчид, бодлого тодорхойлогчдыг харах сонирхолтой бол зарим хуралдаантай танилцах, хурлын үндсэн хэсэгт аялах боломжтой байдаг.

Үндэсний Ассамблейн ордон нь Ханганг голын дэргэдэх Зочдын төв, алхах талбай, зочид амрах сандлаас бүрдэнэ. Барилгын урд хэсэг нь эргэн тойрон ногоон зүлэг, цэцэгт ургамал, усан оргилуур, хөшөө байх бөгөөд түүгээр зугаалах боломжтой, цэлгэр цэцэрлэг юм.




Ордон нь төв зам, метроны буудлын ойролцоо байрладаг тул нийтийн тээврээр зорчин ирж танилцах боломжтой. Хэрэв иргэн бага насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, эсхүл өндөр настай хүнтэй хамт хувийн машинаар явж байгаа бол машинаа зогсоолд байрлуулахыг зөвшөөрдөг.

Тэргэнцэртэй хүнд зориулсан хаалга нь өдөр бүр 24 цаг нээлттэй байна.



*Үндэсний Ассамблейн цогцолбороор явах явган аяллын маршрут:*

Үндэсний Ассамблейн музей → Үндэсний Ассамблейн номын сан → Үндэсний Ассамблейн байр → Үндэсний Ассамблейн танхим → Үндэсний Ассамблейн төв хаалга → Үндэсний Ассамблейн музей



**Автомашины зогсоол ашиглалтын мэдээлэл:**

Үндэсний Ассамблейн цогцолборын автомашины зогсоолд зөвхөн албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн үйлчилгээний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хамгаалалт шаардлагатай бусад тээврийн хэрэгслийг байрлуулахыг зөвшөөрдөг. Жуулчид болон энгийн зочид Ханганг голын эрэг дээрх автомашины зогсоол дээр машинаа байрлуулдаг байна.

Үндэсний Ассамблейн автомашины зогсоол нь 2 цаг үнэгүй үйлчилгээ үзүүлдэг. Ингэхдээ Үндэсний Ассамблейн ордны зочдын төв, эсхүл Үндэсний Ассамблейн музейн мэдээллийн төвөөс зогсоолын тасалбараа тамгалуулдаг байна.

**2.2.3. Үндэсний Ассамблейн Тамгын газар**

Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төсөв, бүртгэл тооцоог хянах, зохион байгуулах болон захиргааны үйл ажиллагааг удирдан явуулах зорилгоор Үндэсний Ассамблейн Тамгын газрыг<sup>161</sup> байгуулна (Үндэсний Ассамблейн тухай хуулийн<sup>162</sup> 21 дүгээр зүйл).

<sup>161</sup> Үндэсний Ассамблейн Тамгын газрын цахим хуудас.,  
<sup>162</sup> Үндэсний Ассамблейн тухай хуулийн 21 дүгээр зүйл., [https://elaw.klri.re.kr/kor\\_service/lawView.do?lang=ENG&hseq=57599&joseq=JO0046030](https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=57599&joseq=JO0046030)

Үндэсний Ассамблейн Тамгын газар нь Үндэсний Ассамблейн гишүүн, хорооны хүсэлтийн дагуу Үндэсний Ассамблейн хууль тогтоох, төсвийн хяналт шалгалт, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай зүйлсээр хангаж, туслалцаа үзүүлнэ.

Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай хуулийг (National assembly secretariat act)<sup>163</sup> 1963 онд баталсан бөгөөд хамгийн сүүлд 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Хууль нь 4 бүлэг, 13 зүйлтэй. Хуулийн зорилго нь *“Үндэсний Ассамблейн Тамгын газрын зохион байгуулалт, чиг үүрэг болон шаардлагатай бусад асуудлыг зохицуулахад оршино”* гэжээ.

Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд Үндэсний Ассамблейн дарга намын бүлгүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр нэгдсэн хуралдаанаар томилж, чөлөөлнө.

Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндэсний Ассамблейн даргын удирдлага дор Үндэсний Ассамблейн үйл ажиллагаанд хяналт тавьж, өөрийн харьяанд байгаа төрийн албан хаагчдыг удирдан чиглүүлж, хяналт тавих үүрэгтэй.

Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэд:

- хууль тогтоох асуудал, хорооны ажлыг дэмжих чиг үүрэгтэй Хууль тогтоох асуудал эрхэлсэн орлогч;
- төлөвлөлт, төсөв санхүү, хүний нөөц, гадаад харилцаа, сургалт, олон нийтийн хэвлэл мэдээллийн төлөвлөлт зэрэг Захиргааны асуудал эрхэлсэн орлогч байна.

Үндэсний Ассамблейн Тамгын газрын чиг үүрэг нь хууль тогтоогчдын үйл ажиллагааг бүхэлд нь дэмжих, парламентын хуралдааныг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн төсөл хэлэлцэх, төсөв, тооцоо, төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт, мөрдөн байцаалтад туслахаас эхлээд парламентын гадаад харилцааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, иргэний ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

<sup>163</sup> National assembly secretariat act., [https://elaw.klri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=54178&type=lawname&key=NATIONAL+ASSEMBLY+SECRETARIAT+ACT](https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=54178&type=lawname&key=NATIONAL+ASSEMBLY+SECRETARIAT+ACT)



### **а) Үндэсний Ассамблейн харуул хамгаалалтын алба**

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 144 дүгээр зүйлд Үндэсний Ассамблейн харуул хамгаалалтын алба, цагдаагийн харуулын тухай тусгаж өгсөн байна.



Үндэсний Ассамблейн аюулгүй байдал, хамгаалалтыг хангах зорилгоор Үндэсний Ассамблейн бүрэлдэхүүнд харуул хамгаалалтыг томилон ажиллуулна.

Үндэсний Ассамблейн аюулгүй байдал, хамгаалалтад шаардлагатай гэж үзвэл Үндэсний Ассамблейн дарга Танхимын Удирдах хорооны (House Steering Committee) зөвшөөрлөөр үндэсний цагдаагийн албан хаагчдыг тогтоосон хугацаанд ирүүлэх хүсэлтийг Засгийн газарт гаргадаг байна.

Үндэсний Ассамблейн ордны гаднах цагдаагийн харуул болон хуралдаан болж буй танхимын доторх дэг журмыг сахиулах, аюулгүй байдал, харуул хамгаалалтыг Үндэсний Ассамблейн даргын удирдлага дор явуулна. Үндэсний Ассамблейн цагдаагийн харуул нь Сөүл хотын цагдаагийн газарт харьяалагддаг байна.

Үндэсний Ассамблейн Тамгын газрын бүтцийн нэгжид *Үндэсний Ассамблейн аюулгүй байдлын алба* байдаг бөгөөд дараах үндсэн үүргийг хэрэгжүүлдэг байна.

- Үндэсний Ассамблейн аюулгүй байдал, хамгаалалт;
- Үндэсний Ассамблейн зочдын аюулгүй байдал, хамгаалалт;
- Үндэсний Ассамблейн ордонд зочлох зочдод үзүүлэх дэмжлэг, аюулгүй байдлын үзлэг, шалгалт;
- Зочны үнэмлэх олгох, зочдод зааварчилгаа өгөх, удирдан зохион байгуулах;
- Терроризмоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой асуудлуудыг (кибер терроризмоос бусад) хариуцан ажилладаг байна.

(Үндэсний Ассамблейн хамгаалалт, музейн хамгаалалт, Үндэсний Ассамблейн цогцолборын хамгаалалт, гадна талбай, авто зогсоолын хяналт, зогсоолын дарааллын хяналт, хуралдааны танхимын хамгаалалт, нөхцөл байдлын иж бүрэн хяналтын камерын хяналт, CCTV хяналт, цахим хандалтын системийн удирдлагын хяналт гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлдэг байна)

## б) Үндэсний Ассамблейн засвар үйлчилгээ

Тамгын газрын бүтцийн нэгж болох *Товчооны алба* (관리국) нь Менежментийн, Байгууламжийн, Тоног төхөөрөмжийн гэсэн 3 хэлтэстэй. Товчооны албаны үндсэн үүрэг нь:

- Үндэсний Ассамблейн өмчийн менежментийн асуудал;
- Үндэсний Ассамблейн ордны засвар үйлчилгээ, тохижилттой холбоотой асуудал;
- Чуулганы танхимын ерөнхий удирдлагын асуудал;
- Механик, цахилгаан, холбооны хэрэгслийн засвар үйлчилгээ, засварын менежментийн асуудал;
- Барааны менежментийн асуудал;
- Гамшиг, аюулгүй байдлын ослоос урьдчилан сэргийлэх, арилгах, байгууламжид учирсан хохирлыг арилгахтай холбоотой асуудлуудыг тус тус хариуцан ажилладаг байна.

### 2.2.4. Үндэсний Ассамблейн Номын сан

Үндэсний Ассамблейн ном, хууль тогтоомжийн материалтай холбоотой асуудлыг зохицуулахын тулд Үндэсний Ассамблейн номын сан<sup>164</sup> байгуулна (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйл).

Үндэсний Ассамблейн номын сан нь ном, тогтмол хэвлэл, нийтлэл, мультимедиа болон цахим материал, түүнчлэн нийгэм, хүмүүнлэгийн ухааны эх сурвалжуудыг цуглуулах, цуглуулгыг хөтлөх, хууль тогтоох болон хяналтын үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн мэдээлэл цуглуулах, шаардлагатай тоо баримтуудыг гаргах, дүн шинжилгээ хийх, эмхэтгэх, цуглуулах, мэдээллээр хангах чиг үүрэгтэйгээ гадна олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байлгах үүрэгтэй.



Үндэсний Ассамблейн номын сан нь хууль тогтоогчдын хууль тогтоох үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор байгуулагдсан бөгөөд олон нийтийн хүсэж буй асуудал, хууль тогтоомжийн талаар шаардлагатай мэдээллийг цуглуулах, хадгалах, түгээн дэлгэрүүлэх, цуглуулсан материалтай танилцах боломжийг ажлын бус цагаар ч олон нийтэд нээлттэй олгодог.

<sup>164</sup> Үндэсний Ассамблейн номын сангийн цахим хуудас.,

Үндэсний Ассамблейн номын сангийн тухай хуулийг (National Assembly Library Act)<sup>165</sup> анх 1988 онд баталсан бөгөөд хамгийн сүүлд 2021 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Хуулийн зорилго нь Үндэсний Ассамблейн номын сангийн зохион байгуулалт, чиг үүрэг, бусад асуудлыг зохицуулахад чиглэгдэнэ.



Үндэсний Ассамблейн номын сан нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. (Үндэсний Ассамблейн номын сангийн тухай хуулийн 2 дугаар зүйл) Үүнд:

1) Үндэсний Ассамблейн номын сан нь Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагааг дэмжин ажиллана:

- номын сангийн сан хөмрөгийг цуглуулах, боловсруулах, хадгалах, номын сангийн үйлчилгээ үзүүлэх;
- хууль тогтоох байгууллага, хууль тогтоомжтой холбоотой судалгаа хийх, асуулгад хариу өгөх, мэдээлэл өгөх;
- Үндэсний Ассамблейн дижитал номын сан байгуулж ажиллуулах;
- Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг цуглуулах, боловсруулах, хадгалах, үнэлэх, ашиглах;
- хууль тогтоох үйл ажиллагааны үндэсний ном зүйг бэлтгэх, стандартчилах;
- дотоод, гадаадын хууль тогтоох байгууллагуудын бусад номын сангуудтай хамтран ажиллах;
- Хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай бусад асуудал.

<sup>165</sup> National Assembly Library Act., [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=56084&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=56084&lang=ENG)

2) Номын сан нь Үндэсний Ассамблейгаас бусад төрийн байгууллагад номын сангийн үйлчилгээ үзүүлж болно. Бусад байгууллага гэдэгт орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн байгууллага, боловсролын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага зэрэг орох ба иргэд, олон нийтэд үйлчилгээ үзүүлнэ. Ингэхдээ номын сангийн үйлчилгээг ашиглах эрх олгох бөгөөд үүнийг журмаар зохицуулдаг байна.

## **2.2.5. Үндэсний Ассамблейн Төсвийн алба**

Төсөв, төсвийн төлбөр тооцоо, улсын сан, санхүүгийн менежмент, санхүү, бүртгэлтэй холбоотой асуудлыг судлах, дүн шинжилгээ хийх, дүгнэх, парламентын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үндэсний Ассамблейн Төсвийн алба (국회예산정책처)<sup>166</sup> байгуулна (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйл).

Үндэсний Ассамблейн Төсвийн алба (National Assembly Budget Office - NABO) нь парламентын санхүүгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдсан санхүүгийн асуудлаар мэргэшсэн, хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх байгууллага бөгөөд мэргэжлийн, бодит судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан улсын төсөв, төсвийн гүйцэтгэл хэлэлцэхэд туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

2003 оны 10 дугаар сарын 20-ны өдөр NABO нь үйл ажиллагаагаа эхлүүлж анхны дарга нь томилогдсон бөгөөд 2004 оны 03 дугаар сарын 03-ны өдөр өөрийн гэсэн байр, мэргэшсэн ажилтнуудтай болсон байна. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь нэг даргатай (Chief), Төсвийн албыг удирдах бөгөөд Танхимын Удирдах хорооны зөвшөөрснөөр Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө.

Төсвийн алба нь дараах чиг үүрэгтэй ажилладаг байна. Үүнд:

- төсвийн орлого, зарлага, санхүүгийн тооцоо, сангийн үйл ажиллагааны тооцоо, сангийн төлбөр тооцоонд судалгаа, дүн шинжилгээ хийх;
- төсөвт мөнгө болон бусад хөрөнгийг ашиглах шаардлагатай үнэт цаасны зардлыг тооцоолох;
- улсын болон макро эдийн засгийн санхүүгийн чиг хандлагын талаар дүн шинжилгээ хийх, таамаглал гаргах;
- төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төслүүдэд дүн шинжилгээ хийх, үнэлэх;
- улсын дунд болон урт хугацааны санхүүгийн төсөөлөл гаргах;
- Үндэсний Ассамблейн хороо, гишүүдийн хүсэлтээр дүн шинжилгээ хийх.

<sup>166</sup> Үндэсний Ассамблейн Төсвийн албаны цахим хуудас., [www.korea.nabo.go.kr](http://www.korea.nabo.go.kr)

## 2.2.6. Үндэсний Ассамблейн Судалгааны алба

Хууль тогтоомж, бодлоготой холбоотой асуудлаар судалгаа хийх, холбогдох материал, мэдээллээр хангах замаар парламентын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үндэсний Ассамблейн Судалгааны алба<sup>167</sup> байгуулна (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22-3 дугаар зүйл).

Үндэсний Ассамблейн Судалгааны албаны тухай хуулийг (National assembly research service act) 2007 оны 01 дүгээр сард баталсан бөгөөд хуулийн зорилго нь “Үндэсний Ассамблейн Судалгааны албаны зохион байгуулалт, чиг үүрэг болон шаардлагатай бусад асуудлыг шийдвэрлэхэд оршино.” гэжээ.

Үндэсний Ассамблейн Судалгааны албыг Үндэсний Ассамблейн даргын удирдлага дор байгуулах бөгөөд судалгааны албаны бие даасан байдлыг хүндэтгэн үзнэ гэж хуульд тусгаж өгсөн байна.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба (NARS) нь хууль тогтоох, бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх зорилгоор Үндэсний Ассамблейн хүрээнд байгуулагдсан бие даасан бодлогын судалгааны хүрээлэн юм. Судалгааны алба нь хууль тогтоомж, бодлогын асуудлаар судалгаа шинжилгээг бодитой, мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, шаардлагатай материалуудыг цуглуулах, боловсруулах, түгээх чиглэлээр ажилладаг байна.

Үндэсний Ассамблейн гишүүдийн хууль тогтоох үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үндэсний Ассамблейн тухай хууль, Үндэсний Ассамблейн Судалгааны албаны тухай хуулийг тус тус үндэслэн 2007 оны 03 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан бодлогын судалгаа, шинжилгээний мэргэжлийн байгууллага юм.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь нэг даргатай (Chief), Судалгааны албыг удирдах бөгөөд Танхимын Удирдах хорооны зөвшөөрснөөр Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө.

- БНСУ-ын бүхий л салбарт мэргэшсэн цорын ганц мэргэжлийн судалгааны байгууллага болох Үндэсний Ассамблейн Судалгааны албаны ажилтнууд нь мэргэжлийн ур чадвар, төвийг сахих, нууцлалыг үндсэн үнэт зүйл болгон авч, асуудлыг олон талаас нь судалж, дүн шинжилгээ хийх бөгөөд хууль тогтоох болон бодлого боловруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээг үзүүлдэг.

<sup>167</sup> Үндэсний Ассамблейн судалгааны албаны цахим хуудас., <https://www.nars.go.kr/index.do>



- Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь Үндэсний Ассамблейн гишүүдийн хууль тогтоох үйл ажиллагааг үнэнчээр дэмжиж, ард түмний төлөөллийн байгууллагын үүргээ биелүүлэх, ардчиллын төлөвшилд хувь нэмрээ оруулахад идэвхтэй дэмжлэг үзүүлэхийг эрмэлздэг.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь Үндэсний Ассамблейн хороод, Үндэсний Ассамблейн гишүүдээс хүссэн хууль тогтоомж, бодлого боловсруулахтай холбоотой асуудлыг шинжлэх ухаан, мэргэжлийн өндөр түвшинд судалж, дүн шинжилгээ хийн, хариултыг өгдөг.

### 2.2.7. Үндэсний Ассамблейн Фьючерс институт

Үндэсний Ассамблейн Фьючерс Институт (National Assembly Futures Institute)<sup>168</sup> нь орчны өөрчлөлтийг урьдчилан таамаглах, дүн шинжилгээ хийх, дунд болон урт хугацааны үндэсний хөгжлийн стратегийг боловсруулах, Үндэсний Ассамблейн бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх, үндэсний хөгжилд хувь нэмэр оруулах зорилготойгоор 2018 оны 05 дугаар сард байгуулагдсан.



**Алсын хараа:** Үндэсний ирээдүйн стратегийг боловсруулах Үндэсний Ассамблейн Тинк Танк.

NAFI нь Үндэсний Ассамблейн даргын дэргэдэх шууд харьяа институт бөгөөд аль нэг намын харьяалалд байдаггүй, ирээдүйн урт хугацааны судалгааг улс төрийн нөлөөллөөс хараат бусаар тууштай явуулах зорилгоор байгуулагдсан. Институтын Удирдах зөвлөл нь Үндэсний Ассамблейн эрх баригч болон сөрөг хүчний тэнцүү тооны гишүүдээс бүрдэх бөгөөд судалгааны сэдэв, судалгааны үр дүнг эрх баригч болон сөрөг хүчний намуудын төлөөллөөс бүрдсэн Үндэсний Ассамблейн Удирдах хороонд тайлагнана. Мөн бүлэглэлээс ангид чадварлаг боловсон хүчин, мэргэжлийн судлаачид, судалгааны найдвартай, бодитой үр дүнгээр судалгааны институтын эрх мэдэл, бие даасан байдлыг баталгаажуулна.

<sup>168</sup> Үндэсний Ассамблейн Фьючерсийн институтын цахим хуудас., <http://www.nafi.re.kr>

### 2.2.8. Үндэсний Ассамблейн Харилцаа холбооны танхим

Үндэсний Ассамблейн Харилцаа холбооны байгууламж нь 4 давхар, нийт 24.732м<sup>2</sup> талбайтай Үндэсний Ассамблейн ордон болон Үндэсний Ассамблейн гишүүдэд зориулсан оффисын барилгын хажууд байрладаг.



Байгууламжийн 2, 3 дугаар давхарт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлэх танхим, сэтгүүлчдэд зориулсан, тоноглогдсон 125 хүний суудал бүхий мэдээллийн танхимтай Хэвлэлийн төв; өндөр тоноглол бүхий ухаалаг ажлын төв; 4 дүгээр давхарт нэмэлт оффисын танхимууд; газар доорх зогсоол, 1 дүгээр давхарт 1200 хүний суудал бүхий зоогийн газар, хүлээн



авалтын танхим, биеийн тамирын заал, жижиглэнгийн худалдааны талбай бүхий нийтийн үйлчилгээний газруудтай бөгөөд энэ нь төрийн албан хаагчид болон олон нийтэд үйлчилдэг байна.



## 2.2.9. Үндэсний Ассамблейн Музей

Үндэсний Ассамблейн Музей (National Assembly Museum)<sup>169</sup> нь Үндэсний Ассамблейн үйл ажиллагаа, Парламентын ардчилалтай холбоотой төрөл бүрийн материалыг Үндэсний Түр Ассамблейгаас өнөөг хүртэлх хугацаанд хадгалж, дэлгэн үзүүлдэг үндэсний нэгдүгээр зэрэглэлийн музей юм.



Музейн байр одоогоос 24 жилийн өмнө буюу 1998 онд “Үндсэн хуулийн дурсгалын ордон” (Constitution Memorial Hall) нэртэйгээр баригдсан. 2020 онд музейн үзэсгэлэнгийн талбайг системтэйгээр шинэчлэн зохион байгуулах зорилгоор анх удаа иж бүрэн засвар үйлчилгээ хийж 2022 онд “Үндсэн хуулийн дурсгалын ордон”-ы суурин дээр “Үндэсний Ассамблейн Музей” нэрээр дахин нээгдсэн байна.

Үндэсний Ассамблейн Музейн зорилго нь Үндэсний Ассамблей болон парламентын ардчиллын талаарх зөв ойлголтыг төлөвшүүлэх төв, боловсролын газар болгоход чиглэгдэнэ.

Үндэсний Ассамблейн Музей нь газар доор 1 давхар, газар дээр 3 давхар барилгаас бүрдэх бөгөөд 2 дугаар давхартаа Үндэсний Ассамблейн түүхэн үйл явцын байнгын үзэсгэлэнгийн 1, 2, 3, 4 дүгээр танхим, тусгай үзэсгэлэнгийн танхим, 1 дүгээр давхарт хүүхдийн музей болон музейн зочдод зориулсан тав тухтай амрах орчин, талбайг бүрдүүлсэн.

Музейн ажиллах цагийн хуваарь нь Даваа – Баасан гарагт 10:00-18:00 цаг (17:00 цаг хүртэл орохыг зөвшөөрнө) Бямба гаригт 10:00-13:00 цаг (12:00 цаг хүртэл орохыг зөвшөөрнө) хүртэл, Ням гарагт амардаг байна.

<sup>169</sup> Үндэсний Ассамблейн музейн цахим хуудас., <https://museum.assembly.go.kr/museum/main/main.do>

## 2.3.ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

### 2.3.1.Парламентын буюу Вэстминстерийн ордон

Их Британийн Парламент байрладаг Вэстминстерийн ордон бол дэлхийн хамгийн алдартай барилгуудын нэг бөгөөд хаант улсын ардчиллын гол цөм болж байдаг.

Вэстминстерийн ордны эдлэнд байрлах хамгийн эртний барилга болох Вэстминстер танхим нь 900 гаруй жилийн өмнө II Виллиам барьсан бөгөөд тухайн үед Европ дахь хамгийн том танхим гэж тооцогддог байжээ. XIII зуунаас тус танхимд Английн Парламент хуралдах болсон.



### 2.3.2.Эрх зүйн орчин

Вэстминстерийн ордны нутаг дэвсгэрдээрх барилгууд хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, явуулах арга хэмжээ өөр байхын хамт барилгуудад мөрдөх дүрэм, журам өөр өөр байдаг. Эдгээр дүрэм, журмууд нь тэдгээр барилгуудын аюулгүй байдал, үйл ажиллагааг хангахад чиглэгддэг.<sup>170</sup>

Вэстминстерийн ордны нутаг дэвсгэр дээр мөрддөг дүрэм, журам, удирдамж, төлөвлөгөөнүүдийг тоймлон үзвэл:

**а) Түүхэн болон соёлын өвийн хамгаалалт, хадгалалт** – Вэстминстерийн ордон нь ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн бөгөөд түүний архитектур, түүнд хадгалагдаж буй урлагийн үнэт бүтээлүүд, түүхийн баримт бичиг, эд өлгийн зүйлсийг хадгалахын тулд нэлээдгүй дүрэм, журам мөрддөг.

<sup>170</sup> <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/sn00485/>

- *Жагсаалтад орсон барилгууд (listed building)*: Архитектур, түүх, үндэсний онцлог шинж чанартай барилгуудыг уг жагсаалтад гурван зэрэгт ангилж оруулдаг. Энэ нь барилгын түүх, архитектурын бүрэн бүтэн байдлыг хадгалахын тулд аливаа өөрчлөлт, өргөтгөл, засварыг нарийвчилсан зааврыг баримталж хийх ёстой гэсэн үг. Вэстминстерийн ордон нь уг жагсаалтын I зэрэглэлд тодорхойлогдсон.
- *Хамгаалалтын бүсүүд (Conservation Areas)*: Вэстминстерийн ордны нутаг дэвсгэрийг хамгаалалтын бүс гэж тодорхойлдог. Энэ нь эдгээр газруудын шинж чанар, өнгө үзэмжийг хамгаалах нэмэлт зохицуулалт, тухайлбал, шинээр барих, хуучин барилгуудад өөрчлөлт оруулахыг хязгаарласан гэсэн үг юм.
- *Төлөвлөсөн эртний дурсгалт газрууд (Scheduled Ancient Monuments)*: Вэстминстерийн ордны зарим хэсэг, эсхүл түүний ойр орчмын газрыг эртний дурсгалт газруудаар тооцож болно. Энэ нь өндөр түвшний хамгаалалтыг санал болгодог бөгөөд эдгээр бүс дэх аливаа өөрчлөлт, хөгжил нь өвийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл шаарддаг. Түүнчлэн Английн түүхэн барилга, дурсгалт газруудыг хадгалах, хамгаалах үүрэгтэй Засгийн газрын өвийн агентлаг болох Түүхэн Англи (Historic England) нь Вэстминстерийн ордон болон бусад түүхэн дурсгалт газруудыг хамгаалах талаар заавар, зөвлөгөө өгч, хяналт тавьдаг.
- *Төлөвлөлтийн зөвшөөрөл (Planning Permission)*: Вэстминстерийн ордны нутаг дэвсгэр дээр болон түүний ойр орчмын санал болгож буй аливаа өөрчлөлт, бүтээн байгуулалтыг төлөвлөлтийн зөвшөөрлийн дагуу хийнэ. Орон нутгийн төлөвлөлтийн байгууллага нь өвийн асуудал хариуцсан байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зөвшөөрөл олгохоос өмнө түүхэн болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийдэг.
- *Хамгаалалтын төлөвлөгөөнүүд (Conservation Plans)*: Вэстминстерийн ордны нутаг дэвсгэр дээрх барилгууд нь байгаль хамгаалах талаар төлөвлөгөөтэй байдаг. Эдгээр төлөвлөгөөнүүд нь тэдгээр барилгуудыг хадгалах, сэргээн засварлах зарчим, зорилгыг тодорхойлж, үүнд материал, техник, дизайны талаарх тусгай удирдамж багтсан болно.

**б) Барилгын стандарт, дүрэм, журам** – Вэстминстерийн ордны байгууламжийн бүрэн бүтэн байдал, галын аюулгүй байдал болон барилга угсралт, засвар үйлчилгээний бусад асуудалд тавигдах стандартыг тогтоосон үндэсний болон орон нутгийн барилгын стандарт, дүрэм, журмыг мөрдөнө.

- *Галын аюулгүй байдал (Fire Safety)*: Вэстминстерийн ордон нь түүхэн ач холбогдолтой, үнэт бичиг баримт, эд өлгийн зүйл байдгаараа онцгой ач холбогдол бүхий объект болдог. Ордныг гал

түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах системийн бэлэн байдлыг хангах төдийгүй галын аюулгүй байдлын үзлэг, сургуулилтыг тогтмол хийхтэй холбоотой дүрэм, журам, төлөвлөгөөг мөрддөг.

- *Хүртээмжтэй байдал (Accessibility)*: Вэстминстерийн ордныг хамгаалахын зэрэгцээ олон нийтэд хүртээмжтэй байлгахын тулд ордонд хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэлтгүй бүх хүн нэвтрэх, ашиглахтай холбоотой зохицуулалтын дүрэм, журмыг мөрддөг. Үүнд, налуу зам, цахилгаан шат, зориулалтын бие засах газар, тэмдэг тэмдэглэгээ зэрэг онцлогууд багтана. Мөн олон нийтэд Вэстминстерийн ордны түүхэн, соёлын ач холбогдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хөтөчтэй аялал, боловсролын хөтөлбөрүүдийг явуулах дүрэм, журам, төлөвлөгөөг мөрддөг.
- *Парламентын гишүүд болон албан хаагчдад хүртээмжтэй байдал (Accessibility for Parliamentarians and government officials)*: Вэстминстерийн ордон нь олон нийтэд хүртээмжтэй байхаас гадна Парламентын гишүүд, төрийн албан хаагчдад ажлаа явуулах аюулгүй, үр ашигтай орон зайг хангахтай холбоотой стандарт, дүрэм, журмыг мөрддөг.
- *Байгаль орчны зохицуулалт (Environmental Regulations)*: Вэстминстерийн ордны нутаг дэвсгэр дээрх барилгуудын эрчим хүчний хэмнэлт, тогтвортой байдал, орчны ногоон байгууламжтай холбоотой стандарт, дүрэм, журмыг мөрддөг.

**в) Аюулгүй байдал** – Вэстминстерийн ордон болон түүний дотор ажиллаж байгаа улс төрийн зүтгэлтнүүдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмууд нь Парламентын гишүүд болон зочдын аюулгүй байдлыг хангах үүднээс аюулгүй байдлын арга хэмжээнүүд багтаасан байдаг. Үүнд, нэвтрэх хяналт, хяналтын систем, хамгаалалтын ажилтнууд, аюулгүй бүсүүд, онцгой байдлын бэлэн байдал, харилцаа холбоо, зохицуулалт, болзошгүй эрсдэл, эмзэг байдлын аюулын үнэлгээ, кибер аюулгүй байдал, зочдод болон ажилтнуудад аюулгүй байдлын дүрэм, журмыг таниулах сургалт, сурталчилгааны ажил зэрэг багтдаг.

**г) Засвар үйлчилгээ, сэргээн засварлалт** – Вэстминстерийн ордон дотор аливаа үйл ажиллагаа, арга хэмжээг хэвийн зохион байгуулах, хэрэгжүүлэхийн тулд тус ордонд байнгын засвар үйлчилгээ, сэргээн засварлахтай холбоотой дүрэм, журам, төлөвлөгөөг мөрддөг. Мөн Вэстминстерийн ордны өвийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн хадгалах, Их Британийн Парламентын ордон хэвээр байхын сацуу тус ордныг шинэ технологи, ирээдүйн шаардлагад нийцүүлэн өөрчлөхийн тулд томоохон засварын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага үүсэж 2019 онд тус улсын Парламентын хоёр танхимаас Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулийг<sup>171</sup> баталсан.

<sup>171</sup>Parliamentary Buildings (Restoration and Renewal) Act 2019. <https://www.legislation.gov.uk/ukpga/2019/27/enacted#printOptions>

### 2.3.3. Вэстминстерийн ордныг сэргээн засварлах хөтөлбөр

2019 онд Вэстминстерийн ордны хоолой хагарснаас болж Парламентын танхимуудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон нь тус ордныг илүү өргөн хүрээнд сэргээн засварлах, шинэчлэх тухай яригдах болсон.

Парламентын хоёр танхимаас Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулийн дагуу Сэргээн засварлах, шинэчлэх хөтөлбөр (Restoration and Renewal Programm) хэрэгжүүлэх ба энэхүү хөтөлбөр нь Их Британийн өвийн шинэчлэлийн хамгийн том төсөл болж байна. Сэргээн засварлах ажил нь дараах хэсэгт хуваагдаж Вэстминстерийн ордны томоохон асуудлуудыг шийдвэрлэхээр төлөвлөж байна<sup>172</sup>:

- эрүүл мэнд, аюулгүй байдал – ордны 4000 хүрэл цонхыг сольж, асбестыг<sup>173</sup> арилгаснаар галын хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулах;
- барилга доторх дэд бүтэц – ордон нь хуучирсан үйлчилгээтэй холбоотой 40.000 гаруй асуудлыг мэдээлсний дагуу сэргээн засварлах төлөвлөгөө нь бүх HVAC систем, ус зайлуулах суваг, сантехник, галын хамгаалалтын системийг солих;
- барилгын гадна фасад – тус ордны гадна фасадын чулуун хэсгүүд унах үед ноцтой асуудал үүсгэдэг тул тус асуудлыг шийдэх;
- олон нийтэд үзүүлэх түүхэн өв – сэргээн босголтын төлөвлөгөө нь энэхүү өвийн дурсгалт газарт хүн бүр ирж, үзэхэд тааламжтай, хүртээмжтэй болгох зорилготой;
- үйл ажиллагаа ба дизайн – шаардлагатай бүх аюулгүй байдлын арга хэмжээг багтаасан тус барилгыг ирээдүй хойч үедээ үлдээх, мөн харилцаа холбоог сайжруулах үүднээс ордонд мэдээлэл, харилцаа холбооны технологи суурилуулах;
- тогтвортой байдал – Парламентын үйл ажиллагаанд нийцсэн бөгөөд байгаль орчинд ээлтэй, тогтвортой шийдлүүдийг гаргах.

Сэргээн засварлах, шинэчлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 19-28 жилийн хугацаа шаардагдах ажээ. Тус барилгыг хоосон байлгаж сэргээн засварлахад ихээхэн зардал, цаг хугацаа хэмнэх тул Парламентын хоёр танхим 12-20 жилийн хугацаанд Вэстминстерийн ордны гадна ажиллах аж.

<sup>172</sup><https://www.re-thinkingthefuture.com/architectural-styles/a7718-timeline-of-restoration-palace-of-westminster/>

<sup>173</sup> Асбест (asbestos) нь байгаль дээр тархсан гидросиликат магни, төмөр, кальци, натригаас тогтсон маш нарийхан утсархаг бүтэцтэй, бутрамтгай чулуулаг эрдсүүд юм. Асбестийн бүлгийн эрдэс нь бат бэх, дулаан цахилгааныг бага дамжуулдаг, гадаад орчин, халуун, хүйтэн, галд болон химийн бодисын үйлчлэлд тэсвэртэй, удаан эдэлгээтэй зэрэг онцлог шинж чанаруудтай. Асбестийн 6 төрөл байдаг бөгөөд бүгд хүний биед онцгой хортой, хорт хавдар үүсгэгч бодис юм.

Сэргээн босгох, шинэчлэх хөтөлбөрийн ажил нь дөнгөж эхэлж байгаа бөгөөд одоогийн байдлаар тус хөтөлбөрийн Гүйцэтгэгч хэлтэс нь Парламентын Тамгын газартай хамтран сэргээн засварлах, шинэчлэх ажлын хамрах хүрээг тодорхойлж байна. Хамрах хүрээг тодорхойлж, энэ том төслийн иж бүрэн судалгааг хийж, зураг төслийг тохиролцсоны дараа ажлын арга барил, шаардлагатай зардлыг хоёр танхимын гишүүдэд танилцуулж шийдвэрлэнэ.

Дэлхийн хамгийн алдартай барилгуудын нэг болох Вэстминстерийн ордонг хойч үедээ үлдээхийн тулд их засвар хийх шаардлагатай ажээ. Түүнийг сэргээн засварлах хөтөлбөр нь Их Британийн аж үйлдвэрийг идэвхжүүлж эхлээд байгаа бөгөөд аль болох тус улсын бүтээгдэхүүнийг ашиглаж, инженер, дизайнер, мужаан, өрлөгчин зэрэг олон мэргэжилтнүүдийг ажлын байр, дадлага хийх боломжоор ханган ажиллаж байна.

2019 онд батлагдсан Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулийн<sup>174</sup> зорилго нь Вэстминстерийн ордныг сэргээн засварлах ажил болон Парламентын эдлэнд хамаарах бусад ажилтай холбоотой харилцааг зохицуулна.

Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулиар Вэстминстерийн ордны сэргээн засварлах ажлын оролцогч талууд, тэдний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, хариуцлага, хариуцан тайлагнах үйл явц, оролцогч талууд хоорондын болон Парламент хоорондын харилцаа, Парламентын эрх, үүрэг, хэрэгжүүлэх үе шатууд, арга хэмжээнүүд болон түүнд аудит хийх зэрэг өргөн хүрээний харилцааг зохицуулсан байна.

Энэ хуулиар Вэстминстерийн ордныг сэргээн засварлах үүрэгтэй Парламентын ажлыг Ивээн тэтгэгч байгууллага (Parliamentary Works Sponsor Body)-ыг байгуулсан. Тус байгууллагын боловсруулсан Вэстминстерийн ордныг сэргээн засварлах хөтөлбөрийн зардал, хуваарийн анхны үнэлгээтэй Нийтийн танхимын хороо 2022 оны 01 дүгээр сард танилцаж, хоёр танхимын хороодын хамтарсан хуралдаанаар 2022 оны 03 дугаар сард Сэргээн засварлах, шинэчлэх хөтөлбөрт өөрчлөлт оруулахаар тохиролцон, Ивээн тэтгэгч байгууллагын чиг үүргийг Парламентад шилжүүлэх, эсхүл өөр байгууллагад шилжүүлэхийг санал болгосон байна.<sup>175</sup>

<sup>174</sup> Parliamentary Buildings (Restoration and Renewal) Act 2019. <https://www.legislation.gov.uk/ukpga/2019/27/enacted#printOptions>

<sup>175</sup> <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8968/>





2022 оны 07 дугаар сард Парламентын хоёр танхимын хороод уг хөтөлбөрийн хэрэгжилтэд хамтарсан хяналт тавихаар санал нэгдсэн байна.<sup>176</sup>

Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулийн дагуу Сэргээн босгох, шинэчлэх хөтөлбөрийн захиргаа (Restoration and Renewal Programme governance) байгуулагдсан. Мөн Сэргээн засварлалтын ажлын зураг төсөл боловсруулах, гүйцэтгэх үүргийг Гүйцэтгэгч хэлтэс (Delivery Authority)-т олгосон байна.

2022 оны 09 дүгээр сард Лордын танхим ба Нийтийн танхимын шинэ хамтарсан хороо болох Сэргээн засварлах, шинэчлэх үйлчлүүлэгчийн зөвлөл (Restoration and Renewal Client Board)-ийг байгуулжээ. Тус зөвлөл нь хоёр танхимын спикерүүд, парламентын 15 гишүүн, мөн парламентын бус 8 гишүүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөлийн парламентын бус 8 гишүүнд хоёр танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга (Clerk) нар, Нийтийн танхимын ерөнхий захирал, хоёр танхимын комиссын гадаад гишүүд орсон байна.


<sup>176</sup> <https://www.restorationandrenewal.uk/about-us/governance>



### 2.3.4. Вэстминстерийн ордны танхимууд

Өнөөдөр Вэстминстерийн ордон 3.24 га талбайг эзэлдэг бөгөөд 4 давхар, 1100 орчим өрөө, 100 шат, 4.8км гарцтай. Урд талын Виктория цамхгаас хойд зүгт Цагтай цамхаг хүртэлх барилга нь бараг 300 метр урттай.

Тус ордонд олон тооны коридор, галерей байдаг бөгөөд ихэнх нь урлагийн бүтээлүүд, түүхэн олдворууд, Их Британийн улс төрийн зүтгэлтнүүдийн хөрөг зургууд байдаг.



### **а) Вэстминстерийн танхим**

Вэстминстерийн танхим бол Парламентын ордны нутаг дэвсгэр дээрх хамгийн эртний барилга бөгөөд томоохон арга хэмжээнүүд зохион байгуулагддаг. Тус танхим нь уужим цэлгэр бөгөөд архитектурын гайхамшигт шийдэл бүхий тааз, дотоод засал нь Их Британид төдийгүй дэлхийд архитектурын гайхалтай бүтээлд тооцогддог.



### **б) Лордын Танхим**

Их Британийн Парламентын дээд танхим болох Лордын Танхимын хуралдааны танхимд парламентын гурван элемент (бүрэн эрхт ноёд, ард түмэн)-үүдийг нэгтгэсэн учир Вэстминстерийн ордны хамгийн тансаг чимэглэлтэй өрөөнд тооцогддог. Танхим дахь тавилга нь ихэвчлэн улаан өнгөтэй байдаг.



### **в) Нийтийн Танхим**

Парламентын доод танхим болох Нийтийн Танхимын урт сандал болон бусад тавилга нь 300 жилийн өмнөх уламжлалт ногоон өнгөтэй. Эсрэгцүүлж тавьсан урт сандлууд нь Их Британийн анхны байнгын ажиллагаатай Нийтийн Танхим болох Гэгээн Стефан сүмийн анхны зохион байгуулалтыг хадгалсан байна.



### **г) Төв лобби**

Төв лобби нь барилгын гол хэсэгт байрладаг бөгөөд дугуй хэлбэртэй, Вэстминстерийн ордны гол цөм болдог. Энэ нь Вэстминстерийн танхим, Парламентын хоёр танхимын уулзвар бөгөөд хоёр танхимын гишүүдийн уулзалт хийх газар, Парламентын гишүүд сонгогчидтойгоо уулзах газар болгон төлөвлөжээ.



### 2.3.5. Парламентын номын сангууд

Парламентын хоёр танхим тусдаа өөрсдийн номын сантай. Эдгээр түүхэн номын сангууд нь Парламентын түүхэн баримт бичиг, ном, тэмдэглэл зэрэг арвин сан хөмрөгтэй.

Номын сангууд нь хоёр танхимын гишүүд болон тэдний ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг байна.

#### **а) Лордын Танхимын номын сан**

Лордын Танхимын номын сан нь Парламентын ажилд тусалж хууль эрх зүйн болон лавлах номоор хангах зорилгоор 1826 онд байгуулагджээ.

Тус номын сан нь Лордын Танхимд хэлэлцэж байгаа асуудлуудын талаар товч мэдээлэл, тойм, тухайн асуудлын Парламент дахь хэлэлцүүлгийн явц, сүүлийн үеийн үйл явдлуудыг танилцуулах үйлчилгээг Танхимд үзүүлдэг.



Номын сан нь 80.000 орчим түүхэн (тусгай) болон орчин үеийн ном, сэтгүүл, сонин, парламентын баримт бичгийн цуглуулгатай. Лордын Танхимын гишүүд болон түүний Ажлын албаны ажилтнуудаас гадна иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлдэг. Тухайлбал, номын сангийн тусгай цуглуулгын талаар судалгаа хийх сонирхолтой иргэд Парламентын архиваар дамжуулан материалаа авах хүсэлт гаргана. Иргэд Лордын Танхимын үйл ажиллагаатай холбоотой лавлагааг цахимаар, эсхүл утсаар авах боломжтой байдаг.

Утасны лавлах үйлчилгээ нь Даваа-Пүрэв гараг хүртэл 10:00-17:00, Баасан гарагт 10:00-16:00 цагийн хооронд ажилладаг.

#### **б) Нийтийн Танхимын номын сан**

Нийтийн Танхимын номын сан нь тус Танхимын гишүүд болон түүний Ажлын албаны ажилтнуудад хууль тогтоомжийн төслийг нягтлан шалгах, хэлэлцүүлэгт бэлтгэх, тухайлсан чиглэлээр бодлого боловсруулах, сонгогчдоо дэмжихэд тусалцаа үзүүлдэг.





Тус номын сангаас судалгааны тайлан, улс төрийн хувьд хараат бус дүн шинжилгээ, статистикийн мэдээлэл бэлтгэдэг.

### 2.3.6. Виктория цамхаг буюу Парламентын архив

Вэстминстерийн ордны хамгийн өндөр цамхаг бол Виктория цамхаг юм. Хатан хаан Викториягийн нэрээр нэрлэгдсэн, 98.5 метр өндөртэй энэ цамхаг олон жилийн турш дэлхийн хамгийн өндөр, хамгийн том чулуун дөрвөлжин цамхаг байв. Анхандаа хаан тус цамхагаар дамжиж ордон руу ордог байсан, мөн Парламентын бичиг баримтыг хадгалах зориулалттай байсан бөгөөд одоо Парламентын архивын байр болсон байна. Виктория цамхгийн хуучирсан өрлөгийг засах ажлыг 2024 онд эхлүүлэх төлөвтэй байна.

Парламентын архив нь Их Британийн Парламентын бүртгэлийг цуглуулж, хадгалж, тэдгээрийг Парламентын гишүүд болон түүний Ажлын албаны ажилтнуудад хүргэх үйлчилгээ үзүүлдэг. Мөн тус архив нь хоёр танхимд албан хэргийг хөтөлдөг.



Тус архивын сан хөмрөгт Их Британийн Парламентын үйл ажиллагаатай холбоотой түүхэн баримт бичиг, материал хадгалагддаг. Архивын сан хөмрөг нь ихэвчлэн органик материалаас (цаас, арьс шир, илгэн цаас, лав гэх мэт) бүрддэг. Сан хөмрөгийн цуглуулгыг механик гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчноос хамгаалж хадгалах, стандартын дагуу зөв зөөвөрлөхийг шаарддаг байна. Парламентын архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, зөөвөрлөлтийн ажлыг хариуцдаг.

Парламентын архив нь мөн сан хөмрөгөө олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлдэг. Олон нийтэд зориулсан архивын үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг. Энэхүү үйлчилгээг архивын лавлагаа гаргах, бүлгийн аялал хийх, ордон дотор болон Вэстминстерийн нутаг дэвсгэрт үзэсгэлэн болон сурталчилгааны хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, сан хөмрөгтэй цахимаар танилцах хэд хэдэн платформыг ажиллуулж байна.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Австралийн Холбооны Улс:

- Parliamentary Service Act 1999
- Application to use Formal Gardens
- Application to use Parliamentary Precincts - Authorised Assembly Area
- Australian Parliament House CCTV Code of Practice Guidance
- Australian Parliament House EACS Code of Practice Guidance
- Australian Parliament House Protest and other assemblies in the Parliamentary precincts policy
- Australian Parliament House Site Book Version 10.1 2022
- Department of Parliamentary Services Annual Report 2022
- General principles relating to the radio broadcasting of parliamentary proceedings
- Guidelines for filming and photography in Parliament House 2008
- Parliament House Private Area Access Policy
- Parliament House Private Car Parks Policy
- Parliament House smoking policy
- Parliament of Australia. Retrieved 26 December 2017.
- Parliamentary Library Statement of Client Services
- Rules for media related activity in parliament house and its precincts
- Standing determinations relating to the radio broadcasting of parliamentary proceedings
- Summit 2021, Australian Clean Energy.
- Use of the Parliament House facilities for functions and events
- <http://www.parliamenthousecateringbyihg.com.au/>
- <https://peo.gov.au>
- <https://pressgallery.net.au/>
- <https://www.abc.net.au>
- <https://www.legislation.act.gov.au/a/2004-11>

### Бүгд Найрамдах Солонгос Улс:

- Үндэсний Ассамблейн тухай хууль. <https://elaw.klri.re.kr>
- National Assembly Library Act. <https://elaw.klri.re.kr/eng>
- National Assembly Research Service Act. <https://elaw.klri.re.kr/eng>
- National Assembly Secretariat Act. <https://elaw.klri.re.kr/eng>
- Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв. УБ., 2012 он. 154-158 хуудас.
- Үндэсний Ассамблейн цахим хуудас. <https://korea.assembly.go.kr>
- Үндэсний Ассамблейн Тамгын газрын цахим хуудас.
- Үндэсний Ассамблейн Номын сангийн цахим хуудас
- Үндэсний Ассамблейн Төсвийн албаны цахим хуудас., [www.korea.nabo.go.kr](http://www.korea.nabo.go.kr)

- Үндэсний Ассамблейн судалгааны албаны цахим хуудас. <https://www.nars.go.kr/index.do>
- Үндэсний Ассамблейн Фьючерсийн институтын цахим хуудас. <http://www.nafi.re.kr>
- Үндэсний Ассамблейн музейн цахим хуудас. <https://museum.assembly.go.kr/museum/main/main.do>
- [http://nationalatlas.ngii.go.kr/pages/page\\_573.php](http://nationalatlas.ngii.go.kr/pages/page_573.php)
- <https://krguide.kr/MNG/1149/contents.do>

**Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс:**

- Parliamentary Buildings (Restoration and Renewal) Act 2019. <https://www.legislation.gov.uk/ukpga/2019/27/enacted#printOptions>
- Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Парламентын цахим хуудас. <https://www.parliament.uk/>
- <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8968/>
- <https://www.re-thinkingthefuture.com/architectural-styles/a7718-timeline-of-restoration-palace-of-westminster/>
- <https://www.restorationandrenewal.uk/about-us/governance>



## ТАЙВАНИЙН ХЯНАЛТЫН ЮАНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

*Г.Билгээ, О.Нарантуяа, П.Уранчимэ*

### АГУУЛГА

Хяналтын Юаны эрх зүйн орчин

Хяналтын Юаны бүрэлдэхүүн

Хяналтын Юаны бүтэц, зохин байгуулалт

Хяналтын Юаны нэгдсэн хуралдаан

Хяналтын Юаны хороод

Хяналтын Юаны эрх, үүрэг

1) Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх

2) Мөрдөн шалгах

3) Зөрчил арилгах арга хэмжээ

4) Итгэл үзүүлэх эсэх

5) Хариуцлага тооцох

6) Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээх авах

Аудитын үйл ажиллагаа

Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагаа

### ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Тайванийн Үндсэн хуулийн Хяналтын Юантай холбоотой зохицуулалт

Хавсралт 2. Тайванийн Хяналтын Юаны тухай хууль

Хавсралт 3. Тайванийн Хяналтын тухай хууль

Хавсралт 4. Хяналтын Юаны бүтэц, зохион байгуулалтын схем

Хавсралт 5. Хяналтын Юаны хяналтын үйл ажиллагааны зураглал

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1947 онд батлагдсан Тайванийн Үндсэн хуулиар<sup>177</sup> (Хавсралт 1.) тус улсад Гүйцэтгэх, Хууль тогтоох, Шүүх, Шалгалт (Examination) болон Хяналт (Control) гэсэн таван Юан бүхий Төв засгийн газрыг байгуулжээ.<sup>178</sup> (Зураг 1.)

Төв засгийн газрыг Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нар удирдана.

### Зураг 1. Төв Засгийн газрын бүтэц

Хятадын төрийн зүтгэлтэн, эмч, улс төрийн гүн ухаантан Сун Ят Сен<sup>179</sup> нь барууны уламжлалт эрх мэдлийн хуваарилалтын гурван салбар



дээр Хятадын эзэнт гүрний үеийн Шалгалтын Юан (Examination Yuan), Хяналтын Юан (Control Yuan) гэсэн хоёр салбарыг нэгтгэсэн эрх мэдлийн хосолсон загвар (hybrid model)-ыг хөгжүүлэхийг дэмжиж байжээ.<sup>180</sup>

### Хяналтын Юаны эрх зүйн орчин

Тайванийн Хяналтын Юаны эрх зүйн үндсийг Үндсэн хуулиар тогтоосон бөгөөд дараах хууль, журмаар нарийвчилсан харилцааг зохицуулна.<sup>181</sup> Үүнд:

- Хяналтын хууль (Control Act);
- Хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам (Enforcement Rules of the Control Act);
- Төрийн албан хаагчдын өмч хөрөнгө мэдүүлэх тухай хууль (Act on Property-Declaration by Public Servants);
- Төрийн албан хаагчдын өмч хөрөнгө мэдүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам (Enforcement Rules of the Act on Property-Declaration by Public Servants);

<sup>177</sup> Constitution of the Republic of China (Taiwan). Announced Date: 1947-01-01. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0000001>

<sup>178</sup> Government Portal of the Republic of China (Taiwan) - <https://www.taiwan.gov.tw>

<sup>179</sup> Сун Ят Сен (Sun Yat-sen) (1866-1925) - БНХАУ-ын анхны түр ерөнхийлөгч (1912 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл), Гоминдан (Хятадын үндэсний нам)-ы анхны удирдагч байсан.

<sup>180</sup> Chinese Constitutionalism: Five-Power Constitution. Ernest Caldwell. Max Planck Encyclopedia of Comparative Constitutional Law (Forthcoming 2017).

<sup>181</sup> <https://www.cy.gov.tw/en/News.aspx?n=256&sms=8939>

- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас төрийн албанаас хасах тухай хууль (Act on Recusal of Public Servants Due to Conflict of Interest);
- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас төрийн албанаас хасах тухай хуулийн хэрэгжилтийг хангах журам (Enforcement Rules of the Act on Recusal of Public Servants Due to Conflicts of Interest);
- Улс төрийн хандивын тухай хууль (Political Donations Act);
- Аудитын тухай хууль (Audit Act);
- Хяналтын Юаны тухай органик хууль (Organic Law of the Control Yuan);
- Хяналтын Юаны Хороодын тухай органик хууль (Organic Act of the Control Yuan Committees);
- Хяналтын Юаны Хүний эрхийн үндэсний комиссын тухай органик хууль (Organic Act of the Control Yuan National Human Rights Commission);
- Хяналтын Юанд иргэдээс бичгээр ирүүлсэн гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журам (Regulations for Receiving and Handling People’s Written Complaints Submitted by the Control Yuan);
- Хяналтын Юаны схемчилсэн хяналтыг зохицуулах журам (Regulations Governing Circuit Supervision by the Control Yuan).

### **Хяналтын Юаны бүрэлдэхүүн**

Хяналтын Юаны тухай органик хуулийн 3-1 дүгээр зүйлд зааснаар Хяналтын Юаны гишүүд нь 35 нас хүрсэн байх ба дараах шалгууруудын аль нэгийг хангасан байна. Үүнд:

1. хууль тогтоох байгууллагын гишүүнээр 1-ээс доошгүй удаа, эсхүл хотын тусгай зөвлөлийн гишүүнээр 2-оос доошгүй удаа нэр хүндтэй ажилласан байх;
2. 12-оос доошгүй түвшний шүүгч, прокуророор 10-аас доошгүй жил, эсхүл Дээд шүүх, Захиргааны хэргийн дээд шүүх, Дээд шүүхийн Прокурорын газар болон түүнээс дээш шатны шүүхийн шүүгч, прокуророор нэр хүндтэй ажилласан байх;
3. сонгосон зэрэглэл (Selected Rank)-д төрийн албан хаагчаар 10-аас доошгүй жил нэр хүндтэй ажилласан байх;
4. их сургуулийн профессороор 10-аас доошгүй жил нэр хүндтэй ажилласан байх;
5. дотоодын Мэргэжлийн болон Техникийн ахисан түвшний шалгалт (Professional and Technical Senior Examination)-д тэнцсэн, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил нэр хүндтэй ажилласан байх;
6. улс төрийн арвин туршлагатай, эсхүл сэтгүүл зүй, соёлын үйл ажиллагааг удирдаж байсан туршлагатай, нэр хүндтэй, шударга, ухамсартай хүн;

7. нэр хүндтэй, хүний эрхийг хамгаалах чиглэлийн судлаач, эсхүл хүний эрхийг хамгаалагч, эсхүл иргэний нийгмийн байгууллагад хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиллаж байсан туршлагатай хүн.

Дээрх жагсаалтын 7-д заасан шаардлага хангасан гишүүний тоо долоо байх ба сул орон тоо байх ёсгүй.

Хяналтын Юаны гишүүдийн бүрэлдэхүүн нь үндэстэн ястан, мэргэжлийн салбарын төлөөлөгчдийг багтаасан байна. Бүрэлдэхүүний хүйсийн тэгш байдлыг хангах үүднээс аль нэг хүйс нь 1/3-ээс доошгүй хувийг бүрдүүлнэ. Гишүүдийг нэр дэвшүүлэхээс өмнө иргэний нийгмийн байгууллагуудын саналыг нээлттэй авч үзнэ.

Үндсэн хуулийн 92 дугаар зүйлд зааснаар Хяналтын Юан нь гишүүдээсээ сонгосон Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчтэй байна. Хяналтын Юаны тухай органик хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Хяналтын Юаны Ерөнхийлөгч нь тус Юаны үйл ажиллагаанд болон харьяа агентлагуудад хяналт тавина.

### ***Тойргийн хяналт ба мөрдөн шалгалт***

Хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлд Хяналтын Юаны гишүүд төв болон орон нутгийн хэмжээнд тойргийн хяналтыг явуулна гэж заасан. Төвийн түвшинд тойргийн хяналтыг үйл ажиллагаатай нь хамаарал бүхий байнгын хороод, орон нутагт нь засаг захиргааны бүсээр нь ялгаж, багаар гүйцэтгэдэг.

Хяналт нь дараах салбаруудыг хамаарна.

1. Ерөнхий захиргаа, төсвийн гүйцэтгэл;
2. Төрийн бодлого, зохицуулалтын хэрэгжилт;
3. Төрийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах;
4. Хяналтын Юанаас үүрэг болгосон сайжруулах талаарх арга хэмжээний хэрэгжилт;
5. Ард түмний амьжиргаа, нийгмийн байдал;
6. Иргэдийн өргөдөл, гомдол, түүнтэй холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх.

### **Хяналтын Юаны бүтэц, зохион байгуулалт**

Хяналтын Юаны тухай органик хууль (Organic Law of the Control Yuan<sup>182</sup>)-д заасны дагуу Хяналтын Юан нь хороод, Хүний эрхийн үндэсний комисс,

<sup>182</sup> Organic Law of the Control Yuan. Promulgated on March 31, 1947. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0010071>

Үндэсний аудитын газар, дүүргүүд дэх хяналтын захиргааны албууд (district administrative offices)-ыг байгуулна.

Мөн Хяналтын Юан нь дараах нэгжийг байгуулна:

- Хяналтын үйл ажиллагааны газар (Department of Supervisory Operations);
- Мөрдөн шалгах газар (Department of Supervisory Investigation);
- Төрийн албан хаагчдын өмч хөрөнгийн мэдүүлгийн газар (Department of Property-Declaration by Public Servants);
- Тамгын газар (Secretariat);
- Зохицуулалт, төлөвлөлтийн газар (Department of Coordination and Planning).

Эдгээр нэгжүүд нь дараах асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд:

1. иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, боловсруулах, санал гаргахтай холбоотой асуудал;
2. хариуцлага тооцох асуудал;
3. мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой хамтран шалгах асуудал;
4. төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн улмаас төрийн албанаас хассан, улс төрийн хандив, лоббитой холбоотой асуудал;
5. хуралдааны тэмдэглэл хийх, олон нийтэд зориулсан тайланг эмхэтгэх, хэвлэх;
6. баримт бичиг хүлээн авах, олгох, тамга тэмдэг хадгалах, хэрэглэх;
7. төрийн сангийн болон ерөнхий үйл ажиллагаа;
8. цогц төлөвлөгөө боловсруулах, судалгаа, боловсруулалт, үнэлгээ хийх;
9. мэдээллийн төлөвлөгөө, систем, тоног төхөөрөмж, аюулгүй байдал, сургалтын ерөнхий төлөвлөлтийн менежменттэй холбоотой асуудал;
10. зохицуулалт, уялдаа холбоо, мэдээ мэдээлэлтэй холбоотой асуудал;
11. холбогдох бусад асуудал.

Мөн Хяналтын Юаны тухай органик хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Хяналтын Юан нь Нягтлан бодох бүртгэлийн алба, Статистикийн алба, Боловсон хүчний алба, Ёс зүйн албыг байгуулна. (Хавсралт 3.)

## Хяналтын Юаны нэгдсэн хуралдаан

Хяналтын Юаны нэгдсэн хуралдаан нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, гишүүдээс бүрдэх бөгөөд Ерөнхийлөгч сар бүр хуралдуулдаг. Нэгдсэн хуралдааныг Ерөнхийлөгч даргалах ба түүний эзгүйд Дэд Ерөнхийлөгч энэ үүргийг гүйцэтгэнэ. Хэрэв хоёулаа байхгүй бол хуралдаан даргалагчийг гишүүдээс сонгоно. Хяналтын Юаны нэгдсэн хуралдааны кворум нь гишүүдийн тал хувь байдаг.<sup>183</sup>

Хяналтын Юаны нэгдсэн хуралдаанд дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

- Хууль тогтоох Юанд өргөн мэдүүлэх хуулийн төсөл;
- Хяналтын Юаны эрх зүйн байдалтай холбоотой асуудал;
- төрийн захиргааны төв болон орон нутгийн төсөвт хийсэн аудитын тайлантай холбоотой асуудал;
- итгэл үзүүлэх эсэх (impeachment), хариуцлага тооцох болон аудит хийх бүрэн эрхийг сайжруулахтай холбоотой асуудал;
- зөрчил арилгах арга хэмжээг сайжруулахтай холбоотой асуудал;
- байнгын болон онцгой хороотой холбоотой асуудал;
- Хүний эрхийн үндэсний комисстой холбоотой асуудал;
- Юаны Ерөнхийлөгчийн тавьсан асуудал;
- Юаны гишүүдийн тавьсан асуудал болон бусад чухал асуудлууд.

## Хяналтын Юаны хороод

Үндсэн хуулийн 96 дугаар зүйл, Хяналтын Юаны хороодын органик хууль (Organic Act of the Control Yuan Committees)-ийн 2 дугаар зүйлд заасны дагуу Хяналтын Юан дараах 7 хороог байгуулсан.<sup>184</sup> Үүнд:

- Дотоод болон угсаатны асуудал эрхэлсэн хороо;
- Гадаад хэргийн болон үндэсний батлан хамгаалахын асуудал эрхэлсэн хороо;
- Нийгмийн хамгаалал, байгаль орчны эрүүл ахуйн асуудал эрхэлсэн хороо;
- Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн хороо;
- Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн хороо;
- Тээвэр, худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн хороо;
- Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудал эрхэлсэн хороо.

Хороод нь Хяналтын Юаны гишүүдээс бүрдэнэ. Гишүүн бүр гурваас илүүгүй хорооны бүрэлдэхүүнд орох ба бусад хороодод саналын эрхгүй гишүүнээр оролцож болно. Хороо нь 14 хүртэл гишүүнтэй байх бөгөөд дундаасаа хорооны даргыг сонгоно.

<sup>183</sup> <https://www.cy.gov.tw/en/cp.aspx?n=233>

<sup>184</sup> <https://www.cy.gov.tw/en/cp.aspx?n=235>

Хяналтын Юаны хороодын органик хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу Хяналтын Юан дараах 4 тусгай хороог байгуулав. Үүнд:


- Хууль зүйн судалгааны хороо;
- Зөвлөлдөх хороо;
- Юаны гишүүдийг хянах сахилгын хороо;
- Авлигатай тэмцэх хороо.

**Хяналтын Юаны эрх, үүрэг**

Хяналтын Юаны эрх, үүрэг<sup>185</sup>

- 1) Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх (Receipt of People’s Complaints);
- 2) Мөрдөн шалгах (Investigation);
- 3) Зөрчил арилгах арга хэмжээ (Corrective Measures);
- 4) Итгэл үзүүлэх эсэх (Impeachment);
- 5) Хариуцлага тооцох (Censure);
- 6) Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээх авах.

**Control Yuan Powers**



<sup>185</sup> <https://www.cy.gov.tw/en/cl.aspx?n=237>



## 1) Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх

Хяналтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд Хяналтын Юан болон түүний гишүүд иргэдээс бичгээр гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авна гэж заасан. Хяналтын тухай хуульд заасан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журмын дагуу гомдол гаргагч нь төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, зөрчилд гэм буруутайг нотлох баримт болон түүний жагсаалтыг Хяналтын Юан, эсхүл түүний гишүүдэд шууд мэдээлнэ.

Хяналтын Юан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах ажилтныг өдөр бүр ажиллуулна. Ажилтан нь бичгээр гаргасан өргөдөл, гомдолд дурдсан баримтыг үндэслэн холбогдох гишүүн болон байгууллагад шалгуулахаар шилжүүлэх, эсхүл зохих журмын дагуу шийдвэрлэнэ. Харин уг хэрэг нь Хяналтын Юанд хамаарахгүй бол гомдлыг хүлээн авахгүй. Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэсний дараа Хяналтын үйл ажиллагааны газар гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.

## 2) Мөрдөн шалгах

Хяналтын Юан нь хяналтын эрхээ хэрэгжүүлэхдээ БНХАУ-ын Үндсэн хуулийн 95 дугаар зүйлд заасны дагуу Гүйцэтгэх Юан, яам, зөвлөл, комиссоос гаргасан бүх тушаал шийдвэр, холбогдох баримт бичгийг хянах бүрэн эрхтэй. Хяналтын тухай хуулийн 26 дугаар зүйлд хяналтын тусгай зөвшөөрөлтэй Хяналтын Юаны гишүүн, эсхүл Хяналтын Юанаас томилогдсон ажилтан болон мөрдөн байцаалтын тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий ажилтан төрийн болон хувийн хэвшлийн байгууллага дээр очиж хавтаст хэрэг, холбогдох баримт бичигтэй танилцаж болно гэж заасан. Дээрх байгууллагын дарга, холбогдох бусад албан хаагчид шалгалт явуулахад татгалзах эрхгүй. Хяналтын Юан нь төрийн албан хаагчид болон захиргааны байгууллагын хууль бус үйлдэл, зөрчилд хариуцлага хүлээлгэх, буруутгах, засч сайжруулах талаар арга хэмжээ авах санал хүргүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, эсхүл захиргааны байгууллагын хууль бус үйлдлийг тогтоохын тулд заавал нотлох баримт шаардлагатай. Тиймээс үнэнийг илрүүлэх нь мөрдөн шалгалтын явцад буруутгах, яллах, засч сайжруулах арга хэмжээг санал болгох эрх мэдлийн үндэс болдог.

Хяналтын Юаны мөрдөн шалгалтыг гурван төрөлд хувааж болно:

- үүрэг болгосон мөрдөн шалгалт;
- томилсон мөрдөн шалгалт;
- өөрөө эхлүүлсэн мөрдөн шалгалт.

Үүрэг болгосон мөрдөн шалгалт нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шалгахыг холбогдох байгууллагуудад даатгадаг. Томилсон мөрдөн шалгалт нь Хяналтын Юан, эсхүл Хорооны тогтоолоор мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар гишүүдийг ээлжлэн (rotation) томилдог. Гишүүд иргэдийн өргөдөл, гомдол болон бусад мэдээллийн үндсэн дээр холбогдох байгууллагад бүртгүүлж, өөрийн санаачлагаар мөрдөн байцаалтын ажиллагаа эхлүүлэхийг өөрөө эхлүүлсэн мөрдөн шалгалт гэж нэрлэдэг. Хяналтын Юан нь томилсон болон өөрөө эхлүүлсэн мөрдөн шалгалтын ажиллагаанд туслах мөрдөн байцаагч томилно.



### 3) Зөрчил арилгах арга хэмжээ (Corrective Measures)

Хяналтын тухай хуулийн 24 дүгээр зүйлд Хяналтын Юан, Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагуудын ажил, үйлчилгээг шалгасны дараа холбогдох хорооны хурлаар хэлэлцэн баталж, засч сайжруулах арга хэмжээг Гүйцэтгэх Юан, эсхүл түүний харьяа байгууллагуудад арга хэмжээний саналыг хүргүүлнэ гэж заажээ. Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагууд саналыг хүлээн авсны дараа нэн даруй арга хэмжээ авч, Хяналтын Юанд бичгээр хариу өгнө.

Хэрэв арга хэмжээг хэрэгжүүлээгүй, эсхүл Хяналтын Юанд хоёр сарын дотор хариу ирүүлээгүй бол Хяналтын Юан холбогдох хорооны хурлаас гаргасан тогтоолоор тухайн байгууллагад бичгээр асуулга тавих, эсхүл эрх бүхий албан тушаалтныг дуудан байцаах үүрэгтэй.

#### **4) Итгэл үзүүлэх эсэх**

Хяналтын Юан нь төрийн төв болон орон нутгийн захиргааны албан хаагч албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан, хууль зөрчсөн гэж үзвэл хариуцлага тооцох хэрэг үүсгэнэ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хяналтын тухай хуульд зааснаар төрийн өндөр албан тушаалтанд итгэл үзүүлэх эсэх асуудлыг Хяналтын Юаны хоёроос доошгүй гишүүн санаачлах бөгөөд санаачлагчаас бусад 9-өөс доошгүй гишүүн шалган тогтооно. Шалгалтын дараа хэргийг Сахилгын шүүхэд шилжүүлнэ.

Хяналтын Юаны бүх гишүүд ээлжлэн итгэл үзүүлэх эсэх асуудлыг шалгах шалгалтын хороонд орно. Уг хэрэгт холбогдолгүй 13 гишүүн оролцоно. Хэрэв итгэл үзүүлэх эсэх асуудал нь шалгалтад тэнцээгүй, мөн хэрэг үүсгэсэн гишүүд огцруулах үндэслэлтэй байна гэж үзвэл тус хэргийг өөр 9 гишүүнээс бүрдсэн шалгалтын комисс дахин хянан үзэх бөгөөд тус шалгалтын комиссын шийдвэр эцсийнх байна.

Хэрэв албан хаагч албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан, хууль зөрчсөн үйлдэл нь нэн даруй арга хэмжээ авахуйц ноцтой бол тухайн этгээдийн дээд шатны байгууллагад хэргийг шилжүүлнэ. Хэрэв эрүүгийн хууль зөрчсөн бол холбогдох шүүхэд шилжүүлнэ.

Хяналтын Юаны Ерөнхийлөгч итгэл үзүүлэх эсэхийг шийдвэрлэх ажиллагааг удирдах бөгөөд хөндлөнгөөс оролцохгүй. Шалгалтын арга хэмжээ дуусахаас өмнө итгэл үзүүлэх эсэхтэй холбоотой хэргийг нууцлах бөгөөд шалгалтаар тогтоогдсоны дараа Хяналтын Юаны мэдэгдлийг олон нийтэд мэдээлнэ.

Сахилгын шүүх яллагдагчаас мэдүүлэг авсан бол мэдүүлгийг нэн даруй Хяналтын Юанд хүргүүлэх бөгөөд түүнийг итгэл үзүүлэх эсэх асуудлаар хэрэг үүсгэсэн гишүүдэд нэн даруй илгээнэ. Санаачлагч гишүүд мэдүүлэг хүлээн авснаас хойш арав хоногийн дотор Сахилгын шүүхэд саналаа хүргүүлнэ.

#### **5) Хариуцлага тооцох**

Хяналтын Юаны гишүүн төрийн албан хаагч албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан, хууль зөрчсөн болохыг тогтоосон бол түүнийг албан тушаалаас түдгэлзүүлэх, эсхүл нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл төрийн албан хаагчийн эсрэг бичгээр хариуцлага тооцох талаар бичиж болно. Хяналтын Юан нь уг хүсэлтийг гурав ба түүнээс дээш гишүүний бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх бөгөөд шийдвэрээ тухайн төрийн

албан хаагчийг хариуцсан албан тушаалтанд хүргүүлнэ. Энэ асуудал нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй бол эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар эрх бүхий шүүхэд шилжүүлнэ.

Бичгээр сануулга хүлээн авсан албан хаагч, түүний дарга нь нэг сарын дотор Төрийн албан хаагчийн сахилгын тухай хуульд заасан журмын дагуу зохих арга хэмжээ авна. (Эрүүгийн хууль, Зэвсэгт хүчний эрүүгийн хуультай холбоотой асуудлыг холбогдох хяналтын байгууллагууд нь шийдвэрлэдэг).

Удирдах албан тушаалтан нь сануулга авсан этгээдийг үүрэгт ажлаас нь түдгэлзүүлэх, эсхүл бусад арга хэмжээ авч болно. Хэрэв дээд албан тушаалтан нь ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагагүй гэж үзвэл тайлбараа Хяналтын Юанд хүргүүлнэ. Хэрэв удирдах албан тушаалтан нь хуулийн дагуу арга хэмжээ аваагүй, эсхүл Хяналтын Юаны хоёроос дээш гишүүн энэ үйлдлийг зохисгүй гэж үзвэл буруутгагдаж буй этгээдэд итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал гаргаж болно. Хэрэв итгэл үзүүлэх эсэх асуудал нь буруутгагдсан этгээдэд торгууль ногдуулахад хүрвэл, үүрэг хариуцлага алдсаны хариуцлагыг түүний дарга хүлээнэ.

## **6) Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээх авах**

Төрийн албан хаагчдын өмч хөрөнгө мэдүүлэх тухай хуулийн 2 дугаар зүйлд дараах албан тушаалтнууд хөрөнгө орлогын мэдүүлгээ Хяналтын Юанд тайлагнана.

- БНХАУ-ын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч;
- таван Юанын Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нар;
- улс төрийн томилогдсон албан тушаалтнууд;
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын орон тооны ахлах зөвлөх, үндэсний бодлогын зөвлөх, стратегийн зөвлөхүүд;
- Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан (12 дугаар түвшин буюу түүнээс дээш түвшин эсхүл түүнтэй адилтгах), төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтнууд, үндсэн болон салбар, харьяа төрийн байгууллагын дарга, дэд дарга, төрийн болон олон нийтэд томилогдсон шүүхийг төлөөлж буй дарга, зөвлөх нар;
- улсын коллежоос дээш боловсролын байгууллагын захирал, тэдгээрийн харьяа байгууллагын дарга нар;
- хошууч генералаас дээш зэрэглэлийн цэргийн ангиудын дарга нар;
- Төрийн албан хаагчдыг сонгох, эгүүлэн татах тухай хуулийн дагуу сонгогдсон суурин (хот)-аас дээш газрын төрийн байгууллагын дарга нар;

- бүх түвшний ард түмний төлөөлөл;
- дээд шатны (6-аас дээш түвшний) шүүгч, прокурор.

Мөн хуулийн 12 дугаар зүйлд зааснаар хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв тайлагнах ёстой албан тушаалтан санаатайгаар нуун дарагдуулсан бол 200.000-аас дөрвөн сая ам.доллар хүртэл торгууль ногдуулна. Хэрэв хөрөнгө орлогын мэдүүлгийн жилийн тайланг харьцуулан үзэхэд төрийн албан хаагч, түүний эхнэр, нөхөр, тэдний асрамжид байдаг хүүхдийн нийт орлого хоёр дахин нэмэгдсэн нь тогтоогдвол тухайн төрийн албан хаагчид нэг сарын хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгийн талаарх тайлбар гаргахыг зөвшөөрнө.

Дараах хууль тогтоомжоор зохицуулна:

- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас төрийн албанаас хасах тухай хууль (Act on Recusal of Public Functionaries Due to Conflicts of Interest);
- Өргөдлийн бүртгэлийг зохицуулах, өөрчлөх, эсхүл лобби хийх хэргүүдийг дуусгавар болгох тухай (Handling Registration for the Application, Change, or Termination of Lobbying Cases);
- Улс төрийн хандивын дансыг батлах, өөрчлөх, хаах, дансны бүртгэлийн мэдүүлгийг зохицуулах тухай (Handling the Approval, Change, and Closing Political Donation Accounts, and the Declaration of Account Records).

### **Аудитын үйл ажиллагаа**

Үндсэн хуулийн 90 дүгээр зүйл, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 7 дугаар зүйлд зааснаар аудитын эрх мэдэл нь хяналтын эрх мэдлийн нэг юм.

Хяналтын Юаны тухай органик хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Ерөнхий аудитор нь Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд хяналт тавина.

Үндсэн хуулийн 105 дугаар зүйлд Ерөнхий аудитор нь Төв засгийн газрын жилийн тайланг Гүйцэтгэх Юанд ирүүлснээс хойш 3 сарын дотор тайланд аудит хийж, аудитын тайлангаа Хууль тогтоох Юанд өргөн мэдүүлнэ.

Аудитын тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар аудитын эрх мэдэлд дараах асуудлууд хамаарна. Үүнд:

- төсвийн хэрэгжилтэд хяналт тавих;
- төлбөрийн баримт, төлбөрийн даалгаврыг баталгаажуулах;
- санхүүгийн үйл ажиллагааг шалгах;

- жилийн санхүүгийн тайланг баталгаажуулах;
- санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил, албан үүргийн биелэлтийг шалгах;
- санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх;
- санхүүгийн хариуцлагыг шүүх (to judge);
- бусад хуульд заасан аудитын бусад ажлыг гүйцэтгэх.

Аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу аудитор зөрчил, албан үүргээ биелүүлээгүйг илрүүлсэн бол холбогдох аудитын байгууллагад мэдэгдэнэ. Мөн шаардлагатай арга хэмжээ авахыг холбогдох байгууллагад мэдэгдэж, хуулийн дагуу арга хэмжээ авах талаар Хяналтын Юанд тайлагнана. Эрүүгийн гэмт хэргийн шинжтэй хэргийг шүүхэд шилжүүлж, Хяналтын Юанд мэдэгдэнэ.


Аудитын тухай хуульд аудиторуд ажил үүргээ бие даан, хөндлөнгийн оролцоогүйгээр гүйцэтгэх, аудитын байгууллага эрх, үүргээ хэрэгжүүлэхийн тулд аудиторудад төрөл бүрийн байгууллагад тогтмол болон түр хугацаагаар томилон ажиллуулж байхаар заасан. Аудитын байгууллага нь тухайн байгууллага руу аудиторудад томилоогүй тохиолдолд холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, санамсаргүй хяналт шалгалтад хамруулахыг шаардаж болно.

Аудитын байгууллага нь төрийн байгууллагын төлбөрийн баримт, санхүүгийн баримт, эд хөрөнгийг хүссэн үедээ шалгаж болно. Аудиторуд ном, эрхийн бичиг, бусад баримт бичиг, бэлэн мөнгө, эд хөрөнгөд үзлэг хийхийг шаардсан тохиолдолд тухайн байгууллагын хариуцсан ажилтан нь нуух, хүлээлгэн өгөхөөс татгалзах ёсгүй. Тэд аудитын асуултанд дэлгэрэнгүй хариулж, шаардлагатай бол холбогдох материалыг гаргаж өгнө.

Аудиторуд байгууллагын албан тушаалтнуудын санхүүгийн зөрчил, шударга бус үйлдэл илрүүлсэн тохиолдолд аудитын эрх бүхий байгууллагад мэдээлж, арга хэмжээ авах талаар байгууллагын даргад мэдэгдэнэ. Түүнчлэн хуулийн дагуу хэргийг хянан шийдвэрлэхийн тулд аудитын байгууллагаар дамжуулан Хяналтын Юанд тайлагнаж болно. Хэрэв хэрэг үйлдсэн бол шүүхийн байгууллагад шилжүүлж, Хяналтын Юанд мэдэгдэнэ.

Аудитын байгууллага нь үр ашиггүй, эсхүл чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа байгууллагыг илрүүлсэн бол тухайн байгууллагыг холбогдох хяналтын байгууллагад нь мэдэгдэхээс гадна Хяналтын Юанд мэдэгдэнэ. Хэрэв уг асуудал нь системийн зохицуулалтын дутагдал, эсхүл хүлээн зөвшөөрөгдөөгүй байгууламжаас шалтгаалсан бол сайжруулах тухай санал гаргах эрхтэй.

## Government Accountability System



Source: NAO 2020 Annual Report, p.13

### Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагаа

Хяналтын Юаны Хүний эрхийн үндэсний комиссын тухай органик хууль (Organic Act of the Control Yuan National Human Rights Commission)-ийн 2 дугаар зүйлд заасны дагуу Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК) дараах чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- эрүү шүүлт, хүний эрхийг зөрчих, ялгаварлан гадуурхах зэрэг янз бүрийн хэлбэрээр гарсан зөрчлийг өөрийн эрх мэдлийн дагуу буюу олон нийтээс ирүүлсэн өргөдлийн дагуу шалгах, хуулийн дагуу шийдвэрлэж арилгах;
- хүний эрхийн талаарх үндэсний бодлогыг судлах, дүгнэлт, зөвлөмж гаргах;
- хүний эрхийн дотоодын нөхцөл байдлыг судалж, үнэлэх зорилгоор хүний эрхийн гол асуудлаар сэдэвчилсэн илтгэл, эсхүл хүний эрхийн байдлын талаарх жилийн тайланг гаргах;



- хүний эрхийн олон улсын баримт бичигт гарын үсэг зурах, соёрхон батлах, тэдгээрийг нэгтгэхэд төрийн байгууллагуудад туслалцаа үзүүлэх, дотоодын хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, захиргааны арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн хангах;
- Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахад шаардлагатай, хэрэгжих боломжтой зөвлөмж гаргах зорилгоор Үндсэн хууль, эрх зүйн актуудыг хүний эрхийн олон улсын жишигт тулгуурлан системчилсэн судалгаа хийх;
- хүний эрхийн боловсролыг дэмжих, хүний эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийн асуудалд төрийн байгууллагуудын үр нөлөөг хянах;
- хүний эрхийг хамгаалах чиглэлээр дотоодын байгууллага, олон нийтийн бүлгүүд, олон улсын байгууллага, хүний эрхийн үндэсний хүрээлэн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;
- хүний эрхийн олон улсын гэрээний заалтын дагуу Засгийн газраас өргөн мэдүүлсэн үндэсний тайланд бие даасан дүгнэлт гаргах;
- хүний эрхийг хамгаалах, дэмжихтэй холбогдсон бусад асуудал.

ХЭҮК нь Хяналтын Юаны Ерөнхийлөгчийн хамт 10 гишүүнээс бүрдэнэ. Хяналтын Юаны тухай органик хуулийн 3-1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан “нэр хүндтэй хүний эрхийг хамгаалах чиглэлийн судлаач, эсхүл хүний эрхийг хамгаалагч, эсхүл иргэний нийгмийн байгууллагад хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиллаж байсан туршлагатай” гишүүний тоо 7 байна.

ХЭҮК-ыг Хяналтын Юаны Ерөнхийлөгч удирдах ба дэд даргыг ХЭҮК-ын гишүүдээс сонгодог.

## ХАВСРАЛТУУД

### Албан бус орчуулга

#### **Хавсралт 1. Тайванийн Үндсэн хуулийн Хяналтын Юантай холбоотой зохицуулалт**

**60 дугаар зүйл.** Гүйцэтгэх Юан (Executive Yuan) санхүүгийн жил бүр дууссанаас хойш дөрвөн сарын дотор орлого, зарлагын эцсийн тайлангаа Хяналтын Юанд танилцуулна.

**79 дүгээр зүйл.** Шүүх Юан (Judicial Yuan) нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчтэй байх ба тэднийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Хяналтын Юанын зөвшөөрснөөр томилно.

Шүүх Юан энэ Үндсэн хуулийн 78 дугаар зүйлд заасан асуудлыг хариуцах тодорхой тооны шүүгчтэй байх бөгөөд шүүгчдийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Хяналтын Юанын зөвшөөрснөөр томилно.

**84 дүгээр зүйл.** Шалгалтын Юан (Examination Yuan) нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, тодорхой тооны гишүүдтэй байх ба тэднийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Хяналтын Юанын зөвшөөрснөөр томилно.

**115 дугаар зүйл.** Хэрэв Мужийн өөрөө удирдах ёсны дүрэм (the Provincial Self-Government Regulations)-ийг хэрэгжүүлэх явцад түүнд тусгагдсан аливаа заалтыг хэрэгжүүлэхэд ноцтой саад бэрхшээл тулгарвал Шүүхийн Юан эхлээд холбогдох талуудыг дуудаж санал бодлоо илэрхийлнэ. Үүний дараа Гүйцэтгэх Юан, Хууль тогтоох Юан, Шүүх Юан, Шалгалтын Юан, Хяналтын Юанын Ерөнхийлөгч нар Шүүх Юанын Ерөнхийлөгчөөр удирдуулсан хороо байгуулж, уг асуудлыг шийдвэрлэх томъёолол санал болгоно.

## IX БҮЛЭГ. ХЯНАЛТ

**90 дүгээр зүйл.** Хяналтын Юан (Control Yuan – хяналтын эрх мэдэл) нь төрийн хяналтын эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага ба зөрчил арилгах арга хэмжээ авах, итгэл үзүүлэх эсэх, хариуцлага тооцох, аудит хийх эрх мэдлийг хэрэгжүүлнэ.

**91 дүгээр зүйл.** Хяналтын Юаныг аймгийн болон хотын зөвлөл, Монголын болон Төвдийн орон нутгийн зөвлөл (the local Councils of Mongolia and Tibet), мөн гадаад улсад оршин суугаа Бүгд Найрамдах Хятад Улс (БНХУ, Republic of China)-ын иргэдээс сонгосон гишүүдээс бүрдэнэ. Гишүүдийн тоог дараах байдлаар тогтооно:

1. аймаг тус бүрээс таван гишүүн;
2. Гүйцэтгэх Юан (Executive Yuan – гүйцэтгэх эрх мэдэл)-д шууд харьяалагддаг хот тус бүрээс хоёр гишүүн;
3. Монголын хошуу болон аймаг (Mongolian Leagues and Banners)-аас найман гишүүн;
4. Төвдөөс найман гишүүн;
5. гадаад улсад оршин суугаа БНХУ-ын иргэдээс найман гишүүн.

**92 дугаар зүйл.** Хяналтын Юан нь гишүүдээсээ сонгосон Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчтэй байна.

**93 дугаар зүйл.** Хяналтын Юаны гишүүн зургаан жилийн хугацаатай сонгогдох ба дахин сонгогдож болно.

**94 дүгээр зүйл.** Хяналтын Юан нь энэхүү Үндсэн хуульд заасны дагуу зөрчил арилгах арга хэмжээ авах эрхээ хэрэгжүүлэхдээ хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор шийдвэрлэнэ.

**95 дугаар зүйл.** Хяналтын Юан нь хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Гүйцэтгэх Юан, түүний яамд болон хороодоос гаргасан тушаалын эх хувь болон холбогдох бусад бүх баримт бичгийг авахаар шаардаж болно.

**96 дугаар зүйл.** Хяналтын Юан нь Гүйцэтгэх Юан, түүний яамд болон хороодын үйл ажиллагааны хүрээг харгалзан, тэдний хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэм буруутай эсэхийг тогтоох зорилгоор тэдний үйл ажиллагааг мөрдөн шалгахын тулд хороо байгуулж болно.

**97 дугаар зүйл.** Хяналтын Юан нь өөрийн хороодын мөрдөн шалгалт, шийдвэрийн үндсэн дээр зөрчил арилгах арга хэмжээний саналыг Гүйцэтгэх Юан, холбогдох яамд болон хороодод хүргүүлэх ба сайжруулахад чиглэсэн арга хэмжээнд хяналт тавьж болно. Хяналтын Юан нь Төв Засгийн газар, эсхүл орон нутгийн засаг захиргааны төрийн албан хаагчийг хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэм буруутай гэж үзвэл зөрчил арилгах арга хэмжээ авах, эсхүл итгэл үзүүлэх эсэх талаар санал гаргаж болно. Хэрэв эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол уг хэргийг шүүхэд шилжүүлнэ.

**98 дугаар зүйл.** Төв Засгийн газар, эсхүл орон нутгийн засаг захиргааны төрийн албан хаагчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг Хяналтын Юаны есөөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй хорооны нэг буюу түүнээс дээш гишүүн санал болгож, журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэсний үндсэн дээр Хяналтын Юан хэлэлцэнэ.

**99 дүгээр зүйл.** Хяналтын Юанаас Шүүхийн Юан (Judicial Yuan) болон Шалгалтын Юан (Examination Yuan)-ын албан хаагчдыг хууль зөрчсөн, эсхүл албан үүрэгтээ хайхрамжгүй хандсан гэх үндэслэлээр итгэл үзүүлээгүй бол энэхүү Үндсэн хуулийн 95, 97, 98 дугаар зүйлд заасан заалтыг мөрдөнө.

**100 дугаар зүйл.** Хяналтын Юанд Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг Хяналтын Юаны бүх гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь санал болгож, журмын дагуу хэлэлцсэний дараа олонхын саналаар шийдвэрлэнэ. Хяналтын Юаны нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ.

**101 дүгээр зүйл.** Хяналтын Юаны гишүүн Юанд хэлсэн үг, өгсөн саналын хариуцлагыг Юанаас гадуур хүлээхгүй.

**102 дугаар зүйл.** Хяналтын Юаны гишүүнийг гэмт хэргийн газарт баривчлахаас бусад тохиолдолд Хяналтын Юаны зөвшөөрөлгүйгээр баривчлах, эсхүл албадан саатуулахыг хориглоно.

**103 дугаар зүйл.** Хяналтын Юаны гишүүн төрийн албанд, эсхүл өөр мэргэжлээр хавсран ажиллаж болохгүй.

**104 дүгээр зүйл.** Хяналтын Юан нь Ерөнхий аудитортай байх ба түүнийг Хууль тогтоох Юан (Legislative Yuan)-ын зөвшөөрснөөр Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилно.

**105 дугаар зүйл.** Ерөнхий аудитор нь Гүйцэтгэх Юанаас орлого, зарлагын эцсийн тайланг ирүүлснээс хойш гурван сарын дотор хуульд заасан журмын дагуу аудит хийж, тайланг Хууль тогтоох Юанд хүргүүлнэ.

**106 дугаар зүйл.** Хяналтын Юаны зохион байгуулалтыг хуулиар тогтооно.

Албан бус орчуулга**Хавсралт 2. Тайванийн Хяналтын Юаны тухай хууль**

**1 дүгээр зүйл.** Энэ хуулийг Үндсэн хуулийн 106 дугаар зүйлд заасны дагуу баталсан.

**2 дугаар зүйл.** Хяналтын Юан нь Үндсэн хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

**3 дугаар зүйл.** Хяналтын Юан нь тусдаа хороод байгуулж болох бөгөөд тэдгээрийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

Хяналтын Юан нь Хүний эрхийн үндэсний комиссыг байгуулах бөгөөд түүний эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

**3-1 дүгээр зүйл.** Хяналтын Юаны гишүүд нь 35-аас доошгүй настай байх ба дор дурдсан шалгууруудын аль нэгийг хангасан байна:

- 1) хууль тогтоох байгууллагын гишүүнээр 1-ээс доошгүй удаа, эсхүл хотын тусгай зөвлөлийн гишүүнээр 2-оос доошгүй удаа сонгогдож, нэр хүндтэй ажиллаж байсан;
- 2) 12-оос доошгүй түвшний шүүгч, прокуророор 10-аас доошгүй жил, мөн Дээд шүүх, Захиргааны хэргийн дээд шүүх, Дээд шүүхийн Прокурорын газар болон түүнээс дээш шатны шүүхийн шүүгч, прокуророор нэр хүндтэй ажиллаж байсан;
- 3) Сонгогдсон зэрэг (Selected Rank)-т төрийн албан хаагчаар 10-аас доошгүй жил нэр хүндтэй ажиллаж байсан;
- 4) их сургуулийн профессороор 10-аас доошгүй жил нэр хүндтэй ажиллаж байсан;
- 5) дотоодын Мэргэжлийн болон Техникийн ахисан түвшний шалгалт (Professional and Technical Senior Examination)-ын дагуу мэргэшсэн, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил нэр хүндтэй ажиллаж байсан;
- 6) улс төрийн арвин туршлагатай, эсхүл сэтгүүл зүй, соёлын үйл ажиллагааг удирдаж байсан туршлагатай, нэр хүндтэй, шударга, ухамсартай хүн;
- 7) нэр хүндтэй хүний эрхийг хамгаалах чиглэлийн судлаач, эсхүл хүний эрхийг хамгаалагч, эсхүл иргэний нийгмийн байгууллагад хүний эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиллаж байсан туршлагатай хүн.

Дээрх жагсаалтын 7-д заасан шаардлагыг хангасан гишүүний тоо долоо байх ба сул орон тоо байх ёсгүй. Хяналтын Юаны бүрэлдэхүүн нь өөр үндэстэн ястан, мэргэжил зэрэг олон талын төлөөллийг багтаасан

байна. Аль нэг хүйсийн төлөөлөл гишүүдийн гуравны нэгээс бага хувийг эзлэх ёсгүй. Гишүүнд нэр дэвшүүлэхээс өмнө иргэний нийгмийн байгууллагуудын саналыг нээлттэй авна.

Дээрх жагсаалтын 1-т заасан албан тушаал хашсан хугацааг Хяналтын Юаны гишүүний дараагийн хугацаа эхлэхийн өмнөх өдөр хүртэл тооцно.

**4 дүгээр зүйл.** Хяналтын Юан нь дараах асуудлуудыг хариуцах Үндэсний аудитын газрыг байгуулна:

- 1) Засгийн газрын бүх шатны төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;
- 2) төрийн бүх шатны байгууллагын орлого, төлбөрийн даалгаврыг баталгаажуулах;
- 3) Засгийн газрын бүх шатны байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг шалгах, жилийн санхүүгийн тайланг баталгаажуулах;
- 4) төрийн бүх шатны байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хууль бус байдал, албан үүргийн хариуцлагаа алдсан байдлыг шалгах;
- 5) Засгийн газрын бүх шатны байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх;
- 6) төрийн байгууллагын ажилтны санхүүгийн үүрэг хариуцлагыг батлах;
- 7) бусад хуульд заасан аудитын бусад чиг үүргийг гүйцэтгэх.

Үндэсний аудитын газрын эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

**5 дугаар зүйл.** Ерөнхий аудитор нь Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд хяналт тавина.

**6 дугаар зүйл.** Хяналтын Юаны Ерөнхийлөгч нь Юаны үйл ажиллагаанд болон харьяа агентлагуудад хяналт тавина. Хэрэв Ерөнхийлөгч ямар нэг шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон бол Дэд Ерөнхийлөгч түүний нэрийн өмнөөс гүйцэтгэнэ.

Хэрэв Хяналтын Юаны Ерөнхийлөгчийн орон сул байгаа бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь дараагийн Ерөнхийлөгчийг нэр дэвшүүлж, Хууль тогтоох Юан (Legislative Yuan)-ы зөвшөөрснөөр томилох хүртэл Дэд Ерөнхийлөгч уг албан үүргийг орлон гүйцэтгэнэ.

Хэрэв Хяналтын Юаны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийн орон нэгэн зэрэг сул байгаа бол Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь тэднийг нэр дэвшүүлж, Хууль тогтоох Юан (Legislative Yuan)-ы зөвшөөрснөөр томилох хүртэл Хяналтын Юаны нэг гишүүнийг орлон гүйцэтгэгчээр томилно.

Хэрэв Хяналтын Юаны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, гишүүний орон сул байгаа бол тэдний залгамжлагчдын бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

**7 дугаар зүйл.** Хяналтын Юаны хуралдааныг Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Хяналтын Юаны гишүүд зохион байгуулах ба Ерөнхийлөгч хуралдааныг даргална.

**8 дугаар зүйл.** Хяналтын Юан нь бодит хэрэгцээнд нийцүүлэн Хяналтын Юаны гишүүдэд зориулсан дүүргийн захиргааны албыг улсын хэмжээнд байгуулж болно. Тэдгээрийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

**9 дүгээр зүйл.** Хяналтын Юан нь Юаны Ерөнхийлөгчийн зарлигаар Юаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, ажилтнуудыг удирдан чиглүүлэх/хянах үүрэгтэй тусгайлан томилогдсон ерөнхий нарийн бичгийн даргатай байна. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Юаны Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон Сонгогдсон зэрэг (the Selected Rank)-ийн 14 дүгээр түвшний нэг орлогчтой байна.

**10 дугаар зүйл.** Хяналтын Юан нь дор дурдсан асуудлуудыг хариуцах Хяналтын үйл ажиллагааны газар, Мөрдөн шалгах газар, Төрийн албан хаагчдын өмч хөрөнгийн мэдүүлгийн газар, Тамгын газар, Зохицуулалт, төлөвлөлтийн газрыг байгуулна. Газар бүр хэлтэс, эсхүл хэсгүүдэд хуваагдаж болно:

- 1) иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, боловсруулах, санал гаргахтай холбоотой асуудал;
- 2) хариуцлага тооцох асуудал;
- 3) хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа;
- 4) төрийн албан хаагчдын эд хөрөнгийн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн улмаас эргүүлэн татах, улс төрийн хандив, лоббитой холбоотой асуудал;
- 5) хуралдааны тэмдэглэл хөтлөх, олон нийтэд зориулсан тайланг эмхэтгэн хэвлэхтэй холбоотой асуудал;
- 6) баримт бичиг хүлээн авах, олгох, тамга тэмдэг хадгалахтай холбоотой асуудал;
- 7) улсын төсөв болон үйл ажиллагаатай холбоотой ерөнхий асуудал;
- 8) нэгдсэн төлөвлөгөө, судалгаа боловсруулах, хөгжүүлэх, үнэлгээ хийх асуудал;
- 9) мэдээллийн төлөвлөлт, систем, тоног төхөөрөмж, аюулгүй байдал, сургалтын ерөнхий төлөвлөгөө болон удирдлагатай холбоотой асуудал;
- 10) зохицуулалт, харилцаа холбоо, мэдээ мэдээлэлтэй холбоотой асуудал;
- 11) холбогдох бусад асуудал.



**11 дүгээр зүйл.** (Хүчингүй болсон)

**12 дугаар зүйл.** Хяналтын Юан нь Сонгогдсон зэрэг (the Selected Rank)-ийн 12-13 дугаар түвшний хоёроос дөрвөн зөвлөх, таван хэлтсийн дарга; Сонгогдсон зэргийн 11-12 дугаар түвшний хэлтсийн даргын таван орлогч; Сонгогдсон зэргийн 10-12 дугаар түвшний 24-28 мөрдөн байцаагч; мөрдөн байцаагчийн албан үүргийг хавсран гүйцэтгэх мөрдөн байцаах хэсгийн найман дарга; Сонгогдсон зэргийн 10-11 дүгээр түвшний Гомдол хүлээн авах төв (Complaint Receipt Center)-ийн нэг дарга, 11 хэсгийн ахлагч, дөрвөн ахлах мэргэжилтэн, нэг системийн ахлах шинжээч; Дэвшүүлэн томилсон зэрэг (the Recommended Rank)-ийн 8-9 дүгээр түвшний 26-31 нарийн бичгийн дарга, тэдний 11 нь Сонгогдсон зэргийн 10-12 дугаар түвшнийх байж болно; Дэвшүүлэн томилсон зэргийн 9 дүгээр түвшний 11 хэсгийн ахлагч; Дэвшүүлэн томилсон зэргийн 8-9 дүгээр түвшний 24-28 ахлах мөрдөн байцаагч; Дэвшүүлэн томилсон зэргийн 7-9 дүгээр түвшний 10-16 мэргэжилтэн, хоёр системийн шинжээч; Дэвшүүлэн томилсон зэргийн 6-8 дугаар түвшний хоёр системийн дизайнер, нэг системийн зохицуулагч; Томилогдсон зэрэг (Designated Rank)-ийн 5 дугаар түвшний, эсхүл Дэвшүүлэн томилсон зэргийн 6-7 дугаар түвшний 24-28 мөрдөн байцаагч, 20-28 алба хаагч, 2-4 стенографич; Томилогдсон зэргийн 4-5 дугаар түвшний дөрвөөс найман туслах албан хаагч, хоёр оператор, тэдний дөрвөн туслах албан хаагч, нэг оператор нь Дэвшүүлэн томилсон зэргийн 6 дугаар түвшнийх байж болно; Томилогдсон зэргийн 3-5 дугаар түвшний 10-18 бичиг хэргийн ажилтан; Томилогдсон зэргийн 1-3 дугаар түвшний долоон туслах ажилтан; Эмнэлгийн ажилтны Гуравдугаар зэргийн нэг эм зүйч, хоёр сувилагчтай байна.

**13 дугаар зүйл.** Хяналтын Юан нь хуулийн дагуу төсөв, нягтлан бодох бүртгэл, статистик, хүний нөөц, ёс зүйн асуудлаарх чиг үүргийг гүйцэтгэх Нягтлан бодох бүртгэлийн алба, Статистикийн алба, Боловсон хүчний алба, Ёс зүйн албыг тус тус байгуулна.

Нягтлан бодох бүртгэлийн алба, Статистикийн алба, Боловсон хүчний алба, Ёс зүйн алба тус бүр Сонгогдсон зэргийн 10-11 дүгээр түвшний нэг захиралтай байна. Шаардлагатай бол хуульд заасан квотын хүрээнд албан хаагчдыг нэмж томилж болно.

**13-1 дүгээр зүйл.** Хяналтын Юаны гишүүн бүр сонгогдсон хугацаатайгаа ижил хугацаанд нэг туслах томилно.

**14 дүгээр зүйл.** Хяналтын Юаны хуралдааны болон Хяналтын хэлтсийн ажлын журмыг Хяналтын Юан тогтооно.

**15 дугаар зүйл.** Энэ хуулийг нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн заалтуудыг нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Албан бус орчуулга**Хавсралт 3. Тайванийн Хяналтын тухай хууль<sup>186</sup>****I БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.** Хяналтын Юан (Control Yuan – хяналтын эрх мэдэл) нь Үндсэн хууль болон Үндсэн хуулийн нэмэлт заалт (Additional Articles of the Constitution)-д заасны дагуу итгэл үзүүлэх эсэх (impeachment), хариуцлага тооцох, аудит хийх бүрэн эрхийг хэрэгжүүлэх ба зөрчил арилгах арга хэмжээ санал болгоно. Аудитаас бусад бүрэн эрхийг энэ хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

**2 дугаар зүйл.** Хяналтын Юаны гишүүн нь итгэл үзүүлэх эсэх, хариуцлага тооцох эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Хяналтын Юаны хороод нь зөрчил арилгах арга хэмжээг санал болгоно.

**3 дугаар зүйл.** Хяналтын Юаны гишүүд бүхий л нутаг дэвсгэрт аливаа салбар чиглэлээр хяналт тавьж болно.

**4 дүгээр зүйл.** Хяналтын Юан болон түүний гишүүд иргэдээс гомдлыг бичгээр хүлээн авч болно. Хяналтын Юан энэ талаар журам тогтооно.

**II БҮЛЭГ. ИТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЭСЭХ**

**5 дугаар зүйл.** (Хүчингүй болсон)

**6 дугаар зүйл.** Хяналтын Юаны хоёроос доошгүй гишүүн санал болгосноор Хяналтын Юаны гишүүд хууль зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд төрийн албан хаагчид хариуцлага тооцно.

**7 дугаар зүйл.** Итгэл үзүүлэх эсэх асуудлыг бичгээр дэлгэрэнгүй санал болгоно. Санал гаргасан гишүүд уг асуудлыг хянан шалгах аас өмнө нэмэлт мэдээлэл хийж болно.

**8 дугаар зүйл.** Санал гаргасан гишүүдийг оролцуулахгүйгээр ес буюу түүнээс дээш гишүүн хянан шалгаад хариуцлага тооцох ёстой гэж үзвэл Хяналтын Юан уг асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий сахилгын байгууллага (disciplinary organ)-д шилжүүлнэ. Хэрэв шинэ баримт, эсхүл нотлох баримт илэрсэн бол түүнийг хянан шалгасны дараа сахилгын байгууллагад шилжүүлнэ.

Итгэл үзүүлэх эсэх асуудлын талаарх шалгалтын хорооны шийдвэрийг гарын үсэг зурж санал хураах ба олонхын саналаар шийдвэрлэнэ.

<sup>186</sup> Control Act. Announced Date: 1947-01-01. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0030199>

**9 дүгээр зүйл.** Итгэл үзүүлэх эсэх асуудлаар хянан шалгах ажлыг Хяналтын Юаны бүх гишүүд ээлжлэн явуулна.

**10 дугаар зүйл.** Хэрэв хянан шалгах явцад итгэл үзүүлэх эсэх хэрэг нь үндэслэлгүй гэж үзэж, санал гаргасан гишүүд энэ шийдвэрийг эсэргүүцсэн бол уг асуудлыг эцэслэн шийдвэрлэхийн тулд Хяналтын Юаны бусад ес буюу түүнээс дээш гишүүн дахин хянан шалгана.

**11 дүгээр зүйл.** Итгэл үзүүлэх эсэх хэрэгт оролцсон Хяналтын Юаны гишүүд уг хэргийг хэлэлцэхэд оролцохгүй.

**12 дугаар зүйл.** Хяналтын Юаны Ерөнхийлөгч нь аливаа тохиолдолд итгэл үзүүлэх эсэх асуудалд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцохгүй.

**13 дугаар зүйл.** Хяналтын Юаны гишүүд болон түүний ажилтнууд хяналт шалгалтын дүгнэлт гарахаас өмнө итгэл үзүүлэх эсэх асуудлын талаар олон нийтэд мэдээлэхгүй.

Хяналтын Юан нь итгэл үзүүлэх эсэх хэргийн хяналт шалгалтын дүгнэлтийг олон нийтэд мэдээлнэ. Хэрэв уг хэрэг нь үндэсний аюулгүй байдал, дипломат харилцаа, эсхүл хуулиар нууцад хамруулсан бусад салбартай холбоотой бол уг нууц мэдээллийг хянан засварласны дараа олон нийтэд мэдээлнэ.

**14 дүгээр зүйл.** Хяналтын Юан итгэл үзүүлэх эсэх хэргийг сахилгын байгууллагад шилжүүлэх үед тухайн хэрэг нь хууль зөрчсөн, эсхүл албан үүргээ биелүүлээгүйн улмаас нэн даруй зөрчил арилгах арга хэмжээ авахаар хангалттай ноцтой гэж үзвэл, Хяналтын Юанаас гэм буруутай этгээдийн удирдах албан тушаалтан, эсхүл зөрчил арилгах арга хэмжээ авах эрх бүхий албан тушаалтанд тухайн зөрчлийг арилгах арга хэмжээ нэн даруй авахыг мэдэгдэнэ.

Удирдах албан тушаалтан нь ийнхүү мэдэгдэл авсан боловч гэм буруутай этгээдэд зохих хариуцлага тооцоогүй бол түүнийг албан үүргээ биелүүлээгүй гэм буруутайд тооцно.

**15 дугаар зүйл.** Хэрэв Хяналтын Юан итгэл үзүүлэх эсэхийг нь хөндсөн төрийн албан хаагчийг эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзвэл, Хяналтын Юан уг хэргийг сахилгын байгууллагад шилжүүлэхээс гадна эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхэд хуулийн дагуу арга хэмжээ авахуулахаар шилжүүлнэ.

**16 дугаар зүйл.** Итгэл үзүүлэх эсэх хэргийг сахилгын байгууллага болон ерөнхий харьяаллын шүүх, эсхүл цэргийн шүүхэд шилжүүлсэн бол эрх бүхий байгууллагууд яаралтай арга хэмжээ авч, авсан арга хэмжээний талаар Хяналтын Юанаар дамжуулан санал гаргасан гишүүдэд нэн даруй мэдэгдэнэ.

Итгэл үзүүлэх эсэхийг нь хөндсөн төрийн албан хаагчийг өмгөөлсөн аливаа мэдэгдлийг Хяналтын Юанаар дамжуулан санал гаргасан гишүүдэд нэн даруй хүргүүлнэ. Санал гаргасан гишүүд мэдэгдэл хүлээн авснаас хойш арав хоногийн дотор санал, дүгнэлтээ сахилгын байгууллагад хүргүүлж болно.

**17 дугаар зүйл.** (Хүчингүй болсон)

**18 дугаар зүйл.** Итгэл үзүүлэх эсэхээс болж хариуцлага хүлээсэн этгээд албан үүргээс нь түдгэлзүүлсэн хугацаанд төрийн аливаа байгууллагад ажилд орохыг хориглоно.

Хариуцлага тооцох тухай шийдвэр гарснаар тухайн этгээдийн хууль ёсны урамшуулал нь хариуцлага хүлээх хугацаанд хүчингүй болно. Хэрэв тухайн этгээд сануулах арга хэмжээ авсан бол түүний урамшуулал нь хүчинтэй хэвээр байна.

### III БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА ТООЦОХ

**19 дүгээр зүйл.** Хяналтын Юаны гишүүн нь төрийн албан хаагчийг хууль зөрчсөн, эсхүл албан үүргээ биелүүлээгүйн улмаас албан үүргээс нь түдгэлзүүлэх, эсхүл нэн даруй зөрчил арилгах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн бол хариуцлага тооцож болох ба үүнийг Хяналтын Юаны бусад гурав буюу түүнээс дээш гишүүн хянан шийдвэрлэнэ. Хяналтын Юан хариуцлага тооцох хэргийг тухайн төрийн албан хаагчийн удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтанд илгээнэ. Хэрэв уг хэрэг нь эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомж зөрчсөн гэж үзвэл уг хэргийг эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхэд шилжүүлнэ.

Хяналтын Юаны гишүүн нь өөрийн хянах үүрэгтэй албан тушаалын зэргээс доогуур төрийн албан хаагчид хариуцлага тооцох хэргийг бичгээр хүргүүлэх бол тухайн албан тушаалтны удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

**20 дугаар зүйл.** Хэрэв хариуцлага тооцох хэргийг үндэслэлгүй гэж үзэж, санал гаргасан гишүүд энэ шийдвэртэй санал нийлэхгүй бол Хяналтын Юаны бусад гурав буюу түүнээс дээш гишүүн дахин хянан шалгаж эцсийн шийдвэрийг гаргана.

**21 дүгээр зүйл.** Эрх бүхий шүүх, эсхүл цэргийн шүүхээр тусад нь хянан шийдвэрлэх эрүүгийн, эсхүл цэргийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой хэргээс бусад тохиолдолд төрийн албан хаагчид хариуцлага тооцохыг эсэргүүцсэний дараа түүний удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулах тухай хууль (Law of Discipline Against Public Functionaries)-ийн

дагуу нэг сарын дотор уг хэргийг авч хэлэлцэнэ. Тэрээр хариуцлага тооцуулсан албан тушаалтныг албан үүргээс нь түдгэлзүүлж болно. Хэрэв удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь тухайн этгээдэд хариуцлага тооцох шаардлагагүй гэж үзвэл үндэслэлээ Хяналтын Юанд мэдэгдэнэ.

**22 дугаар зүйл.** Удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтан нь өмнөх зүйлд заасны дагуу хариуцлага тооцсон хэргийг авч хэлэлцээгүй, эсхүл авсан арга хэмжээг нь Хяналтын Юаны хоёр буюу түүнээс дээш гишүүн тохирохгүй гэж үзсэн бол хариуцлага тооцуулсан төрийн албан хаагчид итгэл үзүүлэх эсэх асуудлыг хөндөнө.

Хариуцлага тооцуулсан төрийн албан хаагчийн удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтан хариуцлага тооцсон тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш түүнд хариуцлага тооцоогүй, эсхүл хариуцлага тооцохгүй гэж шийдвэрлэсэн бол хариуцлага тооцуулсан төрийн албан хаагчид итгэл үзүүлэхгүй байх, удирдах, эсхүл эрх бүхий албан тушаалтанд албан үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр тус тус хариуцлага тооцно.

**23 дугаар зүйл.** Хариуцлага тооцсон хэрэгт энэ хуулийн 8, 11, 12, 13, 16 дугаар зүйлийг зайлшгүй өөрчлөлтүүдтэй хэрэглэнэ.

#### **IV БҮЛЭГ. ЗӨРЧИЛ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ**

**24 дүгээр зүйл.** Хяналтын Юан нь Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагуудын ажил, чадавхыг мөрдөн шалгасны дараа холбогдох хороод зөрчил арилгах арга хэмжээнүүдийг хянан шалгаж, баталсны дараа Гүйцэтгэх Юан болон түүний харьяа байгууллагуудад тэдгээрийг санал болгож болно.

**25 дугаар зүйл.** Гүйцэтгэх Юан, эсхүл түүний харьяа яамд, хороод зөрчил арилгах арга хэмжээний талаар мэдэгдэл авсан даруйдаа сайжруулах буюу зохих арга хэмжээг авч, сайжруулсан, авсан арга хэмжээнийхээ талаар Хяналтын Юанд бичгээр хариу өгнө. Хэрэв Хяналтын Юан хоёр сарын дотор хариу аваагүй бол холбогдох байгууллагад хандаж болно.

#### **V БҮЛЭГ. МӨРДӨН ШАЛГАХ**

**26 дугаар зүйл.** Хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд хяналтын гэрчилгээтэй Хяналтын Юаны гишүүн, эсхүл Хяналтын Юанаас томилсон шалгалтын гэрчилгээтэй ажилтан нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллага дээр очиж, хавтаст хэрэг, бүртгэл, холбогдох баримт бичгийг шалгаж болно. Эдгээр байгууллагын дарга, холбогдох бусад ажилтнууд шалгуулах ба байцаалт авахад дэлгэрэнгүй хариулт өгч, байцаалтын тэмдэглэлд гарын үсгээ зурна.

Шалгагч хэргийг шалгахдаа энэ тухай бичгээр гомдол гаргаж гарын үсэг зурсан этгээдэд мэдэгдэх ба шалгагдаж байгаа этгээдийг тогтоосон газарт дуудан байцаалт авч болно.

Шалгагч хэргийн агуулгыг нийтэд мэдээлэхгүй.

Хяналтын болон шалгалтын гэрчилгээг ашиглах журмыг Хяналтын Юан тогтооно.

**27 дугаар зүйл.** Шаардлагатай бол шалгагч нь холбогдох нотлох баримтыг түр хугацаагаар хураан авах, эсхүл бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хураан авч болно.

Ингэхдээ эхлээд тухайн байгууллагын даргаас зөвшөөрөл авна. Энэ нь үндэсний эрх ашгийг хохироохгүй бол байгууллагын дарга зөвшөөрөл олгоно.

Байгууллагын дарга нь шалгагчийн хураан авсан нотлох баримт дээр тамгаа дарж, баримт авна.

**28 дугаар зүйл.** Шалгагч нь орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн шүүх болон бусад холбогдох байгууллагаас туслалцаа авч болно.

Шалгагч эсэргүүцэлтэй тулгарсан, эсхүл нотлох баримтыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл шаардлагатай арга хэмжээ авахуулахаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

**29 дүгээр зүйл.** Хэргийг чухал гэж үзсэн, эсхүл шалгуулагч оргон зайлж болзошгүй гэж үзвэл шалгагч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

**30 дугаар зүйл.** Хяналтын Юан нь тодорхой асуудал, хэргийг мөрдөн шалгахын тулд өөр агентлагт даатгаж болно. Тус байгууллага хэргийг хүлээн авсны дараа нэн даруй мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж, Хяналтын Юанд бичгээр хариу өгнө.


## VI БҮЛЭГ. НЭМЭЛТ ЗААЛТУУД

**31 дүгээр зүйл.** Энэ хуулийг хэрэгжүүлэх журмыг Хяналтын Юан тогтооно.

**32 дугаар зүйл.** Энэ хуулийг нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.


Энэ хуулийн 1, 2, 5, 6 дугаар зүйл, 22 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг 1993 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хавсралт 4. Хяналтын Юаны бүтэц, зохион байгуулалтын схем





**Хавсралт 5. Хяналтын Юаны хяналтын үйл ажиллагааны зураглал**



**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

- Constitution of the Republic of China (Taiwan). Announced Date: 1947-01-01. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0000001>
- Government Portal of the Republic of China (Taiwan) - <https://www.taiwan.gov.tw>
- The Control Yuan цахим хуудас <https://www.cy.gov.tw/en/cp.aspx?n=233>
- Organic Law of the Control Yuan. Promulgated on March 31, 1947. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0010071>
- Control Act. Announced Date: 1947-01-01. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=A0030199>

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ  
МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

*Г.Билгээ, П.Уранчимэг, Э.Билгүүн*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

ТОВЧИЛСОН ҮГ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

1.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

- 1.1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо
- 1.2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны бие даасан байдал
- 1.3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

2.Бүгд Найрамдах Киргиз Улс

- 2.1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо
- 2.2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны бие даасан байдал
- 2.3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

3.Бүгд Найрамдах Тунис Улс

- 3.1.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо
- 3.2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны бие даасан байдал
- 3.3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

## ТОВЧИЛСОН ҮГ

ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НПМ	Национальный превентивный механизм
ҮУСМ	Үндэсний урьдчилан сэргийлэх механизм
ЭШЭКНП	Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протокол

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “**Гадаадын зарим орны эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо**” сэдэвт мэдээлэл, лавлагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (ПССХ)-д гүйцэтгэв.

### **Судалгааны захиалгын даалгавар:**

- эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны хэлбэр;
- үндэсний тогтолцооны үйл ажиллагааны болон төсвийн хараат бус байдал;
- үндэсний тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавх;
- эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй үйл ажиллагаа.

### **Судалгааны зорилго:**

Гадаадын зарим орны эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо, бие даасан байгууллага, бие даасан хараат бус гишүүний талаарх олон улсын туршлагыг судлах.

### **Судалгааны хамрах хүрээ:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоотой Герман, Киргиз, Тунис зэрэг улсыг хамруулан дараах асуудлуудын хүрээнд авч үзлээ:

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны бие даасан байдал;
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа.

### **Судалгааны бүтэц:**

Энэхүү судалгаа нь бүтцийн хувьд судалгааны хураангуй болон Герман, Киргиз, Тунис улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо, бие даасан байгууллагын талаар судалсан дэлгэрэнгүй хэсгээс бүрдэнэ.

**Түлхүүр үг:** эрүү шүүлт, эрүүдэн шүүх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо

**Key words:** *torture, torture prevention, national preventive mechanisms, The Optional Protocol.*

**Ключивые слова:** национальный превентивный механизм.

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

**Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц** (цаашид “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц”)-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1984 онд баталж, 20 орчим орон нэгдэн орсны дараа 1987 онд хүчин төгөлдөр болсон. 2023 оны байдлаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод 173 улс нэгдэн ороод байна.<sup>187</sup>

Энэхүү баримт бичгийн заалтын дагуу ажиглагч байгууллага болох Эрүүдэн шүүхийн эсрэг хороог байгуулсан бөгөөд түүний гол үүрэг нь оролцогч бүх улс конвенцыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхэд хяналт тавих явдал юм. Мөн эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан харьцах, шийтгэхийг бүрэн хориглохыг тогтоосон. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод нэгдэн орсон улс орнууд дараах тохиолдолд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үүрэг хүлээсэн<sup>188</sup>:

- тухайн хүнийг өөр улсад эрүү шүүлт тулгана гэж үзэх үндэслэлтэй бол буцаах, албадан гаргах, шилжүүлэн өгөх;
- баривчлах, саатуулах, цагдан хорих;
- байцаах;
- баривчлах, саатуулах, байцаахад оролцож буй иргэний болон цэргийн цагдаа, эмнэлгийн мэргэжилтнүүд, төрийн албан хаагчид болон бусад хүмүүст зориулсан сургалт зохион байгуулах.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг нэмэлт олон улсын гэрээ болгон **Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол** (цаашид “Нэмэлт протокол”)-ыг 2002 онд баталж, 2006 онд хүчин төгөлдөр болсон. 2023 оны байдлаар Нэмэлт протоколд 76 улс гарын үсэг зурж, 93 улс соёрхон батлаад байна.<sup>189</sup>

Энэхүү баримт бичиг нь эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх олон улсын болон үндэсний механизм байгуулах үндэс суур нь юм.

Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцыг 2000 онд, түүний Нэмэлт протоколыг 2015 онд соёрхон баталж, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм (тогтолцоо, байгууллага)-ыг байгуулах үүрэг хүлээсэн.

<sup>187</sup> [https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=IND&mtdsg\\_no=IV-9&chapter=4&clang=\\_en](https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=IND&mtdsg_no=IV-9&chapter=4&clang=_en)

<sup>188</sup> <https://www.ohchr.org/ru/treaty-bodies/cat/background-convention> – 2023.12.27-ны байдлаар.

<sup>189</sup> [https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg\\_no=IV-9-b&chapter=4&clang=\\_en](https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-9-b&chapter=4&clang=_en) – 2023.12.27-ны байдлаар.

Улсын Их Хурлаас 2020 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг хэлнэ гэж заасан. Уг хуулиар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгасан.<sup>190</sup>

Энэхүү захиалгат судалгаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан байгууллагатай улсуудыг авч үзсэн бөгөөд НҮБ-ын Нэмэлт протоколын дагуу Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрхэн зохицуулж байгааг тусгасан.

Нэмэлт протоколд нэгдэн орсон улсад Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага (ҮУСБ)-ыг өөрийн орны онцлог, эрх зүйн тогтолцоо зэрэгт нийцүүлэн үйл ажиллагааны хараат бус бие даасан байдал, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавх бүхий мэргэшсэн байдал зэрэг шаардлагыг ханган үйл ажиллагаа явуулж байна.<sup>191</sup>

**Холбооны Бүгд Найрамдах Герман Улс** (ХБНГУ)-ын хувьд Нэмэлт протоколын өмнө хүлээсэн үүргийн дагуу Эрүүдэн шүүхээс сэргийлэх Үндэсний агентлаг (National Agency for the Prevention of Torture)-ийг байгуулжээ. Энэхүү агентлаг нь бие даасан байгууллага бөгөөд Холбооны Засгийн газар, мужуудын Засгийн газар болон Бундестагт ажлаа тайлагнадаг байна. Тус агентлаг нь бүтцийн хувьд Холбооны агентлаг ба Мужуудын хамтарсан хороо гэж хуваагддаг бөгөөд мөн тэдний ажил үүргийг дэмжих зорилготой Ажлын албатай.

**Бүгд Найрамдах Киргиз Улсын** хувьд Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудаас Нэмэлт протоколын шаардлагыг хангасан Үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг бий болгосон анхны улсуудын нэг бөгөөд Нэмэлт протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бие даасан байгууллага болох Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төв (Национальный центр по предупреждению пыток и других жестоких, бесчеловечных или унижающих достоинство видов обращения и наказания)-ийг байгуулжээ. Энэхүү төв нь хуулийн хүрээнд бие даасан төрийн байгууллага бөгөөд төрийн эрх мэдэл, удирдлагын байгууллага, тэдгээрийн албан тушаалтан Үндэсний төвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг бие даан шийдвэрлэдэг байна.

<sup>190</sup> Хүний эрхийн үндэсний комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга., <https://www.parliament.mn/nn/30303/>

<sup>191</sup> <https://www.ohchr.org/ru/treaty-bodies/spt/national-preventive-mechanisms>



***Бүгд Найрамдах Тунис Улс*** нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан нэгжтэй бөгөөд мөн Нэмэлт протоколын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагын дагуу Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газар (National Authority for the Prevention of Torture, INPT)-ыг байгуулсан байна. Тус газар нь бүтэц зохион байгуулалт болон санхүүгийн хувьд бие даасан, эрх бүхий төрийн байгууллага юм. Тунис Улсын Парламент нь Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын тухай хуулийг батлан тэдний үйл ажиллагааны чиглэл, гишүүдэд тавигдах шаардлага зэргийг нарийн тодорхойлж өгсөн байна.

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

### Нэг. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

#### 1.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “ХБНГУ”) нь Нэмэлт протоколыг 2002 онд соёрхон баталсан. ХБНГУ нь Нэмэлт протоколын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор 2009 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн сайдын тушаалаар бие даасан байгууллага болох Холбооны Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх агентлагийг (цаашид Үндэсний агентлаг) байгуулсан.<sup>192</sup>

Тус Үндэсний агентлаг нь бүтцийн хувьд Холбооны агентлаг ба Мужуудын хамтарсан хорооноос бүрддэг:

- Холбооны агентлаг нь Холбооны хариуцдаг бүх цагдан хорих газруудыг (Зэвсэгт хүчний цагдан хорих төв, Цагдаа, Гаалийн алба) хариуцдаг.
- мужуудын хамтарсан комисс нь 2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Нэмэлт протоколын 3 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан бөгөөд мужуудын цагдан хорих газруудыг (Хорих анги, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагууд, хүүхэд залуучуудын халамжийн үйлчилгээний газар, ахмадын асрамжийн газрууд) хариуцдаг.

Холбооны агентлаг болон мужуудын хамтарсан комисс нь хамтарч ажилладаг бөгөөд тэд жил бүр үйл ажиллагааны нэгдсэн тайлан гаргадаг байна.

Үндэсний агентлаг нь нийт 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд, Мужуудын хамтарсан хорооны 8 гишүүн, Холбооны агентлагийн 2 гишүүнээс бүрдэнэ. Мөн тэдний үйл ажиллагааг дэмжих зорилготой Ажлын алба (The Secretariat) нь үндсэн 6 ажилтантай. Тус Ажлын алба нь Гэмт хэргийн төв (Centre for Criminology)-д харьяалагддаг.<sup>193</sup> Ажлын албаны ажилтнуудыг зөвхөн Үндэсний агентлагийн даргын зөвшөөрлөөр томилж, чөлөөлнө.<sup>194</sup>

Үндэсний агентлагийн дарга түүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсны дараа дахин нэг удаа сонгогдох боломжтой. Мөн тэрээр өөрийн санал хүсэлтээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохын өмнө ХБНГУ-ын

<sup>192</sup> [www.nationale-stelle.de/en](http://www.nationale-stelle.de/en)

<sup>193</sup> <https://www.nationale-stelle.de/en/the-national-agency/secretariat.html>

<sup>194</sup> [https://www.nationale-stelle.de/fileadmin/dateiablage/Dokumente/Rechtsgrundlagen/Organisationserlass\\_OP-CAT.pdf](https://www.nationale-stelle.de/fileadmin/dateiablage/Dokumente/Rechtsgrundlagen/Organisationserlass_OP-CAT.pdf)

Шүүгчдийн тухай хуульд заасны дагуу Хууль зүйн яам болон Дотоод хэргийн яамны шийдвэрээр Үндэсний агентлагийн даргаас чөлөөлөгдөж болно.<sup>195</sup>

Үндэсний агентлагийн 10 гишүүнийг дараах байдлаар томилдог.

- Мужуудын хамтарсан хорооны гишүүдийг бүрдүүлэхдээ мужуудын Хууль зүйн сайд нарын бага хурлаар санал болгож Хууль зүйн яам томилдог.
- Холбооны агентлагийн дарга, түүний орлогчийг Холбооны Дотоод хэргийн яам, Холбооны батлан хамгаалах яамтай тохиролцсоны дагуу мөн адил Хууль зүйн яам томилдог байна. Тэдний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.<sup>196</sup>

Үндэсний агентлагийн гишүүд нь Холбооны улсуудаас хууль эрх зүйн болон бусад байдлаар бие даасан, хараат бус байна. Харин тэднийг ХБНГУ-ын Шүүхийн тухай хуулийн дагуу эгүүлэн татаж болно.<sup>197</sup>

## **1.2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны бие даасан байдал**

Нэмэлт протоколд заасан журмын дагуу Үндэсний агентлагт дараах бүрэн эрхийг олгодог:

- цагдан хорих газарт эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн тоо, тэдгээрийн байршил зэрэг холбоотой бүхий л мэдээллийг авах;
- цагдан хорих газарт чөлөөтэй нэвтрэх;
- эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй гэрчгүйгээр биечлэн ярилцах, эсхүл шаардлагатай тохиолдолд орчуулагчтай, мөн үндэсний урьдчилан сэргийлэх механизмаар холбогдох мэдээлэл өгөх боломжтой гэж үзэж буй хүмүүстэй биечлэн ярилцах;
- НҮБ-ын Урьдчилан сэргийлэх дэд хороотой холбогдох зэрэг болно.

Үндэсний агентлаг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- цагдан хорих газруудад гарч буй аливаа зөрчил дутагдалд анхаарч, гарсан зөрчлийн тухай зөвлөмж гаргах;
- цагдан хорих газарт эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн нөхцөл байдлыг тогтмол хянан шалгаж байх;
- одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн төсөлд санал, дүгнэлт гаргах;

<sup>195</sup> [https://www.nationale-stelle.de/fileadmin/dateiablage/Dokumente/Rechtsgrundlagen/Organisationserlass\\_OP-CAT.pdf](https://www.nationale-stelle.de/fileadmin/dateiablage/Dokumente/Rechtsgrundlagen/Organisationserlass_OP-CAT.pdf)

<sup>196</sup> <https://www.nationale-stelle.de/en/the-national-agency/members.html>

<sup>197</sup> <https://www.nationale-stelle.de/en/frequently-asked-questions.html>

- цагдан хорих газарт эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн нөхцөл байдлыг сайжруулах, эрүүдэн шүүх болон бусад хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар эрх бүхий байгууллагад санал болгох;
- ХБНГУ-аас хүмүүсийг албадан гаргах асуудалд хяналт тавих;
- одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн мэдээлэл өгөх үүрэгтэй.

Нэмэлт протоколын 21 дүгээр зүйлд заасны дагуу Үндэсний агентлагийн гишүүд, ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэж байх явцдаа мэдээллийн нууцыг задруулахгүй байх бөгөөд бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон ч мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хүлээсэн байдаг.<sup>198</sup>

Үндэсний Агентлаг санхүүжилтийн хувьд нийт төсвийн 1/3-ыг Холбооны төсвөөс, 2/3-ыг муж улсын төсвөөс бүрдүүлдэг бөгөөд 2021 оны байдлаар жилийн төсөв нь 640.00 Евро байсан. Санхүүжилтийг Хессиа мужийн хууль зүй, Интеграц, Европын хэрэг эрхлэх яамнаас (Hessian Ministry of Justice, Integration and European Affairs) хуваарилан зохицуулдаг.<sup>199</sup>

### **1.3.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

Үндэсний Агентлаг нь ХБНГУ-ын хууль тогтоомж, Холбооны Үндсэн хуулийн шүүх, Холбооны Дээд шүүхийн хууль тогтоомжид тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг. Мөн аливаа шийдвэр гаргахдаа Европын хүний эрхийн баримт бичиг, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хороо, дэд хороодын зөвлөмжийг баримтлан ажилладаг байна.

Үндэсний агентлаг нь үйл ажиллагааныхаа жилийн тайланг Холбооны Засгийн газар, Мужийн Засгийн газар болон ХБНГУ-ын парламент болох Бундестагт тайлагнадаг байна.

<sup>198</sup> Үндэсний агентлагийн жилийн тайлан 21-р нүүр.

<sup>199</sup> Үндэсний агентлагийн жилийн тайлан 21-р нүүр.

## Хоёр. БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛС

### 2.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо

Бүгд Найрамдах Киргиз Улс (цаашид “Киргиз Улс”) Нэмэлт протоколд 2008 онд соёрхон баталж, цагдан хорих, эрх чөлөөг хязгаарлах газруудад тогтмол очиж үзэх Урьдчилан сэргийлэх механизмыг (Национальный превентивный механизм, НПМ) бий болгох үүрэг хүлээсэн. Үүний дагуу 2012 оны 07 дугаар сард тус улсын Парламент (Жогорку Кенеш)-аас Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх Үндэсний төвийн тухай хуулийг<sup>200</sup> батлав.

Энэ хуулийн дагуу Киргиз Улс Нэмэлт протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бие даасан байгууллага болох Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төвийг байгуулжээ. Киргиз Улс нь Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл (Содружество Независимых Государств)-ийн орнуудаас Нэмэлт протоколын шаардлагыг хангасан Үндэсний урьдчилан сэргийлэх механизм (ҮУСМ)-ыг бий болгосон анхны улсуудын нэг болов.<sup>201</sup>

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний төв (Үндэсний төв)-ийн энэхүү загвар нь хуулийн хүрээнд бие даасан төрийн байгууллага бөгөөд төрийн эрх мэдэл, удирдлагын байгууллага, тэдгээрийн албан тушаалтан Үндэсний төвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд аливаа хэлбэрээр хөндлөнгөөс оролцохыг дээрх хуулиар хориглосон байна. (Үндэсний төвийн тухай хуулийн §5.3.)

#### *Үндэсний төвийн Зохицуулах зөвлөл*

Үндэсний төвийн удирдах дээд байгууллага нь 11 гишүүнтэй Зохицуулах зөвлөл юм. Уг зөвлөлтэй холбоотой харилцааг Үндэсний төвийн тухай хуулийн 9-13 дугаар зүйлд зохицуулсан байна.

Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах этгээдүүд багтана:

- 1) Акыйкатчи (Омбудсмен) - албан тушаалаараа;
- 2) Жогорку Кенешийн олонхын санал болгосон нэг депутат;

<sup>200</sup> Закон «О Национальном центре Кыргызской Республики по предупреждению пыток и других жестоких, бесчеловечных или унижающих достоинство видов обращения и наказания» от 12 июля 2012 года N 104. <https://npm.kg/ru/normativnaya-baza/natsionalnye-normy/>

<sup>201</sup> Национальный центр Кыргызской Республики по предупреждению пыток, Управление Верховного комиссара ООН по правам человека, Penal Reform International. Национальный центр Кыргызской Республики по предупреждению пыток (2020-2021 годы). 3 дахь тал. <https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2022/01/%D0%B1%D1%80%D0%BE%D1%88%D1%8E%D1%80%D0%B0-%D0%BF%D1%8B%D1%82%D0%BA%D0%B8.pdf>

- 3) Жогорку Кенешийн сөрөг хүчнээс санал болгосон нэг депутат;
- 4) хуулиар тогтоосон үйл ажиллагаа нь эрүү шүүлт, хэрцгий харьцах, шийтгэлээс ангид байх эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжид заасан журмаар бүртгүүлсэн ашгийн бус байгууллагын 8 төлөөлөгч зэрэг байна.

Киргиз Улсын энэхүү ҮУСМ-ын загварын онцлог бол тус Үндэсний төвийн үйл ажиллагаанд нь иргэний нийгмийн буюу ашгийн бус байгууллагуудыг албан ёсоор оролцуулах явдал юм.<sup>202</sup>

Нэг ашгийн бус байгууллагаас Зохицуулах зөвлөлийн гишүүнд нэг хүний нэрийг дэвшүүлэх эрхтэй. Гишүүнд ашгийн бус байгууллагаас нэр дэвшигчид Үндэсний төвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Үндэсний төвийн ажилтанд тавигдах шаардлагыг мөрдөх аж. Ашгийн бус байгууллагаас зөвлөлийн гишүүдийг сугалаагаар сонгохоор хуульд зохицуулжээ.

Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 жилийн хугацаагаар сонгоно. Акыйкатчи (Омбудсмен)-аас бусад тохиолдолд нэг хүн Зохицуулах зөвлөлийн гишүүнээр 2-оос дээш удаа дараалан сонгогдохгүй. Зөвлөлийн удирдлагыг дарга, түүнийг эзгүйд дэд дарга гүйцэтгэнэ.

Зохицуулах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагааг нь хөгжүүлэх стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;
- цагдан хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан газарт хоригдож байгаа хүмүүсийг эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахаас хамгаалж, шаардлагатай бол тэднийг эмчлэх асуудлыг тогтмол авч үзэх;
- Үндэсний төвөөс боловсруулсан цагдан хорьсон, эрх чөлөөг хязгаарлагдсан газарт урьдчилан сэргийлэх үзлэг хийх аргачлал, жил бүрийн хөтөлбөрийг батлах;
- зөвлөмж, уриалга боловсруулан холбогдох төрийн байгууллагуудад илгээх, мөн өөрийн зөвлөмж, уриалгын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тэдгээр байгууллагуудын дарга нарын саналыг сонсох;
- Киргиз Улсын одоогийн хууль тогтоомжийн талаар санал, дүгнэлт гаргах;
- сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн Үндэсний төвийн захирал, түүний орлогчийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- Үндэсний төвийн ажилтны сул орон тоонд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг явуулж, Үндэсний төвийн захиралд томилуулахаар нэр дэвшигчийг өргөн мэдүүлэх;

<sup>202</sup> Мөн тэнд. 7 дахь тал.

- эрх чөлөөгөө хасуулсан болон эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээдийг эрүүдэн шүүх, зүй бус харьцахаас хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, бусад зохицуулалтын эрх зүйн актуудын төсөл, тэднийг цагдан хорих дэг журам, нөхцөл байдалд олон нийтийн хэлэлцүүлэг явуулах;
- Үндэсний төвийн төсвийн төслийг батлах;
- Үндэсний төвийн үйл ажиллагааны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитыг оролцуулах Зохицуулах зөвлөлийн журам, Үндэсний төвийн журмыг боловсруулж батлах;
- Үндэсний төвийн даргын санал болгосноор Үндэсний төвийн бүтэц, орон тоог батлах зэрэг болно.

Үндэсний төвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар Зохицуулах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг дараах үндэслэлээр дуусгавар болгоно:

- сонгогдсон хугацаа дууссан бол;
- огцрох өргөдлөө бичгээр гаргаж, цаашид ажил үүргээ гүйцэтгэхээс сайн дураараа татгалзсан бол;
- Киргиз Улсаас гадна байнга оршин суухаар явах бол;
- шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол;
- түүнийг сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол;
- нас барсан бол;
- шүүх чадваргүй буюу чадваргүй гэж хүлээн зөвшөөрсөн бол;
- хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 сарын хугацаанд зөвлөлийн үйл ажиллагаанд оролцоогүй бол;
- цагдан хорьсон, эрх чөлөөг хязгаарласан газарт хүний эрх, эрх чөлөөг зөрчихөд хүргэсэн ёс зүй, үйлдлийг хүлээн зөвшөөрсөн бол.

Гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлыг Зохицуулах зөвлөлийн нийт гишүүдийн олонхын саналаар баталсан Зохицуулах зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.

Зохицуулах зөвлөл нь дээр дурдсан үндэслэлээр тус зөвлөлийн гишүүнийг Жогорку Кенешийн депутатуудаас эгүүлэн татах асуудлыг Жогорку Кеңешийн өмнө санаачлах эрхтэй. Энэ тохиолдолд тус зөвлөлийн гишүүнийг хугацаанаас нь өмнө эгүүлэн татах асуудлыг Жогорку Кенешийн холбогдох хорооны дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

Харин Акыйкатч (Омбудсмен)-ийн Зохицуулах зөвлөлийн гишүүний бүрэн эрх нь хуульд заасан журмын дагуу дуусгавар болсон тохиолдолд хугацаанаасаа өмнө дуусгавар болно.



Зохицуулах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаагаа үнэ төлбөргүй хэрэгжүүлнэ. Харин Зохицуулах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ албан томилолтын зардлыг нөхөн төлөх баталгааг хуулиар хангасан байна. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, материал техникийн дэмжлэгийг Үндэсний төв хариуцдаг.

#### *Үндэсний төвийн дарга*

Үндэсний төвийг тус төвийн дарга тэргүүлж, үйл ажиллагааг нь зохион байгуулна. Даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн Зохицуулах зөвлөл 2 жилийн хугацаатай сонгодог. Даргын албан тушаалд нэг хүн дараалан 2 удаа сонгогдож болно. Тэрээр 25-аас доошгүй настай, дээд боловсролтой, удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай Киргиз Улсын иргэн байна. Даргын сонгон шалгаруулалтад хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Үндэсний төвийн дарга нь Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулна, мөн жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тус төвийн өнгөрсөн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Жогорку Кенешт өргөн мэдүүлнэ.

Уг жилийн тайланд эрүү шүүлт, зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх салбарын төлөв байдлын талаарх ерөнхий үнэлгээ, дүгнэлт, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг, мөн Үндэсний төвийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, зөвлөмжийг нь авч хэлэлцээгүй төрийн байгууллага (албан тушаалтан)-ыг заавал заахыг Үндэсний төвийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт шаардсан байна. Мөн жилийн тайланд Үндэсний төвийн өнгөрсөн оны санхүүгийн тайланг хавсаргана.

Шаардлагатай тохиолдолд цагдан хорих, эрх чөлөөг хязгаарлах газруудад хүний эрхийг бүдүүлгээр зөрчиж, нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байгаа баримтуудын талаар Үндэсний төвөөс тусгай илтгэл (мэдээлэл) гаргаж, Жогорку Кенешт өргөн мэдүүлж болно.

Үндэсний төвийн жилийн тайлан, тусгай илтгэлийг Жогорку Кенешт өргөн мэдүүлсэн өдрөөс хойш нэг сарын дотор албан ёсны хэвлэл, Үндэсний төвийн цахим хуудсанд нийтэлж тараана.


#### *Үндэсний төвийн албан хаагчид*

Үндэсний төвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Үндэсний төвийн бүтэц, орон тоог Үндэсний төвийн даргын санал болгосноор Зохицуулах зөвлөл батална. Ингэхдээ Үндэсний төвийн төлөөлөгчийн газар

(төлөөлөгчид)-ыг Киргиз Улсын нийт нутаг дэвсгэрт заавал ажиллуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг харгалзана.

Тус төвийн ажилтныг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн Зохицуулах зөвлөлийн санал болгосноор Үндэсний төвийн дарга томилно, мөн ажилтныг албан тушаалаас нь чөлөөлнө.

*Зураг. Үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч зураг*



Үндэсний төвийн ажилтны албан тушаалд нэр дэвшигчдийг сонгохдоо хүйсийн тэнцвэрт байдал, үндэстний цөөнхийн төлөөллийг хангах бөгөөд ингэхдээ нэг хүйсийн төлөөлөл 70-аас дээш хувиар давамгайлж болохгүй. Хэрэв Үндэсний төвийн ажилтны сул орон тоонд өөр хүйсийн хоёр нэр дэвшигч өрсөлдөж байгаа бол ижил нөхцөлөөр тус төвд бага төлөөлөлтэй хүйсийн нэр дэвшигчийг хүлээн авна.

Үндэсний төв нь нийт 26 албан хаагчтай, тус улсын 7 бүс нутагт төлөөлөгчийн газартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.<sup>203</sup>

<sup>203</sup> Мөн тэнд. 7 дахь тал.

### *Үндэсний төвийн ажилтанд тавигдах шаардлага*

Үндэсний төвийн албан хаагчдад тавих шаардлагыг Үндэсний төвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд тусгасан. Тус төвийн ажилтнаар Киргиз Улсын иргэн, дээд боловсролтой, хуульч, багш, эмч, сэтгэл зүйч, сэтгэцийн эмч, нийгмийн ажилтны мэргэжлээр практик туршлагатай, мөн цагаачид, насанд хүрээгүй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэстний болон хэлний цөөнх зэрэг нийгмийн эмзэг бүлэгтэй хамтран ажиллаж байсан туршлагатай, цагдан хорих, эрх чөлөөг хязгаарлах газруудыг удирдаж байсан, хяналт тавьж байсан туршлагатай аливаа хүн сонгогдож болно. Харин ажилтан нь шүүгч, хууль сахиулах болон эрүүгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, эрх чөлөөг хязгаарлах газар (насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цагаачид, сэтгэцийн өвчтэй хүмүүс гэх мэт эмзэг бүлгийн хүмүүс их төвлөрсөн газар)-т ажиллаж байсан, мөн гэмт хэрэг үйлдсэн ялтай хүн байж болохгүй.

Дээрх шаардлагуудыг мөн Зохицуулах зөвлөлийн ашгийн бус байгууллагаас сонгогдсон гишүүдэд тавидаг.

### **2.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны бие даасан байдал**

Үндэсний төвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд Үндэсний төвийн зохион байгуулалт, үйл ажиллагааны бие даасан байдлыг дараах хүчин зүйлээр тодорхойлсон:

- Үндэсний төвийн ажилтныг сонгон шалгаруулах, томилох, Зохицуулах зөвлөлийн гишүүдийг сонгох ил тод журам, шалгуур, бүрэн эрхийн хугацаа, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох журам;
- Үндэсний төвийн зохион байгуулалт, чиг үүргийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх;
- Зохицуулах зөвлөлийн гишүүн, Үндэсний төвийн ажилтны халдашгүй байдал;
- Үндэсний төвийн үйл ажиллагааны хангалттай санхүүжилт.

Мөн хуулийн 18 дугаар зүйлд Зохицуулах зөвлөлийн гишүүд, Үндэсний төвийн ажилтны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг хориглож, хуульд заасан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна.

### *Үндэсний төвийн төсвийн хараат бус байдал*

Үндэсний төв нь өөрийн санхүүжилтэд шаардагдах хөрөнгийн хэмжээг бие даан тодорхойлох, зардлын тооцоонд багтаан захиран зарцуулах эрхийг Үндэсний төвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь хэсэгт тогтоож өгсөн.

Мөн хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар Үндэсний төвийн үйл ажиллагааг санхүүжүүлэх нь улсын төсөв, түүнчлэн Киргиз Улсын хууль тогтоомжид харшлаагүй бусад сангаас хийгдэнэ.

Үндэсний төв нь төсвийн төслийг боловсруулж, батлуулахаар Засгийн газарт илгээнэ. Хэрэв хоёр тал төсвийн төслийн талаар санал нийлэхгүй тохиолдолд Засгийн газар тус төвийн саналыг өөрчлөхгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, дүгнэлтийг нь хавсаргахыг хуулиар зохицуулжээ. Үндэсний төв нь баталсан зардлын тооцоонд багтаан хөрөнгийг бие даан захиран зарцуулах ба төвийн дарга санхүүгийн тайлангаа хуульд заасан журмын дагуу тайлагнана.

Төвийн ажилтны цалингийн хэмжээг Акыйкатчи (Омбудсмен)-ны Ажлын албаны төрийн албан хаагчдын цалингийн хэмжээтэй ижил тогтооно. (Үндэсний төвийн тухай хуулийн §5.10.)

### **2.3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

#### *Урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээ*

Үндэсний төвөөс урьдчилан сэргийлэх дараах гурван төрлийн хяналт шинжилгээ хийдэг:

- 1) *урьдчилан сэргийлэх тусгай хяналт шинжилгээг* цагдан хорих, эрх чөлөөг хязгаарлах газарт эрүүдэн шүүх, зүй бусаар харьцсан, нас барсан тухай мэдээлэл бүрд, эсхүл тодорхой асуудал судлах зорилгоор хийнэ;
- 2) *урьдчилан сэргийлэх иж бүрэн хяналт шинжилгээг* тухайн байгууллагын нөхцөл байдлыг судлах, цагдан хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан хүмүүсийн эсрэг эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахад нөлөөлж буй үндсэн шалтгааныг тогтоох зорилгоор хийнэ;
- 3) *урьдчилан сэргийлэх ээлжит хяналт шинжилгээний* зорилго нь зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний багтай хамтран ажилласны төлөө хэлмэгдүүлэлтэд өртөхгүй байх явдал юм.

Үндэсний төвийн бүрэн эрх нь цагдан хорих, эрх чөлөөг хязгаарласан аливаа газарт өдрийн аль ч цагт, байгууллагын удирдлагад урьдчилан мэдэгдэлгүйгээр очих бөгөөд хяналт шинжилгээ хийхдээ дараах эрхтэй (Үндэсний төвийн тухай хуулийн §22, 24):

- цагдан хоригдсон, эрх чөлөөг нь хязгаарласан хүмүүстэй гэрчгүй, биечлэн уулзаж ярилцах;
- цагдан хоригдсон, эрх чөлөөгөө хязгаарлагдсан хүмүүст хэрхэн хандаж байгаа байдал, тэдний цагдан хорих нөхцөл, түүний дотор эрүүл мэндийн бүртгэлтэй холбоотой мэдээллийг захиргаанаас хүсэх, хүлээн авах;
- заасан газарт очих хууль ёсны эсэхийг баталгаажуулсан баримт бичигтэй танилцах;
- цагдан хорих, эрх чөлөөг хязгаарлах газрын захиргаанаас гэрэл зураг, дуу, дүрс бичлэг авах, мөн баримт бичгийн хуулбарыг авах;
- цагдан хоригдсон, эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн аюулгүй байдал, түүнийг хангах объектын гэрэл зураг, дуу, дүрс бичлэгийг захиргааны зөвшөөрөлтэйгөөр, мөн гэрэл зураг, дүрс бичлэгийн камер чиглүүлж байгаа хүмүүсийн зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэх.

Эрүүдэн шүүлтийн талаарх хувь хүний гомдол нь прокурор, шүүх, иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрхэд хамаарах тул ийм төрлийн гомдлыг Үндэсний төв авч үзэх, хянан шалгахгүй. Харин Үндэсний төв нь хяналт шалгалтаар илэрсэн хэргийн тайланг эрх бүхий байгууллагад дамжуулах үүрэгтэй.

Үндэсний төвийн дарга, бүс нутгийн төлөөлөгчийн газрын дарга нь тус төвийн ажилчид, Зохицуулах зөвлөлийн гишүүдээс ажлын хэсэг байгуулж, шаардлагатай тохиолдолд янз бүрийн салбарын шинжээч, мэргэжилтнүүдийг татан оролцуулж урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг хийдэг байна.

#### *Зохицуулах зөвлөлийн зөвлөмж*

Үндэсний төвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах зөвлөл нь цагдан хорих, эрх чөлөөг хязгаарлах газруудад урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээг нэгтгэсэн үр дүнд үндэслэн хорих газарт хоригдож буй хүмүүсийг эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахад хүргэж буй шалтгаан, нөхцөлийг арилгах, цаашлаад сайжруулах зорилгоор зөвлөмж боловсруулан холбогдох төрийн байгууллагад хүргүүлдэг.

Зөвлөмж хүлээн авсан төрийн байгууллага нь тухайн зөвлөмжийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор түүний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар Зохицуулах зөвлөлд мэдээлэх үүрэгтэй.

## ГУРАВ. БҮГД НАЙРАМДАХ ТУНИС УЛС

### 3.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоо

Нэмэлт протоколын 3 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага (ҮУСБ) байгуулах эрх зүйн үндсийг тогтоож өгсөн бөгөөд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх нэг болон хэд хэдэн байгууллага байгуулах үүрэг хүлээдэг.<sup>204</sup>

Бүгд Найрамдах Тунис Улс (цаашид “Тунис Улс”) нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх **бие даасан нэгжтэй** бөгөөд эрүүдэн шүүх, хүнлэг бусаар шийтгэх, харьцсан тухай гомдолд хариу өгөх зорилгоор Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газар (National Authority for the Prevention of Torture, INPT)-ыг 2013 онд байгуулсан байна.<sup>205</sup>

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газар нь бүтэц зохион байгуулалт болон санхүүгийн хувьд бие даасан, эрх бүхий төрийн байгууллага юм.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын гол зорилго нь баривчлах, саатуулах төвүүдэд зочлох, эрүүдэн шүүхтэй тэмцэх соёлыг түгээн дэлгэрүүлэх, мэдээлэл цуглуулах, гомдол гаргагчдыг хүлээн авах, мэдүүлэг авах ажлыг зохион байгуулахад чиглэгдэнэ.

Тунис Улсын Парламент нь 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын тухай хуулийг<sup>206</sup> баталсан байна. Хууль нь 4 бүлэг, 27 зүйлтэй.

Тус байгууллага нь хөндлөнгийн оролцоо бүхий, салбар бүрийн мэргэжилтнүүдээс бүрдэх 16 гишүүнтэй. Үүнд:<sup>207</sup>

- хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, холбоодыг төлөөлсөн 6 гишүүн;
- нийгмийн чиглэлээр мэргэшсэн 2 их сургуулийн профессор;
- хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн 1 гишүүн;
- хуульчийн салбарыг төлөөлсөн 2 гишүүн;
- эмч нарыг төлөөлсөн 3 гишүүн, тэдгээрийн нэг нь сэтгэцийн эмч байх ёстой;
- тэтгэвэрт гарсан 2 шүүгчээс бүрдэнэ.

<sup>204</sup> “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” гарын авлага, 2021 он.

<sup>205</sup> National Authority for the Prevention of Torture (INPT), <http://www.inpt.tn/index.php?id=193>

<sup>206</sup> Loi organique n° 2013-43 du 21 octobre 2013, relative à l'Instance nationale pour la prévention de la torture., [http://www.inpt.tn/fileadmin/user\\_upload/pdf/jo0852013.pdf](http://www.inpt.tn/fileadmin/user_upload/pdf/jo0852013.pdf)

<sup>207</sup> Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын тухай хуулийн 5 дугаар зүйлд

### *Гишүүдийг сонгох*

Парламентын мэргэжлийн хороо<sup>208</sup> Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын гишүүнээр нэр дэвших хүсэлтэй иргэдийн өргөдөл, холбогдох материалыг авах зарыг Тунис Улсын албан ёсны сэтгүүлд нийтлүүлнэ. Ингэхдээ гишүүнд тавигдах шаардлага, өргөдөл гаргах эцсийн хугацаа, бүрдүүлэх материалын жагсаалтыг тодорхой гаргана. Ирүүлсэн өргөдөл, материалуудаас Парламентын мэргэжлийн хороо нь гишүүдийн тавны гурвын (3/5) саналаар доорх тооны нэр дэвшигчдийг сонгодог байна:

- хүний эрхийг хамгаалдаг байгууллага, холбоонд хоёроос доошгүй жил ажилласан арван найман (18) нэр дэвшигч;
- нийгмийн чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн судлаачдаас зургаан (6) нэр дэвшигч;
- хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдээс гурван (3) нэр дэвшигч;
- тэтгэвэрт гарсан шүүгчдээс зургаан (6) нэр дэвшигч;
- мэргэжлийн ангилал хамаарахгүй хуульчдаас зургаан (6) нэр дэвшигч;
- эмч нарын төлөөллөөс есөн (9) нэр дэвшигч, үүнээс 3 нь сэтгэцийн эмч байна.

Хорооны дарга Парламентын нэгдсэн хуралдаанд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг цагаан толгойн үсгийн дарааллаар танилцуулж, нууц санал хураалтаар парламентын гишүүдийн олонхын саналаар сонгоно. (хуулийн §7). Гишүүдийг хамгийн олон санал авсан эрэмбээр сонгох бөгөөд санал тэнцсэн тохиолдолд ахмад настай нь шалгардаг байна.

Сонгогдсон гишүүд нь анхны хурлаа хамгийн ахмад гишүүнээрээ ахлуулан хуралдах бөгөөд байгууллагын Ерөнхийлөгчийг үнэмлэхүй олонхын саналаар сонгоно. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалсан ахмад гишүүн шийдвэрлэх үүрэгтэй оролцоно.

Гишүүдийг 6 жилийн хугацаатай сонгох бөгөөд дахин сонгогдох эрхгүй байна. Ерөнхийлөгч, гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өмнө Засгийн газрын тэргүүний өмнө тангараг өргөдөг байна. (хуулийн §9)

### *Гишүүдэд тавигдах шаардлага*

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын тухай хуулийн 6 дугаар зүйлд гишүүдэд тавигдах шаардлагыг зааж өгсөн байна. Үүнд:

<sup>208</sup> тус хуулийн 27 дугаар зүйлд “Парламентын дэргэдэх эрх, эрх чөлөө, гадаад харилцааны хороог мэргэжлийн хороо гэж үзнэ” гэж заасан байна.



- Тунис Улсын иргэншилтэй байх;
- 25-аас доошгүй настай байх;
- шударга, хараат бус, бие даасан байх;
- шүүхийн эцсийн шийдвэр гараагүй байхад хэн нэгний нэр төрд харшлах аливаа шалтгаанаар албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулаагүй байх;
- нэр дэвших үедээ Парламентын гишүүн бус байх;
- өмнө нь хуулийн хариуцлага хүлээж байгаагүй, улс төрийн үйл ажиллагаанд оролцдоггүй, төрийн зарим албан тушаал (өмнөх ерөнхийлөгчийн үед засгийн газарт ямар нэгэн үүрэг, хариуцлага хүлээгээгүй, мужийн захирагч, ерөнхий нарийн бичгийн дарга, төлөөлөгчийн алба)-ыг хашиж байгаагүй;
- Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын гишүүд нь аливаа хорих анги, хорих төвд урьдчилан мэдэгдэлгүйгээр очиж, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцсан явдлыг баримтжуулах, эрүүгийн болон захиргааны мөрдөн байцаалтад хүсэлт гаргах, хүчирхийлэл, зүй бус харьцах байдлыг арилгах арга хэмжээний талаар зөвлөмж гаргах эрхтэй.

### **3.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцооны бие даасан байдал**

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар тус байгууллага нь бие даасан төрийн байгууллага бөгөөд төв байр нь Тунис хотод байна гэжээ.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газар нь төрийн байгууллага бөгөөд улсын төсвөөс санхүүжнэ. Байгууллагын санхүүгийн дансыг Аудитын шүүхээс шууд хянадаг. (хуулийн §15)

### **3.3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын чиг үүрэг нь:<sup>209</sup>

- цагдан хорих газруудад урьдчилан мэдэгдэлгүйгээр, хүссэн цагтаа тогтмол болон бусад гэнэтийн айлчлал хийх;
- цагдан хорих байранд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай орчин нөхцөл, хамгаалалттай байх;
- цагдан хорих байранд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх, хүний нэр төрийг доромжлон харьцах явдал байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийх, баталгаажуулж, цагдан хорих болон ялыг гүйцэтгэх нөхцөл нь үндэсний хууль тогтоомж, олон улсын хүний эрхийн стандартад нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

<sup>209</sup> <http://www.inpt.tn/index.php?id=194>

- эрүүдэн шүүж болзошгүй тохиолдлын талаарх гомдол, мэдэгдэл хүлээн авч, эдгээр хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг хангаж, шаардлагатай тохиолдолд эрх бүхий захиргааны болон харьяаллын байгууллагад шилжүүлэх;
- эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль, тогтоомжийн төслийн эх бичвэрийн талаар санал, дүгнэлт гаргах;
- эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгөх, хэрэгжилтэд нь хяналт тавихад хувь нэмэр оруулах;
- эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ерөнхий удирдамжийг холбогдох талуудтай уялдуулан батлах;
- мэдээллийн сан бүрдүүлэхийн зэрэгцээ өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд ашиглахаар шаардлагатай мэдээлэл, өгөгдөл, статистик тоо баримтыг цуглуулах, бэлэн байдлыг хангах;
- эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх, хүний нэр төрийг доромжлон харьцах эрсдэлийн эсрэг нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж, сурталчилгаа хийх, сургалт, семинар зохион байгуулах, гарын авлага хэвлүүлэх;
- эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа, тайлан мэдээ гаргах, нийтлэх;
- жил бүрийн тайлангаа Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүн, Ассамблейн Ерөнхийлөгчид хүргүүлэх, Бүгд Найрамдах Тунис Улсын цахим хуудас болон албан ёсны “JORT” сэтгүүлд нийтлэх.

Тус байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах эрхийн хүрээнд ажиллахыг хуулиар зөвшөөрдөг байна:<sup>210</sup>

- Захиргааны бүх боломжит, шаардлагатай арга хэмжээг авах;
- Цагдан хорих газруудтай холбоотой бүх мэдээллийг авах (үүнд, цагдан хорих газрын тоо, байршил, түүнчлэн эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн тоо гэх мэт);
- Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй хэрхэн харьцаж байгаа болон тэднийг саатуулах орчин нөхцөлтэй холбоотой бүх мэдээллийг олж авах;
- Цагдан хорих бүх газар, бусад байгууламж, тоног төхөөрөмжид нэвтрэх;
- Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс болон мэдээлэл өгөх боломжтой бусад хүмүүстэй гэрчийг оролцуулалгүйгээр, эсхүл шаардлагатай тохиолдолд тангараг өргөсөн хэлмэрчээр дамжуулан ганцаарчлан ярилцлага хийх.

<sup>210</sup> Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний газрын тухай хуулийн 4 дүгээр зүйл.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын хууль, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=15152>
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын цахим хуудас, <https://nhrcm.gov.mn/news/57#>
- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” гарын авлага, 2021 он
- Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланд хийсэн шинжилгээний танилцуулга., <https://www.parliament.mn/nn/30303/>
- <https://www.ohchr.org/ru/treaty-bodies/spt/national-preventive-mechanisms>
- <https://www.ohchr.org/ru/treaty-bodies/cat/background-convention>
- <https://treaties.un.org/>

### ХБНГУ

- Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний агентлагийн цахим хуудас [www.nationale-stelle.de/en](http://www.nationale-stelle.de/en)
- Үндэсний агентлагийн жилийн тайлан [https://www.nationale-stelle.de/fileadmin/dateiablage/Dokumente/Berichte/Jahresberichte/Annual\\_Report\\_2021\\_\\_\\_National\\_Agency\\_for\\_the\\_Prevention\\_of\\_Torture.pdf](https://www.nationale-stelle.de/fileadmin/dateiablage/Dokumente/Berichte/Jahresberichte/Annual_Report_2021___National_Agency_for_the_Prevention_of_Torture.pdf)

### Киргиз Улс

- Закон «О Национальном центре Кыргызской Республики по предупреждению пыток и других жестоких, бесчеловечных или унижающих достоинство видов обращения и наказания» от 12 июля 2012 года N 104. <https://npm.kg/ru/normativnaya-baza/natsionalnye-normy/>
- Национальный центр Кыргызской Республики по предупреждению пыток, Управление Верховного комиссара ООН по правам человека, Penal Reform International. национальный центр Кыргызской Республики по предупреждению пыток (2020-2021 годы). <https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2022/01/%D0%B1%D1%80%D0%BE%D1%88%D1%8E%D1%80%D0%B0-%D0%BF%D1%8B%D1%82%D0%BA%D0%B8.pdf>

### Тунис Улс

- Loi organique n° 2013-43 du 21 octobre 2013, relative a l'Instance nationale pour la prévention de la torture, [http://www.inpt.tn/fileadmin/user\\_upload/pdf/jo0852013.pdf](http://www.inpt.tn/fileadmin/user_upload/pdf/jo0852013.pdf)
- The National Authority for the Prevention of Torture (INPT), <http://www.inpt.tn/index.php?id=193>
- <https://www.state.gov/reports/2022-country-reports-on-human-rights-practices/tunisia>
- <https://legislation-securite.tn/fr/law/43975>